

ALBERT EINSTEIN

OLIVER CROMWELL

QUEEN ELIZABETH

JOHANN GUTENBERG

CHRISTOPHER COLUMBUS

LOUIS PASTEUR

BUDDHA

JONH LOCKE

GENGHIS KHAN

ALEXANDER THE GREAT

JESUS CHRIST

ISAAC NEWTON

# ДЭЛЖИЙН ТҮҮЖИЙН СУУТ 100 ХҮН

ARISTOTLE

HENRY FORD

EUCLID

ALEXANDER FLEMING

MARTIN LUTHER

LUDWIG VAN BEETHOVEN

ORVILLE WRIGHT AND WILBUR WRIGHT

NICOLAUS COPERNICUS

WILLIAM HARVEY



ALBERT EINSTEIN  
OLIVER CROMWELL  
QUEEN ELIZABETH

BUDDHA  
JONH LOCKE  
GENGHIS KHAN

JOHANN GUTENBERG  
CHRISTOPHER COLUMBUS  
LOUIS PASTEUR

ALEXANDER THE GREAT  
JESUS CHRIST  
ISAAC NEWTON

# ДЭЛХИЙН ТҮҮЖИЙН СУУТ 100 ХҮН

ARISTOTLE  
HENRY FORD  
EUCLID

ALEXANDER FLEMING  
MARTIN LUTHER  
LUDWIG VAN BEETHOVEN

ORVILLE WRIGHT AND WILBUR WRIGHT  
NICOLAUS COPERNICUS  
WILLIAM HARVEY

ADAM SMITH  
SHIH HUANG TI  
WILLIAM HARVEY

CHARLES DARVIN  
JUSTINIAN I  
JAMES WATT

Дэлхийн түүхийн суут 100 хүн  
Зохиолч: Ч.Өлзийсайхан

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

# Хүн төрөлхтөний түүхийн чухал үйл явдлуудын товчоо

## Манай эриний өмнөх

3500 Шумерүүд бичиг үсэг зохиов

Мина хаан Египетийг нэгтгэв

3000 Дундад дорнодод ХҮРЭЛ ЗУУН эхлэв

Хеопс хаан пирамид бариулав

2500 Аккадийн Саргон хаан Шумерийг эзлэв

2000 Анхны цагаан толгой (эртний ханнаане?)

Вавилоний Хаммурап хаан хуулиуд гарав

1500 Египетийн Эхнатон хаан

Еврей зөнч Моисей; Еврейчүүд Египетээс гарав

Дундад Дорнодод ТӨМӨР дэлгэрэв

Трояны дайн

1000 Давид хаан Иерусалимийг захирч байв

ГОМЕР

Исаия

600 Хятадад төмөр зуун эхлэв

Ираны зөнч ЗОРОАСТР

Вавилончууд Иудеиг эзлэж Соломоны сүмийг нураав Энэтхэгийн шашны зүтгэлтэн  
МАХАВИРА Ираны ИХ КИР хаан Вавилоныг эзлэв БҮДДА

500 Күнз

Марафоны байлдаан

Софокл

Перикл

Геродот

Гиппократ Демокрит

400 Сократын үхэл ПЛАТОН

АРИСТОТЕЛЬ

АЛЕКСАНДР МАКЕДОНСКИЙ

ЛАО-ЦЗЫ

МЭН-ЦЗЫ

ЕВКЛИД

300 Ашока Аристарх Самосский

Архимед

ЦИНЬ ШИХУАНДИ хаан Хятадыг нэгтгэв

200 Пунинийн хоёрдугаар дайнд Ром Карфагенийг дийлэв

Лау Панг нь Хань угсааг үндэслэв.

Ромчууд Грекийг байлдан дагуулав

100 ЮЛИЙ ЦЕЗАРЬ Галлийг байлдан дагуулав

Ромын анхны хаан АВГУСТ ЦЕЗАРЬ

### **Манай эрин**

ХРИСТ цовдлуулав

НАЙДАН ПАВЕЛ-ийн сургаал, зохиолууд

100 ЦАЙ ЛУНЬ цаас бүтээв

Ромын эзэнт улсын цэцэглэлт, Гален Птоломей

200 Хятад улсад Хань угсааныхан мөхөв

Персийн зөнч МАНИ Месопотамид сургаал айлдав

300 Ромын анхны христос шүтлэгтэй хаан

## ИХ КОНСТАНТИН

Готын морин цэрэг ромын явган цэргийг дийлэв

400 Ромын эзэнт гүрэн мөхөв

## АМГАЛАН АВГУСТИН

Английг англосаксоныхан байлдан дагуулав

Баруун Ромын эзэнт гүрэн мөхөв

500 Ромын эзэнт гүрний ЮСТИНИАН хааны хуулиуд

СУЙ ВЕН ТИ Хятадыг дахин нэгтгэв

600 МАГОМЕТ лалын шашныг үндэслэв

Хоёр дахь халиф УМАР ИБН АЛЬ-ХАТТАБ; арабчууд Египет,

Перс, Иракийг байлдан дагуулав

700 Хятад улсад ном хэвлэлт хөгжлөө

Лалын шашинтнууд Испанийг эзлэв

Лалын шашинтнууд Францад ялагдав

Таны угсаа цэцэглэсэн

800 ИХ КАРЛ-ыг Ромд хаанаар өргөмжлөв

Аббасид угсааны Гарун аль-Рашид хаан

Багдадын эзэнт гүрэн цэцэглэв : Мамун

900 Викингүүд Европ руу халдан довтлов

Нормандад викингүүдийн улс байгуулагдав

1000 Лейф Эриксон

БАЙЛДАН ДАГУУЛАГЧ ВИЛЬГЕЛЬМ Английг эзлэв

ХАМБА ЛАМ УРБАН; загалмайтны аян дайны эхлэл

1100 Сум харвах зэвсэг дэлгэрэв

1200 Гуравдугаар Иннокентий. Католик шашин дэлгэрэв

Тэмүүжин ЧИНГИС хааны байлдан дагуулалт "Аугаа Тунхаглал" Монголчууд Оросыг эзлэв  
Фома Аквинский

Монголчууд Хятадыг байлдан дагуулав Монголчуудын хаанчлалын оргил үе

1300 СЭРГЭН МАНДЛЫН ЭХЭН

Марко Поло

Данте

Европт ИХ БУУ бий болов

Англичууд Кресийн дэргэд францийн торгон цэргийг бут ниргэв Европ тивд "Хар үхэл" болов

1400 Доголон Төмөр хаан Энэтхэг, Персийг үгүйрүүлэн хоосруулав

Далайчин Генрих Жанна д'Арк

1450 Алсын тусгалтай их буу бий болсноор цайз, хэрэм барьж хамгаалалт хийх нь утга учиргүй боллоо. Анхны галт зэвсэг үүсэв. Түрэгүүд Константинополийг эзлэн түрэмгийлэв

И.ГУТЕНБЕРГ ном хэвлэж эхлэв

1475 Фердинанд, ИЗАБЕЛЛА нар Испанийг нэгтгэв

Оросууд монголчуудын дарлалаас чөлөөлөгдөв

Х.КОЛУМБ америк тивийг нээв

1500 ВАСКО ДА ГАМА Энэтхэг хүрэх далайн замыг нээв

Леонардо да Винчи

МИКЕЛАНЖЕЛО

Н.МАКИАВЕЛЛИ

ҮНЭН АЛДАРТНЫ ШАШНЫ ШИНЭЧЛЭЛИЙН ЭХЛЭЛ М.ЛЮТЕР

Ф.Магеллан Э.КОРТЕС Мексикийг эзлэв

1525 Ф.ПИСАРРО Перуг эзлэв

Генрих ҮШ Ж.КАЛЬВИН

Н.КОПЕРНИК

1550 Англид ЭЛИЗАВЕТА хатан хааны хаанчлал эхлэв

Энэ үеэс цэргийн хэрэгт ГАЛТ ЗЭВСЭГ гол үүрэг гүйцэтгэх болов

1575 Английн далайн цэргийн флот Францийн тэнгисийн цэргийг бут цохив

1600 У.ШЕКСПИР-Эдуард Вер

Телекопийг зохион бүтээсэн

И.КЕПЛЕР ГАЛИЛЕЙ ФРЭНСИС БЭЖОН

Ла Маншийн хоолойн ойролцоох Плимут Рокийн эрэг дээр хүмүүс анх буув

1625 У.ГАРВЕЙ цусны эргэлтийн тухай нээлтээ хийв

Гучин жилийн дайны явцад Герман сүйрэв

Япон өрнөдөөс тусгаарлагдав

Р.ДЕКАРТ Рембрандт

Таж-Махалыг босгожээ

1650 Англид ИРГЭНИЙ ДАЙН дэгдэв: О.КРОМВЕЛЬ

1675 А.В.ЛЕВЕНГУК нян нээв

Англи дахь "Алдарт хувьсгал" болов

И.НЬЮТОН

Ж.ЛОКК

1700 ОРОСЫН НЭГДҮГЭЭР ПЕТР ХААН

Анхны уурын хөдөлгүүр

1725 ВОЛЬТЕР, францийн соён гэгээрлийн эхлэл

И.С.БАХ 1750 МОНТЕСКЬЕ

Ж.Ж.РУССО

Б.Франклин



ЛЕОНАРД ЭЙЛЕР

Англид АЖ ҮЙЛДВЭРИЙН ХУВЬСГАЛ эхлэв

1770 Ж.УАТТ уурын боловсронгуй хөдөлгүүр бүтээв

Т.ЖЕФЕРСОН, Тусгаар тогтнолын тунхаглал

А.СМИТ, түүний "Ардын баялаг" ном хэвлэгдэв

1780 Ж.ВАШИНГТОН И.Кант

АНУ-ын Үндсэн хууль батлагдав

Цахилгаан гүйдлийг тооцоолох хуулийг нээв

А.Л.ЛАВУАЗЬЕ ФРАНЦИЙН АУГАА ХУВЬСГАЛ эхлэв

В.А.Моцарт

1790 Э.ЖЕННЕР Т.МАЛЬГУС

1800 А.Вольт анхны цахилгаан хураагуур хийв

Н.БОНАПАРТ Ж.ДАЛЬТОН

1810 Ватерлоогийн тулалдаан болов. Л.В.БЕТХОВЕН

Давид Рикардо

1820 Англи Энэтхэгт хаанчлалаа тогтоов

С.БОЛИВАР Бойжийн дэргэд болсон байлдаанд ялалт байгуулав 1830 Төмөр зам дэлгэрч эхлэв

М.ФАРАДЕЙ цахилгаан соронзон индукцийг нээв

Телеграф зохион бүтээгдэв

1840 Л.ДАГЕР гэрэл зураг авах аргыг зохион бүтээв

У.Т.Ш.МОРТОН мэдээ алдуулах аргыг хэрэглэж эхлэв

1860 Э.Ленуар дотоод шаталтат хөдөлгүүр зохион бүтээв

Ч.ДАРВИН "Төрлийн үүсэл" номоо хэвлүүлэв

АНУ-д иргэний дайн болов: А.Линкольн

Ж.МАКСВЕЛЛ Г.МЕНДЕЛЬ

к.МАРКС Ж.ЛИСТЕР

1870 Японд мэйжийн хувьсгал гарав

Л.ПАСТЕР

Н.А.ОТТО дөрвөн шаталбарт дотоод шаталтат хөдөлгүүр зохион бүтээв.

А.Г.БЕЛЛ телефон утас зохион бүтээв

1880 Т.ЭДИСОН чийдэн бүтээв

1890 Британийн эзэнт гүрний цэцэглэлт

Г.Даймлер, К.Бенц нарын бүтээсэн хөнгөн тэргийг худалдаж эхлэв

Кино бий болов РЕНТГЕН цацрагийг нээв

А.А.Беккерель цацраг идэвхт чанарыг нээв

Г.МАРКОНИ радио зохион бүтээв

1900 ЗИГМУНД ФРЕЙД МАКС ПЛАНК

АХ ДҮҮ РАЙТ-ууд нисэх онгоц зохион бүтээв

А.ЭЙНШТЕЙН тусгай харцангуйн онолоо томьёолов

ГЕНРИ ФОРД "Модель Т" загварын хөнгөн тэрэг бөөнөөр үйлдвэрлэж эхлэв

1910 Э.РЕФЕРФОРД атомын цөмийг нээв

Дэлхийн нэгдүгээр дайн, хорт хий, танк хэрэглэж эхлэв

Оросын хувьсгал: В.И.ЛЕНИН

1920 Квант механик: В.ГЕЙЗЕНБЕРГ, де Бройль

Шредингер

А.ФЛЕМИНГ пенициллин нээсэн

1930 П.Пикассо

И.В.СТАЛИН Ф.Рузвельт

А.ГИТЛЕР Ж.М.Кейнс

1940 Дэлхийн хоёрдугаар дайн

Э.ФЕРМИ анхны цөмийн хурдасгуур бүтээв Анхны компьютерийг үйлдвэрлэв АТОМЫН БӨМБӨГ

Транзистор зохион бүтээгдэв (Б.Шокли нар)

1950 МАО ЗЕДУН ЗУРАГТ-ын эрин үеийн эхлэл Устөрөгчийн бөмбөг

Ф.Крик, Ж.Д.Уотсон нар ДНК-ийг бүтцийг тодорхойлов Ж.ПИНКУС жирэмслэлтээс хамгаалах арга бий болгов

1960 Лазерийн туяа

Ж.КЕННЕДИ "Аполлон" төсөл хэрэгжүүлж эхлэв "Аполлон-11" хөлгөөр ХҮН САРАН ДЭЭР БУУВ.

1970 Вьетнамын дайн

Хиймэл генийг нянд суулгав

1980 М.С.ГОРБАЧЁВ

1990 Дорнод Европт зөвлөлтийн ноёрхол дуусав ЗХУ коммунист онолоос татгалзаж задран унав Хүйтэн дайн төгсөв.

# 1. Магомет

(MUHAMMAD)

570-632



Лалыншашныг үндэслэгч Магомет бол шашны салбарт төдийгүй иргэний талбарт гарамгай амжилт гаргасан түүхэн дэх цорын ганц аугаа хүн билээ.

Нийгмийн хамгийн доод давхраанаас гаралтай боловч дэлхий нэгэн том шашны сургаалыг бий болгосон төдийгүй ер бусын амжилтанд хүрсэн улс төрийн зүтгэлтэн юм.

Ертөнцийн мөнх бусыг үзүүлээд 14 зууны хугацаа өнгөрсөн ч өнөө үед түүний сургаалын нөлөө улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Худалдаа, гар урлал, боловсрол гэгээрлийн төвүүдээс алсад орших Мекка хотод 570 онд төрж зургаан настайдаа өнчирч ядуу зүдүү амьдралд өсөж том болжээ. Гэвч 25 настайдаа баян бэлэвсэн бүсгүйтэй гэрлэж материаллаг байдлаа дээшлүүлжээ. Тэр үед арабууд олон бурхан шүтдэг байсан ба Меккад байсан иуд, христос шүтлэгтэнгүү- дээс Ертөнцийн эзэн болох нэгдмэл хүчирхэг бурхны тухай анх сонсож мэдсэн бололтой.

Дөчин нас хүрсэн үедээ цорын ганц жинхэнэ бурхан Аллах найдан Гавриилаар дамжуулан биечлэн ярьж хүмүүсийн дунд жинхэнэ итгэл үнэмшлийг түгээн дэлгэрүүлэхээр өөрийг нь сонгожээ гэсэн итгэлийг олж авчээ.

Шинэ шашныг эхний гурван жил хамаатан садан, анд нөхдийн дунд сурталчилж байгаад дараа нь олны өмнө түгээн дэлгэрүүлэх болжээ.

Удсангүй түүнийг дэмжигчид олон болж ирэхэд засаг захиргаа гадуурхаж эхэлжээ. Тиймд Магомет Меккагээс холгүй Мединд дүрвэж тэнд нэр хүнд нөлөөгөө өргөжүүлж хязгааргүй эрх мэдэлтэй захирагч болов. Үүнээс үүдэн Мекка, Медин хоёр хотын хооронд цэргийн

мөргөлдөөн гарсан нь хэдэн жил үргэлжилж 630 онд Магомет Меккад ялагчаар заларснаар дуусчээ. Түүний дараагийн хоёр жил хагасын хугацаанд арабын омгууд цөмөөрөө шинэ шашинд оржээ. 632 онд Магомет нас барах үедээ нийт Өмнөд Арабын захирагч болсон байлаа.

Түүхэндээ Магометийн ачаар нэгдсэн, жинхэнэ Бурханд итгэсэн бат итгэлээр зоригжсон арабын бедуин омгийн цөөхөн тооны цэрэг хэд дахин илүү цэргийг бут цохиж Месопотами, Сири, Палестинийг эзлэж Византийн эзэнт гүрний эрхшээлийг Египетийг салгаж Персийн цэргийг хиад цохижээ. Магометийн дотнын анд, үйл хэргийг нь үргэлжлүүлэгч Абу Бекра, Омара нар 711 онд Умард Африкийг байлдан дагуулж Энэтхэгийн хилээс Атлантын далай хүртэлх асар уудам нутгийг мэдэлдээ авчээ. Тэд эзлэсэн газар нутагтаа шинэ шүтлэгээ түгээн дэлгэрүүлсээр явжээ. Тэд христос шашны шүтлэгтэй Европ тив рүү уулгалан довтолж Испанийг уландаа гишгэж Францийн газар нутгийн талыг эзлэсэн боловч тэдний цэрэгт бут цохигдон ухарчээ.

Магомет бол лалын шашны сургаал, ёс суртахууны эх суурийг тавьсан хүн төдийгүй энэ шашныг бишрэн шүтэгчдийн тоог нэмэгдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн юм. Тэрбээр лалын шашны зарчмуудыг амьдралд хамгийн түрүүнд хэрэгжүүлсэн юм. Лалын шашны гол номлол болох Коран судрыг зохиосон юм. Гэхдээ Коран судрыг түүнийг нас барсны дараа төгс хэлбэрт оруулсан байна. Коран судар нь араб хэл дээр бичигдсэн болохоор энэхүү хэлийг өнгөрсөн арван гурван зууны хугацаанд хэд хэдэн аялга болон хуваагдахаас хамгаалж чадсан юм.

Өнөөдөр лалын шашин Африк, Төв Ази, Пакистан, Энэтхэгийн умард хэсэг төдийгүй дэлхий дахинаар тархжээ. Лалын шашин дэлхийн бусад шашны адил шүтэн бишрэгчдийнхээ амьдралд асар их нөлөө үзүүлсэн хэвээр байна.

Магомет бол шашны онолч төдийгүй төрийн зүтгэлтэн байсан юм.

Түүний удирдлага дор ҮШ зуунд явагдсан арабын байлдан дагуулалтын үр дүнд нэг шашин төдийгүй нэг хэл, түүх, соёлоор холбогдсон нь шашны болон улс төрийн томоохон нэгдэл бий болсон нь одоо ч хүн төрөлхтөний амьдралд голлох нөлөө үзүүлсэн хэвээр байна.

Өнөө үед дэлхий дахинд лалын шашин шүтэгчид христосын шашин шүтэгчдээс тооны хувьд хоёр дахин бага байгаа боловч лалын шашны хөгжилд Магометын оруулсан хувь нэмэр христос шашны хөгжилд Христосын оруулсан хувь нэмрээс үлэмж их ажээ. Христос нь христос шашны ёс суртахуун, гүн ухааны үндсийг тавьсан боловч чухамдаа найдан Павел христос шашны сургаал бий болоход голлох хувь нэмэр оруулж Шинэ Гэрээний ихээхэн хэсгийн зохиож шүтэн бишрэгчдийн тоог нэмэгдүүлэхэд үнэлж баршгүй их үүрэг гүйцэтгэсэн юм. Чухам ийм учраас энэхүү номонд Магометийн намтар Есус Христосынхоос түрүүнд нь байгаа юм.



## 2. Исаак Ньютон

(ISAAC NEWTON)

1642 -1727



Дэлхийн шинжлэх ухааны хөгжилд хамгийн их нөлөө үзүүлсэн суут эрдэмтэн Исаак Ньютон Английн Вулсторп хотод 1642 онд эцгийнхээ нас барсны дараа мэндэлжээ. Дунд сургуульд таруухан дүнтэй суралцаж байсан боловч механикт сэтгэлээ өгсөн байлаа. Эх нь хүүгээ хөдөө ажиллуулахаар сургуулиас гаргасан боловч түүний гоц авьяас чадвартайг мэдмэгц 18 нас хүрэхэд нь Кембрижийн их сургуульд элсүүлжээ. Их сургуульд суралцаж байхдаа И.Ньютон математик,, байгалийн шинжлэлийн салбар дахь мэдэгдэж байгаа бүх зүйлийг судалж хажуугаар нь бие даан шинжилгээ судалгаа хийж байв. Дэлхийн шинжлэх ухаанд эргэлт болсон онолуудынхаа үндсийг 21-27 настайдаа гаргажээ.

ХҮИ зууны дунд үе шинжлэх ухааны үсрэнгүй хөгжлийн зурвас үе байлаа. Гарвей цусны эргэлтийн тухай, Кеплер нарыг тойрч гаригууд эргэлддэг тухай нээлтүүдээ хийж мөн зууны эхэнд Галилей телескоп нээсэн нь одон орны судлалд шинэ үе шат болж английн гүн ухаантан Ф.Бэкон, францийн гүн ухаантан Р.Декарт европийн эрдэмтдэд хандаж Аристотелийг сохроор бишрэн шүтэхээ больж өөрсдөө туршилт хийхийг уриалж байлаа.

# 3. Есус Христос

(JESUS CHRIST)

(Манай эриний өмнөх 6 оноос танай эриний 30 он)



Хүн төрөлхтөний түүхэнд Есус Христосын үзүүлсэн нөлөө зүйргүй их билээ. Христосын шашин бий болсон цагаасаа хойшхи түүхэндээ бусад аль ч шашнаас илүү шүтэн бишрэгчидтэй болсон юм. Лалын шашныг нэг хүн бий болгосон бол христосын шашныг Есус, Павел гэдэг хоёр хүн үндэслэсэн ба тэр цаглашгүй их гавьяа нь хоёуланд нь хамааралтай юм.

Христосын шашны ёс суртахууны үндсэн үзэл санаа түүний ертөнцийг үзэх үзэл, хүмүүс хоорондын харилцааны гол зарчмуудыг Есус тодорхойлсон ажээ. Харин христосын шашны сургаалыг нь Павел бүтээлдээ тусгасан юм. Есус ёс суртахууны илгээлтийг бичсэн бол Павел христос шашныг бишрэн шүтэх үзлийг түгээн дэлгэрүүлсэн юм. Найдан Павел нь Шинэ Гэрээний дийлэнх хэсгийг бичсэн төдийгүй энэ шашин үүссэн анхны зуунд христосын шашныг бишрэн шүтэгчдийг татах гол хүч болж байсан билээ.

Есус харьцангуй залуугаараа ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн ч түүний үндэслэсэн шашин еврейчүүдийн хэсэгхэн бишрэн шүтэгчдээс дэлхийн олон үндэстэн ястныг эгнээндээ нэгтгэсэн хүчирхэг хөдөлгөөн болон өргөжсөөр дэлхийн аугаа том шашин болж чадсан түүхтэй юм.

Есус Христосын намтар Шинэ Гэрээнд бүрэн эхээрээ байдаг учир түүнийг энд давтах нь илүүц байх гэж бодож байна. Гэвч түүний намтрын зарим хэсгийг тайлбарлахад илүүдэхгүй. Есусын тухай одоогоор бидэнд мэдэгдэж байгаа бүх мэдээллийг барим тавим яг таг үнэн гэж хэлэх бас хэцүү. Жинхэнэ нэр нь Есус гэдэгт ч заримдаа бүрэн итгэхэд хэцүү байдаг, Еврейчүүдийн дунд өргөн дэлгэрсэн Yehosyua (англиар Джошуа) гэдэг нэртэй ч байсан байх. Төрсөн оны хувьд бол бас тодорхойгүй, гэхдээ манай эриний өмнөх 6 онд төрсөн гэдэг нь

лавгай. Есус өөрийнхөө тухай ямар нэгэн бичмэл мэдээлэл үлдээгүй болохоор Шинэ Гэрээнд байгаа мэдээллээр л бид түүний намтрыг ойлгодог.

Есусын тухай бид ярихдаа Хуучин Гэрээнээс ишлэл татдаг нь жирийн хэрэг биш. Христосын шашныг үндэслэгчийн хувьд бурханд гүн биширдэг еврей хүн байжээ. Есус нь Хуучин Гэрээнд гардаг эртний еврейн зөнчидтэй маш адилхан байсан төдийгүй тэдний гүн нөлөөнд байсан тухай олонтаа бичиж ярьдаг. Есус нь аливаа зөнчийн адил гарамгай хүн байсан төдийгүй уулзаж ярилцаж байсан хүмүүстээ гүн гүнзгий мартагдашгүй сэтгэгдэл төрүүлдэг байжээ. Жинхэнэ Бурхны авьяас чадвартай хүн байжээ.

Есус Христос нь түүхэнд шашны тэргүүний хувьд асар их ул мөр үлдээсэн хүн юм бол түүний баримталж байсан ёс суртахууны хэм хэмжээ хүн төрөлхтөнд ямар нөлөө үзүүлсэн бэ? гэдэг асуудал зүй ёсоор тавигдана. Есусын гол сургаалуудын нэг нь мэдээж Алтан дүрэм юм. Христос шашныг бишрэн шүтэгчид төдийгүй эс бишрэн шүтэгчид ч гэсэн Алтан дүрмийг зан заншлын ёс суртахууны үнэхээр бахдам сайхан гарын авлага гэж үзсээр ирсэн юм. Бид өдөр тутмын амьдралдаа Алтан сургаалыг чанд, бүрэн баримталж чаддаггүй ч тэнд зааснаар байхыг хичээдэг билээ. Тэхлээр Есус нь бид бүхний өдөр тутмын амьдралдаа баримталдаг ёс суртахууны хэм хэмжээний өвөг эцэг лавгай мөн. Алтан дүрэмд тусгасан гүн ухааныг дэлхийн бараг бүх шашин хүлээн зөвшөөрдөг.

Хуучин Гэрээнд "Ойр дотнын хүнээ хайрла, өстөн дайснаа үзэн яд" гэж бичсэн бий. Тэгвэл Шинэ Гэрээнд "Өстөн дайснаа хайрла, Таныг хараан зүхэж байгаа хүмүүсийг бишрэн шүт, Таныг үзэн ядаж байгаа хүмүүст буян үйлд, Таныг гомдоож байгаа Таныг хөөн тууж байгаа хүмүүсийн төлөө мөргө ... Муу үйлийг бүү эсэргүүц, гэхдээ баруун хацрыг чинь алгадсан хүнд зүүн хацраа алгадуул." гэж сургасан байна. Энэ бол буурал түүхийн туршид хүн төрөлхтөнд санал болгож байсан хамгийн шилдэг, хамгийн өвөрмөц ёс суртахууны хэм хэмжээ билээ. "Өстөн дайснаа хайрла." гэдэг сургаалийг дийлэнх христос шашин шүтэгчид ямар нэгэн боловсронгуй ертөнцөд хэрэгжих зүйл юм шиг ойлгож түүнд тэмүүлдэг, уг нь бол бид бүхэн амьдарч байгаа энэ бодит хорвоо дэлхийд хүмүүсийн баримталж явах ёстой ухаалаг зарчим юм. Чин үнэнийг хэлэхэд бид эдгээр сургаалийг нийгмийн өдөр тутмын амьдралд хэрэгжүүлэхгүй, бусдаас тийм хандлагыг хүлээхгүй, хүүхдүүдээ ч ийм сургаалиар хүмүүжүүлэхгүй байна шүү дээ. Иймд Есусын хамгийн гол сургаал нь сэтгэл татам ч амьдралд үндсэндээ хэрэгжихгүй байгаа хүсэл тэмүүлэл болж байна.

# 4. Будда

(BUDDHA)

(Манай эриний өтнөх 563 - 483 он)



Анх Сиддхартха Гаутама гэсэн нэртэй байсан Гуатама Будда нь дэлхийн аугаа том шашнуудын нэг болох буддын шашныг үндэслэсэн гавьяатай суут хүн билээ.

Энэтхэгийн шакьев омгийн удирдагч Гуатама хааны удмаас гаралтай Сиддхартха нь манай эриний өмнөх барагцаалбал 563 онд өнөөгийн Балба улсын нутагт орших Лумбини хотод төржээ. Түүнийг 16 настай байхад нь мөн адил настай үеэл дүүтэй нь гэрлүүлжээ.

Хунтайж Сиддхартха хааны тансаг ордонд өсөж бойжсон ч гэсэн эд хөрөнгөнд шуналгүй, орчин тойрны амьдралдаа дургүйцдэг хүн болон хүмүүжжээ. Дийлэнх хүмүүс ядуу зүдүү амьдарч байнга гачигдал зовлонтой байгааг харж сэтгэл гүнээ зовдог байлаа. Баян хүмүүс ч гэсэн амьдралд гуниж гутардаг, хүмүүс өвчин эмгэгт нэрвэгдээд бөөнөөр үхэж үрэгдэж байгааг мэдээд байх суух газраа олж яддаг байлаа. Хорвоо дэлхийд байгаа зовлон зүдгүүр, үхэл хагацалтай харьцуулахад дэндүү агшин зуурын жаргал цэнгэлээс илүү эрхэм зүйл хүний амьдралд байх ёстой гэсэн бодол Сиддхартхын санааг зовоож байлаа.

Сиддхартха анхны хүүхэд нь мэндэлсний дараа 29 настай байхдаа баян тансаг амьдралаа хаяж хойшдын амьдрал хөдөлмөрөө үнэнийг олоход зориулахаар эргэлт буцалтгүй шийдэв. Тэгээд ордон, эхнэр, дөнгөж төрсөн хүүхэд, бүх эд баялгаа орхиж дэлхий ертөнцөөр хэрэн тэнүүчлэхээр халаас хоосон замд гарчээ. Тухайн үеийнхээ нэртэй зөнч нараас хэсэг суралцсан боловч олж авсан мэдлэг нь амьдрал хүний өмнө тавьж байгаа асуудлыг шийдвэрлэхэд хангалтгүй болохыг ойлгожээ.

Тэр цаг үед даяанчлан амьдрах нь жинхэнэ үнэнийг олох арга зам гэсэн үзэл өргөн дэлгэрсэн байсан тул Гуатама хэдэн жилийн турш өлсгөлөн байж даяанчлан суусан ч бие бялдраа зовоож оюун ухаан нь улам доройтож байгааг ойлгож дахин хэвийн байдлаар хооллох болж

даяанч амьдралаа больжээ. Гэвч хүмүүсээс жожиг амьдарч байхдаа хүмүүсийн аж төрөх асуудлыг шийдвэрлэхийг оролджээ. Нэгэн шөнийг инжрийн модны дор гүн бодолд автан өнгөрөөж өглөө болоход өчнөөн олон жил зовоосон бодол санаа нь гэнэт тайлагдаж "гэгээрсэн хүн" буюу Бүдда болон хувирчээ.

Энэ үед Сиддхартка 35 настай байсан ба үүнээс хойшхи амьдралынхаа 45 жилийг Умард Энэтхэгт өөрийн шинэ гүн ухааныг сурталчлан дэлгэрүүлэхэд зориулжээ. Буддагийн сургаал цаасан дээр бичигдээгүй боловч түүнийг бишрэн шүтэгчид дараачийн үеүүддээ аман хэлбэрээр дамжуулж иржээ.

Буддын гол сургаал нь "Дөрвөн үнэн"-ээс бүтнэ. Үүнд нэгдүгээрт хүний амьдрал өөрийн мөн чанараараа аз жаргалгүй амьдрал хоёрдугаарт энэхүү зовлонг амьдралын шалтгаан нь хүний амиа хичээсэн бодол санаа, хүсэл эрмэлзлэл юм, гуравдугаарт хувь хүний амиа хичээсэн бодол санаа, хүсэл эрмэлзлэлийг даван туулж болно, үүнийг нирваан болох буюу амиа хичээсэн бодол санаа, хүсэл эрмэлзлэлийг үгүй хийх гэж ойлгоно, дөрөвдүгээрт "Найман бясалгал" буюу зөв итгэл үнэмшил, зөв сэтгэлгээ, зөв яриа, зөв үйлдэл, зөв аж төрөх ёс, зөв чармайлт, ногдсон үүрэгтээ зөв хандах, гүн бясалгал ажээ. Буддын шашны гол онцлог гэвэл хүмүүсийн арьс өнгөнөөс хамааралгүй хэн ч түүнийг шүтэж болно, индуизмын шашинтай харьцуулбал дотроо давхрагын ялгаа байхгүй.

Гаутамаг нас барсны дараа түүний зохиосон шашин маш удаан удаан тархаж байсан боловч манай эринээс өмнөх гуравдугаар зуунд Энэтхэгийн хаан Ашока тус шашинд орсноор Энэтхэг болон хөрш орнуудад ихээхэн хурдацтай дэлгэрсэн билээ. Дараа нь Цейлон, Балба, Малайз, Индонез, Түвд, Афганистан, Хятад, Солонгос, Япон зэрэг орнуудад дараалан дэлгэрчээ. Өнөөгийн байдлаар дэлхийд хоёр зуун сая орчим хүн бүддийн шашныг бишрэн шүтэж байна. Далимд дурдахад христосын шашныг нэг тэрбум, лалын шашныг таван зуун сая хүн бишрэн шүтдэг гэсэн судалгаа бий.

Буддын шашин нь гол хоёр урсгалтай. Тхеравади урсгал нь Өмнөд Азийн орнуудад ихээхэн дэлгэрсэн ба барууны эрдэмтдийн үзэж байгаагаар Буддын шашны анхны сургаалтай их ойрхон, Махаяны урсгал нь Төвд, Хятад, Умард Азид нөлөө ихтэй ажээ.

Бүддийн шашинд дайн байлдаан, хүчирхийллийн эсрэг үзэл зарчмын байр суурь эзэлдэг болохоор тус шашныг шүтдэг орнуудад христос шашинтнуудын хооронд болж байсан шиг олон цуст дайн, байлдаан огт болж байгаагүй юм.

Бүдда, Күнз хоёр хүн төрөлхтөний хөгжилд адилхан нөлөө үзүүлсэн гэж үздэг. Тэд нэг үе амьдарч байсан төдийгүй шүтэн бишрэгчдийн тоо нь бараг ойролцоо байжээ. Гэхдээ дараах хоёр шалтгаанаар Бүддийн сургаалыг илүү гэж үзэж байгаа юм. Нэгдүгээрт Хятад улсад коммунист үзэл санаа дэлгэрснээр Күнзийн сургаалын хүрээ хумигдсан, хоёрдугаарт Күнзийн сургаал Хятадаас гадагшаа бараг дэлгэрээгүй гэж үзэж болно. Түүнээс гадна бүддийн шашин нь энэтхэгийн өмнөх үеийн гүн ухааны хуулбар юм уу давгалт биш ба Гуатамагийн өвөрмөц үзэл сургаал, бишрүүлэн татах гүн ухааныхаа үр дүнд дэлхийн олон оронд дэлгэрсэн билээ.



# 5. Күнз

(CONFUCIUS)

(Манай эриний өтнөх 551-479)



Хятадын аугаа гүн ухаантан Күнз бол хятадын ард түмний бодол санааг нэгтгэж итгэл үнэмшлийн цогц болгож чадсан анхны хүн билээ. Бие хүн ёс суртахууныг удирдлага болгон ард түмэндээ үйлчилж өөрийн ёс суртахууны үлгэр жишээгээр ард түмнээ удирдаж байдаг удирдагчийн эрх мэдлийн үзэл санаанд тулгуурласан түүний гүн ухаан хоёр мянга гаруй жилийн туршид хятадын ард түмний амьдрал, хятадын соёлыг тэтгэж дэлхийн хүн амын дийлэнх хэсэгт ихээхэн нөлөө үзүүлсээр байна.

Күнз манай эриний өмнөх 551 онд Хятад улсын зүүн хэсэгт орших өнөөгийн Шаньдун мужийн нутагт Лу нэртэй бяцхан хаант улсад мэндэлжээ. Эцэг нь эрт нас барсан учир эхтэйгээ цуг ядуу зүдүү амьдарч байв. Залуудаа төрийн албанд хэдэн жил зүтгээд больсон байна. Дараачийн 16 жилийн туршид багшлах ажил эрхэлж олон хүнийг өөрийн гүн ухаанд сурган итгүүлжээ. Тавин настайдаа Засгийн газарт өндөр албанд томилогдсон боловч дөрвөн жилийн дараа дайснууд нь түүнийг огцруулж хаант улсаас нь хөөж чаджээ. Ингээд 13 жил тэнүүлчлэн багшийн ажил эрхэлж байгаад төрсөн нутагтаа ирж таван жил амьдраад ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ.

Зарим судлаач Күнзийг шинэ шашин зохиосон гэж үздэг нь буруу. Тэр Бурхнаас иш татаж байгаагүй, үхлийн дараах амьдралын тухай маргалдахаас зайлсхийж хүний толгойг эргүүлэх элдэв томъёоллыг бүтээл туурвилдаа хэрэглэдэггүй байсан юм. Энэ утгаараа бие хүн болон улс төрийн ёс суртахуун, хүний зан чанарын асуудлыг судалдаг гүн ухаантан байсан юм.

Амьдралд "жэнь", "ли" гэсэн хоёр сайн үйл бий, сайхан сэтгэлтэй хүн энэ хоёр сайн үйлийг зан чанартаа мөрдлөг болгоно гэж Күнз үздэг байв.

"Жэнь" гэдэг үгийг хайр энхрийлэл юм уу, ойр дотнын хүндээ сайн хандах гэж ойлгож болно. "Ли" гэдгийг нь биеэ авч явах чадвар, зан заншил, ёс дэг, зан чанарын цогц гэж ойлгоно.

Өвөг дээдсээ бишрэн шүтэх үзэл нь Күнзээс өмнөх хятадын гол шашин байсан ба гэр бүлийн

журамт ёс, эцэг эхээ хүндэтгэх үзлийг номлодог аж. Күнз ч гэсэн эмэгтэйчүүд авааль нөхрүүддээ, албат иргэд харьяалах удирдагч нартаа хүндэтгэлтэй хандаж, дуулгавартай байх ёстой гэж үздэг байлаа. Гэхдээ хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөггүй, төр засаг бол хүмүүсийн сайн сайхны төлөө л оршин тогтнодог юм гэж сургаж, удирдагч хүн хүч түрэмгийлж биш, ёс суртахууны үлгэр жишээгээр харьяат албат иргэдээ удирдах ёстой гэж олонтаа давгддаг байлаа. "Өөрийн хүсэхгүй байгаа зүйлээ бусдаар бүү хийлгэ." гэсэн зарчмыг баримтлах нь зүйтэй гэж Күнз хэлдэг байв.

Күнзийн үзэл бодлын гол сургаал нь хуучинсаг шинж чанартай байдаг юм. Дээр үед Алтан сайхан зуун байсан, иймд ард түмэн төдийгүй удирдагч нарт урьдын ёс суртахууны шилдэг үлгэр жишээг дагахыг уриалж байв.

Күнз Хятад улсад оюун санааны их эрэлхийллийн жилүүд болох Чжоу удмын хаанчлалын үед амьдарч байсан ба тухайн үеийн удирдагчид түүний сургаалыг үл ойшоож байсан ч төдөлгүй улс орон даяар өргөн дэлгэрчээ. Гэвч манай эриний өмнөх 221 онд төрийн эрхэнд Цинь удмынхан гараад Күнзийн сургаалыг хориглож, бүх номыг нь шатаах хүртэл эрс хагуу арга хэмжээг авчээ.

Манай эриний өмнөх 220 онд Хань угсааныхан төрийн эрх авсны дараа Күнзийн сургаалыг Хятад улсын албан ёсны шашин болгон өргөмжилсөн байна. Энэ үеэс хятадын хаад төрийн албанд түшмэд сонгон авахдаа "төрийн алба" гэдэг сэдвээр шалгалт авдаг болсон ба хэсэг хугацаа өнгөрөхөд уг шалгалтын үндэс суурь нь Күнзийн сургаал болсон байлаа. Хятадын эзэнт гүрэнд төр засгийн хүнд сурталт албанд орсноор нийгэмд эзлэх байр суурь дээшилж, хөрөнгөжих бололцоо нээгддэг байсан тул "төрийн алба"-ны сэдвээр өгөх шалгалтын гол ноён нуруу болох Күнзийн сургаалыг мэдэхийн төлөө тэмцэл залуучуудын дунд хүчтэй өрнөсөн учиртай. Иймд Күнзийн сургаалд боловсорсон хүмүүс Хятадын иргэний засаг захиргааны албыг нийтдээ бараг хоёр мянга шахам жил нуруундаа үүрч явна. Күнзийн сургаал хятадын засаг захиргааны албан ёсны гүн ухаан байсан төдийгүй тус улсын дийлэнх иргэдийн ертөнцийг үзэх үзэл болж тэдний амьдралд гүн нөлөө үзүүлсээр ирсэн юм.

Күнзийн сургаалыг хятадын ард түмэн яагаад хүлээн зөвшөөрч шүтэн биширч ирэв? Үүнд юуны түрүүнд Күнз хүнийхээ хувьд үнэнч шудрага, бодол саналаа чин сэтгэлээсээ тас түс хэлдэг хүн байжээ, тэрчилэн даруу төвшин, амьдралын хар бор ухаанд төгс хүн төдийгүй аливаа хүнээс хэрээс хэтэрсэн зорилгод хүрэхийг шаарддаггүй нэгэн байжээ. Күнз хүнээс шудрага байхыг шаардахдаа түүнийг өөгүй тэгш хүн болоосой гэж ер боддоггүй байлаа. Күнз өөрийн ард түмнээс хорвоо дэлхий, амьдралын тухай гол үзэл бодлоо өөрчлөхийг шаардаагүй, харин түүний уламжлалт үзэл бодлыг нь илүү ойлгомжтой шинээр томъёолж өгсөн гавьяатай хүн.

Күнзийн сургаал нь хүний эрхээс илүү үүрэгт нь илүү анхаарахыг сургадаг нь өнөө үед хоцрогдсон юм үзэл баримтлал шиг санагдаж болзошгүй юм. Гэвч түүний боловсруулсан удирдлагын гүн ухаан нь маргашгүй үр дүнтэй болохыг төр нь улс орныхоо дотор эв энхийг сахиулж хөгжил цэцэглэлтийг нь хангасаар байгаа хятад улсын хоёр мянга гаруй жилийн түүх бэлхнээ нотолж байна.

Күнзийн сургаал нь хятадын соёл урлагт гүн нэвтэрсэн ч Дорнод Азийн орнуудад сүртэй

нөлөө үзүүлээгүй юм. Гэхдээ хятадын соёлын нөлөө их байдаг Япон, Солонгосын түүхэнд тодорхой үүрэг гүйцэтгэсэн юм. Хятадын коммунистууд өнгөрсөн үеэ басамжлан гоочлох үзэл сурталдаа хөтлөгдөн Күнзийн сургаалын нөлөөг багасгаж чадсан ч энэ шинэ зуунд энэ сургаал хятадын хөрс сууриндаа дахин сэргэн хөгжихийг үгүйсгэх аргагүй юм аа.

# 6. Найдан Павел

(ST.PAUL)

(Манай эриний 4 - 64 он)



Есус Христостой нэгэн үед амьдарч байсан найдан (Христийн 12 найдангийн нэг билээ.) Павел нь христосын шашны сургаалыг хамгийн гарамгай түгээн дэлгэрүүлэгч байсан билээ. Христос шашныг шүтдэг бусад зохиолч, сэтгэгчтэй харьцуулахад энэ шашны сургаалд түүний үзүүлсэн нөлөө урт хугацаатай байсан төдийгүй хамгийн их үр дүнтэй байжээ.

Анх Савл нэртэй байсан Павел Сицилийн арлын Тарсус хотод төржээ. Ромын иргэн байсан боловч еврей үндэстэн, багадаа иврит шашныг талархдаг байжээ. Есусын адил Иерусалим хотод амьдарч байсан боловч тэд тааралдан уулзалдаж байсан эсэхийг одоо тааж хэлэх хэцүү юм.

Есус Христосыг нас барсны дараа анхны христос шүтлэгтнүүдийг тэрс үзэлтэн гэж гадуурхаж мөшгөн мөрдөж байжээ. Тэдний дотор Павел ч байжээ. Гэвч Павел Дамаск хотод аялал хийж очоод шинэ шашныг бишрэн шүтэгч болжээ. Ийнхүү христос шашныг эсэргүүцэгч маань шинэ шашны хамгийн нөлөө бүхий түгээн дэлгэрүүлэгч болон хувирчээ. Үлдсэн бүхий л амьдралаа христос шашны их шашдир туурвих, илүү олон бишрэн шүтэгчдийг бий болгоход зориулсан хосгүй гавьяатай хүн билээ. Шинэ шашныг сурталчилж Бага Ази, Грек, Сири, Палестин орнуудаар аялал хийлээ. Шинэ сургаалаа сурталчилж байгаад нь еврейчүүд дургүйцэж амь насыг нь бүрэлгэх гэж хэдэнтээ оролдоод бүтэлгүйтжээ. Харин еврей бус хүмүүсийн дотор сурталчилгаа явуулахад айх аюулгүй байсан ба түүнийг "еврей бусчуудын найдан" гэж хүндэтгэн нэрлэж байв.

Павел Ромын эзэнт гүрний дорнод хэсэгт гурван жил аялал хийгээд Иерусалим хотод буцан ирэхэд түүнийг баривчлан Ром хотод хүргэж манай эриний 64 онд цаазалжээ.

Христосын шашны хөгжилд Павелийн гүйцэтгэсэн маргашгүй их үүргийг дараах байдлаар тайлбарлаж болно. Нэгдүгээрт аялал хийж сурталчилгаа явуулахдаа ихээхэн амжилтад хүрсэн, хоёрдугаарт "Шинэ Гэрээ"-ний дийлэнх хэсэг болох "Илгээлтүүд"-ийг зохиосон, гуравдугаарт христос шашны онолыг хөгжүүлэхэд зүйргүй их хувь нэмэр оруулжээ.

27 номоос бүрдэх "Шинэ Гэрээ"-ний бараг 14 номыг нь Павелийг зохиосон гэж үздэг. Эдгээр номуудын дөрөв юм уу тавыг нь л өөр хүмүүс бичсэн болохоор "Шинэ Гэрээ"-г гол зохиогч нь яах аргагүй Павел мөн гэж орчин үеийн судлаачид үзэж байна.

Христос шашны онолд түүний үзүүлсэн нөлөө асар их билээ. Есус бол сэтгэл санааг эзэмдэгч зөнч төдийгүй Бурхны хүү, Христос бидний нүглийн төлөө үхсэн, түүний эдэлсэн зовлон биднийг аварна, хүн аврагдахын тулд библийн сургаалийг дагах ёстойгоос гадна Христос шашныг чин сэтгэлээсээ бишрэн шүтэх шаардлагатай, хүн хэрвээ Христосыг хүлээн зөвшөөрч түүнийг дагавал түүний нүгэл уучлал хүлээнэ гэх зэрэг Илгээлтүүдийг туурвисан юм. Тэрчилэн нүгэл анх хэрхэн үйлдэгдсэн тухай сургаалиудыг боловсруулжээ.

Павел гэр бүлгүй байсан нь эмэгтэй хүнтэй ер хавьтаж байгаагүй гэсэн нотолгоо биш юм. Шинэ Гэрээнд дурдсан эмэгтэйчүүд, эр эмийн харьцааны талаар түүний баримталж байсан үзэл бодол нь хожим их ач холбогдолтой болсон билээ. "Нөхөрт гараагүй эмэгтэйчүүд болон бэлэвсэн бүсгүйчүүд над шиг тэвчээртэй бай гэж би ятгадаг, гэхдээ биеэ барьж дийлэхгүй байвал нөхөрт гар, гэхдээ энэ нь хоосон шаналж байснаас хамаагүй дээр." гэж Павел нэгэн сургаалдаа онцлон өгүүлсэн бий. Гэр бүлд эмэгтэйчүүдийн үүргийн тухай номлохдоо "Эхнэр хүн амаа хамхиж дуулгавартай байна, тэрчилэн нөхөртөө зааж сургаж түүнийг захирч эс болно, ер нь эхлээд Адам дараа нь Ева бий болсон гэдэг биз дээ" гэж сургасан байна.

Христосын сургаалийг еврейн нэгэн дугуйлангийн түвшнээс дэлхийн хэмжээний шашин болгон хөгжүүлсэн цаглашгүй их гавьяа найдан Павелд ногдоно. Христос жинхэнэ бурхан болох тухай, итгэл үнэмшлээрээ аврагдах тухай Павелийн гол үзэл санаа Христосын шашин дараагийн зуунуудад давшингүй хөгжих багтай үндэс суурь болсон юм. Августин, Фома Аквинский, Лютер, Кальвин зэрэг христос шашныг сурталчлан түгээн дэлгэрүүлэгчдийн дараа үеийнхний үйл ажилла-гаанд түүний зохиосон Илгээлтүүд үнэлж баршгүй их нөлөө үзүүлсэн билээ.



# 7. Цай Лунь

(TSAI LUN)

(105 оноос хойшхи тууний атьдралын тухай тэдээлэл байдаг)



Цаас зохион бүтээгч Цай Лунийг хүн болгон тэр бүр мэдэхгүй. Хятадын хааны шүүхийн албаны жирийн нэгэн түшмэл Цай Лунь манай эриний 105 оны орчим цаасны дээжийг Хо Ди хаанд бэлэг болгон өргөн барьжээ. Цай Лунь гэдэг нэртэй хүн цаас зохиосон тухай хятадын албан ёсны мэдээлэл түүхэн баримтаар багтай нотлогддог юм.

Түүний амьдралын тухай мэдээлэл маш хомс, олон эхнэртэй хүний тайган харгалзагч байсан тухай, хятадын хаан түүнийг цаас зохиосонд нь талархалтай хандаж байсан тухай хятадын эх сурвалжид бичсэн бий. Хаан цаас бүтээснийг нь хосгүй гарамгай үйлс гэж үнэлж албан тушаал дэвшүүлж язгууртны зэрэг олгожээ. Цай Лунь баян болсон ч жаргал даасангүй, ордны хуйвалдаанд оролцсон нь илэрсэн тул гоёлын хувцсаа өмсөж ёслол төгөлдөр амиа хорложээ.

Манай эриний хоёрдугаар зууны туршид цаас хятад улсад өргөн дэлгэрч Азийн бусад оронд борлуулж эхэлжээ. Хятадууд цаас үйлдвэрлэх технологийг удтал нууцалж байсан ч 715 онд арабууд хятадын хэд хэдэн цаасны үйлдвэрийг булаан авч удалгүй Багдад, Самарканд хотуудад цаас үйлдвэрлэж гарчээ. Ийнхүү цаас үйлдвэрлэх урлаг арабын ертөнцөөр түргэн тархаж дараа нь Европ тивд нэвтэрсэн ажээ. Ийнхүү цаас дэлхий ертөнцөөр түгэж Гутенбергийг ном үйлдвэрлэлийг зохион бүтээсний дараа Европ тивд ном хэвлэхдээ илэгний оронд цаас хэрэглэх болжээ.

Цай Луниас өмнө хятадад номыг хулсаар үйлдвэрлэдэг байсан болохоор дэндүү хүнд, хэрэглэхэд их төвөгтэй байжээ. Зарим номыг торгоор хэвлэдэг байсан нь хэт өндөр өртөгтэй байлаа. Өрнөдийн орнуудад цаас нэвтрэхээс өмнө номыг хонь юм уу тугалын арьсаар хийсэн илэг дээр хэвлэдэг байжээ. Грек, ром, египетчүүд илэг юм уу халуун орны зэгс ашиглан ном судар хэвлэдэг байв. Гэвч илэг, зэгс нь маш өндөр үнэтэй материал байсан болохоор ном болон бусад материалыг олноор үйлдвэрлэх бололцоо гарахгүй байсан нь мэдээж.

Өнөө үед цаас хүн төрөлхтөний өдөр тутмын хэрэглээ болж бид түүнийг ердийн зүйл мэт үзэж хэрхэн ихээр хэрэглэж байгаагаа ер анзаарддаггүй. Гэтэл цаас байгаагүй бол хүн төрөлхтөний амьдрал ямархуу байх байсныг төсөөлөхөд бэрх билээ.

Цаас зохиосон Цай Лунь, ном хэвлэх аргыг бий болгосон Гутенберг хоёрын аль нь хүн төрөлхтөний хөгжилд илүү хувь нэмэр оруулсан эсэх тухай маргаан байдаг. Цаасыг зөвхөн бичиг үйлдэхэд төдийгүй бусад зориулалтаар бас их ашигладаг. Цай Лунь ямар ч тохиолдолд Гутенбергээс түрүү үед амьдарч цаас бий болгосон, хэрвээ цаас байгаагүй бол ном хэвлэх арга тэр даруй нээгдэх эсэх байсан нь эргэлзээтэй. Энэ утгаар авч үзвэл Цай Лунь нь хүн төрөлхтөний түүхэн хөгжилд үзүүлсэн нөлөөгөөрөө Гутенбергийг давж байна.

Цай Лунь цаас зохион бүтээснээрээ бичиг ном үйлдэх маш хөнгөхөн эд бий болж хятадын соёл иргэншил эрчтэй хөгжиж хоёр зуун жилийн дараа гэхэд Өрнөдтэй бараг зэрэгцэж ирсэн түүхтэй билээ. Цай Лунь хятад улсад цаас зохион бүтээснээс бараг нэг мянган жилийн дараа Европ тивийнхэн сая нэг арабчуудаас суралцаж цаас үйлдвэрлэж эхэлсэн билээ. Чухамдаа энэ түүхэн урт хугацаанд хятадад дарь, компас, модон бараар бичиг ном хэвлэх арга бий болсон байна.

# 8. Иоганн Гутенберг

(JOHANN GUTENBERG)

1400 -1468



Иоганн Гутенбергийг ном үйлдвэрлэх аргыг зохион бүтээгч гэж дэлхий даяар зүй ёсоор хүлээн зөвшөөрдөг билээ. Үсэг өрөх болон хэвлэлийн төхөөрөмжийг анх зохиож бичмэл материалыг олон тоогоор, түргэн, алдаагүй хэвлэж байх бололцоог хүн төрөлхтөнд олгосон хосгүй гавьяатан билээ.

Аливаа шинэ бүтээл хүний толгойд шууд бий болдоггүй, гагцхүү урьд байсан зүйлийг боловсронгуй болгох шаардлага, зүй тогтлоор бий болдог билээ. Модон бараар ном хэвлэх аргыг түүнийг төрөхөөс хэдэн зуун жилийн өмнө Хятадад өргөн хэрэглэж байв. Гэхдээ модон барын аргаар ном хэвлэхэд шинэ ном хэвлэх болгонд шинээр модон хэв зорох болж номыг янз бүрийн хэмжээтэй хэвлэх бололцоогүй байлаа.

Гутенбергийн хамгийн том гавьяа нь үсэг өрөх аргыг анх зохион бүтээсэн гэж үздэг тал бий. Гэхдээ үсэг өрж ном хэвлэх аргыг Хятад улсад XI зууны дунд үед Би Шэн гэдэг нэртэй хүн зохиосон байна. Анх шаазангаар үсэг хийдэг байсан нь дорхноо хагардаг муу талтай байсны нь солонгосчууд боловсронгуй болгож металлаар хийдэг болжээ. Гэвч европ тивийнхэн Хятад улсаас хамааралгүй үсэг өрж ном хэвлэх аргыг сэдэн олж өргөн дэлгэр хэрэглэдэг байжээ.

Ном хэвлэх орчин үеийн арга нь дөрвөн гол бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд нэгдүгээрт өрөх хэлбэр хоёрдугаарт хэвлэх төхөөрөмж гуравдугаарт хэвлэлийн зохих будаг дөрөвдүгээрт хэвлэхэд тохирох цаас орно. Гутенбергийг нээлтээ хийх үед дээр дурдсан бүрэлдэхүүн хэсгүүдээс Цай Луний зохион бүтээсэн цаас л ганц бэлэн зүйл байжээ. Гутенберг үсэг өрөхөд тохирох металл хэвийг санаачилсан төдийгүй хэвлэх үйлдлийг хийх төхөөрөмж, тохирох тосон будгийг бий болгосон юм. Товчоор хэлбэл ном хэвлэх үйлдлийн бүх бүрдэл зүйлийг үйлдвэр-лэлийн үр ашигтай цогц болгож чадсан билээ. Хамгийн гол нь ном товхимолыг хүн

хүссэн тоогоороо хэдэн ч хувь хамаагүй үйлдвэрлэх бололцоог нээж өгсөн нь Гутенбергийг хүн төрөлхтөний хөгжил дэвшилд зүйргүй их хувь нэмэр оруулсан суут хүмүүсийн эгнээнд багтаасан юм

1400 оны үед Германы Майнц хотод төрсөн, түүний бичсэн "Гутенбергийн библийн судар" нэртэй ном нь 1454 онд хэвлэгджээ. Аугаа нээлтээ олигтой үнэ хүргэж чадаагүй учир насан туршаа тарчиг амьдарч байсан ажээ. Хэд хэдэн удаа шүүхэд дуудагдаж нэгэн удаа түүний бүтээсэн хэвлэлийн төхөөрөмжийг хамтран зүтгэгч Иоганн Фуст гэгч нь луйвардан авч байжээ. 1468 онд төрөлх хотдоо нүд анижээ. Гутенбер-гийн хэвлэсэн ганц ч ном, тэр ч байтугай түүний бичсэн "Гутенбергийн библийн судар" номонд түүний нэр бичигдээгүй байдаг нь хачирхалтай.

# 9. Христофор Колумб

(CHRISTOPHER COLUMBUS)

1451-1506



Европ тивээс Дорно зүг орох баруун чиглэлийн зам нээх гэж аялалд гарсан Х.Колумб Америк тивийг санамсаргүй нээж дэлхийн түүхэнд асар их нөлөө үзүүлсэн юм.

Газар зүйн судалгаа, Шинэ тивийг түрэмгийлэн колоничлох эрин үеийн эхлэлийг тавьсан тэр аялал нь хүн төрөлхтөний түүхийн гол эргэлтийн үйл зүг орох баруун чиглэлийн зам нээх гэж аялалд гарсан Х.Колумб Америк тивийг санамсаргүй нээж дэлхийн түүхэнд асар их нөлөө үзүүлсэн юм. явдлуудын нэг болсныг хэн ч үгүйсгэж чадахгүй билээ. Энэ аялалын үр дүнд европ тивийнхэн улам хурдацтай өсөж байгаа хүн амаа тараан байрлуулах, хоёр том тив, ашиг малтмал, түүхий эдийн асар их нөөцтэй болж тус тивийн эдийн засгийг өөрчлөх ихээхэн боломжийг олсон юм. Энэ аялал амжилттай дууссанаар америкийн уугуул иргэд болох улаан арьстнуудын хоцрогдсон соёл иргэншил төгсгөл болж ард түмнүүдийн шал өөр гэр бүл үүсэн төлөвших эхлэл тавигдсан ажээ.

Х.Колумб 1451 онд Италийн Генуя хотод төрж том болоод усан онгоцны шилдэг ахмад, туршлагатай усан зам заагч болжээ. Атлантын далайг баруун чиглэлээр дайрч Дорнод Европ орж болно гэсэн бодол мөрөөдлөө олон жил сэтгэлдээ тээж явсаар Кастилийн нэгдүгээр Изабелла хатан хааныг ятгаж аялал хийх санхүүжилт авч чаджээ.

Түүний удирдсан усан онгоцууд 1492 оны наймдугаар сарын 3-ний өдөр замд гарч эхний удаа Африк тивийн хавьд Канарын арлуу-дад буудаллаж дараа нь есдүгээр сарын 6-нд баруун зүгийг барин хөдөлжээ. Удаан үргэлжилсэн энэ аялалын үед усан цэргүүд зах хязгаар нь үл харагдах далайн дунд амиа алдах нь гэх зэргээр олон хэцүү төвөгтэй үйл явдал болж байсан ч Колумб нугаршгүй итгэл өөдрөг тэмүүллээр бүгдийг зоригжуулж явсаар тэд хүн төрөлхтөний соёл иргэншлийн түүхэнд эгнэгт мөнхөрсөн 1492 оны аравдугаар сарын 12-ны өдөр эх газар сая олж харж бөөн баяр хөөрөнд умбажээ.

Дараа оны гуравдугаар сард Х.Колумбийг Испанид буцан ирэхэд түүний нэр Европ даяар алдаршсан байлаа. Гэвч Х.Колумб Ази тив орох дөт зам оллоо гэж бодсоор байсан нь гайхалтай. Үүнээс хойш Атлантын далайг гаталж Хятад, Япон орох шууд зам олох гэж гурван ч удаа аялал хийгээд үр дүнд хүрээгүй байна.

Нэгдүгээр Изабелла хатан хаан түүний хосгүй гавьяаг үнэлж олж нээсэн газар нутаг болгоных нь амбан захирагчаар томилно гэж амласан ч сэтгэл зүрхээ далайд өгсөн Х.Колумб эх газар тогтож сууж чадсангүй, албан тушаалаасаа хөөгдөж эцэст нь баривчлагдаж Испанид дөнгөтэй хүргэгдэж ирж байжээ. Түүний ядуу зүдүү байдалтай нас барсан гэж зарим эх сурвалжид бичсэн байдаг ч 1506 онд өөд болохдоо баян чинээлэг хэвээр байсан тухай лавтай мэдээлэл байдаг.


Түүнийг Америк тивийг анх нээснийг үгүйсгэх оролдлого гардаг. Тухайлбал далайн дээрэмчин Лейф Эриксон Шинэ тивийн эрэгт түүнээс хэдэн зуун жилийн өмнө хүрч байсан гэдэг. Л.Эриксон Америк тивд хөл тавьсан анхны европ хүн байсныг үгүйсгэж аргагүй. Гэхдээ түүний нээлтийн тухай хэн ч мэдээгүй, хамгийн гол нь Европ болон Америк тивд ямар ч өөрчлөлт гараагүй юм. Тэгэхэд Х.Колумб шинэ тив нээсэн тухай мэдээ тэр даруй Европ тивээр тархаж түүний нээлтийг нотолсон хэд хэдэн аялал дараахан нь болж Шинэ тивийг байлдан эзэмших, колоничлох үйл явц тэр даруй эхэлсэн билээ. Түүнээс гадна эртний грекийн гүн ухаантнууд түүний дотор Аристотель дэлхий бөөрөнхий гэсэн таамаглал дэвшүүлж Х1Ү зууны европчууд дэлхий бөөрөнхий болохыг лавтайяа мэддэг байсан ч манай дэлхийд Америк гэж хожим нь нэрлэгдэх том тив байдаг тухай Х.Колумбын аугаа нээлтээс өмнө хэн ч таамаглаагүй байсан юм.

Чин үнэнийг хэлэхэд Х.Колумб хүний үг авдаггүй, дэндүү их шуналтай хүн байсан, тийм ч учраас шинэ нээлтийнхээ дараах аялалыг санхүүжүүлэх тухай гэрээ байгуулах гэж зүтгэхдээ өөртөө хэтэрхий ашигтай нөхцлийг шаардсан учир нэгдүгээр Изабелла хатан хаан түүнийг дахин дэмжээгүй юм. Х.Колумб Шинэ тивд анх хөл тавьсан үеэсээ нутгийн уугуул иргэд болох улаан арьстнуудтай дэндүү харгис хэрцгий харьцаж байсан ажээ.

# 10. Альберт Эйнштейн

(ALBERT EINSTEIN)

1879-1955



Хорьдугаар зууны аугаа эрдэмтэн, бүх цаг үе, ард түмнүүдийн хамгийн хосгүй ухаантнуудын нэг А.Эйнштейний нэрийг сонсоход түүний харьцангуйн онол юуны түрүүнд санаанд бууна. 1905 онд гаргасан тусгай харьцангуйн онол тэрчилэн 1915 онд томьёолсон нийтлэг харьцангуйн онол буюу Эйнштейний дэлхийн таталтын хууль гэсэн хоёр хэсгээс харьцангуйн онол бүрдэнэ.

"Бүх зүйл харьцангуй" гэсэн цэцэн үг бий. Гэхдээ Эйнштейний бүтээл нь хүн бүхний хэлдэг энэ цэцэн үгийг тайлбар биш харин шинжлэх ухааны хэмжигдэхүүнүүд харьцангуй байх магадлалыг математикийн тодорхой үндэслэлээр баталгаажуулсан баримт юм. Цаг хугацаа, орон зайн тухай төсөөлөл нь тухайн хүнээс хамаарна. Иймд тухайн хүний төсөөллийн цаана бодитой орон зай, бодитой цаг хугацаа байна, тэдгээрийг нь оновчтой багажаар яг таг хэмжиж болно гэж түүнээс өмнө үздэг байжээ. Гэтэл Эйнштейний онол туйлын цаг хугацаа байхгүй гэдгийг нотолж шинжлэх ухааны онолын сэтгэлгээнд хувьсгал хийсэн билээ.

Жишээ үзье, сансрын Х хөлөг эх дэлхийгээс секундэд 100 мянган километрийн хурдтай холдож байна. Сансрын хөлөг доторхи багаж төхөөрөмжийн заалт болон газар дээрх хэмжилтүүдийн дүн бас адилхан байж таарна. Мөн сансрын Y хөлгийг секундэд 180 мянган километрийн хурдтай бас хөөргөлөө. Хэмжилтүүдийн дүн нь мөн адилхан байна. Энэ хоёр сансрын хөлөг нэг чиглэлд нисэж байна гэж бодоход тэдний хурдны ялгаа 80 мянган километр секунд байх нь, илүү хурдтай сансрын Y хөлөг нь хурд багатай Х хөлгөөс 80 мянган километр секундын илүү хурдтай холдож байх нь гэж бид бодлоо. Гэтэл А.Эйнштейний онолоор бол тэрхүү хоёр сансрын хөлөг тус бүрээс тус хоёр хөлгийн хурдны хэмжилт хийхэд хоёр хөлгийн хоорондын зай 80 биш чухамдаа 100 мянган километр секундын хурдтай холдож байна гэж үзжээ. Энд ямар нэг алдаа байхгүй, хэмжих багажинд ч эвдрэл гараагүй. Энэ дүн бол орон зай, цаг хугацааны гол шинж чанараас урган гарч байгаа юм гэж



А.Эйнштейн тайлбарласан билээ.

Харьцангуйн онолыг олон жилийн турш "зааны ясан цамхаг"-ийн тухай ямар ч ач холбогдолгүй хоосон таамаглал гэж ойшоохгүй байлаа. Гэвч 1945 онд Хиросима, Нагасаки хотуудад атомын бөмбөг дэлбэлснээс хойш хэн ч харьцангуйн онолыг үгүйсгэхээ больсон юм. Харьцангуйн онолын нэг зүй тогтол нь матери ба энерги нь тодорхой утгаараа тэнцүү ба тэдний хоорондын харьцаа  $E=Mc^2$  ( $E$  нь энерги,  $M$  нь жин,  $c$  нь гэрлийн хурд) гэсэн томъёоллоор илэрхийлэгдэнэ. Иймд  $c$ -ээр илэрхийлэгдэж байгаа 186,0 бээр секундын хурд нь  $c^2$  болохоор бүр их тоо болно. Ингэхлээр жин өчүүхэн хэмжээгээр өөрчлөгдөхөд л асар их энерги ялгаран гарна гэсэн үг юм.

$E=Mc^2$  гэсэн томъёоллыг ашиглан хэн дуртай нь атомын бөмбөг бүтээж цөмийн энергийн үйлдвэр байгуулах бололцоо байхгүй нь мэдээж хэрэг. Атомын эрчим хүчийг хөгжүүлэхэд маш олон эрдэмтэд оролцсон ч А.Эйнштейний хувь нэмэр зүйргүй их болохыг хэн ч үгүйсгэдэггүй. Чухамдаа А.Эйнштейн 1939 онд АНУ-ын ерөнхийлөгчид хандаж атомын бөмбөг бүтээх бололцоо байна, фашистуудаас түрүүлж атомын бөмбөгтэй болох нь АНУ-ын хувьд асар их ач холбогдолтой болох тухай захидал бичсэн нь "Манхэттен" төсөл болон хэрэгжиж анхны атомын бөмбөгийг туршихад хүргэсэн учиртай билээ.

Тусгай харьцангуйн онол анх гарахад ихээхэн маргаан үүссэн ч энэ нээлт бол хүн төрөлхтөний хөгжлийнхээ түүхэнд бодож олсон хамгийн гайхамшигт онол болохыг шинжлэх ухааны ертөнц нэгэн зэрэг хүлээн зөвшөөрсөн билээ. Газрын татах хүчний үйлчлэл нь физикийн хүчнүүдийн үйлчлэлийн үр дүн биш чухамдаа огторгуйн өөрийнх нь үйлчлэлийн үр дүнд бий болно гэсэн эхний үндэслэл гол агуулга нь болох нийтлэг харьцангуйн онол нь хүний оюун ухааны хосгүй бүтээл байлаа!

А.Эйнштейн энэ онолоо цааш нь хөгжүүлсэн төдийгүй баттай тооцоо, таамаглалаа туршилтын замаар нотлох математикийн яг таг үндэслэлийг гаргаж чадсан билээ. Дараачийн туршилтууд ялангуяа нар хиртэлтийн үеийн ажиглалтууд нь түүний тэгшитгэлүүдийн үнэн болохыг улам баталгаажуулсан юм.

Нийтлэг харьцангуйн онолоо туршилтын үр дүнд биш чухамдаа эртний грекийн гүн ухаантнуудын оролдож байсан шиг математик таамаглалын замаар нээсэн нь бүр гайхамшигтай юм. Хамгийн гайхалтай нь, А.Эйнштейний онол аливаа туршилт бүрийг давж гарч чадаж байгаагаараа өнөө үед байгаа шинжлэх ухааны онолуудаас хамгийн үнэмшилтэй, нотолгоотой, бахдам сайхан нь болж байдаг юм. Шинжлэх ухааны хуулиудын дийлэнх нь амьдралд тэр бүр хэрэглэгддэггүй бол нийтлэг харьцангуйн онол нь онолын болон туршилтын бүх тооцоонд ашиглагдаж болдоороо эрдэмтэн мэргэдийн бодож олсон онолуудаас туйлын үнэнд ойртох замыг улам ч дөтлүүлж байна.

А.Эйнштейн харьцангуйн онолоороо нэрд гарсан ч түүний хийж бүтээсэн олон зүйл шижлэх ухааны том ололт болсон юм. Урьд өмнө нь физикч эрдэмтдийг мухардалд оруулаад байсан фото үйлдлийн тайлбарлалтыг хийснийхээ төлөө 1921 онд Нобелийн шагнал хүртсэн. Онолын үндэслэлээрээ фотон буюу гэрлийн квант байдгийг тайлбарласан. Гэрэл нь цахилгаан соронзон долгионоос бүрддэг болохыг туршилтын замаар тогтоосон болохоор гэрлийн долгион болон квантууд эсрэг тэсрэг юм гэж үздэг байсныг А.Эйнштейн няцааж

сонгодог онолыг мухардлаас гаргаж чадсан юм. Фото үйлдлийн тухай А.Эйнштейний хууль нь практик ач холбогдолтой байсан ба фотоны тухай таамаглал нь квантын онолын хөгжилд үлэмж нөлөө үзүүлж өнөөдөр уг онолын бүрэлдэхүүн хэсэг болжээ.

И.Ньютоны онолыг ойлгоход хялбар байдаг бол Эйнштейнийнх тайлбарлаад байхад ч ухааран ойлгоход их хэцүү, хэт "ойлгомжгүй" ч дэндүү их "практик" ач холбогдолтой байдаг.

1879 онд Германы Ульм хотод төрсөн ч Швейцарт дунд сургуульд суралцаж 1900 онд тус улсын иргэн болжээ. 1905 онд Цюрих хотын их сургуульд гүн ухааны докторын зэрэг хамгаалаад, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллах хүсэлтэй байсан ч ажилд авахгүй байсан учир харьцангуйн онол, фото үйлдэл, броуновын хөдөлгөөний тухай илтгэлээ хэвлүүлсээр байлаа. Төдсөнгүй харьцангуйн онолоороо дэлхийн хамгийн гайхамшигт эрдэмтний нэр алдар хүртэж 1913 онд Берлиний их сургуулийн профессороор томилогдож түүний зэрэгцээ Физикийн хүрээлэнгийн захирлаар уригджээ. Пруссын Шинжлэх ухааны академийн гишүүнээр сонгогдсоноор бүх цаг заваа шинжлэх ухаанд зориулах бололцоотой болжээ.

Гитлер засгийн эрхэнд гарснаар А.Эйнштейн еврей үндэстэн хүний хувьд эх орноосоо дүрвэн гарч 1933 оноос АНУ-ын Нью-Жерси мужийн Пристон хотод Дээд судалгааны хүрээлэнд ажиллаж 1940 онд АНУ-ын иргэн болов. Түүний хоёр дахь гэрлэлт түүнд аз жаргал авчирч хоёр сайхан хүүтэй болжээ. 1955 онд Пристон хотод түүнийг насан өөд болоход шинжлэх ухааны түүхэн дэх хамгийн гарамгай эрдэмтэн гэж үзэж өндөр хүндэтгэлтэй оршуулжээ.

А.Эйнштейн дэлхий дахинд болж байгаа үйл явдлыг ихээхэн сонирхож, улс төрийн хурц асуудлаар санал бодлоо олонтаа илэрхийлдэг хүн байв. Улс төрийн хүчирхийллийг буруушааж аливаа дайныг эсэргүүцэгч байв. Нас намбандаа зохицсон даруу төлөв зантай, шог хошин үг их ярьдаг, хийлээр чадварлаг тоглодог хүн байжээ.

Алдарт эрдэмтэн И.Ньютоны шарил дээрх "Хүн төрөлхтөний хосгүй чимэг болох энэ хүн манай дэлхийд амьдарч байсанд бүх хүн баярлаж байтугай!" гэсэн талархлын үг гарамгай эрдэмтэн А.Эйнштейнд мөн хамаарна.

# 11. Луи Пастер

(LOUIS PASTEUR)

1822 -1895



Францийн химич, биологич . Луи Пастер анагаах ухааны түүхэн дэх хамгийн алдарт зүтгэлтнүүдийн эгнээнд зүй ёсоор багтдаг билээ. Анагаах ухааны хөгжилд нэг хүнд ахдах асар их гавьяа байгуулсан юм.

Өвчин түгээгч эгэл биетүүдийн үйлдлийн үр дүнд өвчин дэврээх онолын талыг баримтлагч байсан болон урьдчилан сэргийлэх вакциний технологийг боловсруулсан гавьяагаараа их нэрд гарсан эрдэмтэн билээ.

Францийн дорнод хэсэгт орших Доль хотод 1822 онд төрж Париж хотод коллежид | анагаах ухаан судалжээ. Суралцаж байхдаа сурлагаар тааруу оюутан гэж тооцогддог байсан ч 1847 онд дарсны хүчлийн кристал-луудын оптикийн идэвхтэй чанарын тухай сэдвээр докторын зэрэг хамгаалж 26 настайдаа нэрт химич алдар хүртжээ.

Үүний дараа Пастер бодис исэх асуудлыг судалж тодорхой төр-лийн эгэл биесүүдийн үйл ажиллагааны үр дүнд исэлт бий болдгийг нотлов. Исэх үйлдлийн явцад өөр төрлийн эгэл биесүүд байх нь хүсээгүй бүтээгдэхүүн гарах шалтгаан болдог гэж мөн үзлээ. Эдгээр дүгнэлтийг үндэслэн зарим төрлийн эгэл биетүүд нь хүн болон амьтны биед хүсээгүй бүтээгдэхүүн, үйлдэл бий болгодог юм байна гэсэн үзэл санааг дэвшүүлжээ.

Түүнээс өмнө Жироламо, Фридрих Хенлем болон өөр зарим эрдэмтэн өвчнийг халдварлуулан эмчлэх онолын тухай таамаглал дэвшүүлж байсан ч чухамдаа Луи Пастер олон тооны туршилтаараа түүнийг багтай нотолж хамгийн гол нь шинжлэх ухааны олон нийтэд энэ онолын ач тусыг сэнхэртэл нь ойлгуулж чадсан юм. Аливаа өвчин халдварын хор уршигаар үүсэж байгаа бол өвчин үүсгэгч нянг хүний биед нэвтрэхээс урьдчилан сэргийлж чадвал өвчинг үүсгэхгүй байж болно гэж Луи Пастер үзэж эмч нарын практик ажилд халдварыг эсэргүүцэх арга хэмжээ маш чухал болохыг онцлон зааж байлаа. Энэ утгаараа хагалгааны явцад шархыг халдвараас хамгаалах аргыг нэвтрүүлсэн Жозеф Листерт их нөлөө

үзүүлсэн ажээ.

Өвчин үүсгэгч нян хүний биед хоол ундаар дамжиж орж болохыг Луи Пастер баталсан төдийгүй ундаанд байгаа нянг устгах технологийг боловсруулсан юм. Энэ аргыг өнөө үед ариутгал гэж нэрлэнэ.

Л.Пастер тавин нас хүрснээсээ хойно мал, зарим амьтан тэрчилэн хүнд тусдаг ихээхэн халдвартай өвчин болох боомыг судалж тодорхой төрлийн нян энэ өвчинг үүсгэдэг болохыг нээсэн төдийгүй эмчлэх аргыг боловсруулсан ажээ. Гэрийн тэжээмэл амьтны биед тарьсан боом өвчнийг үүсгэгч нянгийн сул уусмал тухайн амьтны биед ямар ч аюулгүй төдийгүй энэ өвчин үүсэх бололцоог бүрэн хаадаг байна. Л.Пастерийн нээсэн гэрийн тэжээмэл амьтдыг боом өвчнөөс урьдчилан сэргийлэх арга олон нийтийн өргөн талархлыг хүлээсэн төдийгүй энэ аргыг бусад олон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд мөн ашиглаж болох нь тэр даруй нотлогджээ.

Галзуурах гэдэг аймшигт өвчнийг тариа хийж анагаах аргыг Л.Пастер анх олж хүн төрөлхтөнд их буян үйлдсэн гавьяатай хүн. Бусад эрдэмтэн түүний гаргасан онолын гол дүгнэлтүүдийг үндэслэн хижиг, саа зэрэг аймшигт өвчнүүдийг эсэргүүцэх вакцинийг боловсруулан бий болгосон билээ.

Л.Пастер эгэл биетүүд зүгээр өөрсдөө бий болдоггүйг туршилтаар нотолж зарим эгэл биес агааргүй болон хүчилтөрөгчгүй орчинд хүртэл амьдарч чаддагийг мөн нээсэн билээ. Ялмын хүр хорхойн өвчний талаар хийсэн судалгаа тухайн үедээ аж ахуйн их ач холбогдолтой байлаа. Тахианд их тусдаг булчин задрах тахал өвчнийг эсэргүүцэх вакцин бас хийжээ.

Бүх эрин зууны их эрдэмтэн Л.Пастер 1895 онд Париж хотын ойролцоо насан өөд болсон юм.

Түүнээс бараг наяд жилийн өмнө туршилт явуулж цэцгийн тариа тарих аргыг нээсэн эмч Эдуард Женнертэй түүнийг голдуу харьцуулдаг нь буруу биш. Гэвч Э.Женнерийн нээсэн аргыг зөвхөн ганц өвчнийг урьдчилан сэргийлэхэд хэрэглэдэг байсан бол Л.Пастер хүн төрөлхтөнийг зовоож байсан олон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх аргыг гаргаж үр дүнг нь харуулсанаараа анагаах ухааны түүхэнд түүнээс илүү хүндтэй байр эзэлдэг юм.

Л.Пастер олон өвчнийг анагаах аргыг боловсруулж хүн төрөлхтөнд зүйргүй ач хүргэсний ачаар XIX зууны хоёрдугаар хагасаас үхэл эрс багасаж хүний дундаж нас хоёр дахин нэмэгдсэн юм.

# 12. Галелео Галилей

(GALILEO GALILEI)

1564 -1642



Шинжлэх ухааны задлан шинжилгээний аргын хөгжилд онцгой байр суурь эзэлдэг италийн алдарт эрдэмтэн бол Г.Галилей билээ. 1564 онд Пиза хотод төрж хотынхоо их сургуульд элсэн орсон ч төлбөрөө барагдуулаагүй учир гарчээ. Гэвч 1589 онд их сургуульдаа багшийн ажилд орж хожим нь Падуаны их сургуульд шилжиж тэнд 1610 он хүртэл ажиллахдаа шинжлэх ухааны гарамгай нээлтүүдийнхээ дийлэнхийг хийсэн байна.

Галилей чухал нээлтүүдийнхээ анхныхыг механикийн салбарт хийжээ. Хүнд биес хөнгөнөө бодвол илүү хурдтай унадаг гэсэн грекийн гүн ухаантан Аристотелийн томъёоллын үнэн эсэхийг Галилей шалгахаар шийдэж хэд хэдэн туршилт хийсний дараа энэ томъёолол буруу болохыг нотолжээ. Хүнд болон хөнгөн биес агаарын үрэлт саад хийж байгаагаас бусад тохиолдолд адилхан хурдтай унадаг гэсэн дүгнэлтийг Галилей хийв. Түүнээс гадна тухайн хугацаанд унаж байгаа биеийн туулж өнгөрүүлсэн зайг хэмжиж унаж байгаа биеийн замын урт нь уналт явагдсан хугацааны үржвэртэй тэнцүү болохыг тогтоов. Хурдасгалын байнгын коэффициент гэж нэрлэгддэг энэ нээлтээрээ аугаа эрдэмтний тоонд зүй ёсоор багтсан юм.

Г.Галилей олон тооны туршилтуудынхаа дүнг математикийн томъёоллоор илэрхийлж байсан нь маш чухал ач холбогдолтой байлаа. Орчин үеийн шинжлэх ухааны тодорхойлох онцлог нь математик томъёолол, математик аргуудыг хэрэглэж байгаа явдал билээ.

Түүний дараагийн бас нэг том ололт нь инерцийн хуулийг нээсэн явдал юм. Хөдөлгөөнд байгаа бие цааш нь түлхэх хүч нөлөөлөхгүй бол хурд нь саардаг гэж хүмүүс үздэг байсныг Галилей туршилт хийж өөрчлөв. Үрэлт зэрэг хөдөлгөөнийг саатуулж байгаа нөлөөлөл байхгүй бол унаж байгаа бие хөдөлгөөнөө цааш эцэс төгсгөлгүй үргэлжлүүлэх болно гэсэн дүгнэлтийг Галилей хийжээ. Хожим нь И.Ньютон шинээр томъёолсон энэ зарчим нь

физикийн шинжлэх ухааны суурь зарчмуудын нэг болсон билээ.

Галилей хамгийн гайхамшигт нээлтүүдээ одон орны судлалд хийсэн билээ. ХҮI зууны эхнээс Коперникийн гелио төвийн онолыг баримтлагчид болон гелио төвийн эртний онолыг хамгаалагчдын хооронд маргаан үүсэж удал үргэлжилсээр байлаа. Коперникийн зөвийг ойлгож байсан ч Галилей нотолж чадахгүй байлаа. Тэгж байтал 1609 онд Голланд улсад телескоп зохион бүтээгдсэнийг Галилей дуулаад түүний ажиллах зарчмыг нь амаар яриулж байгаад илүү боловсронгуй телескоп бүтээж туршилт хийсээр жилийн дараа цуврал нээлтүүдээ олон нийтэд танилцуулжээ.

Галилей Сар руу дурандан ажиглалт хийж түүн дээр олон тооны галт уулын цар, өндөр уулс байна, тэнгэрийн эрхэсийн гадаргуу тэгш биш манай дэлхий шиг овон товонтой юм байна, Тэнгэрийн заадсыг харсаар тэр бол манан будангаар битүү бүрхэгдсэн цул бие биш хүн энгийн нүдээр алсаас харахад нэг юм шиг харагдаж буй маш олон тооны одоос бүрддэг юм байна гэдгийг хүн төрөлхтөнд ойлгуулсан юм. Тэрчилэн Бархасвадь гаригийг тойрон түүний дөрвөн дагуул байнга эргэлддэг юм байна, иймд тэнгэрийн эрхэс гариг зөвхөн манай эх дэлхийг тойрч эргэлддэг бус мөн аливаа гаригийг тойрч эргэлддэг юм байна гэж Галилей мэдэгдлээ.

Нар руу ажиглалт хийж Нар дээр толбууд байдагт эрдэмтдийн анхаарлыг хандуулж чадлаа. Тэрчилэн Цолмон гаригийн үелэл Сарныхтай адилхан болохыг олж мэджээ. Эдгээр нээлтүүд нь манай эх дэлхий болон бусад гаригууд Нарыг тойрч эргэлддэг гэсэн Коперникийн онолыг багтай нотлоход их тус дэм болжээ.

Галилей ийнхүү Коперникийн онолыг дэмжсэнд шашны хүрээний-хэн дургүйцэж 1616 онд түүнд дээрх онолыг сурталчлахыг хоригложээ. Галилей энэ хоригийг нилээд хэдэн жил эсэргүүцэж байсан боловч 1623 онд Ромын хамба лам насан өөд болсноор дээрх хориг үйлчлэхээ больжээ.

Г.Галилей дараагийн зургаан жилийг «Дэлхийн хамгийн гол хоёр системийн тухай харилцан яриа» гэсэн алдарт бүтээлээ туурвихад зориулжээ. Энэ ном 1672 онд хэвлэгдмэгц шашныхан дургүйцэж 1616 оны хоригийг зөрчлөө гэж буруушаасан ч түүнийг шоронд суулгаж арай зүрхэлсэнгүй, Арчетри дахь шилтгээнд нь гэрийн хорионд байлгах шийтгэл ногдуулжээ. Тэрчилэн Эх дэлхий Нарыг тойрч эргэлддэг гэсэн онолоосоо олны өмнө таггалзах шүүхийн шийдвэр гарсныг 69 настай Г.Галилей биелүүлэв.

Алдарт эрдэмтэн маань Арчетри дахь шилтгээндээ механикийн асуудлуудыг судалж байсаар 1642 онд ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн юм.

Түүний хийсэн шинжлэх ухааны нээлтүүдээс илүү түүний шинжлэх ухааны арга зүйг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмэр зүйргүй аугаа билээ. Түүнээс өмнөх үеийн Аристотелийн чиглэлийг барьсан гүн ухаантан-эрдэмтэд өөрсдийн ажиглалтын чанар, үзэгдлүүдийн ангилалд онцгой анхаардаг байсан бол Галилей аливаа үзэгдлийг судлахдаа үнэн бодит байдал, тоон үзүүлэлтүүдийг эрхэмлэх болжээ. Тэр үеэс тоон үзүүлэлтүүдийг яг таг тооцох нь шинжлэх ухааны судалгааны үндсэн арга болсон юм.

Г.Галилей шинжлэх ухааны танин мэдэхүйд туршилтын хандлага чухал ач холбогдолтойг өргөн сурталчилж аливаа нэр хүндтэй хүний үг биш чухамдаа туршилт бол шинжлэх ухааны үнэний нотолгоо гэж үздэг байжээ.


Чин үнэнийг хэлэхэд Г.Галилей шашны гүн шүтлэгтэй хүн байж шашин сүмээс хэзээ ч татгалзаж байгаагүй ч гэсэн шинжлэх ухааны асуудлыг шийдвэрлэхэд шашны засаг захиргаа саад хийхийн эсрэг шийдвэртэй тэмцдэг байлаа. Хойч олон үеийн эрдэмтэд Галилейг хэвшмэл номлолыг ягштал баримтлах, сэтгэлгээний эрх чөлөөг дарах гэсэн бүдүүлэг оролдлогыг эсэргүүцэхийн билгэ тэмдэг гэж өнөө үед ч бахархан дээдэлсээр байна.



# 13. Аристотель

(ARISTOTLE)

(Манай эриний өмнөх 384- 322)



Аристотель бол эртний үеийн суут гүн ухаантан, эрдэмтэн байсан юм. Формаль логикийн сургаалийг боловсруулж гүн ухааны бараг бүр салбарыг баяжуулж шинжлэх ухаанд их хувь нэмэр оруулсан билээ.

Түүний олон үзэл санаа он цагийн уртад хуучирсан тал бий. Гэхдээ түүний шинжлэх ухаанд хандаж байсан хандлага нь ач холбогдлоо алдаагүй байна. Хүний амьдрал, нийгмийн үйл ажиллагааны ямар ч асуудал шинжлэх ухааны судалгааны объект байж болно, дэлхий ертөнц санамсаргүй тохиолдол, олон ааш ариншинтай бурхны далдын хүчний бүтээгдэхүүн биш чухамдаа зүй зохистой хуулиудад захирагддаг юм, байгаль ертөнцийн үзэгдэл бүрийн мөн чанарыг хүн эрэмбэ дараатай танин мэдэх ёстой, бид аливаа дүгнэлт хийхдээ туршилтын ажиглалт төдийгүй учир шалтгааны баталгааг үндэс болговол зохино гэсэн Аристотелийн үзэл бодол түрүүчийн үеийн ягшмал үзэл баримтлалыг таягдан хаяж өрнөдийн соёл иргэншлийн хөгжилд том алхам болсон билээ.

Манай эриний өмнөх 384 онд Македон улсын Стагира хотод нэртэй эмчийн гэр бүлд төрж 17 настайдаа Афин хот орж Платоний академид суралцжээ. Тэнд хорь гаруй жил амьдарч ажиллаж Платонийг өөд болсны дараа л орхин явжээ. Төрсөн эцгээсээ биологи, «практик шинжлэх ухаан»-ыг Платоноос гүн ухааны бясалгал хийх сонирхлыг өвлөн авсан ажээ.

Манай эриний өмнөх 342 онд Аристотель эх нутаг Македонид буцан ирж хааныхаа, хожмоо түүхэнд аугаа их Александр Македонский нэрээр мөнхөрсөн 13 настай хүүгийн гэрийн багш болжээ. Александрийг хэдэн жил сургаж түүнийг хааны ширээнд заларсны дараа Афин буцан ирж лицей сургууль нээж 12 жил ажиллажээ. Эдгээр жилүүдэд Александр Македонский байлдан дагуулалт хийж байхдаа багшаасаа зөвлөгөө авдаггүй байсан боловч судалгааны ажил хийх хөрөнгө мөнгөөр тасралтгүй хангаж байлаа. Энэ бол эрдэмтэн хүн судалгааны ажилдаа төрөөс ихээхэн хэмжээний санхүүгийн дэмжлэг туслалцаа авч байсан анхны тохиолдол болсон юм. Дараагийн хэд хэдэн зуунд ч тийм явдал гараагүй юм.

Аристотель өөрийн шавь Македонскийн эзлэн түрэмгийлэх бодлогыг тууштай эсэргүүцэгч байсан юм. Тийм учраас Македонский багшийнхаа ач хүүг урвалаа гэж цаазлахдаа золтой л багшийгаа мөн шийтгэчихээгүй юм. Манай эриний өмнөх 323 онд А.Македонскийг өөд болсны дараа Афин хотод Македоний эсрэг бүлэглэл хүчээ авсны улмаас Аристотель аргагүйн эрхээр хотоос оргон зугтаж хэдэн сарын дараа 62 настайдаа ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ.

Аристотель зүйргүй ажилсаг хүн байжээ. Бидний өнөө үед түүний зохиосон 47 зохиол нь өвлөгдөн ирсэн ч нийтдээ 170 орчим ном туурвисан ажээ. Түүнээс гадна атаархам өргөн мэдлэгтэй хүн байжээ. Түүний бичсэн номууд нь тухайн үеийнхээ шинжлэх ухааны нэвгэрхий толь байлаа. Одон орон, амьтан судлал, эс судлал, газар зүй, геологи, физик, анатоми, физиологи зэрэг эртний Грект мэддэг байсан шинжлэх ухааны бараг бүх салбарт бүтээлээ туурвижээ.

Аристотель үнэхээр гарамгай гүн ухаантан байжээ. Бясалгалын гүн ухаанд ихээхэн хувь нэмэр оруулж ёс зүй, метафизик, сэтгэл зүй, эдийн засаг, улс төр, шашин судлал, гоо зүй, уран илтгэлийн онолын тухай том бүтээлүүд бичжээ. Тэрчилэн олон орны үндсэн хуулийг харьцуулан судалж байжээ. Түүнийг гүн ухааны логикийн салбарын үндсийг тавигч гэж зүй ёсоор хүндэлдэг. Судалгааны ажилдаа ямагт эрүүл саруул ухааныг дээдэлж түүний дэвшүүлсэн олон тодорхойлолт, категориуд шинжлэх ухааны олон салбарын хөгжлийн үндэс болжээ.

Өрнөдийн шинжлэх ухааны сэтгэлгээний хөгжилд Аристотелийн оруулсан хувь нэмрийг хэмжээлшгүй их билээ. Эртний болон дундад зууны үед түүний зохиолуудыг латин, сири, араб, итали, франц, иврит, герман, англи хэл дээр орчуулжээ. Түүний зохиолууд лалын шашны гүн ухаанд мөн гүнзгий нөлөө үзүүлжээ. Арабын гүн ухаантнуудын шүтээн болох Аверроэс лалын шашны онол болон Аристотелийн гүн ухааныг нэгтгэн цогц сургаал бий болгохыг оролдож байсан бол дундад зууны үеийн еврейн алдарт сэтгэгч Маймонид мөн иудаизмийн шашинтай Аристотелийн гүн ухааныг нэгтгэхийг зорьж байлаа.

Дундад зууны үед Аристотелийг хэт бишрэн шүтэснээс шинжлэх ухааны хөгжлийг хойш татсан явдал гарсан нь үнэн билээ.

# 14. Евклид

(EUCLID)

Манай эриний 300 жилээс тууний тухай тэдээлэл байдаг.



Эртний грекийн нэрт геометрч Евклид амьддаа алдар цууд гараа-гүй ч түүний нэрийг мэдэхгүй сургуулийн сурагч өнөөдөр дэлхийд бараг байхгүй гэхэд хилсдэхгүй биз ээ.

Түүний амьдралын тухай мэдээлэл маш хомс, манай эриний өмнөх 300 оны үед Египет улсад Александрийн багш байсан тухай л яригддаг. Цөөнгүй ном бичсэнээс хэдхэн нь л бидний үед мэдэгдэж байна. Гэхдээ «Эхлэл» нэртэй геометрийн сурах бичиг нь түүнд дэлхий дахины алдар сууг авчирсан билээ.

Энэ номын ач холбогдол нь тус номонд байгаа теоромуудаар дан ганц тодорхойлогддоггүй юм. Уг номонд байгаа олон теором, баталгаанууд нь түүнээс өмнө олон нийтэд тодорхой байсан. Гэвч Евклид эдгээр их тархай бутархай материалыг цэгцэлж чадсанд түүний гол гавьяа байдаг юм. Шаардлагатай аксиом, томъёоллуудыг зөв сонгон авч теором бүр нь нөгөөгөөсөө урган гарах байдлаар теоромуудыг оновчтой дэс дараалалтай байрлуулсан юм. Евклид хэрэгтэй газар нь шаардлагатай хэсгийг нэмж бичиж огт байхгүй байсан баталгаануудыг ургуулан бодож олсон байна.

«Эхлэл» сурах бичиг нь өнөөгийн байдлаар хоёр мянга гаруй жил хэрэглэгдэж байгаа ба энэ утгаараа хамгийн аугаа сурах бичиг гэж тооцогдоно. «Эхлэл» сурах бичиг хэвлэгдэж гарснаар геометрийн бусад сурах бичгийг огт ашиглахаа больсон ажээ. Анх грек хэл дээр бичигдсэн «Эхлэл» ном бусад олон хэл рүү орчуулагдсан ажээ. Энэ ном 1482 онд анх удаа бичмэл байдлаар хэвлэгдсэнээс хойш дэлхийн бүх оронд хэдэн мянган удаа хэвлэгджээ. Энэ ном логик сэтгэлгээний салбарт хүний оюун ухааныг сорих нэгэн гайхамшигт дасгалын ном болон өргөмжлөгдсөн төдийгүй бүрэн төгс дедуктив бүтцийн сонгодог үлгэр жишээ болсоор байна.

Энэ ном нь орчин үеийн шинжлэх ухаан хөгжилд хамгийн гол хүчин зүйл болсныг дэлхий дахинаараа хүлээн зөвшөөрдөг. «Эхлэл» номын үр дүнд европийн эрдэмтэд ертөнцөд

физикийн хэдхэн чухал зарчим байдаг, тэдгээрээс бусдыг нь ургуулан бодож олж болно гэсэн дүгнэлтийгхийжээ. Тухайлбал Ньютон, Галилей, Коперник, Кеплер зэрэг цуут эрдэмтэд цөмөөрөө «Эхлэл» номыг судалж математикийн мэдлэгээ өргөжүүлж байжээ. Евклидийн ном бичсэн арга зүй үнэхээр цагийн шалгуур дааж дараа үеийн эрдэмтдэд асар их нөлөө үзүүлсээр байсныг аугаа эрдэмтэн И.Ньютоны жишээ дээр тайлбарлаж болно. И.Ньютон «Натур гүн ухааны математикийн эхлэл» нэртэй алдарт номоо «Эхлэл» номоо бичсэн «геометрийн» хэлбэрээр зохиосон байна.

Хожуу үеийн Бертран Рассел, Альфред Норт Уайтхед зэрэг олон математикч тэрчилэн Спиноза зэрэг гүн ухаантнууд Евклидийн жишээгээр анхны томъёоллоос зайлсхийж логик бодомжоос тодорхой жишээнүүдийг гарган авах арга зүйгээр шинжлэх ухааны нээлтүүд, бүтээлээ туурвидаг байлаа.


Евклид замыг нь зааж өгөөгүй бол европчууд орчин үеийн шинжлэх ухааныг хөгжүүлж чадах байсан эсэх байсан талаар маргаан өнөө хэр байдаг.

Өнөөдөр олонхи математикч Евклидийн геометр нь дэс дараалал нь цогц цорын ганц геометрийн систем биш, түүнээс гадна сүүлийн 150 шахам жилд евклидийн бус хэд хэдэн геометр бий болсныг мэднэ. Эйнштейний харьцангуйн онол гарснаар Евклидийн геометр нь дэлхий ертөнцийн хувьд тэр бүр үнэн биш болох нь нотлогдсон. Тухайлбал хар нүхүүд, нейтронны оддын ойролцоо асар их хүчтэй гравитацийн талбай үүсэж байгааг судлахад Евклидийн геометр учир дуталдалтай байгаа юм. Хүн төрөлхтөний оюуны мэдлэгийн хүрээ улам тэлсээр байгаа ч Евклидийн геометрийн ач холбогдол хэзээ ч гандан бууршгүй юм.

# 15. Моисей

(MOSES)

Манай эриний өмнөх XIII зуунаас л түүний тухай мэдээлэл байдаг



Эртний еврейн зөнч Моисей шиг хүн төрөлхтөний талархлыг хүлээсэн хүн бараг үгүй биз ээ. Цагхугацаа өнгөрөх тусам түүнийг бишрэн шүтэгчдийн тоо өссөөр байна.

Моисей нь XIII зуунд амьдарч бүтээл номоо туурвижбайжээ. «Эхлэл» ном нь хэвлэгдсэнээс таван зуун жилийн дараагаас түүнийг еврейн ард түмэн сүслэн дээдлэх болжээ. Манай эриний 500 оны үед Моисейн алдар христос шашин адил Европ даяар тархжээ. Түүнээс зуун жилийн дараа Магомет түүнийгжинхэнэ зөнч гэж өргөмжилжлалын шашин өргөн дэлгэрэхийн хэрээр улам их хүндэтгэл хүлээх болжээ. Гучин хоёр зууны хойно өнөөдөр Моисейг еврейчүүд, христос, лалын шашингууд цөмөөрөө бишрэн хүндэлсээр байна.

Түүний амьдралын тухай мэдээлэл их хомс, түүний нэр нь еврей гэхээсээ египет хэлний «хүүхэд» гэсэн утгатай үг бололтой. Хуучин Гэрээнд байгаа Моисейн амьдралын тухай намтар, түүхийг үнэн бодит гэж үзэж болохгүй, яагаад гэвэл түүний намтар түүхэнд уран сайхны халил зөндөө орсон бий. Тухайлбал очирт таягаа могой болгон хувиргасан тухай, еврейчүүд Египетээс гарч Их нүүдэл хийхэд наян настай Моисей дөчин километр зам элсэн цөлөөр явган туулсан тухай түүх бол итгэхэд бэрх зүйл билээ.

Египетийн арван иргэнийг цаазалсан тухай, Улаан тэнгисийг гаталсан тухай библийн сударт гардаг түүхийг олон хүн зөвөөр тайлбарлахыг оролддог. Ер нь Хуучин Гэрээнд байгаа Моисейн тухай түүх нь домгийн шинжтэй ба өөр бусад домог үлгэрт тааралддаг үйл явдалтай их төстэй байдаг. Жишээ нь Моисей, зэгсний тухай түүх нь манай эриний өмнөх 2360-2305 онуудад хаан байсан Саргоны тухай вавилоны түүхийг яг хуулсан мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Моисейг гурван том гавьяа байгуулсан гэж үздэг юм. Түүнийг еврейчүүд Египетээс гарч явсан Их нүүдлийг толгойлсон улс төрийн зүтгэлтэн гэж магтана. Хоёрдугаарт Библийн хөлгөн судрын «Үйлс», «Эхлэл», «Левит», «Тооллого», «Дэд хууль» гэсэн таван номыг бичсэн

гэж хүндэтгэж өөрөөр хэлбэл еврейн шашны судар болох «Тора»-г зохиосон гэдэг. Библийн цаг үед еврейчүүдийн зан чанарыг тодорхойлж байсан дүрмүүдийн эмхэтгэл болох Моисейн хуулиуд болон «Арван гэрээс»-ээс «Тора» судар бүрдэнэ. Чухам ийм учраас «Тора», «Арван гэрээс»-ийн ач холбогдлоор авч үзэхэд Моисей бол хүн төрөлхтөний хөгжилд асар их нөлөө үзүүлсэн, үзүүлсээр байгаа хүн гэж дээдэлж болно. Эдгээр таван номыг хэд хэдэн хүн нийлж бичсэнээс гол ажлыг нь Моисей нугалсан гэж өнөөгийн судлаачид үзэж байна.

Гуравдугаарт еврейн нэг бурхныг тахин шүтэх үзлийг үндэслэгч гэж тооцно. Түүний амьдралын тухай цорын ганц эх сурвалж нь Хуучин Гэрээ билээ. Уг сударт нэг бурхныг тахин шүтэх үзлийг Авраам анх номлосон гэж бий. Гэхдээ Моисей нэг бурхныг тахин шүтэх үзлийг хамгаалж сурталчилахад гол үүрэг гүйцэтгэсэн нь лавтай. Дэлхийн хамгийн том хоёр шашин болох христос, лалын шашнууд еврейчүүдийн нэг бурхныг тахин шүтэх үзлийг өвлөн авсан болохоор нэг бурхныг тахин шүтэх үзлийг хамгаалж чадсан төдийгүй улам түгээн дэлгэрүүлсэн нь аугаа их гавьяа гэж зүй ёсоор тооцогдоно. Цорын ганц бурхны тухай Моисейн үзэл дэлхийн дийлэнх хэсэгт тархжээ.

# 16. Чарлз Дарвин

(CHARLES DARVIN)

1809-1882



Байгалийн сонгон шалгарлаар органик хувьсал явагддаг тухай онолыг үндэслэгч алдарт эрдэмтэн Ч.Дарвин Английн Шрусбери хотод 1809 оны хоёрдугаар сарын 12-ны өдөр төржээ. 16 настайдаа Эдинбургийн их сургуульд элсэж анагаах ухаан судалж эхэлсэн боловч уйтгартай санагдахаар нь гарч шашин судлахаар Кембрижийн их сургуульд шилжин суралцжээ. Энд ирээд мөн хичээлдээ мэрийсэнгүй, хамаг цагаа морь унах буу буудахад зориулж байв. Гэвч нэг профессор багшаа ятгаж байж английн усан цэргийн «Бигль» усан хөлөгт байгаль судлаачаар томилогджээ.

22 настай Ч.Дарвиний суусан "Бигль" усан хөлөг таван жилийн хугацаанд дэлхийг тойрон аялал хийж Өмнөд Америкийн эргээр мөн очжээ. Аялалын хугацаанд залуу судлаач Галапагоссын бүлэг арал, Номхон, Энэтхэгийн далайн болон Өмнөд Атлантикийн арлуудыг нүдээр үзэж байгалийн сонин хачин үзэгдлүүдтэй танилцаж хүй нэгдлийн үеийн байдлаар амьдарч байгаа омогт очиж чулуужсан олон эд зүйлс илрүүлж тоймгүй олон төрлийн ургамал, олон араатан амьтныг харжээ. Энэ үеэс харсан, үзсэн бүхнээ тэмдэглэдэг зуршилтай болов. Чухамдаа аялалын явцад хийсэн тэмдэглэл нь хожмоо эрдэм шинжилгээний ажлынх нь үндэс суурь болсон ажээ.

Залуу судлаач 1836 онд эх орондоо буцан ирээд дараачийн хорин жилд нь цуврал ном хэвлүүлж Английн хамгийн нэрт биологчийн алдар хүртжээ. Амьтан, ургамлын төрлүүд анх үүсэн бий болсон хэлбэрээрээ байгаад байдаггүй, хөгжлийнхөө явцад хувьсан өөрчлөгдөж байдаг гэсэн суут дүгнэлтээ Ч.Дарвин 1837 онд хийжээ. Гэхдээ тэр үед хувьслын шалтгааныг тогтоож чадахгүй байлаа. 1838 онд Томас Мальтусын "Ард түмний сууршилын хуулийн тухай туршлага" номтой танилцаад амьд байхын төлөө тэмцлийн явцад байгалийн сонгон



шалгаралт явагддаг юм байна гэсэн бодол санааг дэвшүүлэв.

Гэвч Дарвин байгалийн сонгон шалгарлын тухай нээлтээ олон нийтэд зарлахаа түр азнав. Бөөн дайралт ирэхийг мэдэж гаргасан таамаглалаа баттай хамгаалах бэлтгэл ажил хийжээ.

Шинэ онолынхоо үндсийг 1842 онд гаргасан ч 1844 оноос тусгай ном бичиж эхэлжээ. 1858 онд аугаа их бүтээлдээ нэмэлт засвар хийж байх үедээ английн судлаач А.Р.Уоллесийн ирүүлсэн хувьслын онолын тухай гар бичмэлтэй танилцав. Тэгтэл Уоллесийн онолын дийлэнх зүйл Ч.Дарвиний бүтээлтэй яг таарсан байлаа! Тэгээд хоёр эрдэмтэн зохицож Ч.Дарвин номоо А.Р.Уоллес гар бичмэлээ нэгэн баримт болгон шинжлэх ухааны олон нийтэд танилцуулжээ.

Гэтэл ямар ч шуугиан дэгдсэнгүйд Ч.Дарвин гайхжээ. Дараа жил нь "Төрлийн үүсэл" номоо хэвлүүлэхэд бөөн хэлэлцүүлэг маргаан өрнөжээ. "Байгалийн сонгон шалгарлын үр дүнд төрөл бий болсон нь", "Амьдралын төлөө тэмцлийн явцад хүчтэй төрөл нь амьд үлддэг" гэсэн сэдвээр мэргэжлийн бус хүмүүс ч маргалдаж байлаа. Хүнтэй адилхан сармагчингаас хүн үүссэн гэсэн үзэл санааг дэвшүүлсэн "Хүн үүссэн нь, эр эмийн сонголт" номоо Ч.Дарвин 1871 онд хэвлүүлсэн нь урьдын дуусаагүй байсан маргааныг улам дэврээлээ.

Аялал хийж явахдаа Өмнөд Америкт хорт могойд хатгуулсан болон халуун орны өвчин тусаж байсан нь нас ахихад нь сэдэрч бие тааруу Ч.Дарвин дээрх маргаан хэлэлцүүлэгт оролцсонгүй, харин түүний өмнөөс түүний онолыг баримтлагч эрдэмтэн Томас Г.Хаксли оролцжээ. 1882 онд Ч.Дарвинийг нас барах үед дийлэнх эрдэмтэд түүний онолыг хүлээн зөвшөөрсөн байлаа.

Ч.Дарвинаас түрүүнд францийн эрдэмтэн Жан Ламарк, өвөг эцэг Эрамз Дарвин нь хувьслын тухай онолыг гаргаж тавьсан боловч шинжлэх ухааны ертөнцийг нотолгоотой материалаар итгүүлж чадаагүй юм. Гэтэл Ч.Дарвин хувьслын шалтгаан болох байгалийн сонгон шалгарлын учрыг үнэмшилтэй нотолж өөрийн дэвшүүлсэн таамаглалаа батлаж чадсанаараа хүн төрөлхтөний өмнө гайхамшигтай гавьяа байгуулсан юм.

Ч.Дарвинийг аугаа нээлтээ хийж байх үед Грегорь Мендель удамшлын хуулиудаа боловсруулж байсан боловч их эрдэмтний хувьслын тухай онолд тэр тухай огт дурдаагүй байдаг юм. Генетикийн удамшил, байгалийн сонгон шалгарлын тухай ойлголтуудыг багтаасан хувьслын тухай орчин үеийн онол нь Ч.Дарвиний дэвшүүлсэн онолоос илүү бүрэн болох нь мэдээж билээ.

Түүний хийсэн хосгүй нээлтийн хүний оюун ухаанд үзүүлсэн нөлөө зүйргүй их юм. Шинжлэх ухаан талаас нь авч үзэхэд л биологийн шинжлэх ухаанд хувьсгал болсон юм. Байгалийн шалгарлын тухай зарчмыг хүн судлал, социологи, улс төрийн шинжлэх ухаанууд, эдийн засаг зэрэг олон шинжлэх ухаанд шүүрэн авч хэрэглэх болов. Ч.Дарвиний онол нь хүн, байгалийн тухай ойлголтуудыг үндсээр нь өөрчлөв. Хүний төрөл шинжлэх ухаанд тэргүүлэх байр суурь эзэлдэгээ больж төрлүүдийн нэгний хэмжээнд хүртэл буурав. Хүн хэрхэн үүссэн тухай явцыг тайлбарлахдаа хувьслын онолыг хэрэглэдэг болсноор хүн төрөлхтөний өмнө тавигдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд шинжлэх ухааны ач холбогдлыг улам нэмэгдүүлэв.

Чухамдаа Ч.Дарвиний нээлт нь энэ дэлхий ертөнцөд хүний эзэлж байгаа байр суурийн тухай хүн төрөлхтөний үзэл бодлыг өөрчилж чадсан билээ.

# 17. Цинь Шихуанди

(SHIH HUANG TI)

Манай эриний өтнөх 259 - 210 он



Манай эриний өмнөх 238-210 онуудад Хятад улсыг захирч байсан Шихуанди хаан зэр зэвсгийн хүчээр тус улсыг нэгтгэж аугаа их өөрчлөн байгуулалт хийжээ. Цинь Шихуандигийн түүхэнд гүйцэтгэсэн их үүргийг бүрэн ойлгохын тулд тэр үеийн түүхэн бодит байдлыг товчхон ч атугай сонирхох хэрэгтэй.

Чжоу угсааны хаадын үед Хятад улс бие даасан феодалын улсууд болон хуваагдаж толгой толгойгоо мэдсэн жижиг феодалууд эрх мэдлийн төлөө хоорондоо тасралтгүй дайтсаар байв. Хоорондоо дайн дажин хийсээр байгаа феодалын жижиг улсуудаас хамгийн хүчтэй нь Хятад улсын өрнөд хэсэгт оршдог Цинь улс байлаа. Тус улсыг захирагч нар үйл ажиллагаандаа хятадын гүн ухааны сургаал болох Хууль сахиулагчдын дэгийг баримталдаг байв.

Уг нь Күнз удирдагч хүн харьяат ард иргэдээ хувийн ёс суртахууны шилдэг үлгэр жишээгээр удирдах ёстой гэж сургадаг бол Хууль сахиулагчдын дэгийг баримтлагчид бол харьяат иргэдийг ёс суртахууны шилдэг жишээгээр удирдан жолоодно гэж болохгүй, чухамдаа хүн бүр үг дуугүй, заавал биелүүлэх үүрэгтэй хуулиудын хүчээр улс орныг удирдах хэрэгтэй гэж үздэг байв.

Улс орны удирдагчид нь Хууль сахиулагчдын дэгийг чанд мөрдлөг болгон хатуу чанга бодлого явуулж байсны үр дүнд Шихуандийг төрөх үед Цинь улс Хятадын хамгийн хүчирхэг улс болж чадсан байв. Чжэн манай эриний өмнөх 246 онд 13 настайдаа хааны ширээнд заларсан ч нас бие гүйцэх хүртэл нь түүний нэрийн өмнөөс нь улс орныг нь удирдаж байжээ.

Насанд хүрч төрийн эрхийг гартаа авмагц авьяаслаг цэргийн дарга нарыг удирдаж бусад феодалын улсуудтай дайтаж өөрийн оронтой нэгтгэж эхэлжээ. Удтал дайтсаны үр дүнд 221 онд бүх жижиг улсуудыг нэгтгэн дуусгаж өөрийгөө Шихуанди буюу "Тэргүүн хаан" гэж

Өргөмжилжээ.

Шихуанди хаан улс орноо нэгтгэж дуусмагц дахин тархай бутархай байдал гаргахгүйн тулд төр улсын удирдлагын бүтцийг үндсээр өөрчлөх арга хэмжээг яаралтай авав. Улс орноо 33 мужид хувааж муж бүрийг хаан томилдог иргэний амбан захирагчаар удирдуулах болж амбан захирагчийн албан тушаалыг өвлүүлдэг зарчмыг болиулав. Тэрчилэн сайн ажилладаг амбан захирагчийг муж дамжуулан ажиллуудаг журам тогтоосноор тухайн мужид нөлөөгөө өргөжүүлэх бололцоог хаав. Тэрчилэн муж бүрт цэргийн удирдагч тэрчилэн цэргийн болон иргэний захиргааны үйл үйл ажиллагааг зохицуулж байх төвөөс томилогддог түшмэлийг орон тоог гаргажээ.

Мөн нийслэлийг орон нутгуудтай холбосон холбооны боловсронгуй бүтцийг бий болгосноор мужуудад болж байгаа үйл явдлыг сайтар хянах, бослого гаргасан мужуудад цэрэг шуурхай илгээх боломжийг бий болгов. Шихуанди зарлиг гаргаж мужуудад байгаа сурвалжит ноёд цөм нийслэл Сяньянь хотод амьдрах болсноор тэдний үйл ажиллагааг хатуу хянаж байдаг болов.

Хаан Хятад улсыг улс төрийн болон цэргийн талаар нэгтгээд зогсоогүй худалдааны нэгдмэл бүтэцтэй болгох талаар өргөн шинэтгэл явуулав. Улс орон даяар хэмжээ, хүндийн нэгдмэл хэмжүүр бий болгож зоосны бүтцийг адил болгож зам суваг барих ажлыг төвөөс хянадаг болгожээ. Хаан хамгийн гол нь Хятад улс даяар хаанаас гаргасан хуулиудыг л мөрддөг болгож бичгийн хэлүүдийг ч цэгцэлжээ.

Шихуанди хаан манай эриний өмнөх 213 онд хүн төрөлхтөний түүхэнд хамгийн анхны бүх нийтийг хянах бүдүүлэг хууль гаргаж хөдөө аж ахуй, анагаах ухаан, Цинь угсааны хаадын түүх, Хууль сахиулагчдын дэгтэй холбоотойгоос бусад бүх номоос тус бүр нэг хувийг нь хааны номын санд хадгалж бусдыг нь шатаах үүрэг өгчээ.

Хаан идэвхтэй гадаад бодлого явуулж улс орныхоо өмнөд зүгт дайтаж нилээд том газар нутгийг эх орондоо хүчээр нэгтгэжээ. Тус орны хойд, баруун хэсгээр хиллэдэг орнуудын байнгын дайралтаас хамгаалах зорилгоор хойд хил дээрх хэрмүүдийг хооронд нь холбож Хятадын алдарт цагаан хэрмийг босгосон билээ. Хаан бүтээн байгуулалтын нүсэр том төлөвлөгөө хэрэгжүүлж аян дайн өдөөж байхдаа ард түмэндээ татварын ихээхэн дарамт үзүүлж байсан нь олон түмний дургүйцлийг хүргэж байлаа.

Гэвч хатуу чанга хяналтын нөхцөлд бослого гаргах бололцоогүй байсан тул хааныг алах оролдлого олон удаа гарсан ч ганц нь ч бүтэмжтэй болоогүй ажээ.

Шихуанди хаан манай эриний өмнөх 210 онд насан өөд болсны дараа хоёр дахь хүү Эр Цинь Шихуанди нь залгамжлагчаар нь өргөмжлөгджээ. Гэвч эцгээсээ зохион байгуулах авьяас чадвар арван хуруу дутуу хүү нь улс орноо удирдаж чадсангүй, хаанаар өргөмжлөгдөөд дөрвөн жилийн дараа алагдаж бослого гаргасан тариачид Хааны ордон, номын санг үнсэн товрог болгож Цинь угсааны бүх хүмүүсийг хүйс тэмтэрчээ.

Гэвч хятадын ард түмэн эх орноо нэгтгэж эмх замбараагүй байдлыг эцэс болгосон Шихуанди хааны үйл ажиллагааг дэмжин үргэлжлүүлсэн юм. Хятад улсын төрийн эрхэнд гарч ирсэн

Хань уг-сааны хаад Шихуанди хааны сэдэж байгуулсан засаг захиргааны тогтолцоог хэвээр хадгалж дараагийн 21 зууны турш бараг өөрчлөөгүй билээ. Цинь угсааны хаадын засаг захиргааны хатуу хяналттай бүтцийг зөөлрүүлж Хууль сахиулагчдын дэгийн сургаалыг таягдан хаяж Күнз сургаалийг төрийн албан ёсны гүн ухаанаар өргөмжилсөн боловч Шихуанди хааны бий болгосон улс төрийн нэгдмэл байдлыг үргэлж хадгалсаар байжээ.

Дэлхийд хүн амаараа тэргүүлж байдаг Хятад улсыг нэгтгэж нэгэн том улс болоход өөр олон хүмүүс түүний дотор Суй Веньди зэрэг төрийн зүтгэлтнүүд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн ч хамгийн гол гавьяаг Шихуанди хаан байгуулсантай хэн ч маргахгүй.

Шихуанди хааны үйл ажиллагааны тухай ярихад түүний шадар туслах, цэргийн яамны алдарт сайд Ли Сюгийн тухай дурдахгүй өнгөрч хэрхэвч болохгүй. Ли Сю хааны дотнын зөвлөх байсны хувьд аугаа шинэтгэл хийхэд түүнд маш их нөлөө үзүүлсэн байна.

Шихуанди хааны түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар маргаан бий. Түүнийг ном шатаасан, олон түмний бослого тэмцлийг хэрцгийгээр дарж байсан гэх зэргээр күнзийн сургаал баримтлагчид буруушаадаг бол хятадын коммунистууд түүнийг дэвшилтэт сэтгэгч гэж үнэлдэг, өрнөдийн эрдэмтэд Наполеонтой харьцуулдаг. Гэхдээ Шихуанди хааныг Ромын эзэнт улсыг үндэслэгч Август Цезарьтай харьцуульбал зүйтэй юм шиг санагдана. Энэ хоёр суут хүмүүс газар нутаг, хүн амаар бараг адилхан улс гүрэн байгуулсан. Гэвч А.Цезарийн байгуулсан том улс түүхийн богинохон хугацаанд наслаад задарсан бол Шихуанди хааны байгуулсан гүрэн улс төрийн нэгдлээ өдий хүртэл хадгалсаар байгаа нь түүний үйл ажиллагаа ямархуу их үр дүнтэй байсныг үнэм-шилтэй нотлон харуулж байна.

# 18. Август Цезарь

(AUGUSTUS CAESAR)

Манай эриний өмнөх 63 он-манай эриний 14 он



Август Цезарь бол Ромын эзэнт гүрнийг үндэслэгч юм. Манай эриний өмнөх нэгдүгээр зууны үед Ромын улсыг сүйрүүлж байсан олон жилийн сунжирсан дайныг зогсоож Ромын эзэнт гүрнийг байгуулж дараачийн хоёр зууны турш энх амгалан байх нөхцөлийг бүрдүүлсэн гавьяатай билээ.

Гай Октавиус (ер нь Октавиан нэрээрээ нийтэд алдартай ба "Август" хэргэмийг 35 настайдаа хүртжээ.) нь манай эриний өмнөх 63 онд төрсөн ба Ромын улс төрийн гарамгай зүтгэлтнүүдийн нэг болох Юлий Цезарийн өргөмөл ач хүү байсан юм. Хууль ёсны хүүхэдгүй Юлий Цезарь залуу Октавианыг ямагт дэмжиж улс төрийн талаар өсөж өндийхөд нь тусалжээ. Түүнийг 18 настай байхад Юлий Цезарь алагдсан нь Ромын улс төр, цэргийн зүтгэлтнүүдийн дунд бөөн тэмцэл өрнөх шалтгаан болжээ. Анхандаа Октавиан тэмцэл сөргөлдөөнийг огт тоохгүй байсан ч Ю.Цезарийн өргөмөл хүү гэсэн нэрээр хэд хэдэн нөлөө бүхий хүмүүсийн дэмжлэгийг нь авч чадав.

Гэвч Ю.Цезарийн хамтран зүтгэгчийн нэг болох Марк Антоний цэргийн дийлэнх хэсгийн дэмжлэгийг авч удтал байлдаан хийв. Тэр дайны уршгаар Ромын хоёр хуваагдаж дорнод хэсгийг нь М.Антоний, өрнөд хэсгийг нь Октавиан захирдаг болж хэсэг хугацаанд түр эвлэрэв.

Энэ хооронд М.Антоний гоо бүсгүй Клеопатрагийн хормойноос зүүгдэж хамаг цагаа "хоосон" үрж байхад Октавиан байр сууриа улам бэхжүүлж амжжээ. Хоёр гол улс төрийн зүтгэлтний хоорондын шийдвэрлэх тулалдаан манай эриний өмнөх 31 онд Акцийн хошууны орчим болж тэнгисийн амь өрсөн тулалдаанд Октавиан ялалт байгуулж Антоний, Клеопатра нар амиа хорлов.

Эрх мэдэлд хүрэхийн төлөө харгис хэрцгийгээр тэмцэж байсан Август ялалт байгуулсны дараа энх амгаланг тууштай хамгаалагч болон хувирав. Манай эриний өмнөх 27 онд

сенаторуудыг тайвшруулахын тулд бүгд найрамдах улсыг сэргээж бүх албан тушаалаасаа татгалзаж байгаагаа мэдэгдэв. Гэвч ромын цэргийн дийлэнх хэсэг байрлаж байгаа Испани, Бага Ази, Сирийн амбан захирагч хэвээр үлдэж байгаа болохоор бодит эрх мэдэл түүний гарт хэвээр байлаа. Сенат түүнд Август хэргэм олгосон ч хааны бүрэн эрх олгосонгүй.

Манай эриний 14 онд Август Цезарь нас барах үедээ бүгд найрамдах засаглалыг халж хааны хэмжээлшгүй эрх мэдлийг авч чадсан тул түүний залгамжлагч дагавар хүү нь эрх мэдлийг шууд шилжүүлэн авсан билээ.

Август авьяаслаг, сайхан сэтгэлтэй дарангуйлагчийн шилдэг үлгэр жишээ болон дэлхийн түүхэнд мөнхөрсөн юм. Ромын иргэний дайны үеэс тасралтгүй үргэлжилсээр байсан дайтах явдлыг зогсоож бүрэн эвлэрүүлж чадсан төрийн зүтгэлтэн билээ.

Август бараг дөчин жилийн турш Ромын эзэнт гүрнийг захирч нийт Европод нөлөө үзүүлж чадсан юм. Армиа биечлэн удирдаж Испани, Швейцар, Бага Ази, Балканы хойгийн ихэнх хэсгийг бүрэн эзлэж улсынхаа умард хилийг Рейн-Дунай мөрнөөр тогтоосон нь хэдэн зуун жилийн турш хэвээр хадгалагдаж байсан юм.

Август Цезарь чадварлаг төрийн зүтгэлтэн байсны хувьд иргэний албыг зохион байгуулахад гол үүрэг гүйцэтгэж татварын албаны бүтэц, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгож армиа шинэчилж цэрэгжүүлсэн усан флот байгуулсан юм. Августын захиргааны үед зам харилцааны сүлжээ бий болж барилга байгууламж олноор боссон. Түүний санаачилгаар сүм хийд олноор баригдаж эртний ромын ёс заншлыг сэргэж гэр бүл болох, хүүхэд хүмүүжүүлэх хуулиуд батлагдан гарчээ. Манай эрний өмнөх 30 оноос ард түмний амьдралын түвшин дээшилснээр Август сэтгэл тайван амьдарч ажиллаж байв.

Түүнийг хаан байх үеийг Ромын уран зохиол, урлагийн алтан үе гэж зүй ёсоор нэрлэдэг. Алдарт зохиолч Рим Виргилий, Гораций, Тит Ливий нар шилдэг бүтээлүүдээ түүний дэмжлэгтэйгээр туурвиж байв.

Харамсалтай нь, Август хүүхэдгүй, түүнээс гадна зээ хүү, хоёр ач хүү нь нас барсан учир дагавар хүү Тиберийгээ өөрийн залгамжлагчаар өргөмжлөв. Августын үед Ромын эзэнт гүрэнд бий болсон тайван байдал нь хоёр зуу гаруй жил үргэлжилж түүний залгамжлагчдын байлдан түрэмгийлсэн орнуудад Ромын соёл гүнзгий нэвтэрсэн билээ.

Ромын эзэнт гүрэн бол эртний түүхийн хамгийн алдарт улс билээ. Ром улс нь эртний соёл иргэншил байсан төдийгүй эртний улсуудын хамаг ололт амжилт Өрнөд Европ руу нэвтрэх суваг болж байлаа.


Августыг түүний өвөг болох алдарт Юлий Цезарьтай харьцуулахад гадаад төрх байдлын хувьд ганган, илүү ухаантай, цэргийн жанжны хувьд ямагт ялалт байгуулж байсан ч олон түмний бодол санааг эзэмдэх талаар дутуу байсан юм.



# 19. Николай Коперник

(NICOLAUS COPERNICUS)

1473-1543



Польшийн алдарт одон орон судлаач Николай Коперник 1473 онд Висла мөрний эрэг дээрх Торунь хотод баян айлд мэндэлжээ. Идэр залуудаа Краков хотын их сургуульд сурч байхдаа одон орны судлал сонирхож байв. Дараа нь Италийн Болонь, Падуан хотуудын их сургуульд хууль зүй, анагаах ухаан судалж Феррара хотын их сургуульд докторын зэрэг амжилттай хамгаалжээ. Амьдралынхаа ихэнх хэсгийг Фройнбург хотод сүмд ажиллан өнгөрөөжээ. Мэргэжлийн хувьд одон оронч биш байсан ч чөлөөт цагаараа дур сонирхолдоо татагдан судалсаар хүн төрөлхтөний түүхэнд нэр үлдээсэн аугаа нээлтээ хийсэн билээ.

Коперник Италид суралцаж байхдаа Дэлхий Нарыг тойрч эргэдэг гэсэн эртний грекийн гүн ухаантан (манай эриний өмнөх III зуун) Аристарх Самосскийн үзэлд санаатай танилцаж түүний үнэн болоход итгэжээ. Тэгээд дөчин настайдаа нар төвтэй гариг эрхсийн тухай таамаглалаа энгийн хэлбэрээр илэрхийлсэн гар бичмэлээ анд найзууддаа өгч уншуулжээ. Олон жилийн турш ажиглалт явуулж тооцоо хийж өөрийн онолыг нарийвчлан тайлбарлаж бодитой нотолгоог дэвшүүлэн тавьсан "Тэнгэрийн эрхсийн эргэлтийн тухай" нэртэй цуут номоо туурвижээ.

Коперник жаран настайдаа 1533 онд Италийн Ром хотод лекц уншихдаа хамба ламын эгдүүцлийг хүргэхгүйгээр өөрийн дэвшүүлсэн онолын гол үндэслэлүүдийг тайлбарлаж байжээ. Гэвч далан насны өндөрлөгт хүрсэн үедээ дөнгөж сая номоо хэвлүүлэхээр зориглож нүд анихаасаа хэдхэн хоногийн өмнө 1543 оны тавдугаар сарын 24-ний өдөр хэвлэх үйлдвэрээс номынхоо анхны хувийг нь гар дээрээ авч бөөн баяр хөөр болж байжээ.

Коперник "Тэнгэрийн эрхсийн эргэлтийн тухай" нэртэй цуут номондоо Дэлхий өөрийн тэнхлэгээ тойрон эргэдэг, Сар Дэлхийг тойрч эргэдэг, харин Дэлхий болон бусад гариг Нарыг тойрч эргэдэг гэж тас түс бичсэн байлаа. Гэвч Коперник түрүүчийн үеийн эрдэмтдийн адил

нарны тогтолцооны далайцийг дугуу үнэлсэн, тийм ч учраас түүний дэвшүүлсэн онол математикийн хувьд авч үзвэл буруу байсан юм.

Гэвч энэ ном хэвлэгдэж гарангуутаа олон нийтийн анхаарлыг гойд их татсан байна. Ялангуяа энэ номын нөлөөгөөр олон одон оронч түүний дотор данийн одон оронч Тихо Браге тэнгэрийн эрхсийн хөдөлгөөнд нарийвчилсан ажиглалттооцоохийжэхэлжээ. Гэхдээ Т.Брагийн хийсэн ажиглалтын тооцоог ашиглаж германы одон оронч Иоганн Кеплер од, гаригуудын хөдөлгөөний хуулиудыг үнэн зөв тодорхойлсон билээ.


Аристарх Самосский Коперникээс 17 зууны өмнө нар төвтэй гариг эрхсийн тухай таамаглалыг дэвшүүлсэн боловч түүнийгээ тодорхой тайлбарлан бичиж хэвлүүлж байгаагүй юм. Чухамдаа Н.Коперник таамаглалаа математик үндэслэлээр баталгаажуулж хамгийн гол нь одон орны ажиглалтуудаар шалгаж Дэлхий Ертөнцийн төв болох тухай хуучны онолуудтай харьцуулах бололцоог олгосон шинжлэх ухааны онолын түвшинд хүргэж чадсан билээ.

Коперникийн онол нь Ертөнцийн тухай хүн төрөлхтөний ойлголтод хувьсгал хийж ертөнцийг үзэх гүн ухааны суурь үзлүүдэд зарчмын ач холбогдолтой өөрчлөлт оруулсан билээ. "Тэнгэрийн эрхсийн эргэл-тийн тухай" ном нь Галилей, Кеплер нарын алдарт эрдэмтдийн бүтээлүүдийн эхлэл болж тэдгээр нь Ньютоныг гарамгай нээлтүүдээ хийхэд хүргэсэн юм. Энэ утгаар авч үзвэл Коперникийн ном нь орчин үеийн шинжлэх ухааны үсрэнгүй хөгжлийн гарааны эхлэл болсон билээ.

# 20. Антуан Лоран Лавуазье

(ANTOINE LAURENT LAVOISIER)

1743-1794



Францийн нэрт эрдэмтэн А.Л.Лавуазье химийн шинжлэх ухааны хөгжилд цаглашгүй их үүрэг гүйцэтгэсэн билээ. Түүнийг Париж хотод 1743 онд төрж байх үед химийн шинжлэх ухаан физик, математик, одон орны судлалаас хол хоцорсон байлаа. Химичид олон чухал нээлтүүд хийж байсан ч тэр бүх нээлтийг эмхэтгэн нэгтгэх онолын үндэс илт дутагдаж байв. Тэр үед агаар, усыг энгийн бодис гэж үзэж шатах үйлдлийг бүрэн таньж мэдээгүй, шатдаг эд зүйлсэд "флогистон" гэдэг бодис агуулагддаг ба тэр нь шатах үйлдлийн явцад агаарт цацагдана гэж ойлгодог байжээ.

1754 оноос 1774 онуудад Жозеф Блэк, Жозеф Пристли, Генри Кавендиш гэх зэрэг авьяаслаг химичид хүчилтөрөгч, устөрөгч, азот, нүүрсхүчлийн хий зэрэг чухал хийнүүдийг нээсэн боловч флогистон гэдэг бодис байдаг тухай онолыг баримталж байсан учраас нээж олсон хийнүүдийн мөн чанар, ач холбогдлыг бүрэн гүйцэд таньж мэдээгүй юм.

Чухамдаа химийн шинжлэх ухааны дэвшлийн энэхүү шийдвэрлэх үед Лавуазье тусдаа мэдээллүүдийг нэгтгэн дүгнэж химийн шинжлэх ухааныг зөв чиглэлээр хөгжих нөхцөлийг бүрдүүлж өгсөн билээ. Флогистон гэдэг бодис бий гэдэг онол бол буруу, байгальд тийм нэртэй бодис ердөө ч байхгүй гэж шүүмжилж шатдаг эд зүйлс, хүчилтөрөгч хоёрын химийн харилцан үйлчлэлийн үр дүнд шатах үйлдэл явагддаг юм, ус бол энгийн бодис биш чухамдаа хүчилтөрөгч, устөрөгч хоёрын нэгдэл тэрчилэн агаар бол мөн жирийн бодис биш чухамдаа хүчилтөрөгч, азотын хийнүүдийн нэгдэл юм гэж мэдэгджээ.

Гэтэл тухайн үеийн тэргүүлэх эрдэмтэд түүний онолыг хүлээн зөвшөөрсөнгүй. Тиймд Лавуазье 1789 онд "Химийн энгийн сурах бичиг" гэдэг номоо хэвлүүлж өөрийн таамаглал

нотолгоог нийтлүүлсэн нь олон залуу эрдэмтдийн талархал дэмжлэгийг хүлээжээ. Ус, агаар нь химийн элемент биш гэдгийг нотлоод хамгийн энгийн гэж үзсэн эд зүйлсийн нэрсийг жагсаажээ. Уг номонд хэд хэдэн алдаа байсан ч химийн элементүүдийн өнөө үеийн жагсаалт нь Лавуазегийн хийсэн хүснэгтийн өргөжүүлсэн хувилбар байгаа юм.

Бертолле, Фуркруа, Гитон де Морво нартай хамтран Лавуазье химийн нэр томъёоны анхны системийг боловсруулжээ. Тэрхүү системд химийн бодисуудыг шинж чанараар нь дэс дараалуулан байрлуулсан ба тийнхүү химийн нэр томъёоны анхны нэгдмэл систем бий болсноор олон орны химичид хийсэн нээлтийнхээ тухай бие биендээ түргэн мэдээлэх бололцоо үлэмж нэмэгдсэн билээ.

Химийн урвалд орж байгаа элементүүд яаж ч задарч нийлж мөн чанар нь өөрчлөгдлөө гэсэн жин нь яг хэвээр байдаг гэдгийг Лавуазье нотолж химийн урвалын үед жин хадгалагдах хуулийг анх нээсэн юм. Химийн урвалд орж байгаа элементүүдийг жигнэж байхын чухлыг анхааруулж байсны үр дүнд химийн шинжлэх ухаан жинхэнэ утгаараа ямагт нарийн тооцоо шаардсан шинжлэх ухаан болон хувирч цаашдын хөгжлийнх нь дардан замыг нээсэн юм.

Лавуазье химийн шинжлэх ухааны үндсийг тавьж түүний хөгжлийн зөв хандлагыг зааж чиглүүлсэн болохоор түүнийг "орчин үеийн химийн шинжлэх ухааны эцэг" гэж зүй ёсоор өргөмжилдөг юм.

Лавуазье геологийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж физиологийн шинжлэх ухаанд дорвитой нээлт хийсэн юм. Лапластай хамтран судалгаа хийж амьсгалах физиологийн үйлдэл нь алгуур шатах үйлдэлтэй адилхан гэдгийг нотолж чадсан. Өөрөөр хэлбэл органик эдийн дотоод шаталтын үр дүнд хүн, амьтад эрчим хүч авдаг юм, тэд агаараас хүчилтөрөгч сорж амьсгалдаг гэдгийг тайлбарласан юм.

Лавуазье идэр залуудаа хууль зүй судалж докторын зэрэг хамгаалсан ч энэ мэргэжлээрээ ер ажиллаагүй юм. Гэхдээ засаг захиргаа, олон нийтийн ажилд ихээхэн анхаарч Францийн хааны Шинжлэх ухааны академийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож "Ferme Genegale" нэртэй татвар хураах албанд ажиллаж байв. 1789 онд хувьсгалт засгийн газар түүнийг "Ferme Genegale" байгууллагын бусад 27 гишүүний хамт цөмийг нь гэр бүлтэй нь хамт баривчилжээ. 1794 оны тавдугаар сарын 8-нд тус татварын байгууллагын бүгд 28 гишүүнийг нэг өдөр байцааж толгойг нь тасдан цаазлах ял оноожээ. Эрдэм судалгааны ажилд нь насан туршид нь тусалж байсан эхнэр нь нөхрийнхөө эх орон, шинжлэх ухаан өмнө байгуулсан асар их гавьяаг шүүхийн хуралдаан дээр тайлбарлан хэлж амийг нь өршөөхийг гуйхад шүүгч "Бүгд найрамдах улсад ухаантнууд хэрэггүй." гэж үгийг нь эс тоож цаазлах ялыг хэвээр баталж байжээ.

Их математикч Лагранж түүнийг цаазлуулсныг дуулаад "Энэ аугаа толгойг тасдахад хэдхэн секунд хэрэгтэй байж, гэтэл тийм толгойг бий болгоход хэдэн зуун жил ч багадна." гэж харамсан өгүүлж байв.

# 21. Их Константин

(CONSTANTINE THE GREAT)

280-337



Их Константин бол Ромын эзэнт гүрний түүхэн дэх анхны христос шүтлэгтэй хаан байсан билээ. Хаан христосын шашныг сурталчлан дэлгэрүүлэхийг ил дэмжиж эл шашныг хавчигдан гадуурхагдсан хэдхэн тооны бишрэн шүтэгчдийн хэмжээнээс нь Европ тивд бүхэлд нь ноёрхсон шашин болгон хувиргаж чадсан бодлого явуулснаараа хүн төрөлхтөний түүхэнд балрашгүй ул мөрөө үлдээсэн юм.

Өнөөгийн Сербии улсын нутаг дэвсгэр дээр орших Наиссе хотод (одоогийн Ниш хот) 280 оны үед ромын цэргийн зүтгэлтний гэр бүлд төржээ. Бага, идэр насаа хаан Диоклетианий ордонд Никомеди хотод өнгөрөөжээ.

305 онд Диоклетиан хаан ширээнээсээ бууж Константиний эцэг Констанций Ромын эзэнт гүрний өрнөд хэсгийн захирагч болжээ. Дараа жил нь эцэг нь өөд болоход арми нь Константинийг хаанаар өргөмжлөв. Гэвч бусад цэргийн жанжин нь дургүйцэж хэд хэдэн удаа иргэний дайн дэгдээж тэр дайн нь 312 он хүртэл үргэлжилжээ. Энэ онд Ром хотоос холгүй Мильвиний гүүрийн ойролцоо болсон тулалдаанд Константин хамгийн сүүлчийн өрсөлдөгч болох цэргийн жанжин Максенийг дийлжээ.

Ийнхүү Константин Ромын их эзэнт гүрний өрнөд хэсгийг дангаараа захирах болов. Тус эзэнт гүрний дорнод хэсгийг захирагч жанжин Лицинийтэй байлдаан өдөж түүнийг 323 онд дийлж 337 онд насан эцэслэх хүртлээ Ромын эзэнт гүрнийг бүхэлд нь ганцаараа захирч байсан юм.

Константин хаан чухам хэдэн оноос христос шашныг таашаадаг болсон нь тодорхойгүй байдаг. Цэргийн жанжин Максенийтэй байл-даан хийхийн өмнөхөн тэнгэрт "Чи ялна!" гэсэн галт хэрээс харсан гэдэг домог бий. Энэ домог үнэн худал эсэх нь хамаагүй, Константин хаан христосын шашныг түгээн дэлгэрүүлэхэд бүхий л амьдралаа зориулсан юм.

Хаанаар залраад түүний гаргасан хууль эрхийн бичгүүд дотор Миланий зарлиг чухал ач холбогдолтойд тооцогддог. Энэхүү зарлигаар христосын шашныг албан ёсоор хүлээн зөвшөөрч бишрэн шүтэгчдийг нь хавчин гадуурхахыг хоригложээ. Тэрчилэн урьд үед хураагдсан эд хөрөнгийг буцаан олгож бүтэн сайн өдрийг шашны баяр болгон зарлажээ. Гэхдээ энэхүү зарлиг нь ер нь аливаа шашныг хүлээн зөвшөөрсөн баримт бичиг байгаагүйг тэмдэглэх нь зүйтэй. Энэ үеэс хожим нь Европ тивд хэдэн зуун жил үргэлжилсэн иудаизм шашныг гадуурхах үйл ажиллагааны эхлэлийг тавьсан хор уршигтай билээ.

Константин хаан христосын шашныг улсынхаа албан ёсны шашнаар тунхаглаагүй ч түүний гаргасан зарлиг, бодлого нь эл шашныг сурталчлан хөгжүүлэхэд чиглэж байлаа. Христос шашныг бишрэн шүтэгчид түүнийг хаан байх үед албан тушаал ахих бололцоогоор бусад иргэдтэй харьцуулбал илүү байж христос шашны сүм хийд онцгой эрх дарх эдэлдэг болов. Тэр үед Вифлеем хот дахь Христос бурхны сүм, Иерусалим хот дахь Бурхны шарилын сүм зэрэг нэр цуутай сүм хийдүүд сүндэрлэн боссон юм.

Константин хаан шашны үйл ажиллагаанаас гадна төр, засгаа бэхжүүлэхийн төлөө их үйлс хийжээ. Эртний хот Византийг өргөжүүлж түүнийг Константинополь нэртэй болгож эзэн гүрнийхээ нийслэлээр өргөмжилсөн юм. Константинополь хот (өнөөгийн Стамбул хот) дэлхийн их хотуудын нэг болж 1453 он хүртэл Византи улсын нийслэл байсан юм.

Константин хаан шашны дотоод үйл ажиллагаанд мөн хувь их хувь нэмэр оруулсан билээ. Христос шашны мөн чанарын асуудлаар зөрөлдсөөр байсан тухайн үеийнхээ шашны хоёр гол зүтгэлтэн Арий, Афанасий нарын хоорондын зөрөлдөөнийг шийдвэрлэхийн тулд Никее хот дахь сүмд шашны зүтгэлтнүүдийн маргаан зохион байгуулж биечлэн оролцжээ. Энэ маргааны үр дүнд хожмоо христос шашны ортодокс онол болон хувирсан Никейн гэж нэрлэгдсэн итгэл үнэмшлийн билэгтэмдгийг нийтээр нь хүлээн зөвшөөрүүлж чадсан билээ.

Константин хааны иргэний хуулийн талаар авсан арга хэмжээнүүд нь мөн ихээхэн ач холбогдолтой байлаа. Тухайлбал махны худалдаачин, талхчин гэх зэрэг мэргэжлүүдийг өв залгамжлах ёстой гэж зарлаж газар түрээслэгч тариачдыг сууршисан нутгаасаа явахыг хориглосноор хамжлагын тариачид болгон хувиргасан юм. Эдгээр хуулиуд нь нийт дундад зууны европийн нийгмийн байгууллын үндэс суурь болсон түүхтэй.


Константин их харгис, доггшин хаан байжээ. Тухайлбал, зарлиг гаргаж хатан, ууган хүүгээ боож алж байжээ.

Чухамдаа Константин хааны ухаалаг бодлогын үр дүнд христосын шашин өргөн дэлгэрч түүний нөлөө, бишрэн шүтэгчдийн тоо эрс өссөн билээ. Ганцхан зууны хугацаанд христосын шашин дэлхийн хамгийн том гүрэнд ноёлогч шашин болон хувирчээ. Иймд Константин хаан Европийн түүхийн суут хүмүүсийн тоонд зүй ёсоор багтдаг ажгуу.

# 22. Жеймс Уатт

(JAMES WATT)

1736-1819



Уурын хөдөлгүүр зохион бүтээснээрээ алдаршсан шотландын зохион бүтээгч Жеймс Уатт Аж үйлдвэрийн хувьсгалын гол зүтгэлтэн байжээ.

Уурын хөлгүүр зохиосон анхны хүн нь яг Ж.Уатт биш юм. Нэгдүгээр зуунд Александрийн Герон тиймэрхүү төхөөрөмжийн тухай бичиж үлдээсэн байв. Томас Сейвери 1698 онд ус татаж гаргах хөдөлгүүрийн эрх, 1712 онд Томас Нью-Ньюкомен сайжруулсан хөдөлгүүрийн эрхийг авч байжээ. Гэвч Томас Нью-Ньюкомен сайжруулсан хөдөлгүүрийг уурхайн гүнээс ус татан гаргахад л ашигладаг, хөдөлмөрийн бүтээмж нь туйлын бага байв.

Нью-Ньюкомений бүтээсэн хөдөлгүүрийг Уатт 1764 онд засаж байхдаа уурын хөдөлгүүрийг сонирхож эхлэжээ. Уатт нь багаж хэрэгслийн засварчны мэргэжлээр дөнгөж ганц жил суралцсан ч зохион бүтээх төрөлхийн авьяастай залуу байжээ. Нью-Ньюкомений бүтээсэн хөдөлгүүрийг ихээхэн боловсронгуй болгож чадсанаараа уурын хөдөлгүүрийг зохион бүтээгч гэдэг алдрыг зүй ёсоор хүртсэн юм.

Уаттын 1769 онд эрхийг нь авсан анхны боловсронгуй болгосон зүйл нь агшаах тусдаа хорго болсон юм. Тэрчилэн уурын бортогуудыг салгаж 1782 онд давхар үйлдэлтэй хөдөлгүүрийг зохион бүтээв. Дээр дурдсан болон бусад жижиг боловсронгуй болгосон эд зүйлсийн үр дүнд уурын хөдөлгүүрийн хүчин чадал гурваас дөрөв дахин нэмэгджээ.

1781 онд буцан давших хөдөлгөөнийг эргэх хөдөлгөөн болгон хувиргадаг хэд хэдэн эд ангийг хийсний ачаар уурын хөдөлгүүр хэрэглэгчдийн тоо эрс өсөв. 1788 онд хөдөлгүүрийг хурдыг шууд хянах үүрэг бүхий төвөөс зугтаагч тохируулагч тэрчилэн даралт хэмжигч (1790 онд), цахилгаан тоолуур, түвшин заагч, уурын даралтыг багасгаж ихэсгэх хаалт зэргийг мөн бүтээжээ.

Ж.Уатт нь аугаа их зохион бүтээгч байсан ч хийсэн бүтээснээ олны хүртээл болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх талаар санаачилга зүтгэл гаргахгүй байлаа. Аз болоход 1775 онд

инженер мэргэжилтэй ч арилжаа наймааны ажилд дадамгай Мэть Баултон гэдэг хүнтэй хамтран ажиллаж эхэлснээр ажил үйлс нь улам өөдрөг явах болжээ. Тэдний хамтран байгуулсан пүүс нь 25 жилийн хугацаанд олон тооны уурын хөдөлгүүр үйлдвэрлэн борлуулж хоёулаа их баяжээ.

Аж үйлдвэрийн хувьсгалын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн маш олон нээлт байдаг боловч тэдгээр нь аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг механикжуулах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, өөрийн өртгийг багасгахад дорвитой нөлөө үзүүлж чадаагүй юм. Гэтэл чухамдаа Ж.Уаттын зохион бүтээсэн уурын хөдөлгүүр аж үйлдвэрийн хувьсгалд хэн ч маргашгүй эргэлт хийсэн билээ. Түүнээс урьд салхин болон усан тээрэм ашиглагдаж байсан ч эрчим хүчний гол эх үүсгэвэр нь хүний булчингийн хүч хэвээр байлаа. Тэгтэл уурын хөдөлгүүр бий болсноор эрчим хүчний үйлдвэрлэл эрс нэмэгдэж түүний үр дүнд аж үйлдвэрийн салбар эрчтэй хөгжлийн замд шилжин орсон юм.

Уурын хөдөлгүүрийг зөвхөн үйлдвэрүүдэд хэрэглээд зогссонгүй 1873 онд гүн Жоффруа д'Аббан усан хөлөг онгоцыг хөдөлгөхөд амжилттай хэрэглэж эхлэлжээ. 1804 онд Ричард Тревитик галт тэрэгний анхны уурын зүтгүүр үйлдвэрлэв. Ийнхүү уурын хөдөлгүүр бий болсноор усан болон төмөр замын тээврийн тогтолцоо үндсээрээ өөрчлөгдөх эхлэл тавигдсан байна.

Аж үйлдвэрийн хувьсгал нь цаг хугацааны хувьд Америкийн болон Францийн хувьсгалуудтай яг таарсан ч хүн төрөлхтөний өдөр тутмын амьдралд үзүүлсэн нөлөөгөөрөө энэхүү хоёр хувьсгалаас дутахгүй их ач холбогдолтой болсон юм. Иймд Аж үйлдвэрийн хувьсгалын гол хүн Ж.Уатт хүн төрөлхтөний түүхэн дэх суут хүмүүсийн тоонд зүй ёсоор багтдаг юм.



# 23. Майкл Фарадей

(MICHAEL FARADAY)

1791-1867



Хорьдугаар зууныг сансрын, атомын, цахилгаан эрчим хүчний зуун гэх зэргээр олон янзаар нэрлэдэг. Гэвч сансрын аялал, атомын бөмбөгний хүн төрөлхтөний өдөр тутмын амьдралд үзүүлдэг нөлөө тийм их биш. Гэтэл цахилгаан хэрэгсэлгүйгээр өнөө үеийн хүмүүсийн өдөр тутмын амьдралыг төсөөлөх аргагүй юм. Өөрөөр хэлбэл цахилгаан эрчим хүч шиг орчин үеийн амьдралд гүн гүнзгий нэвтгэрсэн техникийн нээлт үгүй билээ.

Цахилгаан эрчим хүчийг хүн төрөлхтөнд нээж өгөхийн тулд дэлхийн янз бүрийн орны эрдэмтэн мэргэд хэдэн зууны турш толгойгоо гашилган нойр хоолоо умартан зүтгэж байсан юм. Үүнд Шарль Огюстен Кулон, Александро Вольта, Ханс Кристиан Эрстед, Андре Мари Ампер нар их хувь нэмэр оруулсан. Гэхдээ английн хоёр суут эрдэмтэн Майкл Фарадей, Жеймс Клерк Максвелл нар хамтарч ажиллаж байгаагүй ч тус бүрийнх нь нээлт бие биенээ нөхөн цахилгаан эрчим хүчийг нээсэн билээ.

М.Фарадей 1791 онд Английн Ньювингтон хотод ядуу айлд төрж бие даан боловсрол олжээ. 14 настайдаа ном хавгаслагч, худал-дагчийн туслах ажилчин байхдаа олдсон боломжийг ашиглан гартаа тааралдсан ном бүрийг уншина. Хорин нас хүрээд английн нэрт эрдэмтэн Г.Дэвийн лекцэнд суудаг болж удалгүй түүний туслах болов. Хэдхэн жилийн дараа гэхэд М.Фарадей математикийн суурь мэдлэг тааруу байсан ч гайхамшигт туршилтуудын үр дүнд физикийн салбарт бие даасан нээлтүүдээ хийж эхэлжээ.

Цахилгааны салбар дахь анхны том нээлтээ 1821 онд хийв. Түүнээс хоёр жилийн өмнө Эрстед жирийн соронзон луужингийн зүү цахилгаан гүйлгэсэн утасны дэргэд тавихад хөдөлж байгааг анх олж мэджээ. Үүнийг дуулаад Фарадей соронзонг тодорхой байрлалд тогтвортой байрлуулбал цахилгаан гүйдэлтэй утас өөрөө хөдлөх юм биш биз гэсэн таамаглал

дэвшүүлэв. Тэгээд энгийн төхөөрөмж хийж утсыг соронзонтой хамт байрлуулж цахилгаан гүйдэл бий болтол нь эргүүлжээ. Чухамдаа бол Фарадей цахилгаан гүйдлийг ямар нэг материаллаг зүйлийг хөдөлгөөнд оруулахад ашиглаж болох анхны цахилгаан хөдөлгүүрийг зохион бүтээсэн юм.

Фарадейн хийсэн цахилгаан хөдөлгүүр нь бүтцийн хувьд бүдүүлэг байсан хэдий ч өнөө үед дэлхий даяар хэрэглэгдэж байгаа бүх цахилгаан хөдөлгүүрийн анхны загвар болсон түүхтэй.

Энэ нээлт бол үнэхээр аугаа байв. Гэвч тэр үед химийн бүдүүлэг батарейгаас өөр зүйлээс цахилгаан гүйдлийг гаргаж авч чадахгүй байсан учраас шинэ нээлтийг өргөн хэрэглэж болохгүй байсан юм. Тиймд Фарадей соронзонг ашиглан цахилгаан гүйдэл гаргах өөр аргыг эрж гарлаа. Тэгээд соронзонг утсан гогцоо дундуур гаргахад цахилгаан гүйдэл бий болж байгааг 1831 онд нээв. Энэ үзэгдлийг цахилгаан соронзон индукц гэж нэрийджээ. Энэ бол хүн төрөлхтөний түүхэн дэх үнэхээр хосгүй том нээлт байв.

Учир нь нэгдүгээрт цахилгаан соронзон гэж нэрлэгдсэн үзэгдлийг онолын хувь ойлгоход чухал ач холбогдолтой болсон хоёрдугаарт Фарадей цахилгаан динамо-хөдөлгүүр бүтээж нотолсноор цахилгаан соронзон индукцийг байнгын цахилгаан гүйдэл бий болгоход ашиглаж болохыг баталсан. Манай дэлхийн хот тосгод, үйлдвэрүүдэд зориулан цахилгаан эрчим хүч гаргаж байгаа орчин үеийн цахилгаан хөдөлгүүрүүд нь Фарадейн бүтээсэн анхны хөдөлгүүрээс хүчин чадлын хувьд харьцуулашгүй их боловч цахилгаан соронзон индукц гэсэн ганц л зарчимд хоёул тулгуурлагдаж байгаа юм.

М.Фарадей химийн шинжлэх ухаанд мөн дорвитой хувь нэмэр оруулсан юм. Хийг шингэн хэлбэрт оруулах төхөөрөмж бүтээж бензол зэрэг хэд хэдэн бодисийг нээжээ. Олон удаагийн нарийн туршилтын үр дүнд цахилгаан химийн үндэс суурь болох электролизийн хоёр хуулийг гаргасан юм. Тэрчилэн анод, катод, электрод зэрэг химийн салбар дахь техникийн нэр томъёонуудыг олон нийтэд түгээн хэвшүүлжээ.


М.Фарадей нь соронзонгийн хүчний шугам, цахилгаан гүйдлийн хүчний шугамын тухай ойлголтуудыг физикийн шинжлэх ухаанд оруулсан юм. Тэрчилэн зөвхөн соронзон төдийгүй соронзонгуудын хооронд орших талбайд анхаарлаа хандуулж байснаар орчин үеийн физикийн шинжлэх ухааны олон салбарт чухал нээлт гарах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж өгсөн билээ. Соронзон талбайгаар туйлжсан гэрэл өнгөрдөг ба уг туйлуудыг өөрчилж болно гэдгийг М.Фарадей мөн олж харсан юм. Энэ бол гэрэл, соронзон талбайн хооронд харилцан уялдаа байна гэдгийг анх нотолсноороо гарамгай нээлт болсон юм.

М.Фарадей бол авьяаслаг эрдэмтэн төдийгүй ганган хээнцэр эр байсан. Түүний лекцийг эрдэмтэд, оюутнууд төдийгүй жирийн хүмүүс ирж сонсдог байв. Гэхдээ нэр алдар, мөнгөний хойноос хөөцөлддөггүй даруу төлөв зантай хүн байсныг нь тайжийн хэргэм олгох гэхэд дургүйцэж Их Британий Физикийн нийгэмлэгийн ерөнхийлөгчийн нэр хүндтэй албан тушаалаас татгалзаж байсан нь нотолдог. Гэр бүлийн хувьд эхнэртэйгээ он удаан жил аз жаргалтай амьдарч байсан боловч харамсалтай нь хүүхэдгүй байсан ажээ. 1867 онд Лондон хотын ойролцоо нас баржээ.

# 24. Жеймс Клерк Масквелл

(JAMES CLERK MAXWELL)

1831-1879



Английн цуут эрдэмтэн Жеймс Клерк Масквелл цахилгаан гүйдэл, соронзон үзэгдлийн үндсэн хуулиудын илэрхийлэл болох дөрвөн тэгшитгэлийг томъёолсон юм.

Цахилгаан гүйдэл, соронзон үзэгдлийг Масквеллээс өмнө судалж хоорондоо харилцан уялдаатай гэдгийг эрдэмтэд мэддэг байсан. Тэрчилэн цахилгаан гүйдлийн олон хуулиуд нээгдсэн байсан боловч тэд бүгдийг нэгтгэсэн нийтлэг онолын суурь дутагдаж байлаа. Тэгтэл Масквелл богинохон боловч харьцангуй адармаатай дөрвөн тэгшитгэлээрээ цахилгаан гүйдлийн болон соронзон талбайнуудын мөн чанар, харилцан үйлчлэлийг яг таг тодорхойлсноороо энэхүү хэцүү үзэгдлийг ойлгоход хялбар нэгдмэл онолын суурийг бий болгосон гавьяатай.

Түүний нээсэн тэгшитгэлүүдийг өнгөрсөн хоёр зуунд онолын болон хавсрага шинжлэх ухаануудад өргөн дэлгэр хэрэглэж байжээ.

Масквеллийн тэгшитгэлүүдийн хамгийн гол давуу тал нь гэвэл ямар ч нөхцөлд ашиглаж болох нийтлэг ач холбогдолтой байдаг юм. Урьд өмнө нь мэдэгдээд байсан цахилгаан гүйдэл, соронзон үзэгдлийн хуулиудын үнэн мөнийг шалгажхамгийн гол нь мэдэгдээгүй бусад хуулиудыг эдгээр тэгшитгэлийг ашиглан шууд томъёолж болдог юм.

Түүний тэгшитгэлээс цахилгаан соронзон талбайд байнга хэлбэлзэл байдаг, тэрчилэн цахилгаан соронзон долгионоос үүссэн хэлбэлзлүүд нь орон зайд тархдаг гэсэн дүгнэлт гарна. Масквелл өөрийн зохиосон тэгшитгэлээ ашиглаж тийм цахилгаан соронзон долгионы хурд нь секундэд 300,000 километр болохыг тогтоосон. Тэрчилэн энэ хурд нь гэрлийн хурдтай тэнцдэг, гэрэл нь цахилгаан соронзон долгионоос бүтдэг болохыг Масквелл нээсэн билээ. Энэ утгаараа Масквеллийн нээсэн тэгшитгэлүүд нь цахилгаан гүйдэл, соронзон үзэгдлийн төдийгүй гэрлийн тухай шинжлэх ухааны үндсэн хуулиуд болсон юм. Чухамдаа

Максвеллийн тэгшитгэлүүдийг ашиглан гэрлийн тухай шинжлэх ухааны урьд өмнө нь мэдэгдэж байсан хуулиудын үнэн болохыг нотолж болж байгаа төдийгүй шинэ үр дүн, харилцан уялдааг мөн гаргаж болж байгаагаараа гайхамшигтай байлаа.

Хүний нүдэнд харагдаж байгаа гэрэл нь цахилгаан соронзон туяарлын төрөл төдий биш юм. Хүний нүдэнд харагдаж байгаа гэрлээс долгионы урт, давтамжаараа ялгаатай өөр бусад цахилгаан соронзон долгион байж болохыг Максвелл тэгшитгэлүүдээрээ урьдчилсан тодорхойлсон юм. Хожим нь энэхүү онолын дүгнэлтийг Генрих Герц улам баяжуулж үл харагдах долгионуудыг бий болгож төдийгүй шулуутгаж болохыг нотолсон билээ. Хэдэн жилийн дараа Г.Маркони энэхүү үл харагдах долгионуудыг утасгүй холбоонд ашиглаж радиог нээсэн түүхтэй билээ. Тэрхүү үл харагдах долгионуудыг бид өнөөдөр зурагтын нэвтрүүлгийг дамжуулахад өргөн хэрэглэж байна. Рентген туяа, гамма туяа, хэт улаан туяа зэрэг нь цөмөөрөө цахилгаан соронзон таяарлын жишээнүүд билээ. Энэ бүгдийг Максвеллийн тэгшитгэлүүдийг хэрэглэн судалж болно.

Максвелл нь цахилгаан соронзон долгион, гэрлийн тухай шинжлэх ухааны хосгүй нээлтүүдээрээ цуутай ч одон орны судлал, дулааны судлалд мөн дорвитой хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм. Хийн кинетикийн онолыг судалж хийн бүх молекул адилхан биш хурдтай хөдөлгөөн үйлддэг, тухайлбал зарим нь удаан зарим нь хурдан зарим нь бүр асар их хурдтай хөдөлгөөн үйлддэг болохыг олж харсан юм. Тухайн хийн молекулуудын ямар ч тодорхой хэсгийг тохируулсан хурдаар хөдөлгөж байх томъёолол гаргасан нь "Максвеллийн хуваарилалт" нэртэй болж өнөө үед физикийн шинжлэх ухааны олон салбарт өргөн хэрэглэгдэж байна.

Ж.Максвелл нь 1831 онд Шотландын Эдинбург хотод төрсөн ба хар багаасаа эрдэмтний авьяас билэг нь тодорч 15 настайдаа Шотландын хааны шинжлэх ухааны нийгэмлэгт шинжлэх ухааны илтгэлээ илгээж байв. Эдинбургийн их сургуульд суралцаж Кембрижийн их сургууль төгссөн боловч амьдралынхаа ихэнх хэсгийг коллежийн профессороор ажиллаж өнгөрөөжээ. Гэхдээ 1879 онд идэр залуу 48 насандаа өмөн үү өвчнөөр өөд болохынхоо өмнөх хэдэн жилд Кембрижийн их сургуульд багшаар ажиллажээ.

Ж.Максвеллийг Ньютон, Эйнштэйн хоёрын хоорондох түүхэн үеийн хамгийн гарамгай онолын физикч гэж зүй ёсоор үнэлдэг юм.

# 25. Мартин Лютер

(MARTIN LUTHER)

1483-1546



Ромын католик шашны сүмд захирагдаагүйн улмаас үнэн алдартны шашны Шинэчлэл хийхэд хүргэсэн шашны нэрт зүтгэлтэн Мартин Лютер Герман улсын Эйслебен хотод төржээ. Их сургууль төгсөж өндөр боловсрол эзэмшиж хэсэг зуур бас эрх зүй судалж байсан ч лам болохоор шийджээ. Виттенбергийн их сургуульд суралцан шашны докторын зэрэг хүртэж тэндээ багшаар ажиллажээ.

Шашинд бүх амьдралаа эгнэгт зориулахаар шийдсэн Лютер сүм хийдийн арчаагүй байдалд дургүйцэж эхлэв. 1510 онд Ром хотод очоод тэндхийн шашны зүтгэлтнүүдийн ёс суртахуунгүй, хээл хахуульд автсан байдлыг нүдээр үзэж мэл гайхжээ. Тэгээд Лютер Виттенберг хотдоо буцан ирээд 1517 оны аравдугаар сарын 31-ний өдөр шашны ёс суртахуунгүй байдал, хээл хахууль автсан байдлыг эрс тэс буруушаасан алдарт 95 сэдвээ зарлаж хамба лам Майнцад явуулжээ. Тэрчилэн сэдвүүдээ хэвлэж олон түмэнд тараав.

Лютер сүм хийдийн эсрэг тэмцлээ улам чангатгаж ромын хамба лам, шашны ерөнхий зөвлөлийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж үйл ажиллагаандаа зөвхөн библийн судар, эрүүл саруул ухааныг дээдлэхээ мэдэгдэв. Үүний дараа католик шашны албан ёсны удирдлагууд түүний дуудан уулзаж олон түмний өмнө буруугаа хүлээхийг ятган шаардав. Гэвч Лютер бодол саналаасаа ухрахгүй гэдгээ тас түс хэлсэн тул түүнийг буруу номтон гэж зарлаж гаргасан сэдвүүдийг нь хэвлэх, уншихыг хориглосон шийдвэрийг Вормосскийн рейхстагаас гаргав.

М.Лютерийн үзэл бодол Германд түүний дотор нөлөө бүхий хэд хэдэн хунтайж нарын өргөн дэмжлэг хүлээж байсан тул түүдэг галд шатаагдан шийтгэгдэх аюулаас аврагдсан юм. Гэвч жил гаруй нууц байдалд амьдарчээ.

Авьяаслаг зохиолч байсны хувьд түүний бүтээлүүд олон түмэнд ихээхэн нөлөө үзүүлсэн юм. Библийн судрыг герман хэл дээр орчуулс-наар боловсролтой хүн бүр элдэв лам хуврагын яриагаар биш библийн судрыг биечлэн уншиж танилцах бололцоотой болов.

М.Лютерийн баримталж байсан шашны үзэл бодлыг хэдхэн үгээр тайлбарлах хэцүү ажээ. Гэхдээ түүний үзэл бодлын гол санаа нь итгэл үнэмшлийн тусламжтайгаар хүн өөрийгөө аврах явдал юм. Энэ санааг найдан Павелийн илгээлтүүдээс олж авчээ. Хүн өөрийн мөн чанараараа нүгэлд битүү идэгдсэн байдаг, гэхдээ дан ганц чин шударга үйл ажиллагааны үр дүнд тэр бүх нүглээс ангижирч чадахгүй, харин итгэл үнэмшил, Бурханы ачаар л аврагдана гэж М.Лютер сургажээ. Тэрчилэн сүм хийд нь Христосын шашныг шүтэн бишрэгчид болон Бурхан хоорондын зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг гэдэг нь шал худлаа, тиймд Ромын католик шашны төвийн үйл ажиллагаа нь огт шаардлагагүй, илүүц зүйл гэж үзжээ.

Сүм хийдийн бодит үүргийг тайлбарлахдаа шашны зарим үйл ажиллагаа тухайлбал нүглээс ангижирсан тухай жуух олгох, лам нарт гэрлэхийг хориглох тухай зэрэг заалтуудыг эрс буруушаасан юм. Буруушаагаад зогсоогүй, хэлсэн үгээ бодит хэрэг болгож лам эмэгтэйг гэргийгээ болгон авч зургаан хүүхэд болжээ. 1546 онд төрөлх Эйслебен хотдоо өөд болжээ.

М.Лютерээс өмнө XIY зуунд амьдарч байсан английн эрдэмтэн Жон Уиклиф дараагийн зуунд нь Богемээс гаралтай Ян Гус, XII дугаар зуунд амьдарч байсан францийн лам Питер Вальдо нар үнэн алдартны шашны шилдэг сэтгэгчид байсан ч үзэл бодлоо орон нутгийн хэмжээнд л сурталчилж байв. Гэтэл 1517 онд М.Лютер алдарт сэдвүүдээ зарласнаар урьд нь газар аваад байсан католик шашинд дургүйцэх үзэл европ тивийн дийлэнххэсгийг хамарсан билээ. Чухам иймд М.Лютерийг шашны Шинэчлэлийн эхийг тавихад дэм үзүүлсэн хүн гэж зүй ёсоор тооцогддог юм.

Энэхүү Шинэчлэлийн үр дүнд үнэн алдартны шашны олон урсгал чиглэл бий болсон явдал юм. Хоёрдугаарт гэвэл Европ тивд шашны олон дайн дэгдсэн. Тухайлбал Германд 1618 оноос 1648 он хүртэл үргэлжилсэн гучин жилийн дайныг нэрлэж болно. Шинэчлэлийн үр дүнд дараагийн хэдэн зууны турш европийн улс төрийн бодлогод католик болон үнэн алдартны шашинтнуудын хоорондын улс төрийн маргаан гол байр суурь эзэлж байлаа.

Энэ Шинэчлэл нь Өрнөд Европийн оюун санааны хөгжилд маш чухал үүрэг гүйцэтгэжээ. Урьд нь дан ганц Ромын католик шашин ноёрхож эл шашныг эсэргүүцэгчдийг буруу номтон гэж гадуурхан хавчдаг байсан бол Шинэчлэлийн буянаар шашны сэтгэлгээний эрх чөлөө бий болсон юм. Үнэн алдартны шашин бий болж дэлхийн олон оронд тархаснаар хүн төрөлхтөний түүхийн сүүлийн 450 жилд тус шашныг бишрэн шүтдэг орнуудаас аугаа хүмүүс олноор төрөн гарсан юм.

М.Лютер ромын католик шашны дангаар дарангуйлагч эрх мэдлийн эсрэг тууштай тэмцэгч байсан ч шашны асуудлаар санал бодол зөрсөн хүмүүсийг өөрөө нүд үзүүрлэдэг байсныг дурдахгүй байж болохгүй. Түүнээс гадна М.Лютерийн еврейчүүдийг үзэн яддаг үзэл бодлыг нь хорьдугаар зуунд гитлерчүүд аймшигт гэмт хэрэг үйлдэхдээ ашиглаж байсан юм.

М.Лютер нь иргэний засгийн газрын үйл ажиллагаанд сүм хийд оролцож байгааг эсэргүүцдэг байсны хувьд хууль ёсны иргэний засаг захиргаанд үг дуугүй захирагдахыг

уриалдаг байсан нь германы үнэн алдартны шашны шүтлэгтэй олон зүтгэлтнүүдийг улс төрийн шийдвэр гаргахдаа хязгааргүй эрх мэдэл эдлэх түвшинд хүргэсэн билээ. Энэ нь Гитлерийг засгийн эрхэнд гарахад шийдвэрлэх хүчин зүйл болсон билээ.

# 26. Жорж Вашингтон

(GEORGE WASHINGTON)

1732-1799



АНУ-ын анхны ерөнхийлөгч Жорж Вашингтон 1732 онд Виржини муж улсын Уэйфилд хотод чинээлэг газрын эзний гэл бүлд төрж хорин настайдаа том эдлэн газар өвлөн авчээ. 1753-1758 онуудад армид алба хааж францчууд, индианчуудын хооронд болсон дайн оролцож байлдааны туршлага хуримтлуулж их нэр хүнд олжээ. 1758 онд цэргийн албанаас халагдаж төрөлх нутагтаа буцан ирж хоёр хүүхэдтэй бэлэвсэн бүсгүй Марта Дендриж Кастистай гэрлэсэн ч хүүхэдтэй болоогүй юм.

Дараачийн 15 жилийн хугацаанд эдлэн газраа өөд татаж улам баяжиж 1774 онд Эх газрын анхдугаар их хуралд төлөөлөгчөөр сонгогджээ. Ж.Вашингтон тусгаар тогтнолын төлөө анхны тэмцэгчдийн эгнээнд байгаагүй ч 1775 онд Эх газрын хоёрдугаар их хурлаас байлдааны баялаг туршлага, өндөр нэр хүнд, эдлэн газрын баян эзэн, хүдэр том бие бялдар, зохион байгуулах хосгүй авьяас, хамгийн гол нь тавьсан зорилгын төлөө тууштай тэмцдэг чадвараа Эх газрын армийн командлагчаар томилогдов. Бүхий л дайны турш даалгасан итгэл найдварыг биелүүлж тусгаар тогтнолын төлөө ариун үйлсэд туйлбартай зүтгэсэн билээ.

Эх газрын армийн командлагчаар томилогдсон 1775 оны долоодугаар сараас ерөнхийлөгчийн хоёр дахь удаагийн хугацаагаа дуусгасан 1797 оны гуравдугаар сарын хооронд маш их амжилтад хүрсэн юм. 1799 оны 12 дугаар сард Виржини муж улсын Маунт-Вернон дахь эдлэн газартаа нас баржээ.

АНУ-ыг байгуулахад Ж.Вашингтоны байгуулсан гавьяа дор дурдсан гурван зорилтыг биелүүлснээр тодорхойлогдоно:

Нэгдүгээрт Умард Америкт болсон тусгаар тогтнолын төлөө дайны үед цэргийн хамгийн чадварлаг удирдагч байв. Их Александр, Юлий Цезарь шиг цэргийн гарамгай жанжин байгаагүй нь мэдээж. Чухамдаа бол английн цэргийн дарга нарын бүдүүлэг алдаа Ж.Вашингтонийг байлдааны хэд хэдэн гарамгай ялалт байгуулахад хүргэсэн гэхэд хилсдэхгүй



биз ээ. Гэхдээ америкийн цэргийн зарим генералууд томоохон ялагдал хүлээж байсны адил Ж.Вашингтон зарчмын бус жижиг байлдаануудад ялагдал амсаж байсан ч дайныг ялалтад хүргэж чадсан билээ.

Хоёрдугаарт Ж.Вашингтон нь үндсэн хуульт Конвентийн (Үндсэн хууль батлах, хууль тогтоох байгууллагын нэр) ерөнхийлөгч байсан юм. АНУ-ын Үндсэн Хуулийг боловсруулахад түүний дэвшүүлсэн үзэл санаа чухал ач холбогдолтой байгаагүй ч тус Үндсэн Хуулийг зарим муж улсын засгийн газраар батлуулахад түүний нэр хүнд, дэмжлэг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн билээ. Шинэ Үндсэн Хуулийг сэргүүцэгч талынхан дийлэнхболжбайсан нөхцөлд Ж.Вашингтон нөлөө үзүүлээгүй бол Үндсэн хууль батлагдахгүй байсан билээ.

Гуравдугаарт АНУ-ын анхны ерөнхийлөгч байлаа. Түүн шиг өргөн сэтгэдэг, түүн шиг туйлбартай үзэл бодолтой хүн тус улсын анхны ерөнхийлөгч байсан нь үнэхээр аз завшаантай хэрэг болсон юм. Шинээр байгуулагдаж байгаа улс ардчилсан Үндсэн Хууль гаргаж дагаж мөрдөхгүй бол цэргийн дарангуйллын засаг руу хальтран ордгийг нь хожим нь өмнөд америк, африкийн олон оронд болсон үйл явдал харуулсан.

Улс орноо хагарал хямралд хүргэчихээргүй хүчирхэг ерөнхийлөгч байсан хэдий ч эрх мэдлийг олон жил эзэгнэх бодолгүй байсан юм. Хаан, дарангуйлагч болохыг хүсээгүй ба чухамдаа эрх мэдлийг тайван замаар шилжүүлж байх төр, засгийн тогтолцоог анх бий болгосныг нь түүний анхны ерөнхийлөгч байсан улс нь өнөө үе хүртэл нандигнан хадгалсаар байгаа юм.

Ж.Вашингтон нь Томас Жеферсон, Жеймс Медисон, Александр Гамильтон, Бенжамин Франклин зэрэг цаг үеийнхээ америкийн бусад удирдагч нар шиг хурц гүнзгий сэтгэгч байгаагүй ч улс төрийн ямар ч хөдөлгөөнд амжилт олох бололцоог хангадаг гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэхэд дээр дурдсан авьяаслаг хүмүүсээс илүү шийдвэрлэх хувь нэмэр оруулж чадсан улс төрийн зүтгэлтэн билээ. АНУ-ыг байгуулахад Ж.Медисон чухал хувь нэмэр оруулсан ч Ж.Вашингтон шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм.

# 27. Карл Маркс

(KARL MARX)

1818-1883



Шинжлэх ухааны коммунизмын онолыг үндэслэгч К.Маркс Германий Трир хотод 1818 онд мэндэлж 17 настайдаа Бонн хотын их сургуульд элсэж хууль зүй судлаж эхлэжээ. Дараа нь Берлиний их сургуульд шилжин суралцаж Йен хотын их сургуульд гүн ухааны докторын зэрэг хамгаалжээ.

Сэтгүүл зүйд хүчээ сорьж Кельн хотод сонины эрхлэгчээр ажиллалаа. Гэвч улс төрийн давшингуй үзэл баримтлал нь амьдарч буй нийгэмтэйгээ зөрчилд хүргэж Париж хотод шилжин сууришав. Тэнд байхдаа ирээдүйн хамтран зүтгэгч Ф.Энгельстэй танилцаж насан туршаа нөхөрлөжээ. Тэд хэд хэдэн ном тусдаа гаргасан боловч тэдний оюун ухааны хамтын ажиллагаа үнэхээр бат бэх байсан тул хамтын бүтээл нь нэг хүнийх шиг байдаг.

К.Маркс Францаас бас хөөгдөж Брюссельд ирсэн ба 1847 онд анхны томоохон бүтээл болох "Гүн ухааны гуйланчлал" номоо хэвлүүлжээ. Дараа жил нь Ф.Энгельстэй хамтран "Коммунист намын тунхаг" хэмээх хамгийн зартай бүтээлээ гаргажээ. Дараа нь Кельн хотод ирсэн ч бас эх орноосоо хөөгдөж Лондон хотод насан эцэслэтлээ суужээ.

Сонин гаргаж амьжиргаагаа залгуулж байсан ч ихэнх цагаа Лондон хотын номын санд өнгөрүүлж судалгааны ажил хийж улс төр эдийн засгийн асуудлуудаар ном бичиж байв. Түүний хамгийн гол бүтээл болох "Капитал" зохиол 1867 онд хэвлэгдэн гарчээ. Түүнийг 1883 онд насан өөд болсны дараа Ф.Энгельс түүний тэмдэглэл, гар бичмэлийг ашиглаж дараачийн хоёр ботийг гүйцээн бичиж хэвлүүлсэн байна.

К.Маркс бүтээл туурвилаараа коммунизм, социализмын олон хэлбэрийн онолын үндсийг тавьсан юм. Түүнийг нас барах үед ганц ч оронд түүний үзэл санаа хэрэгжээгүй ч зуун жилийн дараа Орос, Хятад зэрэг олон оронд коммунистууд төр, засгийн эрхийг хүчээр булаан авсан юм. Марксын онолыг удирдлага болгосон коммунист намууд засгийн эрхийг

хүчээр булаан авах сурталчилгаа явуулж аллага хядлага бослого гаргаж зорилгоо биелүүлээд дайн, хэлмэгдүүлэлт, цуст аллага үйлдэж дэлхий дахиныг хэдэн арван жилийн турш дагжин чичрүүлж зуун сая гаруй хүний амь насыг хөнөөсөн аймшигт гамшиг үйлдсэн билээ. Зохиол бүтээл нь хүн төрөлхтөний түүхэнд ийм их нөлөө үзүүлсэн өөр гүн ухаантан байдаггүй юм.

Зөвлөлт Засгийн газар К.Марксын нэрийг барьж байснаас биш түүний бүтээл туурвилыг үйл ажиллагаандаа хэзээ ч ягштал баримталж байгаагүй юм. К.Марксын бичиж үлдээсэн гегелийн диалектик, нэмүү өртөг зэрэг хийсвэр ойлголтууд нь оросын болон хятадын засгийн газруудын үйл ажиллагаанд үлэмж нөлөө үзүүлж байсан гэж хэлэхэд бэрх.

Марксын эдийн засгийн онол нь үндсээрээ буруу байсан гэдэг. Түүний нилээд олон таамаглал биелээгүй. Капиталист орнуудад ажилчид улам ядуурна, дунд анги устаж дийлэнх хэсэг нь үгээгүй ядуучуудын эгнээнд шилжиж цөөхөн хэсэг нь капиталистуудын эгнээнд багтана, үйлдвэрлэлд механикжуулалт нэмэгдэхийн хэрээр капиталистуудын ашиг буурна гэж урьдчилан таамагласан нь нотлогдсонгүй, талаар өнгөрсөн ч К.Марксын онол буруу байсан эсэх талаар одоо ч маргаан үргэлжилсээр байна.

Гэхдээ аливаа гүн ухаантны зохиол туурвилын ач холбогдол нь түүний дэвшүүлсэн онол буруу, зөв байсан эсэхэд биш чухамдаа тэр онол нь хүмүүсийн үйл ажиллагаанд удирдлага болж чадсан эсэхээр хэмжигдэнэ. Энэ утгаар авч үзвэл К.Маркс бол үнэхээр аугаа онолч юм.

Марксист хөдөлгөөн нь дараах дөрвөн гол үзэл санааг удирдлага болгоно. Үүнд нэгдүгээрт капиталист нийгэмд хэдхэн тооны баян хүмүүс жаргалтай амьдарч дийлэнх олонхи нь ядуу өлмөн зөлмөн амьдарна, хоёрдугаарт энэхүү шудрага бус байдлыг халахын тулд үйлдвэрлэлийн хэрэгсэл хувь хүмүүст биш засгийн газрын мэдэлд байдаг тийм социалист тогтолцоог бий болгох нь зохилтой, гуравдугаарт социалист тогтолцоог бий болгох цорын ганц практик арга нь ерөнхийдөө хүчирхийллийн замаар хувьсгал хийх явдал юм, дөрөвдүгээрт бий болгосон социалист тогтолцоог тодорхой хугацаанд байлгахын тулд коммунист намын дарангуйлал тогтоох хэрэгтэй.

Энэхүү дөрвөн гол үзэл санааны эхний гурвыг нь К.Маркс томъёолсон ба хамгийн сүүлчийнхийг нь түүний "пролетарын диктатурын тухай" сургаалаас авчээ. Гэхдээ Зөвлөлтийн диктатур олон арван жил тогтсон нь К.Марксын сургаалаас илүү Ленин, Сталин нарын практик үйл ажиллагааны үр дүн байсан нь ойлгомжтой. Үүнээс үндэслэн коммунист хөдөлгөөнд Марксын үзүүлсэн нөлөө нэр төдий байсан гэж батлахыг оролддог онолчид судлаачид бий.

Гэтэл бодит байдал өөр байдаг. Тухайлбал коммунист хөдөлгөөний гол онолчдын нэг Ленин өөрийгөө марксист сургаалыг тууштай баримтлагч гэж үздэг байсан төдийгүй түүний зохиол туурвилыг нэвтэрхий мэддэг, бүрэн хүлээн зөвшөөрдөг, бүхий л үйл ажиллагаандаа хэлбэрэлтгүй удирдлага болгодог байсан билээ. Тэрчилэн Мао Зэдун гээд коммунист бараг бүх орны удирдагчид К.Марксыг багшаа гэж үзэж сургаалыг нь үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог байсан юм. Тэгэхлээр К.Марксын онолыг хэрхэн ойлгож тайлбарлахад хэргийн гол учир утга нь байгаа юм. Чин үнэнээр хэлэхэд "түүхийн явцыг эдийн засгийн үндэслэлээр тайлбарлах тухай" К.Марксын үзэл коммунист сургаал алга болсон нөхцөлд ч ач холбогдолтой хэвээр байх магадлалтай байна.

Хүн төрөлхтөний түүхэнд К.Марксын гүйцэтгэсэн үүргийг тодор-хойлох үндсэн хэмжүүр нь коммунист хөдөлгөөнөөс хүн төрөлхтөний хөгжлийн урт удаан хугацааны түүхэнд үзүүлсэн нөлөө болох ёстой юм. К.Маркс нас барснаас зуу гаруй жилийн дараа түүний үзэл санааг баримтлагч хүмүүсийн тоо бараг тэрбумд хүрч байсан үе бий. Коммунист удирдагчид энэхүү тоог дэлхийн нийт хүн амтай харьцуулаад марксист сургаал даян дэлхийд мандана гэж найдаж байсан билээ.

Маш олон хүн хосгүй оюун ухаан, авьяас билгээ зориулсан салбарт ах дүү хоёр Райт нар чухам яагаад амжилт олов гэдэг асуудал байнга гардаг. Учир нь гэвэл тэд хоёулаа ямагт хамт ажиллаж бие биенийхээ дутууг нөхөж гар нийлэн ажилладаг байжээ. Хоёрдугаарт гэвэл тэд эхлээд ямар ч атугай агаарт хөөрч нисэж сурах хэрэгтэй, харин дараа нь л хөдөлгүүртэй нисэх төхөөрөмж хийх нь зохилтой гэсэн туйлын ухаалаг шийдвэр гаргасан байжээ.

Тэд нисэхийн тулд анхандаа цаасан могой, хөдөлгүүргүй онгоц хийж сурав. Тэд 1900 онд нэг хүн багтахаар хэмжээтэй хөдөлгүүргүй нисэх онгоц хийж Умард Каролин муж улсын Китти Хок хотод туршилт хийхээр аваачжээ. Тэд дараагийн жил нь хоёр дахь 1902 онд гурав дахь хөдөлгүүргүй нисэх онгоцны туршилт хийлээ. Тэд гурав дахь хөдөлгүүргүй нисэх онгоцоороо бараг мянга гаруй туршилт хийжээ.

Нисэх онгоц бүтээх гэсэн хүмүүс зохиосон төхөөрөмжөө яаж газраас хөндүүрүүлж агаарт хөөргөх гэсэн асуудлыг чухалчилж байсан бол ах дүү Райт агаарт хөөргөсөн төхөөрөмжийг хянах асуудалд голлон анхаарч байснаараа бусдаас түрүүлж амжилтад хүрсэн юм. Тийм учраас тэд нислэгийн үед нисэх төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, түүнд хяналт тавих аргыг боловсруулахад ихэнх цаг хугацаа, хүчин чармайлтаа тавьж байсны үр дүнд нисэх төхөөрөмжинд гурван шатлалтай хяналт тавих аргыг олж түүний хөдөлгөөнийг удирдах бололцоотой болжээ.

Ах дүү Райт нисэх төхөөрөмжийн далавчны асуудалд онцгой анхаарч агаарын урсгалын дамжуулах анхны хоолойг зохион бүтээж янз бүрийн хэлбэрийн хоёр зуу гаруй далавчийг туршиж үзсэний үр дүнд далавчинд үзүүлж байгаа агаарын даралт нь далавчны хэлбэрээс өөрчлөгддөг хүснэгтийг гаргаж авчээ.

Урьд үед байсан уурын хөдөлгүүр нь нисэх онгоц нисгэх хүчин чадлыг бий болгоход дэндүү хүнддэж байсан учраас ямар ч амжилтад хүрэхгүй байжээ. Гэтэл ах дүү Райтын аз болоход тэдний үед өндөр хүчин чадалтай дотоод шаталтат хөдөлгүүр гарсан байлаа. Гэхдээ дотоод шаталтат хөдөлгүүрийн жин, овор хэмжээ, хүчин чадал нисэх төхөөрөмжинд ашиглахад бас л тохиромжгүй байлаа. Ах дүү Райт нисэх төхөөрөмжинд хэрэглэх дотоод шаталтат хөдөлгүүр бүтээхдээ тухайн үеийн бүх хөдөлгүүрээс илүү, асар их хүчин чадалтай хөдөлгүүр хийж чадсан гавьяатай юм. Тэдний 1903 онд ашигласан хөдөлгүүрийн жин, хүчин чадлын харьцаа 66 хувь байжээ.

Ах дүү Райтын бүтээсэн анхны нисэх онгоцны анхны нислэг 1903 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Умард Каролин муж улсын Китти Хок тосгоноос холгүй Килл Дейвил Хилл гэдэг газар болжээ. Хүн төрөлхтөний түүхийн техникийн дэвшлийн энэхүү аугаа өдөр ах дүү Райт тус бүр хоёр нислэг хийжээ. Дүү Орвилл Райт 12 секундын хугацаанд агаарт 120 фут зам туулсан бол ах Уилбур Райт 59 секундын хугацаанд 852 фут зам явжээ. Тухайн үедээ нэг мянган

ам.долларын өртөгөөр бүтсэн энэхүү "Флайер-1" нисэх онгоцны далавчны урт 40 фут (1 фут нь 30,48 сантиметртэй тэнцэнэ.), 750 фунт (1 фунт нь 409,5 граммтай тэнцэнэ.) жинтэй, хөдөлгүүр нь 170 фунт жинтэй, 12 морины хүчин чадалтай байжээ.

Энэхүү түүхт нислэгийг дөнгөж таван хүн байлцаж харсан ч орон нутгийн хэвлэлд нислэгийн тухай ташаа мэдээлэл гарснаас хүн төрөлхтөн тэр тухай таван жилийн дараа л дөнгөж мэджээ.

Ах дүү Райт Дейтон хотод буцаж ирээд "Флайер-2" нисэх онгоц бүтээж 1904 онд 105 нислэг, "Флайер-3" нисэх онгоцоор 1905 онд хоёр зуу гаруй нислэг хийжээ. Гэвч хүмүүс учрыг ойлгосонгүй хэвээр, 1906 онд Парижийн "Геральд трибюн" сонинд "Нисгэгчид үү далан худалчууд уу?" гэсэн нэртэй нийтлэл хүртэл гарч байжээ.

1908 онд Уилбур Райт бүтээсэн хэд хэдэн нисэх онгоцоосоо нэгийг нь Париж хотод авчирч цуврал үзүүлэх нислэг хийж шинэ бүтээлээ худалдах компаниа байгуулснаа зарлажээ. Энэ үед Орвилл Райт АНУ-д мөн үзүүлэх тоглолт хийж байгаад 1908 оны есдүгээр сарын 17-ны өдөр осолд оржээ. Нисэх онгоцонд хамт суусан хүн нь амь эрсдэж Орвилл хөл, хоёр хавиргаа хугалсан ч амьд үлджээ.

Ах дүү Райтын нислэг амжилттай болсноор АНУ-ын Засгийн газар Батлан хамгаалах яаманд ах дүү Райт нараас нисэх онгоц худалдаж авах гэрээ байгуулах зөвшөөрөл олгожээ. АНУ-ын 1909 оны холбооны төсөвт ах дүү Райт нараас гучин мянган ам.доллараар нисэх онгоц худалдаж авах зүйл анги тусгагдсан байв.

Уилбур Райт хижиг өвчин тусаж 1912 онд 45 настайдаа нас барав. Шинэ бүтээлийн эрхээ 1915 онд нэгэн нисэх онгоц үйлдвэрлэх компанид худалдсан Орвил Райт 1948 онд өөд болжээ. Ах дүү Райт баян тансаг амьдарч байсан ч хоёулаа ганц ч удаа гэрлэж байгаагүй нь хачирхалтай.

Хүн төрөлхтөн эрт дээр үеэс агаарт нисэхийг хязгээргүй хүсэн мөрөөдөж байсан билээ. Арабын "Мянган нэгэн шөнийн үлгэр"-т гардаг мөрөөдлийг ах дүү Райт нар биелүүлж үлгэрийг бодит хэрэг болгосон билээ.

# 28. Нисэх онгоц зохион бүтээгч ах дүү Райт

(ORVILLE WRIGHT AND WILBUR WRIGHT )

Орвил 1871-1948), (Уилбер 1867-1912



Ах Уилбер Райт нь 1867 онд Индиана муж улсын Мелвил хотод, дүү Орвил нь 1871 онд Огайо муж улсын Дейтон хотод төржээ. Хоёул дунд сургуульд суралцсан боловч диплом авч чадаагүй ажээ. Ах дүү хоёр багаасаа удирдлагат нислэгийн асуудлыг сонирхдог байсан боловч дуртай ажлаа хийж байх хөрөнгө мөнгөтэй болохын тулд 1892 онд унадаг дугуй худалдаж засварладаг урлан байгуулжээ. Тэд агаарын нислэгийн асуудлыг мөн сонирхдог О.Лиенталь, О.Чанюта, С.П.Лэнгли нарын гаргасан бүхзохиол бүтээлийгуншин судалсаар 1899 оноос нислэгийн асуудлаар дагнан ажиллаж 1903 оны 12 дугаар сард анхныхаа тодорхой үр дүнд хүрчээ.

Маш олон хүн хосгүй оюун ухаан, авьяас билгээ зориулсан салбарт ах дүү хоёр Райт нар чухам яагаад амжилт олов гэдэг асуудал байнга гардаг. Учир нь гэвэл тэд хоёулаа ямагт хамт ажиллаж бие биенийхээ дутууг нөхөж гар нийлэн ажилладаг байжээ. Хоёрдугаарт гэвэл тэд эхлээд ямар ч атугай агаарт хөөрч нисэж сурах хэрэгтэй, харин дараа нь л хөдөлгүүртэй нисэх төхөөрөмж хийх нь зохилтой гэсэн туйлын ухаалаг шийдвэр гаргасан байжээ.

Тэд нисэхийн тулд анхандаа цаасан могой, хөдөлгүүргүй онгоц хийж сурав. Тэд 1900 онд нэг хүн багтахаар хэмжээтэй хөдөлгүүргүй нисэх онгоц хийж Умард Каролин муж улсын Китти Хок хотод туршилт хийхээр аваачжээ. Тэд дараагийн жил нь хоёр дахь 1902 онд гурав дахь хөдөлгүүргүй нисэх онгоцны туршилт хийлээ. Тэд гурав дахь хөдөлгүүргүй нисэх онгоцоороо бараг мянга гаруй туршилт хийжээ.

Нисэх онгоц бүтээх гэсэн хүмүүс зохиосон төхөөрөмжөө яаж газраас хөндүүрүүлж агаарт хөөргөх гэсэн асуудлыг чухалчилж байсан бол ах дүү Райт агаарт хөөргөсөн төхөөрөмжийг хянах асуудалд голлон анхаарч байснаараа бусдаас түрүүлж амжилтад хүрсэн юм. Тийм учраас тэд нислэгийн үед нисэх төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, түүнд хяналт тавих аргыг боловсруулахад ихэнх цаг хугацаа, хүчин чармайлтаа тавьж байсны үр дүнд нисэх төхөөрөмжинд гурван шатлалтай хяналт тавих аргыг олж түүний хөдөлгөөнийг удирдах бололцоотой болжээ.

Ах дүү Райт нисэх төхөөрөмжийн далавчны асуудалд онцгой анхаарч агаарын урсгалын дамжуулах анхны хоолойг зохион бүтээж янз бүрийн хэлбэрийн хоёр зуу гаруй далавчийг туршиж үзсэний үр дүнд далавчинд үзүүлж байгаа агаарын даралт нь далавчны хэлбэрээс өөрчлөгддөг хүснэгтийг гаргаж авчээ.

Урьд үед байсан уурын хөдөлгүүр нь нисэх онгоц нисгэх хүчин чадлыг бий болгоход дэндүү хүнддэж байсан учраас ямар ч амжилтад хүрэхгүй байжээ. Гэтэл ах дүү Райтын аз болоход тэдний үед өндөр хүчин чадалтай дотоод шаталтат хөдөлгүүр гарсан байлаа. Гэхдээ дотоод шаталтат хөдөлгүүрийн жин, овор хэмжээ, хүчин чадал нисэх төхөөрөмжинд ашиглахад бас л тохиромжгүй байлаа. Ах дүү Райт нисэх төхөөрөмжинд хэрэглэх дотоод шаталтат хөдөлгүүр бүтээхдээ тухайн үеийн бүх хөдөлгүүрээс илүү, асар их хүчин чадалтай хөдөлгүүр хийж чадсан гавьяатай юм. Тэдний 1903 онд ашигласан хөдөлгүүрийн жин, хүчин чадлын харьцаа 66 хувь байжээ.

Ах дүү Райтын бүтээсэн анхны нисэх онгоцны анхны нислэг 1903 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Умард Каролин муж улсын

Китти Хок тосгоноос холгүй Килл Дейвил Хилл гэдэг газар болжээ.

Хүн төрөлхтөний түүхийн техникийн дэвшлийн энэхүү аугаа өдөр ах дүү Райт тус бүр хоёр нислэг хийжээ. Дүү Орвилл Райт 12 секундын хугацаанд агаарт 120 фут зам туулсан бол ах Уилбур Райт 59 секундын хугацаанд 852 фут зам явжээ. Тухайн үедээ нэг мянган ам.долларын өртөгөөр бүтсэн энэхүү “Флайер-1” нисэх онгоцны далавчны урт 40 фут (1 фут нь 30,48 сантиметртэй тэнцэнэ.), 750 фунт (1 фунт нь 409,5 граммтай тэнцэнэ.) жинтэй, хөдөлгүүр нь 170 фунт жинтэй, 12 морины хүчин чадалтай байжээ.

Энэхүү түүхт нислэгийг дөнгөж таван хүн байлцаж харсан ч орон нутгийн хэвлэлд нислэгийн тухай ташаа мэдээлэл гарснаас хүн төрөлхтөн тэр тухай таван жилийн дараа л дөнгөж мэджээ.

Ах дүү Райт Дейтон хотод буцаж ирээд “Флайер-2” нисэх онгоц бүтээж 1904 онд 105 нислэг, “Флайер-3” нисэх онгоцоор 1905 онд хоёр зуу гаруй нислэг хийжээ. Гэвч хүмүүс учрыг ойлгосонгүй хэвээр, 1906 онд Парижийн “Геральд трибюн” сонинд “Нисгэгчид үү далан худалчууд уу?” гэсэн нэртэй нийтлэл хүртэл гарч байжээ. 1908 онд Уилбур Райт бүтээсэн хэд хэдэн нисэх онгоцоосоо нэгийг нь Париж хотод авчирч цуврал үзүүлэх нислэг хийж шинэ бүтээлээ худалдах компаниа байгуулснаа зарлажээ. Энэ үед Орвилл Райт АНУ-д мөн үзүүлэх тоглолт хийж байгаад 1908 оны есдүгээр сарын 17-ны өдөр осолд оржээ. Нисэх онгоцонд хамт суусан хүн нь амь эрсдэж Орвилл хөл, хоёр хавиргаа хугалсан ч амьд үлджээ.

Ах дүү Райтын нислэг амжилттай болсноор АНУ-ын Засгийн газар Батлан хамгаалах яаманд ах дүү Райт нараас нисэх онгоц худалдаж авах гэрээ байгуулах зөвшөөрөл олгожээ. АНУ-ын 1909 оны холбооны төсөвт ах дүү Райт нараас гучин мянган ам.доллараар нисэх онгоц худалдаж авах зүйл анги тусгагдсан байв. Уилбур Райт хижиг өвчин тусаж 1912 онд 45 настайдаа нас барав. Шинэ бүтээлийн эрхээ 1915 онд нэгэн нисэх онгоц үйлдвэрлэх компанид худалдсан Орвил Райт 1948 онд өөд болжээ. Ах дүү Райт баян тансаг амьдарч байсан ч хоёулаа ганц ч удаа гэрлэж байгаагүй нь хачирхалтай.

Хүн төрөлхтөн эрт дээр үеэс агаарт нисэхийг хязгээргүй хүсэн мөрөөдөж байсан билээ. Арабын “Мянган нэгэн шөнийн үлгэр”-т гардаг мөрөөдлийг ах дүү Райт нар биелүүлж үлгэрийг бодит хэрэг болгосон билээ.



# 29. Чингис хаан

(GENGHIS KHAN)

1162-1227



Монголын их эзэнт гүрний хаан Чингис 1162 онд төржээ. Монголын нэгэн аймгийн удирдагч болох эцэг нь хүүдээ байлдаж дийлсэн Тэмүүжин омгийн нэр хайрлажээ. Хүүг дөнгөж 9 нас хүрэх үед эцэг нь хөрш аймгийнхандаа хорлогдон алагдах үеэс эх нь таван хүүхэдтэйгээ өнчрөн үлдэж аймшигт зовлон зүдгүүр туулжээ. Тэмүүжин амьд мэнд үлдэхийн тулд хар багаасаа өлсөх, даарах гэх зэрэг бие бялдар, санаа сэтгэлийн түмэн зовлонг амсан хатуужиж сэтгэлийн тэнхээ суужээ.

Идэр насанд хүрэх үедээ дайсагнагч омгийнхонд олзлогдож хүзүүндээ дөнгө зүүж хэдэн жилийг өнгөрөөв. Тийнхүү ертөнцийн хамаг зовлонг эрийн мятаршгүй зоригоор даван туулсан Тэмүүжин хэдхэн жилийн дараа гэхэд тухайн цаг үедээ дэлхийн хамгийн хүчирхэг улс гүрнийг байгуулж хаанаар нь өргөмжлөгдсөн билээ.

Ер нь монголчууд морь унахдаа төрөлхийн гарамгай, дайчин цэргүүд билээ. Монголын олон аймаг, омог хоорондоо байнга дайтаж цэргийн хүчин чадлаа барж байлаа. Тэмүүжин олзноос оргосны дараа эцгийнхээ анд найз, хөрш аймгийн удирдагч Жамухтай нийлж хэдэн жилийн дотор хоорондоо дайсагнагч олон аймгийг бүгдийг нь эрийн хатан зориг, суут оюун ухаан, зохион байгуулах хосгүй чадвар, цэргийн жанжны гоц авьяас, гайхам заль мэхээрээ нэгтгэж чаджээ. Монголын бүх аймаг, омог 1206 онд их хуралдай хийж Тэмүүжинг Монголын их хаанаар залж Чингисхаан гэж өргөмжилжээ.

Чингис хаан цэргийн их хүчээрээ хөрш ард түмнүүдийг довтолон түрэмгийлж эхлэв. Хамгийн түрүүнд өнөөгийн хятад улсын баруун хойд хэсэгт орших Си-Ся улс, умард хэсэгт орших Цзинь улсуудыг байлдан дагуулжээ. Эдгээр аян дайны үед Чингис хаан Перс, Дундад Азийн өргөн уудам нутагт байдаг их эзэнт гүрний хаан Мухаммедтай муудалцаж маргаан үүсэхэд 1219 онд хөлгийн жолоог алс нутаг руу залав. Төдөлгүй монголын хүчит морин цэрэг Дундад Ази, Персийг байлдан дагуулж Мухаммедын эзэнт гүрнийг бүрэн эзлэжээ. Чингис хаан цэргийнхээ гол хүчийг Оросын олон вангуудыг түрэмгийлэн дайрахад илгээчихээд өөрөө зарим цэргээ удирдаж Афганистан, Хойд Энэтхэгийг дайлаар морджээ. Чингис хаан 1225 онд эх нутагтаа буцан ирээд 1227 онд 65 настайдаа насан өөд болжээ.

Чингис хаан нүд анихынхаа өмнө том хатнаасаа төрсөн дөрвөн хүүгийнхээ гурав дахь нь болох цэргийн гарамгай жанжны авьяас нь тодорсон Өгөөдэйг залгамжлагчаараа өргөмжилжээ. Монголын морин цэрэг Өгөөдэй хааны удирдлага дор Хятад улсын дийлэнх хэсгийг эзэлж Орос улсыг бараг бүрэн хяналтдаа авч Европ тивийн гүн рүү нэвтэрчээ. Польш, Герман, Унгарын цэргийг бут ниргэж Будапешт хотыг эзлээд цааш хөдлөх үед Өгөөдэй хаан 1241 онд нас барж монголын үй түмэн морин цэрэг эх нутагтаа буцаж дахин Европ тив рүү аян дайн хийгээгүй билээ.

Өгөөдэй хаан өөд болсны дараа монголын удирдагчид хоорондоо эрх мэдлийн төлөө тэмцэлдэж гадаад орнуудад аян дайн хийсэнгүй, нилээд хэдэн жилийг өнгөрөөв. Дараагаар нь Чингис хааны ач Мөнх, Хубилай хаад Ази тивд дахин аян дайн хийж Хубилай хаан 1279 онд Хятад улсыг бүрэн эзэлснээр монголчууд дэлхийн түүхэнд хамгийн том нутаг дэвсгэртэй, хамгийн том эзэнт гүрэн болж чаджээ. Тэр үед монголын эзэнт гүрний бүрэлдэхүүнд Хятад, Орос, Дундад Ази тэрчилэн Перс, Зүүн өмнөд Азийн дийлэнх хэсэг багтаж байлаа. Монголын морин цэрэг Польш, Умард Энэтхэгийг эзэлж Солонгос, Түвд, Зүүн өмнөд Азийн зарим хэсэг Хубилай хаанд захирагдаж байв.

Тийм том гүрэн улс харилцаа холбооны хэрэгсэл бүдүүлэг байсан үед урт удаан хугацаагаар оршин тогтнох бололцоогүй байсан болохоор төдөлгүй сарнин бутарчээ. Гэвч Монголын хаадын эрх мэдэл олонхи оронд урт удаан хугацаагаар хэвээр байлаа. 1368 он гэхэд Хятадын дийлэнх хэсгээс монголчууд хөөгдсөн байна. Орос улсад Чингис хааны ач хүү Бат хааны байгуулсан Алтан ордны улс ХҮ1 зуун хүртэл, Крымийн хаант улс 1783 он хүртэл оршин тогтносон билээ.

Чингис хааны бусад хүү, ач нар өөрсдийн улс гүрнийг Дундад Ази, Персийн нутагт байгуулсныг Чингис хааны удам гэж өргөмжилсөн Доголон Төмөр хаан эзлэн түрэмгийлжээ. Түүний удмын ноёрхол ХҮ зууны сүүлчээр төгсгөл болжээ. Доголон Төмөр хааны гуч Бабур хаан Энэтхэг улсад халдан довтолж Их Моголын (Монголын) улсыг үндэслэжээ. Их Моголын удмынхан Энэтхэг улсыг бүхэлд нь эзэлж ХҮШ дугаар зууны дунд үе хүртэл оршин тогтножээ.

Хүн төрөлхтөний түүхэнд дэлхий дахиныг байлдан дагуулж захирах гэсэн аугаа зорилго тавьж, тодорхой амжилтад хүрсэн Их Александр, Чингис хаан, Наполеон Бонапарт, Адольф Гитлер гэсэн дөрөвхөн хүн л байдаг. Эдгээр дөрвөн том зүтгэлтэн бүр тухайн цаг үедээ асар уудам газар нутаг, маш олон тооны хүн ам захирч байснаараа тухайн үеийнхээ нийгмийн амьдралд ихээхэн нөлөө үзүүлж байсныг хэн ч үгүйсгэж чадахгүй билээ.

# 30. Адам Смит

(ADAM SMITH)

1723-1790



Эдийн засгийн онолын хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн гол эрдэмтэн болох Адам Смит 1723 онд Шотландын Керколди хотод төржээ. Идэр залуудаа Оксфордын их сургуульд суралцаж 1751-ээс 1764 онуудад Глазго хотод их сургуульд гүн ухааны профессороор ажиллаж байхдаа "Ёс суртахууны мэдрэмжийн онол" хэмээх ном гаргаж шинжлэх ухааны хүрээлэлд нэр хүнд олж авчээ. Гэхдээ 1776 онд хэвлэгдэн гарсан "Ард түмнүүдийн баялагийн мөн чанар, шалтгааны тухай судалгаа" ном нь түүний нэрийг дэлхий даяар цуурайтуулж үлдсэн амьдралаа нэр төртэй, баян тансаг өнгөрөөжээ.

Амьдралдаа ганц ч удаа эхнэр аваагүй, хүүхэдгүй байсаар 1790 онд өөд болжээ.

Эдийн засгийн онолд бүхий л амьдрал, хөдөлмөрөө зориулсан эрдэмтэд түүнээс өмнө байсан. Гэхдээ А.Смит эдийн засгийн онол цаашид дэвшин хөгжих үндэс суурийг тавьж чадсан гавьяатай юм.

"Ард түмнүүдийн баялгийн мөн чанар, шалтгааны тухай судалгаа" номондоо олон жилийн өмнөөс буруу ташаа баримталсаар ирсэн эдийн засгийн ойлголтуудыг зөвөөр тайлбарласан юм. Жишээ нь улс орны хувьд алтан нөөц чухал ач холбогдолтой гэж үздэг эдийн засгийн механик онол үндсээрээ буруу болохыг шүүмжлэв. Тэрчилэн хуримтлалын гол эх сурвалж нь газар гэж үздэг физиократуудыг буруушааж газар биш чухамдаа хөдөлмөр л баялгийн эх сурвалж болохыг онцлон тэмдэглэжээ. Хөдөлмөрийн хуваарилалтын үр дүнд л үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлж болохыг зааж аж үйлдвэрийн хөгжлийг саатуулж байгаа засгийн газрын бодлогыг тууштай шүүмжилж байлаа.

Гаднаас нь харахад эмх замбараагүй мэт санагдах чөлөөт зах зээл нь нийгмийн зүгээс шаардаж байгаа, нийгэмд зайлшгүй хэрэгтэй байгаа бүтээгдхүүнүүдийг гарцаагүй үйлдвэрлэхийг шаарддаг өөрөө өөрийгөө зохицуулдаг механизм I юм гэсэн үзэл санаа энэхүү алдарт бүтээлийн амин сүнс юм. Жишээ нь нийгэмд ямар нэгэн бүтээгдэхүүний хомсдол бий боллоо гэхэд үнэ нь өсөж түүнийг хамгийн түрүүнд мэдэрч үйлдвэрлэж эхэлсэн хүн маш

их ашиг олно, тэгэхлээр бусад үйлдвэрлэгч мөн их ашиг олохын тулд тухайн бүтээгдэхүүнийг бас үйлдвэрлэж эхэлнэ. Ингэж үйлдвэрлэлийн хэмжээ өссөнөөр үйлдвэрлэгчдийн хооронд өрсөлдөөн үүсэж бүтээгдэхүүний үнэ өөрийн өртгөө хүртэл унана. Иймд аливаа бүтээгдэхүүний хомсдолыг арилгахын тулд засгийн газрын зүгээс ямар нэгэн албадлагын арга хэмжээ авах шаардлагагүй, асуудал өөрөө шийдвэрлэгдэнэ.

Хүн бүр ашиг хонжоо олох гэж үхэн хатан тэмцэнэ, гэхдээ "үл үзэгдэгч гартүүнийгсэтгэлд ньчороогүйзорилгодхүргэнэ... Хүн бүрхувийнявцуу зорилгодоо хүрэхийн төлөө эрмэлзэх явцдаа нийгмийн ашиг сонирхолд үйлчилнэ."

Гэхдээ чөлөөт өрсөлдөөнийг боймолсон хязгаарлалт тавьсан тохиолдолд "үл үзэгдэгч гар" ногдсон үүргээ биелүүлж чадахгүй. Тийм учраас А.Смит чөлөөт худалдааг дэмжиж өндөр татвар тогтоохгүй байхыг уриалж байв. Төрийн зүгээс бизнес, чөлөөт худалдаанд хэт хутгалдан оролцохыг буруушааж тийм хэт оролцоо нь үйлдвэрлэлийн үр ашгийг багасгаж түүний улмаас үүсэх үнийн хөөрөгдлийн хор уршгийг хүн ам амсдаг гэж үзэж байв.

Зарим судлаач, эрдэмтэн А.Смит нь чөлөөт бизнесийг хамгаалагч байсан гэж үздэг нь буруу юм. А.Смит нь хувийн бизнесийн дангаар ноёрхолыг буруушааж нэг төрлийн бизнес эрхлэгчид уулзаж ярилцахаараа гаргаж буй бүтээгдхүүний үнийн асуудлаар тохиролцон нууцаар хуйвалдаж нийгэмд хор хохирол учруулдаг гэж бичиж байв.

А.Смит урьд үеийнхээ эдийн засагчдын сургаалыг хол ахиулсан эдийн засгийн цогц тогтолцоог бий болгож чадсан юм. Түүний залгамжлагч Томас Мальтус, Давид Рикардо зэрэг алдарт эдийн засагчид түүнийг эдийн засгийн онолыг гол үндэслэлийг нь хөндөхгүйгээр цааш нь хөгжүүлж өнөөдөр сонгодог эдийн засаг гэж нэрлэдэг бүтэцтэй болгож чадсан билээ. Өнөө үеийн эдийн засгийн онолчид дээрх бүтцэнд шинэ үндэслэл, арга нэмж оруулсаар байгаа ч тэднийг эдийн засгийн сонгодог онолын хөгжүүлэгчид гэж нэрлэдэг юм.

"Ард түмнүүдийн баялгийн мөн чанар, шалтгааны тухай судалгаа" номондоо А.Смит хүмүүсийн туйлын илүүдлийн тухай Мальтусын үзэл бодлын зарим үндэслэлийг буруушаажээ. Д.Рикардо, К.Маркс нар хүн амын хэт өсөлт нь ажлын хөлсийг амжиргааны доод түвшинг дээшлүүлэхэд саад болдог гэж үзэж байсан бол А.Смит үйлдвэрлэл өсөж байгаа нөхцөлд ажлын хөлс нэмэгдэж болно гэж нотолж байлаа. Цаг хугацаа А.Смитийн санаа зөв, Д.Рикардо, К.Маркс нарын томьёолол буруу болохыг багтай нотолсон билээ.

Бизнес худалдаанд төрийн оролцоог багасгах, татварыг бууруулах, чөлөөт худалдааг дэмжих тухай А.Смитийн үзэл бодол засгийн газрын бодлогод бүхэл бүтэн XIX зууны турш шийдвэрлэх нөлөө үзүүлж байсан билээ. Тэр нөлөө өнөөдөр ч хэвээр байна.

Улирах цаг хугацааны уртад эдийн засгийн онол А.Смитийн үеийнхээ хол ахисан ч бол мэдлэгүүдийн цогц бүтэц болох эдийн засгийн онолыг зохиогч байсан болохоор хүн төрөлхтөний оюун санааны хөгжлийн түүхэнд хүндтэй байр суурийг зүй ёсоор эзэлдэг юм.

# 31. Уильям Шекспир

(WILLIAM SHAKESPEARE)

1550-1604



Английн их жүжгийн зохиолч, яруу найрагч У.Шекспирийг дэлхий даяар бүх цаг үеийн хамгийн аугаа зохиолч гэж үздэг. "Гамлет", "Макбет", "Лир хаан", "Юлий Цезарь", "Отелло", "Ричард III" гэх зэрэг эмгэнэлт болон инээдмийн гуч гаруй жүжиг, 154 сонет, нилээд хэдэн томоохон шүлэг туурвисан нь дөрвөн зуу гаруй жил уншигч, үзэгчдийн тааашаал талархлыг хүлээсээр байна. Түүний жүжгийг тоглодоггүй драмын театр дэлхийд ганц ч үгүй билээ.

Уильям Шекспир гэдэг нууц нэрээр уран бүтээлээ хэвлүүлдэг байсан хүний жинхэнэ нэр нь Эдуард де Вера байжээ. Түүнийг нас барснаас долоо жилийн хойно жүжгүүдийн анхны түүвэр хэвлэгдэн гарсны дараа л түүнийг Шекспир гэдэг нууц нэрээр уран бүтээлээ нийтлүүлдэг байсныг мэдэж англи даяар мэл гайхаж байжээ. Түүний амьдралын тухай бодит мэдээлэл хомс учраас түүний намтрын тухай судлаачдын дийлэнх нь хүлээн зөвшөөрдөг хоёр хувилбар байдгийг толилууля.

Түүний эцэг Жон цагтаа зэгсэн худалдаачин байсан ч хэцүү байдалд оржээ. Гэвч хүү Уильям нь Стратфордын хэл бичгийн сур-гуульд орж латин хэл, сонгодог уран зохиол үзжээ. Эдуард де Вера 18 настайдаа Анна Хатуэй нэртэй бүсгүйг жирэмслүүлснээс аргагүйд хүрч гэрлэж хоёр жил хагасын дараа эхнэр нь хоёр ихэр хүүхэд төрүүлжээ. Дараагийн зургаан жилд хаана амьдарч ямар хөдөлмөр эрхэлж байсан тухай мэдээ байхгүй. 1590 оны эхээр Лондон хотод хэрмэл театрын хамтлагт жүжигчнээр орж төдөлгүй жүжиг зохиодог болжээ. 1598 онд гэхэд английн хамгийн шилдэг жүжгийн зохиолчийн алдар хүртсэн байв.

Лондон хотод хорин жил амьдрахдаа бүх уран бүтээлээ туурвисан ажээ. 1597 онд гэр бүл нь амьдарч буй Стратфорд хотод том байшин худалдан авч эхнэр хүүхдээ оруулж хөрөнгө

мөнгөөр байнга тэтгэдэг байв.

Шекспир 1612 онд 48 нас хүрэх үедээ гэнэт зохиол бичихээ больж Стратфорд хотод буцаан очиж эхнэр хүүхдүүдтэйгээ амьдарч байгаад 1616 оны дөрөвдүгээр сард өөд болоход нь сүмийн хашаа дотор нутаглуулжээ. Тэр газар нь хожим нь хөшөө босгожээ. Нас барахаасаа гурван долоо хоногийн өмнө хөрөнгөнийхөө дийлэнх хэсгийн ууган охин Сюзаннадаа өвлүүлэх гэрээслэл бичсэн байв.

Нөгөө хувилбарт нь Оксфордын нэгэн гүнгийн угсааны 16 дугаар үеийн хүний хүү болон төрж баян, язгууртан эцгийнхээ ачаар морь унаж ан хийж цэргийн хэрэгт суралцаж тэрчилэн бүжиг хийж, хөгжим тоглож сурчээ. Гэрийн багшаар латин, франц хэл, бусад шинжлэх ухаан заалгаж байгаад Кембрижийн их сургуульд суралцаж, бакалаврын зэрэг хүртжээ. Дараа нь нийслэл хотын нэртэй Грейс Инн корпорацид хууль зүй судалжээ.

Хүүг 12 настай байхад нь эцэг нь нас барсны дараа эх нь хоёр дахь удаагаа гэрлэхэд хатан хааны зарлигаар түүнийг тус улсын санхүүч лорд Ульям Сесилийн ивээлд өгчээ. Бие бялдар сайтай, гадаад үзэмж сайхан залуу болсон учир нэгдүгээр Елизавета хатан хааны шадар тайж болжээ. 21 настайдаа ивээгч У.Сесилийн охин Аннатой гэрлэжээ. 24 нас хүрмэгц Европ тивээр аялалд гарч Франц, Герман, Итали улсуудаар ороод буцаж явахдаа Ла Маншийн хоолойн ойролцоо далайн дээрэмчдэд баригдахдаа нэгдүгээр Елизавета хатан хааны шадар тайж гэдгээ хэлж суллагдаж байжээ. (Энэ үйл явдалтай төсөөтэй зохиомж “Гамлет” жүжигт бий.)

Эх орондоо буцан ирээд явснаас нь хойш найман сарын дараа эхнэрийнхээ төрүүлсэн охиныг өөрийн хүүхэд биш гэж үзэж гэрээсээ явжээ. (Буруугүй ч нөхрөө араар нь тавьсан хэрэгт унадаг бүсгүйчүүл Шекспирийн жүжгүүдэд олонтаа гарна, тухайлбал “Өвлийн шөнийн үлгэр”, “Отелло” жүжиг байна.) Анхны эхнэрээсээ салснаас хойш таван жилийн дараа ордны нэгэн хатагтайг жирэмслүүлснийг нь дуулаад хатан хаан Елизавета уурлаж түүнийг Тауэрийн цайзанд хорьжээ. Хэдэн сарын дараа суллагдахад жирэмслүүлсэн хатагтайн дурлалт хархүү халз тулаанд дуудаж шархдуулжээ. Хатан хаан энэ тухай сонсоод хэл амаа ололцохгүй бол хоёуланг нь шоронд хорьж насан турш нь хатаана гэж айлгаж байжээ.

(“Ромео, Жульетта” жүжгийн зохиомжийг санагдуулж байна.) Де Вер дахин эхнэртээ буцан ирсний хойно гэргий нь бас дөрвөн хүүхэд төрүүлсний дараа өөд болжээ. Де Верийг 36 настай байхад хатан хаан түүнд жилийн нэг мянган паундын тэтгэлэг олгох зарлиг гаргажээ.

Де Вер яруу найраг, театр сонирхдог, олон зохиолчтой нөхөрлөдөг нэгэн байв. Тэр үед ноёрхож байсан язгууртан хүн “шүлэг зохиол бичиж жижгэрч болохгүй” гэсэн зарчмыг баримталж ганц ч жүжиг, шүлгээ өөрийн нэрээр нийтлүүлдэггүй байв. Түүнээс гадна ордны язгууртан хүн байсан болохоор жүжгийн сэдвүүд нь голдуу хаад ноёдын тухай байсан болохоор илүү дутуу хэл амнаас зайлхийж нууц нэрээр жүжгүүдээ гаргадаг байжээ. 1604 онд болсон тахлын үеэр нас барахад нь Стратфорд хотын ойролцоо орших Хэрни дэх шилтгээнийх нь дэргэд оршуулжээ.

Шекспир амьд байхдаа нэг ч жүжгээ хэвлүүлж байгаагүй нь туйлын хачирхалтай. Хувь хүмүүс жүжгүүдийнх нь бараг тал хувийг хэвлэн борлуулж байхад ганц ч удаа шүүхэд гомдол

мэдүүлж байгаагүй ажээ.

Аугаа жүжгийн зохиолч маань хорь гаруй жил Лондон хотод амьдарч хүн төрөлхтөний оюуны санд эргэлт хийсэн уран бүтээлээ туурвиж байсан атал түүнтэй уулзаж байсан, харж байсан ганц ч зохиолч, жүжигчний дурсамж олдохгүй байгаа нь хачирхалтай. Тэрчилэн түүний төрөлх хотынхон, эхнэр, хүүхдүүд нь түүнийг дэлхийн зиндааны уран бүтээлч гэдгийг мэддэггүй байсан төдийгүй ер тааварладаггүй байжээ.

# 32. Жон Дальтон

(JOHN DALTON)

1766-1844



XIX зууны эхээр шинжлэх ухаанд атомын тухай онолыг нээсэн хүн бол английн эрдэмтэн Жон Дальтон билээ. Хорвоод байгаа бүх материаллаг эд зүйлс атом гэж нэрлэгддэг хуваагдашгүй маш өчүүхэн хэсгүүдээс бүрдэнэ гэдгийг урьдчилан таамагласан хүн нь мэдээж Ж.Дальтон биш ээ. Түүнээс урьд эртний грекийн гүн ухаантан Демокрит "Эд зүйлсийн мөн чанарын тухай" хэмээх алдарт найраглал туурвисан ромын зохиолч Лукреций нар эгэл хуваагдашгүй хэсгийн тухай таамаглалыг дэвшүүлж байсан билээ.

Ер нь Демокритийн дэвшүүлсэн онолыг дундад зууны үед эс тоож байсан учраас тухайн үеийнхээ шинжлэх ухаанд нөлөө үзүүлж чадаагүй өнгөрсөн ажээ. Гэхдээ ХҮ11 зуунд алдарт эрдэмтэд түүний дотор И.Ньютон зэрэг тэргүүлэх эрдэмтэд түүний онолыг бас судалж байжээ. Гэхдээ атомын тухай гүн ухааны төсөөлөл болон химийн шинжлэх ухааны нотлогдсон баримт хоорондын харилцан холбоог хэн ч олж харж чадаагүй юм.

Ж.Дальтон судалгааны ажлын явцдаа химийн туршилтын үр дүнг тайлбарлахад ашиглаж болох тоон үзүүлэлтийн онолыг гаргаж ирсэн юм. Тэр үед түүний хэрэглэж байсан нэр томъёо өнөө үеийнхээс ялгаатай байсан ч атом, молекул, элемент, химийн нэгдлүүдийн ойлголтуудыг зөв тодорхойлж өгсөн юм.

Хорвоо дэлхий дэх атомын нийт тоо хязгааргүй олон ч түүний янз бүрийн төрөл харьцангуй цөөхөн болохыг мөн гаргаж ирсэн билээ. Түүний номонд хориод элемент буюу мөн тийм тооны атомын тухай бичиж байсан бол өнөөдөр шинжлэх ухаанд зуу гаруй элемент мэдэгдээд байна.

Янз бүрийн төрлийн атомууд жингээрээ ялгаатай ч дурын хоёр атом бүх үзүүлэлтээрээ түүний дотор жингийн хувьд ч адилхан гэж Дальтон үзэж байв. (Өнөө үед орчин үеийн нарийн туршилтын үр дүнд химийн элемент бүр нь изотоп гэж нэрлэгддэг хоёр буюу түүнээс илүү тооны атомаас бүрдэх ба изотопууд нь химийн чанааруудаар адилхан боловч жингээрээ ялгагддаг болохыг нотолсон.) Ж.Дальтон номондоо, янз бүрийн төрлийн атомуудын



харьцангуй жингийн анхны хүснэгтийг оруулсан. Энэ бол атомын аливаа тоон онолын гол хэсэг байсан юм.

Химийн нэгэн нэгдлийн дурын хоёр молекул нь атомуудын адилхан зохицлоос бүрддэг гэдгийг яг таг тодорхойлсон билээ. Иймд тухайн химийн нэгдэл ямар ч аргаар бий болсон бай, хаанаас ч олдсон бай ялгаагүй жингийн хувьд адилхан зохицолтой адилхан элементүүдээс тогтдог гэсэн дүгнэлт гарч байна. Энэ бол хэдэн жилийн өмнө эрдэмтэн Жозеф Луи Прустын туршилтын явцад нээсэн "тодорхой зохилцлын" хуулийг бататгасан хэрэг байв.

Ж.Дальтоны номондоо дэвшүүлсэн атомуудын харьцангуй жинг яг таг тодорхойлох, химийн нэгдлүүдийг жингээр нь судлах, молекулын төрөл бүрийг бүрдүүлж буй атомуудын зохицлыг магадлах зэрэг хөтөлбөрийг эрдэмтэд хэрэгжүүлсэн нь үнэхээр гайхам амжилтад хүргэсэн билээ.

Орчин үеийн химийн шинжлэх ухааны үндсэн ойлголт болох атомын тухай таамаглалыг гаргажтавьсан нь Ж.Дальтоны үнэлж баршгүй гавьяа юм.

1766 онд Английн хойд хэсэгт орших Иглсфилд хотод төрж 11 настайдаа бага сургууль төгсөж түүнээс хойш бие даан боловсрол мэдлэг олж авчээ. 12 настайгаасаа насан эцэслэтлээ багшийн ажил эрхэлж байжээ. 15 настайдаа Кендел хотод ирж 26-тайдаа Манчестер хотод шилжин сууж тэндээ 1884 онд өөд болтлоо амьдарчээ. Эхнэр авч байсангүй ажээ.

1787 оноос цаг уурын шинжлэх ухааны сонирхож 21 насандаа энэ сэдвээр анхны номоо хэвлүүлжээ. Агаар, агаарын даралтыг судлах явцдаа хийн чанарыг бүхэлд нь сонирхож эхэлжээ. Туршилтын үр дүнд хийн үйл ажиллагааг чиглүүлэн удирддаг хоёр чухал хуулийг нээжээ. Хийн оршиж буй эзлэхүүн нь түүний халуун хүйтэнтэй тэнцдэг гэсэн анхны хуулиа 1801 онд олон нийтэд зарлажээ. (Энэ хууль нь түүнээс өмнө энэ хуулийг анх нээсэн ч нийтлүүлж амжаагүй францийн эрдэмтэн Шарлийн нэрээр нэрлэгдсэн хууль билээ.) Мөн онд гаргасан хоёр дахь хууль нь элементийн өчүүхэн хэсгүүдийн даралтын тухай хууль юм.

1804 онд атомын тухай онолоо томъёолж атомуудын жингийн хүснэгтийг бэлтгэсэн байна. Гэвч түүний гол ном болох "Химийн гүн ухааны шинэ тогтоц" ном нь дөнгөж 1808 онд хэвлэгдэж түүнд алдар суу авчирсан түүхтэй билээ.

Ж.Дальтон өнгө ялгадаггүй өвчнөөр өвддөг байсан болохоор уг үзэгдлийг судалж энэ сэдвээр дэлхийд анхны шинжлэх ухаан бүтээлийг хэвлүүлсэн байна.

# 33. Александр Македонский

(ALEXANDER THE GREAT)

Манай эриний өмнөх 356-323



Эртний үеийн хамгийн том байлдан дагуулагч Их Александр манай эриний өмнөх 356 онд Македоны Пелла хотод хосгүй авьяаслаг хоёрдугаар Филиппий хааны гэр бүлд төржээ. Тэрбээр цэргийнхээ тоог эрс нэмэгдүүлж шинэчлэл хийж байлдах өндөр ур чадвартай арми болгон өргөжүүлжээ. Хөрш орших Грекулсын нутагдэвсгэрийн дийлэнх хэсгийг эзэлж грекийн хот-улсуудын холбоог байгуулж удирдагч нь болжээ. Персийн хүчирхэг гүрнийг байлдах төлөвлөгөөтэй байсан ч 46 насандаа алагдсан ажээ.

Эцгийгээ нас барахад хорин настай байсан Александр хаан ширээг өвлөн авав. Эцэг нь хүүгийнхээ багшаар алдарт эрдэмтэн гүн ухаантан, Аристотелийг урьж тэрчилэн түүнд байлдааны тодорхой туршлага хуримтлуулж амжсан байв.

Александр хаан болсны дараах хоёр жилд Македоны ноёрхлын эсрэг боссон грекчүүдийн үймээнийг дарж сая нэг анхаарлаа Персийн зүг хандуулав. Тэр үед Газрын дундад тэнгисээс Энэтхэг хүртэл өргөн удам дэлгэр нутагт орших Перс гүрэн нь тухайн үедээ дэлхийн хамгийн том, хүчирхэг, баян улс байжээ. Александр манай эрний өмнөх 334 онд Персийн гүрэн рүү аян дайн эхлэхдээ европийн дэвсгэр нутаг дахь эзэмшлээ хатуу чанга гараар барьж байхын тулд армийнхаа нилээд хэсгийг орхисноос дөнгөн данган 35 мянган цэрэг авч гарчээ.

Өрсөлдөгчөөсөө хэдэн дахин бага хүчтэй байсан ч хэд хэдэн томоохон ялалт байгуулжээ. Үүнд үндсэн гурван гол шалтгаан байв. Түүний удирдсан арми байлдааны бэлтгэл, зохион байгуулалтын түвшингээр илүү байсан, өөрөө ч цэргийн жанжны хосгүй авьяас билгээс гадна хувийн мохошгүй зориггоо илтгэн харуулсан ажээ. Александр хэдэнтээ шархадсан ч морин цэргийн шийдвэрлэх дайралтыг биечлэн толгойлж цэргүүдийнхээ урам зоригийг сэргээж чадаж байжээ.

Эхлээд Бага Азиар дайрч тэнд байсан персийн армийн багахан хүчийг бут ниргэж дараахан нь Иссе голын ойролцоо болсон тулалдаанд томоохон армийг ньхиар цохижээ. Удалгүй өмнө зүг рүү хүлгийн жолоог залж өнөөгийн Ливан улсын нутаг дээр оршиж байсан Финикиний

хот улс Тирийг долоон сар бүслэлтхийсний дараа байлдан дагуулав. Энд байлдаан хийж байхдаа энхийн гэрээ байгуулсан тохиолдолд эзэнт гүрнийхээ тал хэсгийг сайн дураар өгөх санал бүхий Персийн хааны захидлыг авав. Генерал Парминий энэхүү саналыг хүлээн авахыг хүсэхэд Александр татгалзаж цааш хөдөлж Газа хотыг хоёр сарын бүслэлтийн дараа эзэлж Египетийг байлдаан хийлгүй буулган авав. Энд армия хэсэг амраалаа.

Александр тэр үед дөнгөж 24 настай байсан ч түүний цэргийн жанжны авьяасыг биширч бурханчлан шүтэх боллоо. Ази тив рүү эргэж манай эриний өмнөх 331 онд Арабеллийн дэргэд болсон байлдаанд Персийн армийн гол хүчийг дийлжээ.

Энэ ялалтын дараа Вавилон хотыг эзэлж Персийн нийслэл Сузы, Персеполийг өвдөг сөхрүүлжээ. Персийн армийн офицерүүд гуравдугаар Дарий хааныг эзлэн түрэмгийлэгчдэд олзлуулахгүй гэж цааш харуулсан байв. Гэвч Александр Персийн дараачийн хааныг алж дорнод Ираныг бүхэлд нь эзэлж Төв Ази руу нэвтэрлээ.

Александр Персийн эзэн гүрнийг бүрэн эзэлсний дараа эх нутаг руугаа буцаж болох байсан ч дайн байлдаанаа үргэлжлүүлэх хүсэл нь дийлж Афганистан руу халдан довтлов. Армия удирдан Гиндукушийн уулсыг давж Энэтхэгийн дорнод хэсэг рүү довтолж хэд хэдэн ялалт байгуулав. Энэтхэгийн баруун хэсэг рүү байлдах төлөвлөгөө гаргасан ч олон жилийн турш тувт байлдаж ядарч залхсан цэргүүд нь дургүйцсэн учир арга буюу Перс рүү буцжээ.

Александр эх орондоо буцаж ирээд нэг жилийн турш эзэнт гүрэн, армидаа гүн гүнзгий өөрчлөлт хийжээ. Грекийн соёлыгдан ганцжинхэнэ соёл иргэншил гэж өргөмжилж бусад олон ард түмнийг бүдүүлэг гэсэн үзлийг ард түмэндээ номлож байв. Гэхдээ Персийг байлдан дагуулж явахдаа тус ард түмэн бол бүдүүлэг дорой биш ухаантай чадварлаг хүмүүс цөөнгүй байгааг олж харжээ. Тэгээд улсынхаа хоёр хэсгийг нэгтгэж эзэнт гүрэн байгуулахаар шийджээ. Энэ зорилгоо хэрэгжүүлж "Дорно, Өрнийн хурим" нэртэй баяр зохиож македоны хэдэн мянган цэргийг ази бүсгүйчүүлтэй гэрлүүлж өөрөө үлгэр жишээ үзүүлж ази нутгийн гүнж эхнэртэй байсан ч Персийн хаан агсан Дарийн охинтой суужээ.

Александр армидаа персүүдийг авах зэргээр армидаа гүн өөрчлөлт хийж байхдаа дахин аян дайн хийж Арави руу нэвтэрч Персийн хойт хэсэг, Энэтхэгт дахин довтолж Ром, Карфаген, Газрын дундад тэнгисийн өрнөд хэсгийг эзлэх зорилго тавьж байв. Гэтэл манай эриний өмнөх 323 онд Вавилон хотод байхдаа гэнэт өвчин тусаж арав хоногийн дараа 33 настайдаа нас баржээ.

Цэл залуугаараа нүд анисан учир залгамжлагчаа зарлаж амжсангүй. Түүнийг нас барсны дараа эрх мэдлийн төлөө ширүүн тэмцэл өрнөж түүний хатнууд, хүүхдүүдийг нь цөмийг алж эзэнт гүрнийг нь генералууд нь хуваан захирчээ.

Александр идэр залуудаа өөд болоогүй бол Газрын дундад тэнгис рүү байлдаан хийж гарцаагүй ялалт байгуулах байсан нь лавтай. Тэгсэн бол Өрнөд Европийн цаашдын хувь заяа өөр байх байсан нь мэдээж хэрэг.

Их Александр бол дэлхийн түүхэнд хамгийн бахархал атаархал төрүүлсэн цэргийн жанжин юм. Хосгүй авьяаслаг цэргийн жанжин байсан ба 11 жил байлдаан тулаан хийхдээ ганц ч

удаа ялагдал хүлээж байгаагүй билээ. Ойр дотнын хүмүүстэй харьцахдаа сайхан ааш зантай хүн байсан ч нэг уурлахаар биеэ барьж чаддаггүй хүн байжээ. Нэгэн удаа галзууртлаа уурлаж хамтран зүтгэгч цэргийн зүтгэлтэн Клитусыг алж байжээ.

Наполеон, Гитлерийн адил Александр Македонский тухайн үеийнхээ хөгжилд маш их нөлөө үзүүлсэн юм. Грекийн болон Дундад Дорнын соёлыг ойртуулж бие биенийг нь харилцан баяжуулсан юм. Түүний аян дайны үед грекийн сонгодогсоёл Иран, Месопотами, Сири, Египетэд гүн гүнзгий нэвтэрч Энэтхэг, Төв Азид хүрсэн билээ.

Хорь гаруй хотын шавыг тавьснаас хамгийн цуутай нь удалгүй дэлхийн боловсрол, соёлын төвийн нэг болсон Египетийн Александри, бас Афганистаны Герат, Кандагар хотууд юм.

# 34. Наполеон Бонапарт

(NAPOLEON BONAPARTE)

1769-1821

Францийн алдарт цэргийн жанжин, нэгдүгээр Наполеон хаан 1769 онд Корсик арлын Аяччо хотод төржээ. Франц улс түүнийг төрөхөөс 15 сарын өмнө Корсикийн арлыг өөртөө хүчээр нэгтгэсэн учир Наполеон залуудаа францчуудыг эзлэн түрэмгийлэгчид гэж таашаадаггүй байжээ. Гэвч Францад цэргийн академи төгсөж 1785 онд 16 настайдаа францийн армийн их бууны бага дэслэгч цол хүртэв.

Дөрвөн жилийн дараа Францийн их хувьсгал эхэлж тус орны шинэ засгийн газар хэд хэдэн гадаад орнуудтай дайтаж Наполеон 1793 онд Тулон хотын дэргэд болсон байлдаанд их бууны анги удирдан оролцож ялалт байгуулсан учир хошууч генерал цолоор шагнуулж 1796 онд Италид аялан байлдах францийн армийн командлагчаар томилогджээ. 1796-1797 онуудад хэд хэдэн гялалзсан ялалт байгуулж Париж хотод буцан ирэхэд түүнийг үндэсний баатрын хэмжээнд хүндэтгэн угтан авчээ.

1798 онд Египет рүү халдан довголсон боловч адмирал Нельсоны удирдсан английн усан цэргийн флотод бут ниргүүлж 1799 онд эх орондоо буцан ирэв. Буцан ирснийхээ дараа хамба лам Сюа зэрэг бусад хүмүүстэй хамтран төрийн эргэлт хийж консулын шинэ засгийн газар байгуулагдахад Наполеон анхны консулоор сонгогджээ. Хуйвалдаан хийгчид шинэ үндсэн хууль баталсан боловч тэр нь Наполеоны толгойлсон цэргийн дарангуйллын засаглалын үнэн нүүр царайг далдлах зорилгод нийцсэн баримт бичиг болсон байлаа.

Ийнхүү 1793 онд Тулоны дэргэд болсон байлдаанд гавьяа байгуулж тодорсон Наполеон зургаан жилийн дараа гэхэд гучин насандаа европийн хүчирхэг гүрэн болох Франц улсын хэмжээгүй эрхт удирдагч болж 14 жил гаруй захирчээ.

Наполеон төр засгийн эрх мэдлийг барьж байхдаа засгийн газартаа томоохон шинэчлэлтүүд эрэмбэ дараатай хийсэн байна. Санхүүгийн бүтэц, хуулийн тогтолцоог өөрчилж төв банк, их сургууль байгуулж засаг захиргааны шинэчлэл хийж төвлөрсөн засгийн газрыг бэхжүүлэв. Эдгээр өөрчлөлтүүдийн үр дүнд Франц улсын хүчин чадал нэмэгдсэн ч өөр бусад оронд ямар ч нөлөө үзүүлээгүй юм.

Гэхдээ Наполеоны хэрэгжүүлсэн олон өөрчлөлтүүдээс түүний нэрээр нэрлэгдсэн Францийн иргэний хууль тогтоомж гадаад орнуудад томоохон нөлөө үзүүлсэн юм. Францийн иххувьсгалын үзэл санаа нэвт шингэсэн Наполеоны хууль тогтоомжид бүх хүн хуулийн өмнө тэгш эрхтэй, иймд хүнийг анх төрөхөд нь эцэг, эхийнх нь эрх дархыг уламжлуулан эдлүүлж болохгүй гэж заасан байлаа. Маш товч тодорхой найрууллагатай, францийн ард түмний эртний уламжлалын санааг тусгасан энэ хууль тогтоомжийг ард түмэн хүндэтгэлтэй хүлээн авч хэрэгжүүлсэн юм. Наполеоны хууль тогтоомжийг европийн олон орон өөрийн өвөрмөц онцлогтой уялдуулан шууд хуулбарлан хэрэглэсэн ажээ.

Наполеоны явуулж байсан улс төрийн бодлогын нэг онцлог нь тэр Францийн их хувьсгалын үзэл санааг ямагт хамгаалж байсан явдал юм. Гэсэн ч 1804 онд өөрийгөө Францийн хаанаар өргөмжилсөн нь бүгд найрамдахчуудын дургүйг ихэд хүргэжээ. Наполеон хөрш орнуудтайгаа байнга дайтсаар байгаа Франц улсад амгалан тайван амьдрал бий болгохын төлөө ихээхэн хүчин чармайлт тавьж байлаа. 1802 онд Амьен хотод Англи улстай энхийн гэрээ байгуулж арваад жил үргэлжилсэн дайныг зогсоож чадав. Гэвч дараа жил нь тэр гэрээг цуцалж Англи болон түүний холбоотнуудтай дайн зарлав.

Наполеоны удирдсан цэргүүд английн армийг хуурай газар дээр болсон байлдаан бүртээ ялж байсан ч Английн гол хүч болох усан цэргийн флотыг дийлэхгүй байлаа. 1805 онд Трафальгарт болсон тулалдаанд английн флотод бут ниргүүлжээ. Зургаан долоо хоногийн дараа Наполеон Аустерлицийн дэргэд болсон байлдаанд орос, австрийн цэргийг бут ниргэж гайхамшигт ялалт байгуулсан ч Англи флот тэнгист бүрэн ноёрхсон хэвээр үлджээ.

1808 онд Пиренейн хагас арал дээр дайн өдөөсөн нь хэдэн жил сунжирч нэр нүүрээ барав. Гэвч түүний гол алдаа нь 1812 онд Орос улсад халдан довтолсон явдал байлаа. 1812 оны есдүгээр сард болсон алдарт Бородиногийн тулалдааны дараа францийн арми нийслэл Москваг эзлэсэн ч таван долоо хоногийн дараа аргагүйд тулж ухрав. Гэвч хугацаа хожимдож оросын хүйтэн өвөлд сайтар бэлтгээгүй учир оросын армид ялагдаж францийн Аугаа армийн арван хувь нь дөнгөн данган амь мэнд мултарчээ.

Энэ үед Францийн ноёрхолд дургүйцсэн Австри, Прусс орнууд цэргийн хүчээ нэгтгэж 1813 онд Лейпциг хотын дэргэд болсон тулалдаанд

Наполеоны армийг бас бут цохив. Дараа жил нь төр, засгийн эрхнээс зайлуулагдаж Италийн эргийн Эльба аралд цөлөгджээ.

1815 онд Наполеон Париж хотод буцан ирж бүх эрх мэдлээ сэргээсэн ч европийн бусад орон нэгдэж түүний эсрэг дайн зарлаж Ватерлоо тосгоны дэргэд болсон шийдвэрлэх тулалдаанд ялжээ. Үүний дараа Наполеоныг Атлантын далайн өмнөх хэсэгт орших Ариун Еленагийн аралд цөлсөн байна. Наполеон тэнд 1821 онд зүрхний шигдээс өвчнөөр нас баржээ.

Наполеон бол цэргийн хосгүй авьяаслаг жанжин байсан юм. Түүний тактикийн маневр хийх чадвар гайхамшигтай байсан ч стратегийн хувьд Египет, Орос руу довтолж засаж болшгүй алдаа хийсэн юм. Хэдийгээр цэргийн аугаа жанжин байсан ч эцэст нь гутамшигтай ялалдал хүлээсэн болохоор түүний хийсэн байлдан дагуулалт үр дүнгүй болсон юм. Наполеоны өдөөсөн дайны уршгаар францийн таван зуун мянган цэрэг амь насаа алдсан байна. 1815 онд Франц улс бүрэн ялалдал хүлээсний уршгаар 1789 онд хувьсгал гарч байх үеэс бага газар нутагтай болсон байлаа.


Наполеон хаант ёсыг сэргээх зорилго агуулж байсан ч Францийн аугаа их хувьсгалын үзэл санааг нийт европ даяар түгээн дэлгэрүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн билээ. Наполеон тойруу замаар Латин Америкийн хөгжилд асар их нөлөө үзүүлсэн юм. Түүний арми Испани улсад халдан довтолсноор тус улсын засгийн газрын хүчин чадал мөхөсдөж түүнийг нь далимдуулан Латин Америк дахь колони орнуудад нь тусгаар тогтнолын төлөө тэмцэл хүчтэй өрнөжээ.

Умард Америк дахь францийн эзэмшил нутгийг английн довтолгооноос хамгаалах туйлын хэцүү болохыг ойлгож тэрчилэн мөнгөний гачаалаас болж Наполеон АНУ-д худалдсанаар тус улс бараг тив эзэгнэсэн асар том газар нутагтай орон болон хувирчээ. Энэ арилжаа нь хүн төрөлхтөний түүхэнд асар том газар нутгийг нэг улс нөгөөдөө тайван замаар шилжүүлэн өгсөн цорын ганц тохиолдол болсон юм. Хэрэвзээ Наполеон Луизана муж улсын газар нутгийг АНУ-д худалдаагүй бол АНУ өнөөгийн шиг дэлхийн аугаа гүрэн болох байсан эсэх нь эргэлзээтэй байх байсан биз ээ.

# 35. Томас Эдисон

(THOMAS EDISON)

1847-1931



Аугаа их зохион бүтээгч Томас Алва Эдисон 1847 онд АНУ-ын Огайо муж улсын Милан хотод төржээ. Дунд сургуульд орж гурван сар суралцсаны дараа ангийн багш нь түүнийг юу ч заасан ойлгодоггүй, оюуны хомсдолтой хүүхэд гэж нүд үзүүрлэх болжээ.

Т.Эдисон анхны шинэ бүтээл болох дуу ярианы бичлэгийн төхөөрөмжөө 21 настайдаа хийж зарахыг оролдсон ч бүтээгүй байна. Тиймд худалдан авагчийн сонирхол татах ямар нэгэн зүйл бүтээхийг чармайх болов. Дуу ярианы бичлэгийн төхөөрөмжөө улам боловсронгуй болгосны үндсэн дээр биржийн холбооны тогтолцоог шинэчилж тухайн үедээ асар их мөнгө болох дөчин мянган ам.долларын шагнал хүртжээ. Дараагаар нь олон шинэ бүтээл хийж төдөлгүй баян, нэрд гарсан хүн болжээ. Түүний олон тооны шинэ бүтээл дотроос 1877 онд патентийг нь авсан авиа тэмдэглүүр хамгийн өвөрмөц нь болсон билээ. Гэхдээ 1879 онд асдаг чийдэнг боловсронгуй болгосон нь түүний олон шинэ бүтээлүүдээс хүн төрөлхтөний хувьд хамгийн хэрэгтэй нь болсон юм.

Ер нь цахилгаан гэрэлтүүлгийн тогтолцоог нээсэн анхны хүн нь Т.Эдисон байгаагүй юм. Түүнийг нээлтээ хийхээс өмнө Париж хотын гудамж талбайг гэрэлтүүлэхэд нум хэлбэрийн цахилгаан чийдэн ашиглаж байв. Гэхдээ Т.Эдисон цахилгаан гүйдлийг дамжуулах тогтолцоог боловсруулж айл гэр бүрийг гэрэлтүүлэх бололцоог хүн төрөлхтөнд олгож гарамгай гавьяа байгуулсан билээ.

Түүний байгуулсан компани 1882 онд Нью-Йорк хотын бүх байшинг гэрэлтүүлэх гэрээ байгуулж үйлдвэрлэл эхэлснээс хойш чийдэн дэлхий даяар тархаж айл гэр бүр гэрэлтэй болсон билээ.

Т.Эдисон айл бүрт цахилгаан гэрэл түгээх анхны компани байгуулснаар асар том аж



Үйлдвэрийн салбарын үндэс суурийг тавьсан юм. Энэ бол зөвхөн чийдэн асаахад хэрэглэгдэх цахилгаан гүйдэл дамжуулах төдийгүй зурагтаас авхуулаад угаалгын төхөөрөмж хүртэлх айл гэрийн хэрэгцээний өчнөөн төчнөөн цахилгаан хэрэгслийг ажиллуулах бололцоог нээж өгсөн билээ. Т.Эдисон цахилгаан эрчим хүчийг сүлжээнээс авч хэрэглэж болох аргыг нээснээр аж үйлдвэрийн салбарт цахилгаан эрчим хүчний хэрэглээг улам нэмэгдүүлэх замыг шулуутгасан юм.

Шинэ бүтээл нь кино зураг авах, гаргах төхөөрөмжийг боловсронгуй болгоход шийдвэрлэх нөлөө үзүүлсэн байна. Тэрчилэн ярьдаг утас (түүний санаачилсан өнцөгт мембран нь дуулдах чадварыг улам сайжруулсан), телеграф, бичгийн машиныг боловсронгуй болгох талаар ихээхэн дэвшил хийх бололцоог нээжээ. Тэрчилэн өнөөдөр өдөр тутмын хэрэглээ болсон диктофон, цэнэглэгч батареиг анх бий болгосон. Ер нь бол Т.Эдисон мянга гаруй шинэ бүтээл гаргасан нь өнөөдөр ч хүн төрөлхтөний бахархлыг төрүүлж байна.

Түүний маш үр дүнтэй ажиллаж байсны нэг нууц нь Менло-Парк, Нью-Жерсид судалгааны лаборатори байгуулж олон тооны туслахуудтай хамтарч ажиллаж байсан явдал гэж үздэг. Энэ бол аж үйлдвэрийн пүүсүүд дэргэдээ судалгааны том том лабораториудтай ажиллах эхлэлийг тавьсан гэсэн үг.

Т.Эдисон зөвхөн зохион бүтээгч байсангүй, тэрчилэн үйлдвэрлэлд идэвхтэй оролцож хэд хэдэн аж үйлдвэрийн компани байгуулан удирдан ажиллуулж байснаас хамгийн том нь одоо ч дэлхийд зартай "Женерал Электрик" компани юм.

Онолын эрдэмтэн байгаагүй ч шинжлэх ухаанд нэг томоохон нээлт хийсэн юм. Вакуумтай ойролцоо орон зайд цахилгаан гүйдэл хоорондоо хавирч нийлээгүй хоёр утсаар дамжин өнгөрдөг болохыг 1882 онд нээжээ. Эдисоны үзэгдэл гэж нэрлэсэн энэхүү ер бусын үзэгдэл нь онолын төдийгүй практик маш их ач холбогдолтой болсон юм. Энэхүү нээлт нь вакуумны хоолой бий болгоход хүргэж цахилгааны аж үйлдвэрийн хөгжлийн эхлэл болсон билээ.

Амьдралынхаа дийлэнх хэсэгт чих дүлий байсан ч энэхүү өвчнөө ажиллах асар хосгүй их чадвараараа нөхөж чадсан зохион бүтээгч юм. Амьдралдаа хоёр удаа гэрлэхдээ эхнэр бүрээсээ гурван хүүхэдтэй байжээ. 1931 онд Нью-Жерси муж улсын Вест-Оранж хотод 84 настайдаа өөд болсон.

Т.Эдисон дэлхий ертөнц дээр амьдарч байсан хамгийн гарамгай зохион бүтээгч байсныг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрдөг. Түүний шинэ бүтээл бүрийг тус тусад нь салангид авч үзвэл аль нь ч шинжлэх ухааны хөгжилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгээгүй юм шиг санагддаг. Тухайлбал чийдэн өнөөдөр өргөн хэрэглэж байгаа ч орчин үеийн амьдралын зайлшгүй хэрэгтэй зүйлийн зөвхөн нэг юм. Авиатэмдэглүүр нь үнэхээр аугаа нээлт ч радио, зурагт, ярьдаг утас шиг бидний амьдралыг орвонгоор нь өөрчилж чадаагүй билээ.

Түүний авсан патентын дийлэнх нь бусад хүмүүсийн нээж амьдралд аль нэг хэмжээгээр хэрэглэж байсан зүйлийг улам боловсронгуй болгосон ач холбогдолтой юм. Ер нь түүний шинэ бүтээл нь амьдралд ашигтай байснаас биш хүн төрөлхтөний шинжлэх ухааны хөгжилд чухал үе шат болж чадаагүй юм. Гэхдээ нэг биш мянга гаруй шинэ бүтээл хийсэн хосгүй гавьяатай хүн юм. Чухам ийм учраасуут хүмүүсийн энэжагсаалтад Г.Маркони, А.Г.Белл

зэрэг гарамгай зохион бүтээгч нараас түүрүүнд бичигдэж байгаа юм.

# 36. Антони Ван Левенгук

(ANTONY VAN LEEUWENHOEK)

1632-1723



Хүн төрөлхтөнд нянг нээж өгсөн зүйргүй их гавьяатай алдарт эрдэмтэн Антони ван Левенгук 1632 онд Нидерландын Дельфт хотод мэндэлжээ. Дунд зиндааны чинээлэг гэр бүлээс гаралтай иргэн байсан болохоор амьдралынхаа дийлэнх хэсгийг хотын захиргаанд багахан албан тушаал хашиж өнгөрөөжээ.

Аль багаасаа микроскоп сонирхдог "донтой" байсан нь түүний нэрийг түүхэнд мөнхөлсөн нээлт хийхэд хүргэжээ. Тэр цаг үед микроскопийг дэлгүүрт зардаггүй байсан болохоор Левенгук дийлдэшгүй дур сонирхолдоо хөтлөгдөн бие даан микроскоп хийж ашигладаг байв. Томруулдаг шил бэлтгэдэг мэргэжилтэн байгаагүй ч алтан гартай зохион бүтээгч байжээ.

Урьд өмнө нь өөр хүмүүсийн бүтээсэн нарийн зохион байгуулалттай микроскоп байсан ч Левенгук тэдгээрийг огт ашиглаагүй юм. Жижиг томруулдаг шилийг нягт нямбай, нарийн тооцоотой өнгөлөн зүлгэж маш нарийнхан тусгалтай болгож чадсанаар урьд үеийнхээсээ илүү сайн томруулдаг шил бий болгосон ажээ. Өнөө үед хадгалагдаж ирсэн түүний хэрэглэж байсан томруулдаг шилүүд дотор 270 дахин томруулдаг шил байна. Түүнээс илүү олон дахин томруулдаг шил зохион ашиглаж байсан тухай таамаглал бас бий.

Атаархам тэвчээртэй, гярхай ажиглагч, хурц нүдтэй, ихийг сонирхдог хүн байжээ. Анхандаа жижигхэн хэмжээний томруулдаг шил хэрэглэж хүний үснээс авхуулаад нохойн шүлс, борооны уснаас өчүүхэн шавьж хорхой тэрчилэн булчин шөрмөс, арьс гээд өчнөөн төчнөөн эд зүйлсийг томруулдаг шилээр харж ажигладаг байлаа.

1673 оноос хийж байгаа ажиглалтынхаа талаар тэр үеийн шинжлэх ухааны тэргүүлэх төв болох Английн Хатан хааны шинжлэх ухааны нийгэмлэгтэй холбоо тогтоож байнга мэдээлэл солилцож байсан бөгөөд жирийн дунд сургууль л төгссөн, төрөлх голланд хэлнээсээ өөр гадаад хэл мэддэггүй түүнийг 1680 онд тус нийгэмлэг шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг нь өндөр үнэлж гишүүнээрээ элсүүлжээ. Түүнийг Парижийн Шинжлэх ухааны

академи мөн гишүүнээр сонгожээ.

Амьдралдаа хоёр удаа гэрлэж зургаан хүүхэдтэй болжээ. Биеийн эрүүл мэнддээ онцгой анхаарал тавьдаг байсны ачаар насан өндөр болтлоо ажиллах чадвараараа хүмүүсийг бишрүүлж байжээ. Түүнтэй уулзахаар Оросын нэгдүгээр Петр хаан, Английн хатан хаан зэрэг алдар цуутай хүмүүс ирж байжээ.

Левенгук нь хэд хэдэн чухал нээлт хийсэн билээ. 1677 онд үрийн шингэний мөн чанарыг анх тайлж цусны цул бөөмийг мөн анх тайлбарлажээ. Байгалийн эгэл биетүүд өөрсдөө өсөн үрждэг тухай онолыг буруушааж бөөс нь жирийн далавчит хорхой шавьж шиг тархдаг зэрэг хэд хэдэн нотолгоог гаргажээ.

Нянгийн тухай алдарт нээлтээ 1674 онд хийжээ. Энэ бол хүн төрөлхтөний түүхэн дэхь хамгийн гайхамшигт нээлтүүдийн оргил нь болсон юм. Левенгук нь он удаан жилийн асар их ажиглалтынхаа үр дүнд усны дусал дотор бүхэл бүтэн ертөнц, амьдрал бялхсан маш өвөрмөц ертөнц байгааг анх олж харсан билээ.

# 37. Уильям Томас Грин Мортон

(WILLIAM THOMAS GREEN MORTON)

1819-1868



Мэс засал хийхэд мэдээ алдуулах аргыг нээсэн гол гавьяа Ульям Томас Грин Мортонд ногддог юм.

Ер нь нисэх онгоц бүтээсэн, цахилгаан гүйдэл нээсэн, мэс засал хийхдээ ухаан алдуулах арга олсон гэх зэрэг хэд хэдэн чухал нээлт хүн төрөлхтөний хувь заяанд асар их өөрчлөлт оруулсан билээ. Эрт дээр үед ухаан саруул үедээ ясаа хөрөөдүүлж байгаа өвчтөн, ясыг нь хөрөөдөж байгаа эмч хоёрын байдлыг төсөөлөн бодоход аймшигтай. Тэрхүү аймшигт зовлонгоос хүмүүсийг эгнэгт ангижруулсан хүний мөнхийн гавьяаг хүн төрөлхтөн мартаж эрхгүй билээ.

Т.Мортон 1819 онд АНУ-ын Массачусетс муж улсын Чарлстон хотод мэндэлж Балтимор хотод шүдний мэс заслын коллежид суралцаж 1842 оноос ажил хийж эхлэв. Насаар ахмад, мэдээ алдуулах асуудлыг сонирхдог Хорас Уэллос гэдэг хүнтэй жил гаруй хамтарч ажиллаад ашиг олсонгүй учир 1843 оны сүүлчээс больжээ.

Уэллс жилийн дараа азотын эслээр туршилт хийж эхэлж Коннектикут муж улсын Хартфорд хотод эмчилгээний ажилдаа амжилттай хэрэглэж өвчтөнийг эмчлэх явцдаа мэдээ алдуулалт хийж хэвшив. Гэвч Бостон хотод олон нийтийн өмнө мэдээ алдуулах аргаа хэрэглэн үзүүлэх эмчилгээ хийсэн нь үр дүнгүй болж бөөн шүүмжлэлд өртжээ.

У.Мортон хиймэл шүд суулгах эмчилгээ хийхдээ араа шүдний ёзоорыг авахад өвчтөн ихээхэн зовдогийг багасгах зорилгоор мэдээ алдуулах ямар нэг арга олох хэрэгтэй гэдгийг ойлгож байсан тул азотын ислээс өөр ямар нэгэн бодис эрж олохоор шийджээ. Дотнын найз, нэрт эрдэмтэн Чарлз Т.Жексон түүнд цийлэгийг ашиглахыг зөвлөв. Швейцарын цуутай эрдэмтэн Парацельс бараг гурван зуун жилийн өмнө цийлэгийг өвчин намдаадаг чанарыг нээсэн боловч ганц ч эрдэмтэн түүнийг мэс засал хийхэд ашиглаж байсангүй ажээ.

Мортон цийлэгийн тухай сонсоод авралын од олсон мэт чин сэтгэлээсээ баярлаж цийлэгийг

эхлээд нохой дээр дараа нь биен дээрээ туршилт хийж эхэлжээ. Тэгээд 1846 оны есдүгээр сарын 30-ны өдөр аз дайрч Эбен Фрост нэртэй хүн өрөөнд нь орж ирээд шүд өвдөж тэсэхээ байлаа, шүдийг минь яаж ийгээд өвгөлгүй аваач гэж гуйжээ. Ингээд Мортон зориг гаргаж цийлэг тарьж өвчтэй шүдийг нь авав. Фрост ухаан орсны дараа ямар ч зовиур мэдэрсэнгүй гэж хэлэхэд Мортон магнай хагартлаа баярлаж алдар нэрийн оргилд хүрлээ, мөдхөн хагартлаа баяжина гэж дотроо боджээ.

Олон гэрчийн дэргэд болсон энэ "онцгой явдлыг" маргааш нь гэхэд Бостон хотын хэд хэдэн сонин мэдээлсэн ч олон нийтийн анхаарал татсангүй. Үүнд У.Мортон гайхсан ч Бостон хотын төв эмнэлгийн ахлах мэс засалч доктор Жон С.Уорренд хандаж эмч нарын өмнө мэдээ алдуулдаг арга олсноо үзүүлэх бололцоо олгохыг гуйжээ. 1846 оны аравдугаар сарын 16-ны өдөр Мортон эмч, оюутнуудын өмнө өвчтөн Гилберт Эбботийг цийлэг тарьж унтуулж өвчтөний хүзүү дээрх хавдрыг доктор Уоррен авч хаяв. Ийнхүү мэдээ алдуулалт үнэхээр санаанд багтамгүй үр дүнтэй болох нь нотлогдов. Энэ мэс заслаас хойш мэс засал хийхэд мэдээ алдуулалтыг өргөн хэрэглэж эхэлсэн түүхтэй ажээ.

Дээрх мэс заслаас сарын дараа Мортон шинэ нээлтийн зохиогчийн үнэмлэх авсан ч доктор Жексон гэх зэрэг зарим хүн бөөн зарга үүсгэжээ. Түүгээр ч барахгүй мэс засал хийхэд мэдээ алдуулах аргыг хэрэглэдэг болсон эмч, эмнэлгүүдийн дийлэнх нь зохиогчийн татвар төлөхөөс зайлсхийх болсон тул хязгааргүй баян болох мөрөөдөл нь талаар өнгөрчээ. Мортон зохиогчийн эрхээ баталгаажуулахын төлөө шүүхэд заргалдаж олсон хамаг хөрөнгөө барж 1668 онд Нью-Йорк хотод 49 настайдаа сэтгэл санааны хямралыг дийлсэнгүй, ядуу байдалд нас баржээ.

У.Мортоны эсрэг түүний шинэ нээлтийг өөрийн болгох гэсэн олон хүн байсны дотор Хорас Уэллс, Чарлз Жексон, Кроуфорд В.Лонг нар байсан юм.

Чин үнэнийг хэлэхэд доктор Хорас Уэллс шүд эмчлэх явцдаа Мортонгоос хоёр жилийн өмнө азотын ислийг хэрэглэж мэдээ алдуулалт хийж байсан юм. Азотын исэл нь мэдээ алдуулах тодорхой чанартай ч мэс заслын салбарт өргөн дэлгэр хэрэглэх ямар ч бололцоогүй, харин түүнийг өөр бодисуудтай нийлүүлж шүд эмчлэхэд л ашиглаж ирсэн юм. Гэтэл цийлэг нь мэдээ алдуулах чанараараа юутай ч харьцуулашгүй үр дүнтэй бодис байж мэс заслын салбарт хувьсгал болсон билээ.

Өнөө цаг үед дийлэнх тохиолдолд мэдээ алдуулалт хийхдээ цийлэгээс илүү хүчтэй бодис ашиглаж байгаа ч цийлэгийг бараг зуун жил гаруй мэдээ алдуулах хамгийн гол хэрэгсэл болгон ашиглаж ирсэн юм. Цийлэгийг хэрэглэхэд бөөлжис цутгахаас өөр ямар ч таагүй нөлөө хүний биед үзүүлдэггүй гайхамшигт эд юм.

Жорж хотын иргэн доктор Кроуфорд В.Лонг 1842 онд буюу Мортонгоос дөрвөн жилийн өмнө цийлэгийг мэдээ алдуулах зорилгоор мэс засал хийхдээ хэрэглэж эхэлсэн байна. Гэвч өөрийн эмчилгээний үр дүнг 1849 он хүртэл хэвлүүлээгүй байна.

Чарлз Жексоны хувьд цийлэгийг хэрэглэх зөвөлгөөг анх Мортонд хэлж өгсөн ч цийлэгийг мэс засал хийхдээ ганц ч удаа хэрэглэж зориглоогүй бөгөөд Мортон цийлэгийг хэрэглэн олны өмнө өвчтөн Гилберт Эбботыг ухаан алдуулж мэс засал хийгээд тэр мэс засал нь

амжилтгүй болсон бол Чарлз Жексон гарах бүх хор уршгийг хариуцах чадваргүй эрдэмтэн байсан юм.

Эрдэмтэн У.Мортоны 1846 оны аравдугаар сард олон эрдэмтэн, оюутны өмнө хийсэн мэдээ алдуулалтын үзүүлбэрээс хүн төрөлхтөний түүхийн нэгэн аугаа цаг мөч эхэлсэн билээ. Түүний шарил дээр бичсэн доорх үгүүд түүний баталгаа болно:

"Уильям Т.Мортон бол Мэс засал хийхэд бүх үеийн турш хамгийн аймшигтай зовлон байсан өвдөлтийг устгаж шинжлэх ухаан өвдөлтийг хянадаг болсон эрин үеийг нээсэн мэдээ алдуулалтыг зохион бүтээгч мөн."

# 38. Гульельмо Маркони

(GUGLIELMO MARCONI)

1847-1937



Радио зохион бүтээгч Гульельмо Маркони 1847 онд Италийн Болонь хотод баян айлын гэр бүлд төрж гэрийн багшаар хичээл заалгаж өндөр боловсрол эзэмшжээ. 1894 онд хорин настай залуу эр нилээд хэдэн жилийн өмнө германы эрдэмтэн Генрих Герцийн хийж байсан туршилтын тухай лекц уншжээ. Эрдэмтэн Г.Герц туршилт хийх явцдаа байгальд хүний нүдэнд үл үзэгдэх цахилгаан соронзон долгион байна, тэдгээр долгион нь орон зайд гэрлийн хурдтай адилхан хурдаар тархдаг гэсэн дүгнэлт хийсэн байжээ. Г.Маркони дээрх дүгнэлтийг үндэслэн тэрхүү цахилгаан соронзон долгионыг ашиглан алс холын зайд утас хэрэглэлгүй дохио дамжуулж болох тухай таамаглал дэвшүүлэв.

Энэ таамаглал нь алс зайд дохио дамжуулахад ашиглаж байгаа телеграфас илүү олон бололцоо нээх байлаа. Тухайлбал далайн гүнд байгаа усан хөлөг онгоц руу дохио дамжуулан мэдээлэл солилцож байх сайхан боломжийг олгох байв.

1895 онд Г.Маркони ажлын төхөөрөмж бэлэн болгож түүнийгээ дараа жил нь Англи улсад аваачин үзүүлж шинэ бүтээлийн зохиогчийн анхны эрхээ авав. Удсангүй хувийн компани байгуулж 1898 онд анхны радио дохионуудыг агаарт цацаж эхлэжээ. 1899 онд Ла Маншийн хоолойгоор дамжуулан ямар ч утас хэрэглэлгүйгээр мэдээлэл солилцож хэвшив. Г.Маркони утасгүйгээр мэдээлэл дамжуулах шинэ нээлтийн зохиогчийн үнэмлэхээ 1900 онд авсан ч дараа жилүүдэд нь төхөөрөмжөө улам сайжруулсаар байв. 1901 онд Англиас Ньюфаундленд руу Атлантын далайг гатлуулан радио дохио амжилттай дамжуулжээ.

1909 онд "Бүгд найрамдах" нэртэй усан хөлөг онгоц далайн гүнд живэх аюул тулгарсан үед Г.Маркони шинэ нээлтийн аугаа ач холбогдол бүрэн дүүрэн илэрсэн билээ. Тус хөлөг онгоцноос аюул учирсан тухай радио дохиог цацсанаар ойролцоо явсан олон усан хөлөг онгоц туслахаар очиж зургаан хүнээс бусад бүх хүний амь насыг аварч чаджээ.

1909 онд Г.Маркони Нобелийн шагнал хүртэж дараа жил нь Ирландиас Аргентин улс руу зургаан мянга гаруй бээр зайд радио дохио дамжуулж дэлхий нийтийг дахин бишрүүлжээ.

Дээр дурдсан бүх радио мэдээллийг Морзегийн цагаан толгойн үсгүүдээр дамжуулж байв. Гэхдээ радиогоор хүний дуу хоолойг дамжуулах бололцоотой нь илт мэдэгдэж байсан ч 1906 онд л анх удаа хүний дуу хоолойг радиогоор дамжуулсан байна.



Арилжаа наймааны зорилгоор радио мэдээллийг ашиглах явдал хорьдугаар зууны хориод оноос улам идэвхжээ.

Алдар нэр нь дэлхий даяар түгсэн Г.Маркони амьдралынхаа сүүлийн жилүүдэд богино болон хэт богино долгионы холбооны талаар судалгаа хийж байгаад 1937 онд Ром хотод өөд болжээ.

Г.Маркони радио зохион бүтээгчийн хувьд дэлхийн түүхэнд үзүүлсэн нөлөө нь асар их билээ. Зурагт радиог зохион бүтээгээгүй ч зурагт радио бий болох үндэс суурийг бас тавьсан гэж зүй ёсоор тооцдог юм. Утасгүй холбоо нь орчин үеийн ертөнцөд маш их ач холбогдолтой байна.

Утасгүй холбоог мэдээ дэмжуулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, цэргийн, шинжлэх ухааны, цагдаагийн зориулалтаар гээд нийгмийн амьдралын олон салбарт өргөн дэлгэр ашиглаж байна. Ихэнх тохиолдолд радиогоос хагас зуун жилийн өмнө зохиогдсон телеграфыг мөн өргөн ашиглаж байгаа ч радиогийн ач тус хэмжээлшгүй юм. Радиогийн дохио хээр талын замд яваа машин, тэнгист хөвж байгаа усан онгоц, тэнгэрт нисэж байгаа нисэх онгоц тэр ч байтугай сансрын хөлөгт ямар ч саадгүй хүрнэ. Радио нь телефон утаснаас илүү ач тустай, телефон утсаар дамжуулж байгаа мэдээллийг радиогоор дамжуулж болдог бол радио мэдээг телефон утасны шугамгүй бөглүү газар хүртэл хүрнэ.

# 39. Адольф Гитлер

(ADOLF HITLER)

1889-1945



Гучин таван сая хүнийг үхэлд хүргэсэн Адольф Гитлерийг дэлхийн суут хүмүүсийн жагсаалтад оруулах нь гутамшигтай, ёс суртахуунгүй санагдсан ч түүний үйл ажил-лагаа маш олон тооны хүмүүсийн амьдралд ихээхэн нөлөө үзүүлсэн учир аргагүйд тулж түүний тухай хэдэн үг бичлээ.

1889 онд Австрийн Браунау хотод төрж залуудаа зураач болох гээд чадаагүй ч германы үндэсний үзлээр нэвт шингэсэн хүн болон төлөвшжээ. Дэлхийн нэгдүгээр дайны үед германы армид алба хааж зоригтой тулалдаж шархдаж эрэлхэг зоригийн төлөө хоёр медалиар шагнагджээ.

Дэлхийн дайнд Герман улс ялагдсанд Гитлер багтарлаа цухалдаж байж суух газраа олж яддаг байв. 1919 онд гучин настайдаа Мюнхен хотод байрладаг барууны чиглэлийн бяцхан намд элсэв. Удалгүй германы үндэсний-социалист ажилчны нам болон хувирсан тус намд хоёр жилийн дотор өндөр нэр хүнд олж удирдагч нь болж чаджээ. Түүний удирдлага дор тус нам улам бэхжиж 1923 оны 11 дүгээр сард "Мюнхений шар айрагны хуйвалдаан" гэгч нэртэй төрийн эргэлт хийхийг оролджээ. Гитлер баривчлагдаж шоронд орсон ч жил бололгүй суллагджээ.

1928 онд нацист нам ямар ч нөлөөгүй байсан ч дэлхий дахиныг нөмөрсөн их хямралын үед олон түмний улс төрийн намуудад итгэх итгэл буурсан үед нацистууд улам хүчирхэгжиж Гитлер 1933 оны нэгдүгээр сард 44 насандаа Германы канцлераар томилогджээ. Засгийн газрын тэргүүний өндөр албанд очмогц аливаа эсэргүүцлийг дарж ганцаар захирах дэглэмийг тогтоов. Улс төрийн өрсөлдөгч нараа бараг цөмийг нь устгаж харгислал үйлдсэн ч ажилгүйдлийн түвшинг бууруулж эдийн засгийг сэргээж чадсан учир улс орныхоо дийлэнх иргэдийн талархлыг хүлээж байв.

Гитлер хөрш зэргэлдээ орнуудыг эзлэн түрэмгийлэх бодлого явуулснаар дэлхийн хоёрдугаар дайныг өдөөв. Англи, Франц зэрэг европийн том орнууд эдийн засгийн хурц асуудалтай тулгарч энх амгаланг хүсэж байсан болохоор Гитлерийг Версалийн гэрээг зөрчиж германы армийг сэргээж 1936 оны гуравдугаар сард Рейн мужийг эзлэн Австри улсыг 1938 онд Германд хүчээр нэгтгэж 1938 оны есдүгээр сард Чехословакийн хилийн Судет мужийг довлоход саад хийсэнгүй.

Мюнхений гэрээ гэж түүхэнд орсон олон улсын гэрээг ашиглан Гитлер Чехословак улсыг бүхэлд нь эзлэв. Англи, Франц улсууд Гитлерийн дараагийн зорилго болох Польшийг халдан довлоход эсэргүүцэн тэмцэхээр болов. Гэтэл Гитлер Орос улстай 1939 онд харилцан үл довтолох тухай гэрээ байгуулж 9 хоногийн дараа Польшид халдан довтолжээ. 16 өдрийн дараа дайсны эсрэг ор ганцаараа зогссон Польш дийлдчихээд байхад зөвлөлтийн цэрэг сая Польшид мөн нэвтэрч дорнод мужуудыг нь эзэлжээ.

Гитлер 1940 онд эхлээд Дани, Норвег дараа нь Бельги, Голланд, Люксембургийг дайрч зургаадугаар сард Францийг буулган авав. Мөн сараас Гитлер Англи улс руу агаарын довтолгоон хийж эхэлсэн ч тус улсыг эзлэж чадаагүй юм. 1941 оны дөрөвдүгээр сард Грек, Югославыг довтолж зургаадугаар сард харилцан үл довтолох гэрээг зөрчин Оросод халдав. Нацистын арми зөвлөлтийн асар удам нутгийг эзлэж чадсан ч өвлөөс өмнө зөвлөлтийн цэргийг устгаж дийлсэнгүй.

Гитлер 1941 оны 12 дугаар сард АНУ-д дайн зарлажээ.

1942 оны дунд үед гэхэд Гитлер Европ тивд түүхэнд хэнээс ч илүү газар нутгийг захирдаг болсон байв. Гэвч 1942 оны хоёрдугаар хагаст нацистын арми Оросод Сталинград хотын дэргэд, Египетэд Эль-Аламейний ойролцоо болсон шийдвэрлэх тулалдаануудад ялагдлаа. Тэр үеэс ялагдал хүлээх нь тодорхой болсон ч Гитлер бууж өгөхийг хүссэнгүй. 1945 оны хавар нацистын дэглэм унаж дөрөвдүгээр сарын 30-ны өдөр Гитлер амиа хорложээ.

Засгийн эрх барих хугацаандаа түүхэнд байгаагүй аймаглан устгах үйл ажиллагаа явуулсан юм. Еврейчүүдийг үзэн ядаж дэлхийн бүх еврейчүүдийг устгах зорилгыг төрийн бодлого болгон явуулж хэдхэн жилийн хугацаанд зургаан сая гаруй еврей иргэдийг устгасан. Нацистын дэглэмийн үед орос, польш, цыган зэрэг "дутуу төрсөн" үндэстнүүдийн олон сая иргэдийг мөн хайр найргүй устгаж байлаа. Эзлэгдсэн нутаг бүртээ бөөнөөр хорих шоронгууд олноор байгуулж хорт хийгээр ямар ч гэм зэмгүй иргэдийг түүний дотор эмэгтэйчүүд, хүүхдүүдийг алж байлаа. Бөөнөөр хорих шоронгуудыг аж үйлдвэрийн том үйлдвэрүүд шиг ажиллуулж алж байгаа хүмүүсийн тоог нямбай хөтөлж алтан шүд, хуримын бөгж зэрэг үнэт эдлэлийг хурааж авдаг байлаа.

А.Гитлер бол хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн аймшигт алуурчин юм. Түүнээс гадна хүн төрөлхтөний түүхэнд хамгийн өргөн далайцтай болсон дэлхийн хоёрдугаар дайныг өдөөсөн юм. Түүний хувийн амьдрал нь нэн өвөрмөц хачин байжээ. Австри улсад төрсөн, Германд бол гадаадын иргэн болох Гитлер улс төрийн үйл ажиллагааны ямар ч туршлагагүй, хөрөнгө мөнгөгүй, дээдсийн хүрээлэлд ямар ч хэлхээ холбоогүй байсан мөртөө 14-хөн жилийн дотор дэлхийн томоохон гүрний удирдагч болж чадсан нь хачирхалтай. Хосгүй уран илтгэгч байсны хувьд олон түмнийг шийдвэрлэг үйл ажиллагаанд чиглүүлэн зоригжуулж чадаж

байжээ.

Цаг үеийнхээ хүмүүст Гитлер шиг гайтай нөлөө үзүүлсэн улс төрийн зүтгэлтэн хүн төрөлхтөний түүхэнд бараг байхгүй биз ээ. Гитлерийн дэглэм хэдэн арван сая хүний амь насыг бүрэлгэснээс гадна олон сая хүнийг орох оронгүй оочих аягагүй болгож хэдэн арван сая хүмүүсийн хувь заяагаар тоглосон юм.

Коммунист дэглэмийн ноёрхолд Маркс, Ленин, Сталин гээд олон удирдагчид зохих ёсоор үүрэг гүйцэтгэж байсан бол үндэсний-социалист хөдөлгөөнд Гитлерээс өөр удирдагч байгаагүй. Түүнийг нас бармагц түүний удирдсан нацист нам, засгийн газар бүрмөсөн унасан юм. Гитлер засгийн эрх барьж байх хугацаандаа Герман улсын газар нутгийг өргөжүүлэх, нөлөөг нэмэгдүүлэх зорилго тавьж тодорхой амжилтад хүрсэн ч үр дүн нь түр зуурынх байсан юм.

Өнөөдөр Герман улсын нутаг дэвсгэрийн хэмжээ Гитлерийн үеийнхээс бага байна. Гитлер насан туршаа еврейчүүдийг толгой дараалан устгах зорилго тавьж байсан ч түүнийг өөд болсноос хойш 15 жилийн дараа хоёр мянган жилийн түүхэндээ еврейчүүдийн анхны бие даасан тусгаар тогтносон улс бий болсон билээ. Гитлер коммунист үзэл, Зөвлөлт гүрнийг үзэн яддаг байтал түүний өдөөсөн дэлхийн хоёрдугаар дайны дараа коммунизмын үзэл бодол Дорнод Европийн олон оронд нэвтэрч дэлхий даяар улам өргөн тархсан юм. Гитлер ардчиллыг үзэн ядаж түүнийг ор үндсээр нь арилгахыг хүсэж байсан боловч өнөөдөр германы ард түмэн ардчилсан нийгэмд аж төрж байна.

# 40. Платон

(PLATO)

Манай эриний өтнөх 427- 347



Эртний грекийн гүн ухаантан Платон нь өрнөдийн улс төрийн гүн ухаан төдийгүй гоо зүй, метафизик сэтгэлгээний эх суурийг тавьсан билээ. Түүний дэвшүүлсэн таамаглалуудыг бараг 2300 жил уншиж судалж байгаа болохоор түүнийг өрнөдийн аугаа сэтгэгчдийн сор гэж зүй ёсоор үздэг юм.

Манай эриний өмнөх 427 жилийн үед афиний язгууртны гэр бүлд төрж идэр залуудаа алдарт гүн ухаантан Сократтай танилцаж түүний анд нөхөр багш болжээ. Гэтэл манай эриний өмнөх 399 онд Сократыг далан настайд нь афиний залуучуудыг эс тоосон хэргээр буруушаан шийтгэж цаазаар авсанд Платон их зэвүүцжээ.

"Миний мэдэх хамгийн ухаантай, хамгийн шудрага хүнийг" цааш харуулснаараа "ардчилсан" хэмээх төр үнэн нүүр царайгаа харууллаа гэж Платон буруушааж төдөлгүй Афин хотыг орхиж бараг арваад жилийг хэрэн тэнэж өнгөрөөжээ. Манай эриний өмнөх 387 оны үед Афин хотод буцан ирж сургууль болон бараг 99 гаруй жил үйл ажиллагаагаа явуулсан Академийг санаачлан байгуулжээ. Багшлахын зэрэгцээ гүн ухааны бүтээлүүд туурвилаа Платоныг жаран настай байхад нь Академид нь 17 настайдаа элссэн Аристотель түүний хамгийн нэртэй шавь болсон юм.

Амьдралынхаа туршид голдуу улс төр, гоо зүйн асуудлаар тэрчилэн метафизик, шашны асуудлаар 36 ном бичиж хэвлүүлжээ. Эдгээр зохиолуудын агуулгыг дэлгэрэнгүй дурдах боломжгүй тул боловсронгуй нийгмийн тухай үндсэн гол санаануудаа тусгасан алдарт "Бүгд найрамдах улс" номынх нь улс төрийн гол үзэл бодлыг товчхон өгүүлье.

Засгийн газруудын шилдэг нь язгууртнууд удирдсан төр юм гэж Платон үздэг байв. Язгууртнууд гэдэг нь үе дамжсан язгууртан, хаад ноёд биш чухамдаа төрийг удирдах шилдэг ухаантай хүмүүс буюу хүний шилдэг чанаруудыг шингээсэн язгууртнууд юм. Эдгээр

язгууртнуудыг сонгох биш дахин сонголтыг үр дүнгээр гаргаж ирнэ. Засгийн газрын гишүүд буюу дээд ангийн төлөөлөгчид болсон язгууртнууд нэмэгдэл гишүүдийг хүн чанарын шалгуураар сонгон авч эгнээгээ байнга өргөжүүлнэ.

Эрэгтэй, эмэгтэй гээд бүх хүмүүст дээд ангийн гишүүн болох авьяас чадвараа харуулах бололцоог олгох ёстой гэж Платон үздэг байлаа. (Энэ утгаараа Платон бол эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байх ёстой гэсэн зарчмыг санал болгосон анхны гүн ухаантан болсон билээ.) Иймд нийгмийн бүх гишүүдэд авьяас чадвараа гаргах бололцоог нээж өгөхийн тулд тухайн улсын бүх хүүхдүүдэд сайн хүмүүжил, тодорхой боловсрол олгох хэрэгтэй, хүүхдүүдэд юуны өмнө бие бялдын хувьд сайн хүмүүжил олгоно, гэхдээ хөгжим, математик, бусад сонгодог мэдлэгийг эс хайхарч үл болно гэж Платон шаардаж байв. Хүмүүжил сургалтын бүх үе шатанд нарийн шалгалт явуулж шалгалтыг дийлээгүй хүүхдүүд нь нийгэмд эдийн засгийн үйл ажиллагаа явуулж шалгалтад тэнцсэн нь цаашаа үргэлжлүүлэн суралцана. Хүүхдүүдэд нэмэгдэл боловсрол болгож боловсронгуй хэлбэрүүдийн метафизик онол гэж ойлгодог гүн ухааны мэдлэг олгох нь зүйтэй гэж Платон үзэж байлаа.

35 настайдаа онолын асуудлаар ур чадвараа үнэмшилтэй харуулсан залууст практик ажлаас бүрдсэн нэмэгдэл 15 жилийн боловсрол олгоно. Авьяас чадвараараа олж авсан онолын мэдлэгээ бодит амьдралд үзүүлж чадсан хүн л сая дээд ангийн хүрээлэлд орох ёстой. Хамгийн гол нь дээд ангийн хүрээлэлд орох хүн амьдарч буй нийгмээ цэцэглүүлэн хөгжүүлэх сонирхолтой хүн байх ёстой.

Дээд ангийн хүрээллийн гишүүд нь бүх иргэдээс онцгой ялгарах шаардлагагүй, баян байж болохгүй, өчүүхэн эд хөрөнгөтэй, хувьдаа газар, байшинтай байх ёсгүй. Тэд нарийн тогтоосон бага хэмжээний цалин авна, алт мөнгөн эдлэл худалдан авч болохгүй, дээд ангийн хүрээллийн хүмүүс гэр бүлтэй байж болохгүй, эрэгтэй эмэгтэй гишүүд цөмөөрөө хамт хооллож байна. Дээд ангийн хүрээллийн хүмүүсийн нандин зорилго нь ард түмэндээ үйлчлэх явдал юм.

"Бүгд найрамдах улс" номыг хэдэн зууны турш уншин судалж байсан юм. Энэ номд дэвшүүлэн тавьсан улс төрийн тогтолцоог тухайн үед оршин тогтнож байсан ганц ч иргэний улсад хэрэглэж байгаагүй билээ. Платон болон манай үеийн хооронд европийн дийлэнх орнуудад эрх мэдлээ үе дамжуулан шилжүүлдэг хаад удирдан захирч байсан бөгөөд сүүлийн хэдэн зуунд л зарим оронд төрийн ардчилсан дэглэм ноёрхож байгаа билээ. Түүнчилэн Гитлер, Муссолини гэх зэрэг дайнч хүмүүсийн захирч байсан цэргийн дэглэмт орнууд бас байсан. Төрийн удирдлагын эдгээр олон хэлбэрээс ганц нь ч Платоны "Бүгд найрамдах улс" номондоо дэвшүүлсэн ардчилсан төрийн хэлбэртэй адилхан байгаагүй.

Гэхдээ дундад зууны үеийн европийн католик шашны сүм хийд, Платоны дээд ангийн хүрээлэл хоорондоо маш адилхан байсан юм. Дундад зууны үеийн сүм хийд нь албан ёсны гүн ухааны мэдлэг бүхий бараг өөрчлөгддөггүй дээд тушаалын гишүүдээс бүрддэг байсан. Гэхдээ ямар ч эрэгтэй хүн гарал үүслээс хамаарахгүй лам болж болно гэж сурталчилдаг байв. Шашны зүтгэлтнүүд эхнэр авах эрхгүй байсан нь хувийн амьдралаа биш чухамдаа шашны үйл ажиллагаандаа бүх амьдралаа зориулах ёстой гэсэн далд утга агуулж байжээ.

АНУ-ын Үндсэн хуулийн зөвлөлийн дийлэнх гишүүд Платоны үзэл санааг мэддэг байсан тул

АНУ-ын засгийн газрын бүтцийг бий болгоход ашигласан юм. АНУ-ын Үндсэн хууль нь ард түмний хүсэл зоригийг ил гаргаж түүнд нөлөө үзүүлэх аргуудыг хангах үүрэгтэй ч улс орныг удирдахад хамгийн ухаантай, хамгийн шилдэг хүмүүсийг сонгох агуулгатай байсан нь юм.

Ер нь Платоны үйл ажиллагааны ач холбогдлыг үнэлэхэд түүний үзэл санааг мянга гаруй жилийн хугацаанд газар сайгүй өргөн дэлгэр судалж маргалдаж байсан ч нөлөө нь үнэхээр шууд биш байсан юм. Платоны гоо зүй, метафизикийн талаар дэвшүүлж тавьсан үзэл бодлыг олон ухаантнууд хүлээн зөвшөөрч ягштал баримталж тууштай хамгаалан баяжуулж ирсэн билээ.

Платоны үзэл бодол нийтдээ 23 зууны турш хүн төрөлхтөний гүн ухааны сэтгэлгээний ноён оргил болсоор байна.

# 41. Оливер Кромвель

(OLIVER CROMWELL)

1599 -1658



Англи улсад болсон иргэний дайны үед парламентын талыг дэмжигч хүчнүүдийг ялалтад хүргэж парламентын ардчиллыг Англи улсад төрийн удирдлагын хэлбэр болгосон гол гавьяа цэргийн авьяаслаг жанжин Оливер Кромвельд ногддог юм.

Шашин хоорондын мөргөлдөөн тасардаггүй, хаант ёсыг эх орондоо тогтоосон хааны хэмжээгүй эрхт засаглал ноёрхсон Англи улсын Харлингтон хотод 1599 онд төрж хаант ёсыг эсэргүүцэгч хөдөөгийн сэхээтэн болон төлөвшжээ. Фермерийн аж ахуйн эзэн байхдаа 1628 онд парламентын гишүүнээр сонгогдсон ч дараа жил нь нэгдүгээр Карл хаан парламентыг тарааж төрийг дангаараа захирах болсон тул нутагтаа буцан ирж мөн аж ахуй эрхлэж байв.

Гэвч нэгдүгээр Карл хаан Шотландтай хийх дайнд хөрөнгө мөнгө хэрэгтэй болсон тул 1640 онд шинэ парламент байгуулав. О.Кромвелийн бас гишүүнээр нь сонгогдсон шинэ парламент хааны дарангуйлагч засаглалыг сэргээхгүй байх баталгааг хаанаас шаардав. Гэтэл хаан тийм шийдвэр гаргахаас эрс татгалзсан тул 1642 онд хааны болон парламентын талыг баримтлагчдын хооронд дайн дэгдэв.

Парламентыг талыг дэмжигч О.Кромвель төрөлх Харлингтон хотод буцан ирээд морин цэргийн анги эмхлэн байгуулав. Хааны эсрэг хийсэн дөрвөн жилийн дайны хугацаанд түүний цэргийн жанжны авьяас тодорч олон түмний хүндэтгэл хайрыг хүлээжээ. 1644 оны долоодугаар сарын 2-нд Марстон Мур, 1645 оны зургаадугаар сарын 14-нд Несбийн дэргэд болсон шийдвэрлэх тулалдаанд парламентын талынхны армийг удирдаж ялалтанд хүргэж нэгдүгээр Карл хааныг баривчлан шоронд хорьжээ.



Гэтэл ялалт байгуулсны дараа парламентын хүчнийхэн шал өөр зорилготой хоёр жигүүр болон хуваагдаж хоорондоо тэмцэлдэх болж түүнийг далимдуулан хаан шийтгэлээс мултарчээ. Байдал улам хурцадсаар жилийн дараа хоёр дахь удаагаа иргэний дайн дэгдэж шоронгоос суллагдсан хаан цэргийн хүч хуралдуулж эхлэв. О.Кромвель парламентын талынхны армийг дахин чадамгай удирдан хааны цэргийг бут цохиж парламентаас хуучинсаг үзэлтэй гишүүдийг нь хөөж дараа нь хааныг цаазлажээ.

Энэ үеэс Хамтын нөхөрлөлийн орон гэж нэрлэгдэх болсон Англи орныг Бүгд найрамдах улс гэж зарлан тунхаглаж тус орныг захирах Төрийн түр зөвлөл байгуулж О.Кромвелийг даргаар нь сонгожээ. Тэгтэл хааны талынхан Ирланд, Шотландад засгийн эрхийг хүчээр булаан авч цаазлагдсан хааны хүү, ирээдүйн хоёрдугаар Карл хаанд дэмжлэг үзүүлэх болов. О.Кромвель дахин армиа удирдаж Ирланд, Шотландыг довтлон эзэлж 1652 онд хааны цэргийг бүрмөсөн бут ниргэжээ.

Үүний дараа шинэ засгийн газар байгуулсан ч төрийн удирдлагын парламентын хэлбэрийг Үндсэн хуулиар баталгаажуулах ажил нь урагш ахисангүй. Шашны маргаанаас болж үнэн алдартны болон католик шашинтнууд хоорондын тэмцэл улам хурцдаж нэгдсэн тохиролцоонд хүрч чадаагүй учраас Шинэ Үндсэн хууль батлах чухал үйл ажиллагаагаа О.Кромвел амьддаа бүрэн дүүрэн дуусгаж чадаагүй юм.

О.Кромвелийг шинэ засгийн газар эмхлэн байгуулах үед 1640 оны Удаан гэж нэрлэгдсэн парламентад хэдхэн гишүүн амьд үлдсэн байв. Иймд шинэ сонгууль явуулах талаар ихээхэн хүчин чармайлт тавьж удтал хэлэлцээ хийсэн ч үр дүнд хүрсэнгүй тул 1653 онд Удаан парламентыг хүчээр тараажээ. Тэр үеэс О.Кромвелийг өөд болсон 1658 онд хүртэл гурван удаа парламент байгуулагдаж хоёр удаа Үндсэн хууль батлагдсан ч аль нь ч бүрэн дүүрэн хэрэгжээгүй билээ. Энэ хугацаанд О.Кромвель улс орноо цэргийн хүчээр удирдаж байсан юм. Гэхдээ улс орондоо ардчилсан дэглэм тогтоохын төлөө олон удаагийн оролдлого хийж хаанаар өргөмжлөх гэхэд нь татгалзаж байсан удаатай тул түүнийг цэргийн дарангуйлагч болох гэж мөрөөдөж байсан гэх ямар ч үндэслэлгүй юм.

1653-1658 онуудад Англи, Шотланд, Ирланд улсуудыг бүхэлд нь захирч биечлэн засгийн газар байгуулж таван жил гаруй улс орноо муугүй удирдаж төв болон орон нутгуудад засаг захиргааг эмхлэн байгуулж олон хууль тогтоомжийг шинэ нөхцөл байдал тохируулан шинэчилж боловсролын салбарт дорвитой өөрчлөлт хийжээ. Тэрчилэн шашны үзэл бодлоор хүнийг ялгаварлан гадуурхахыг буруушааж гурван зуун жилийн өмнө нэгдүгээр Эдуард хааны хөөж туусан еврейчүүдэд Англи улсад сууршиж үндэсний шашнаа шүтэх бололцоог олгосон юм. Мөн гадаад бодлогын салбарт их ахиц гаргажээ.

1658 онд хумхаа өвчнөөр нас барахад ууган хүү Ричард нь оронд томилогдсон ч 1660 онд хаант ёсыг сэргээж хоёрдугаар Карлыг хаанаар өргөмжилжээ. О.Кромвелийн шарилыг ухан гаргаж олны өмнө доромжилсон ч тус улсад хэмжээгүй эрхт хааны засаглалыг сэргээх ямар ч бололцоогүй болсныг хоёрдугаар Карл хаан ойлгож улс орныг захирч байгаа парламенттай огт тэрсэлдээгүй юм. Харин түүний дараа хаанаар тодорсон нэгдүгээр Яков хаант ёсыг сэргээх гэж оролдоод 1688 оны цуст хувьсгалаар зайлуулагдсан билээ. Чухамдаа Англи орон 1688 онд парламентад бүрэн захирагдсан хэмжээт эрхт хаант засагтай, шашны үзэл бодлоор хүнийг ялгаварлан гадуурхдаггүй улс болж О.Кромвелийн мөрөөдөл биелсэн билээ.

Гурван зуун жилийн турш английн улс төрийн нэрт зүтгэлтэн О.Кромвелийн тухай маргаан дуусахгүй үргэлжилсээр байна. Парламентын засаглалыг дэмжиж хаант ёсыг эсэргүүцэж байсан ч цэргийн засаглалыг тогтоосон гэж түүнийг буруушаасаар байна. Гэхдээ О.Кромвель ардчилсан дэглэмийг тууштай мөрөөдөгч түүний төлөө зоригтой тэмцэгч байсан бөгөөд тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан харгис арга хэмжээ авч байсан нь үнэн билээ. Түүний удирдсан засгийн газар аливаа асуудалд хүлээцтэй ханддаг, олон түмний төлөө эрс тэс биш чухамдаа аядуу зөөлөн бодлого явуулж байсан юм.


О.Кромвель нь эх орондоо болсон иргэний дайнд хааны ёсыг хамгаалагчдын армийг ялсан цэргийн том жанжин юм. Олон удаагийн амь өрссөн байлдаанд түүний байгуулсан ялалтын үр дүнд Англи улсад ардчилсан төрийн дэглэм тогтож бэхэжсэн билээ.

ХҮ11 зуун үед европийн дийлэнх орон хаант ёсыг бэхжүүлэх хандлагатай байсан үед О.Кромвель Англи улсад ардчилсан дэглэмийн төлөө тууштай тэмцэж түүхийн хүрдийг өөрчилсөн гавьяатай юм. Английн ардчиллын үлгэр жишээ хожим нь Францийн Соён гэгээрэлт, Францийн их хувьсгал дараа нь Өрнөд Европт ардчилсан засаглал эгнэгт тогтоход маш чухал хүчин зүйл болсон билээ. Англи улсад төрийн ардчилсан дэглэмийн төлөө тэмцэл ялсан нь АНУ болон Английн хараат улс байсан Канад, Австрали орнуудад ардчилал ялахад ихээхэн түлхэц өгсөн юм.

# 42. Александр Грэхем Белл

(ALEXANDER GRAHAM BELL)

1847-1922



Телефон утсыг анх зохион бүтээгч алдарт эрдэмтэн А.Г.Белл Шотландын Эдинбург хотод 1847 онд төрж дунд сургуульд хэдхэн жил суралцсан ч гэрийн өндөр боловсрол эзэмшжээ. Хамар хоолойн эмчийн мэргэжилтэй эцэг нь дүлий хүмүүсийг бичиг үсэгт сургах ажил эрхэлдэг байсан тул залуу Белл аль багаасаа хүний хоолойг дууриах дуртай байжээ.

1871 онд А.Г.Белл АНУ-ын Массачусетс муж улсын Бостон хотод шилжин сууршиж 1875 онд хэд хэдэн нээлт хийсэн нь телефон бүтээхэд хүргэжээ. 1876 онд шинэ нээлтийнхээ патент авах өргөдлөө бичиж өгчээ. Хамгийн сонирхолтой нь, Элиша Грей гадэг хүн түүнээс яг нэг цагийн дараа мөн яриа дамжуулдаг төхөөрөмж хийсэн патент авах өргөдөл бичиж өгч байжээ.

А.Г.Белл патент авсныхаа дараа Филадельф хотод нээгдсэн "Зуун жилийн үзэсгэлэн"-д телефон утсаа тавьж үзүүлэхэд олон хүн шохоорхож үзэсгэлэнгийн шагнал хүртжээ. Гэтэл уг төхөөрөмжийг үйлдвэрлэх эрхийг худалдан авахаар 100 мянган ам.долларын гэрээ байгуулахаар тохиролцсон "Вестерн Юнион Телеграф Компани" өгсөн амлалтаасаа буцжээ. Гэсэн ч сэтгэлээр унасангүй хэсэг хамтран зүтгэгчидтэйгээ нийлж 1877 оны долоодугаар сард өнөөгийн "Америкен Телефон энд Телеграф Компани"-йн эх суурь болох бяцхан компанийг байгуулж удалгүй асар их ашиг олжээ.

Байгуулсан компанийхаа нийт хувьцааны 15 хувийг эхнэрийнхээ хамт эзэмшдэг Белл үйлдвэртээ асар их орлого олох санаа сэдэж долоон сарын хугацаанд хувьцааныхаа дийлэнх хэсгийг ширхэг бүрийг нь дунджаар 250 ам.доллараар худалджээ. Гэтэл 11 дүгээр сар гэхэд хувьцааны үнэ нь 1000 ам.долларт хүртэл өсчээ. Тэд 1881 онд үлдсэн хувьцааныхаа гуравны нэгийг ашиг багатай арилжаалсан ч гэсэн 1883 онд нэг саяар хэмжигдэх хөрөнгөтэй болсон байлаа.

А.Г.Белл телефон бүтээж баян болсон ч судалгааны ажлаа үргэлжлүүлж дахин хэд хэдэн чухал шинэ нээлт хийсэн юм. Гэхдээ дүлий хүмүүст туслахаа амьдралынхаа гол зорилгоо гэж үздэг байсан юм. Дүлий эхнэрээ сонсголтой болгох гэж нилээд их зүйл хийжээ. Дөрвөн хүүхэдтэй байснаас хоёр нь багадаа нас баржээ. 1882 онд АНУ-ын иргэн болж 1922 онд ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ.

А.Г.Белл телефон утас зохион бүтээснээрээ хүн төрөлхтөний өдөр тутмын амьдралд маш их нөлөө үзүүлснийг хэн ч үгүйсгэж чадахгүй нь мэдээж билээ.

# 43. Александр Флеминг

(ALEXANDER FLEMING)

1881-1955



Пенициллинийг анх нээсэн цуут эрдэмтэн А.Флеминг 1881 онд Шотландын Лочфилд хотод төрж Лондон хот дахь Гэгээн Мариагийн эмнэлгийн дэргэдэх эмнэлгийн сургууль төгсөж хүний өвчин эсэргүүцэх чадварыг судлах туршилт хийж эхэлжээ.

Хожмоо цэргийн эмч болж дэлхийн нэгдүгээр дайнд хээрийн эмчээр оролцож шархны улмаас үүсэж байгаа халдварыг судалж байхдаа халдваргүйтэлийн зориулалттай олонхи эм нь нянгаас илүү хүний бие бялдрын эсүүдэд хор хөнөөлтэй байгааг ажиглажээ. Тэгээд нян устгахдаа хүний эсүүдэд ямар ч хор хөнөөл үзүүлдэггүй ямар нэгэн бодис олох хэрэгтэй юм байна гэдгийг ухаарчээ.

Дайны дараа Гэгээн Мариагийн эмнэлэгтээ буцан ирж туршилт хийх явцдаа 1922 онд "лилозим" нэртэй бодис нээжээ. Энэхүү бодис нь зарим нянг устгадаг ч хүний биед илүү хор уршигтай нянгуудыг устгаж чадахгүй байв. Гэвч А.Флеминг гайхамшигт нээлтээ 1928 онд хийсэн билээ.

Лабораторийн туршилтын үед агаарт тавьсан стафилококкийн нян хөгцөрч хамгийн гол нь эргэн тойронд байсан бодисууд нь түүний нөлөөгөөр мөн хөгцөрч байгааг эрдэмтний билгийн нүдээр ажиглаж хөгц нь стафилокогийн нянгийн хувьд хортой ямар нэг бодис ялгаруулж байна гэсэн дүгнэлт хийжээ. Туршилтаа үргэлжлүүлж энэхүү бодис нь олон хорт бодисуудын тархалтыг саатуулж байгааг нотлов. Хөгцийг (*penicillium notatum*) билэгдэж пенициллин гэж нэрлэсэн энэ бодис нь хүн болон амьтны алинд ч ямар ч хортой нөлөөгүй байлаа.

А.Флеминг судалгааны дүнгээ 1929 онд нийтлүүлсэн ч олон нийтийн анхаарлыг татсангүй. Хамгийн гол нь пенициллинийг үйлдвэрлэх технологийг зохион бүтээж чадахгүй байсан учраас хүн төрөлхтөнд тустай энэхүү гайхамшигт эмийг бараг арваад жил хэрэглэхгүй байсан нь үнэхээр харамсалтай.

Гэвч гучаад оны сүүлчээр английн эмч судлаач Говард Уолтер Флори, Эрнст Борис Чейн хоёр А.Флемингийн судалгааг санамсаргүй уншаад туршилтыг нь давгаж пенициллин гарган аваад эхлээд амьтад дээр дараа нь 1941 онд өвчтэй хүмүүс дээр туршихад үнэхээр хүчтэй маш

чухал эм болох нь дахин нотлогджээ.

Английн болон АНУ-ын засгийн газрын санаачилгаар эмийн үйлдвэрүүд пенициллин үйлдвэрлэх болж удсангүй ихээхэн хэмжээгээр үйлдвэрлэх аргыг олжээ. Пенициллийн анхандаа дайны үед армид хэрэглэж байснаа 1944 оноос Англи, АНУ-ын энгийн хүн амын дотор хэрэглэх болжээ. Дайны дараа пенициллинийг дэлхий даяар хэрэглэх болжээ.

Пенициллин бий болсноор өвчин эсэргүүцэгч өөр бодис эрэх судалгааны ажил шинэ шатанд гарч олон гайхамшигт эм бий болсон билээ. Пенициллин нь маш олон хортой бичил биетийн эсрэг тэмцэхэд маш их үр дүнтэй эм байлаа. Пенициллинийг тэмбүү, улаан эсэргэнэ, хий ханиалгах, цус халдварлах, үү, уушигны үрэвсэл, гал халдвар зэрэг олон өвчнийг эмчлэхэд ашиглаж байна.

Хүний биед ямар ч аюулгүй байдаг нь пенициллиний бас нэг сайн тал юм. 50 мянган нэгж пенициллин нь нилээд олон халдварт өвчнийг эмчлэхэд үр дүнтэй байдаг бөгөөд 100 мянган нэгжийг өдөр тутам хэрэглэхэд ч хүний биед ямар ч хор хөнөөлгүй байдаг.


Ийнхүү пенициллин нь олон сая хүний амь насыг аварсан, одоо ч аварсаар байна, хойшид ч аварсаар байх нь мэдээж юм.

А.Флеминг гэр бүлийн хувьд аз жаргалтай байсан бөгөөд 1945 онд Флори, Чейни нарын хамт Нобелийн шагнал хүртэж байлаа.

# 44. Жон Локк

(JOHN LOCKE)

1632-1704



Английн алдарт гүн ухаантан Жон Локк бол үндсэн хуульт ардчиллын гол үзэл санааг тодорхой хэлбэрт оруулсан анхны зохиолч билээ. Түүний дэвшүүлсэн үзэл санаа АНУ-ын Үндсэн хуулийг зохиогчид, Францийн Сэргээн мандалтын үеийн тэргүүлэх гүн ухаантнуудад хосгүй их нөлөө үзүүлсэн юм.

1632 онд Английн Урингтон хотод төрж Оксфордын их сургуульд суралцаж 1656 онд бакалаврын 1658 онд магистрын зэрэг авчээ. Идэр залуугаасаа шинжлэх ухаан сонирхож 36 насандаа хааны Шинжлэх ухааны нийгэмлэгт гишүүнээр сонгогдож анагаах ухааны магистрын зэрэг хүртэж явжээ.

Алдарт физикч Роберт Бойл, Исаак Ньютон нартай үерхэж байжээ. Улс төрийн чөлөөт үзэл бодлыг баримтлагч, улс төрийн үйл ажиллагааны төлөө Францийн хоёрдугаар Карл хааны үед шоронд сууж байсан гүн Шафтсберитэй Париж хотод танилцсан нь түүний амьдралд эргэлтийн үе болжээ. Гүн Шафтсбери 1682 онд Голланд руу зугтсан ч дараа жил нь нас баржээ. Түүний үзэл санааг хуваалцдаг болсон Ж.Локк баривчлагдах аюул заналхийлж байгааг мэдэрмэгц мөн Голланд улс руу оргож Францийн хоёрдугаар Карл хааныг залгамжлагч, ууган хүү Яковыг нь 1688 оны хувьсгалаар хаан ширээнээс хүчээр зайлуулах хүртэл тэндээ суужээ.

1689 онд эх орондоо эргэн ирж 1704 онд нас бартлаа Лондон хотод амьдарчээ. Амьдралдаа ганц ч удаа гэрлэсэнгүй ажээ.

Ж.Локк 1690 онд хүний таних мэдэхүйн үүсэл, мөн чанар, боломж хязгаарын тухай өгүүлсэн "Хүний мөн чанарыг ойлгох эссе" нэртэй номоо гаргаж олны танил болжээ. Үзэл бодолдоо туршилтын зарчмыг баримталдаг байсан бөгөөд Фрэнсис Бэкон, Рене Декарт нарын үзэл бодлын нөлөө энэхүү номонд нь илт мэдрэгддэг юм. Танин мэдэхүйн тухай түүний үзэл бодол хамба лам Ж.Бреккли, Д.Хьюм, И.Кант зэрэг цуутай гүн ухаантнуудад нөлөө

үзүүлснийг маргах аргагүй юм. "Хүний мөн чанарыг ойлгох эссе" ном нь сонгодог гүн ухааны шилдэг бүтээлийн нэг мөн ч хүн төрөлхтөний түүхэнд түүний улс төрийн бүтээлүүдтэй харьцуулбал бага нөлөө үзүүлсэн билээ.

1689 онд нууц нэрээр хэвлүүлсэн "Тэвчих тухай захидал" номонд аливаа төр хүний шүтэн бишрэх эрх чөлөөг хязгаарлаж болохгүй, түүнд тэвчээртэй хандвал зохино гэж бичсэн байв. Ж.Локк бол үнэн алдартны шашин шүтэгчдийг ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг номлосон английн анхны иргэн биш байсан ч шашны эрх чөлөөг хамгаалсан нотолгоо сайтай үндэслэл гаргаж чадсан учир олон түмний дэмжлэгийг хүлээсэн байна. Түүнээс гадна шашин шүтлэгээр нь хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг христос бус шашныг шүтэгчдийн хувьд мөн баримтлахыг сургаж "Лалын болон иудийн шашин шүтэгчид бишрэн шүтдэг шашныхаа улмаас Хамтын нөхөр-лөлийн орны иргэний эрхээ алдах ёсгүй." гэж энэхүү номондоо бичсэн байна.

Гэхдээ Ж.Локк католик шашин шүтэгчид шашингүй үзэлтнүүдийн бус чухамдаа католик шашныг нь өргөн дэлгэрүүлсэн гадаадын хаадын өмнө үүрэг хүлээсэн болохоор тэдэнд шашны үзлээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчим хамаарахгүй гэж номлосон байдаг. Өнөөгийн ойлголтоор бол номлосон зарчмаасаа ухарсан гэж шүүмжилж болох юм, гэхдээ түүний амьдарч байсан цаг үе одоогоос гурван зуу гаруй жилийн тэртээ гэсэн шалтгаанаар түүнийг уучилж болох талтай.

Түүний бас нэг том бүтээл нь үндсэн хуульт либерал ардчиллын тухай гол үзэл санаагаа дэвшүүлсэн "Удирдлагын тухай хоёр номлол" ном билээ. 1689 онд хэвлэгдсэн энэ номын англи хэлт ертөнцөд үзүүлсэн нөлөө асар их юм. Хүн бүр амьдрах төдийгүй хувийн эрх чөлөө эдлэх, өмчтэй байх эрхийг багтаасан зүй ёсны эрх эдлэх ёстой гэж сургаж байв.

Засгийн газрын үүрэг нь иргэдийг төдийгүй тэдний өмчийг хамгаалах явдал юм гэж Ж.Локк нотолж байв. Түүний энэ үзэл бодлыг "шөнийн манаачийн удирдлагын онол" гэж заримдаа нэрлэдэг.

Хаант засаглалыг тэнгэрийн хишиг гэдгийг Ж.Локк эрс буруушааж засгийн газар эрх мэдлийг удирдуулж байгаа хүмүүсийн зөвшөөрлөөр л зөвхөн эдлэх ёстой гэсэн үзэл санааг дэвшүүлсэн юм. "Нийгэмд хүний эдэлж байгаа эрх чөлөө нь Хамтын нөхөрлөлийн орны нийт иргэдийн зөвшөөрснөөс өөр ямар ч хууль тогтоомжийн захиргаадальт дор байхгүй ёсгүй гэсэн утгаар тодорхойлогдоно." гэж "Удирдлагын тухай хоёр номлол" номондоо бичсэн байдаг.

Английн гүн ухаантан Томас Гоббсын (1588-1679) зохиол бүтээлээс авсан нийгмийн гэрээний тухай үзэл санаанд Ж.Локк ихээхэн ач холбогдол өгч байжээ. Гэхдээ Т.Гоббс нийгмийн гэрээний тухай үзэл бодлоо хаант ёсыг зөвтгөх зорилгоор дэвшүүлсэн бол "Хууль тогтоогчид нь хүмүүсийн өмчийг булаан авч сүйтгэж тэднийг хатуу чанга захиргаадальтын дор боол болгон хувиргахыг эрмэлзэх юм бол ард түмэнтэйгээ дайтах болно, ард түмэн нь ч цаашид захиргаадуулахаас чөлөөлөгдөхийн тулд босож хүчирхийллээс оргон зугтсан бүх хүнд Бурханы олгодог нийтээр хоргодох эрхээ эдлэх болно." гэж Ж.Локк үзэж тийм нөхцөлд нийгмийн гэрээг өөрчлөх ёстой гэсэн санааг гаргасан юм.



Энэ номондоо бас "Хууль тогтоогчид нь тэдэнд үзүүлсэн итгэл найдварыг алдсаныг нь илрүүлбэл тэднийг зайлуулах, өөрчлөх дээд эрх иргэдэд байна." гэж бичсэн байна. Хувьсгал хийж эрхээ хамгаалах тухай Ж.Локкийн дээрх үзэл санаа нь Томас Жефферсон зэрэг америкийн хувьсгалчдын үзэл санаанд гүнзгий нөлөөлсөн билээ.

Ж.Локк засаглалын эрх мэдлийг хуваах зарчимд итгэдэг байсан ч хууль тогтоогчид нь гүйцэтгэх засаглалаас дээгүүр байх ёстой гэдгийг мэдэрч байв. Хууль тогтоогчдын давамгайлах эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөг байсан ч гаргасан хууль тогтоомжийг нь үндсэн хуулийн бус гэж тогтоох эрхийг шүүгчид эдлэх ёстой гэж үзэж байжээ.

Ж.Локк олонхийн удирдлагын зарчимд багтай итгэдэг байсан ч засгийн газар хязгааргүй эрх мэдэл эдлэх ёсгүй, олонхийн зүгээс хүмүүсийн зүй ёсны эрхийг хүчирхийлж болохгүй, хүмүүсийн өмч эзэмших эрхийг хасаж халдаж болохгүй, засгийн газар хууль ёсны үндэслэл гаргаж байж тухайн иргэний зөвшөөрснөөр л ямар нэг өмчийг нь хураан авч болно гэж үзэж байлаа. (Энэ үзэл санааг нь АНУ-д "Батлагдаагүй ямар ч татвар авч болохгүй!" гэсэн уриагаар илэрхийлж байсан.)

Дээрх зүйлээс үзэхэд америкийн хувьсгалын бүх гол үзэл санааг уул хувьсгал гарахаас бараг нэг зуун жилийн өмнө Ж.Локк бараг томъёолсон байжээ. Түүний үзэл санаа Т.Жефферсоны үйл ажиллагаанд маш их нөлөө үзүүлсэн. Тэрчилэн түүний үзэл санаа Европ тивд түүний дотор Франц улсад түгэн дэлгэрч Францийн аугаа их хувьсгал, францийн Хүний эрхийн тунхаглалд хүргэсэн тойруу хүчин зүйл болсон гэж үзэж болно.

# 45. Людвиг Ван Бетховен

(LUDWIG VAN BEETHOVEN)

1770-1827



Дэлхийн хамгийн суут хөгжмийн зохиолч Л.Бетховен 1770 онд Германы Бонн хотод төрсөн бөгөөд түүний хөгжмийн гоц авьяас нь аль багад нь тодорчээ. Түүний хэвлүүлсэн хөгжмийн зохиолуудаас хамгийн анхных нь 1783 онд гэж бичигдсэн байдаг. Идэр залуудаа Австрийн Вена хотод очихдоо хөгжмийн их зохиолч Моцарттай танилцсан боловч тэд удтал нөхөрлөөгүй ажээ. 1792 онд Вена хотод дахин ирж тухайн үеийн хамгийн цуутай хөгжмийн зохиолч Гайднын шавь оржээ. Тухайн цаг үед дэлхийн хөгжмийн төв гэж тооцогдож байсан Вена хотод Л.Бетховен насан туршаа амьдарч мөнхийн уран бүтээлээ туурвиж байсан билээ.

Төгөлдөр хуур тоглох хосгүй ур чадвараараа европийг бишрүүлж байсан төдийгүй хөгжимчин, сурган хүмүүжүүлэгчийн хувьд ч мөн олны анхаарлыг ихэд татаж байжээ. Хөгжмийн зохиолчийн хувьд ч маш үр бүтээлтэй ажиллаж 25 настайдаа гэхэд л уран бүтээлээ ямар ч төвөггүй зарж борлуулдаг болсон байв.

Нас нь гуч дөхөх үед сонсгол нь муудах шинж тэмдэг илрэх үеэс сэтгэл санааны хямралд орж тэр ч байтугай амиа хорлохоор завдаж байсан удаатай.

1802-1815 онуудыг түүний уран бүтээлийн оргил үе гэж үздэг. Тэр үед сонсгол нь улам муудсанаас олноос зайдуу явах болоход учрыг нь мэдээгүй зарим хүмүүс түүнийг хэт жожиг гэж гоочилж байв. Тэр үед Бетховен дээдсийн хүрээлэнгийн хэд хэдэн үзэсгэлэнт хатагтай нартай нэр холбогдсон ч ганцыг нь ч эхнэрээ болгож аваагүй юм.

Бетховен улам оргилуун онгодтой ажиллаж жил өнгөрөх бүр тухайн цаг үед хөгжим сонирхогчдын таашаадаг урсгал чиглэлийг эс тоож зөвхөн сэтгэлдээ нийцсэн уран бүтээл хийж байсан ч шинэ уран бүтээл бүр нь шуугиан дэгдээж байлаа.

Тавин нас хүрэх үедээ дүлий болж концертод төгөлдөр хуурчийн хувьд ч оролцохоо больж тэр ч байтугай хүнтэй уулзахаа больж олон түмнээс бүрмөсөн холдов. Уран бүтээл гараасаа гаргах нь улам цөөрч түүний хөгжмийг ойлгох бүр төвөгтэй болов. Энэ үеэс Бетховен уран бүтээлээ зөвхөн өөртөө болон хөгжмийг гүн ойлгодог хүмүүст зориулан бичдэг болжээ. Энэ

тухайгаа нэгэн шүүмжлэгчид тайлбарлаж "Би өнөөгийн бус ирээдүй үеийнхэнд зориулан аялгуу бичиж байна." гэж байжээ.

Хүн төрөлхтөний түүхийн хамгийн суут хөгжмийн зохиолч дүлий байсан нь үнэхээр хачирхалтай юм. Гэвч Бетховен сэтгэл санааны асар их зориг, хэмжээлшгүй их тэвчээр гаргаж байж мөнхийн уран бүтээлээ туурвисаар байсан гайхамшигтай хүн байлаа. Дүлий болсон амьдралынхаа жилүүдэд чанарын хувьд урьд өмнөхөөсөө хол давуу бүтээл хийж байсныг нь нь ойлгоход бэрх. Чухамдаа амьдралынхаа сүүлийн жилүүдэд гаргасан бүтээл нь дэлхийн хөгжмийн урлагийн түүхийн хамгийн хосгүй бүтээлүүд болон алдаршсан билээ. 1827 онд Вена хотод 57 настайдаа өөд болжээ.

Л.В.Бетховен амьдралынхаа туршид 9 симфони найраглал, төгөлдөр хуурт зориулсан 32 сонат, төгөлдөр хуурын 5 концерт, төгөлдөр хуур хийлд зориулсан 9 сонат, утсан хөгжмийн гайхамшигт цуврал концерт, театрын болон дууны хөгжим зэрэг маш их уран бүтээл туурвисан билээ. Уран бүтээлдээ сэтгэл санааны хүч, төгс хэлбэрийг чадварлаг хослуулж чадаж байлаа. Уран бүтээлээрээ найрал хөгжмийг маш өндөр түвшинд гаргаснаар хоёрдугаар зэргийн гэж гадуурхагдаж байсныг нь эгнэгт болиулжээ.

Бетховен өвөрмөц онцлогтой хөгжмийн зохиолчийн хувьд хөгжмийн урлагт олон шинэчлэл хийснийг нь хойч үеийнх нь хөгжмийн зохиолчид хүлээн зөвшөөрч үргэлжлүүлэн баяжуулсан билээ. Симфони найрал хөгжмийн тоглолтын хугацааг сунгаж далайцыг нь өргөжүүлсэн төдийгүй төгөлдөр хуур хөгжмийн асар их боломжийг нээн харуулж хамгийн тэргүүний хөгжмийн зэмсэг болохыг нь нотолсон. Сонгодог хөгжмөөс романтик чиглэлийн хөгжим рүү хийх шилжилтийн эхийг тавьж өгсөн гавьяатай юм.

Бетховен нь өөрөөс нь хожуу төрсөн, хөгжмийн өөр чиглэлийг баримталж байсан Брамс, Вагнер, Шуберт, Чайковский зэрэг цуут хөгжмийн зохиолчдын уран бүтээлд үнэлж баршгүй нөлөө үзүүлсэн төдийгүй Берлиоз, Густав Малер, Рихард Штраус зэрэг хөгжмийн зохиолчдын уран бүтээлийн дардан замыг зааж өгсөн билээ.

Улс төр, гоо зүйн үзэл санааг үгээр илэрхийлэх нь хөгжмөөс илүү боломжтой, энэ утгаараа уран зохиол нь урлагийн төрлийн хувьд хөгжмөөс илүү нөлөөтэй юм. Чухам ийм учраас суут хүмүүсийн нэрсийн жагсаалтанд Л.В.Бетховений нэр зохиолч У.Шекспирээс хойно орсон юм.

# 46. Вернер Гейзенберг

(WERNER HEISENBERG)

1901-1976



Германы алдарт физикч Вернер Карл Гейзенбергийн шинжлэх ухааны түүхэн дэх чухал нээлтүүдийн нэг болох квант механикийн шинжлэх ухааныг бий болгоход оруулсан их нэмрийг нь үнэлж 1932 онд физикийн салбарын Нобелийн шагнал хүртээжээ.

Механикийн шинжлэх ухаан бол материаллаг эд зүйлсийн хөдөлгөөнийг зохицуулдаг үндсэн хуулиудтай холбоотой физикийн салбар юм. Чухамдаа механикийн шинжлэх ухаан нь физикийн суурь салбар бөгөөд энэ утгаараа бүх шинжлэх ухаануудын тулгуур үндэс болдог юм. Хорьдугаар зууны эхээр механикийн хуулиуд нь атом түүнийг бүрэлдүүлэгч элементүүд зэрэг эгэл хэсгүү-дийг судлахад учир дутагдалтай болох нь мэдэгдэж эхэлсэн билээ.

В.Гейзенберг 1925 онд физикийн Ньютоны сонгодог томъёоллоос эрс ялгаатай шинэ томъёоллыг дэвшүүлжээ. Түүний шавь нарын хийсэн зарим шинэчлэлийн дараа энэ томъёолол нь физикийн шинжлэх ухаанд маш их ач холбогдолтой болж өнөөдөр энэхүү томъёоллыг бүх төрлийн, ямар ч хэмжээний физикийн системийг судлахад хэрэглэгдэж байна.

Сонгодог механик нь математикийн үүднээс авч үзвэл квант механикийг бодвол илүү энгийн, шинжлэх ухааны аливаа тооцоо хийхэд хялбар ч атомын түвшинд тооцоо хийхэд квант механик яг тохирно.

В.Гейзенберг бүх шинжлэх ухаанд суурь үндэс болох "тодорхойгүйн зарчмын тухай" алдарт дүгнэлтээ 1927 онд хийжээ. Энэхүү зарчим нь шинжлэх ухааны хэмжилт явуулах талаархи хүний оюун чадварын онолын тодорхой хэмжээ хязгаарыг харуулж байдаг. Судалж байгаа системийн тухай бодит мэдээллийг олж авахад эрдэмтэн хүнд физикийн үндсэн хуулиуд саад болно. Чухамдаа тодорхойгүйн тухай зарчмын үүднээс авч үзвэл хэмжигч багажийг хичнээн

ч боловсронгуй болгоод бодит мэдээлэл авах бололцоо гардаггүй юм.

Тодорхойгүйн зарчмаар бол физикийн шинжлэх ухаан нь мөн чанарынхаа хувьд гагцхүү статистик урьдчилсан тооцоо хийж болох бололцоотой юм. Тухайлбал цацраг идэвхт бодисыг судалж байгаа эрдэмтэн радийн тэрбум атомаас маргааш гэхэд хоёр сая нь гамма туяа цацруулна гэдгийг урьдчилан тодорхойлж чадна. Гэхдээ тухайн атом нь гамма туяа цацруулах эсэхийг яагаад ч тааж тодорхойлж чадахгүй. Хэмжээ хязгаар нь том байхад статистик арга хэрэглэж үйл ажиллагааны бодит үндэслэлийг гаргаж болно, гэтэл хэмжээ хязгаар нь өчүүхэн бол статистик тооцооны аргыг хэрэглэх ямар ч бололцоо байдаггүй юм.

Хэмжээ хязгаар нь өчүүхэн жижиг байгаа нөхцөлд тодорхойгүйн зарчим нь бүх эд зүйл физикийн хувьд учир шалтгаантай байдаг гэсэн ердийн сэтгэлгээг өөрчлөхөд хүргэсэн билээ. Энэ бол шинжлэх ухааны гүн ухаанд хийсэн гүн гүнзгий өөрчлөлт байсан юм. Чухам тийм учраас тэр зарчмын тухай аугаа эрдэмтэн А.Эйнштейн "Бурхан манай дэлхийтэй дандаа тоглон наадаж байх юм" гэж бахархан өгүүлжээ.

Онолын талаас нь авч үзвэл квантын онол нь харьцангуйн онолоос илүү дэлгэрсэн ч физикийн ертөнцийн тухай хүн төрөлхтөний суурь ойлголтыг өөрчилсөн юм. Гэхдээ энэ онолоос хийх дүгнэлт нь цэвэр бясалгалын чанартай биш гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Квантын онолыг цахилгаан микроскоп, лазерийн төхөөрөмж, транзистор гээд орчин үеийн олон тоног төхөөрөмжийг ашиглахад хэрэглэж байна. Тэрчилэн цөмийн физик, атомын эрчим хүч, хими, одон орны судлалд өргөн хэрэглэж байна. Квантын онол нь спектроскопийн тухай бидний ойлголтын үндэс болж шингэн гелийн өвөрмөц чанар, оддын дотоод бүтэц, ферро соронзон, цацраг идэвхт чанар зэрэг янз бүрийн сэдвийн онолын судалгаа хийхэд ашиглагдаж байна.

В.Гейзенберг нь 1901 онд Германд төрсөн, 1923 онд Мюнхений их сургуульд онолын физикээр бакалаврын зэрэг хамгаалжээ. 1924-1927 онуудад Копенгаген хотод данийн цуут физикч Н.Бортой цуг ажиллаж байжээ. Квант механикийн талаархи түүний анхны чухал бүтээл нь 1925 онд нийтлэгдсэн бөгөөд 1927 онд тодорхойгүйн тухай зарчмыг анх томъёолж олон нийтэд танилцуулжээ. 1976 онд 74 настайдаа өөд болсон, эхнэр, 7 хүүхэдтэй байв.

Квант механикийг хөгжүүлэхэд В.Гейзенбергээс гадна түүний өмнө судалгаа шинжилгээ явуулж байсан алдарт эрдэмтэн М.Планк, А.Эйнштейн, Н.Бор, францийн эрдэмтэн Луи де Брольи түүний дараа дэвшүүлэн тавьсан онолыг нь гүнзгийрүүлэн судалсан австрийн эрдэмтэн Э.Шрёдингер, английн эрдэмтэн П.А.М.Дирак нар ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Гэвч В.Гейзенберг квант механикийн хөгжилд хамгийн гол үүргийг гүйцэтгэснийг хэн ч үгүйсгэж чадахгүй юм.

# 47. Луи Дагер

(LOUIS DAGUERRE)

1787-1851

Францийн зохион бүтээгч Луи Жак Манде Дагер XIX зууны гучаад оны сүүлчээр гэрэл зураг авах анхны практик аргыг боловсруулахад ихээхэн амжилт олсон хүн билээ.

1787 онд Францийн хойд хэсэгт орших Кормель хотод төрсөн бөгөөд залуудаа зураач байжээ. 35 настайдаа гэрлээр чимсэн уран зургуудын цуглуулбар хийж байхдаа орчин тойрныг бийр, будаг ашиглалгүй, автоматаар зурах төхөөрөмж боловсруулах санааг олж авчээ.

Зураг буулгагч хийх гэсэн түүний анхны оролдлогууд бүтэлгүйтсэн тул мөн зорилгоор ажиллаж байгаа Жозеф Ньепстэй 1827 онд танилцаж хоёр жилийн дараа хамтран ажиллаж эхэлжээ. Гэтэл 1833 онд Ньепс нас барж Дагер цаашид ганцаараа ажиллах болов. Олон жил уйгагүй хөдөлмөрлөсний үр дүнд 1837 онд дагеротипи гэж нэрлэгдсэн гэрэл зураг авах бүдүүвчийг боловсруулж чаджээ.

1839 онд тэрхүү бүдүүвчээ олон нийтэд танилцуулсан нь бөөн шуугиан дэгдээсэн ч шинэ бүтээлийн гэрчилгээ авсангүй. Гэвч Францийн Засгийн газар шинэ бүтээлийнх нь ач холбогдлыг өндөр үнэлж Л.Дагер болон Ж.Ньепсийн хүүд тэтгэмж бүх насаар нь олгож байх шийдвэр гаргажээ. Л.Дагер үндэсний баатар болон мандаж дагеротипийн аргыг өргөн хэрэглэх боллоо. 1851 онд Париж хотын ойролцоох байшиндаа өөд болжээ.

Бий болмогцоо дэлхий даяар өргөн хэрэглэгдэж байгаа хэдхэн тооны томоохон нээлтүүд байдгийн нэг нь гэрэл зураг авах арга юм. Гэрэл зураг авах аргыг шинжлэх ухаан судалгаа, аж үйлдвэр, цэргийн салбарт өргөн дэлгэр хэрэглэдэг. Гэрэл зураг авах нь зарим хүмүүст урлагийн чухал төрөл бол хэдэн сая хүний хувьд чөлөөт цагаа өнгөрөөх дуртай ажил нь билээ. Боловсрол, сэтгүүл зүй, зар сурталчилгаанд гэрэл зураг ихээхэн үүрэг гүйцэтгэж байна. Гэрэл зураг нь өнгөрсөн үеийг яг хэвээр нь санагдуулах нэгэн арга тул хүмүүсийн хувьд хамгийн мартагдашгүй дурсамж байдаг. Гэрэл зургийн боловсронгуй хэлбэр болох кино нь хүмүүсийг хөгжөөх ач холбогдлоосоо гадна гэрэл зураг шиг амьдралд улам өргөн хэрэглэгдсээр байна.

Л.Дагерээс өмнө гэрэл зураг авах төхөөрөмж бүтээх гэсэн оролдлого зөндөө гарч байсан нь мэдээж. Түүнээс найман зуун жилийн өмнө дундаа бяцхан нүхтэй, гэхдээ хальсгүй гэрэл зургийн төхөөрөмжтэй адилдуу төхөөрөмж бүтээгдсэн байжээ. ХҮ! дугаар зуунд Жероламо Кардано гэдэг хүн тэрхүү бяцхан нүхэнд томруулдаг шил суулгаж өнөөгийн гэрэл зураг авах төхөөрөмжийн сонирхолтой эх суурийг тавьжээ. Гэхдээ тэрхүү төхөөрөмж нь дэндүү бүдэг зураг гаргаж байсан тул гэрэл зураг гэж нэрлэж арай болмооргүй байжээ. Бас нэгэн чухал нээлтийг 1727 онд Иоганн Шульц нэртэй хүн хийжээ. Мөнгөний давс гэрлийн мэдрэмжтэй болохыг илрүүлж хэд хэдэн зураг авсан ч шинэ санаагаа цааш нь боловсронгуй болгох талаар тодорхой зүйл хийгээгүй өнгөрчээ.

Л.Дагерийн өмнө гэрэл зураг авах төхөөрөмж бүтээхэд их ойрхон очсон хүн бол түүнтэй хэдхэн жил хамтран ажилласан Ж.Ньепс байв. 1820 оны орчим засмал зам барихад хэрэглэгддэг нэгэн эд болох битум гэрлийн мэдрэмжтэй болохыг илрүүлж энэхүү гэрлийн мэдрэмжтэй эдийг дээр дурдсан гэрэл зураг авах төхөөрөмжинд суулгаж хэд хэдэн гэрэл зураг авснаас нэг ширхэг нь өнөө хүртэл хадгалагдан иржээ. Энэ шалтгаанаар зарим хүмүүс Ж.Ньепсийг гэрэл зургийн төхөөрөмжийн анхны зохион бүтээгч гэж үздэг. Гэтэл түүний бүтээсэн гэрэл зураг авах төхөөрөмж нь ашиглахад дэндүү төвөгтэй, бүтэн 8 цаг хүлээж байж бүдэг гэрэл зураг тодрон гардаг байсан юм.

Л.Дагерийн аргаар бол мөнгөний йодоор бүрсэн ялтас дээр авсан дүрс 15-20 минутанд л тодрон гардаг байжээ. Ийм учраас Л.Дагерийн зохиосон төхөөрөмж овор томтой ч практикт хэрэглэх талаасаа үнэхээр хялбар байсан юм. Түүний зохиосон төхөөрөмж гарсны дараах хоёр жилийн хугацаанд өөр хүмүүс түүнийг улам боловсронгуй болгож гэрэлд мэдрэмжтэй мөнгөний йод дээр мөнгөний бромид нэмснээр гэрэл зураг тодрох хугацааг улам богиносгожээ. Ийнхүү гэрэл зургаар бодит байдал, хүнийг яг хэвээр нь хуулбарлан гаргадаг болжээ.

Л.Дагер шинэ нээлтээ олон түмэнд зарласны дараахан 1839 онд английн эрдэмтэн Ульям Генри Фокс Тальбот негатив хэрэглэн гэрэл зураг авах арга олсноо мөн зарлажээ. У.Тальбот анхны гэрэл зургуудаа 1835 онд буюу Л.Дагерээс хоёр жилийн өмнө авсан нь сонин. Гэвч У.Тальбот өөр асуудал судалж гэрэл зураг авах төхөөрөмж хийх оролдлогоо орхисон байжээ.

Л.Дагер, У.Тальбат хоёроос хойш гэрэл зураг авах технологид нойтон болон хуурай ялтас, хальсийг ороомогт хуйлах, өнгөт гэрэл зураг, хөдөлгөөнт гэрэл зураг, полароид, дижитал гэрэл зураг зэрэг нилээд олон шинэчлэл хийгдсэн билээ.

Гэрэл зураг авах төхөөрөмжийн хөгжилд олон хүн оролцсон ч хамгийн гол хувь нэмрийг Л.Дагер оруулсан нь маргаангүй юм. Түүний хийсэн шинэ бүтээл хэрэглэхэд маш хялбар байсан болохоор богино хугацаанд их өргөн дэлгэрсэн билээ.

# 48. Симон Боливар

(SIMON BOLIVAR)

1783-1830



Испанийн дарлалаас Өмнөд Америкийн орнуудыг (Колумб, Венесуэл, Эквадор, Перу, Боливи) чөлөөлөхөд Симон Боливарын гүйцэтгэсэн үүргийг өндрөөр үнэлж "Өмнөд Америкийн Жорж Вашингтон" гэж алдаршуулсан билээ. Ер нь бүхэл бүтэн тивийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн улс төрийн зүтгэлтэн дэлхийн түүхэнд цөөхөн байдаг юм. .

1783 онд Венесуэлийн Каракас хотод испанийн эзлэн түрэмгийлэгч язгууртны гэр бүлд төржээ. Идэр залуудаа Жон Локк, Ж.Ж.Руссо, Вольтер, Монтескье зэрэг европийн гүн ухаантнуудын зохиол бүтээлийг уншсаар францийн Сэргэн мандалтын үзэл санаагаар хүмүүжжээ. Тэрчилэн европийн хэд хэдэн орноор аялал хийж яваад 1805 онд Ром хотын Авентиний довын орой дээр гарч эх орноо испанийн эзлэн түрэмгийлэгчдээс чөлөөлөх тангариг тавьж байжээ.

Францийн Наполеон Бонапарт хаан 1808 онд Испани улсыг довтлон эзэлж засгийн газрын удирдагчаар төрсөн ахаа залжээ. Ийнхүү хааны гэр бүлийг улс төрийн бодит эрх мэдлээс зайлуулснаар Испани улсын Өмнөд Америк дахь колони улсуудад улс төрийн тусгаар тогтнолын төлөө тэмцэл өрнүүлэх алтан бололцоог олгожээ.

1810 онд Венесуэл улсад хувьсгал гарч Испанийн амбан захирагчийг зайлуулж тус улсын тусгаар тогтнолыг 1811 онд албан бусаар тунхаглан зарлажээ. Чухамдаа тэр жил С.Боливар тэмцлийн замд орж хувьсгалт армийн офицер болов. Гэвч дараа жил нь испанийн арми Венесуэл улсад дахин хяналтаа тогтоож хувьсгалын удирдагч Франсиско Мирандуг шоронд хорив. С.Боливар алагдах аюулаас зугтаж эх орноосоо дүрвэлээ.

Дараагийн хэдэн жил тувт дайтаж олон удаа ялж ялагдаж байсан ч түүний зориг мохсонгүй.



819 онд муу сургагдсан, цөөхөн тооны цэрэгтэй армия удирдан гол мөрөн гатлан тал хөндийг туулж Андын өндөр уулсыг давж Колумб дахь испанийн цэргийг гэнэдүүлэн довтолжээ. 1819 оны наймдугаар сарын 7-нд Бойакагийн дэргэд болсон шийдвэрлэх тулалдаанд ялалт байгуулж тэмцлийнхээ шинэ үе шатыг нээжээ. Дараа нь 1821 онд төрөлх эх орон Венесуэл, 1822 онд Эквадор улсыг чөлөөлөв.

Энэ үед аргентиний эх оронч Хосе де Сан-Мартин Аргентин, Чили улсуудыг чөлөөлж Перу улс руу довтлохоор зэхэж байлаа. Латин Америкийн эрх чөлөөний төлөө тэмцэгч алдарт хоёр хүн 1822 оны зун Эквадорын Гуаякиль хотод уулзсан ч тэмцлээ нэгтгэх ерөнхий төлөвлөгөө боловсруулж чадсангүй. Учир нь гэвээс Сан Мартин эрх тушаалд дуртай Боливартай эрх мэдлийн төлөө тэмцэлдэхийг хүссэнгүй, цэргийн командлагчийн үүргээс татгалзаж өөрийн захирдаг цэргийг Өмнөд Америкаас гаргахаар шийдэв. 1824 онд Боливарын удирдсан арми одоогийн Перу улс орших газар нутгийг бүрмөсөн чөлөөлж 1825 онд Дээд Перуд буюу өнөөгийн Боливи улсад испанийн армийг ялан дийлжээ.

Амьдралынхаа сүүлчийн жилүүдэд С.Боливарын үйл ажиллагаа бүтэмж муутай байв. АНУ-ын туршлагаар Өмнөд Америкийг холбооны улс болгохыг мөрөөдөж байв. Үнэндээ бол Венесуэл, Колумб, Эквадор улсууд нэгдэж Их Колумб нэртэй улс байгуулж С.Боливарыг ерөнхийлөгчөөр томилсон байв. Гэвч Өмнөд Америкт төвөөс зугтаах хүч Умард Америктай харьцуулбал илүү хүчтэй байсан юм. С.Боливарыг 1826 онд Испанийн Нэгдсэн Улсуудын их хурал зарлахад Өмнөд Америкийн дөрөвхөн орон л дэмжжээ. Их Колумб улсад нилээд хэдэн жижиг улсууд нэгдсэн ч тус бүгд найрамдах улс нь удсангүй задарчээ. Тэр ч байтугай иргэний дайн дэгдэж ерөнхийлөгч С.Боливарыг алахаар завдлаа. 1830 онд Венесуэл, Эквадор улсууд бүгд найрамдах улсаас тусгаарлалаа.

Дайн дажныг зогсоож энх амгаланг тогтооход саад болж байгаагаа С.Боливар ойлгож ерөнхийлөгчийн албан тушаалаасаа сайн дураараа огцорсон билээ. Төрөлх эх орон Венесуэлээс хөөгдөж ядуу байдалд орж сэтгэл санааны их хямралаас болж 1830 оны дөрөвдүгээр сард нас баржээ.

С.Боливар нь тухайн цаг үедээ тохирсон улс төрийн том зорилго тавьсан хүн байсан бөгөөд заримдаа дарангуйлагчийн ааш араншин гаргадаг байжээ. Гэвч түүхэн сонголтын цаг мөч ирэхэд сэтгэлийн тэнхээ, зориг гаргаж хувийн санаархлаа ард түмнийхээ ашиг сонирхол, ардчиллын ариун зорилгод захируулж дарангуйлагчийн эрх мэдлээсээ татгалзсан гайхамшигтай хүн билээ. Нэгэн удаа түүнд хэмжээлшгүй эрх мэдэл бүхий хаан болох санал болгоход эрс татгалзаж байжээ. "Эрх чөлөөг олгогч" гэгч олон түмнээс өгсөн нэр алдрыг хамгаас илүү эрхэмлэн дээдэлж байсан юм.

Испани улсын колони байсан Өмнөд Америк тивийг чөлөөлөхөд С.Боливар хамгийн гол үүрэг гүйцэтгэсэн билээ. Өгүүлэл захидал хэвлүүлж сонин эрхлэн гаргаж хаа сайгүй хурал цуглаан зохион байгуулж гал цогтой үг хэлж эрх чөлөөний төлөө тэмцлийн үзэл санааны үндэс суурийг тавьсан юм. Тэрбээр эрх чөлөөний төлөө тэмцлийг дэмжих хөрөнгө мөнгө цуглуулах бүх арга бололцоог эрэн хайж байв.

С.Боливар нь хувьсгалт цэргийн хүчний цэргийн удирдагч байлаа. Гэхдээ түүнийг цэргийн хосгүй жанжин гэж нэрлэж арай болохгүй. Түүний ялан дийлсэн армиуд нь тооны хувьд

цөөхөн, цэргийн бэлтгэлийн хувьд тааруу байсан. Цэргийн ямар нэгэн боловсрол эзэмшээгүй болохоор цэргийн стратеги, тактикийн урлагийн талаар ямар ч мэдлэггүй хүн байсан. Гэхдээ тулгарч байсан аливаа бэрхшээл саадыг сэтгэлийг асар их зориг тэвчээр гарган даван гарч байсан билээ. Испаничуудас ялагдал хүлээж хамтран зүтгэгчид нь сэтгэл санааны хямралд орж тэмцлээс татгалзаж байхад ч тэднийг зоригжуулж дахин цэрэг цуглуулж арми эмхлэн байгуулж тулалдаж байсан юм.

С.Боливарыг АНУ-ын анхны ерөнхийлөгч Ж.Вашингтонтой харьцуулж болох талтай. Вашингтон шиг жижигхэн, цэргийн бэлтгэлийн хувьд тааруу арми командлан захирч байсан, хөрөнгө мөнгө багатай болохоор армия тараан алдчихгүйн тулд хурц дайчин үгээр зоригжуулж байлаа. Гэхдээ Ж.Вашингтоноос С.Боливарын нэг давуу тал гэвэл бүх боолчуудыг ганц зарлиг гаргаад л чөлөөлсөн билээ. Түүгээр ч барахгүй чөлөөлсөн нутаг дэвсгэртээ уриалга гаргаж үндсэн хуулийн тогтоолоор боолчлох явдлыг шууд таслан зогсоож байсан юм. Гэвч боолчлолыг эгнэгт устгах түүний чармайлт талаар өнгөрч түүнийг өөд болох үед Өмнөд Америкт боолчлох ёс бас л байсаар байсан билээ.

С.Боливар нь хувь хүнийхээ хувьд сонирхолтой, хатан зоригтой, сэтгэл уярамтгай хүн байжээ. Гадна төрх байдлын хувьд ганган хээнцэр эр хүн байсан болохоор тухайн цаг үеийнхээ үзэсгэлэнт олон бүсгүйтэй нэр холбогдож явжээ. Ж.Вашингтон шиг төрийн захиргааны үйл ажиллагааны мэдрэмж авьяас чадваргүй байсан болоод ч тэр үү өөрийг нь магтан сайшааж тал засдаг хүнд их итгэдэг байжээ.

Эрх чөлөөг бүхнээс дээдэлдэг тэмцэгч байсан тул эдийн шуналгүй хүн байв. Улс төрийн тэмцэлд баян чинээлэг орж ирсэн мөртөө ядуу байдалд ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн юм.

Түүний чөлөөлсөн газар нутаг нь АНУ-ын газар нутгаас илүү байсан. Гэхдээ АНУ нь С.Боливарын чөлөөлсөн улсуудаас илүү түүхэн үүргийг дэлхийн ертөнцөд гүйцэтгэж байгаа тул С.Боливар нь Ж.Вашингтонтой харьцуулбал түүнээс доогуур ач холбогдолтой бие хүн юм.

# 49. Рене Декарт

(RENE DESCARTES)

1596-1650



Францийн алдарт гүн ухаантан, математикч Рене Декарт 1596 онд Га Гайе тосгонд төрж идэр залуудаа шашны сургуульд суралцаж хорин настайдаа Потье хотын их сургуульд хуульчийн мэргэжил эзэмшжээ. Баян эцгийн хөрөнгөөр өндөр боловсрол эзэмшсэн ч математикаас өөр салбарт онцгой авьяас чадваргүй гэж тооцогдож байжээ. Р.Декарт боловсролоо дээшлүүлэхийн оронд аялал хийж нүд тайлах нь дээр гэж үзэж европ тивийн бүх орныг үзэж танилцахаар замд гарчээ.

1616-1628 онуудад олон орноор аялал хийж Голланд, Бавар, Унгар гээд гурван улсын армид богино хугацаагаар цэргийн алба хаахдаа ганц ч байлдаан, тулалдаанд оролцсонгүй ажээ. Тэрчилэн Итали, Польш,

Дани гээд олон орноор явж байх хугацаандаа үнэнийг нээх үндсэн арга олжээ. 32 настайдаа олж нээсэн аргаа дэлхий ертөнцийн нийтлэг дүр зураг гаргахдаа ашиглахаар шийдэж оюун санааны эрх чөлөө харьцангуй чөлөөтэй Голланд улсад сууришаж тэнд 21 жил амьдарчээ.

1629 оны хавьд үнэнийг нээх аргыг тайлбарласан "Сэтгэлгээ-ний чиглэлийг тодорхойлох дүрэм" нэртэй, нас барснаас нь хойш тавин жилийн дараа хэвлэгдсэн номоо бичиж

дуусгажээ. 1630-1634 онуудад шинээр нээсэн аргаа шинжлэх ухаанд хэрэглэх үйл ажиллагаа явуулжээ. Энэ үед анатоми, физиологийн талаар мэдлэг олж авахын тулд задлан хагалгаа хийж байв. Хараа зүй, цаг уур судлал, математик зэрэг шинжлэх ухааны олон салбарт бие даасан судалгаа хийж байжээ.

Шинжлэх ухаан салбарт хийсэн олон талт судалгааныхаа үр дүнг нэгтгэсэн "Ертөнц" нэртэй ном бичихээр төлөвлөж байв. Гэвч дэлхий нарыг тойрон эргэлддэг тухай Коперникийн онолыг хамгаалсан Галилейг шашны засаг захиргаа Италид шүүмжилсэн тухай сонсоод Р.Декарт Голланд улс дахь католик шашны засаг захиргаанд захирагддаггүй ч Коперникийн онолыг хамгаалсан номоо хэвлүүлэхээ больжээ. Тэгээд 1637 онд алдарт "Шинжлэх ухаан

дахь үнэний шалтгааныг зөв олох аргын тухай бясалгал" номоо гаргажээ.

Энэхүү номоо латынь хэл дээр биш францаар бичсэн болохоор сонгодог боловсрол эзэмшээгүй жирийн иргэд хүртэл уншиж байв. Энэ номынхоо өмнөх үг болгон гурван найруулал бичсэний эхнийх нь болох "Хараа зүй" найруулалд гэрлийн хугарлын хуулийг тайлбарласан байлаа. Тэрчилэн томруулагч шил, хараа зүйн бусад хэрэгсэлийн тухай бичиж нүдний ажиллагааны зарчмыг тайлбарлаж хожим нь Кристиан Гюйгенсийн томъёолсон долгионы онолын эх суурь болох гэрлийн онолыг дэвшүүлэн тавьжээ.

Хоёрдахь өгүүлэл нь цаг уурын тухай орчин үеийн ойлголтын анхны төсөөлөл байжээ. Үүл, борооны мөн чанарыг гаргаж солонгын учрыг тайлбарласан байна. Дулаан нь үл харагдах шингэн гэсэн ойлголт буруу болохыг нотлож дулаан нь дотоод хөдөлгөөний хэлбэр гэж үзжээ.

Геометрийн тухай гуравдугаар найруулалд шинжлэх ухаанд хийсэн гол хувь нэмэр болох аналитик геометрийн тухай ойлголтуудыг гаргаж тавьсан. Энэ бол математикийн шинжлэх ухааны маш чухал ололт байсан бөгөөд И.Ньютонд дифференциаль болон интеграл тоог нээх дардан замыг зааж өгсөн билээ.

Р.Декартын гүн ухааны сонирхолтой хэсэг нь судалгаагаа эхэлсэн арга юм. Үнэнд хүрэхийн тулд бидний зөв гэж хүлээн зөвшөөрдөг олон тооны буруу саналаас бүхнийг эхлэх ёстой гэж үзжээ. Өөрөөр хэлбэл Р.Декарт багш нарынхаа зааж итгүүлсэн бүх зүйлд түүний дотор эргэн тойрон оршин буй ертөнц тэр ч бүү хэл өөрийгөө байгаа эсэхэд эргэлзэж эхэлсэн байна.

Ийнхүү ертөнцийн тухай эргэлзэл тээнэгэлзэлийг хэрхэн даван гарах, хорвоогийн бүх зүйлийн тухай тодорхой мэдлэг хэрхэн олж авах тухай асуудал тавигджээ. Р.Декарт ухаалаг метафизик нотолгооноос гадна "Би бодон сэтгэж байна, тэхлээр би оршиж байна." гэсэн тайлбар хийж өөрийгөө оршиж байгаа, Бурхан байдаг, тэрчилэн эргэн тойрон бодит ертөнц байна гэж батлаж байлаа. Энэ бол түүний дэвшүүлэн тавьсан онолын үндэс суурь байсан юм.

Түүний сэтгэлгээний арга нь хоёр чухал ач холбогдолтой. Нэгдүгээрт гүн ухааны тогтолцооны төвд "Хүний анхны танин мэдэхүй гэж юу вэ?" гэсэн суурь асуудлыг дэвшүүлсэн. Түүнээс өмнөх үеийн гүн ухаантнууд дэлхий ертөнцийн мөн чанарыг тайлбарлан бичихийг оролдож байсан бол Р.Декарт "Би хэрхэн танин мэдэж байна вэ?" гэсэн асуултаас өөрөөр зөв хариулах боломжгүй гэж үзсэн юм.

Хоёрдугаарт гэвэл бид танин мэдэх үйл ажиллагааг итгэл үнэмшлээс биш эргэлзлэл тээнэгэлзлэлээс эхлэх ёстой гэсэн санааг дэвшүүлсэн. Энэ бол итгэл үнэмшлийг гол болгодог байсан Амгалан Августин болон дундад зууны үеийн бусад шашны онолчдын байр сууринаас эрс ялгаатай байлаа. Гэвч эцсийн эцэст шашны бурангуй дүгнэлтийг давтсан нь хачирхалтай.

Р.Декарт гүн ухаандаа сэтгэлгээ болон материаллаг эд зүйлийн хоорондын ялгааг онцлон үзэж энэ утгаараа давшингуй дуалист үзлийг хамгаалж байв. Гэхдээ дээрх ялгаа өмнө нь байсан ч Р.Декарт энэ асуудлаар гүн ухаантнуудын дунд маргаан дэгдээсэн. Энэ асуудлаар гүн ухаантнууд хэдэн зуун жил маргалдсаар өнөө хэр нэгдсэн ойлголтод хүрээгүй байна.

Хорвоо дэлхийн гүн ухааны тухай Декартын номлол дараа үеийнхэндээ их нөлөө үзүүлсэн

билээ. Бурхан, хүний сэтгэлгээнээс бусад ертөнц эрчээрээ хөдөлдөг, ийм учраас байгалийн бүх үзэгдлийг механик аргаар тайлбарлаж болно. Тийм учраас зурхай, ид шид зэрэг далдын хүчин зүйлийг буруушаасан төдийгүй үйл явдал бүрийг шашны сургаалаар тайлбарладагийг үгүйсгэсэн юм. Амьтад бол маш нарийн бүтэцтэй хөдөлгүүр, хүний бие махбодь нь механикийн хуульд захирагддаг зүйл юм гэж үзэж байлаа. Чухам тэр үеэс хүний бие махбодь орчин үеийн физиологийн шинжлэх ухааны судалгааны гол зүйл болсон байна.

Р.Декарт шинжлэх ухааны судалгааны ач холбогдлыг өндөр үнэлж судалгааны үр дүнг амьдралд хэрэглэх нь нийгэмд ашиг тус өгнө гэсэн байр суурь баримталж байжээ. Тэрчилэн аливаа судлаач эрдэмтэн бүрхэг таамаглал дүгнэлтээс зайлсхийж ертөнцийн байдлыг математик тэгшитгэлээр тайлбарлахыг чармайх ёстой гэж үзэж байжээ.

1641 онд цуут "Бодрол", 1644 онд "Гүн ухааны эхлэл" номоо латынь хэлээр хэвлүүлж 1647 онд франц хэлээр гаргажээ. Түүний бичлэгийн найрууллага гайхамшигтай оновчтой ч үг хэллэг нь дэндүү хуучинсаг байжээ.

Их шүтлэгтэй, өөрийгөө католик шашинтан гэж үздэг байсан ч сүм хийдийн удирдлага түүний үзэл санааг буруушааж бичсэн номуудыг нь унших байтугай хэвлэхийг хориглож байв. Тухайн үедээ үзэл бодлыг хавчин гадуурхах талаар бусад орнуудаас илүү чөлөөтэй байсан Голланд улсад хүртэл түүнийг шашингүйн үзэлтэн гэж нүд үзүүрлэж байв.

1649 онд гэрийн багшаар ажиллахыг урьсан Шведийн Кристина хатан хааны саналыг хүлээн авч Стокгольм хотод амьдрахаар иржээ. Гэвч нойр ихтэй түүнд хатан хаан өглөө үүрээр таван цагт босож хичээл заах хүсэлт тавихад ихээхэн цааргалж байсан удаатай. Төдсөнгүй уушигний хатгалгаа тусаж 1650 оны хоёрдугаар сард өөд болжээ. Амьдралдаа гэрлэж байгаагүй, ганц охинтой болсон ч аль багадаа нас баржээ.

Р.Декартын гүн ухааныг цаг үеийнх нь хүмүүс ихээхэн шүүмжилж байсан төдийгүй дараа үеийн эрдэмтэд олон дутагдал олж илрүүлж байв. Гэхдээ түүний бүтээлүүдэд тусгагдсан олон үзэл санаа нь түүхэнд асар их нөлөө үзүүлсэн билээ. Түүний дэвшүүлсэн олон тооны үзэл санаанаас тав нь европийн сэтгэлгээний хөгжилд ихээхэн түлхэц өгсөн гэж үздэг юм. Үүнд нэгдүгээрт ертөнцийн үзэгдэл юмсыг механикийн байр сууринаас тайлбарлаж байсан, хоёрдугаарт шинжлэх ухааны судалгааны ач холбогдлыг өндөр үнэлсэн, гуравдугаарт шинжлэх ухаанд математикийг ашиглах нь зүйтэй болохыг сургасан, тавдугаарт танин мэдэхүйн онолд анхаарлаа онцгой төвлөрүүлсэн.

Бид Р.Декартын шинжлэх ухаанд хийсэн гарамгай ололтуудыг үнэлэхдээ аналитик геометрийн шинжлэх ухааныг бий болгосон гавьяаг нь онцлон үздэг билээ.

# 50. Микеланжело

(MICHELANGELO)

1475-1564

Сэргэн мандалтын үеийн аугаа зураач Микеланжело Буонарроти бол дүрслэх урлагийн түүхэн дахь хамгийн гарамгай уран бүтээлч билээ. Хосгүй зураач, уран барилгач, уран барималч Микеланжело үзэгчдийн сэтгэлийг дөрвөн зуу гаруй жил бишрүүлсээр байгаа төгс нандин бүтээлүүд туурвисан юм. Түүний бүтээлүүд нь европийн уран зураг, уран барилгын цаашдын хөгжилд асар их нөлөө үзүүлсэн билээ.

1457 онд Италийн Флоренц хотоос дөчин бээрийн зайтай орших Капрезе хотхонд төржээ. Аль багад нь түүний авьяас тодорсон тул 13 настайд нь флоренцийн алдарт уран зураач Гирландайод шавиар оруулжээ. 15 нас хүрэхэд нь Флоренц хотын амбан захирагч Лоренцо түүнийг Медичи ордондоо бараг гэр бүлийн гишүүнээр авч ивээн асрамжлагч нь болжээ. Бүхий л амьдралынхаа туршид сод авьяас билгээрээ гайхагдаж байсан бөгөөд хамба лам нар, хаад вангууд, төрийн удирдагчид зураг зуруулахаар баримал хийлгэхээр өндөр шан харамж амлан урьдаг байжээ.

Микеланжело амьдралынхаа хугацаанд олон хотод очиж уран бүтээлээ туурвиж байсан ч дийлэнх хэсгийг нь Ром, Флоренц хотуудад өнгөрөөжээ. 1564 онд 89 настайдаа Ром хотод нас баржээ. Тэр эхнэр авч байгаагүй ажээ.

Микеланжело нь өмнөх үед нь уран бүтээлээ туурвиж байсан Леонардо да Винчи шиг бүх талаараа суут хүн байгаагүй ч олон талын авьяасаараа гайхагдаж байлаа. Микеланжело бол хүний тэмүүлэл мөрөөдлийн хоёр салбарт уран бүтээлийн санаанд багтамгүй оргилд зэрэг хүрсэн цорын ганц суут хүн билээ. Зураачийн хувьд уран бүтээлийн үлэмж өндөрлөгт хүрч хойч үеийнхээ алтан гартнуудад юутай ч зүйрлэшгүй их нөлөө үзүүлсэн юм. Ром хотын Сикстиний капелла сүмийн таазыг чимсэн хананы олон зураг нь урлагийн бүх цаг үеийн аугаа их ололт гэж тооцогдсоор байна.

Гэхдээ Микеланжело өөрийгөө юуны өмнө уран барималч гэж үзэж байсан бөгөөд зарим судлаачид түүнийг бүх цаг үеийн хамгийн аугаа уран барималч гэж шагшин магтдаг юм. Давид, Мойсей нарын цээж баримал тухайлбал алдарт "Христийг өрөвдөн уйлсан нь" баримал нь өнөө үеийнхнийг ч бишрүүлсээр байна.

Микеланжело бас авьяаслаг уран барилгач байлаа. Энэ салбарт түүний туурвисан уран бүтээлүүдийн дотор Флоренц хот дахь Медичийн ордны бунхан цуутай билээ. Ром хот дахь Гэгээн Петрийн сүмийн барилга байгууламжийн ерөнхий уран барилгачаар олон жил ажилласан юм.

Бас олон тооны шүлэг найраглал бичсэнээс бидний үед гурван зуу орчим нь хадгалагдан иржээ. Энэ утгаар түүнийг авьяаслаг яруу найрагч байжээ гэж үнэлэх бүрэн үндэслэл бий.

Энэхүү суут ухаантны олон тооны сонет, шүлэг, найраглал нь амьд ахуйд нь хэвлэгдэж байгаагүй нь даан ч харамсмаар.

# 51. Хоёрдугаар Урбан Хамба лам

(POPE URBAN II)

1042-1099

Хоёрдугаар Урбан хамба ламыг мэдэхгүй хүн өнөө үед ховор биз ээ. Ариун газар нутгийг лалын шашинтнуудаас чөлөөлөх эрхэм зорилгод христчүүдыг анхны аян дайнд уриалан дуудсанаар загалмайтны аян дайны эхлэлийг тавьж хүн төрөлхтөний түүхэнд асар их нөлөө үзүүлсэн билээ.

Багадаа Одо де Лажери нэртэй байсан хамба лам Урбан 1042 оны үед Францийн Шатильон-на-Марне хотын ойролцоо язгууртны гэр бүлд төрсөн тул сайн боловсрол эзэмшжээ. Идэр залуудаа Реймс хотод лам, сүмийн хамба байгаад 1088 онд хамба ламаар өргөмжлөгджээ.

Урбан бол хүчтэй, улс төрийн хувьд мэргэн хамба лам байсан юм. 1095 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Клермон хотод Шашны их зөвлөл зарлан хуралдуулжээ. Хуран цугларсан олон мянган хүний өмнө түүний хэлсэн үг европ тивийн хувь заяанд дараагийн хэдэн зуун жилд нөлөө үзүүлсэн билээ. Тэрхүү алдарт үгэндээ, Ариун газар нутгийг эзлэн түрэмгийлсэн тэрс шашинтан түрэгүүд ариун нандин дурсгалт газруудаар дүүрч христосын даянчдад түвэг учруулж байгааг эсэргүүцэж байгаагаа мэдэгдээд Ариун газар нутгийг чөлөөлөхийн тулд бүх христчүүдыг аян дайнд мордохыг уриалжээ.

Гэхдээ тавьсан зорилгоо зөвхөн шашны учир шалтгаанаар тайлбарлаад зогссонгүй, Ариун газар нутаг бол үржил шимтэй, хүн ам шигүү суусан европ тивээс илүү баян тансаг нутаг гэсэн үндэслэл бас гаргажээ. Ариун газар нутгийг чөлөөлөх загалмайтны аян дайнд оролцох нь шашны бүх цээрлэлийг орлох төдийгүй аян дайнд оролцогч болгон бүх гэм нүглээсээ ангижрах болно гэж айлджээ.

Хуран цугларсан олон шашны итгэл үнэмшил болон хувийн ашиг сонирхлыг нь хөндсөн түүний яруу тод айлтгалыг сонсоод цөмөөрөө загалмайтны аян дайнд оролцох зориг хүсэл нь оргилжээ. Тэд хамба ламыг гал цогтой дайчин үгээ дуусгахын өмнө "Бурхан биднийг дуудаж байна!" гэж цуурайтуулан хашгирсан нь загалмайтны аян дайнд оролцогчдын уриа болсон билээ. Энэ цуглаанаас хойш хэдхэн сарын дараа анхны загалмайтны аян эхэлжээ.

Нийтдээ найман олон жижиг байлдаан, тулалдаанаас бүрдсэн энэхүү загалмайтны аян дайн бараг хоёр зуу гаруй жил үргэлжилсэн билээ.

Загалмайтны анхны аян дайнд оролцогчид Иерусалим хотыг эзлэснээс хоёр долоо хоногийн дараа, тэр баярт мэдээг дуулж амжилгүй 1099 онд хамба лам Урбан нас барсан байна.

Загалмайтны аян дайны ач холбогдлыг тайлбарлах нь илүүц биз. Энэ аян дайн аливаа дайны адил уг үйл явдалд оролцогчид хийгээд хамрагдсан газар нутагт ихээхэн нөлөө үзүүлсэн билээ. Удтал үргэлжилсэн дайны явцад европ тив аль ч утгаараа илүү хөгжилтэй байсан



Византийн эзэнт гүрэн, лалын шашны ертөнцтэй нягт хэлхээ холбоо тогтоосон юм. Чухамдаа энэхүү бүх талын хамтын харилцаа нь орчин үеийн европийн соёл иргэншлийг оргилуун хөгжилд хүргэсэн юм. Тэрчилэн Сэргэн мандалтын үеийн суурь дэвсгэр болсон билээ.

XI зуунд нийгмийн хөгжлийн царцанги байдалд орсон нийт европийг хөдөлгөөнд оруулах удирдагч үнэхээр үгүйлэгдэж байв. Тэрхүү түүхэн үүргийг европийн хаадаас гүйцэтгэж чадах хүн алга байв. Гэвч тэр үед эрх мэдэл нь баруун европ даяар үйлчилдэг ганц хүн байсан нь христос шашны тэргүүн хамба лам байлаа. Тийм учраас хамба лам Урбан нийгмийн хөгжлөөр тавигдсан нийт европийг хөдөлгөх түүхэн үүргийг зохих ёсоор биелүүлсэн асар их гавьяатай юм. Чухамдаа хамба лам Урбаны зоримог удирдлага байгаагүй бол загалмайтны хөдөлгөөн нийт европийг хамрах боломжгүй байлаа Энэ утгаараа хамба лам хоёрдугаар Урбан нь хүн төрөлхтөний түүхийн явцад он удаан жилийн нөлөө үзүүлсэн гайхамшигт хүн гэж зүй ёсоор тооцогддог юм.

# 52. Умар Ибн Аль-Хаттаб

(UMAR IBN AL-KHATTAB)

586-644



Умар ибн аль-Хаттаб нь лалын шашны хоёр дахь том зүтгэлтэн байсан юм. Их зөнч Магометийн үед амьдарч байсан бөгөөд түүний адил Мекка хотод 586 оны орчим мэндэлжээ.

Умар анхандаа Магомет түүний үндэслэсэн лалын шашныг тас эсэргүүцдэг байснаа удсангүй түүний үнэнч анд, хамтран зүтгэгч болсон түүхтэй. Насан туршаа Магометийн хамгийн дотнын зөвлөх нь байжээ.

Магомет 632 онд нас барахдаа залгамжлагчаа тодруулж амжаагүй учир Умар их зөнчийн ойрын хамтран зүтгэгч, хүргэн Абу Бекрийг анхны халифаар дэвшүүлжээ. Үүний үр дүнд эрх мэдлийн төлөөх хурц тэмцэл хэсэг хугацаанд намжжээ.

Абу Бакр авьяаслаг удирдагч байсан ч халифаар хоёрхон жил ажиллаад өөд болохдоо Умарыг өөрийн залгамжлагчаар өргөмжилж эрх мэдлийн төлөө амь өрсөн тэмцэл дахин өрнөхийг сэргийлж чадав. Умар 634 онд хоёр дахь халифаар тодорч Медина хотод персийн боол эрд 644 онд алагдах хүртлээ байжээ. Умар амьсгаа хураахын өмнө, залгамжлагчаа тодруулах 6 хүний бүрэлдэхүүнтэй Зөвлөл томилж мөн л эрх мэдлийн төлөө цуст тэмцэл гаргахаас мөн урьдчилан сэргийлжээ. Уул Зөвлөлөөс гуравдугаар халифаар өргөмжлөгдсөн Усман 644-656 онуудад удирдагчийн үүрэг гүйцэтгэжээ.

Халиф байх хугацаандаа Умар арабын хамгийн чухал байлдан дагуулалтыг хийжээ. Арабын арми түүний удирдлага дор Византийн эзэнт гүрний бүрэлдэхүүнд багтаж байсан Сири, Палестинд халдан довтолж 636 онд Ярмукийн дэргэд болсон шийдвэрлэх тулалдаанд ялалт байгуулжээ. Тэр ондоо Дамаск хотыг эзэлж хоёр жилийн дараа Иерусалим хотыг бүслэв. 641 онд гэхэд арабууд Палестин, Сирийг бүхэлд нь эзэлж орчин үеийн Түрэг улсын нутаг дэвсгэрт халдав. 639 онд Византийн эзэнт гүрний бүрэлдэхүүнд багтах Египет улс руу мөн довтолж гурван жилийн хугацаанд бүрэн эзэлжээ.

Тэр үед Персийн эзэнт гүрний хэсэг болж байсан Иракийн эсрэг арабчууд Умарыг халифаар өргөмжлөгдөхөөс өмнө дайтаж эхэлсэн бөгөөд хамгийн гол тулалдаан нь Умарыг амьд байх үед 637 онд Квадизийн дэргэд болсон байна. Мөн арабын арми Персийн эзэнт гүрэнд мөн халдан довтолж Нехавендийн дэргэд болсон байлдаанд тус гүрний сүүлчийн хааны цэргийг

бут ниргэжээ. Умарыг 644 онд нас барах үед, Персийн эзэнт гүрний дийлэнх газар нутаг эзлэгдсэн байлаа. Умарыг үхсэний дараа арабчууд дорно зүгт Персийг бүрэн эзэлж баруун зүгт Умард Африкт аян байлдаанаа үргэлжлүүлсэн байна.

Умарын хийсэн байлдан дагуулалтын чухал ач холбогдол нь эзлэн түрэмгийлсэн газар нутгийн асар их хэмжээ байсан төдийгүй тэр газар нутаг нь өнөө хүртэл бах бэх байгаад оршдог юм. Сири, Ирак, Египет улсууд арабуудын нөлөөнд орсон нь өнөө үе хүртэл хэвээр байна. Гагцхүү Перс улс л лалын шашин шүтдэг болсон ч арабын дарлалаас яаж ийгээд чөлөөлөгдөж чадсан юм.

Эзлэн түрэмгийлсэн асар уудам газар нутаг, олон сая хүн амыг захирахын тулд Умар маш зальжин бодлого явуулж байжээ. Арабчууд эзэлсэн газар нутаг дээр цэргийн язгууртны хүрээлэл бий болгож орон нутгийн хүн амаас тусдаа хот суурин газар хуаран болон суудаг байв. Тэрчилэн эзлэгдсэн ард түмнүүдээс өндөр татвар авч байсан ч тэдэнд ямар ч хор хохирол учруулдаггүй байлаа. Тэр ч байтугай лалын шашныг хүчээр түгээн дэлгэрүүлж байсангүй.

Умарын хүрсэн амжилт үнэхээр гайхамшигтай билээ. Их зөнч Магометийн дараа лалын шашныг түгээн дэлгэрүүлэхэд хамгийн гол үүргийг гүйцэтгэсэн юм. Хэрэвзээ Умар томоохон байлдан дагуулалт хийгээгүй бол лалын шашин тийм өргөн нутагт тархаж чадахгүй байсан билээ.

# 53. Ашока

(ASOKA)

Манай эриний өтнөх 300 - 232



Төрийн болон шашны нэрт зүтгэлтэн, Маурья угсааны гуравдугаар Ашока хаан бол Энэтхэг улсын түүхэн дэх хамгийн суут шашны зүтгэлтэн байсан билээ. Түүний өвөг эцэг Чандрагупт нь Александр Македонс-кийн байлдан дагуулалтаас өмнө Умард Энэтхэгийн дийлэнх хэсгийг эзэлж Энэтхэг улсын түүхэнд анхны эзэнт гүрнийг байгуулсан цэргийн гарамгай зүтгэлтэн байжээ.

Ашока нь манай эриний өмнөх 300 оны төрсөн бололтой, манай эриний өмнөх 273 оны үед хаан суудалд заларчээ. Анхандаа өвөг эцгийнхээ замналаар явж аян дайн хийж газар нутгаа өргөжүүлэх бод-лого баримталж байв. Хаан болсныхоо найм дахь жилд Энэтхэгийн дорнод эрэг дээр орших өнөөгийн Орисс мужийн нутаг дэвсгэр дээр орших Калинг улсын эсрэг хийсэн аян дайнаа ялалтаар дуусгав.

Гэвч энэ аян дайны үед зуун мянга хүн алагдаж бас хэдэн хэдэн зуун мянган хүн шархадсаныг Ашока хаан дуулаад энэхүү ялалт нь маш олон хүний амь насаар, маш их үнээр олдсонд харамсан сэтгэл шаналжээ. Ийнхүү сэтгэл санааны хямралд орсон хаан Энэтхэгийн нутаг дэвсгэрийг бүрэн эзлэн түрэмгийлэх зорилгоосоо татгалзаж хөрш зэргэлдээ улс орон руу цэргийн довтолгоон хийхээ бүрмөсөн болив. Тэгээд бүддийн шашин шүтэх болж үнэнч шудрага ёс, энх амгалан, энэрэл хайр номлох дхармын үзэл санааг олон түмний дотор дэлгэрүүлж эхэлжээ.

Ан хийж зугацаахаа больж дан цагаан хоол идэх болов. Гэхдээ хамгийн гол нь хүнлэг, ухаалаг бодлого явуулах болсон нь олон түмний талархал дэмжлэгийг хүлээжээ. Хаан эмнэлэг, амьтны хүрээлэн, зам бариулж олон харгис хууль тогтоомжийг өөрчилж тариан талбайг услах ажлыг өргөжүүллээ. Тэрчилэн хүмүүсийг сайн үйл бүтээх, хоорондоо нөхөрсөг харилцаатай байхыг сурталчилах зорилгоор засгийн газрын тусгай албан тушаалтан, дхармын түшмэдийг орон гутагт томилон явууллаа.

Хаант улсдаа бүх шашин шүтлэгт хүндэтгэлтэй хандах зарлиг гаргаж өөрөө бүддийн шашин шүтдэг болсноор тус шашин Энэтхэг улам өргөн дэлгэрсэн байна. Түүгээр ч зогссонгүй хөрш зэргэлдээ олон оронд бүддийн шашин сурталчилуулахаар лам нар томилон явуулснаас Цейлон улсад илүү их амжилт олсон байна.

Ашока хаан орон даяар багана босгож түүн дээр болон хадан дээр өөрийнх нь амьдрал, үйл ажиллагаа, зарлигуудыг сийлэх зарлиг буулгаснаас өнөө үед олонх нь түүх дурсгалын үнэт зүйл болон хамгаалагдаж байна. Чухамдаа тэдгээр багана, хадны байрлал нь түүний эзэнт гүрний нутаг дэвсгэрийн хэмжээ, түүний үйл ажиллагааны тухай мэдээллийн гол эх сурвалж болсоор байна. Эдгээр баганыг урлагийн хосгүй нандин бүтээл гэж нандигнан хамгаалж байна.

Ашока хааныг нас барснаас хойшхи тавин жилийн хугацаанд түүний захирч байсан эзэнт гүрэн задран унасан бөгөөд дахин ер сэргээгүй юм. Ашока хаан бүддийн шашныг бүх талаар дэмжиж байснаар хүн төрөлхтөний түүхэнд үнэлж баршгүй гавьяа байгуулсан юм. Түүнийг хаанаар өргөмжлөгдөх үед бүддийн шашин нь Энэтхэг улсын баруун хойд хэсэгт л дэлгэрсэн орон нутгийн хэмжээний шашин байсан бол түүний хаанчлалын төгсгөл үед нийт Энэтхэг даяар төдийгүй хөрш зэргэлдээ олон оронд олон сая шүтэн бишрэгчидтэй болж өргөжсөн байлаа. Энэ утгаараа бүддийн шашныг эрчимтэй дэлгэрүүлж дэлхийн томоохон шашны нэг болгоход уг шашныг үндэслэгч Гуатамаас илүү их хувь нэмэр оруулсан билээ.

# 54. Амгалан Августин

(ST.AUGUSTINE)

354-430



Ромын эзэнт гүрнийг мөхөж байх үед амьдарч байсан Августин бол тухайн цаг үеийнхээ шашны суут онолч байв. Түүний бүтээлүүд христос шашны сургаал, дундад зууны үед улс хоорондын харилцаанд хүчтэй нөлөөлж байсан төдийгүй өнөө үед ч ач холбогдлоо алдаагүй байна.

Өнөөгийн Алжир улсын Соук-Арас буюу тэр үеийн Тагаст хотхонд 354 онд төржээ. Эцэг нь бөөгийн мөргөлтөн, эх нь христос шашинтан байсан тул түүнийг багад нь загалмайж адислаагүй ажээ.

Аль багадаа хурц оюун ухаанаараа тодорч 16 настайд нь Гардай хотод сургууль явуулахад нууц амрагтай болж тэр нь түүнд хүү төрүүлж өгчээ. 19 настайдаа гүн ухаан сонирхож 240 жилийн өмнө зохиогдсон манихейство шашны сургаалыг гүнзгий судалж эхэлсэн ч есөн жил үзсэний дараа дургүй нь хүрч больжээ.

Дараа нь 29 настайдаа Ром дараа нь Умард Итали дахь Милан хотод ирж уран илтгэгчийн профессор цол хүртэв. Платоны гүн ухааны боловсронгуй хувилбар болох Латиний гуравдугаар зуунд хөгжүүлсэн неоплатонизмийн гүн ухаантай энд танилцав.

Милан хотын сүмийн хамба лам Амброзийн айлтгалыг Августин нилээд хэдэн удаа сонсоод христосын сургаалын мөн чанарыг сая нэг ойлгожээ. Тийнхүү Августин 32 настайдаа христос шүтлэгтэн болж 387 онд хамба лам Амброзий түүнийг загалмайсны дараа төрөлх Тагаст хотхондоо буцан очжээ.

391 онд төрөлх Тагаст хотхоноос нь 45 бээрийн зайтай орших Гиппон, одоогийн Аннаба хотын сүмийн хамба ламын туслах болоод, түүнийг таван жилийн дараа нас барахад, оронд нь 42 настайдаа хамба ламаар өргөмжлөгдөж ертөнцийн мөнх бусыг үзүүлэх хүртлээ зүтгэжээ.

Гиппон хөдөөгийн хот байсан ч Августин үйл ажиллагаагаараа христос шашны нөлөө бүхий

зүтгэлтэн болон алдаршжээ. Бие сул дорой, хараа муутай хүн байсан ч хурдан бичээчийн ачаар шашны маш олон бүтээл туурвисан юм. Түүний бичсэн таван зуун гаруй айлтгал, хоёр зуу шахам захидал бидний өнөө үед хадгалагдан иржээ. Түүний бүтээлүүдээс "Бурхны хотын тухай", намтар зохиол болох "Нүглээ наминчлах нь" ном нь хамгийн алдартайд тооцогддог.

Түүний бичсэн захидал, айлтгалууд нь манихейсто сургаал, донатизм (христос шашинтнуудыг хагалан бутаргах зорилго бүхий бүлэглэлийн үзэл), пелагианство (христос шашны тухайн үеийн бас нэг тэрс үзэл) зэрэг харш үзэл баримтлалыг илчлэн шүүмжлэхэд чиглэгдэж байлаа. Ялангуяа пелагианство сургаалыг буруушаан маргасан нь Августиний шашны сургаалын гол хэсэг болно. Пелагий бол 400 оны үед Ромд ирж шашны хэд хэдэн сонирхолтой сургаал айлдсан английн лам аж. Хүн бүр анхнаасаа нүгэлтэй байдаггүй, иймд сайн болон муу үйлсийн аль нэгийг сайн дураараа сонгох эрхтэй, аливаа хүн шударга амьдрал, хичээнгүй хөдөлмөр зүтгэлээрээ нүглээ наманчилж болно гэж Пелагий лам номлодог байжээ.

Августиний бүтээлийн нөлөөгөөр Пелагийн үзэл бодлыг тэрс гэж үзэж түүнийг Ромоос хөөж шашны үйл ажиллагаа эрхлэхийг нь хорьжээ. Бүх хүмүүст Адамын үйлдсэн нүгэл хамааралтай, хүмүүс дан ганц хүчин чармайлт хичээнгүй зүтгэлээрээ нүглээс ангижрахгүй, хамгийн гол нь Бурхны өршөөл хэрэгтэй гэж амгалан Августин гэж айлдаж байв.

Иймэрхүү үзэл бодол урьд нь байсан ч Августин энэ айлтгалыг хүмүүсийн ой тойнд хүртэл ойлгуулж чадсан юм.

Бурхан хүнийг өршөөх эсэхээ мэднэ, тийм учраас зарим хүмүүсийн өршөөгдөх нь урьдаас тодорхойлогдсон байдаг гэж Августин нотлож байв.

Энэхүү урьдаас тодорхойлогдсон байх үзэл санаа нь дараа үеийн шашны онолчид түүний дотор Жан Кальвинд ихээхэн нөлөө үзүүлсэн билээ.

Хүйсийн талаар Августиний баримталж байсан байр суурь маш чухал.

Христос шашны шүтлэгтэн болоод эр эмийн жаргал эдлэхээс татгалзахаар шийдсэн ч амьдрал дээр маш хэцүү байжээ. Тэр тухайгаа "Нүглээ наманчилах нь" бүтээлдээ дэлгэрэнгүй бичсэн бий. Хүйсийн талаархи түүний үзэл баримтлал дундад зууны үед маш чухал нөлөөтэй байжээ.

Августиний амьдарч байх үед Ромын эзэнт улс түргэн мөхөж нийслэл хот нь 410 онд вестготуудад эзлэгджээ. Нийслэл хотод үлдсэн бөөгийн мөргөлтнүүд христос шашныг хүчээр сурталчилж байсан учир аргагүйн эрхэнд эрт дээр үеэс шүтэн биширч ирсэн бурхадаасаа татгалзах болсон гэж өөрсдийгөө цагаатгахыг оролдож байжээ. Иймд "Бурхны хотын тухай" номоо христос шашныг шийтгэлээс хамгаалах зорилгоор туурвижээ. Гэхдээ энэ номонд Европ тивийн цаашдын хөгжилд нөлөө үзүүлсэн гүн ухааны сургаалаа айлджээ. Ромын эзэнт улс бол ямар нэгэн чухал үндэс суурь биш ээ, Ром төдийгүй дэлхийн аль ч хот бүхний үндэс байгаагүй юм, хамгийн гол нь "тэнгэрийн хотын" хөгжилт буюу хүн төрөлхтөний оюун санааны дэвшил юм, энэхүү дэвшлийг тээгч нь шашин юм, ("Шашнаас өөр аврагч байхгүй") иймд хамба лам, шашин бол бөөгийн шүтлэгтэн, христос шашинтан хаадаас илүү чухал гэж

Августин сургасан билээ.

Ийнхүү Августин нь аливаа улс орныг тодорхой хугацаанд удирдаж буй хүмүүс хэн ч байлаа хамба ламд захирагдах ёстой гэсэн үзэл санааг дэвшүүлжээ. Дундад зууны үеийн хамба лам нар Августиний дээрх үзэл санааг үйл ажиллагаандаа удирдлага болгосноор шашин, төр хоорондын он удаан жилийн зөрчилдөөнийг эцэс болгох эхлэлийг тавьж европ тивийн дараачийн олон зууны түүхийн мөн чанарыг урьдчилан илэрхийлсэн билээ.

Түүний бүтээлүүд нь грекийн гүн ухааны зарим үзэл санааг дундад зууны европ тивд дэлгэрүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэсэн, ялангуяа неоплатинизмийг судалж байснаар дундад зууны христос шашны гүн ухаанд дам нөлөө үзүүлжээ. Августин нь Декартаас аль түрүүнд “Би сэтгэн бодож байна, тиймд би амьдарч байна.” гэсэн айлтгалыг өөр үгээр илэрхийлж байсныг дурдахад илүүц биш биз ээ.

Августин бол дундад зууны өмнөх христосын шашны аугаа онолч байсан болохоор сүм хийд түүний сургаалыг дундад зууны турш бараг хэвээр нь баримтлаж байжээ. Августин бол ромын католик шашны хамгийн суут онолч байсан болохоор түүний бүтээлийг өргөн дэлгэр хаа сайгүй уншин судалдаг байв. Өршөөл, хүйс зэрэг олон асуудлаархи Августиний үзэл бодол түүхэнд маргашгүй их нөлөө үзүүлсэн юм.

Амгалан Августин 430 онд 76 насандаа Гиппон хотод өөд болжээ. Задран бутарч байгаа Ромын эзэнт гүрэнд халдан довтолсон бүдүүлэг омгийнхон нийслэл хотыг нь эзлэн түрэмгийлж галдан шатаахад Августиний номын сан, сүм азаар сүйдсэнгүй өнгөрчээ.



# 55. Ульям Гарвей

(WILLIAM HARVEY)

1578 -1657



Цусны эргэлт, зүрхний үйл ажиллагааг нээсэн английн суут эрдэмтэн Ульям Гарвей Фолькстоун хотод 1578 онд төржээ. Түүний 1628 онд хэвлүүлсэн "Амьтны зүрх, цусны хөдөлгөөний тухай анатомийн судалгаа" номыг физиологийн шинжлэх ухааны түүхэн дэхь хамгийн чухал ном гэж зүй ёсоор үздэг юм. Чухамдаа тэр ном орчин үеийн физиологийн шинжлэх ухааны эхлэл болсон ажээ. Хүний биеийн үйл ажиллагааны тухай суурь ойлголтуудыг гаргаж тавьсанд энэ номын гол ач холбогдол оршино.

Өнөөдөр цусны эргэлтийн тухай хүн бүр мэддэг болохоор У.Гарвейгийн нээлт энгийн юм шиг санагдаж магадгүй. Гэтэл энэ ойлголт өнгөрсөн зуунуудад биологчдын хувьд "харанхуй" асуудал байжээ. Тэр үеийн тэргүүлэх биологчид "Нэгдүгээрт хоол зүрхэнд цус болон хувиран шингэдэг, хоёрдугаарт зүрх цусыг халаадаг, гуравдугаарт артерийн судсанд агаар дүүрэн байдаг, дөрөвдүгээрт зүрх "амьдралын үзэл оюун санаа" болдог, тавдугаарт артери, вений судсанд цус дүүрч зүрх рүү очоод буцан ирдэг." гэж тайлбарлаж байв.

Олон удаа хагалгаа биечлэн хийж зүрх, цусны гүйдлийн тухай зохиол бүтээл бичиж байсан эртний алдарт эрдэмтэн Гален цус эргэлддэг тухай огт таамаглаагүй билээ. Аристотель биологийн шинжлэх ухааныг судалдаг байсан ч тэр тухай бас ер мэдээгүй өнгөрчээ. Тэр ч байтугай У.Гарвейн ном хэвлэгдсэний дараа ч хүний биед цус судсаар тасралтгүй битүү тойргоор эргэлдэж байдаг, зүрх нь цус эргэлдэх эрчим хүчийг хангаж байдаг гэсэн нээлтийг дийлэнх эмч нар удтал хүлээн зөвшөөрөхгүй байлаа.

Цус эргэлддэг тухай ойлголтыг У.Гарвей математик тооцоо хийж анх нээсэн билээ. Зүрх цохих бүртгээ 2 унц (1 унц нь 29,8 граммтай тэнцэнэ.) хэмжээний цус шахдаг, зүрх минутанд ойролцоогоор 72 удаа цохидог болохоор цагт 540 фунт орчим цус шахна. Гэтэл ийм жинтэй цус нь хүний нийт биеийн жингээс илүү байна, тэгэхлээр цус зүрхээр дамжин эргэлддэг юм байна гэсэн таамаглалыг У.Гарвей хийжээ. Таамаглалаа нотлохын тулд бараг есөн жил

туршилт ажиглалт хийж, цус зүрхээр дамжин эргэлдэг гэсэн алдарт дүгнэлтээ гаргажээ.

Тэрбээр номондоо цус зүрхнээс артерийн судсаар гүйж зүрх рүү венийн судсаар буцан очдог гэж тод тодорхой бичжээ. Микроскоп гараагүй үе байсан болохоор артерийн судаснаас цус нарийхан судсаар гүйж венийн судсанд орж байгааг олж харж чадаагүй ч тийм нарийхан судас байгааг яг таг тодорхойлсон билээ. Капилляр буюу нарийн судас байдгийг италийн биологич Мальпиги түүнийг нас барснаас хэдэн жилийн дараа нээсэн юм.

Цусыг артерийн судас руу шахах нь зүрхний гол үүрэг гэж У.Гарвей баталсан нь бодит үнэн байв. Дэвшүүлсэн онолоо маргашгүй үнэн болохыг нь нотолсон туршилт судалгааны тоймгүй их материалыг олон нийтэд дэлгэн үзүүлэв. Түүний онолыг анхандаа шууд эсэргүүцэж байсан бол амьдралынх нь сүүлийн жилүүдэд бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн байна.

Эс судлалын талаар У.Ганьейн бичсэн ном нь цусны эргэлтийн тухай онолтой нь харьцуулахад ач холбогдлын хувьд бага ч мөн л шинжлэх ухаанд ихээхэн дэвшил болсон юм. 1651 онд хэвлүүлсэн "Амьтад хэрхэн төрдөг тухай" ном нь орчин үеийн эс судлалын шинжлэх ухааны эх суурийг тавьсан байна. Үзэл бодолд нь хүчтэй нөлөө үзүүлсэн Аристотелийн адил У.Гарвей эмбрион нь хөгжлийнхөө эхэн үе шатуудад насанд хүрсэн амьтан шигээ, яг түүн шиг гэхдээ арай бага хэмжээний бүтэцтэй байдаг гэсэн урьдчилсан төлөвшилтийн тухай таамаглалыг буруушаан эсэргүүцэж эмбрионий эцсийн бүтэц аажимдаа төлөвцдөг гэж нотолж байлаа.

У.Гарвей нь урт удаан, маш сонирхолтой амьдрал туулсан эрдэмтэн юм. Идэр залуудаа Кембрижийн их сургуулийн дэргэдэх коллежид суралцаж 1600 онд Итали улсад очиж тухайн үедээ эмнэлгийн шилдэг сургууль гэж тооцогдож байсан Падун хотын их сургуульд анагаах ухаанд суралцжээ. Тэр үед алдарт эрдэмтэн Галилей Падуны их сургуульд профессороор ажиллаж байсан бөгөөд тэд тааралдаж байсан эсэх нь бүү мэд. 1602 онд эмчийн мэргэжил эзэмшиж Англид буцан иржээ. Түүний эмчилж байсан өвчтөний дотор английн хоёр хаан (нэгдүгээр Яков, нэгдүгээр Карл), алдарт гүн ухаантан Фрэнсис Бэкон нар байв.

У.Гарвей хувийн эмнэлэгтээ ажиллахын зэрэгцээ Лондон хот дахь Ариун Варфоломейн эмнэлгийн ерөнхий эмчээр томилогдон давхар ажиллаж байв. 1628 онд цусны эргэлтийн тухай ном нь хэвлэгдсэний дараа алдар нэр нь европ даяар түгжээ. Эхнэр авсан ч хүүхэдгүй байв. 1657 онд Лондон хотод 79 настайдаа өөд болжээ.

# 56. Эрнест Резерфорд

(ERNIST RETHERFORT)

1871-1937



Эрнест Резерфорд нь хорьдугаар зууны суут туршилтын физикч гэсэн алдрыг зүй ёсоор хүртсэн аугаа эрдэмтэн билээ. Цацраг идэвхт чанарын тухай бидний мэдлэгийг өргөжүүлсэн төдийгүй цөмийн физикийн эх суурийг тавьсан билээ. Түүний хийсэн нээлтүүд нь онолын хувьд үлэмж их ач холбогдолтой төдийгүй цөмийн зэвсэг, атомын цахилгаан станц, цацраг идэвхт чанар, цацрагийн судалгаа гээд олон салбарт ихээхэн үр дүн өгсөн билээ. Түүний нээлтүүдийн хүн төрөлхтөнд үзүүлж байгаа нөлөө маргашгүй их ба ирээдүйд ч улам өсөх нь мэдээж юм.

Шинэ Зеланд улсад төрж Кентерберийн коллежид элсэн суралцаж 23 настайдаа хүмүүнлэгийн ухааны, байгалийн шинжлэх ухааны бакалавр бас хүмүүнлэгийн ухааны магистрын зэрэг хамгаалжээ. Дараа нь Англид Кембрижийн их сургуульд суралцах эрхээр шагнуулж тухайн цаг үеийн нэрт эрдэмтний нэг болох Ж.Томсоны удирдлага дор гурван жил судлаач-оюутан байв. 27 настайдаа Канадын Макжилийн их сургуульд физикийн профессор болж есөн жил ажиллаад 1907 онд Англид буцан ирж Манчестерийн их сургуульд физикийн факультетийг толгойлов. 1919 онд Кембрижийн их сургуульд Кавендишийн лабораторийн удирдагчаар томилогдож тэндээ нас бартлаа ажиллажээ.

Францийн эрдэмтэн А.А.Беккерель ураны нэгдлийн туршилт хийж байгаад 1896 онд цацраг идэвх чанарыг анх нээжээ. Гэвч Беккерель түүнийг яагаад ч юм судлахаа больж цацраг идэвхт чанарыг тухай гол нээлтийг Резерфорд өргөн дэлгэр судалгаа хийж нээсэн юм. (Гэр бүл эрдэмтэн Мари, Пьер нар полоний, радий гэсэн цацраг идэвхт хоёр бодисыг нээсэн ч онцгой ач холбогдолтой нээлт хийгээгүй.) Резерфорд ураны цацраг идэвхт чанар нь альфа ба бета гэсэн хоёр цацрагаас бүрдэнэ гэсэн нээлт хийсэн нь түүний анхны том амжилт байв. Дараа нь цацраг идэвхт чанарын хоёр цацраг тус бүрийн мөн чанарыг (Хурдатгалтай хөдөлж буй бөөмсөөс бүрдэнэ.) тодорхойлсон төдийгүй бас гурав дахь хэсэгтэй гэдгийг мөн нээж

гамма цацраг гэж нэрлэжээ.

Цацраг идэвхт чанарын чухал шинж чанар нь түүнтэй холбоотой эрчим хүч юм. Беккерель, гэр бүл Кюри болон бусад олон эрдэмтэн эрчим хүчийг гадаад эх сурвалжтай гэж үзэж байлаа. Гэтэл Резерфорд ураны зарим атомын үйлчлэлээс ялгарч байгаа эрчим хүч нь химийн урвалын үед чөлөөлөгдөж байгаа эрчим хүчнээс зүйрлүүлэшгүй их юм гэдгийг нотолж атомын эрчим хүчний асуудлаархи чухал онолын үндсийг тавьсан юм.

Тодорхой атомууд нь хуваагдашгүй, өөрчлөгдөшгүй гэж эрдэмтэд эрт дээр үеэс үзэж байлаа. Гэтэл Резерфорд авьяаслаг туслах Фредерик

Соддийн хамт, атом нь альфа болон бета цацраг цацруулж байгаа үедээ өөр төрлийн атом болон хувирч байдаг гэсэн дүгнэлт хийв. Химичид энэ дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнгүй.

Гэвч Резерфорд, Содди нар цацраг идэвхт задралын цуврал туршилт хийж ураныг хар тугалга болгон хувиргаж тэрчилэн задрах хурдыг нь хэмжиж маш чухал болох “хагас задралын” томъёоллыг тодорхойлжээ.

Үүний үр дүнд өндөр ач холбогдол бүхий шинжлэх ухааны хэрэгслийн нэг болох цацраг идэвхт чанарын техник үүсэхэд хүргэж түүнийг геологи, хуучны судлал, одон орон зэрэг олон салбарт өргөн дэлгэр хэрэглэх болсон билээ.

Э.Резерфорд ийнхүү цуврал нээлт хийсэн учир 1908 онд Нобелийн шагнал хүртсэн ба хожим нь хамтран зүтгэгч Содди нь мөн шагналыг авчээ. Э.Резерфорд хурдатгалтай хөдөлж байгаа альфа-цацраг маш нимгэн алтан ялтсаар нэвт гарах чадвартай ба гэхдээ замаасаа бага зэрэг хазайж байгааг ажиглажээ. Алтны “бильярдны бяцхан бөмбөлөг” шиг хатуу, үл нэвтрүүлэгч гэгддэг атом нь дотроо зөөлөн байдаг байх гэсэн таамаглал дэвшүүллээ. Альфа цацраг нь алтны атом дундуур төмрийг нэвгэлж байгаа шиг асар хурдтай сум мэт чөлөөтэй нэвтрэн өнгөрч чадаж байна гэсэн дүгнэлтийг мөн хийв.

Гэвч Э.Резерфорд шинэ залуу туслах Гейгер, Марсден нартайгаа цуг туршилт хийх явцдаа зарим альфа бөөм алтны ялтсыг нэвглэн гарахдаа чиглэлээ ихээхэн өөрчилж байгаа болон зарим нь бүр буцан эргэж байгааг илрүүлэв. Тэд энд ямар нэгэн чухал зүйл байгааг мэдэрч чиглэл бүрт нисэж байгаа бөөмсийг тоог гаргалаа. Нарийн, нягт нямбай математик тооцоо хийж алтны атом нь бараг хоосон орон зайгаас бүтэж байна, уг атомын бүх жин нь голд нь байгаа атомын "цөмд" төвлөрсөн байна гэж нотоллоо.

Ийнхүү Э.Резерфор ертөнцийн тухай хүн төрөлхтөний ойлголтыг ганц цохилтоор өөрчлөв! Ухаандаа хамгийн хатуу гэж тооцогдох металлын атом үндсэндээ хоосон орон зайнаас бүтэж байгаа болохоор жинтэй бодитой гэж хүн төрөлхтөний үзэж байсан бүх зүйл гэнэт хязгааргүй орон зайд ийш тийш гүйлдэх өчүүхэн жижиг зүйл болж таарлаа.

Атомын цөмийн тухай Э.Резерфордын нээлт нь атомын бүтцийн тухай орчин үеийн бүх онолын үндэс болж байна. Алдарт эрдэмтэн Нильс Бор атом нь квант механикийн хуулиар удирдуулдаг бяцхан нарны систем болох тухай цуут бүтээлээ хэвлүүлэхдээ загвар болгож Резерфордын цөмийн онолыг ашигласан байна. Тэрчилэн Гейзенберг, Шрёдингер нар

сонгодог болон долгионы механикийг ашиглан атомын бүтцийн илүү нарийн төвөгтэй загвар бүтээхдээ мөн Резерфордын онолыг үндэс суурь болгосон байна.

Э.Резерфордын нээлт нь шинжлэх ухааны шинэ салбар болох атомын цөмийн салбарыг бий болгожээ. 1919 онд хурдатгалтай хөдөлж байгаа альфа цацрагуудыг буудах аргаар азотын цөмийг хүчилтөрөгчийн цөм болгон хувиргасан гавьяатай билээ.

Цөмийн өөрчлөлтүүд нь Нарны эрчим хүчний эх булаг байж болох нь төдсөнгүй нотлогдлоо. Түүнээс гадна атомын цөмийн өөрчлөлтүүд нь атомын зэвсэг үйлдвэрлэх, атомын цахилгаан станц байгуулах үндэс суурь болсон юм.

Э.Резерфорд нь хувь хүнийхээ хувьд чанга дуу хоолойтой, амьдрах урам зориг бялхсан, том бие бялдартай, атаархам ажилсаг хүн байжээ.

# 57. Жан Кальвин

(JONH CALVIN)

1509-1564



Үнэн алдартны шашны цуутай онолч Жан Кальвин бол европийн түүхийн суут хүмүүсийн нэг мөн. Шашин, улс орныг удирдах, хувь хүний ёс суртахуун зэрэг олон асуудлаархи түүний үзэл бодол дөрвөн зуу гаруй жилийн туршид олон сая хүний амьдралд шууд нөлөө үзүүлсэн юм.

Жан Кальвин (жинхэнэ нэр нь Жан Коувин) Францийн Нуайон хотод 1509 онд төрж Париж хотын де Монтегюгийн коллеж төгсөөд Орлеан хотын их сургуульд орж хууль зүй судалжээ. Дараа нь Бурже хотод хууль зүйн мэдлэгээ дээшлүүлсэн байна.

Дөнгөж найман настай байхад шашны их онолч Мартин Лютер Виттенберг хотын сүмийн үүдэнд алдарт 95 сэдвээ өлгөж үнэн алдартны шашны Шинэчлэлийн эх суурийг тавьсан байлаа. Ж.Кальвин католик шашин шүтдэг гэр бүлд төрсөн ч үнэн алдартны шашинд оржээ. Хавчин гадуурхалтыг тэсэхээ байж Париж хотоос зугтаж хэсэг аялал хийсний дараа Швейцарийн Базель хотод сууршижээ. Тэнд нууц нэрээр амь-дарч шашны ухааныг гүнзгий судалж алдарт "Христос шашны байгууллагууд" номоо бичжээ. Үнэн алдартны шашны гол үзэл бодлыг ойлгомжтой хэлбэрт оруулан эмхэтгэсэн энэ ном нь 1536 онд хэвлэгдсэнээр Ж.Кальвин нэрд гарчээ.

Хожим нь үнэн алдартны шашин өргөн дэлгэрч байгаа Женев хотод 1536 онд очсон ч хотын хүн амтай маргалдсанаас болж хөөгджээ. Гэвч 1541 онд урихад нь Женев хотод буцан ирж тус хотын шашны төдийгүй улс төрийн удирдагчаар өргөмжлөгдөж 1564 онд өөд болох хүртлээ амьдарчээ.

Женевт байхдаа тус хотын улс төрийн эрх мэдлийг атгадаг 25 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийн гишүүн биш байсан ч үнэндээ бол хотын бүх үйл ажиллагааг ганцаараа удирдан чиглүүлж байжээ.

Женев хот түүний удирдлага, нөлөөний дор үнэн алдартны шашны Европ тив дэх тэргүүлэх төв болсон ба тус хотыг "үнэн алдартны шашны Ром" гэж нэрлэж байлаа. Бусад оронд ч үнэн алдартны шашныг улам өргөн дэлгэрүүлэх талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байв. Хотын шинэчлэгдсэн сүмийн үйл ажиллагааг зохицуулсан хэд хэдэн дүрэм зохиосныг нь Европийн бусад шинэчлэгдсэн сүм хийд үлгэр болгон авч хэрэглэжээ. Женев хотод байхдаа шашны хэд хэдэн айлтгал бичиж "Христосын шашны байгууллагууд" номоо үргэлжлүүлэн гүйцээжээ. Түүнээс гадна шашны асуудлаар лекц, яриа байнга хийж Библийн судрыг дэлгэрэнгүй тайлбарлаж байжээ.

Тэрчилэн ёс суртахууны асуудлыг өндөрт тавьж байсны ачаар гэр бүлийн хүнээ араар нь тавих, садарлан янаглах төдийгүй мөрийтэй тоглоом тоглох, архи дан согтуурах, шалиг үгтэй дуу дуулах явдлыг гэмт хэрэг гэж үзэж хатуу шийтгэл ногдуулдаг байжээ. Түүнээс гадна тусгай хууль гаргаж хотын бүх иргэн тогтсон цаг сүмд ирж мөргөл үйлдэж айлтгал сонсдог журам тогтоожээ. Ажил хөдөлмөрт зүтгэл санаачилгатай хандаж явдлыг урамшуулан сайшааж бичиг үсэгт сургах, боловсролд онцгой анхаарал тавьж байсан ба Женевийн их сургуулийг санаачлан байгуулжээ.

Ж.Кальвин тэрс үзэлтэй хүмүүсийг хавчин гадуурхаж, хатуу шийтгэдэг байсан юм. Үнэн алдартны шашинд үл итгэдэг испанийн иргэн, эмч, шашны онолч Мигель Серветийг Женев хотод ирэхэд нь баривчилж тэрс номтон гэж шүүж түүдэг галд шатааж шийтгэсэн удаатай.

1564 онд Женев хотод нас барсан, эхнэр нь 1549 онд, ганц хүүхэд нь төрөхдөө өөд болжээ.

Ж.Кальвин бол Библийн судрын нэр хүнд, ач холбогдлыг өндөрт өргөж М.Лютерийн адил Ромын католик сүм хийдээс татгалзсан юм. Ж.Кальвин нь Амгалан Августин, Гэгээн Павелийн адил бүх хүмүүс нүгэлтэй, нүглээсээ ангижрахын тулд шургуу хөдөлмөр, хичээнгүй зүтгэл биш гүн итгэл үнэмшилтэй байх хэрэгтэй гэж үзэж байв. Түүний номлосон өршөөл үзүүлэх эсэх нь урьдаас тодорхойлогдсон байдаг болон шийтгэлийн тухай айлтгал нь маш чухал байлаа. Бурхан хүний гавьяа зүтгэлийг эс анхаарч хэнд өршөөл үзүүлэх, хэнийг шийтгэхээ урьдаас тодорхойлсон байдаг гэж сургаж байлаа. Хэрэвзээ тийм бол хүн ёс суртахууныг дээдлэх хэрэг байна уу гэсэн сөрөг асуулт тавигдахад "Хичээнгүй зүтгэлээр нүглээс ангижрахгүй, хамгийн гол нь Бурхны өршөөл хэрэгтэй гэж сонгосон хүмүүс л зөв ариун ёс суртахуунтай амьдрах ёстой, бид сайн үйлс бүтээж байгаа учир өршөөгдөж байгаа юм биш, харин бид өршөөгдөхөөр сонгогдсон учраас сайн үйл бүтээж байгаа юм." гэж сургасан. Энэ айлтгал нь түүний үзэл бодлыг хүлээн зөвшөөрөн дагадаг шүтлэгтэнгүүдийг өндөр ёс суртахууныг дээдлэн амьдрахад зоригжуулж байжээ.

Ж.Кальвиний шашны үзэл номлол дэлхий ертөнцийн хөгжилд зүйргүй их нөлөө үзүүлсэн ба түүний сургаалийг дэмжигчид М.Лютерийн дэмжигчдээс илүү байжээ. Гэвч Герман, Скандинавын орнууд М.Лютерийн номлолыг дагадаг болсон бол Швейцар, Нидерландын ард түмнүүд Ж.Кальвиний номлолыг шүтэгчид болжээ. Түүнээс гадна Польш, Унгар, Герман, Шотланд, Франц, Англид зэрэг орнуудад Ж.Кальвиний номлолыг дагагчид цөөн тоотой ч гэсэн байсан юм. Тэр ч байтугай АНУд ч Ж.Кальвиний номлол урт удаан хугацааны нөлөө үзүүлсэн билээ.

Түүнийг Женев хотод үйл ажиллагаа явуулж байх үед ардчиллаас илүү шашны үзэл бодол

ноёлож байсан ч эцсийн дүндээ түүний номлол ардчиллын үзэл санааг улам дэлгэрүүлсэн гавьяатай юм.

Түүний номлол нь "үнэн алдартны шашны ёс суртахуун" бий болох, капитализмын хөгжилд гол хүчин зүйл болсон гэж үздэг хүмүүс бас бий.

Үнэн алдартны шашинд Шинэчлэл хийсэн нь түүхэн чухал ач холбогдолтой үйл явдал болсон ба үүнд хамгийн гол үүргийг Мартин Лютер гүйцэтгэсэн юм. Ж.Кальвин бол түүний дараа түүхэн тавцанд гарч ирсэн үнэн алдартны шашны хөгжилд гайхамшигтай нөлөө үзүүлсэн онолчдын нэг байсныг тэмдэглэх нь зүйтэй юм.



# 58. Грегор Мендель

(GREGOR MENDEL)

1822-1884



Грегор Мендель бол удамшлын үндсэн зарчмуудыг нээсэн суут хүн юм. Гэвч шинжлэх ухааны ертөнц түүний гайхамшигт судалгааг нь эс тоож байсны уршгаар лам, сонирхогч эрдэмтэн байдлаар насаа элээжээ.

1882 онд Хейнзендорф хотод тэр үед Австрийн эзэнт улсын нутаг дэвсгэрт, одоогийн Чех улсад төржээ. 1843 онд тэр үед Австрийн Брюнне, одоогийн Чехийн Брно хотод үнэн алдартны шашны сургуульд элсэн орж 1847 онд лам болж 1850 онд багш болох шалгалт өгсөн ч биологи, геологийн хичээлд унаж үнэмлэх авч чадаагүй байна. Гэвч сүмийн хамба лам нь түүнийг Венийн их сургуульд суралцуулахаар илгээжээ.

Мендель 1851-1853 онуудад математик, байгалийн ухаан судалж багшийн үнэмлэх авч чадаагүй ч 1854-1868 онуудад Брюнн хотын Шинэ сургуульд байгалийн ухааны ээлжийн багшийн ажил эрхэлжээ.

1856 оноос эхлэн шинэ ургамал бий болгох цуутай туршилтаа эхэлж 1865 онд удамшлын хуулиудаа нээж Брюнне хотын байгалийн түүхийн нийгэмлэгт танилцуулжээ. 1866 онд түүний туршилтын үр дүнг дээрх нийгэмлэг тогтомол гаргадаг сэтгүүлийнхээ нэг дугаарт "Ургамлыг эрлийзжүүлэх туршилтууд" нэртэй хэвлэжээ. Хоёр дахь илтгэл нь гурван жилийн дараа мөн сэтгүүлд хэвлэгдэв. Гэвч энэхүү нийгэмлэг нь орон нутгийн хэмжээний байгууллага байсан болохоор том номын сангууд тогтмол гаргадаг сэтгүүлүүдийг нь захиалан авдаггүй байжээ.

Тиймд Г.Мендель хийсэн туршилтийнхаа үр дүнг тухайн үеийн удамшлын асуудлаар хамгийн нэр хүндтэй эрдэмтэн Карл Негелид явуулсан ч цаадахь нь түүний нээлтийг ойлгосонгүй өнгөрчээ. Ийнхүү гайхамшигт нээлтийг хэн ч тоосонгүй, гучин жил өнгөрчээ.

1868 онд сүмийн захиргааны түшмэлээр томилогдсоноос хойш ургамлын туршилтаа үргэлжлүүлэх цаг завгүй байсаар 1884 онд 61 настайдаа шинжлэх ухааны салбарт хийсэн аугаа нээлтээ хүлээн зөвшөөрүүлж амжилгүй нас баржээ.

Гурван эрдэмтэн (Голландын иргэн Хуго Де Фриз, германы эрдэмтэн Карл Корренс, австрийн эрдэмтэн Эрих фон Чермак) тус тусдаа туршилт, судалгаа хийж байгаад удамшлын хуулиудыг бие биенээсээ салангид нээжээ. Тэр гурван эрдэмтэн туршилтынхаа дүнг нийтлүүлэхийн өмнө энэ асуудлаар бичсэн зохиол бүтээл хэвлэгдсэн эсэхийг хайж байгаад гурвуулаа Менделийн илтгэлийг 1900 онд олж уншихад гаргасан дүгнэлт нь яг таг таарч байгааг мэдээд мэл гайхаж байжээ.

Английн эрдэмтэн Уильям Бейтсон мөн илтгэлийг олж олон нийтэд танилцуулснаар Г.Менделийн нээлтийг шинжлэх ухааны ертөнц албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байна.

Г.Мендель бүх амьд бие махбодид өнөө үед ген гэж нэрлэгддэг суурь хэсгүүд байдаг ба түүний тусламжтайгаар эцэг, эхийнх нь удамшлын шинж чанарууд дараагийн үе удамд нь дамжин очдог гэдгийг хамгаас түрүүнд мэдсэн юм. Түүний туршилт хийж байсан ургамлуудад үрийн өнгө, навчны хэлбэр гэх зэрэг тухайн ургамлын өвөрмөц шинж чанар бүр нь хоёрхон генээр тодорхойлогдож байгаа болон тухайн ургамал бүр эцэг, эхээсээ нэг нэг генийг нь удамшуулан авч байгаа нь илэрчээ. Тухайн өвөрмөц шинж чанарыг удамшуулан дамжуулж байгаа хоёр ген нь голлох генийн нөлөөгөөр л бие биенээсээ ялгагдаж байдаг, гэхдээ нөгөө ген нь устаж алга болдоггүй, дараачийн үе удмууддаа дахин илэрч байгааг Г.Мендель мөн туршилтын явцад нээсэн байна.

Дахин сэргэгч эс буюу гамета нь (хүнийхээр бол хүний бие махбодид байдаг сперматозоид буюу өндгөн эс) хос бүрийн зөвхөн ганц генийг агуулж байгааг Г.Мендель бас ойлгосон. Тухайн ген нь ямар гаметад илэрч үе удамдаа дамжих нь санамсаргүй тохиолдол болохыг мөн тогтоосон юм.

Ийнхүү түүний нээсэн хуулиуд нь багахан шинэчлэгдсэн ч орчин үеийн удамшлын шинжлэх ухааны эх суурь болсон юм. Сонирхогч эрдэмтэн хэрхэн яаж ийм аугаа нээлт хийсэн нь их сонирхол татна. Г.Мендель туршилт хийхдээ удамшлын өвөрмөц шинж чанар нь гоц тодорхой илэрдэг генүүдтэй ургамлуудыг "санамсаргүй" сонгож авсан байна. Түүнээс гадна ядарч цуцахыг мэдэхгүй ажилсаг, атаархам тэвчээртэй туршигч эрдэмтэн байсныг нь 21 мянган ургамалд туршилт хийж түүнийхээ үр дүнг нягт нямбай тэмдэглэж статистик тооцоо хийж байсан нь нотолдог.

Чухамдаа статистик тооцоонд дүгнэлт хийснээр удамшлын хуулиудыг нээсэн байна.

Удамшлын хуулиуд нь хүний мэдлэгийг хүрээг улам өргөжүүлсэн ба эдгээр хуулиудын ач холбогдол өнөөдрөөс илүү ирээдүйд практик үр дүнтэй байх нь мэдээж хэрэг юм.

# 59. Макс Планк

(MAX PLANCK)

1858-1947



Германы эрдэмтэн Макс Планк 1900 оны 12 дугаар сард гэрлийн энерги (гэрлийн долгионы энерги) байнгын урсгал биш чухамдаа квант гэж нэрлэгдэх хэсгүүдээс бүрдэнэ гэсэн зоримог таамаглал дэвшүүлж шинжлэх ухааны ертөнцийг шуугиулсан билээ. Гэрлийн болон цахилгаан соронзонгийн сонгодог онолтой эрс зөрчилдсэн энэхүү таамаглал нь физикийн шинжлэх ухаанд хувьсгал болж матери, цацрагийн мөн чанарын гүнзгий ойлголтыг төрүүлсэн квантын онолын эх суурь болсон юм.

1858 онд Германы Киль хотод төрж Берлиний их сургуульд элсэж Мюнхений их сургуульд шилжин суралцаж 21 настайдаа физикийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалжээ. Дараа нь Мюнхен, Килийн их сургуулиудад багшилж байгаад 1889 онд Берлиний их сургуулийн профессороор томилогдож 1928 онд огцрох хүртлээ ажиллажээ.

Планк бусад хэд хэдэн эрдэмтний адил тас хар биесийг (Ямар нэгэн гэрэл цацраахгүй, харин туссан гэрлийг бүрэн шингээдэг биесийг тас хар биес гэж нэрлэнэ.) халаах үед цахилгаан соронзон цацруулдаг үзэгдлийг судалдаг хар биесийн цацрагийн асуудлаар туршилт хийж байв. Туршилтын физикчид Планкаас өмнө тас хар биесийн цацрагийг хэмжиж байжээ. Гэхдээ М.Планк хар биесийн цацрааж буй цацрагийг зөв тодорхойлох харьцангуй төвөгтэй алгебрийн томъёог гаргаж чадсан юм. Өнөө үед онолын физикчид дээрх томъёоллыг ашиглаж хийж байгаа туршилтынхаа бүх тооцоог яг таг нэгтгэж чадаж байгаа юм. Гэхдээ тэр үед шинэ таамаглал дэвшигдсэнээр физикийн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хуулиуд нь шал өөр томъёоллыг шаардах нь тэр.

Энэ асуудлыг М.Планк гүнзгий судалж гэрлийн энерги нь квант гэж нэрлэсэн эгэл бөөмсийн тодорхой хэд дахин давтагдсан тоогоор цацраг гаргадаг юм гэсэн шинэ онолыг дэвшүүлэн гаргасан юм. Квантын онолоор квантын хэмжээ нь гэрлийн (өөрөөр хэлбэл гэрлийн өнгө нь)

давгамжтай, тэрчилэн бид одоо Планкийн тогтмол  $h$  гэж нэрлэдэг, товчоор  $h$  гэж томъёолдог физикийн хэмжигдэхүүнтэй шууд хамааралтай гэсэн таамаглал нь физикийн урьдын үзэл баримтлалтай бүрэн зөрчилдсөн.

Гэхдээ Планкийн тогтмол  $h$  ашиглан хар биесийн цацрагийн зөв томъёоллын онолын үндэслэлийг гаргаж болж байлаа.

Физикийн шинжлэх ухаанд эргэлт болсон түүний таамаглалыг дийлэнх физикч анхандаа азтай математик зохиомол томъёолол гэж үзэж эс тоож байв. Гэтэл квантын тухай Планкийн таамаглалыг хар биесийн цацрагийг судлах төдийгүй физикийн аливаа үзэгдлүүдийг судлахад хэрэглэж болох нь нотлогджээ. А.Эйнштейн фотогэрлийн үзэгдлийг тайлбарлахдаа 1905 онд тэрхүү таамаглалыг ашигласан бол Нильс Бор атомын бүтцийн онолыг 1913 онд дэвшүүлэн гаргахдаа мөн хэрэглэсэн байна.

Фашист үзлийг буруушаасан учир түүнийг хавчин гадуурхаж байсан төдийгүй түүний отгон хүүг нь фюрерийг алах зорилго бүхий хуйвалдаанд оролцсон гэж 1945 онд цаазалжээ. 1947 онд 89 настайдаа нас баржээ.

Квант механикийн хөгжил нь хорьдугаар зуунд Эйнштейний харьцангуйн онолоос илүү чухал шинжлэх ухааны нээлт болсон билээ. Планкийн тогтмол  $h$  нь онолын физикт амин чухал үүрэг гүйцэтгэдэг ба физикийн суурь хэдхэн тогтмолын нэг болж байдаг юм. Планкийн тогтмол  $h$  нь атомын бүтцийн онол, Гейзенбергийн тодорхойгүйн зарчим, цацрагийн онол болон шинжлэх ухааны бусад олон томъёонд бий. Планкийн тооцоолсон тогтмолын тоон утга нь өнөө үед хэрэглэж байгаа түүний тоон утгын хоёр хувийн хэмжээнд байна.

М.Планкийг квант механикийн эцэг гэж үздэг. Түүний хийсэн анхны таамаглал нь дараа үеийн физикчдэд илүү төгс онол боловсруулах бололцоог нээж өгсөн билээ.

# 60. Жозеф Листер

(JOSEPH LISTER)

1827-1912



Хагалгааны дараах халдваргүйтэлийн аргыг хэрэглэж эхэлсэн английн мэс засалч Жозеф Листер 1827 онд Аптоп хотод төрж 1952 онд Лондон хотод их сургуулийн дэргэдэх коллежид анагаах ухааны эрдэмтний зэрэг хамгаалжээ. 1861 онд Глазго хотод хааны цэргийн хээрийн эмнэлэгт мэс засалчаар томилогдон найман жил ажиллах хугацаандаа хагалгааны дараах халдваргүйтэлийн аргыг хэрэглэж байжээ.

Хааны цэргийн хээрийн эмнэлэгт ажиллаж байхдаа хагалгааны дараа үхэл дэндүү их гарч байгааг ажиглаж сэтгэл нь үлэмж их зовдог байв. Хагалгаа хийсний дараа хүний биеийн эд эс үхэх зэргээр олон айхтар халдвар бий болох нь ердийн үзэгдэл байлаа. Ингээд халдварыг багасгахын тулд хариуцсан тасагтаа ариун цэврийг дээд зэргээр сахисан ч халдвар авах явдал буурсангүй. Эмнэлэгт халдвар бий болж байгаа нь "миазм" буюу хорт ууртай холбоотой гэж олонхи эмч нар үздэгийг хүлээн зөвшөөрсөнгүй.

Элдэв нян өвчин үүсгэдэг гэсэн Луй Пастерийн онолтой Ж.Листер 1865 онд танилцаж хэрэвзээ халдвар нянгаас үүсэж байгаа юм бол хагалгааны дараа үүсэж байгаа халдварыг бүрэн арилгахын тулд элдэв нянг ил шарханд орохоос нь өмнө устгах хэрэгтэй гэсэн дүгнэлт хийжээ. Тэгээд карболын хүчлийг нян устгах хэрэгсэл болгон хэрэглэж эхэлснээр халдварыг эсэргүүцэх эмчилгээний цогц аргыг үүсгэн бий болгосон юм. Хагалгаа болгоны өмнө гараа савандан удтал угаадаг байсан төдийгүй хагалгааны бүх хэрэгсэл, хувцсыг сайтар ариутгадаг болов. Заримдаа хагалгааны өрөөнд карболын хүчил агаарт цацна. Ийм арга хэмжээний дараа хагалгааны дараах үхлийн тоо эрс цөөрч эхлэв. Эрэгтэй өвчтөнүүдийн тасагт хагалгааны дараах үхлийн хэмжээ 1861-1865 онуудад 45 хувь, 1869 онд 15 хувь болтлоо буурчээ.

Хагалгааны дараах халдваргүйтэлийн аргын тухай анхны бүтээлээ Ж.Листер 1867 онд хэвлүүлсэн ч эмч нар хүлээн авсангүй. Гэвч түүнийг 1869 онд Эдинбург хотын их сургууль

клиникийн хагалгааны тэнхимийн эрхлэгчээр урьжээ. Энд долоон жил ажиллах хугацаанд түүний алдар нэр нь дэлхий даяар түгжээ. 1875 онд Германд уригдаж нээсэн аргынхаа тухай лекц уншсан бол дараа жил нь АНУ-д уригджээ.

1877 онд Лондон хотын хааны Анагаах ухааны коллежийн клиникийн хагалгааны тэнхимийн эрхлэгчээр томилогдож 15 жил ажиллав. Нас барах үед нь түүний нээсэн аргыг бүх дэлхий даяар хэрэглэж хэвшсэн байлаа.

Ж.Листер таван жил хааны Анагаах ухааны нийгэмлэгийн ерөнхийлөгч байж Виктория хатан хааны хувийн мэс засалчаар ажиллаж байв. Эхнэртэй ч хүүхэдгүй байсан ба 85 настайдаа 1912 онд Уолмер хотод нас баржээ.

Түүний нээсэн арга нь мэс засалд хувьсгал болж олон сая хүний амь насыг аварсан юм. Өнөө үед хагалгааны дараах халдвараас шалтгаалж маш цөөхөн хүн үхэж байна гэж нотлож болохгүй. Гэхдээ хагалгааны дараах халдвар зуун жилийн өмнөх шиг аюултай байсан бол өнөөдөр хагалгааг зориглон зөвшөөрөх хүн тийм ч олон байхгүй байсан биз ээ. Тэрчилэн хагалгааны дараах халдварын аюул их байсан бол мэс засалч нар ч нарийн төвөгтэй хагалгаа хийхээс зүрхшээх байсан биз.

Хагалгааны дараах халдваргүйтэлийн орчин үеийн техник нь Ж.Листерийн аргаас ялгаатай ч гол үндэслэл нь адилхан, арга нь илүү боловсронгуй болсон юм.

Ж.Листерээс бараг хориод жилийн өмнө Унгарын эмч Игнац Земмельвейс (1818-1865) Вена хотын төв эмнэлэгт ажиллаж байхдаа хагалгааны дараах халдваргүйтэлийн аргыг эх барих зүй, мэс засалд хэрэглэж профессор цол хүртэж ном бичсэн ч олон нийтэд өргөн тархаагүй. Өнгөрчээ. Гэтэл Ж.Листер хагалгаа хийхдээ халдваргүйтэлийн аргыг байнга хэрэглэх лекц унших, ном бичих зэргээр эмнэлгийн практикт халваргүйтэлийн аргыг хэрэглэхийн ач холбогдлыг дэлхий даяар бүх эмч нар итгүүлж чадсан гавьяатай билээ.

# 61. Николаус Август Отто

(NIKOLAUS AUGUST OTTO)

1832-1891



Николай Август Отто бол 1876 онд дөрвөн шаталбарт дотоод шаталтат хөдөлгүүрийг анх бий болгосон гарамгай зохион бүтээгч юм.

Дотоод шаталтат хөдөлгүүрийг завь, мотоциклд хэрэглэж байсан ба аж үйлдвэрийн салбарт хаа сайгүй ашиглаж байв. 1939 онд анхны тийрэлтэт онгоцыг зохион бүтээх хүртэл бүх төрлийн агаарын төхөөрөмжинд Оттогийн нээсэн зарчмаар ажилладаг дотоод шаталтат хөдөлгүүрийг ашиглаж байв. Гэхдээ машиныг хөдөлгөхөд дотоод шаталтат хөдөлгүүрт ашигласан нь аугаа түүхэн үйл явдал байлаа.

Оттог хөдөлгүүрээ зохиохоос өмнө машин бүтээх гэсэн олон оролдлого байлаа. Тухайлбал Зигфрид Маркус (1875 онд), Этьен Ленуар (1862 онд), Николас Жозеф Канно (1769 онд) зэрэг зохион бүтээгчид ихээхэн амжилтад хүрч явдаг загвар хүртэл хийсэн удаатай. Гэвч жин бага, их хүчин чадлыг зэрэг хослуулсан хөдөлгүүр байхгүй байсан учраас өргөн ашиглаж болохгүй байжээ. Н.Оттог дотоод шаталтат хөдөлгүүр бүтээснээс 15 жилийн дараа Карл Бенц, Готлиб Даймлер нар бие биенээсээ тусдаа худалдахад зориулсан авсаархан машин зохион бүтээжээ. Чухамдаа тэр үеэс янз бүрийн төрлийн хөдөлгүүр хэрэглэж эхэлсэн ба ирээдүйд уурын зүтгүүртэй ч юм уу цахилгаан цэнэгээр явдаг машин бий болохыг үгүйсгэх аргагүй.

Гэвч хорьдугаар зуунд үйлдвэрлэсэн хэдэн зуун сая машины 99 хувь нь дотоод шаталтат хөдөлгүүртэй байсан юм. Ачааны тэрэг, автобус, усан хөлөг онгоцонд Н.Оттогийн зохиосон дөрвөн шаталбартай адилхан ч түлшээ өөр үе шатанд нь цацдаг дизелийн хөдөлгүүр бас ашиглаж байв.

Хувийн хөнгөн тэрэгний хэрэглээ асар их байгаад бас муу тал бий. Дуу чимээ их, агаарыг

бохирдуулна, маш их түлш гарзадна, ослын улмаас хүн үхэх шархдах явдал гарна. Гэвч хувийн хөнгөн тэрэг нь нийтийн тээврийн хэрэгслэлээс илүү ашигтай тээврийн хэрэгсэл мөн. Галт тэрэг, метро, автобустай харьцуулбал хувийн хөнгөн тэргээр дуртай газраа дуртай цагтаа очиж болно, эдлэхэд хялбар, тохилог билээ. Машин бол хүн төрөлхтөний соёл иргэншилд маш их түлхэц өгснийг мөнгөөр хэмжих аргагүй. Зөвхөн АНУ-д гэхэд л өнөөдөр 180 сая гаруй машин байгаа ба жилд ойролцоогоор 3 триллион километр зам явж байгаа нь явганаар, онгоц, галт тэрэг болон тээврийн бусад хэрэгслэлээр явж байгаагаас хавьгүй илүү байна.

Н.А.Отто 1832 онд Германы Хольцхаузен хотод төрсөн, эцэг нь багад нь өөд болжээ. Дунд сургуульд сайн сурч байсан ч бизнесийн салбарт туршлагатай болохын тулд 16 настайдаа дээд сургуулиас гарч нэгэн жижигхэн хотод талх, чихрийн мухлагт ажиллаж байгаад дараа нь Франкфурт хотод албан хаагч болжээ.

Этьен Ленуарын (1822-1900) зохион бүтээсэн дотоод шаталтат анхны хийн хөдөлгүүрийн тухай Отто 1860 оны орчим сонсож хэрэвзээ энэ хөдөлгүүр нь шингэн түлшээр ажилладаг бол илүү өргөн хэрэглэж болох юм гэдгийг ойлгожээ. Төдсөнгүй карбюратор зохион бүтээсэн боловч урьд нь зохиогдсон гэсэн шалтгаанаар түүнд шинэ бүтээлийн гэрчилгээ олгосонгүй.

Үүнд сэтгэлээр унасангүй, Ленуарын хөдөлгүүрийг улам боловсронгуй болгох чиглэлээр идэвхтэй ажилласны үр дүнд Ленуарын зохиосон хоёр шаталбарт бүдүүлэг хөдөлгүүртэй харьцуул-бал зарчмын хувьд шал өөр, дөрвөн шаталбарт хөдөлгүүр сэдэж 1862 оны нэгдүгээр сард анхны загварыг бэлтгэжээ. Гэвч асаах хэцүү асуудалтай тулгарсан учир энэ сэдэмжээ түр орхиж хийгээр ажил-ладаг хоёр шаталбарт хөдөлгүүрийн сайжруулсан хувилбар болох "агаарын хөдөлгүүр" дээр ажилласан байна.

1863 онд агаарын хөдөлгүүрийн шинэ бүтээлийн гэрчилгээ авч үйл ажиллагааг нь ивээн тэтгэх болсон Еуген Ланген гэдэг хүнтэй хамтран ажиллах болжээ. Тэд жижигхэн үйлдвэр байгуулж хөдөлгүүрийг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэв. 1867 онд Париж хотод болсон Дэлхийн үзэсгэлэн худалдаанд хоёр шаталбарт хөдөлгүүр нь алтан медаль хүртсэний ачаар худалдаа арилжаа нь нэмэгдэж компанийн орлого эрс өсөв. Тэд 1872 онд үйлдвэрлэлийг удирдах талаар ихээхэн туршлагатай авьяаслаг инженер Даймлерийг хөлсөлж хөдөлгүүр зохион бүтээх ажилдаа туслалцуулжээ.

Хоёр шаталбарт хөдөлгүүр нь ихээхэн ашигтай байсан ч Отто дөрвөн шаталбарт хөдөлгүүрийн тухай бодлоо сэтгэлдээ тээсээр явлаа. Түлш, агаарын холимогийг гал авалцахаас өмнө шахаж чаддаг дөрвөн шаталбарт хөдөлгүүр нь хоёр шаталбарт хөдөлгүүрээс хол давуу үр дүнтэй болно гэдэгт итгэж байв. Ингээд Отто 1876 оны эхээр асаалтын сайжруулсан загвар бүтээж түүний үр дүнд амьдралд бодитой хэрэглэж болох дөрвөн шаталбарт хөдөлгүүр хийх бүрэн бололцоотой болжээ. Анхны загварыг 1876 оны тавдугаар сард бүтээж дараа жил нь шинэ бүтээлийн гэрчилгээ авчээ.

Дөрвөн шаталбарт хөдөлгүүрийн бүх үзүүлэлт амьдралын шалгуурыг дааж үнэхээр үр ашигтай хөдөлгүүр болох нь дорхноо нотлогдож дараагийн арван жилийн хугацаанд 30 мянга гаруй ширхэгийг борлуулж маш их ашиг олов. Ленуарын хоёр шаталбарт хөдөлгүүрийг ашиглахаа бүрмөсөн больжээ.



Францийн иргэн Альфонс Бо де Роша гэгч 1862 онд дөрвөн шаталбарт хөдөлгүүр бүтээж шинэ бүтээлийн гэрчилгээ авсан гэж шүүхэд заргалдсан. Гэхдээ А.Роша шинэ бүтээл гаргасан боловч ганц ч ажлын загвар хийж байгаагүй, нэг ч хөдөлгүүр борлуулж байсангүй, хамгийн гол нь Отто түүний шинэ санааг огт мэдээгүй байжээ. Гэсэн хэдий ч шүүх А.Рошагийн шинэ бүтээлийн эрхийг хүлээн зөвшөөрсөн ч Н.Оттогийн пүүс хөдөлгүүр үйлдвэрлэсээр, мөнгө олсоор байлаа. Н.Отто 1891 онд нас барах үедээ тухайн үеийнхээ баян хүмүүсийн тоонд багтаж байжээ.

Инженер Г.Даймлер 1882 онд Оттогийн пүүсээс гарч түүний зохион бүтээсэн хөдөлгүүрийг машинд хэрэглэх арга сэдэж 1883 онд асаалтын явцыг нь боловсронгуй болгож хөдөлгүүрийг минутанд 700-аас 900 эргэлт хийдэг болгон сайжруулжээ. Н.Оттогийн зохиосон хөдөлгүүрийн дээд хурд нь минутанд 200 эргэлт хийдэг байв. Даймлер жижиг хөдөлгүүр хийж түүнийгээ дугуйд байрлуулж анхны мотоцикл бий болгожээ. Дараа жил нь Даймлер анхны дөрвөн дугуйтай машин хийжээ. Гэтэл Карл Бенц түүнээс түрүүлсэн нь мэдэгдэв.

Карл Бенц минутанд 400 удаа эргэлттэй дөрвөн шаталбарт хөдөлгүүрээр хөдөлдөг 3 дугуйтай машин бүтээсэн байв. Эхлээд К.Бенц дараа нь Г.Даймлер нар зохиосон машинаа худалдсаар байв. Гэвч тэд эцэстээ нэгдэж өнөөгийн алдарт "мерседес-бенц" хөнгөн тэрэгний өвөг эцгүүд болсон билээ.

Америкийн зохион бүтээгч, бизнесмен Генри Форд хямд үнэтэй хөнгөн тэрэг бөөнөөр үйлдвэрлэдэг болж автомашины хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Дотоод шаталтат хөдөлгүүр, машин нь хүн төрөлхтөний хөгжилд амин чухал нээлт байсныг хэн ч үгүйсгэж чадахгүй. Машин зохион бүтээхэд Э.Ленуар, О.Отто, Г.Даймлер, К.Бенц, Г.Форд нар гэсэн хэдхэн хүн гол үүрэг гүйцэтгэснээс Отто хамгийн үр дүнтэй хөдөлгүүр хийснээрээ нэгдүгээрт бичигддэг юм. Энэ утгаараа Николаус Август Отто хүн төрөлхтөний өнөөгийн ертөнцийг жинхэнээр бүтээгчдийн нэг мөнөөс мөн билээ.

# 62. Франсиско Писарро

(FRANCISCO PIZARRO)

1475-1541



Перу улс дахь Инкийн эзэнт гүрнийг эзлэсэн Испани улсын иргэн, адал явдал эрэлхийлэгч Франсиско Писарро 1475 онд Трухильо хотод төржээ. Одоогийн Гаити, Доминиканы бүгд найрамдах улс нутаг дээр нь оршиж байгаа Карибын тэнгисийн жижиг арал дээр амьдарч байв. Дараа нь Номхон далайг нээсэн, 1519 оноос Панам улсад байнга амьдран суух болсон Васко Нуньес де Больбогийн удирддаг аялалын багийн гишүүн болжээ. 1522 онд 47 настай байхдаа испанийн судлаач Паскуаль де Андагойиноос Инкүүдийн эзэнт гүрэн гэж байдаг тухай анх сонсоод Фернандо Кортес асар их удам нутагтай Мексик улсыг эзэлсэн үйл явдалд зоригжин тус эзэнт гүрнийг байлдан дагуулахаар шийджээ. Түүний 1524-1525 онуудад хийсэн анхны оролдлого бүтэлгүйтэж хоёр завь нь Перугийн эрэг хүрэлгүй буцан иржээ. Хоёр дахь удаагаа Перу хүрч алт, улаан арьстнууд олзлон буцан иржээ.

1528 онд Писаррог Испанид ирэхэд дараа жил нь тавдугаар Карл хаан түүнийг Перуг байлдан дагуулагчаар томилж хөрөнгө мөнгөөр хангав. Панамд буцан ирж аялалын багаа бүрдүүлж 1531 онд Перуг чиглэн гарахдаа 56 настай байв. Хоёр зуун байлдан дагуулагчийг удирдан зургаан сая орчим иргэдтэй эзэнт гүрнийг халдан довтолхоор аян замд гарчээ!

Писарро 1532 онд Перу хүрч есдүгээр сард 177 хүн, 62 морь бүхий аялалын багаа удирдаж Инкийн эзэнт гүрний хаан Атауальпа 40 мянган хүн бүхий армитайгаа байрлаж байгаа Андын нурууны Кахамарка хотыг чиглэн хөдлөв. 1532 оны 11 дүгээр сарын 15-нд Писарро Кахамарка хотод дөхөн ирэхэд маргааш өдөр нь түүний хүсэлтээр Атауальпа хаан таван мянган буу зэвсэггүй бие хамгаалагч нараа дагуулан хэлэлцээ хийхээр иржээ.

Испаничууд эрэг дээр буусан үеэсээ нутгийн уугуул оршин суугчдад дайсагнан, шудрага бус хандаж байгааг ойлгож байсан мөртөө

Атауальпа хаан Писаррогийн удирдсан хэдхэн тооны цэргийг уулын нарийхан хавцалд ганц удаагийн дайралтаар тонилгож өлхөн чадах байтал яагаад тэдэнд Кахамарка хот хүртэл явах бололцоо олгосон нь гайхалтай. Инкүүд тулалдаан хийхдээ голдуу отох арга хэрэглэдэг мөртөө хаан нь эзлэн түрэмгийлэгчидтэй хэлэлцээ хийхээр зэвсэггүй очсон нь бүр хачирхалтай.

Писарро түүхэн хувь заяагаар олдсон алтан боломжийг алдсангүй, хааны зэвсэггүй бие хамгаалагч нар руу довтолж хагас цагийн хугацаанд таван мянга орчим цэргийг хядан дуусгаж Атауальпа хааныг баривчилжээ.

Инкийн эзэнт гүрэн нь бурхан гэж өргөмжлөх хаан бүхий төвлөрсөн удирдлагатай улс тул хааныг нь олзолсон дайсан руу түүний амь насыг бусниулж магадгүй гэж болгоомжлон довтолж зүрхэлсэнгүй. Атауальпа хаан амьд гарахын тулд испанчуудад 28 сая долларын үнэ бүхий алт, мөнгө төлсөн ч цаадуул нь итгэлийг нь эвдэж хэдэн сарын дараа түүнийг алжээ. Хааныг нь олзолсноос яг нэг жилийн дараа 1533 оны 11 дүгээр сард испанчууд тус улсын нийслэл Куског буун дуу гаргалгүй эзлэв.

Писарро Инкийн тоглоомын улс байгуулж 1535 онд Лима хотыг үндэслэсэн нь Перу улсын шинэ нийслэл болсон түүхтэй билээ.

Гэтэл тоглоомын хаан нь 1536 онд оргон зугтаж испаничуудын эсрэг улаан арьстнуудын тэмцлийг толгойлох болж Лима, Куско хотуудыг бүслэв. Гэвч дараа жил нь испаничууд бүслэлтийг сэтлэн дайрч тус улсын дийлэнх хэсэгт хяналтаа тогтоожээ. Улаан арьстнуудын бослогыг 1572 онд бүрмөсөн дарах үед Писарро өөд болсон байлаа.

Инкийн эзэнт гүрнийг захирч байгаа испаничуудын хооронд маргаан үүссэнээс Писарро алагдсан юм. Түүний хамтран зүтгэгч, ойрын туслах Диего де Альмагро олзноос бага хувь хүртээлээ хэмээн дургүйцэн 1537 онд бослого гаргахад нь баривчлан цаазалсан ч маргаан тасарсангүй. 1541 онд Альмагройн талыг баримтлагчид Лима хот дахь Писаррогийн ордонд дайран орж 66 настай удирдагчаа, Куско хотод ялан дийлэгчээр орж ирснээс яг найман жилийн дараа алжээ.

Ф.Писарро бол эрэлхэг зоригтой, тавьсан зорилгодоо туйлбартай, ухаалаг, шашин шүтдэг хүн байжээ. Гэхдээ бүдүүлэг харгис, шуналтай, итгэл найдвар хөөсөрдүүлэг хүн байсныг тэмдэглэх нь зүйтэй.

1967 онд Израиль улс хүн амын тоо, зэвсэглэлээрээ хэд дахин давуу арабын улсуудыг дийлэхэд дэлхий даяараа шагшин магтаж байлаа. Наполеон Бонапарт, Александр Македонский нар хүч давуу дайсныг цэргийн урлагийн гайхамшигт ур чадвараараа ямагт ялж байлаа. Чингис хааны удирдсан монголын морин цэргүүд хүн ам нь гурав дахин давуу Хятад улсыг сөгдүүлж байсан билээ.

Гэтэл Писарро зургаан сая хүн амтай гүрнийг 180 хүнтэй эзэлж түүхэнд цэргийн хамгийн хосгүй гавьяа байгуулсан юм. Таван сая хүнтэй улс руу зургаан зуун цэрэгтэй довтолсон Кортестэй харьцуулбал Писарро илүү их бэрхшээл саадтай учирч байсан юм. Испаничууд галт зэвсэгтэй байснаараа индианчуудыг дийлсэн гэж зарим түүхчид үздэг. Тэгтэл

испаничуудын тэр үед хэрэглэж байсан аркебуз хэмээх бүдүүлэг галт зэвсэг нь цэнэглэхэд их хугацаа шаардана, маш ойрхон тусгалтай байсан ажээ. Писаррог Кахамака хот руу дайрах үед гурван цэрэг нь л аркебуз буутай, хориод цэрэг нь нум сумаар зэвсэглэсэн, бусад нь илд, жадтай байжээ.

Писаррогийн зорилгодоо хүрэх хязгааргүй тэмүүлэл, хатан зориг нь ялалт байгуулах шийдвэрлэх хүчин зүйл болж байжээ.

Түүний байлдан эзлэсэн нутаг дэвсгэр дээр өнөөдөр Перу, Эквадор улсуудын дийлэнх хэсэг, Чилийн хойд хэсэг, Боливийн хэсэг оршиж байна. Хүн ам нь ч Өмнөд Африкийн бусад хэсгээс илүү байжээ. Писаррогийн байлдан дагуулалтын үр дүнд испанийн шашин, соёл тус бүс нутагт өргөн дэлгэрчээ. Инкийн эзэнт гүрэн дийлдсэнээс хойш Өмнөд Америкийн аль ч хэсэг испаничуудад эсэргүүцэл үзүүлж чадаагүй юм. Писаррогийн эзлэсэн нутаг дэвсгэр дээр өнөөдөр хэдэн сая индианчууд амьдарч байгаа ч тэр үеэс хойш улс төрийн засаглалаа дахин хэзээ ч сэргээж чадаагүй төдийгүй одоо тэнд испани хэл, шашин, соёл бүрэн ноёрхож байна.

Инкийн эзэнт гүрэн нь нэг талаасаа Номхон далайгаар эмжээрлэгдсэн болохоор батлан хамгаалах талаас нь авч үзвэл испанийн хөлөг онгоцуудын хувьд Атлантын далайгаас илүү хэцүү байжээ. Инкийн эзэнт гүрэн бол том армитай, хүн ам ихтэй, зохион байгуулалт сайтай орон байсан. Түүнээс гадна Перу улсын нутаг дэвсгэрийн дийлэнх хэсэг нь уулархаг болохоор европийн эзлэн түрэмгийлэгч орнууд түүний уулархаг хэсгийг дайран эзлэхэд маш хэцүү гэж үзэж байв.

XIX зууны сүүлчээр европийн армиуд илүү хөгжингүй болсон үед италичууд Этиоп улсыг эзлэх дайн хийгээд ялагдаж байлаа. Англичууд Энэтхэгийн баруун-хойд хэсгийн уулархаг нутагт суудаг омгуудтай тулалдахдаа маш их хохирол амсаж байлаа. Европчууд Балба, Афганистан, Иран зэрэг уулархаг орнуудыг хичнээн дайтаад ч эзлэн түрэмгийлж чадаагүй. Хэрэвзээ Писарро ялагдсан бол түүнээс европийн зэвсэг, байлдах аргын тухай тодорхой мэдлэг олж авсан байх инкчүүд халдан ирэх европийн илүү хүчтэй армийг дийлэх байсан байж магадгүй.

Энэ утгаараа Ф.Писарро Перу улсын нутаг дэвсгэр дээр оршиж байсан Инкийн эзэнт гүрнийг эзлэн авснаар бүхэл бүтэн тивийн хөгжлийн явцыг өөрчилж чадсан гавьяатай юм.

# 63. Эрнан Кортес

(HERNANDO CORTES)

1485-1547



Мексик улсыг эзлэн түрэмгийлэгч Эрнан Кортес Испанийн Медельин хотод 1485 онд ядуувтар язгууртны гэрт төржээ. Идэр залуудаа Саламанка хотын их сургуульд суралцаж хууль зүй судалж байсан ч хорвоогийн баруун хэсэгт саяхан нээгдсэн нутагт очиж азаа үзэхээр 19 настайдаа одоогийн Гаити, Доминиканы бүгд найрамдах улс оршиж байгаа Карибын тэнгисийн жижиг арал дээр ирж хэдэн жилийг хөдөө аж ахуй эрхэлж нутгийн бүсгүйчүүлийг эргүүлж өнгөрөөжээ. 1511 онд Куба арлыг испаничууд эзлэн түрэмгийлэхэд оролцож тус улсын амбан захирагч Диего Веласкесийн охин дүүтэй сууж Сантьяго хотын захирагч болжээ.

Амбан захирагч Д.Веласкес 1518 онд Мексик рүү хийх аялан байлдах багийн удирдагчаар Кортесийг томилоод хүргэнийхээ алдар нэрд дуртайг санаж тэр даруй тушаалаа өөрчилсөн ч хожимдсон байв. 1519 оны хоёрдугаар сард Э.Кортес 11 хөлөг онгоцонд 110 усан цэрэг, 553 цэргээ (тэдний дотор буутай 13, харвадаг нум сумтай 32 цэрэг байв.) 10 хүнд, 4 хөнгөн их буутай 16 морьтой нь суулган алсын замд гарчээ. Цуваа явсаар одоогийн Веракрус хотын дэргэд эрэг дээр буув. Кортес эхний хэдэн хоногийг Мексикийн дотоод байдлын тухай мэдээлэл цуглуулахад зориулав.

Тус орныг эзэгнэгч ацтекүүдийн нийслэл нь тивийн төв хавьд байдаг, тэрхүү том хотод үнэт эрдэнэс их байдаг, ацтекүүдэд эзлэгдсэн улаан арьстны омгууд тэднийг үзэн яддагийг мэдэж авлаа.

Кортес энэхүү асар том газар нутагтай орныг байлдан түрэмгийлэх зорилгоор ирсэн болохоор тивийн гүн рүү хөдлөв. Гэтэл зарим хүмүүс нь алсын замд танил бус нутагт учрах элдэв бэрхшээлээс айж буцахыг шаардахад Кортес бүх хөлөг онгоцоо шатааж буцах замыг нь хааж нэг бол ялах, нэг бол улаан арьстнуудын гарт үхэх хоёр замын аль нэгийг нь сонгоход хүргэжээ.

Испаничуудын замд улаан арьстнуудын бие даасан тласкаланц омгийнхон хүчтэй эсэргүүцсэн боловч хэд хэдэн цус асгаруулсан ширүүн тулалдаанд ялагдсаныхаа дараа Э.Кортестэй нийлж үзэн яддаг ацтек омгийн эсрэг хамтран тэмцэхээр шийджээ. Үүний дараа испаничууд урагшилсаар ацтек омгийн удирдагч П.Монтесум гэнэтийн дайралт хийхээр зэхэж байсан Чолула хот хүрч тэднээс өрсөн гэнэтийн довтолгоон хийж хэдэн мянган улаан арьстнуудыг хүйс тэмтэрчээ.

Дараа нь Кортес ацтекүүдийн нийслэл Теночтитлан (өнөөгийн Мехико) хотыг 1519 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр байлдаан хийл-гүйгээр эзлэж омгийн удирдагч Монтесумуг олзолж, түүгээр "толгой-луулсан" тоглоомын засгийн газар байгуулж тус орныг бүрэн хяналтдаа авлаа гэж Э.Кортес баярлан бодож байлаа.

Гэтэл өөрийг нь баривчлах зорилго бүхий Панфило де Нарваесийн удирдсан испанийн бас нэг аялалын баг Мексикийн эрэгт буусныг Э.Кортес дуулаад цэргийнхээ зарим хэсгийг Теночтитланд орхиж үлдсэн хэсгийг нь удирдан Нарваесийн багийг амдан тулалдан дийлж амьд үлдсэн цэргүүдийг нь армидаа нэгтгэжээ. Тэгтэл Теночтитлан хотод цэргээ хариуцуулан орхисон төлөөний хүн нь ацтек омгийнхны дургүйг хүргэсний улмаас 1520 оны зургаадугаар сарын 30-нд бослого гарч испаничууд ихээхэн хохирол амсаж Тласкалу хот руу ухарсан байв. Гэвч Э.Кортес хүчээ сэлбэж дараа оны тавдугаар сард нийслэл Теночтитлан хотыг дахин эзлэв. Тус хотыг Мехико гэж нэрлэж Шинэ Испани дахь испанийн колонийн нийслэлээр тунхаглаж Испанийн эрх мэдлийг Мексикт он удаан жилээр баттай тогтоожээ.

Э.Кортес зургаан зуу гаруйхан цэрэг удирдаж таван сая хүн амтай эзэнт гүрнийг сөгдүүлсэн нь үнэхээр цэргийн том гавьяа юм. Э.Кортес цөөхөн тооны цэрэгтэй ч эрэлхэг зориг, аливаа саадыг сэт татан гарах сэтгэлийн харьшгүй тэнхээ, тэрчилэн өрсөлдөгч талаа уран аргаар задлан бутаргаж чадсан нь түүний ялалт байгуулах гол хүчин зүйл болсон билээ. Түүнээс өмнө испанийн хоёр ч аялан байлдах баг Мексикийн эрэгт буусан боловч суурин байгуулж өчүүхэн хэсэг газар ч эзлэн авч чадалгүй буцаж байжээ.

Э.Кортест энэхүү том ялалтыг байгуулахад Кветцалкоатл бурхны тухай ацтек омгийнхны дунд тархсан домог их тус болжээ. Нутгийн улаан арьстнуудын домгоор бол, өндөр нуруутай, цагаан арьстай, өтгөн сахалтай Кветцалкоатл бурхан тус орныг удирдах, хөдөө аж ахуй хөтлөн явуулахад тусалдаг ба буцан ирэхийг амлаад "Дорнодын тэнгис" өөрөөр хэлбэл Мексикийн булангаас цааш явсан ажээ. Ацтек омгийн хувьд хол одсон тэрхүү бурхан нь Э.Кортесийн дүрээр эргэн ирлээ гэж бодож түүнийг бишрэн дээдэлж хүндэлдэг болсон байжээ.

Тийм учраас омгийн удирдагч Монтесум испаничуудыг ирэхэд өөдөөс нь туйлбартай тэмцэл өрнүүлж чадаагүй байна.

Э.Кортес харь нутагт халдан довтолох нь шудрага бус үйлдэл гэдгийг ойлгож байсан ч шашны үзэл бодлын үүднээс халдан довтолсноо зөв, ёс суртахуунтай үйлс гэж үзэж бид Христос бурхны төлөө яваа болохоор заавал ялах ёстой, бидний үйлс зөв зүйтэй гэж хамтран зүтгэгч, цэргүүдээ зоригжуулж байлаа. Гэхдээ хамтран зүтгэгч болсон улаан арьстнуудаа христос шашин шүтдэг болгох гэж оролдоод хийж амжуулсан бүх ажлаа баллах дөхөж байжээ.

Э.Кортес индианчуудтай тэмцэхдээ уран арга, заль хэрэглэж чаддаг байсан мөртөө улаан

арьстнуудтайгаа бол улс төрийн тэмцлийг зохих ёсоор явуулж чадаагүй юм. Испанийн хаан түүнд газар нутаг олгож вангийн зэрэг хүртээх зэргээр шагнал урамшил гар таталгүй олгосон ч түүнийг Мехико хотын захирагчийн албан тушаалаас өөрчилжээ.

1540 онд Испанид буцан ирж Шинэ Испанид өндөр албан тушаалд дахин томилохыг хаанаас гуйж амьдралынхаа сүүлчийн 7 жилийг өнгөрөөжээ. 541 онд Севиль хотын ойролцоо нас баржээ. Мексик дэх түүний асар том эзэмшил газар нутгийг хүү нь өвлөн авсан байна.

Э.Кортес бол ханашгүй шуналтай, нэр төрд дуртай, ихэмсэг дээрэлхүү, түргэн зантай ч зоригтой, ухаантай, тавьсан зорилгодоо хүрэхийн төлөө махруу тэмцдэг эр байжээ. Шог хошин яриатай, гадна байдлаараа хээнцэр эр байсан тул бүсгүйчүүл түүнд унадаг байсан, хүнийг гомдоохыг хүсдэггүй хүн байв. Цэргийн авьяаслаг удирдагч байсан ч утга учиргүй алаан хядааныг буруушаадаг, Писарро бүхнийг үзэн яддаг байсан бол Кортес улаан арьстнуудтай чин сэтгэлээсээ нөхөрсөг харьцдаг, тэднийг хүчирхийллийн аргаар захирахыг хүсдэггүй байжээ.

Э.Кортес хүүдээ бичиж үлдээсэн захиасандаа ёс суртахууны үүднээс зарц, боолтой байх нь зохимжтой байх эсэх талаар нухацтай бодохыг зөвлөсөн бий. Энэ бол тухай үед гайхамшигт хүнлэг бодол санаа байсан билээ. Ер нь бол Э.Кортес бол испанийн эзлэн түрэмгийлэгч дотроос хамгийн шудрага хүнлэг хүн байсан ажээ.

Кортес, Писарро хоёр бол бие биенээсээ тавиад бээр зайтай газар төрсөн, хоорондоо арван насаар зөрүүтэй, тэдний насан туршийн үйлс маш адилхан байжээ. Тэд тивийн хэмжээний газар нутаг эзлэж тэр нутагт төрөлх хэл, шашин, соёлоо түгээн дэлгэрүүлжээ. Тэр цагаас хойш эзлэсэн нутаг дэвсгэр дэх улс төрийн эрх мэдэл европ тивээс гаралтай хүмүүсийн гарт байх болсон юм.

Испани улс алс тэртээ орших Мексик улсыг эзлэн түрэмгийлэх нь гарцаагүй болох үйл явдал байсан. Э.Кортесийн гол гавьяа бол тэр үйл явцыг гардан хийж хурдасгаж чадсан явдал билээ.

# 64. Томас Жефферсон

(THOMAS JEFFERSON)

1743-1826



АНУ-ын гурав дахь ерөнхийлөгч, Тусгаар тогтнолын Тунхаглалыг зохиогч Томас Жефферсон 1743 онд Виржини мужийн Шедвелл хотод хүүдээ ихээхэн хөрөнгө өвлөн үлдээсэн газрын эзний хүү болон төржээ. Уильям, Мерийн коллежид хоёр жил, дараа нь хэдэн жил хууль судалж 1767 онд Виржини муж улсын өмгөөлөгчийн газарт ажилд оржээ. Дараагийн долоон жилийг өмгөөлөгч, газрын эзнээр ажиллан өнгөрөөхдөө мужийн хуультогтоох байгууллагын гишүүн болсон байв.

Анхны чухал зохиол болох "Британийн америкийн эрхийн товч тойм" номоо 1774 онд бичжээ. Дараа жил нь Виржини мужаас эх газрын хоёрдугаар их хуралд сонгогдож 1776 онд Тусгаар тогтнолын Тунхаглалыг зохиожээ. Жилийн дараа Виржини мужийн хууль тогтоох байгууллагад буцан ирж хэд хэдэн чухал шинэчлэл хийхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. "Шашны эрх чөлөөний асуудлаархи Виржини мужийн дүрэм", "Мэдлэгийг бүх нийтээр түгээх тухай хууль" нь түүний боловсруулсан өндөр ач холбогдолтой баримт бичиг байжээ.

Ардын боловсролын талаархи Жефферсоны боловсруулсан төлөвлөгөөнд бүх нийтэд бага боловсрол олгох, авьяаслаг хүүхдүүдэд тэтгэлэг өгч суралцуулан дээд боловсролтой мэргэжилтэн болгох гэсэн хэд хэдэн чухал санаа орсон ч Виржини мужийн засаг захиргаа уг төлөвлөгөөг хүлээн зөвшөөрөөгүй нь харамсалтай. Шашны эрх чөлөөний асуудлаархи дүрэмд аливаа хүнд сэтгэлд нь нийцсэн шашин шүтэхийг нь зөвшөөрөх, сүм хийдийг төрөөс тусгаарлах тухай дурдсаныг нь Виржиний мужийн эрх баригчид удтал эсэргүүцсэний эцэст 1786 онд хүлээн авсан юм. Энэ үзэл санааг бусад мужийн хүний эрхийн тухай хуулиудад болон АНУ-ын Үндсэн хуульд тусгасан байна.

Т.Жефферсон 1779-1781 онуудад Виржини мужийн амбан захирагч байгаад улс төрийн амьдралаас хэсэг холдон байхдаа боолчлолын тогтолцоог өөрчлөх тухай утга санаа бүхий "Виржини муж улсын тухай тэмдэглэл" нэртэй ганц ном бичжээ. Эхнэр нь арван жил хамт



амьдарч зургаан хүүхэд төрүүлж өгснийхөө дараа 1782 онд нас баржээ. Т.Жефферсон залуугаараа бэлбэсэрсэн ч дахин гэрлээгүй юм.

Дараа нь улс төрд буцан орж Конгрессийн гишүүн болж бүх шинэ мужид боолчлолыг хориглох тухай төлөвлөгөөг дэвшүүлэн тавьсныг нь ганц хүний санал дутсанаар хүлээж аваагүй байна.

1784 онд Франц улсад элчин сайдаар томилогдон таван жил ажиллах хугацаанд АНУ-ын Үндсэн хууль зохиогдон батлагдсан байна. Үндсэн Хуулийг сайшаан угтсан ч хүний эрхийн тухай асуудлууд оруулах нь зүйтэй байсан гэж үзэж байв.

1789 онд эх орондоо буцан ирж Төрийн нэгдүгээр нарийн бичгийн даргаар томилогдсон ч Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга А.Гамильтонтой улс төрийн үзэл бодлын талаар таарахгүй байв. А.Гамильтоны талынхан эцэстээ нэгдэж холбооны нам байгуулахад Т.Жефферсоны талынхан гар хамхин суусангүй, бас нэгдэж бүгд найрамдах-ардчилсан нам байгуулсан нь одоогийн ардчилсан намын эх суурь болсон билээ.

1796 онд ерөнхийлөгчийн сонгуульд оролцож Ж.Адамсад ялагдсан ч хуулийн дагуу дэд ерөнхийлөгч болжээ. Харин 1800 оны сонгуульд ерөнхийлөгч Ж.Адамсийг ялж АНУ-ын гурав дахь ерөнхийлөгчөөр сонгогджээ.

Ерөнхийлөгчийн хувьд бусад өрсөлдөгч нартайгаа эв найртай, хүлээцтэй ханддаг байснаараа АНУ-ын хувьд маш үнэтэй улс төрийн туршлагыг өв болгон үлдээсэн юм. Түүний ерөнхийлөгч байх үеийн хамгийн том ололт нь АНУ-ын нутаг дэвсгэрийг бараг хоёр дахин нэмэгдүүлсэн Луизиана мужийг Францаас худалдаж авсан явдал юм. Луизиана мужийг худалдаж авсан нь хүн төрөлхтөний түүхэн дэх асар их газар нутгийг тайван замаар нэгтгэсэн хамгийн том үйл явдал төдийгүй АНУ-ыг дэлхийн хүчирхэг гүрэн болгон хувиргасан түүхэн чухал үйл явдал болсон билээ.

Луизиана мужийг АНУ-д худалдах шийдвэрийг Францийн хаан Наполеон Бонапарт гаргасан юм. АНУ-аас Париж хотод суугаа элчин төлөөлөгч Роберт Ливингстон, Жеймс Монро нар ер бусын том наймаа болохыг дор нь ухаарч эрх мэдлээ хэтрүүлэн асар том нутгийг худалдан авах хэлэлцээг шууд хийж эхэлсэн байна. Т.Жефферсон нас барахынхаа өмнө өөрийн хүрсэн амжилтуудын тухай бичихдээ Луизиана мужийг худалдаж авсныг оруулаагүй байдаг нь их сонин.

1804 онд дахин ерөнхийлөгчөөр сонгогдсон ч 1808 онд гурав дахь удаагаа нэр дэвшихээс татгалзаж Ж.Вашигтоны тавьсан уламжлалыг улам баталгаажуулсан юм. Түүний хамгийн сүүлд оролцсон чухал үйлс нь 1819 онд Виржинийн их сургуулийг байгуулсан явдал байжээ. 1826 оны долоодугаар сарын 4-ний өдөр 83 насандаа, Тусгаар тогтнолын Тунхаглал батлагдсаны 15 жилийн ойн өдөр өөд болсон ажээ.

Т.Жефферсон зургаан гадаад хэл мэддэг, байгалийн шинжлэх ухаан, математик сонирхдог, хувийн эдлэн газар дээрх аж ахуйгаа шинжлэх ухааны үндсэн дээр хөтлөн явуулдаг байсан төдийгүй үйлдвэрлэл эрхэлдэг, зохион бүтээгч, чадварлаг уран барилгач байжээ.

Тусгаар тогтнолын Тунхаглалыг зохиосон нь Т.Жефферсоны хамгийн гарамгай гавьяа юм. Энэхүү Тунхаглал бол АНУ-ын засгийн газрын хуулийн хэсэг биш чухамдаа америкийн эрхэм тэмүүллийн баталгаа юм. Тунхаглалд тусгагдсан үзэл санааны дийлэнх хэсгийг Т.Жефферсон английн гүн ухаантан Жон Локкийн зохиол бүтээлээс авсан юм. Тусгаар тогтнолын Тунхаглал бол гүн ухааны өвөрмөц сургаал биш чухамдаа америкчуудын итгэл үнэмшлийн товч хураангуй билээ.

Гэхдээ Тусгаар тогтнолын Тунхаглал нь АНУ-д тусгаар тогтнолоо зарлах шийдвэрт хүргээгүйг тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү Тунхаглал гарахаас бараг нэг жилийн өмнө, 1775 оны дөрөвдүгээр сард эхэлсэн хувьсгалт дайны явцад Английн Америк тив дэх хараат мужуудаас бүрмөсөн тусгаар тогтнолоо зарлах уу эсвээс Английн засгийн газарт буулт хийх үү гэсэн хоёр тэс ондоо шийдвэрийн аль нэгийг гаргахыг шаардсан. 1776 оны хавар Конгресс дахь үзэл бодол дээрх хоёр шийдвэрийн аль нэгийг заавал гаргах байдалд шилжсэн байна. Гэхдээ Т.Жефферсон биш Виржиний муж улсаас сонгогдсон гишүүн Ричард Генри Ли бүх харьяат мужид Англи улсын харьяаллаас гарч тусгаар тогтнолоо зарлахыг зургаадугаар сарын 7-ны өдөр санал болгосон ажээ.

Конгресс Лигийн дэвшүүлсэн саналаар санал хураалт явуулахыг хэдэн долоо хоногоор хойшлуулж тусгаар тогтнолыг зарлаж байгаа шалтгаануудын тухай нийтэд зориулсан мэдэгдэл гаргах зорилгоор тусгай хороо байгуулж даргаар нь Т.Жефферсоныг томилсон байна. Конгресс долоодугаар сарын 1-ний өдөр Лигийн гаргасан саналыг дахин хэлэлцэж дараа өдөр нь нууц санал хураалт хийхээр тогтжээ.

Ийнхүү тусгаар тогтнолын тухай чухал шийдвэр долоо дугаар сарын 2-ны өдрийн санал хураалтаар нэг тийш болсон билээ. Чухамдаа санал хураалтын дараа Т.Жефферсоны төслийг хэлэлцэж багахан засвар хийсний дараа 1776 оны долоодугаар сарын 4-ний өдөр баталжээ.

Т.Жефферсоны бас нэг гавьяа нь "Шашны эрх чөлөөний асуудлаархи Виржини мужийн дүрэм" юм. Түүнээс өмнө тухайлбал Жон Локк, Вольтер зэрэг хэд хэдэн алдарт гүн ухаантнууд шашин шүтэх эрх чөлөөний тухай гол үзэл баримтлалыг боловсруулсан байсан. Гэхдээ Т.Жефферсон бол баримталдаг үзэл бодлоо хууль болгон батлуулж чаддаг улс төрийн зүтгэлтэн байсан юм.

Т.Жефферсон нь Хүний эрхийн тухай холбооны хуулийг боловсруулан батлуулахын төлөө тэмцэж байсан улс төрийн зүтгэлтнүүдийн оюун ухааны удирдагчдын нэг байсан юм. 1784-1789 онуудад гадаадад байсан учраас Хүний эрхийн тухай холбооны хуулийг батлуулахын төлөө шийдвэрлэх тэмцэлд гар бие оролцож чадаагүй юм. Уг хуулийг Конгрессоор батлуулахад Жеймс Медисон гол үүргийг гүйцэтгэсэн. Хүний эрхийн тухай холбооны хууль 1789 оны есдүгээр сарын 25-нд, Т.Жефферсоныг эх орондоо буцаж ирэхээс өмнө батлагдсан байна.

Ер нь бол Т.Жефферсоны албан ёсны үйл ажиллагаа биш, олон асуудлаар түүний баримталж байсан байр суурь АНУ-д нөлөөлсөн гэж үзэж болно. Түүний дэвшүүлсэн дэвшилтэт олон санааг америкийн ард түмэн хүлээн зөвшөөрсөн гэж үзэхэд бас учир дутагдалтай. Тухайлбал бид өнөөдөр "сүүдрийн засгийн газар" гэж нэрлэдэг үзэл бодлыг тэр тууштай дэмжиж байсан. Ерөнхийлөгчийн тангариг өргөх ёслол дээр "Ухаалаг, хүлээцтэй засгийн газар гэдэг

бол иргэдээ бие биендээ хор хүргэхээс сэргийлж чаддаг, түүний зэрэгцээ иргэддээ аж үйлдвэрлэл хөтлөх, бие боловсронгуй болгох тэдний тэмүүллийг зохицуулах эрх чөлөөг олгодог байхыг хэлнэ." гэж сургаж байв. Түүний энэхүү зөв байр суурийг америкийн ард түмний дийлэнх нь сайтар ойлгоогүй байгааг сүүлийн тавин жилийн сонгуулиуд харуулж байна.

Т.Жефферсон Үндсэн Хуулиар тодорхойлогдсон хууль тогтоох засаглал Дээд шүүхээс хэт хамааралтай байхыг эрс буруушааж байв. Конгрессоор батлагдсан хуулийг Дээд шүүх үндсэн хуульд нийцэхгүй гэж зарлах нь ардчилсан удирдлагын зарчимд нийцэхгүй гэж үзэж байлаа.

АНУ-ын тусгаар тогтнол, ардчиллын байгууллагууд үзэл бодол, үйл ажиллагааны хүмүүсийн нэгдсэн чармайлтаар бий болсон юм. Ямар ч тохиолдолд үзэл бодол чухал хувь нэмэр байдгийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Үзэл бодлыг үйл ажиллагаа болгох талаасаа бол Ж.Вашингтон тэргүүлэх үүрэг гүйцэтгэсэн. Үзэл бодлын гавьяа нь Т.Жефферсон, Ж.Медисон зэрэг америкчууд, Ж.Локк, Вольтер зэрэг европчуудад зүй ёсоор ногдоно.

# 65. Нэгдүгээр Изабелла хатан хаан

(QUEEN ISABELLA I)

1451-1504



Өнөө үед нэгдүгээр Изабелла хатан хааныг Атлантын далайг гаталж америк тивийг анх нээсэн Христофор Колумбын аялалыг санхүүжүүлсэн гэдэг утгаар нь дан ганц мэддэг. Үнэндээ бол Изабелла хатан хаан бол Испани, Латин Америкийн хувь заяанд хэдэн зуун турш нөлөө үзүүлсэн, өнөө үед амьдарч байгаа олон сая хүний амьдралд тойруу замаар туссан олон чухал цуврал шийдвэрийг гаргасан билээ. Улс төрийн чухал шийдвэрүүдээ Арагоны хаант улсын хаан, ухаантай, авьяаслаг нөхөр Фердинандтай зөвлөлдсөнийхээ дараа гаргаж байжээ.

Изабелла 1451 онд өнөөгийн

Испани улсын нэг хэсэг болох Кастилийн хаант улсын Мадригал хотод төрж шашны боловсрол олж католик шашинтан болжээ. Түүний ах IY Генрих нь Кастилийн хаанаар 1454 оноос 1474 онд нас барах хүртлээ байжээ. Тэр үед Испани улс байгаагүй ба нутаг дэвсгэр дээр нь хамгийн том нь болох Кастили, хойд хэсэгт нь орших Арагон, өмнөд хэсэгт нь Гранада хойд хэсэгт Наваррын гэсэн дөрвөн хаант улс байжээ.

Хожим нь европийн хамгийн баян улсын хатан хаан болсон Изабелла гүнжтэй сүй тавих гэж олон ханхүү 1480 оноос оролдож ах хаан нь Португалийн хаантай суулгах санаатай байсан боловч Изабелла бүсгүй 18 настайдаа ахтайгаа зөрж Арагоны хааны залгамжлагч Фердинандтай суужээ. Хаан ах нь уурлаж төрсөн охин Хуанаа өөрийн залгамжлагчаар зарлажээ.

IY Генрих хааныг 1474 онд нас барахад Изабелла хатан хаан болохыг шаардахад Хуаны талынхан татгалзсанаас иргэний дайн дэгдэв. 1479 оны хоёрдугаар сард Изабеллагийн удирдсан цэрэг ялалт байгуулж Арагоны хаан мөн онд нас барж Фердинанд түүний орыг залгажээ. Ийнхүү Изабелла, Фердинанд хоёр Испани улсын дийлэнх хэсгийг захирах болов.

Арагон, Кастили хоёр улс нь тус тусдаа ч Фердинанд, Изабелла хоёр бүх шийдвэрээ хамтран гаргаж байв. Тэд 25 жил хаан ширээнд суух хугацаандаа хүчтэй хаанаар толгойлуулсан Испанийн нэгдсэн хаант улс байгуулах улс төрийн бодлого явуулжээ. Тэдний хэрэгжүү-лэхээр төлөвлөсөн анхны төсөл нь лалын шашинтнуудын хяналтад үлдсэн Пиренейн хагас арлын цорын ганц хэсэг болох Гранадаг эзлэх явдал байв.

Тэд аян дайнаа 1841 онд эхэлж 1492 оны нэгдүгээр сард ялал-таар дуусгаж Испани улсын өнөөгийн нутаг дэвсгэрийг бий болжээ. Наваррын жижигхэн улсыг Изабеллаг өөд болсны дараа Фердинанд 1512 онд нэгтгэжээ.

Фердинанд, Изабелла нар хаанчлалынхаа хамгийн анхнаас шашны залхаан цээрлүүлэх шүүх байгуулжээ. Энэ бол шүүгч, тангариг өргөсөн иргэдийн төлөөлөгч, прокурор, мөрдөгч нарыг нэгтгэсэн байгууллага байлаа. Энэхүү шүүх нь сэжигтэнд өгсөн мэдүүлэгийг нь уншуулж гарын үсэг зуруулдаггүй, гэрчийн мэдүүлэг өгсөн хүний нэрийг хэлдэггүй, сэжигтэнд тулгагдаж байгаа ялыг нь няцаах бололцоо олгодоггүй, тэрчилэн хэргээ хүлээхээс татгалзсан сэжигтэнг гэм буруугаа хүлээтэл нь тамлан яргалдаг байв. 25 жилийн хугацаанд нийтдээ хоёр мянга гаруй хүнийг түүдэг галд шатаан алсан ба тамлан тарчилгасан хүний тоо түүнээс илүү байжээ.

Нэгдүгээр Изабелла хатан хааны хувийн нүглийг наманчлагч, лам Томас де Торкведама шашны залхаан цээрлүүлэх шүүхийг толгойлж байсан мөртөө Ромын хамба ламд биш чухамдаа Испанийн хатан хаанд шууд захирагдаж байжээ. Изабелла хатан хаан шашны залхаан цээрлүүлэх шүүхийг ноёлогч шашныг хүчээр түгээн дэлгэрүүлэх, сөрөг хүчнээ хагалан бутаргах зорилгоор бас ашиглаж байв. Тухайл-бал Англи улсад тайж феодалууд хааныхаа үйл ажиллагааг тогтмол хянах бүрэн бололцоотой байсан бол Испанид феодалууд хүчирхэг байсан хэдий ч шашны залхаан цээрлүүлэх шүүхийг аль зоримог феодалыг хашрааж амыг нь хамхиж төвлөрсөн хэмжээлшгүй эрхт хаант ёсыг тогтоох зорилгод ашиглаж байгаа хатан хаанаа яаж ч чадахгүй байжээ.

Ер нь бол шашны залхаан цээрлүүлэх шүүхийг өөр шашин шүтэн биширч байгаа хүмүүсийг нухчин дарж залхаан цээрлүүлэх ялангуяа католик шашинд хүчээр орсон ч уламжлалт бурхнаа нууцаар шүтсээр байгаа еврей, лалын шашинтнуудын эсэргүүцлийг дарах зорилгоор ашиглаж байсан юм.

Даалгасан үүргийг муйхарлан гүйцэтгэгч Торквемадагийн ятгалгаар, Испанид оршин сууж байгаа бүх еврей иргэн нэг бол католик шашинтан болох эсвээс бүх өмчөө орхин дөрвөн сарын хугацаанд тус улсын нутгаас гарах тухай зарлигт Фердинанд, Изабелла нар гарын үсэг зуржээ. Испанид амьдарч байсан хоёр зуун мянга гаруй еврейчүүдийн хувьд энэ зарлиг ихээхэн хор уршиг тарьж дийлэнх нь оргон гарч амжилгүй амь насаа алдсан ажээ. Ажилсаг, чадварлаг олон мянган худалдаачин, гар урчууд амь эрсдэж оргон явснаар тус улсын эдийн засаг мэдэгдэхүйц дордсон билээ.

Гранадагийн хаант улсыг эзлэсний дараа Испанийн засгийн газар лалын шашин шүтэхийг хориглож тэрхүү хоригийг эсэргүүцэж бослого гаргасныг цэргийн хүчээр нухчин даржээ. 1502 онд Испани улсад амьдарч байсан лалын шашинтнуудад католик шашинд орох эсвээс тус орноос гарах гэсэн хэдэн жилийн өмнө еврейчүүдэд хийж байсан шиг тийм тулган

шаардалт бас тавьжээ.

Изабелла хатан хаан католик шашинтан байсан ч испанийн үндсэрхэг үзлийг илүүд үздэг байсан тул нөхрийнхөө хамт Ромын хамба ламын оронд католик шашны сүм хийдийг захирахын төлөө тэмцэж байсан юм. Чухам ийм учраас ХҮ1 зуунд европ тивд өрнөсөн үнэн алдартны шашны Шинэчлэл Испанийн нутаг дэвсгэрт дэлгэрээгүй юм.

Изабелла хатан хаан дэмжиж санхүүжилт хийсний ачаар Христофор Колумб 1492 онд Америк тивийг нээсэн билээ.

Изабелла хатан хаан 1504 онд нас барсан, нэг хүү дөрвөн охин төрүүлжээ. Ууган хүү Хуан нь 1497 онд өөд болсон, охин Хуана нь Бургундын хааны залгамжлагч, Австрийн нэгдүгээр Филипп хаантай гэрлүүлсний үр дүнд Изабеллагийн ач хүү, тавдугаар Карл хаан Европ тивийн түүхэн дэх хамгийн том эзэнт гүрнийг өвлөн авсан ажээ. Тавдугаар Карл хаан бас Ариун Ромын эзэнт гүрний хаанаар сонгогдсоноор тухайн цаг үедээ хамгийн баян, хамгийн хүчирхэг хаан болжээ.

Түүний шууд болон ёс төдий захирдаг газар нутаг нь гэвэл Испани, Герман, Голланд, Бельги, Австри, Швейцар, Италийн ихэнх хэсэг, Франц, Чехословак, Польш, Унгар, Югославын хэсэг тэрчилэн далайн чанадахь асар том нутаг байв. Католик шашин шүтдэг тавдугаар Карл хаан түүний хүү хоёрдугаар Филипп нар урт удаан хаанчлалынхаа хугацаанд Шинэ Тивийн их баялагийг Европийн хойд хэсэгт үнэн алдартны шашин шүтдэг орнуудын эсрэг дайн хийхэд зарцуулж байлаа. Фердинанд, Изабелла нарын зохион байгуулсан удам угсааны ураг төрөл нь Европийн түүхэнд бараг зуун жилийн нөлөө үзүүлсэн байна.

Фердинанд, Изабелла нарын байгуулсан Испанийн нэгдсэн хаант улсын нутаг дэвсгэр сүүлийн таван зууны туршид хэвээр байна. Тэд эх орондоо төвлөрсөн, хэмжээлшгүй эрхэт хаант ёсыг тогтоосон юм. Лалын шашинтан, еврейчүүдийг шашны үзэл бодлоор нь гадуурхан эх орноосоо хөөсөн, шашны залхаан цээрлүүлэх шүүх байгуулсан нь тус орны цаашдын хөгжилд маш их хор уршиг тарьсан билээ. 1492 оноос хойш хэдэн зууны туршид Өрнөд Европийн дийлэнх хэсэгт оюун ухааны цэцэглэлт болсон атал өөр үзэл бодлыг нухчин дарж, дан ганц католик шашныг хүлээн зөвшөөрсөн Испани улс 1700 он гэхэд бусад оронтой харьцуулахад оюун санааны хувьд хол хоцорсон байлаа. Фердинанд, Изабелла нар шашны залхаан цээрлүүлэх шүүх байгуулснаас хойш таван зуун жил өнгөрч түүнийг устгаад 150 жил болж байгаа ч Испани улс түүний хор уршгаас өнөө хэр ангижирч чадаагүй байна.

Нэгдүгээр Изабелла хатан хаан Х.Колумбын аялалыг санхүүжүүлсний ачаар Өмнөд болон Төв Америкийн ихэнх хэсэг Испани улсын хараат болсон ба тэр том газар нутагт испанийн соёл тэрчилэн шашны залхаан цээрлүүлэх шүүх нэвтэрсэн. Тийм учраас Өмнөд Америк дахь тус орны хараат улсууд Умард Америк дахь английн хараат улсуудаас хөгжлийн түвшингээр илт хоцорч байсан юм.

Түүний явуулж байсан улс төрийн бодлого зарим талаараа харамсмаар боловч түүн шиг хүн төрөлхтөний түүхэнд нөлөө үзүүлсэн хаад дэндүү цөөхөн билээ.

# 66. Иосиф Виссарионович Сталин

(JOSEPH VISSARIONOVICH STALIN)

1879-1953



Олон жилийн турш ЗХУ-ын дарангуйлагч байсан Иосиф Виссарионович Жугашвили 1879 онд Гүрж улсын Гори хотод төржээ. Хожим нь орос хэл сурсан ч насан туршаа илт гүрж аялгуутай ярьдаг байжээ.

Гуталчны мэргэжилтэй эцэг нь үргэлж согтуу байдаг тул түүнийг багад нь дандаа зоддог байсан ба 11 настай байхад нь өөд болжээ. Иосиф хүү Гори хот дахь шашны сургууль дараа нь Тифлис хотод шашны дунд сургуульд элсэн суралцсан ч 1899 онд марксист үзэл суртал дэлгэрүүлсэн учир хөөгджээ. Марксист нууц хөдөлгөөнд оролцож эхлээд 1903 онд нам хагарахад, большевик жигүүрт оржээ. 1917 оноос өмнө большевик намын идэвхтэй гишүүн учир зургаан удаа баривчлагдсан ч цөллөгөөс маш хялбархан зугатаж байснаас нь үзвэл Хаант оросын нууц цагдаагийн албаны мэдээлэгч байсан бололтой. Чухам тэр үед Сталин ("болд хүн" гэсэн утгатай үг) гэсэн нууц нэр авчээ.

1917 оны коммунист хувьсгалд Сталин чухал үүрэг гүйцэтгээгүй ч дараагийн хоёр жил нь идэвхтэй үйл ажиллагаа явуулсны үр дүнд 1922 онд коммунист намын ерөнхий нарийн бичгийн даргаар дэвшжээ. Энэ албан тушаалд очсоноор намын удирдлагад асар их нөлөө үзүүлэх бололцоотой болж ялангуяа Ленинийг нас барсны дараа өрнөсөн эрх мэдлийн төлөө тэмцэлд ялалт байгуулах гол хүчин зүйл нь болжээ.

Ленин залгамжлагчаа Лев Троцкий гэж үзэж байсан бололтой. Улс төрийн гэрээслэлдээ Сталин бол дэндүү бүдүүлэг хүн тул ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалаас чөлөөлөх нь зүйтэй гэж бичжээ. Гэтэл 1924 онд Ленинийг өөд болсны дараа Сталин уг гэрээслэлийг тас нууж Улс Төрийн Товчооны нөлөө бүхий хоёр гишүүн Лев Каменев, Григорий Зиновьев нартай нэгдэж хамтдаа Л.Троцкий болон түүний талынхныг дийлжээ. Дараа нь "зүүний сөрөг хүчнийг" (Троцкий, Каменев, Зиновьев болон тэдний талынхныг) бут ниргэж тэдний улс төрийн хэд хэдэн төлөвлөгөөг зээлдэн авав. Үүний дараа коммунист намын баруун жигүүр болох хамтран зүтгэгчдээ бүгдийг цааш харуулж гучаад оны эхэн гэхэд ЗХУ-ыг дангаар дарангуйлан захирдаг болсон байлаа.

Хэмжээлшгүй эрх мэдэлдээ дулдуйдан улс төрийн цуврал цэвэрлэгээ явуулж эхлэв. 1934 онд коммунист намын нэрт удирдагч Сергей Кировыг алж цэвэрлэгээ хийх шалтаг гаргаж авчээ. Дараагийн хэдэн жилүүдэд 1917 оны социалист хувьсгалын удирдагчид, Лениний удирдлагад ажиллаж байсан бүх хүнийг урвасан гэсэн ял тулгаж бөөнөөр нь цааш харуулжээ. Тэдний дийлэнх нь ил хийсэн шүүх хурал дээр "буруугаа" хүлээж байв. 1938 онд урьд нь цэвэрлэгээг удирдан зохион байгуулсан Генрих Ягода мөн "буруугаа хүлээж" буудуулсан. Түүний орыг авсан Николай Ёжов мөн хувь заяаг дайрчээ.

Гучаад оны дунд үеэс цэвэрлэгээг нийт коммунист нам, зэвсэгт хүчин даяар хийлээ. Лениний удирдлагын үед хувьсгалын эсэргүү нарын дийлэнхийг устгасан байсан тул энэхүү цэвэрлэгээг коммунист намын эсрэг хийжээ. Сталин коммунистуудыг устгах талаар хаант засгийн цагдаагийн албыг давж гарчээ. 1934 онд болсон коммунист намын их хурлаар сонгогдсон Төв Хорооны гишүүдийн гуравны хоёрыг цэвэрлэгээний үед хороов. Улс орны хэмжээнд бие даасан төвүүд бий болгохын эсрэг харгис хагуу тэмцэл хийж байлаа.

Харгис хэрцгий нууц албыг ашиглан коммунист дэглэмийг өчүүхэн ч атугай шүүмжилсэн хүмүүсийг шууд баривчлан буудан хороох, хөдөлмөрийн шоронгуудад хорьж олон жилээр тарчилган зовоох зэрэг залхаан цээрлүүлэх арга хэрэглэсний үр дүнд Сталин улс орны нийт хүн амыг айлган захирдаг болсон байна. Ийнхүү гучаад оны сүүлч гэхэд орчин үеийн түүхэн дэх хамгийн аймшигтай захиргаадалтын удирдлагын улсыг байгуулж иргэдийнхээ эрх чөлөөг боомилсон, амьдралынх нь бүх асуудалд оролцдог засгийн газрын бүтцийг бий болгосон байна.

Сталиний явуулж байсан эдийн засгийн арга хэмжээнүүдийн дотор хөдөө аж ахуйг хүчээр хамтралжуулсан явдал ихээхэн хор уршиг тарьж тариачдын дургүйцэл, эсэргүүцлийг төрүүлжээ. Гучаад оны эхээр түүний тушаалаар хэдэн сая тариачдыг буудан алж өлсгөлөнгөөр үхүүлж үүний үр дүнд түүний дэвшүүлсэн бодлого ялжээ.

Сталин цуврал таван жилүүдээс бүрдсэн аж үйлдвэржүүлэх бодлого явуулсан нь үр ашиг багатай байсан ч тодорхой амжилтад хүргэжээ. ЗХУ дэлхийн хоёрдугаар дайнд асар их хохирол амссан ч аж үйлдвэрийн хүчин чадлын хувьд дэлхийд хоёрдугаарт давшин оржээ.

1939 оны наймдугаар сард Гитлер, Сталин нар "харилцан үл довлолцох тухай" гэрээ байгуулж хоёр долоо хоногийн дараа Гитлер Польш улсад баруун талаас нь довлон дайрч хэдэн долоо хоногийн дараа ЗХУ зүүн талаас нь түрэмгийлэл үйлдэж газар нутгийнх нь тал хэсгийг эзлэжээ. Мөн ЗХУ хөрш зэргэлдээ тусгаар тогтносон Латви, Литов, Эстон улсуудыг (1917 оноос өмнө Хаант Орос улсын бүрэлдэхүүнд багтаж байсан) буун дуу гаргалгүй эзлэж нэгтгэлээ. Тэрчилэн Румын улсын хэсгийг түрэмгийлэл хийх аюулаар айлгаж мөн эзлэлээ. Финланд улс эсэргүүцэн тэмцэхэд ЗХУ зэвсэглэн халдаж газар нутгийнх нь нилээд хэсгийг булаан авав.

Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлд зөвлөлтийн армийн чөлөөлсөн Дорнод Европийн дийлэнх нутагт Сталин ЗХУ-д захирагддаг коммунист дэглэмийг тогтоов. Оросын цэрэг байгаагүй Югослав улсад ч гэсэн марксист засгийн газар байгуулагдсан ч ЗХУ-ын холбоотон болоогүй юм. Бусад орныг Югославын замаар явуулахгүйн тулд Сталин холбоотон орнуудынхаа засгийн газруудыг коммунист бус үзэлтэй хүмүүсээс хүчээр чөлөөлжээ. Ийнхүү



дэлхийн хоёрдугаар дайны дараа хүйтэн дайн эхэлсэн билээ.

Зөвлөлтийн дээд тушаалын зарим зүтгэлтнийг алсан хэсэг эмч нар баригдаж буруугаа хүлээсэн тухай мэдээлэл 1953 оны нэгдүгээр сард Зөвлөлт Засгийн газраас тараажээ. Энэ бол цэвэрлэгээний бас нэгэн давалгааны эхлэл байлаа. Гэвч 1953 оны гуравдугаар сарын 5-нд 73 настай дарангуйлагч нас барж түүний шарилыг занданшуулж Улаан талбай дахь мавзолейд Лениний шарилын дэргэд байрлуулжээ. Өнөө үед

Сталиний нэр хүнд эрс унаж түүний захиргаанд байсан бүх улс аймшигт яргачин гэж үзэн ядсаар байна.

Сталиний хувийн амьдрал бүтэлтэй байгаагүй. 1904 онд гэрлэсэн анхны эхнэр нь гурван жилийн дараа уушигний сүрьеэ өвчнөөр нас барав. Ганц хүү Яков нь дэлхийн хоёрдугаар дайны үед нацистуудад олзлогдож германы тал солих санал дэвшүүлэхэд Сталин татгалзсан учир бөөнөөр хорих шоронд үхжээ. 1919 онд суусан хоёр дахь эхнэр нь 1932 онд амиа хорлосон гэдэг. Үнэндээ бол Сталин түүнийг алсан юм уу эсвээс амиа хорлоход хүргэсэн байна. Тэд хоёр хүүтэй байсны том нь болох зөвлөлийн цэргийн нисэх хүчний генерал архичин болж 1962 онд нас барсан. Охин Светлана нь ЗХУ-аас оргож 1967 онд АНУ-д дүрвэн гарчээ.

Сталин бол өрөвдөж хайрлахыг огт мэддэггүй аймшигтай харгис хэрцгий, үргэлж хардан сэжиглэдэг, гэхдээ ухаантай, тавьсан зорилгынхоо төлөө туйлбартай тэмцдэг, гоц ажилсаг хүн байв. Бараг хорин таван жил ЗХУ-ын дарангуйлагч байсны хувьд олон сая хүний хувь заяанд нөлөө үзүүлсэн юм Түүхэн дэх хамгийн хүчтэй дарангуйлагч байсан, бүхий л амьдралынхаа туршид хэдэн сая хүнийг цаазалж хөдөлмөрийн лагерьт явуулж тарчлаан зовоосон юм. Зөвхөн цэвэрлэгээний явцад гуч гаруй сая хүн амь насаа алджээ.

Сталин амьдралынхаа хугацаанд ЗХУ-ын хил хязгаарыг өргөжүүлж Дорнод Европод холбоотон орнууд бий болгож ЗХУ-ыг дэлхийн өнцөг булан бүрт нөлөө үзүүлдэг хүчирхэг гүрэн болгон хувиргажээ. Гэхдээ сүүлийн жилүүдэд Дорнод Европ дахь холбоотнууд нь салж ЗХУ 15 бие даасан улс болон задарсан билээ. Сталины үед ЗХУ нь цагдаагийн орон байсан бол одоо нууц цагдаагийн албаны үйл ажиллагаа нь хумигдаж иргэд нь эрх чөлөөтэй аж төрж байна.

Сталин эдийн засгийн бодлогоо явуулахдаа Маркс, Ленин нарын үзэл бодлыг үндэс болгож байлаа. Марксын дэвшүүлсэн, Лениний эхлэсэн бодлогыг Сталин хэрэгжүүлж ЗХУ-д хувийн хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн газруудыг бүрмөсөн устгасан. Гэвч тийм бодлого нь ямархуу хор уршигтай болохыг түүх маргашгүй нотолсон юм.

Сталины нас барсан ч түүний түүхэнд үзүүлсэн нөлөө их байлаа. Хүн төрөлхтөний түүхэнд дэлхийн хоёрдугаар дайн ч Сталиний үед эхэлсэн хүйтэн дайн шиг тийм их хор уршигийг тариагүй юм. Хүйтэн дайнд ЗХУ, АНУ хоёулахнаа сөргөлдөн зогсож байгаагүй, чухамдаа дэлхийн бүх орон дипломат, эдийн засгийн тэмцэлд татагдан орсон байлаа. Дэлхийн хоёр том гүрний хоорондох зэвсэглэлээр хөөцөлдсөн тэмцэл нь олон триллион доллараар хэмжигдэж байна. Хүн төрөлхтөний соёл иргэншлийг бүрмөсөн устгаж болзошгүй байсан цөмийн дайны аюул хэдэн арван жилийн турш дэлхий ертөнцийг нөмөрч байлаа.

Өнөөдөр хүйтэн дайн дуусаж Сталиний үйл ажиллагааны хор уршиг арилж байна. Гэхдээ түүний замыг засаж түүхийн тавцанд гүйцэтгэх харгис үүргийг нь бэлтгэж өгсөн В.И.Ленинд Сталиний үйлдсэн аймшигт гэмт хэргийн тодорхой хувь ногдох ёстой. Гэсэн хэдий ч Сталин бол түүхэн дэх хамгийн харгис дарангуйлагчдын нэг байсан ба түүний хорон ухааныг мартаж хэрхэвч таарахгүй.

# 67. Юлий Цезарь

(JULIUS CAESAR)

Манай эриний өмнөх 100-44 он



Ромын цэрэг, улс төрийн гарамгай удирдагч Юлий Цезарь манай эриний өмнөх 100 онд улс төрийн эмх замбараагүй байдал ноёрхож байсан үед төржээ.

Манай эриний өмнөх хоёрдугаар зуунд ромчууд Пунийн хоёрдугаар дайнд карфагенчуудыг ялж том гүрэн улс байгуулжээ. Энэ дайны явцад олонхи ромчууд баяжсан боловч Ромын нийгэм, эдийн засгийн үндэс суурь хүчтэй ганхжээ. Тариачид өмчгүй болж жижигхэн хотын зөвлөлийн ажлыг зохицуулдаг байсан Ромын сенат том улс орныг удирдах чадваргүй болох нь илт мэдрэгдсэн юм. Улс орны удирдлагын түвшинд хээл хахууль газар авч Ромын олхиогүй удирдагчдаас болж нийт Газрын дундад тэнгисийн ертөнц зовж байв. Ром хотод ч манай эрний өмнөх 133 оноос эхлэн эмх замбараагүй байдал үүсэж улс төрчид, генералууд, хоосон цэцэрхэгчид засгийн эрхийн төлөө хоорондоо тэмцэж партизаны армиуд Ромыг хоёр ч удаа довлон эзлэж байсан удаатай.

Улс орны байдал дордож байсан ч ромын дийлэнх иргэд бүгд найрамдах засгийн газрыг сэргээх хүсэлтэй байв. Гэтэл иймэрхүү засаг захиргааг цаашид хадгалж болохгүй гэдгийг олж харсан анхны улс төрийн нэрт зүтгэлтэн нь Юлий Цезарь болсон юм.

Язгууртан айлд төрсөн Юлий сайн боловсрол эзэмшиж аль залуугаасаа улс төрд оржээ. Манай эриний өмнөх 58 онд Юлий 42 настайдаа Цизальпиний Гали (Умард Итали), Иллири (өнөөгийн Югославын эрэг орчмын нутаг), Нарбоны Галли (Францийн өмнөд эрэг орчим) гэсэн гурван мужийн амбан захирагчаар томилогдож ромын дөрвөн легион буюу хорин мянган орчим торгон цэрэг удирдаж байв.

Манай эриний өмнөх 58-аас 51 онуудад Юлий Цезарь цэргээ удирдан тулалдаж нийт Галли мужийг буюу өнөөгийн Франц, Бельгийн нутаг дэвсгэрийг Швейцар, Герман, Голландын хэсэгтэй нийлүүлсэнтэй тэнцэх нутгийн эзлэв. Цөөхөн цэрэгтэй байсан ч галлийн олон

омгийн хүчирхэг цэргийг дийлж Рейн мөрөн хүртэлх нутгийг Ромын харьяанд нэгтгэсэн юм. Англи руу хоёр удаа аялан байлдах баг явуулсан ч үр дүнд хүрээгүй байна.

Улс төрийн нэрт зүтгэлтэн болох Ю.Цезарь Галлийг бүхэлд нь эзэлснээр түүний нэр хүнд Ром улам өсөж байгаад өрсөлдөгчид нь их айж байлаа. Цэрэг командлах хугацаа нь дуусах үед түүнийг Ромд армиа орхин ирэхийг шаардав. Ромд цэрэггүй очвол улс төрийн өрсөлдөгчид нь шууд ална гэдгийг Ю.Цезарь ойлгож байлаа. Манай эриний өмнөх 49 оны нэгдүгээр сарын 10-наас 11-нд шилжих шөнө Ю.Цезарь Умард Итали дахь Рубикон голыг армитайгаа гаталж Ромын зүг хурдавчлан явлаа.

Энэхүү хууль бус үйлдлээс болж Цезарь болон Ромын сенатын хооронд иргэний дайн дэгдэж дөрвөн жил үргэлжилсэний эцэст Ю.Цезарийн ялалтаар төгсөв. Хамгийн сүүлчийн шийдвэрлэх тулалдаан нь манай эриний өмнөх 45 оны гуравдугаар сарын 7-ны өдөр Испанийн Мунда хотын ойролцоо болжээ.

Ромд хэрэгтэй үр ашигтай үйл ажиллагаа явуулж чадах, гэгээрсэн дарангуйлагч засаглалыг тогтоож чадах цорын ганц хүн нь өөрийгөө болохыг Ю.Цезарь ухаарч манай эриний өмнөх 45 оны аравдугаар сард Ромд эргэн ирж насан туршийн дарангуйлагчаар томилогджээ. Дараа жилийн хоёрдугаар сард түүнд хаан ширээнд залрахыг санал болгоход татгалзав. Гэвч цэргийн жанжин хүн хааны ширээнээс татгалзсанд сөргөлдөгч хүчин болох бүгд найрамдах засаглалын талынхан итгэсэнгүй, манай эриний өмнөх 44 оны гуравдугаар сарын 15-ны өдөр Сенатын хуралдааны үеэр түүний амийг хороожээ.

Ю.Цезарь амьдралынхаа сүүлчийн жилүүдэд улс орны байдалд онцгой анхаарч шинэчлэл хийх өргөн хөтөлбөр боловсруулсан байна. Дайн тулаанд оролцсон ахмад дайчид, ром хотын ядуучуудыг гүрэн даяараа тараан байрлуулахаар зэхэж байв. Зарим хүмүүст Ромын эзэнт гүрний иргэний эрх олгож италийн хотуудыг удирдлагын адилхан бүтэцтэй болгохоор төлөвлөж барилга байгууламжийн ажлыг өргөн далайцтай өрнүүлэх эхлэл тавиад байв. Хууль тогтоомжинд ихээхэн өөрчлөлт хийх зорилготой байв. Гэвч Ромд удирдлагын таарч тохирох үндсэн хуулийн тогтолцоог бүрдүүлж чадаагүй учир дорхноо ялагдал хүлээсэн байна.

Мунда хотод болсон ялалтаас хойш ганцхан жилийн дараа Ю.Цезарь алагдсан учир төлөвлөсөн олон шинэчлэлээ бүрэн хэрэгжүүлж амжаагүй юм. Гэхдээ шинэ он тоолол бий болгосон нь хүн төрөлхтөний хөгжилд их нөлөө үзүүлж өнөөдөр ч хэрэглэгдсээр байна.

Ю.Цезарь хүн төрөлхтөний түүхэн дэх гарамгай улс төрчдийн нэг гарцаагүй мөн ба сод авьяаслаг хүн байв. Азтай улс төрийн зүтгэлтэн, цэргийн гарамгай жанжин, алдартай уран илтгэгч, сайн зохиолч байв. "Галлийн дайны тухай тэмдэглэл" ном нь сонгодог уран зохиолын жагсаалтад зүй ёсоор багтана. Олонхи оюутны саналаар бол энэ ном нь латыний сонгодог уран зохиолын хамгийн сонирхолтой, уншууртай бүтээл ажээ. Зоригтой, далайцтай үйл ажиллагаа явуулдаг, гадна хээнцэр төрхөөрөө олон бүсгүйчүүлийн сэтгэлийг эзэмддэг эр байжээ. Түүний тодорхой жишээ нь алдарт Клеопатраг хатнаа болгож байсан домогт түүх юм.

Эрх мэдэлд дуртай, баян болохын тулд улс төрийн хэлхээ холбоогоо өргөн ашигладаг хүн байсан ч залилах, хууран мэхлэх явдал гаргаж байсангүй. Галлийн дайны үед харгис хэрцгий

зан гаргаж байсан ч дайснаа бууж өгсний дараа найрсаг хандахыг цэргүүддээ анхааруулж байв.

Түүний нэр хүнд асар өндөр болохыг германы хааны нэр болох "цайзер" гэсэн үг, оросын хааны нэр болох "царь" гэдэг үгийг түүний нэрнээс авсан явдал тод гэрчилнэ. Түүний үр удам мөн алдартай хүмүүс байснаас Ромын эзэнт улсыг үндэслэгч, ач хүү Август Цезарь нь бусдаас онцгой билээ. Ю.Цезарь Ромын бүгд найрамдах улсын мөхөлд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн ч Ромын бүгд найрамдах засаглал бараг унаж байсан болохоор тийм их ач холбогдолтой биш ээ.

Галлийг эзлэн түрэмгийлсэн нь томоохон ололт байв. Түүний эзлэсэн нутаг дэвсгэр таван зууны турш Ромын захиргаанд байх хугацаанд тус эзэнт гүрний хууль тогтоомж, ёс заншил, хэл хожим нь христос шашин өргөн дэлгэрчээ. Өнөөгийн франц хэл бол үндсэндээ тэр үеийн ярианы латынь хэлнээс гаралтай юм. Галлийг эзлэн авсны ачаар Итали улс умард зүгээсээ хэдэн зууны турш айх эмээх явдалгүй амар жимэр аж төрж байжээ. Галлийг эзлэсэн нь Ромын эзэнт улсын аюулгүй байдлын баталгаа болж байсан билээ.

Ю.Цезарь бол цэргийн бага хүчээр кельтүүдийн том армийг бут ниргэсэн цэргийн хосгүй гарамгай жанжин юм.

# 68. Байлдан дагуулагч Вильгельм

(WILLIAM THE CONQUEROR)

1027-1087



1066 онд Нормандын ван Вильгельм Англи улсын хаан болох зорилгоор хэдэн мянган цэргээ захирч Ла-Маншийн хоолойг гатлав. Тэр довтолгоон нь Английн нутаг дэвсгэрт гадаадын цэрэг нэвтэрсэн сүүлчийн аян байжээ. Вильгельм болон түүний талынхан Английн хааны ширээг булааж авсан төдийгүй тус улсын цаашдын хөгжилд асар их үзүүлсэн билээ.

Вильгельм 1027 оны орчим Францийн Фалайсе хотод Нормандын ван нэгдүгээр Роберын цорын ганц ба хууль бусаар төрсөн хүү нь болон мэндэлжээ. Эцэг нэгдүгээр Робер нь 1035 онд Иерусалим хотод аялал хийгээд буцаж явах замдаа нас барж аялалд гарахаасаа өмнө Вильгельмийг залгамжлагчаараа гэрээсэлсэн байсан тул найман настай хүү Нормандын вангаар өргөмжлөгджээ.

Вильгельм хүү ийнхүү хар багадаа их эрх мэдэлтэй, баян хүн болсон нь түүний хууль бус гарлыг гоочилдог феодал ноёдын дургүйцлийг төрүүлжээ. Тэд эрх мэдлийн төлөө тэмцэлдэж Вильгельмийн бүх бие хамгаалагч, багшийг нь алжээ. Бяцхан ван хүү Францийн нэгдүгээр Генрих хааны ачаар л амь мэнд гарчээ.

1042 онд 15 настайдаа цэрэг болж хэдэн жилийн дараагаас улс төрийн үйл явдлуудад оролцож феодал ноёдын эсрэг цуврал дайн хийсний үр дүнд сая нэг гүнлэгийнхээ хэмжээнд бүрэн хяналт тогтоож чадлаа. 1063 онд хөрш Майн муж руу дараа нь Бретани муж руу довтолж эзлэжээ.

1042-1066 онуудад Английн хаан байсан Эдуард хүүхэдгүй байсан тул түүнийг зайлуулах гэсэн оролдлого олонтаа гарч байлаа. Эдуардын эх нь өвөөгийнх нь эгч байсан тул ураг

төрлийн талаасаа Вильгельмийн хувьд Английн хаан болох үндэслэл бага байв. Гэвч Эдуард 1051 онд Вильгельмийн зүтгэл тэмүүллийн нөлөөгөөр түүнийг залгамжлагчаараа гэрээслэхээ амлав.

Английн хамгийн хүчирхэг лорд, Эдуардын хамтран зүтгэгч, хүргэн Гарольд Годвин 1064 онд олзлогдоход хааны титмийн төлөө тэмцэлд нь дэмжлэг үзүүлэх амлалт өгөх хүртэл нь Вильгельм түүнийг шоронд чандлан хорьжээ. 1066 онд Эдуард нас барсны дараа Гарольд Годвин өөрийг нь хаанаар өргөмжлөхийг шаардав. Английн лордуудын зөвлөл хааны залгамжлагчийг тодруулах асуудлыг хэлэлцэн шийддэг ёсоороо хуралдаан хийж түүнийг хаанаар залах шийдвэр гаргав. Улсынхаа нутаг дэвсгэрийг өргөжүүлэх ялангуяа өгсөн амлалтаасаа буцсан Гарольдад уурласан Вильгельм Англи улсад зэвсэглэн довлохоор шийдэв.

Вильгельм францийн эрэг орчим усан флот, армия байрлуулж 1066 оны эхээр хөдлөхөөр бэлтгэж байв. Гэтэл умард зүгээс далайн хүчтэй салхи эхэлж аялалаа хэдэн долоо хоног хойшлуулав. Энэ зуур Норвегийн Харальд Хардаад хаан Умард тэнгисийн зүгээс Англид халдахад Вильгельмийг амдан байлдахаар өмнөд зүгт байрлуулсан цэргээ Гарольд Годвин аргагүйд тулж хойд зүгт шилжүүлэн байрлуулав. Стемфорд-Брижийн дэргэд болсон тулалдаанд Норвегийн хаан алагдаж цэрэг нь ухран зугтаж бут ниргүүлжээ.

Хоёр хоногийн дараа Ла-Маншийн хоолойд цаг агаар тогтуун болж Вильгельм цэргээ хөдөлгөж Английн эрэг дээр буулгав. Гарольд тулалдаанд ядарсан цэргээ амрааж сэхээ авхуулах юм уу Вильгельмийн цэргийг амдан хүлээхийн оронд армия халдан түрэмгийлэгчдийн эсрэг шууд хөдөлгөв. 1066 оны аравдугаар сарын 14-ний өдөр Гастингсийн дэргэд болсон алдарт тулалдаанд Вильгельмийн морин цэрэг, нум сумаар зэвсэглэсэн явган цэрэг англосаксоны хүчийг бут ниргэв. Харанхуй болохоос өмнө шинэ хаан Гарольд түүний хоёр ах нь алагдаж английн цэрэг удирдлагагүй болжээ. Тэр жил өвөл нь зул сарын баяраар Вильгельмийг Английн хаанаар өргөмжилөх ёслолыг хийжээ.

Дараагийн таван жилд хэд хэдэн бослого гарсан ч Вильгельм тухай бүрт нь цэргийн хүчээр дарж чаджээ. Шинэ хаан тэдгээр бослогыг далимдуулан английн бүх газар нутагт хяналтаа тогтоож өөрийн өмч болсныг зарлаж дийлэнх хэсгийг нь нормандын хамтран зүтгэгч нартаа бэлэг болгон хуваарилан өгчээ. Ийнхүү английн язгууртнууд газаргүй болов.

Вильгельм өөрийгөө английн жинхэнэ хаан гэж үздэг байсан тул тус улсын төрийн байгууллагуудыг бараг өөрчлөөгүй. Эзэмшил нутаг дэвсгэрийнхээ тухай бүрэн мэдээлэлтэй болохын тулд хүн ам, эд хөрөнгийн бүртгэл явуулах зарлиг буулгасны үр дүнд "Английн газрын бүртгэл" нэртэй том ном гарсан нь өнөө үед түүхэн мэдээллийн үнэт эх сурвалж болж байдаг юм.

Вильгельм хатан, дөрвөн хүү, таван охинтой байсан ба түүнийг 1097 онд Францийн хойд хэсгийн Руан хотод таалал төгссөнөөс хойш Английн бүх хаан түүний үр удам гэж тооцогдсоор өнөөг хүрчээ. Вильгельм нь Английн бүх хаанаас хамгийн чухал нь мөртөө англи хүн биш байсан нь сонин. Францад төрж өөд болсон, амьдралынхаа дийлэнх хугацааг тэнд өнгөрөөсөн, дандаа францаар ярьдаг байжээ. Бичиг үсэгт тайлагдаагүй хүн байсан нь хачирхалтай.

Вильгельм зохион байгуулаагүй бол нормандчууд хэзээ ч Английг эзлэн түрэмгийлж чадахгүй байсан юм. Мянга гаруй жилийн тэртээ болсон ромын байлдан дагуулалтын үеэс хойш Францаас Англи руу довтолж байсангүй, Вильгельмээс хойш Англи руу аль ч улсаас халдан довтолоод үр дүнд хүрсэнгүй өнөө үеийг хүрчээ.

Нормандын байлдан дагуулагчид тооны хувьд цөөхөн байсан ч Английн түүхэнд хэмжээлшгүй их нөлөө үзүүлсэн юм. Нормандын байлдан дагуулалтаас өмнө Английн нутаг дэвсгэр дээр амьдарч байсан хүмүүс үндсэндээ тевтоны буюу германы соёлтой байв. Нормандчууд бол умард зүгийн далайчдын удам боловч соёл хэл нь франц байв. Ийм учраас нормандын байлдан дагуулалт англи, францийн соёлыг нэгтгэжээ.

Вильгельм Англи улсад феодализмын боловсронгуй хэлбэрийг нэвтрүүлсэн юм. Нормандын хаад англосаксоны хаадтай харьцуулахад өөрсдийн мэдэлд хэдэн мянган зэвсэглэсэн дайчидтай байв. Нормандчууд чадварлаг удирдагчид байсны ачаар Английн Засгийн газар Европ тивийн хэмжээнд хамгийн хүчирхэг, үр дүнтэй ажилладаг засгийн газар болсон байна.

Нормандын байлдан дагуулалтын үр дүнд англи хэл англосаксоноос илүү франц, латынь гаралтай үгүүдээр их баяжиж хэл зүйн дүрэм нь улам хялбар болон өөрчлөгджээ.

Нормандын байлдан дагуулалтын дараа английн (норманд гарлынхаа улмаас францад ихээхэн эдлэн газар өмчилдөг) болон францийн хаадын хооронд таван зууны туршид цуврал дайн үргэлжилсэн юм.

1066 оноос өмнө Англи улс үргэлж гаднын халдлагад өртдөг байжээ. Гэтэл Вильгельмийн зохион байгуулсан төвлөрсөн хүчирхэг удирдлага, цэргийн томоохон хүчнээс айж тус улсад халдан довтолох улс орон ганц ч байхгүй болж харин Англи улс гадаад орнууд руу байлдаан хийж эхэлжээ. Европийн орнууд далайн чанадад аян дайн хийх үед Англи улс бусад улсаас илүү их харьяат орон, удам газар нутагтай болсон билээ.


Вильгельмийг английн түүхийн дараагийн бүх үйл явдалд холбоотой гэж үзэж болохгүй боловч нормандын байлдан дагуулалт хожим нь болсон олон үйл явдалд нөлөөлсөн дам хүчин зүйл болсныг хэн ч үгүйсгэх аргагүй юм.



# 69. Зигмунд Фрейд

(SIGMUND FREUD)

1856-1939



Сэтгэл зүйн задлан шинжилгээний эмчилгээний аргыг үндэслэгч, гарамгай эрдэмтэн Зигмунд Фрейд 1856 онд одоогийн Чех улсын нутаг дэвсгэр дээр орших, тухайн үеийн Австрийн эзэнт гүрний Фрайбург хотод төржээ. Дөрвөн настай байхад нь эцэг, эх нь Вена хотод шилжин сууршснаас хойш насан туршаа тэнд амьдарч ажиллажээ.

1881 онд Венийн их сургуулийг эмчийн мэргэжлээр төгсөж дараагийн арван жилд сэтгэцийн клиникийн эмнэлгийн бүх ажилтантай хамтран сэтгэл зүйн салбарт судалгаа туршилт, неврологийн салбарт бие даасан эмчилгээ хийж Париж хотод францийн тэргүүлэх невролог Жан Шарко, тэрчилэн Венийн эмч Йозеф Бреер нартай хамт ажиллажээ.

З.Фрейдийн Бреертэй хамтран туурвисан "Галзуурлын үе шатууд" ном нь 1895 онд хэвлэгджээ. Дараагийн "Зүүдийг тайлбарлах нь" ном нь 1900 онд гарч муу борлогдож байсан ч зохиогчийнхоо нэр хүндийг улам өргөжээ. Түүний бүтээлүүд дараалан хэвлэгдсээр, 1908 онд АНУ-д цуврал лекц уншиж байх үед дэлхийд нэр алдар нь аль хэдийнээ цуурайтсан байлаа. 1902 онд Вена хотод сэтгэл зүйн маргааны дугуйлан байгуулахад, Адольф Гитлер анхны гишүүдийнх нь нэг болж удсангүй Карл Юнг гишүүнээр элсчээ. Ийнхүү З.Фрейд, К.Юнг хоёр дэлхийд алдартай сэтгэл зүйчид болжээ.

З.Фрейд эхнэр, зургаан хүүхэдтэй байв. Амьдралынхаа сүүлчийн жилүүдэд эрүүний өмөн үү өвчин тусаж түүнээсээ ангижрах гэж 1923 оноос хойш гуч гаруй хагалгаа хийлгэжээ. Өвчтэй байхдаа ч ажилласаар нилээд хэдэн чухал бүтээл туурвижээ. 1938 онд нацистууд Вена хотыг эзлэхэд 82 настай З.Фрейд еврей үндэстэн тул заалхаан цээрлүүлэлтээс зугтаж Лондон руу нисэж тэнд жилийн дараа өөд болсон ажээ.

Түүний сэтгэл зүйн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр зүйргүй их ажээ. Хүний аливаа үйлдэлд байдаг оюун санааны ухамсарлаагүй үйлдлүүдийн их ач холбогдлыг гаргаж тавьсан. Оюун санааны ухамсарлаагүй үйлдлүүд нь зүүдний агуулгад нөлөөлж хэлээ хазах, хүний нэр мартаж, золгүй явдал тэр ч бүү хэл өвчин зэрэг ердийн таагүй явдлуудын шалтгаан болдгийг нээн харуулсан билээ.

Сэтгэл зүйн задлан шинжилгээний техникийг сэтгэцийн өвчнийг анагаах арга болгон

хөгжүүлсэн юм. Хувь хүний бүтцийн онолыг томъёолж сэрэл, хамгаалах үйлдэл, үргүйдлийн цогц, сэтгэл санаагаар унах, хатуу байдлаас шингэн байдлыг алгасан хийн хэлбэрт орох бодисын шилжилттэй холбоотой сэтгэл зүйн онолуудыг хөгжүүлэн дэлгэрүүлжээ. Ер нь бүтээл туурвилаараа сэтгэл зүйн онолд олон нийтийн анхаарлыг хандуулж чадсан юм. Түүний дэвшүүлсэн олон санаа хоорондоо зөрчилдөөнтэй болохоор өнөөдөр ч эрдэмтэд маргалдсаар байна.

Сексийн сэрлээ зориуд дарах нь ихэнхи тохиолдолд сэтгэцийн өвчний шалтгаан болдог, сексийн сэрэл хүсэл нь идэр залуу биш чухамдаа бага насанд бий болдог гэсэн үзэл нь З.Фрейдийг нэрд гаргасан билээ.

Тэр шинэ бодол санаа дэвшүүлэхдээ гарамгай эрдэмтэн байлаа. Түүний дэвшүүлсэн онолууд нь Дарвин, Пастер нартай харьцуулахад эрдэмтдийн дэмжлэгийг хэзээ ч хүлээж байгаагүй билээ. Тийм учраас түүний дэвшүүлсэн олон онолоос нь алийг нь туйлын зөв гэж хэлэхэд их бэрх байдаг.

Үзэл бодол нь зөрчилдөөнтэй боловч З.Фрейд хүн төрөлхтөний сэтгэлгээний түүхэн дэхь аугаа хүн мөн. Сэтгэл зүйн салбарт түүний дэвшүүлсэн санаа хүний тархины тухай хүн төрөлхтөний ойлголтод жинхэнэ хувьсгал хийсэн юм.

Сэтгэл зүйн задлан шинжилгээний аргыг хэрэглэхэд эмчилгээ тухай бүр үр дүнд хүрч сэтгэцийн өвчин тэр бүр эдгэрдэггүй, гэхдээ маш их амжилтын баталгаа болдог юм. Сексийн сэрлээ зориуд дарах нь хүний зан аашинд харьцангуй бага үүрэг гүйцэтгэдэг гэж ирээдүйд сэтгэл зүйчид нотлож болох талтай. Гэхдээ л Фрейдийн өмнөх үеийн сэтгэл зүйчдийн үзэж байснаас хавьгүй илүү үүрэг гүйцэтгэж байдгийг нь хэн ч буруу гэхгүй биз ээ. Оюун санааны ухамсарлаагүй үйлдэл нь хүний аливаа үйлдэлд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг юм байна гэж өнөөдөр ихэнхи сэтгэл зүйчид үзэж байна.

# 70. Эдуард Женнер

(EDWARD JENNER)

1749-1823



Аймшигт хор хөнөөлтэй цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын техникийг хөгжүүлж түгээн дэлгэрүүлсэн хүн бол английн эмч Эдуард Женнер билээ.

Чухамдаа түүний ачаар өнгөрсөн зуунуудад аймшигт хор уршигтай байсан цэцэг өвчнөөс хүн төрөлхтөн бүрмөсөн ангижирсан билээ. Цэцэг өвчин нь халдвартай ихтэй тул тухайн үедээ европ тивд халдвар авсан хүмүүсийн 10-20 хувь нь үхэж эдгэрэн амьд үлдсэн хүмүүсийн 10-15 хувийнх нь бие үзэшгүй муухай болдог байв. Цэцэг өвчин Европ төдийгүй Хойд Америк, Энэтхэг, Хятад гээд дэлхийн өнцөг булан бүрт гарч хүмүүсийг толгой дараалан хяргадаг байлаа. Ялангуяа хүүхдэд их тусдаг билээ.

Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжийн арга олох оролдлого удтал үргэлжилсэн юм. Цэцэг өвчин тусаад эдгэрсэн хүнд дархлал бий болж дахин ер хүрдэггүйг нь хүмүүс аль хэдийнээс ажиг-лан мэддэг болсон байлаа. Тийм учраас дорно зүгийн орнуудад цэцэг өвчин хөнгөн тусаад эдгэрсэн хүний эдийг авч эрүүл хүнд тарьвал цэцэг өвчин хөнгөн тусна, дархлаатай болно гэж үздэг байв.

ХҮШ зууны эцсээр хатагтай Мери Уортли дээрх аргыг Англид нэвтрүүлж Женнерээс өмнө өргөн хэрэглэж байжээ. Э.Женнер ч гэсэн багадаа цэцэг өвчнөөр өвдөөд эдгэсэн байлаа. Дээрх аргын гол дутагдал нь гэвэл тийм тарилга хийлгэсэн хүмүүс цэцэг өвчнөөр хөнгөн биш харин бүр хүнд өвчилж бие нь зүйргүй муухай болсон хэвээр байв. Тэр ч бүү хэл тарилга хийлгэсэн хүмүүсийн хоёр хувь нь цэцэг өвчин тусаж үхсээр байв. Иймд цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх өөр найдвартай арга олох шаардлагатай байлаа.

Э.Женнер Английн Глочестершир гүнлэгийн Беркли хэмээх бяцхан хотод 1749 онд төрж 12 настайдаа мэс засалчийн шавь болжээ. Анатоми судалж эмнэлэгт ажиллана. 1792 онд Гэгээн Эндрюгийн их сургуульд анагаах ухааны эрдмийн зэрэг хүртэж 35 настай хүрэх үедээ

Глочестершир гүнлэгтээ нэр хүндтэй эмч, мэс засалч болсон байлаа.

Үнээнд тусдаг цэцэг өвчний халдвар авсан хүнд цэцэг өвчин дахин тусдаггүй гэж гүнлэгийн саальчин бүсгүйчүүл, тариачид ярьдагийг Женнер дуулсан байв. Тэд лавтайяа үнэн ярьцгааж байгаа бол үнээнд туссан цэцэг өвчний тунг хүнд таривал уг өвчний эсрэг дархлаа бий болох юм биш байгаа гэсэн бодол түүнд төржээ. Тэгээд энэ асуудлыг анхааралтай судалж 1796 онд биечлэн шалгахаар шийдэв.

Үнээний цэцэг өвчин халдсаны улмаас саальчин эмэгтэйн гар дээр гарсан батганаас нян авч тухайн оны тавдугаар сард Жеймс Фиппсу нэртэй найман настай хүүд тарьжээ. Хүү үнээнээс цэцэг өвчний халдвар авсан ч төдсөнгүй бие нь эдгэжээ. Хэдэн долоо хоногийн дараа өнөөх хүүд жинхэнэ цэцэг өвчний тариа хийв. Женнерийн найдаж байснаар хүүд халдвар авсан ямар ч шинж тэмдэг илэрсэнгүй.

Туршилтаа үргэлжлүүлсээр "Цэцэг өвчний вакцинний нөлөөг судалсан нь" нэртэй товхимол бичиж 1798 онд хэвлүүлсний дараа цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх явдал түргэн дэлгэрчээ. Женнер мөн таван өгүүлэл бичиж олсон аргаа өргөн дэлгэрүүлэх талаар нилээд хэдэн жил ихээхэн хөдөлмөр зарцуулсны үр дүнд эхлээд Английн арми, тэнгисийн цэргийн флотод дараа нь дэлхий даяар хүлээн зөвшөөрчээ.

Женнер цэцэг өвчний эсрэг ванцинжуулах техникийг хаа сайгүй сурталчлах явцдаа ямар ч ашиг хонжоо хөөцөлдөж байсангүй, тийм учраас Английн парламент түүний хүнлэг зүтгэлийг үнэлж 1802 онд арван мянган паундаар, хэдэн жилийн дараа дахин хорин мянган паундаар нэмж шагнажээ. Түүний нэр дэлхий даяар алдаршиж гадаад орны олон одон, медалиар энгэрээ цоолжээ. Эхнэр, гурван хүүхэдтэй байсан, 1823 оны эхээр 73 настайдаа Беркли хот дахь гэртээ өөд болжээ.

Э.Женнер нэртэй цуутай эрдэмтэн байгаагүй ч хүн төрөлхтөнд их ачтай тустай гавьяа байгуулсан жирийн эмч юм. Э.Женнер чухамдаа эмч нар ойшоож үздэггүй байсан олон түмний яриаг туршилт судалгаа хийн нотлож хэдэн арван сая хүний амь насыг авран хамгаалсан юм.

# 71. Вильгельм Конрад Рентген

(WILHELM CONRAD RONTGEN)

1845-1923



Рентген цацрагийг нээсэн их эрдэмтэн Вильгельм Конрад Рентген Германы Леппен хотод 1845 онд төрж 1869 онд Цюрихийн их сургуульд гүн ухааны докторын зэрэг хамгаалжээ. 19 жилийн хугацаанд нилээд хэдэн их сургууль дамжин багшилж сайн эрдэмтэн гэсэн алдар хүртжээ. 1888 онд Вюрцбургийн их сургуулийн физикийн профессор, тус их сургуулийн дэргэдэх физикийн хүрээлэнгийн захирлаар томилогдон ажиллаж байх үедээ дэлхийд цууд гарсан нээлтээ хийжээ.

1895 оны II дүгээр сарын 8-ны өдөр катодын цацрагийн туршилт хийж байв. Хоёр талаас нь гагнасан, доторхи агаарыг нь сорон гаргасан шилэн хоолойны дотор байрлуулсан электродуудын дундуур өндөр хүчдэл гүйлгэхэд электронуудын урсгалаас катодын цацраг үүснэ. Катодын цацраг бол нэвтрэх чадвар тааруу учир хэдхэн сантиметр зузаан агаар байхад л цааш явдаггүй ажээ. Тийм учраас катодын хоолойг зузаан хар цаасаар сайтар хааж цахилгаан гүйдэл гүйлгэсэн нөхцөлд ч ямар ч цацраг нэвтрэн гарахгүй гэж тооцож байв. Гэтэл гүйдлийг хоолойд хүргэтэл ойролцоо орших флуоренценцийн дэлгэц гэрэл туссан мэт гэрэлтэхийг ажиглаж мэл гайхжээ. Гүйдлийг салгахад дэлгэц харанхуй болов.

Катодын хоолой бүрэн хаалттай байсан болохоор, цахилгаан гүйдэл өгсөн тохиолдолд ямар нэгэн үл харагдах цацраг тархаж байна гэдгийг ойлгов. Учир нь үл мэдэгдэх тэр цацрагийг, математикт үл мэдэгдэх хэмжигдэхүүнийг "x" үсгээр тэмдэглэдэг шиг мөн "x" гэж бичжээ.

Рентген санамсаргүйгээр нээлт хийснээ ухаарч "x" цацрагийн шинж чанаруудыг судлахад бүхий л анхаарлаа төвлөрүүлэв. Хэд хоног туршилт хийсний эцэст: нэгдүгээрт "x" цацрагийг платиноцианидийн бари болон химийн бусад янз бүрийн бодисоос өөр бодисоор гэрэлтүүлж болно, хоёрдугаарт "x" цацраг нь ердийн гэрэл нэвтрэч чадахгүй олон эд зүйлсийг нэвтрэн гарч чадна, түүний дотор биеийг нь нэвтрэн гарч байсан ч ясанд тулаад саатаж байсан, учир нь катодын хоолой болон флуоресцентийн дэлгэц хоёрын хооронд гараа барьтал дэлгэц дээр гарынхаа ясыг харжээ, гуравдугаарт "x" цацраг нь шулуун замаар цацардаг, цахилгаан

гүйдлээс цэнэглэгдсэн хэсгүүдээс ялгаатай нь гэвэл соронзон талбай үүсгэхэд чиглэлээ огт өөрчлөхгүй байлаа.

1895 оны II дүгээр сард "х" цацрагийн тухай анхны бүтээлээ бичиж нийтлүүлсэн нь тэр дороо эрдэмтдийн анхаарлыг татаж жилийн дараа гэхэд хэдэн зуун эрдэмтэн тэрхүү цацрагийн тухай мянга шахам өгүүлэл хэвлүүлсэн байлаа. Эрдэмтэн Анри Беккерель рентген цацрагийг судалж байхдаа цацраг идэвхт чанарын илүү чухал үзэгдлийг нээсэн юм.

Электронууд асар их хурдтайгаар ямар нэгэн зүйл мөргөхөд рентген цацраг бий болно. Цацраг нь электронуудаас биш цахилгаан соронзон долгионоос бүрдэнэ. Энэ утгаараа харагдаж байдаг цацрагтай (өөрөөр хэлбэл гэрлийн долгионтой) адилхан ч долгионы урт нь бүр богинохон юм.

Эмнэлгийн дүгнэлт гаргах шүд эмчлэхэд рентген цацрагийг өргөн хэрэглэж байна. Радиотерапид рентген цацрагийг ашиглаж хорт хавдрыг устгах юм уу өсөлтийг нь зогсооно. Рентген цацрагийг аж үйлдвэрийн салбарт өргөн хэрэглэнэ, тухайлбал зарим материалын зузааныг хэмжих, доторхи гологдлыг илрүүлэхэд ашиглана, ер нь биологийн шинжлэх ухаанаас одон орны судлал хүртэлх олон салбарт хэрэгтэй байна. Атомын болон молекулын бүтцийн тухай өргөн мэдээлэл байгаа нь рентген цацрагтай холбоотой.

Рентген цацрагийг нээхэд Рентген гол үүрэг гүйцэтгэсэн нь мэдээж. Гэхдээ рентген цацраг нь хүн төрөлхтөнд технологийг шинэчлэх, шинжлэх ухааны онолд суурь ач холбогдолтой байгаагүй. Хүн төрөлхтөн нээгээд зуу гаруй жил болж байгаа хэт ягаан туяатай адилхан рентген цацраг нь сонгодог физикийн хүрээнд л багтана.

Хүүхэдгүй байсан тул эхнэртэйгээ цуг өргөмөл охиноо өсгөж бойжуулжээ. 1901 онд физикийн салбар дахь Нобелийн анхны шагналыг түүнд олгосон, 1923 онд Германы Мюнхен хотод нас баржээ.

# 72. Иоганн Себастьян Бах

(JOHANN SEBASTIAN BACH)

1685-1750



Сод хөгжмийн зохиолч И.С.Бах бол Өрнөд Европийн бүх үндэстний хөгжмийн дэг жаягийг амжилттай нэгтгэж чадсан анхны уран бүтээлч юм. Итали, франц, германы хөгжмийн шилдэг уламжлалыг хоршиж тэдгээрийг улам баяжуулсан юм. Амьд сэрүүндээ ч өргөн олон танил бус байсан түүнийг нас барснаас нь хойш бараг тавин жил мартсан байлаа.

Гэвч түүний нэр хүнд, алдар суу сүүлийн 150 жилийн туршид улам өссөөр бүх цаг үеийн хоёр гуравхан суут хөгжмийн зохиолчдын нэг гэж зүй ёсоор тооцож байна.

Германы Эйзенах хотод 1685 онд хөгжмийн авьяасыг бишрэн шүтдэг гэр бүлд төржээ. Эцэг нь чадварлаг хийлч, өвөөгийнх нь хоёр ах нь нэртэй хөгжмийн зохиолч, хэд хэдэн үеэл ах нар нь цуутай хөгжимчид байжээ.

Эх нь есөн настай байхад нь эцэг нь арван настай байхад нь өөд болж өнчирчээ. Хүүхэд байхдаа Лüneбург дэхь Гэгээн Михаилийн сургуульд элсэж 1702 онд төгсөж дараа жил нь цөөхүүл хөгжмийн хамтлагт хийлч болов. Дараагийн хорь гаруй жил олон газар дамжин ажиллажээ. Бах нь аугаа их хөгжмийн зохиолч, нэртэй багш, цуутай удирдаач байсан ч амьд сэрүүн байх үедээ бадралт баг бишгүүрт хөгжим хосгүй тоглогч байснаараа л алдартай байсан байна.

1723 онд 38 настайдаа Лейпциг хотод Гэгээн Томасын сүмд бадралт баг бишгүүр хөгжимчний ажилд орж 1750 онд нас барах хүртлээ 27 жил тэнд ажиллажээ.

Ажил хөдөлмөр хийж гэр бүлээ тэжээж чадаж байсан ч Моцарт, Бетховен шиг амьд сэрүүн байхдаа алдар нэртэй байгаагүй юм. Тэр ч бүү хэл түүний багш нар ч гайхамшигт авьяасыг нь хүлээн зөвшөөрч байсангүй. Лейпциг хотын сүм "авьяаслаг хөгжимчинтэй" болох зарлал

гаргасны дараа хоёр хүн ирсэн нь шаардлага хангаагүй учир уг албан тушаалд Бахыг аргагүйн эрхэнд авчээ. Хамгийн хачирхалтай үйл явдал нь, Бахыг Веймар хотод сүмийн бадралт баг бишгүүр хөгжимчний албан тушаалас татгалзахад тус хотын захирагч хилэгнэж түүнийг баривчлуулж гурван долоо хоног шоронд суулгаад суллаж байжээ.

22 настайдаа үеэл дүү охинтойгоо сууж долоон хүүхэдтэй болсны дараа эхнэр нь түүнийг 35 настай байхад нь өөд болжээ. Бах дараа жил нь дахин гэрлэж тэр эхнэр нь түүний хүүхдийн тоог 13-т хүргэжээ. Гэвч долоон хүүхэд нь эцгийнхээ дараа нас барж тэд нараас дөрөв нь алдар цуутай хөгжимчид болжээ. Энэ утгаараа И.С.Бахын гэр бүл үе дамжсан хөгжмийн авьяастнууд байжээ.

Бах бол үнэхээр асар их уран бүтээл туурвижээ. Ойролцоогоор 30 кантат, 48 фуг, прелюди тэрчилэн 140 прелюди, клавесин хөгжимд зориулсан зохиомж, 23 концерт, 4 удиртгал, 33 сонат, 5 месс, 3 магтуу зэрэг олон бүтээл гараасаа гаргажээ. Амьдралынхаа хугацаанд найман зуу гаруй хөгжмийн дорвитой бүтээл туурвижээ.

Бах шашны гүн шүтлэгтэн байсан болохоор түүний бүх уран бүтээл шашны аялгуугаар дүүрэн байдаг нь ойлгомжтой. Хөгжмийн шинэ чиглэл, урсгал бий болгохыг хүссэнгүй, харин аль хэдийнээ бий болсон төрлийг улам боловсронгуй болгохын төлөө насан туршаа зүтгэжээ.

Өөд болоод тавь гаруй жил болсны дараа ч Гайдн, Моцарт, Бетховен нараас бусад хөгжмийн зохиолч түүний аугаа болохыг хүлээн зөвшөөрөхгүй байлаа. Яагаад гэвэл хөгжмийн шинэ урсгал гарч нэг хэсэгтээ түүний бүтээлийг тоохгүй байлаа. Гэвч 1800 онд Бахыг дахин сонирхож эхэлсэн үеэс түүний нэр дэлхий даяар алдаршжээ. Өнөө үед амьд байх үеэсээ илүү улам нэрд гарсаар байна. Хоёр зуу гаруй жилийн тэртээ хоцрогдсон гэж гоочлогдож байсан Бах өнөөдөр илүү орчин үеийнх гэж үнэлэгдэж байгаа нь хачирхмаар. Тэр яагаад ийм их алдар цуутай байгаа юм бэ?

Түүний тоглолтын техник арга барилын хувьд аугаа хөгжмийн зохиолчид дотроо хамгийн гарамгай нь байгаа юм. Тухайн цаг үеийнхээ хөгжмийн бүх эх сурвалжийг бүрэн эзэмшиж, байжээ. Тухайлбал дараа үеийн хөгжмийн зохиолчдоос олон аялгууг нэгэн зэрэг дуугаргах (хоёр болон түүнээс илүү аялгуу дуугаргах ур чадвар) талаар хэн нь ч түүнтэй эн зэрэгцэхүйц байж чадаагүй билээ. Түүний зохиосон аялгуунууд дотоод төгс цогц, зохиомжийн бүтэц, аялгууны талаасаа бүхний гайхшийг өнөө хэр төрүүлсээр байна.

Түүний бүтээлүүдийн бүтцийн өвөрмөц байдал, гүн утга агуулга хөгжим судлаачдын анхаарлыг одоо ч татсаар байна. Бах бол хөгж-мийн зохиолчийн хувьд судлах байтугай сонсоход төвөгтэй хэдий боловч түүний бишрэн шүтэгчид нь дан хөгжмийн зохиолчид, судлаачид биш юм. Бахын аялгуутай пянз, хальсууд бусад сонгодог хөгжмийн зохиолчдынхоос илүү арилжаалагдсаар байгаа нь нэн сонин.



# 73. Лао-Зы

(LAO TZU)

Манай эриний өтнөх Үзууны уе



Хятад улсын хэдэн мянган жилийн түүхэнд хамгийн олон удаа гадаад хэл дээр орчуулагдсан зохиол нь хоёр мянга гуруй жилийн тэртээ зохиогдсон "Лао-цзы" буюу "Дао де цзин" ("Сонгодог зам ба түүний хүч") хэмээх таозм шашны гүн ухааны учрыг тайлбарласан нимгэн ном билээ.

Тао хэмээх шашны гол санаа болох энэ үг нь зам гэсэн утгатай. Гэхдээ уг ном нь "Дао гэдэг үгийг хэлж болно, гэхдээ энэ үг бол мөнхийн биш." гэсэн бүрхэг агуулгаар эхэлнэ. Ер нь бол Дао гэдэг нь "байгаль" буюу "жам ёсны дэг журам" гэсэн утгатай ажээ.

Аливаа хүн Даоизм шашны эсрэг тэмцэх ёсгүй, харин түүнд дасаж түүний төлөө тэмцэх хэрэгтэй. Эрх мэдлийн төлөө идэвхтэй тэмүүлэх нь ёс суртахуунгүй төдийгүй утга учиргүй үйлдэл болой. Даог ялан дийлнэ гэж хэзээ ч байхгүй, тиймд түүнтэй зохицон амьдрах нь өлзийтэй. Зөөлөн ба ямар ч хэлбэр-гүй ус нь намхан газар руу зөнгөөрөө урсаж ямартаа боловч эвдлэн сүйтгэгч биш боловч он цагийн уртад асга хадыг хүртэл элээдэг гэж даостууд үзнэ.

Жирийн иргэн энгийн, байдгаараа байх нь зүйтэй. Хөрөнгө мөнгө, алдар нэрийн төлөө мэрийх шиг хүчирхийллийг таашааж болохгүй. Хүн хорвоо дэлхийг өөрчлөх биш түүнийг хүндэтгэх хэрэгтэй. Засгийн газруудын хувьд идэвхтэй бус бодлого явуулах нь зөв чиглэл болно. Нийгэмд үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн дэндүү олон дүрэм журам байна. Шинээр хууль санаачлах буюу хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудыг хүчээр шинэчлэх нь үйл байдлыг улам дордуулна. Юмны үнийг хөөрөгдөх, засгийн газрууд элдэв хөтөлбөр дэвшүүлэх, дайн байлдаан өдөөх нь таоист гүн ухаантай харшилна.

Хятадын домгоор бол "Лао-цзы" сургаалыг үндэслэгч нь Күнзтэй нэгэн үе амьдарч байсан Лао-Цзы гэдэг хүний бүтээл ажээ.

Манай эриний өмнөх ҮI зуунаас өмнө амьдарч байсан Күнзийн зохиол бүтээлүүдтэй агуулга, бичлэгийн хэв маягаар нь харьцуулж үзэхэд "Лао-цзы" зохиол түрүү үед бичигджээ. Иймд энэхүү зохиол хэзээ зохиогдсон, Лао-цзы гэдэг хүн ханаа хэдийд төрсөн, ямар үйл ажиллагаа явуулж байсан талаар өнөө хэр эрдэмтэд, судлаачид маргалдсаар байна. Гэхдээ Лао-цзы манай эриний өмнөх 320 оны үед мэндэлсэн нь яг таг тогтоогдсон байна.

Зарим судлаач, Лао-Цзы нь манай эриний өмнөх ҮI зуунд амьдарч байсан, тиймд "Лао-цзы" зохиолыг бичээгүй гэж үздэг. Зарим судлаач түүнийг домгийн баатар гэнэ. Гэхдээ нэгдүгээрт Лао-Цзы гэдэг бодит хүн байсан ба "Лао-цзы" зохиолыг туурвисан, хоёрдугаарт тэр хүн ҮI зуунд амьдарч байсан, гуравдугаарт Лао-Цзы нь Күнзтэй нэгэн үед амьдарч байсан гэдэг нь худлаа, таоист гүн ухаантнууд түүний бичсэн номын нэр хүндийг өргөх гэж тийм сурталчилгааг өргөн дэлгэр хийсэн гэж бас үздэг юм.

Хятадын эртний зохиолч гүн ухаантнуудаас Күнзий (манай эриний өмнөх 551-479 он), Мо-Цзы (манай эриний өмнөх Ү зуун), Мэн-Цзы (манай эриний өмнөх 371-289 он) нар Лао-Цзы, Тао Те Чин нарын тухай ер дурдаагүй байдаг мөртөө манай эриний өмнөх 300 оны үед бүтээл туурвилаа хийж байсан таоист шашны онолч Чжуан Цзыгаас дандаа ишлэл авсан байна.

Лао-Цзы нь Хятад улсын хойд хэсэгт төрж амьдралынхаа дийлэнх хугацааг Чжоу угсааны хаадын нийслэл Лоян хотод албан ёсны архивын газарт дарга, түүхчийн ажил эрхэлж өнгөрөөжээ. Лао-Цзы гэдэг нь нэр биш чухамдаа хэргэм ба "эртний уран чадвартан" гэсэн утгатай ажээ. Гэрлэж нэг хүүтэй болж Цанг нэр өгсөн нь хожим нь Вэй мужид цэргийн жанжин болсон байна.

Таоизм нь жирийн нэгэн гүн ухааны сургаал болон үүссэн ч яваандаа шашны урсгал болон хувирсан билээ. Таоизм нь гүн ухааны сургаалын хувьд "Лао-цзы" номонд илэрхийлсэн үзэл санаанаас үүсэлтэй юм. "Лао-Цзы" номоос эхтэй таоизм шашин нь түүхийн олон жилийн хугацаанд ер бусын домог, заншлаар улам баяжсаар Лао-Цзын сургаалаас улам холдсон байна.

Гэхдээ "Лао-Цзы" зохиолын түүхэнд үзүүлсэн нөлөө асар их юм. Хэмжээний хувьд хятад хэлний зургаан мянган ханз үсгээс бүрдэх ба энэ нь сонины ганц хуудастай тэнцэнэ.

"Лао-цзы" зохиол нь Конфуций болон хятадын бусад сэтгэгчдээс илүү өрнөд европт дэлгэрсэн бүтээл юм. Англи улсад гэхэд л дөч гаруй орчуулга байгаа нь Библийн судраас давж байна.

Хятад улсад Күнзийн сургаал хамгийн өргөн дэлгэрсэн ч Лао-Цзы, Күнзийн сургаалиудын хооронд маргаан гарахад Күнзийн үзэл бодлыг илүүд үзсээр иржээ. Гэсэн хэдий ч Күнзийн сургаалыг баримтлагчид Лао-Цзыг бишрэн хүндэтгэдэг. Түүнээс гадна Лао-Цзын сургаалын олон үзэл бодол Күнзийн сургаалд шингэж таоист шашныг бишрэн шүтэгч бус олон сая хүний оюун санаанд нөлөө үзүүлсээр хэдэн зуун жил болж байна. Таоист шашин нь хятад улсад бүддийн шашин дэлгэрэн түгэхэд ихээхэн нөлөө үзүүлснийг дурдахгүй байж болохгүй юм. Лао-Цзыгээс өөр хүн төрөлхтөний оюун санааны хөгжилд Күнзтэй эн зэрэгцэх нөлөө үзүүлсэн хятадын гүн ухаантан байхгүй билээ.

# 74. Вольтер

(VOLTAIRE)

1694-1778



Вольтер хэмээх нууц нэрээрээ алдаршсан Франсуа Мари Аруэ бол францийн Сэргэн мандалтын гол зүтгэлтэн байлаа. Яруу найрагч, жүжгийн зохиолч, роман зохиогч, богино өгүүллэгийн хосгүй ур чадвартан, түүхч, гүн ухаантан Вольтер эрх чөлөөг эрмэлзэгч үзэл санааны загалмайлсан эцэг байлаа.

1694 онд Париж хотод дунд зэргийн чинээлэг хуульчийн гэр бүлд төржээ. Луи-ле-Грандын шашны сургуульд элсэж хууль зүй үзэж байснаа сургуулиа хаяж төдсөнгүй шог, хошин шүлэг зохиогч болж Париж даяар алдаршжээ. Францийн тухайн үеийн бүдүүлэг дэглэмийн үед түүний хурц үг таалагдсангүй, улс төрийн агуулгатай шүлгүүд бичсэн учир баривчлагдан Бастилийн шоронд оржээ. Жил гаруй шоронд хоригдож байх хугацаандаа "Генриада" хэмээх найраглал бичсэн нь хожим нь ихэд түгжээ. 1718 онд шоронгоос суллагдсаныхаа дараа "Эдип" драмын жүжиг туурвиж Париж хотод тоглуулсан нь олны талархал хүлээв. 24 настайдаа нэрт зохиолч болж амьдралынхаа үлдсэн хугацаанд францийн уран зохиолын гол төлөөлөгч байжээ.

Вольтер мөнгийг уран үг шигээ хямгаддаг байсны үр дүнд их баян, бие даасан хүн болжээ. Гэвч цаг үеийнхээ хамгийн ухаалаг уран хурц үгтэй хүн байсан ч францийн язгууртнуудын үнэлдэг даруу зан ааш түүнд байсангүй. 1726 онд язгууртан Шевалье де Рогантай олны өмнө үгээр цэц маргалдан түүнийг дийлжээ. Үүнд хорссон Шевалье де Роган хулиганууд хөлслөн түүнийг зодуулж дараахан нь элдэв шалтаг зааж Бастилийн шоронд хориулжээ. Вольтер эх орон Франц улсаасаа эгнэгт явах болзолтойгоор шоронгоос суллагдаж Англид гарч тэнд хоёр жил хагас амьдарчээ.

Англид очсон нь түүний амьдрал, үйл ажиллагаанд эргэлтийн үйл явдал болж англи хэлийг сайтар сурч Жон Локк, Фрэнсис Бэкон, Исаак Ньютон, Уильям Шекспир зэрэг алдарт сэтгэгч, эрдэмтэн, зохиолчдын бүтээлүүдтэй болон тухайн үеийн ухаантнуудтай дотно танилцаж сэтгэлгээнийхээ хүрээг үлэмж тэлжээ. Шекспир, английн шинжлэх ухаан,

эмпиризмийг биширч ялангуяа тус улсын улс төрийн тогтолцоог шагшин бахархжээ. Англи дахь ардчилал, хувь хүний эрх чөлөөний асуудал Францийн бодит байдалтай эрс тэс зөрж байгааг ойлгов. Чухамдаа английн ямар ч баян, ямар ч их эрх мэдэлтэй лорд Вольтерийг буруу хэрэг хийгээгүй байхад хууль гаргаж шоронд суулгаж чадахгүй байгаа нь түүний сэтгэлийг догдлуулжээ. Түүнийг буруу хэрэг хийлээ гэж гүжирдэхэд шүүхээр орсны дараа гарцаагүй цагаадах байсанд Вольтер үнэхээр биширчээ.

Эх орондоо буцаж ирсний дараа гүн ухааны анхны чухал бүтээл болох "Гүн ухааны захидлууд" буюу голдуу "Английн захидлууд" гэж нэрлэдэг номоо гаргав. 1734 онд хэвлэгдсэн энэ ном нь францийн Сэргэн мандлын эхлэл болсон билээ. "Английн захидлууд" номондоо английн улс төрийн тогтолцоо, Жон Локк зэрэг бусад сэтгэгчийн үзэл бодлыг сайшаан магтсаны улмаас францийн эрх баригчдын гүн дургүйцлийг хүргэж Париж хотоос зугтан гархаас өөр аргагүй болжээ.

Дараагийн 15 жилийг Францийн дорнод хэсэгт орших Цири хотод гүнгийн үзэсгэлэн гоо, боловсролтой гэргий хатагтай дю Шателейн дэргэд өнгөрөөжээ. Хайрт бүсгүйгээ нас барснаас нэг жилийн дараа 1750 онд Пруссын Их Фридрих хааны урилгаар Подстам хотод очиж тэнд гурван жил суув. Өндөр боловсролтой, ухаантай хаантай нөхөрлөж дотно байсан ч эцэст нь хэрэлдэж 1753 онд Германаас явжээ.

Швейцарын Женев хотын ойролцоо эдлэн газарт франц, германы хаадаас алсад хэсэг амьдарсан ч эрх чөлөөг эрхэмлэгч үзэл санаанаасаа болж мөн тэндээс дүрвэжээ. Орон нутгийн засаг захиргаатай маргалдсан үедээ аль ч зүгт оргон зугтаж болохоор газрыг сонгож 1758 онд франц-швейцарын хилийн ойролцоох Фернье эдлэн газарт сууришав. Энд уран зохиолын болон гүн ухааны ном зохиол туурвиж европийн сэтгэгчидтэй байнга захидлаар харилцаж зочид хүлээн авч хорь гаруй жилийг өнгөрөөв.

Ядарч зүдрэхийг эс хайхран зогсоо зайгүй ажиллаж энэ үед найраглал, шүлэг, захидал, роман, шог өгүүллэг, богино өгүүллэг, жүжиг, түүх болон гүн ухааны ном гээд нийтдээ гучин мянга гаруй хуудас бүтээл бичжээ.

Хүнийг шашны үзэл баримтлалаар нь гадуурхан хавчихыг буруушаадаг учир бараг далан нас хүрч байх үед нь Францад үнэн алдартны шашин шүтэгчдийг залхаан цээрлүүлсэн хэд хэдэн аймшигт хэрэг гарсныг дуулаад ихээхэн зэвүүцэж шашны үзлийг хэт шүтэхийн эсрэг оюун ухааны тэмцлийг өрнүүлэв. Шашны сөргөлдөөнийг буруушааж шүмжилсэн улс төрийн шог зохиол олныг туурвижээ. Зохиол бүрээ "Олны дургүйцлийг төрүүлсэн зүйлийг эцэс болгоё" гэж дуусгаж байлаа. "Олны дургүйцлийг төрүүлсэн зүйл" гэсэн хэллэгээр шашны үзлийг хэт шүтэхийг илэрхийлж байв.

Вольтер 1778 онд 83 настайдаа "Ирена" хэмээх шинэ жүжгийнхээ нээлтийг үзэхээр сая Париж хотод хөл тавихад түүнийг олон мянган хүн францийн Сэргэн мандлын "аугаа их эцэг" гэж хүндэтгэн угтжээ. Түүнийг бишрэн шүтэгчдийн дотор Бенжамин Франклин байлаа.

Түүнийг 1778 оны тавдугаар сарын 30-ны өдөр Париж хотод өөд болоход аливаа шашны харгис явууллагыг тууштай эсэргүүцэгч байсан учир түүнийг нийслэл хотод христос шашны

ёсоор нутаглуулаагүй байна. Гэвч 13 жилийн дараа ялсан хувьсгалчид түүний шарилыг Париж хотод авчирч бунхан барьж ёслол төгөлдөр оршуулсан байна.

Вольтер нь зохиол бүтээлийн асар өв үлдээсэн болохоор түүний дэвшүүлсэн гол гол үзэл санааг тодруулья. Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг насан туршаа сурталчилж байлаа. "Би таны ярьж байгаа зүйлтэй санал нийлэхгүй ч энэ үгийг хэлэх Таны эрхийг би амьсгаа хураах хүртлээ хамгаалах болно." гэсэн үгийг Вольтер анх өгүүлсэн гэж үздэг. Энэ үгийг яг хэлээгүй ч тухайн асуудалд яг ийм байр сууринаас ханддаг байсан нь үнэн билээ.

Шүтэн бишрэх эрх чөлөөг тууштай хамгаалж байлаа. Насан туршаа шашны хүчирхийлэл, мөшгөн мөрдөхийн эсрэг туйлбартай тэмцсэн юм. Бурхан бий гэдэгт итгэдэг ч шашны зарим номлолыг буруушааж зохион байгуулалттай шашин бол үндсэндээ заль мэх гэж үргэлж нотолж байв.

Францийн үе дамжсан язгууртнууд ухаантай гэдэг нь оргүй худал, "хаадын бурханлаг эрх" гэгч нь зүгээр л тэнэглэл гэж үздэг байв. Хүчирхэг гэхдээ гэгээрсэн хаант ёсыг сайшаадаг, энэ утгаараа орчин үеийн ардчиллын тухай үзлээс хол байсан ч үе дамжин удирдах ёсны аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрдөггүй байсан юм. Ийм учраас түүний үзэл санааг баримтлагчдын дийлэнх нь ардчиллыг хүлээн зөвшөөрч чадсан юм. Түүний баримталж байсан улс төр, шашны үзэл бодол нь францийн Сэргэн мандлын гол чиглэл болж ихэнхи үзэл санааг нь 1789 оны Францийн их хувьсгалын үед зээлдэн авсан байлаа.

Вольтер эрдэмтэн байгаагүй ч шинжлэх ухаан сонирхдог, Фрэнсис Бэкон, Жон Локк нарын туршилтын үзэл санааг халуунаар талархан дэмжигч байв. Бузгай авьяаслаг түүхч байсан ба түүний "Үндэстнүүдийн заншил, үзэл санааны хүүрнэл" нэртэй дэлхийн түүхийн тухай бүтээл нь ихэд алдартай. Энэ ном нь түүхийн талаархи түрүү үеийн бүтээлүүдээс хоёр зүйлээр давж байлаа. Үүнд нэгдүгээрт Европ бол дэлхийн нэгээхэн хэсэг тул азийн түүхэнд ихээхэн анхаарал хандуулсан, хоёрдугаарт соёлын түүх нь улс төрийн түүхээс илүү чухал гэсэн үзлийг сайшааж байв. Тийм учраас номондоо хаад тэдний өдөөж байсан дайн байлдаанаас илүү нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, соёлын хөгжлийн тухай түлхүү бичсэн байдаг.

Вольтер бол Ж.Локк, Ф.Бэкон зэрэг бусад сэтгэгчийн үзэл санааг зээлдэн авч олон нийтэд хүргэн түгээн дэлгэрүүлсэн гавьяатай гүн ухаантан юм. Чухамдаа зохиол бүтээлээрээ ардчилал, шашны үзэл бодлыг тэвчих, оюун санааны эрх чөлөөний тухай үзэл баримтлалыг Франц төдийгүй Европийн дийлэнх хэсэгт түгээн сурталчилсан билээ. Францийн Сэргэн мандлын үед Дидро, д'Аламбер, Руссо, Монтескье зэрэг гарамгай зохиолчид байсан ч Вольтер тэргүүлэх удирдан чиглүүлэгч нь байсан юм. Учир нь гэвээс нэгдүгээрт бичлэгийн өвөрмөц хэв маяг, олон тооны зохиол бүтээлээрээ бусдаас илүү уншигчтай байсан, хоёрдугаарт түүний дэвшүүлсэн үзэл бодол Сэргэн мандлын үед өргөн тархмал байсан, гуравдугаарт бусад сэтгэгчээсээ түрүү үед амьдарч уран бүтээлээ туурвиж байсан. "Английн захидлууд" ном 1734 онд хэвлэгдэж олны хүртээл болсон бол Монтескьегийн "Хуулиудын үзэл санаа" хэмээх алдарт бүтээл 1748 онд, "Нэвтэрхий толийн" нэгдүгээр боть 1751 онд, Руссогийн анхны бүтээл 1750 онд тус тус гарч байжээ.

Өнөө үед Вольтерийн зохиолуудаас "Кандид" романаас бусдыг нь хүмүүс бараг уншдаггүй нь

үнэн. Гэвч түүний бүтээлүүд ХҮШ зуунд ихэд тархмал байж хүмүүсийн үзэл бодлын өөрчлөлтөд чухал үүрэг гүйцэтгэж Францийн их хувьсгалыг оюун санааны хувьд бэлтгэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан юм. Тэрчилэн Т.Жефферсон, Жеймс Медисон, Бенжамин Франклин зэрэг америкийн нэрт сэтгэгчид түүний бүтээлүүдийг гүнзгий судалж америкийн улс төрийн уламжлалд олон үзэл баримтлалыг тусгасан билээ.

# 75. Иоганн Кеплер

(JOHANNES KEPLER)

1571-1630



Гариг эрхсийн хөдөлгөөний хуулиудыг нээсэн суут эрдэмтэн Иоганн Кеплер 1571 онд, гариг эрхэс дэлхийг биш чухамдаа Нарыг тойрч эргэдэг тухай үзэл бодлоо дэвшүүлсэн "Тэнгэрийн эрхсийн эргэлтийн тухай" Коперникийн ном хэвлэгдсэнээс 28 жилийн дараа Германы Вайл хотод төрж Тюбинген хотын их сургуульд суралцаж бакалаврын, гурван жилийн дараа магистрын зэрэг хүртжээ.

Тэр үед дийлэнх эрдэмтэн, Коперникийн дэвшүүлсэн Нар төвтэй гариг эрхсийн тухай онолыг хүлээн зөвшөөрөхгүй байлаа. И.Кеплер их сургуульд суралцаж байхдаа Коперникийн онолын тухай лекц сонсож бодитой үнэн болохыг нь ойлгожээ.

Их сургууль төгссөний дараа Грац хотын академид хэдэн жил профессороор ажиллах хугацаандаа 1596 онд одон орон судлалын талаархи анхны бүтээлээ бичжээ. Тэр номонд түүний дэвшүүлсэн онол буруу байсан ч математикчийн их чадвар, өвөрмөц сэтгэлгээгээ харуулж тухайн үеийн нэрт одон орон судлаач Тихо Браге түүнийг Прага хот дахь одон орон судлалын төвдөө туслахаараа ажиллахыг урьжээ.

И.Кеплер түүний саналыг хүлээн авч 1600 оны нэгдүгээр сараас хамтран ажиллаж эхэлжээ. Гэтэл багш нь дараа жил нь нас барсан ч хэдхэн сар хамт ажиллах хугацаандаа өндөр сэтгэгдэл төрүүлсэн тул хоёрдугаар Рудольф хаан түүнийг Тихо Брагийн залгамжлагч, ордны математикчаар томилсон байна. И.Кеплер энэ албан тушаалд насан өөд болтлоо ажиллажээ.

Аз болоход И. Кеплер Тихо Брагийн шууд залгамжлагчийн хувьд түүний олон жилийн хугацаанд гариг эрхсийг судалж хийсэн гярхай ажиглалтын маш их тэмдэглэлийн өв залгамжлагч болжээ. Тихо бол телескоп нээгдэхийн өмнөх үеийн хамгийн сүүлчийн гарамгай одон оронч байсан болохоор түүний хийсэн ажиглалтууд шинжлэх ухаанд асар их ач холбогдолтой байсан билээ. Багшийнхаа үлдээсэн маш их тэмдэглэлийг хүлээн авч байх

үедээ эдгээр тэмдэглэлд математик дүн шинжилгээ хийж гариг эрхсийн хөдөлгөөний тухай онолууд тухайлбал Нар төвтэй гариг эрхсийн тухай Коперникийн онол, үл хөдлөх Дэлхий төвтэй гариг эрхэсийн хөдөлгөөний тухай Птомелейн онол, багш Тихо Брагийн дэвшүүлсэн гурав дахь онолын аль нь үнэн болохыг тогтоож болно гэж гүн итгэсэн байлаа.

Хэдэн жилийн турш махруу тооцоо хийсний дараа багшийнх нь дэвшүүлсэн онол нь буруу болохыг мэдэж өмнөөс нь их ичжээ.

Тихо Браге, Н.Коперник болон бусад бүх сонгодог одон оронч гариг эрхсийн хөдөлгөөний зам нь тойргууд буюу тойргуудын нэгдлээс бүрдэнэ, хөдөлгөөний зам нь тойруу гэж үздэг нь буруу юм байна, хөдөлгөөний зам нь чухамдаа зууван байдаг юм гэсэн дүгнэлтийг И.Кеплер хийв.

Гэвч хийсэн дүгнэлтдээ итгэж ядан дахин хэдэн сарыг математик тооцоо хийж дэвшүүлсэн санаа нь багшийнх нь хийсэн ажиглалтдаа тохирч байгаа эсэхийг шалгалаа. Тэгээд гариг эрхэсийн хөдөлгөөний анхны хоёр хуулийг томъёолсон "Шинэ одон орон" нэртэй цуут бүтээлээ 1609 онд хэвлүүлжээ. Гариг бүр Нарыг тойрч Нар төвтэй зууван замаар хөдөлдөг гэсэн анхдугаар хууль, гариг бүр Наранд ойртох тусам хурд нь нэмэгдэнэ гэсэн хоёрдугаар хуулиа дээрх номондоо дэлгэрэнгүй тайлбарлан бичив. Аливаа гаригийн хөдөлгөөний хурд нь гариг болон Нарыг холбосон шугам нь ижил хугацаанд ижил талбайг туулах байдлаар өөрчлөгдөнө.

Арван жилийн дараа аливаа гариг Нарнаас хол зайтай байх тусам түүний Нарыг бүтэн тойрох хугацаа төдийчийнээ уртасна, гаригуудын эргэлтийн үеийн квадрат нь түүний Нар хүртэлх зайны шоо зэрэгтэй шууд хамааралтай гэсэн гурав дахь хуулиа томъёолжээ.

Гариг эрхэсийн хөдөлгөөний тухай хуулиудыг нээж Нарыг тойрч эргэлдэх гариг эрхэсүүдийн хөдөлгөөнийг үндсэндээ бүрэн зөв тайлбарласнаараа Коперник, Галилей зэрэг суут ухаантнуудыг будлиулж байсан одон орон судлалын үндсэн асуудлуудын нэгийг шийдвэрлэсэн юм. Гэхдээ гариг эрхэс чухам яагаад зууван замаар хөдөлгөөн үйлддэгийг И.Кеплер тайлбарлаагүй, энэ асуудлыг хожим нь И.Ньютон шийдсэн юм.

Одон орны судлалд И.Кеплерийн оруулсан хувь нэмрийг Н.Коперниктэй дүйцүүлж болно. Тэр үед математик тооцооны техник өнөө үеийнх шиг өндөр хөгжилд хүрээгүй, тооцоолон бодох машин огт байгаагүй үед И.Кеплер асар их математик тооцоог хийж чадсан нь үнэхээр бахархмаар.

Алдарт эрдэмтэн Галилей түүнтэй харилцан захидал солилцож эрдэм шинжилгээний ажлынхаа үр дүнтэй байнга харилцан танилцдаг байсан мөртөө түүний дэвшүүлсэн онолыг хүлээн зөвшөөрөхгүй байжээ. Чухамдаа И.Кеплерийн дэвшүүлсэн онолыг үндэслэн Галилей Птоломейн онолыг буруу болохыг нотолж байсан юм. Тухайн үеийн олонх эрдэмтэн аугаа нээлтийг нь хүлээн зөвшөөрөхгүй удаж байх хооронд И.Кеплер хийсэн нээлтийнхээ үнэн болоход баярлаж "Миний зүрх сэтгэл баяр хөөрөөр бялхаж байна, би номоо бичиж дуусгалаа. Миний номыг манай үеийнхэн төдийгүй ирээдүй хойч үеийнхэн унших эсэх нь надад падгүй, бүтээлийг нь зохих ёсоор үнэлж цэгнэхийг Бурхан зургаан мянган жил тэвчээртэй хүлээсэн шиг миний номыг ойлгох уншигч хэдэн мянган жилийн дараа ч төрөх юм бил үү, бүү мэд.."



гэж бардамнан бичиж байлаа.

Хэдэн арван жил өнгөрөхөд дэлхийн оюуны ертөнц түүний онолыг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн билээ. ХҮШ зууны сүүлч гэхэд Ньютоны дэвшүүлсэн онол үнэн болох нь уг онолоос И.Кеплерийн хуулиудыг гаргаж болж байгаагаар нотлогдож байна гэж сайшааж байжээ. Тухайлбал хөдөлгөөний тухай Ньютоны хуулиудыг авч үзэхэд И.Кеплерийн нээсэн хуулиудаас Ньютоны дэлхийн татах хүчний тухай хуулийг яг гаргаж болж байлаа. Гэхдээ энэхүү хуулийг нээхэд математик тооцооны илүү дэвшилтэт техник эх сурвалж болсон нь ойлгомжтой. Чухам тийм учраас И.Кеплер математик тооцооны техникийн түвшин бүдүүлэг байх үед гариг эрхэсүүдийн хөдөлгөөн нь Нарнаас үүсэлтэй хүчинд захирагдана гэсэн санааг цухуйлгасан нь үнэхээр гайхамшигтай.

И.Кеплер гариг эрхэсийн хөдөлгөөнөөс гадна одон орон судлал, гэрлийн онолд бас хэд хэдэн чухал хувь нэмэр оруулсан. Гэвч амьдралынх нь сүүлчийн жилүүдэд, Герман улс гучин жилийн дайнд татагдан орж эрдэмтний хөдөлмөрийг нь ойшоох хүн олдохгүй болсон байна.


Түүний хувьд судалгаа шинжилгээний ажлаа явуулахад гол асуудал нь цалин пүнлүү байв. Хаад цаг амгалан тайван байх үед ч түүний хөдөлмөрийг зохих ёсоор үнэлэхгүй, амласан цалингаа өгөхгүй зовоодог байжээ. Тэгээд ч хэдэнтээ гэрлэж нийтдээ 12 хүүхэдтэй байсан болохоор мөнгө түүнд их хэрэгтэй байсан нь мэдээж. Төрсөн эхийг нь 1620 онд шулам гэж баривчилж шоронд хорьсныг суллах гэж үйлээ үзэж байжээ.

1630 онд Баварын Регенсбург хотод нас баржээ. Гучин жилийн дайны үед түүний шарил дээр босгосон хөшөөг нураасан ч түүний нээсэн гариг эрхэсийн хөдөлгөөний тухай хуулиуд нь түүнд мөнхийн хөшөө болсон юм.

# 76. Энрико Ферми

(ENRICO FERMI)

1901-1954



Цөмийн анхны хурдасгуур зохион бүтээсэн алдарт эрдэмтэн Энрико Ферми 1901 онд Италийн Ром хотод төрж Пизе хотын их сургуульд суралцаж 21 настайдаа гүн ухааны докторын зэрэг хүртэж 26 настайдаа гэхэд Ромын их сургуулийн профессор болсон байлаа. Тэр үедээ физикийн хэцүү салбарын нэг болох квант статистикийн асуудлаар анхныхаа бүтээлийг нийтлүүлж өнөө үед фермионууд гэж нэрлэж байгаа эд бөөмсүүдийн ихээхэн бөөгнөрлийн байдлын тухай статистик онолыг урагшлуулжээ.

Жирийн материйн гурван бүрэлдэхүүн хэсгүүд болох электрон, протон, нейтронууд нь фермионууд байдаг тул түүний дэвшүүлсэн онол шинжлэх ухааны асар их ач холбогдолтой байлаа. Түүний гаргаж ирсэн тэгшитгэл нь атомын цөм, шинээр бий болж байгаа материйн (зарим төрлийн оддын дотор бий болж байдаг үзэгдэл) байдал, металлуудын шинж чанар, байдлыг илүү гүнзгий судлах бололцоог нээсэн юм.

Өнөө үед физикийн шинжлэх ухаанд чухал сэдвүүд болсон нейтрино болон сул харилцан үйлчлэлийн асуудлыг анх хөндсөн бета цацрагийн задралын тухай онолоо 1933 онд томъёолжээ. Ийнхүү Э.Ферми орчин үеийн тэргүүлэх физикчдийн эгнээнд багтжээ. Гэхдээ гол гол нээлтүүдээ хийгээгүй байлаа.

Английн физикч Жеймс Чедвик 1932 онд атомын бас нэг бүрэлдэхүүн хэсэг болох нейтроныг нээлээ. Э.Ферми 1934 оноос эхлэн химийн олон тодорхой элементүүдийг нейтроноор бөмбөгдөх туршилт хийж олон төрлийн атомууд нь нейтроныг шингээх чадвартай, тийм цөмийн өөрчлөлтийн явцад олон тохиолдолд атомууд нь цацраг идэвхт чанартай болж байгааг нотлов. Нейтрон нь хөдөлгөөн их хурдтай үйлдэж байх үедээ атомын цөм дотор хялбархан нэвтрэн орж болно гэж үзэж байв. Гэтэл Э.Ферми туршилт хийх явцдаа нейтронууд нь ус юм уу лааны тос нэвтрэх үедээ эхэндээ хурд нь саарч энэ үедээ атомд шингэх илүү их боломжтой болдог гэсэн дүгнэлт хийв. Чухамдаа энэхүү нээлт нь цөмийн хурдасгуур бүтээхэд маш их ач холбогдолтой болсон юм.

Цөмийн хурдасгуур дотор нейтронуудын хурдыг сааруулах зориулалттайгаар хийсэн материалыг сааруулагч гэж нэрлэнэ.

Э.Ферми нейтронүүдийг шингээх чадварын талаархи туршилтынхаа дүнгээр 1938 онд физикийн салбар дахь Нобелийн шагналыг хүртсэн билээ. Гэвч Итали улсад фашистууд засгийн эрхэнд гарч еврейчүүдийн эсрэг харгис бодлого явуулж эхэлсэн учир еврей эхнэртэй, фашизмыг үзэн яддаг түүний хувьд эх орондоо аж төрж ажиллах ямар ч бололцоогүй болов. Тиймд 1938 оны 12 дугаар сард Стокгольм хотод Нобелийн шагналаа гардан авахаар ирсний дараа эх орондоо буцсангүй, харин АНУ-д дүрвэн гарав. Нью-Йорк хот дахь Колумбын их сургууль дэлхийд нэртэй эрдэмтнийг тэр даруй профессороор авчээ. 1944 онд АНУ-ын иргэн болов.

1939 оны эхээр эрдэмтэн Лиза Мейтнер, Отто Ган, Фриц Штрасман нар нейтронүүдийг шингээх явцад заримдаа ураны атом задардаг гэсэн дүгнэлт хийлээ. Э.Ферми тэдний илтгэлийг уншаад зарим физикчийн адил ураны атом задрах явцад гинжин урвалыг эхлүүлэхэд хүрэлцэхүйц тооны нейтронүүд бий болно гэдгийг дор нь ойлгов. Түүнээс гадна гинжин урвал нь цэргийнхэнд их хэрэгтэй зүйл болохыг мөн мэдэрч 1939 оны гуравдугаар сард АНУ-ын тэнгисийн цэргийн флотын удирдлагатай холбоо барьж цөмийн зэвсэг бүтээх бололцоо бий болсон тухай мэдээлж анхаарлыг нь татахыг оролджээ.

Гэвч А.Эйнштейн хэдхэн сарын дараа АНУ-ын ерөнхийлөгч Т.Рузвельтэд захидал бичсэнээр тус улсын удирдлага атомын бөмбөгний учрыг ойлгож анхаарлаа хандуулсан байна.

Энэ үеэс гинжин урвал явагдах бололцоог хангасан цөмийн хурдасгуурыг зохион бүтээх ажил эрдэмтдийн өмнө хурцаар тавигдав. Э.Ферми бол нейтрон судлалын асуудлаархи дэлхийн тэргүүлэх эрдэмтэн, туршигч, онолчийн ур чадварыг хослуулсан гарамгай эрдэмтэн байсан тул түүнийг дэлхийд анхны цөмийн хурдасгуур зохион бүтээх хэсгийн ахлагчаар томилжээ. Анхандаа Колумбын дараа нь Чикагогийн их сургуульд ажиллав.

Чухамдаа Чикагогийн их сургуульд ажиллаж байхдаа түүний төслөөр түүний удирдлагаар зохион бүтээсэн цөмийн хурдасгуур 1942 оны 12 дугаар сарын 2-ны өдөр анх ажиллажээ. Ийнхүү хүн төрөлхтөн анх удаагаа гинжин урвалыг амжилттай явуулж атомын эрин үеийн эхлэлийг тавьсан билээ. Цөмийн хурдасгуурыг амжилттай туршсан тухай Англи улс руу "Италийн чиглүүлэгч шинэ ертөнцөд нэвтрэн орлоо." гэсэн цахилгаан утас илгээж байлаа.

Цөмийн хурдасгуурын туршилт амжилттай болсны дараагаар атомын бөмбөг үйлдвэрлэх Манхэттений төсөл хэрэгжиж эхлэхэд Э.Ферми шинжлэх ухааны зөвлөхөөр томилогдон ажилласан юм.

Дайны дараа Чикагогийн их сургуулийн профессор болж 1954 онд өөд болжээ. Гэргий, хоёр хүүхэдтэй байсан, Шинжлэх ухааны өмнө байгуулсан гавьяаг нь үнэлж нэг зуу дахь элементийг түүний нэрээр Фермий гэж нэрлэжээ.

Э.Ферми бол хорьдугаар зууны аугаа эрдэмтдийн нэг мөнөөс мөн ба туршигч, онолын эрдэмтний ур чадварыг гарамгай хослуулс-наараа бүр ч илүү цуутай физикч юм. Амьдралынхаа хугацаанд 250 орчим эрдэм шинжилгээний бүтээл туурвижээ.

Атомын бөмбөгийг бүтээх үйлсэд өөр олон хүн их хувь нэмэр оруулсан ч түүний гүйцэтгэсэн үүрэг их чухал байсан. Цөмийн хурдасгуур бүтээсэн гол гавьяа Э.Фермид ногдоно.

Атомын бөмбөгийг 1945 оноос хойш цэрэг дайнд огт хэрэглээгүй боловч энх тайвны зорилгоор эрчим хүч үйлдвэрлэхэд цөмийн хурдасгуурыг маш өргөн ашигласаар байна. Ирээдүйд цөмийн хур-дасгуур нь эрчим хүчний илүү чухал эх сурвалж болох нь ойлгомжтой. Тэрчилэн зарим цөмийн хурдасгуурыг анагаах ухаан, шинжлэх ухааны судалгаанд өргөн хэрэглэдэг радио изотоп бий болгоход ашиглаж байна. Атомын бөмбөгийг бүтээхэд ашиглаж болох плутонийг гарган авахад хурдасгуур бас ашиглагдаж байна. Цөмийн хурдасгуур нь хүн төрөлхтөнд ихээхэн аюултай ч түүнийг зохион бүтээснийг буруушаах ямар ч үндэслэл байхгүй билээ.

# 77. Леонард Эйлер

(LEONHARD EULER)

1707-1783



ХҮШ зууны швейцарийн математикч, физикч Леонард Эйлер нь тухайн цаг үеийнхээ хамгийн гаргуун, үр бүтээлч эрдэмтэн байлаа. Түүний бүтээлийг өнөө үед физик болон инженер зүйн маш олон салбарт ашиглаж байна.

Л.Эйлер нь математик болон бусад шинжлэх ухааны асуудлаар туурвисан тус бүр нь бараг нэг ботиос бүрдэх 32 ном, хэдэн зуун өгүүлэл бичжээ. Түүний шинжлэх ухааны өв дал орчим боть ном болж байдаг! Сонгодог болон хавсарга математикийн салбар бүрийг баяжуулсан ба математик физикт оруулсан хувь нэмэр нь амьдралд өргөн хэрэглэгдэж байна.

Түрүүчийн зуунд нь И.Ньютоны механикийн үндсэн хуулиудыг физикийн бий болсон тодорхой нөхцөл байдалд хэрхэн хэрэглэж болохын шилдэг жишээг Л.Эйлер харуулжээ. Тухайлбал Ньютоны хуулиудыг шингэний хөдөлгөөнд ашиглаж гидродинамикийн тэгшитгэлийг гаргасан. Тэрчилэн хатуу биеийн бүх боломжтой хөдөлгөөнийг нягтлан судалж Ньютоны зарчмуудыг хэрэглэж хатуу биеийн хөдөлгөөнийг бүрэн тодорхойлох хэд хэдэн тэгшитгэлийг нээсэн юм. Мөн уян хатан чанарын онолд хувь нэмэр оруулж хатуу биетүүд гадаад хүчний нөлөөгөөр хэлбэрээ өөрчилдөг болохыг зөвөөр тайлбарласан байна.

Судлаачийн хосгүй авьяасаа одон орны математик судлалд зориулж Нар, Дэлхий, Сар гурав харилцан таталцлалын нөхцөлд хөдөлгөөн үйлдэнэ гэсэн асуудлыг онцгой анхаарч байв. Энэ асуудал одоо хэр бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Тэрчилэн гэрлийн долгионы онолыг дэмжиж байсан ХҮШ зууны үеийн цөөхөн эрдэмтний нэг билээ.

Хожим нь олон аугаа хүмүүсийн хийсэн их нээлтүүдийн эх суурийг тавьсан билээ. Тухайлбал францийн математикч, физикч Жозеф Луи Лагранж механикийн олон асуудлыг шийдвэрлэх бололцоо олгосон түүний нэрээр нэрлэгдсэн тэгшитгэлүүдийг гаргажээ. Тэр тэгшитгэлүүдийнх нь гол үндсийг Л.Эйлер анх тавьсан болохоор Эйлер-Лагранжийн тэгшитгэл гэж одоо нэрлэдэг. Өөр нэг францийн математикч Жан Батист Фурье нь Л.Эйлер

гол тэгшитгэлийг нь нээсэн математик аргыг боловсронгуй болгож Фурьегийн дүн шинжилгээ гэдэг аргыг бий болгосон. Тэр арга одоо Эйлер-Фурьегийн томьёо гэж нэрлэгдэж байна. Энэ томьёо нь авианы ухаан, цахилгаан соронзон онол зэрэг физикийн олон салбарт өргөн хэрэглэгдэж байна.

Математикийн шинжлэх ухаанд хийж байсан судалгаандаа тоолол, дифференциаль тэгшитгэл, зарим төгсгөлгүй цувааны асуудалд онцгой анхаарч байв. Комплекс тооны болон хувьсагчдыг тооцоолох онолд түүний оруулсан хувь нэмэр нь эдгээр салбарт дараа үеүүдэд хийгдсэн нээлтүүдийн суурь дэвсгэр болсон юм. Дээр дурдсан хоёр онол нь ач холбогдлоороо сонгодог математикийн цаашдын хөгжилд өргөн ач холбогдолтой болсон билээ.

Л.Эйлерийн  $e^{i\varphi} = \cos \varphi + i \sin \varphi$  томьёо нь тригонометрийн функц болон санаандаа дүрслэн бодсон тоонуудын хоорондын харьцааг харуулдаг ба сөрөг тооны логарифмыг олоход ашиглагддаг. Энэ бол математикт өргөн хэрэглэдэг томьёонуудын нэг мөн.

Аналитик геометрийн асуудлаар ном хэвлүүлж дифференциаль болон ердийн геометрт ихээхэн хувь нэмэр оруулсан байна.

Шинжлэх ухаанд өндөр ач холбогдолтой олон нээлтийг математикийн салбарт хийсэн ч сонгодог математикт мөн гаргуун эрдэмтэн байжээ. Гэхдээ түүний хийсэн олон нээлтийг энд дурдахад жирийн уншигчдад ойлгоход хэцүү тул оруулсангүй. Математикийн шинжлэх ухаанд хорьдугаар зуунд маш чухал ач холбогдолтой байсан топологийн салбарыг анх бий бологчдын нэг гэж зүй ёсоор тооцогддог юм.

Шинжлэх ухааны хэллэгийг боловсронгуй болгоход үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан эрдэмтэн билээ. Тухайлбал грекийн "пи" үсгийг тойргийн уртыг голчоор тооцоолох коэффициентийг тэмдэглэхэд анх ашигласан. Түүний хийсэн тийм тэмдэглэлийг математикийн шинжлэх ухаанд өнөөдөр ч хэрэглэсээр байна.

1707 онд Швейцарийн Базель хотод төрж 13 настайдаа тус хотын их сургуульд элсэж анхандаа шашин судлал үзэж эхэлснээ больж математикийн шинжлэх ухаанд шилжжээ. 17 настайдаа их сургуульдаа магистрын зэрэг хамгаалж хорин настайдаа Оросын нэгдүгээр Екатерина хатан хааны урилгаар тус улсын нийслэл Санкт-Петербург хотод Шинжлэх ухааны академид уригджээ. 23 насандаа физикийн профессор болж 26 настайдаа нэрт математикч Даниель Бернуллийн оронд математикийн тэнхимийн эрхлэгчээр томилогджээ. Хоёр жилийн дараа нэг нүд нь сохорсон ч шинжлэх ухааны алдарт бүтээлүүдээ туурвисаар байжээ.

Пруссын Их Фридрих хаан 1714 онд түүнийг Оросоос дуудан ирүүлж Берлин хотын Шинжлэх ухааны академид томилов. Берлин хотод 25 жил ажилласны дараа 1766 онд Оросод буцан ирэв. Тэгтэл хоёр дахь нүд нь бас сохорсон ч судалгааны ажлаа үргэлжлүүлэн хийсээр байв. Ой маш сайн учир 1783 онд Санкт-Петербург хотод 76 настайдаа нас барах хүртлээ математикийн чиглэлээр гайхамшигт өгүүллүүдээ туслахдаа хэлж өгч бичүүлэн хэвлүүлсээр байжээ. Амьдралдаа хоёр удаа гэрлэж нийт 13 хүүхэдтэй байснаас найм нь багадаа өөд болжээ.

Л.Эйлер байгаагүй бол түүний хийсэн нээлтүүдийг хэн нэг нь хожим нь мөн хийх л байсан

мэдээж хэрэг. Гэхдээ Л.Эйлерийн томъёолол, тэгшитгэл, аргууд байгаагүй бол орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хөгжил удаашрах байсан нь лавтай. Физик, математикийн аливаа сурах бичиг, гарын авлагыг нээхэд Эйлерийн өнцгүүд (хатуу биеийн хөдөлгөөн), Эйлерийн тогтмолууд (төгсгөлгүйн цуваанууд), Эйлерийн тэгшитгэлүүд (гидродинамик), Эйлерийн хөдөлгөөний тэгшитгэлүүд (хатуу биеийн динамик), Эйлерийн томъёо (олон хувьсагчидтай), Эйлерийн тоонууд (төгсгөлгүйн цуваанууд), Эйлерийн олон өнцөгт муруйнууд (дифференциаль тэгшитгэлүүд), Эйлерийн нэгэн төрөл функцийн теорем (тухайн уламжлалт дифференциаль тэгшитгэлүүд), Эйлерийн өөрчлөлтүүд (төгсгөлгүйн цуваанууд), Бернулли-Эйлерийн хууль (уян хатны онол), Эйлер-Фурьегийн томъёонууд (тригонометрийн цуваанууд), Эйлер-Лагранжын тэгшитгэл (хувьсагчдыг тооцоолох болон механикт), Эйлер-Маклорений томъёо (тоон аргууд) гэсэн нэр томъёо байнга тааралдана.

Л.Эйлер бол Ньютоны хуулиудыг хэрэглэх аргуудыг харуулж чадсан ч шинжлэх ухааны ганц ч өвөрмөц аргыг нээгээгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ шинжлэх ухаан, инженер зүй, математикт хийсэн хувь нэмэр нь үнэлж баршгүй билээ.

# 78. Жан-Жак Руссо

(JEAN-JACQUES ROUSSEAU)

1712-1778



Суут гүн ухаантан Ж.Ж.Руссо 1712 онд Швейцарын Женев хотод төрсний дараа эх нь нас барж түүнийг есөн нас хүрэх үед эцэг нь Женев хотоос хөөгджээ. Ийнхүү Руссо хүү том хотод ор ганцаараа хоцорч 16 нас хүрэх үедээ 1728 оноос хот тосгон дамжин тааралдсан ажлыг хийж нилээд хэдэн жилийг өнгөрөөв. Бүсгүйчүүлд хөл алддаг нэгэн байсан тул Тереза хэмээх эмэгтэйтэй явалдаж хууль бусаар таван хүүхэд төрүүлж өгөхөд нь цөмийг нь өнчин хүүхдийн газарт өгчээ. Хожим нь 56 настайдаа Тереза бүсгүйтэй сая нэг албан ёсоор суужээ.

1750 онд гэнэт нэрд гарах нь тэр. Дижоны академиэс зарласан "Хүний нийгэмд урлаг, шинжлэх ухааны ёс зүй ашигтай нөлөөлдөг үү?" сэдэвт уралдаанд түүний бичсэн өгүүлэл тэргүүнд байранд шалгарчээ. Шинжлэх ухаан, урлаг дахь дэвшлийн цэвэр үр дүн нь хүн төрөлхтөний хувьд ашиггүй гэж өгүүлэлдээ бичсэн байв.

Үүний дараагаар түүний бүтээлүүд цувлаа. 1755 онд "Тэгш бус байдлын эхлэл, үндэслэлийн тухай бодрол", 1761 онд "Шинэ Элоиза", 1762 онд "Эмиль", "Нийгмийн гэрээний тухай", 1770 онд "Гэрээслэл" номуудаа хэвлүүлж алдрын оргилд хүрэв. Хөгжим ихэд сонирхож хоёр дуурийн хөгжим бүтээжээ.

Уран бүтээлээ туурвиж эхлэх үедээ францийн Сэргэн мандлын зарим либерал зохиолчид, Дени Дидро, Жан д'Аламбер нартай дотно нөхөрлөж байсан ч түүний үзэл бодол бусдынхаас эрс тэс ялгагдаж байжээ. Ж.Руссо театрыг ёс суртахуунгүй гэж үздэг байсан тул Женев хотод театр байгуулах гэсэн Вольтерийн төлөвлөгөөг эрс эсэргүүцсэнээс олон хүний дургүйг хүргэв. Түргэн ааш авираасаа болж аливаа асуудалд ухаалаг нухацтай ханддаг Вольтер, бусад эрдэмтэй мэдлэгтэй хүмүүстэй таарч тохирохгүй байлаа.

Тэрчилэн 1762 оноос улс төрийн үзэл баримтлалаасаа болж тухайн үеийн засаг захиргаатай



тэрсэлдэж тэдний харилцаа улам мууджээ. Түүний үзэл бодлыг дэмждэг зарим хүн холдож сэтгэл мэдрэлийн өвчтэй болох нь илт мэдэгдэж эхэлжээ. Олонхи хүмүүс түүнд хүндэтгэлтэй ханддаг ч орчин тойрны хүмүүстэйгээ дандаа дайсагналнаж бараг л хүн бүртэй хэрэлдэж хүн бүрийг зэвүүцэн сэжиглэнэ. Ийнхүү амьдралынхаа сүүлчийн хориод жилийг аз жаргалгүй өнгөрөөж 1778 онд Францийн Эрменонвилл хотод нас баржээ.

Ж.Ж.Руссогийн бүтээл нь социалист, националист үзэл, дангаар захирах дэглэм, оюун ухааныг дээдлэх, романтизмын үзлийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж Францийн их хувьсгалын дардан замыг засаж ардчилал, тэгш эрхийн тухай өнөөгийн эрхэм тэмүүлэлд нилээд нөлөө үзүүлсэн гэж үнэлдэг. Тэрчилэн боловсролын онолд даацтай гавьяа байгуулсан гэж магтдаг. Хүн бол оршин байгаа нөхцөл байдлынхаа бүтээгдэхүүн гэдэг онолын үндсийг Руссо тавьсан гэж үздэг.

Орчин үеийн технологи, нийгэм бол таагүй зүйл, сайхан сэтгэлтэй зэрлэг хүний тухай үзэл бодлыг Руссо гаргасан гэх нь бий. Үнэндээ бол дээр дурдсан хэд хэдэн үзэл бодлыг Руссо огт дэвшүүлээгүй буюу уу заримыг нь түүний нэртэй зүгээр холбосон байгаа юм.

Тухайлбал сайхан сэтгэлтэй зэрлэг хүний тухай санааг авч үзье. Энэ нэр томъёог тэр хэзээ ч хэрэглэж байгаагүй, түүнээс гадна Өмнөд тэнгисийн арлуудын оршин суугчид, америкийн улаан арьстнуудыг бишрэн шүтэгч байгаагүй. Тэгээд сайхан сэтгэлтэй зэрлэг хүний тухай ойлголт нь түүнээс өмнө байсан ба английн нэртэй яруу найрагч Жон Драйден бараг зуугаад жилийн өмнө энэ хэллэгийг зохиолдоо анх хэрэглэсэн байжээ. Нийгэм ямагт таагүй зүйл гэж Руссо хэлэх нь бүү хэл нийгэм хүнд хэрэгтэй гэсэн байр суурийг баримталж байсан юм.

Нийгмийн гэрээний тухай ойлголт бол Руссотой огт хамааралгүй, түүнийг төрөхөөс өмнө английн гүн ухаантан Жон Локк энэ ойлголтыг удтал тайлбарлаж байсан төдийгүй английн гүн ухаантан Томас Гоббс Ж.Локкоос бүр өмнө энэ санааг дэвшүүлж байжээ.

Хүн зан чанар төлөвшихөд хүрээлэн байгаа орчин нөхцөл шийдвэрлэх ач холбогдолтой гэж олон сэтгэгчид үзэж байсан, гэхдээ энэ санааг Руссо бодож олсон гэдэг нь худлаа. Үндсэрхэх үзэл нь түүнийг төрөхөөс бүр өмнө бүрэлдэн бий болсон байсан юм.

Руссогийн бүтээл нь Францийн их хувьсгалын дардан замыг засаж Дидро, д'Аламбер нараас илүү оюун санааны нөлөө үзүүлсэн гэдэг нь бол маргашгүй үнэн юм.

Руссо тухайн үеийн бусад алдарт зохиолчидтой харьцуулахад зан авирын хувьд оюун ухааныг шүтэн бишрэгч байгаагүй юм. Түүний уран бүтээлийн цаг үедээ болон дараагийн үеүүдэд үзүүлсэн нөлөө аугаа биш юм гэлээ гэхэд их байсан юм. Уран зохиолын салбарт романтизмын үзэл санааг хөгжүүлэхэд чухал хүчин зүйл болж практик амьдралаар нотлогдсон боловсролын онолд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан ажээ.

Далимд дурдахад хүүхдийг хөхөөр хооллохын ач хогбогдлыг өндөрт өргөж байжээ. Төрсөн хүүхдүүдээ ад үзэж өнчин хүүхдийн сургуульд өгч байсан хүн эцэг, эхчүүдэд үр хүүхдээ хэрхэн өсгөн бойжуулж хэрхэн нийгэмд хэрэгтэй хүн болгон төлөвшүүлэхийг зааж сургаж байсан нь хачирхалтай ч боловсролын талаар түүний баримталж байсан үзэл бодол боловсролын тухай орчин үеийн онолд жинтэй ул мөрөө үлдээсэн билээ.

Түүний улс төрийн үзэл бодолд олон сонирхолтой чиглэл байдаг. Тэгш эрхийг хангахыг бүхий л бүтэээлдээ номлож нийгэмд одоо байгаа бүтэц тэсвэрлэшгүй шудрага биш байна, хүн эрх чөлөөтэй төрсөн мөртөө хаа сайгүй гинжинд хүлэгдсэн байна гэж буруушааж байлаа. Хүчирхийлэл хийхэд уриалан дуудаж байгаагүй ч бусад хүмүүсийг хувьсгалыг үндсэн өөрчлөлт хийх арга болгон сонгон авахад нь зоригжуулж байлаа.

Хувийн өмчийн талаархи түүний үзэл баримтлал ихээхэн зөрчилдөөнтэй байлаа. Өмч бол иргэдийн хамгийн эрхэм ариун эрх гэж сургамжилж байснаас нь илүү хувийн өмчийн эсрэг шүүмжлэл нь уншигчдын талархлыг татаж байсан нь үнэн билээ. Руссо нь хувийн өмчийг нухацтай шүүмжилж байсан анхны нэртэй зохиолчдын нэг байсныхаа хувьд коммунист, социалист үзлийн үндэс суурь тавигчдын нэг гэж үзэж болох талтай.

Үндсэн хуулийн асуудлаар түүний баримталж байсан үзэл бодол сонирхол татдаг. Тухайлбал нийгмийн гэрээний гол утга санаа бол иргэн бүрийг түүний эдэлж буй бүх эрхийг нийтийн коммуний нийтлэг эрх ашигт захируулах явдал юм гэж үзэж байсан нь иргэний эрх, эрхийн тухай хуулийн үзэл баримтлалаас эрс зөрж байна. Цаг үеийнхээ засаг захиргаатай тэмцэлдэж байсан ч түүний бичсэн номууд нь хожим нь бий болсон захиргаадалтын тогтолцоог зөвтгөх агуулгатай байсан юм.

Түүнийг үндсэрхэг үзэлтэн, үзэл бодол нь бодит амьдралаас тасархай сэтгэгч гэж орон гаран зан авирыг иш үндэс болгон шүүмжилдэг нь үнэний хувьтай. Гэхдээ түүний үзэл санааны төөрөгдлийн дотор байгаа өвөрмөц тод яруу сэтгэлгээ нь хоёр зуу гаруй жилийн туршид хүн төрөлхтөний оюун санаанд нөлөөлсөөр байна.

# 79. Никколо Макиавелли

(NICCOLO MACHIAVELLI)

1469-1527



Эрх мэдлээ хадгалж бэхжүүлэх сонирхолтой төр баригч нь ов заль мэх, түмэнтээ худал хэлэхийг цэргийн хүчийг үргэлж хэрэглэх явдалтай хослуулсан байх ёстой гэсэн зөвөлгөө хэлж байсан италийн улс төрийн гүн ухаантны нэрийг Никколо Макиавелли гэдэг.

Зарчимгүй адгийн шаар гэж зарим нь зэмлэдэг, дэлхий ертөнцийн байдлыг яг байгаагаар нь бичиж зориглосон эрүүл сэтгэлгээтэй хүн гэж зарим нь үнэлдэг Макиавелли нь улс төрчид, гүн ухаантнууд одоо ч зохиол бүтээлийг шимтэн уншдаг цөөхөн зохиолчдын нэг мөн билээ.

1469 онд Италид Флоренц хотод баян бус ч язгууртан гэр бүлээс гаралтай хуульчийн гэр бүлд төржээ. Италийн Сэргэн мандалтын оргил үед түүний амьдрал таарсан ба энэ үед Итали улс Франц, Испани, Англи шиг нэгдмэл бус олон тооны жижиг вант улсуудаас бүрдэж байв. Тийм учраас соёл, урлаг өндөр дээд шатанд хөгжиж байсан ч Итали нь цэргийн хүчний хувьд сул дорой улс байв.

Түүнийг идэр залуу байх үед нь Флоренц хотыг алдарт Медичийн удам захирч байсан ба түүнийг 1492 онд хөөж Бүгд найрамдах улсыг тунхаглажээ. 1494 онд Флоренцийн бүгд найрамдах улсын иргэний албанд өндөр албан тушаалд томилогдож 14 жилийн турш дипломат үйлсэд зүтгэж Франц, Герман болон Италийн бусад нутгаар байнга явдаг байжээ.

1512 онд Флоренцийн бүгд найрамдах улс унаж Медичийн удам дахин засгийн эрхэнд гарав. Макиавеллийг өндөр албан тушаалаас нь буулгаж дараа жил нь гэр бүлийнх нь эсрэг хуйвалдаан хийх гэж байсан гэсэн шалтгаанаар сэжиглэж баривчилжээ. Түүнийг тамлан байцааж гэм буруугүй болох нь нотлогдмогц тэр даруй суллажээ. Макиавелли Флоренц хотын ойролцоо орших Сан-Касциано хэмээх жижиг улсад очив.

Энд суусан 14 жилийн хугацаанд маш олон ном бичсэнээс 1513 онд хэвлүүлсэн "Төр баригч",

"Тит Ливийгийн анхны арван номын тухай бодрол" номууд нь ихэд алдаршжээ. Тэрчилэн "Дайны урлаг", "Флоренцийн түүх" ном, театруудад одоо хэр тоглогдож байгаа "Мандрагору" драмын жүжиг туурвижээ. Эхнэртэй, зургаан хүүхэдтэй байсан. 1527 онд 57 настайдаа ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ.

"Төр баригч" ном бол зохиолч хүнээс төрийн тэргүүнд өгсөн түүхэн дэх анхны зөвлөмж билээ. Энэ номын гол агуулга нь төр баригч нь амжилт олохыг эрмэлзэж байгаа бол ёс суртахууны зарчмуудыг таягдан хаяж хүч залиг үйл ажиллагаандаа удирдлага болгох ёстой гэсэн зарчим юм. Төр улсаа сайтар зэвсэглэх нь туйлын чухал, армид зөвхөн өөрийн орны иргэдийг татах хэрэгтэй, хөлсний этгээд юм уу бусад орны цэрэгт итгэж болохгүй, хөлсний цэрэгтэй байх нь сулд дорой байгаагийн шинж гэж сургажээ.

Төр баригч нь өөрийн талын хүмүүстэй байхын тулд олон түмний баттай дэмжлэгтэй байх нь зохилтой. Шинээр тодорсон төр баригч нь эрх мэдлийнхээ аюулгүй байдлыг хангах зорилгоор заримдаа хүчирхийллийн арга хэрэглэж болно, аль нэг улсыг эзлэн түрэмгийлсний дараа ялагч нь харгислалыг дараа нь өдөр тутам үйлдэж олон түмний дургүйцлийг төрүүлэхээс зайлсхийж нэн даруй шийдвэрлэг үйлдэнэ, байгуулсан ялалтынхаа үр шимийг тамшаалан амсахдаа цаг хугацааны удаан нь дээр гэдгийг үргэлж санаж байх нь илүүдэхгүй.

"Төр баригч" номын 17 дугаар бүлэгт төрийн тэргүүний хувьд олон түмэнд хайрлагдаж байх уу эсвээс айлгаж байх уу гэсэн асуудлын талаар бичихдээ "Төр баригч олон түмэнд хайрлагдан хүндлэгдэж байна, түүний зэрэгцээ бас айдас төрүүлж байх ёстой, гэхдээ энэ хоёрын аль нэгийг сонгохдоо тулбал олон түмэнд айдас төрүүлж байх нь аюулгүй байдлын талаасаа өлзийтэй гэсэн зарчмыг баримтална. Учир гэвээс хайр хүндлэл нь бөөн үүрэг амлалтыг дагуулдаг бол, айдас бол хүний сэтгэлээс хэзээ ч арилахгүй, олон түмнийг шийтгэгдэхээс эмээдэг болгох нь чухал." гэжээ.

Уг номын 18 дугаар бүлэг нь "Төр баригчид итгэл үнэмшлийг хэрхэн дэмжих вэ?" гэсэн гарчигтай. "Хашир төр баригч нь ашиг сонирхолд нь харшилж байвал ямар ч итгэл үнэмшлийг дэмжих хэрэггүй. Биелүүлж чадаагүй амлалтуудынхаа талаар харамсал илэрхийлэхийг хүсэж байгаа төр баригчид ямар ч хууль эрх зүйн үндэслэл саад болох ёсгүй, яагаад гэвэл олон түмэн бол үнэхээр гэнэн цайлган, захирагдахад ямагт бэлхэн байдаг болохоор заль мэх хийх гэж байгаа хүнд залилуулах гэсэн хүн дандаа олдоно. Төр баригч нь бусдын амлалтад хууртаж болохгүй."

"Төр баригч" номыг дарангуйлан захирагч нарт зориулсан гарын авлага гэж олонтаа нэрлэдэг. Гэхдээ уг номыг зохиогчийн амьдралдаа баримталж байсан байр суурь, бусад бүтээлээс нь харахад дарангуйлал биш харин бүгд найрамдах засаглалыг дэмжин сайшаадаг байжээ. Итали улсын улс төр, цэргийн сул дорой байдал түүний сэтгэлийг их зовоож байжээ. Улс орныг нь нэгтгэж төрөлх нутгийг нь талхилж байгаа гадаадын цэргийг хөөн гаргаж чадах хүчтэй эзнийг хүсэмжилж байв. Макиавелли нь төр баригч хүний шудрага бус, ичгүүр сонжуургүй бодлого явуулахыг хөхүүлэн хамгаалдаг мөртөө эх оронч, сайн сайхныг мөрөөдөгч хүн байсан төдийгүй өөрийн санал болгож байгаа хуурч мэхлэх явдлыг биечлэн хэрэгжүүлж чаддаггүй байжээ.

Олон зууны турш Макиавеллийг муу муухай, заль мэх, худал хуурмагийн илэрхийлэл гэж

зэмлэн буруушааж байлаа. Гэхдээ түүний өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэглэж тодорхой амжилтад хүрч байсан хүмүүс түүнийг бусдаас илүү шүүмжлэн зэвүүцэж байжээ.

Ёс суртахууны үүднээс Макиавеллийг шүүмжлэхэд түүхэнд ямар ч нөлөө үзүүлээгүй юм шиг сэтгэгдэл төрнө. Тэгээд ч түүний дэвшүүлж байсан үзэл бодол хурц, өвөрмөц биш. "Би ямар нэгэн бодлогыг номлоогүй, харин эрт дээр үеэс азтай хаадын үйл ажиллагаандаа удирдлага болгож байсан аргуудыг л нээн гаргахыг оролдсон юм." гэж олонтаа тайлбарласан байдаг. Өөрийн санал бодлоо илэрхийлэхдээ эртний түүхээс юм уу италийн ойрхон хугацаанд болсон үйл явдлаас бишрэм жишээ татдаг байжээ.

Бенито Муссолини нь Макиавеллийн бүтээлүүдээс ил тод ишлэл татдаг цөөхөн тооны улс төрийн зүтгэлтний нэг байсан болохоор "Төр баригч" номыг улс төрийн нэрт зүтгэлтнүүд дандаа уншсаар байдаг гэсэн дүгнэлт хийж болно. Наполеон энэхүү номыг дэр дороо тавьж унтдаг байсан, Сталин, Гитлер нар ч үргэлж уншдаг байсан тухай яриа оргүй зүйл биш ээ.

Бодит улс төрийн үйл ажиллагаанд Макиавеллийн нөлөө хэр зэрэг байсан нь тодорхойгүй ч улс төрийн онолд үзүүлсэн нөлөө нь маргашгүй их юм. Платон, Амгалан Августин зэрэг илүү дээр үеийн зохиолчид улс төрийг ёс зүй юм уу шашин судлалтай холбодог байсан бол Макиавелли түүх, улс төрийг хүмүүсийн үйл ажиллагааны агуулгаар тодорхойлж ёс суртахууны талыг нь ор тас үгүйсгэсэн. Хүмүүс ямар үйл ажиллагаа явуулах ёстой гэдэг нь биш чухамдаа ямар үйл ажиллагаа явуулж байна, хэн нэгэн хүн ямархуу эрх мэдэлтэй байгаа нь биш чухамдаа хэдэн хүн бодит эрх мэдэлд хүрсэн нь сонирхолтой, үүнд л асуудлын гол гогцоо байгаа юм гэж үзэж байжээ.

Улс төрийн онол урьд үетэй харьцуулбал илүү бодитой болсон нь Макиавеллийн гавьяа юм. Тийм учраас түүнийг улс төрийн сэтгэлгээний үндсийг тавигчдын нэг гэж зүй ёсоор үнэлдэг юм.

# 80. Томас Мальтус

(THOMAS MALTHUS)

1766-1834



1798 онд жирийн лам Томас Роберт Мальтус нимгэхэн ч гүн гүнзгий агуулга бүхий "Хүн амын хуулиудын тухай найраглал, тэр нь нийгмийн ирээдүйн сайн сайханд хэрхэн нөлөөлж байна вэ?" нэртэй ном хэвлүүлжээ.

"Хүн амын өсөлт нь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс түрүүлэх чиглэлтэй байна, хүн амын тоо геометрийн дэвшлээр өсөж байхад хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл арифметикийн дэвшлээр нэмэгдэж байна, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл дээд цэгтээ хүрэх хүртэл хүн амын тоо өссөөр байна, иймд хүн төрөлхтөний дийлэнх хэсэг нь ядуу зүдүү амьдарч гол зогоох төдий байсаар өлсгөлөнгийн ирмэгт тулж очно, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт хязгаартай учраас техникийн дэвшлийн ямар ч ололт байдлыг өөрчилж дийлэхгүй. Хүн амын өсөлтийн хүч нь хүнийг тэжээх газрын үржил шимийн хүчнээс илүү юм." гэж уг номонд бичсэн байна.

"Хүн амын өсөлтийг бууруулах ямар нэгэн арга байна уу? Байна, дайн, тахал болон өөр бусад гай гамшгийн үр дүнд хүн амын тоо мэдээж багасна. Гэхдээ энэ бол хүн ам хэт олшрох явдлыг хэсэг зуур саатуулахаас хэтрэхгүй, иймд "ёс суртахууны хязгаарлалтын" аргыг хэрэглэх нь зүйтэй. Гэрлэх доод насны хязгаарыг нэмэгдүүлэх, гэр бүл болохын өмнөх насанд эр эмийн ажилд ухаалаг хандаж сургах, гэр бүл болохын өмнөх насанд санамсаргүй хавьталтыг хүчээр хязгаарлах зэрэг арга хэмжээг хослуулан хэрэглэхийг ёс суртахууны хязгаарлалтын арга гэж ойлгоно.

Гэхдээ хүмүүс миний санал болгож байгаа хязгаарлалтад захирагдахгүй нь мэдээж. Бодит амьдрал дээр дэлхийн хүн амын тоо хэт нэмэгдэнэ, иймд ядуу зүдүү байдал нь олон тооны хүмүүсийн хувь заяа болно." гэсэн гутрангуй үзэл санааг Мальтус номондоо дэлгэрэнгүй дурдсан бий.

Хүн амын тоог үр тогтохоос хамгаалах аргаар тохируулах үйл ажиллагааг сайшаадаггүй байсан ч түүний дэвшүүлсэн үзэл санаа нь хүн амын төрөлтийг зохицуулах бодлогод гарцаагүй хүргэсэн юм.

Үр тогтохоос хамгаалах аргыг өргөнөөр хэрэглэхийг ил тод уриалсан анхны хүн нь английн нөлөө бүхий шинэчлэгч Фрэнсис Плейс (1771 — 1854) байлаа. Мальтусын номыг уншаад сэтгэл нь хөдөлж үр тогтохоос хамгаалах аргыг сурталчилсан ном 1822 онд хэвлүүлж ажилчдын дотор хүүхэд төрөлтийг хянах тухай мэдээлэл түгээж эхэлжээ. АНУ-д эмч Чарльз Ноултон үр тогтохоос хамгаалах аргын тухай ном 1832 онд мөн гаргажээ. 1860 онд "Мальтусын холбоо" байгуулагдаж эгнээгээ өргөн тэллээ. Т.Мальтус нь ёс суртахууны үүднээс үр тогтохоос хамгаалах аргыг таашаадаггүй байсан тул үр тогтохоос хамгаалах аргаар хүн амын өсөлтийг тохируулах үзэл бодлыг сурталчлагчид өөрсдийгөө шинэ мальтусчууд гэж нэрлэх болжээ.

Түүний дэвшүүлсэн санаа эдийн засагчдад мөн нөлөөлжээ. Хэвийн нөхцөл дэх хүн амын хэт өсөлт нь цалингийн хэмжээг байгаа түвшингээс нь нэмэгдүүлэхээс урьдчилан сэргийлнэ гэсэн дүгнэлтийн эдийн засагчид хийв. Английн нэрт эдийн засагч Давид Рикардо (Мальтусын дотнын найз) "Хөдөлмөрийн жинхэнэ үнэ гэдэг нь хөдөлмөрчин хүнд хойч удмаа нэмэгдүүлэхгүйгээр, хүн амын тоог өсгөхгүйгээр амьдрах бололцоог олгох зайлшгүй шаардлагатай үнэ юм." гэж сургалаа. "Хөдөлмөрийн хөлсний хатуу хууль" гэж нэрлэгдсэн энэхүү онолыг К.Маркс зээлдэн авч нэмүү өртгийн тухай онолынхоо гол агуулга болгосон билээ.

Түүний үзэл баримтлал биологчдын анхаарлыг бас татжээ. Байгалийн сонгон шалгаруулалтын замаар органик хувьсал явагддаг тухай онолоо баталгаажуулахад минь хүн амын хэт өсөлтийн тухай Мальтусын ном надад их тус боллоо гэж Чарльз Дарвин бичсэн бий.

Т.Мальтус 1766 онд Английн Доркинг хотоос холгүй орших Сурее хотхонд төрж Кембрижийн их сургуулийн дэргэдэх Есүсийн коллежид элсэн онц суралцжээ. 1788 онд коллеж төгсөж лам болов. 1791 онд магистрын зэрэг хүртэж 1793 онд коллежийнхээ удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогджээ.

"Хүн амын хуулиудын тухай найраглал, тэр нь нийгмийн ирээдүйн сайн сайханд хэрхэн нөлөөлж байна вэ?" номынхоо анхны хувилбарыг нууц нэрээр гаргасан нь олны анхаарлыг татаж түүнд алдар хүнд авчирчээ. Илүү дэлгэрэнгүй ном нь таван жилийн дараа хэвлэгдсэн ба номоо байнга засвар хийж шинэ мэдээлэл нэмж нийтдээ зургаан удаа хэвлүүлснээс хамгийн сүүлчийнх нь 1826 онд гарчээ.

1804 онд 38 настайдаа анх гэрлэж гурван хүүхэдтэй байв. Вест-Энэтхэгийн компанийн Хейлбери хот дахь коллежийн түүх, улс төрийн эдийн засгийн профессорын албан тушаалд 1805 онд томилогдож насан эцэслэх хүртлээ ажиллажээ. Эдийн засгийн асуудлаар хэд хэдэн ном бичсэнээс 1820 онд хэвлүүлсэн "Улс төрийн эдийн засгийн хуулиуд" ном нь ихээхэн алдартай. Энэ ном дараа үеийн олон эдийн засагчид түүний дотор хорьдугаар зууны нэрт эдийн засагч Ж.М.Кейнсэд ихээхэн нөлөө үзүүлсэн. Т.Мальтус амьдралынхаа сүүлийн жилүүдэд улам их нэрд гарч олон ч өндөр шагнал хүртжээ. 1834 онд Английн Бат хотын

ойролцоо 68 настайдаа өөд болжээ.

Үр тогтохоос хамгаалах аргыг Т.Мальтусыг нас барснаас хойш өргөн дэлгэрээгүй учир түүнийг түүхэн дэх аугаа хүмүүсийн тоонд оруулахгүй явдал заримдаа гардаг нь буруу. Түүний үзэл бодол Х!Х зууны суут сэтгэгч Ч.Дарвин, К.Маркс нарт их нөлөө үзүүлсэн. Шинэ мальтусчуудын үйл ажиллагааг олон түмэн талархан угтаагүй ч буруушааж эсэргүүцээгүй ба төрөлтийг зохицуулах орчин үеийн хөдөлгөөн нь Мальтусыг амьд байх үед эхэлсэн хөдөлгөөний шууд үргэлжлэл юм.

Зохион байгуулалт сайтай улс орон хүн амын хэт өсөлтөөс болж төвөгтэй байдалд орж болохыг анхааруулсан анхны хүн нь Т.Мальтус биш. Түүнээс өмнө Аристотель, Платон нарын гүн ухаантнууд хүн амын өсөлтийн асуудлыг сонирхож байв. Тухайлбал Аристотель "Ихэнх оронд хүн бүрт хүссэн тооны хүүхэдтэй болох эрх чөлөөг олговол хор уршиг нь ядуурал үгүйрэл болно." гэж анхааруулж байжээ.

Гэхдээ Т,Мальтус хүн амын хэт өсөлтийн асуудлыг дагнан судалж шинжлэх ухааны ач холбогдол бүхий ном товхимол олныг бичиж цэгцтэй үзэл санааг дэвшүүлсэн гавьяатай эрдэмтэн юм. Хүн амын хэт өсөлтийн асуудалд оюуны ертөнцийн анхаарлыг хандуулж чадсан билээ.



# 81. Жон Фицджеральд Кеннеди

(JOHN FITZGERALD KENNEDY)

1917-1963



Ж.Ф.Кеннеди 1917 онд АНУ-ын Массачусетс муж улсын Бруклин хотод төржээ. Тэнгисийн цэргийн флотын офицер байгаад 1947-1961 онуудад ардчилсан намаас Конгресийн гишүүнээр сонгогдож байжээ. 1961 оны нэгдүгээр сарын 20-ноос 1963 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Техас мужийн Даллас хотод алагдах хүртлээ АНУ-ын 35 дахь ерөнхийлөгчөөр ажиллаж байсан билээ.

Мянган жилийн дараа гэхэд түүний шууд оролцон байгуулсан АНУ-ын Энх тайвны корпус, Дэвшлийн төлөө Холбоо, Кочиносийн буланг бараг санахгүй биз ээ. Гэхдээ улс төрчийн хувьд татварын бодлого, хүний эрхийг хамгаалах асуудлаар ихийг бүтээсэн нь түүхэнд мартагдахгүй билээ. Сансрын "Аполлон" хөтөлбөрийг бий болгон хэрэгжүүлэхэд гол гавьяа байгуулсан улс төрийн зүтгэлтэн мөнөөс мөн. Сар руу хийсэн хүн төрөлхтөний аялалыг таван мянган жилийн дараа ч гэсэн хүн төрөлхтөний буурал түүхэн дэх хамгийн гайхамшигт үйл явдлын нэг гэж зүй ёсоор тооцсоор байх нь мэдээж.

Сарыг судлах хөтөлбөр нь хүний оюун ухааны суу гайхамшиг мөн. Түүний санаачилга зоригийн үр дүнд Нейли Армстронг, Эдвин Олдрин хоёр Саран дээр мөрөө гаргасан анхны хүмүүс болсон юм. Вернер фон Браун зэрэг эрдэмтэд, инженерүүд сансарт хийх аялалыг бэлтгэхэд чухал хувь нэмэр оруулсан нь үнэн. Гэхдээ "Аполлон" хөтөлбөрийг хэрэгжүүлэх улс төрийн шийдвэр гараагүй бол хичнээн ч эрдэмтэн, хичнээн ч инженер хүн төрөлхтөний мөнхийн мөрөөдлийг биелүүлэх бололцоотой болж чадахгүй байсан юм. Чухамдаа сар руу хийх аялалд 24 тэрбум ам.доллар зарцуулах болсон нь шинжлэх ухааны хөгжлийн ээлжит алхам биш харин улс төрийн зоримог шийдвэрийн үр дагавар байлаа.

Ж.Кеннеди байгаагүй ч гэсэн сар руу хийх аялалын тухай шийдвэрийг аль нэг засгийн газар гаргах байсан нь мэдээж. Гэхдээ Ж.Кеннеди олон түмний зүгээс ямар ч дэмжлэг байгаагүй үед татвар төлөгчдийн асар их мөнгийг зарцуулах шийдвэрийг дангаараа гаргаснаараа

Өнөөдөр хүн төрөлхтөний талархал хүндэтгэлийг хүлээж байна. "Аполлон-11" хөтөлбөр хэрэгжиж эхэлсний дараа ч гэсэн дэндүү их хөрөнгө гарч байна гэсэн маргаан үргэлжилсээр 1969 оноос НАСА хөтөлбөрийн төсвийг багасгасан билээ.

Хүн жолоодсон сансрын хөлгийг энэ арван жилдээ багтааж Саран дээр буулгах амлалтыг Ж.Кеннеди 1961 онд америкийн ард түмэнд өгсөн төдийгүй "Аполлон-11" хөтөлбөрийг боловсруулж Конгрессээр батлуулж чадсан юм.

Өнөөдөр сарыг судлах хөтөлбөр үргэлжилсээр байгаа ба сансрын аялал нь ирээдүйд өнөөгөөс илүү ач холбогдолтой болох нь дамжиггүй. Х.Колумб америк тивийг нээсэн шиг "Аполлон-11" хөлөг 1963 оны долоодугаар сарын 20-ны өдөр сарны гадаргуу дээр хүн буусан нь хүн төрөлхтөний түүхэнд бүхэл бүтэн эрин үеийг нээсэн билээ.

# 82. Грегори Пинкус

(GREGORY PINCUS)

1903-1967



Жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл бий болоход гол үүрэг гүйцэтгэсэн эрдэмтэн бол америкийн биологч Грегори Пинкус юм. Тэрбээр нэрд гарсан эрдэмтэн байгаагүй ч хүн төрөлхтөний амьдрал асар их нөлөө үзүүлсэн юм.

Хүн амын хэт өсөлт нь хортой үр дагавартай байж болзошгүй тул дэлхий ертөнцөд жирэмслэлтээс хамгаалах хэрэглэл нь маш чухал ач холбогдолтой болох нь ойлгомжтой. Ийм хэрэгсэл бий болсноор хүн төрөлхтөнөөс эр эмийн ажилд хандах хандлагад эрс өөрчлөлт орсон юм.

Сүүлийн дөч гаруй жилд АНУ-д сексийн хувьсгал явагдаж байгаа ба энэ хувьсгалд улс төр, эдийн засаг, нийгмийн олон хүчин зүйл нөлөөлж байгаа ч жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл хамгийн гол хүчин зүйл болж байгаа юм. Эмэгтэйчүүд урьд цагт хүсээгүй жирэмслэлтээс айж нөхөрт гарахаас өмнө тэр ч бүү хэл хань ижилтэйгээ энгэр зөрүүлэхээс татгалздаг байсан бол хамгаалах хэрэгсэл бий болсноор жирэмслэлтээс огт эмээхээ больж дуртаа цагтаа хүссэн хүнтэйгээ загас наалдуулдаг болжээ. Үүнтэй уялдан хүмүүсийн зан авирт ч өөрчлөлт гарсан билээ.

Жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл гарахаас өмнө диафрагм нэртэй үнэхээр аюулгүй, харьцангуй хүртээлтэй хэрэгсэл байсан нь үнэн. Гэхдээ дийлэнх эмэгтэйчүүд диафрагмийг таашаадаггүй байсан ба одоо ч гэсэн түүнийг мөн тээршаасаар байна.

Жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл эрүүл мэндэд эрсдэлтэй тэрчилэн ирээдүйд илүү аюулгүй арга олдох учир түүнийг хүний оюун ухааны гайхамшигт ололт гэж үзэхийг эсэргүүцдэг хүмүүс бий. Сүүлийн жилүүдийн судалгаанаас үзэхэд жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл нь ихээхэн нааштай үр дүн өгч байна. Тухайлбал сүүлийн гучин жилд америкийн хэдэн сая эмэгтэйчүүд жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл ашиглаж байгаагийн ачаар тэдний

дундаж нас өссөн байна. Энэ бол жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл нь хүний эрүүл мэндэд хор уршиггүй болохыг гэрчилж байна.

Хорьдугаар зууны тавиад оны дунд үеэр жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл бий болсон нь хүүхэд төрөлтийг зохицуулах аргад шийдвэрлэх дэвшил болсон юм.

Жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийг бүтээхэд олон хүн хувь нэмэр оруулсан. Гэхдээ химийн ямар нэгдэл шаардлагатай болохыг анхандаа хэн ч мэдэхгүй байлаа. 1937 онд А.В.Мейкпис, Ж.Уэйнштейн, М.Г.Фридман нар прогестерон (эмэгтэй гормоны нэг)-ий тарилга нь лабораторын амьтдын эм эсийг умайд ороход нь саад болж байгааг нээжээ. Гэвч арьсанд тухай бүр тарилга хийж байх нь төвөгтэй, тэгээд ч прогестерон нь үнэтэй бэлдмэл байсан тул энэ арга олон нийтийн дэмжлэг хүлээсэнгүй.

Гэвч америкийн биологч Грегори Пинкус жирэмслэлтээс хамгаалах аргыг 1950 онд олж чадсан юм. Гэр бүлийн төлөвлөлтийн асуудлыг сурталчлагч Маргарет Сенгер гэдэг бүсгүй стероидын солилцоо, хөхтөн амьтдын нөхөн үйлдвэрлэлийн физиологийн мэргэжилтэн, Массачусетс муж улсын Шреусберийн туршилтын биологийн Уорчестерийн сангийн лабораторийн захирал Г.Пинкуст хандаж жирэмслэлтээс хамгаалах найдвартай хэрэгсэл бий болгоход туслалцаа үзүүлэхийг хүсчээ.

Техникийн өндөр мэдлэг, судлаачийн хосгүй мэдрэмж хослуулсан Г.Пинкус жирэмслэлтээс хамгаалах арга олох ажилд тэр даруй шамдан орж Уорчестерийн сангийн багш, доктор Мин Че Чангад хандаж лабораторийн амьтад дээр прогестероныг шалгаж эм эсийг умайд ороход нь саад болж байгаа эсэхийг нь нотлохыг хүсчээ. М.Ч.Чангийн туршилт амжилттай болов. Энэ явдлаас хэдэн жилийн өмнө химич Рассел Маркер прогестероныг хямд үнээр нийлжүүлэх аргыг зохиосон байжээ.

Г.Пинкусын саналаар, прогестерон хэрэглэн эм эсийг умайд ороход саад болж байгааг тестийн аргаар шалгасан эмэгтэйчүүдийн эмч Жон Рок мөн чухал хувь нэмэр оруулжээ. Гэхдээ Ж.Рокийн туршилт дараах хоёр хэцүү асуудлыг илрүүлсэн, үүнд нэгдүгээрт прогестерон нь эм эсийн зөвхөн 85 хувийг умайд ороход нь саад болж чадаж байлаа, хоёрдугаарт дээрх дурдсан хувийг хангахын тулд улам их прогестерон шаардагдаж байв.

Гэвч зөв чиглэлээр явж байгаадаа итгэсэн Г.Пинкус судалгааны ажлаа зогсоосонгүй, прогестеронтой адилхан гэхдээ илүү сайн үзүүлэлттэй химийн нэгдэл байж таарна гэж үзэж байв. Тэгээд химийн үйлдвэрлэл эрхэлдэг компаниудад хандаж химийн бүтцээрээ прогестеронтой адилхан химийн нэгдлүүдийн дээжийг ирүүлэхийг уриалжээ. Ирүүлсэн химийн нэгдлүүдийг шалган үзэхэд Ж.Д.Сирлийн үйлдвэрт хийдэг норетинодрел гэдэг бэлдмэл илүү тохиромжтой болох нь мэдэгджээ.

Сиэтл хотын лабораторид ажилладаг, биохимич мэргэжилтэй доктор Фрэнк Б.Колтон 1952 онд норетинодрел бэлдмэлийг бий болгож шинэ бүтээлийн гэрчилгээ авсан байжээ. Гэвч тэд чухал юу бүтээснээ удтал ойлгохгүй байжээ.

Г.Пинкус судалгааны баг байгуулан ажиллаж норетинодрел бэлдмэлд местранол нэртэй химийн нэгдэл нэмэхэд бүр илүү үр дүнтэй болохыг нь нотлов. 1955 онд бий болгосон

бэлдмэлээ жинхэнэ ёсоор турших цаг ирснийг ойлгож дараа жил нь Пуэрто-Рико улсын Сан-Хуан хотын ойролцоох хүрээлэнд туршилт хийж эхэлжээ. Дараа нь мөн гурван жилийн турш туршилт хийсээр Хүнсний бүтээгдэхүүн болон эмийн удирдах газраас 1960 онд сая хийсэн бэлдмэлээ арилжаалах зөвшөөрөл олгожээ.

Дээр дурдсан үйл явлуудаас харахад жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл бүтээхэд Г.Пинкусийн хувь нэмэр бага юм шиг ойлгогдож байж болох юм. Тухайлбал норетинодрел бэлдмэлийг Ф.Колтон бий болгож тэрчилэн Г.Пинкусын судалгааны бүлэгт ажиллаж байсан Ж.Рок, М.Ч.Чанг, доктор Цесо-Рамон Гарсия, Райс-Урай, М.Сенгер гээд олон эрдэмтэд өөрсдийн хувь нэмрийг оруулсан нь үнэн. Гэхдээ төслийг хэрэгжүүлэх ажлыг гол зохион байгуулагч, хөдөлгөгч хүч нь Г.Пинкус байсан нь маргаангүй үнэн. Судлаачийн болон зохион байгуулах их чадвар, эрдэмтний өндөр нэр хүнд, хамаг цаг хугацаагаа төслийг бодитой болоход зарцуулж санхүүжилтийн асуудлыг биечлэн хөөцөлдөж шийдсэн хүн юм.

Г.Пинкус нь 1903 онд АНУ-ын Нью-Жерси муж улсын Вудбайн хотод орос-еврей гэр бүлд төрж 1924 онд Корнеллийн их сургууль төгсөж 1927 онд Гарвардын их сургуульд докторын зэрэг хүртжээ. Гарвард, Кембрижийн гэх зэрэг нилээд хэдэн их сургуульд судалгааны ажил хийж Кларкийн их сургуульд профессор байжээ. 1944 онд Туршилтын биологийн Уорчестерийн сан байгуулж хэдэн жилийн турш захирлаар нь ажиллажээ. Шинжлэх ухааны 250 гаруй өгүүлэл түүний дотор 1965 онд хэвлэгдсэн "Үржихийн ялалт" ном хэвлүүлжээ.

Г.Пинкус амьд сэрүүн байхдаа олон шагнал хүртэж байсан ч хамтран зүтгэгчдээс нь хэн ч Нобелийн шагнал хүртээгүй юм. 1967 онд Бостон хотод түүнийг өөд болоход шинжлэх ухааны ертөнц бараг мэдээгүй өнгөрсөн гэхэд хилсдэхгүй. Гэсэн хэдий ч Г.Пинкус нь хүн төрөлхтөний түүхэн дэх хэдхэн аугаа нээлтийн нэгнийх нь зохиогч байсан билээ.

# 83. Мани

(MANI)

216-276



Гуравдугаар зууны үеийн зөнч Мани нь аль хэдийнээ мөхсөн ч тухайн цагтаа дэлхий даяар маш олон тооны шүтэн бишрэгчтэй байсан манихейство шашныг үндэслэгч байсан билээ. Дундад Дорнодод үүссэн энэхүү шашин нь өрнө зүгт Атлантын далай хүртэл, дорно зүгт Номхон далай хүртэл тархаж бараг мянга гаруй жил олон сая хүний оюун санааг эзэмдэж байсан юм.

Манийн бүтээсэн шашин нь эрт дээр цагийн шашнуудын холимог байлаа. Мани нь Зороастр, Будда, Есүс бурхдыг хүлээн зөвшөөрдөг, гэхдээ ертөнцийг тэднээс илүү бүрэн дүүрэн нээсэн гэж өөрийгөө үнэлдэг байжээ.

Түүний бий болгосон шашинд Будда, Христосын зохиосон шашны сургаалуудаас бий боловч гол номлолоо Зороастрын хоёр эхлэлтэй гэсэн үзлээс хуулбарласан байна. Дэлхийн ертөнцийг бурхан удирдан чиглүүлдэггүй, Манийн харанхуй, идээ бээр гэж тодорхойлсон муу үйлийн зарчим болон гэрэл, ухаан гэж тодорхойлсон сайн үйлийн зарчим гэсэн хоёр хүчний хоорондын мөнхийн зөрчил тэмцэлдээн юм. Энэ нь бол христосын шашны номлолоор бол Бурхан, чөтгөрийн тухай сургаал шиг санагдана. Гэхдээ манихейство шашнаар бол сайн болон муу үйлсийн зарчмууд нь хүчний хувьд адил тэнцүү ажээ. Энэ утгаараа христосын болон еврейн гүн ухаантнуудын сэтгэлийг зовоож байсан муу үйлийн тухай үзлийг нэг тийш болгосон байлаа.

Энд манихейство шашны тухай дэлгэрэнгүй өгүүлэх боломж алга. Гэхдээ хүний сэтгэл санаа сайн болон муу үйлийн зарчимтай холбоотой болох тухай дурдах нь зохилтой. Манихейство шашныг номлогчид нь үндэс угсаагаа залгамжлах зорилгоор хүртэл энгэр зөрүүлэхийг буруушаадаг байв. Тэрчилэн махан хоол идэх, дарс уухыг хориглодог байв.

Дээр дурдсан шиг бүдүүлэг, хүмүүнлэг бус ч гэмээр номлолтой шашин олон сая хүний сэтгэлийг яаж эзэмдэж байсан нь хачирхалтай. Учир нь гэвээс дээр дурдсан хоригууд нь жирийн шүтэгчид биш чухамдаа сонгомол гэж нэрлэгдэх дээд зиндааны хэдхэн тооны хүмүүст хамааралтай байжээ. Сүм хийдийн жирийн лам нарт эхнэртэй тэр ч бүү хэл нууц амраг бүсгүйтэй байх, мах идэх, дарс уух зэрэг ертөнцийн бүхий л таашаалыг амсахыг бүрэн зөвшөөрдөг байжээ. Гэхдээ тэд "сонгомол хүмүүс"-т туслах ёстой байв. Нас барсны дараа

"сонгомол" хүмүүсийн оюун санаа диваажинд шууд очдог бол жирийн лам нарын сүнс тийшээ удаж байж сая нэг хүрдэг гэж үздэг байжээ.

Персүүдийн удам болох Мани нь 216 онд тухайн үед Арсакидийн угсааныхан төрийн эрх мэдлийг барьж байсан Персийн эзэнт гүрний хэсэг болох Месопотами хотод төржээ. Тэр үед дийлэнх персүүд зороастризмыг шүтдэг байсан бол Мани христос шашны нөлөө бүхий бяцхан бүлэгт өсчээ. 12 настайдаа шашны өвөрмөц үзэлтэй болж 24 настайдаа шинээр бий болгосон шашнаа сурталчилж эхэлжээ. Эх орондоо амжилт эс олсон тул, Энэтхэгийн баруун-хойд хэсэгт очиж нутгийн удирдагчийн итгэлийг олж чаджээ.

242 онд Персийн эзэнт гүрэнд буцан ирж нэгдүгээр Шапур хааныг шинэ шашиндаа итгүүлж эс чадсан ч сайхан сэтгэгдэл төрүүлж чадсаны үр дүнд тус улсад сурталчлах зөвшөөрөл авчээ. Ийнхүү Мани бараг гучин жилийн туршид Шапур хаан түүний өв залгамжлагч нэгдүгээр Хормидзегийн үед шинэ шашнаа түгээн дэлгэрүүлснээр олон тооны бишрэн шүтэгчидтэй болов. Энэ хугацаанд гадаадын олон оронд лам нар явуулж мөн сурталчилгаа хийлгэж байжээ.

226 оны үед төрийн эрхэнд гарсан Сасадиновын удмынханы үед Персийн эзэнт гүрэнд зороастрийн шашин голлох үүрэг гүйцэтгэж байсан тул Мани томоохон эсэргүүцэлтэй тулгарав. 276 оны орчим нэгдүгээр Бахрам хаанаар өргөмжлөгдсөнийхөө дараа Манийг баривчилж шоронд хорьжээ. Шоронгийн тамлалтыг дийлсэнгүй, 26 хоногийн дараа нас баржээ.

Мани амьдралынхаа хугацаанд олон ном бичсэнээс нэгийг нь л перс хэл дээр бусдыг нь сири хэл дээр хэвлүүлсэн нь манихейство шашны гол судрууд болжээ. Уг шашин мөхсөнөөр дийлэнх номууд нь алга болсон ч бидний үед хэд хэдэн бүтээл нь хадгалагдан ирсэн юм.

Мани амьд сэрүүн байх үед манихейство шашин Энэтхэгээс Европ хүртэлх орон зайд тархсан бол дараа нь өрнө зүгт Испани хүртэл, дорно зүгт Хятад хүртэл түгжээ. Түүгээр ч зогсохгүй дөрөвдүгээр зуунд өрнөдөд оргил үедээ хүрч христос шашны гол өрсөлдөгч байлаа. Далимд өгүүлэхэд Амгалан Августин есөн жил манихейство шашныг шүтэж байжээ. Гэвч христос шашин Ромын эзэнт улсын төрийн шашин болон өргөмжлөгдсөнөөр манихейство шашны нөлөө багассаар 600 оны үед европ тивээс бүрэн зайлуулагдсан байлаа.

Гэхдээ Месопотами, Иранд хүчтэй хэвээр байсан. Чухамдаа тэндээс Төв Ази, Туркестан, Хятадын өрнөд хэсэгт нэвгэрчээ. ҮШ зууны эх гэхэд Хятадын өрнөд хэсэг, Монголд хяналт тавьж байсан Уйгуруудын албан ёсны шашин болжээ. Удалгүй Хятадад бүхэлд нь Тайваны аралд мөн түгжээ. Гэвч ҮИ зуунд лалын шашин бий болж манихейство шашинд үхлийн цохилт өгчээ. ҮШ зууны эхнээс Багдад дахь лалын шашныг бишрэн шүтэгчид манихейство шашныг хавчин шахаснаар Месопотами, Иранд дараа нь IX зуунаас Төв Азид нөлөө нь буурч XIII зуунд монголчуудын халдан довтолгооны үеэс бүр сөнөжээ. Гэхдээ италийн аялагч Марко Поло манихейство шашны бүлгүүдтэй Хятадын дорнод хэсэгт 1300 онд тааралдаж байснаа бичиж үлдээсэн байдаг.

Энэ зуур манихейство шашнаас салбарласан бүлгүүд Европ тивд өргөн тархсаар байлаа. ҮИ зууны үед Византийн эзэнт гүрэнд павликианууд, аравдугаар зууны үед Балканы орнуудад

богомилууд, Францийн Альби хот дахь альбичууд буюу катарууд манихейство шашныг шүтсээр байв. Альбичууд манихейство шашны номлолыг баримталдаг байсан ч өөрсдийгөө христосчууд гэж нэрлэдэг байсан нь их сонин. Гэтэл христос шашны сүм хийдүүд тэднийг буруу номтнууд гэж гадуурхана. Гэвч эцсийн эцэст Дундад зууны хаадаас хамгийн хүчирхэг, хамгийн тэвчээргүй нь болох хамба лам гуравдугаар Иннокенний манихейство шашин шүтэгчдийн эсрэг 1209 онд загалмайтны аян дайн зарлаж 1244 он гэхэд альбичуудыг бүрэн дийлжээ. Гэвч Итали дахь катарчууд ХҮ зуун хүртэл оршин тогтносон билээ.

Аливаа шашин бишрэн шүтэгчдийнхээ амьдральд тодорхой нөлөө үзүүлдэг. Тийм учраас манихейство шашин одоо оргүй байгаа ч цаг үедээ шүтэн бишрэгчдийнхээ амьдрал, аж төрөх ёсонд ихээхэн нөлөө үзүүлж байсан нь лавгай.

Мани манихейство шашны номлолыг боловсруулж ёс суртахууны хэм хэмжээг нь тогтоожээ. Зарим үзэл бодлоо түрүү үеийн сэтгэгчдээс зээлдсэн ч тэр бүхнийг нэгэн цогц сургаал болгон нэгтгэж чаджээ. Шинэ шашны судар зохиолуудыг туурвиж биечлэн сурталчилж олон тооны бишрэн шүтэгчидтэй болж шашны зохих байгууллагуудыг байгуулсан ажээ.



# 84. Владимир Ильич Ленин

(V.I.LENIN)

1870-1924



Ленин хэмээх нууц нэрээрээ алдаршсан Владимир Ильич Ульянов бол Орос улсад коммунист нийгэм байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн улс төрийн удирдагч байлаа. К.Марксын сургаалыг үнэнчээр үргэлжлүүлэгч гэж өөрийгөө тунхагладаг байсан Ленин тэр сургаалтай нь тойруу замаар холбоотой бодлогыг явуулж байлаа. Коммунист сургаалын лениний хувилбар дэлхийн олон хэсэгт түргэн тархсан учир Ленинийг түүхэн дэх хамгийн нөлөө бүхий улс төрийн зүтгэлтэн гэж үзэхээс өөр аргагүй юм.

1870 онд Оросын Симбирск хотод Засгийн газарт үнэнч түшмэлийн гэр бүлд төржээ. Том ах Александр нь хувьсгалч болж хааныг алах хуйвалдаанд оролцсон хэргээр цаазлуулжээ. 23 настайдаа марксын сургаалыг тууштай баримтлагч болж 1895 онд хувьсгалт үйл ажиллагаанд оролцсон учир баривчлагдаж арван дөрвөн сар шоронд суусны дараа алс бөглүү Сибирыг цөллөгджээ.

Тэнд гурван жил байх хугацаандаа хамтран зүтгэгч бүсгүйтэйгээ гэрлэж "Орос дахь капитализмын хөгжим" номоо туурвижээ. 1900 оны хоёрдугаар сард цөллөгөөс буцан ирүүт Өрнөд Европт гарч тэнд мэргэжлийн хувьсгалчийн ажил эрхлэн 17 жил суужээ. Оросын социал-демократ нам хоёр хэсэг болон задрахад олон тооны гишүүнтэй болох большевик жигүүрийн удирдагч болжээ.

Дэлхийн нэгдүгээр дайны уршгаар Орос улсад цэрэг, эдийн засгийн сүйрэл болж Хаант засагт ард түмний дургүйцэл ихэссэн нь Ленинд түүхэн бололцоо олгожээ. 1917 оны хоёрдугаар дугаар сард Хаант засаг унаж орос улсад ардчиллын замд гарах бололцоо нээгдэв.

Хаант засаг унасныг мэдмэгц Ленин эх орондоо яаран ирээд ардчилсан намууд Түр засгийн газар байгуулсан ч бодит эрх мэдэлтэй болж чадаагүй байгааг гярхай харж хүч сул коммунист намыг засгийн эрхэнд гаргах сайхан боломж бүрдсэнийг ойлгов. Тэгээд большевикууд Түр засгийн газрыг унагаж оронд нь коммунист засгийн газар байгуулах зорилгоор эргэлт

хийхийг уриалав. Гэвч долоодугаар сар хийсэн оролдлого нь бүтэлгүйтэхэд нууц байдалд оров. Дараа нь аравдугаар сард хийсэн хоёр дахь оролдлого нь амжилтад хүрч Ленин засгийн газрын толгойлогч болжээ.

Засгийн газрыг толгойлж байхдаа ов зальтай, бодит байдлыг жинхэнээр үнэлж чаддаг удирдагчийн хувьд социалист эдийн засагт бүрэн шилжилт хийхийг юуны өмнө зорилгоо болгов. Энэ зорилго нь биелэгдэх бололцоогүй нь тодорхой болоход мөн алсыг харж алхам ухралт хийж капиталист-социалист холимог эдийн засгийг хэвшлийг бий болгосон нь ЗХУ-д нилээд хэдэн жил оршин тогтножээ.

1922 оны тавдугаар сард буудуулж хүнд шархадсаны улмаас 1924 онд нас барах хүртлээ төрийн ажилд оролцох чадваргүй байжээ. Түүнийг өөд болсны дараа шарилыг нь занданшуулж Москва хотод Улаан талбайд Мавзолейд тавьсан байна.

Идэвхтэй үйл ажиллагааг удирдлага болгодог хүний хувьд Ленин большевикүүдийг оросод засгийн эрхэнд хүргэж дэлхийд анхны коммунист засгийн газрыг байгуулжээ. Улс төрийн амьдралд М.Марксын үзэл санааг анх удаа хэрэгжүүлж эхэлсэн нь хүн төрөлхтөний түүхийн эргэлтийн цэг болжээ. 1917 оноос 1979 онуудад коммунист хөдөлгөөн дэлхий даяар тархаж нэгэн үе дэлхийн нийт хүн амын гуравны нэг нь коммунистуудын удирдлага дор амьдарч байсан.

Улс төрийн удирдагчийн хувьд зохиол бүтээлээрээ түүхийн явцад их нөлөө үзүүлсэн юм. Лениний баримталж байсан үзэл санаа К.Марксын сургаалтай зөрчилдөж байгаагүй ч түүний сургаалд нилээд хэдэн зарчмын өөрчлөлт оруулсан. Хувьсгалын тактикийг онцгой сонирхож энэ асуудлаар гаргуун мэдлэгтэй гэж өөрийгөө үнэлдэг байжээ. Хүчирхийлэл зайлшгүй шаардлагатайг байнга онцлон тэмдэглэж "Ангийн тэмцлийн ганц ч асуудал хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэгдэж байсан удаагүй." гэж сургаж байжээ. К.Маркс пролетарийн диктатурын тухай зохиол бүтээлдээ хааяа нэг дурдаж байсныг Ленин өлгөн авч улам лавшруулан "Пролетарийн диктатур гэдэг нь хүчинд тулгуурласан, хууль болон засгийн газраар хязгаарлагддаггүй эрх мэдэл юм." гэж үзэж байлаа.

Зөвлөлт засгийн газар оршин байх үндэслэлээ эдийн засгийн бодлого биш (социалист засгийн газрууд хэд хэдэн оронд одоо ч байна), чухамдаа эрх мэдлээ ямар ч үнээр хамаагүй атгаж байх чадвар гэж үзэж байлаа.

Улс орныхоо дотор хэвлэл мэдээлэл, банк, сүм хийд, хөдөлмөрийн шорон гээд засгийн газрын бүх байгууллагуудыг төрийн эрх баригч коммунист нам хатуу чанд хянаж байлаа. Ленин бөөнөөр хорих шорон, коммунист сурталчилгааг хослуулан байж олон зуун жил оршин байж чадах удирдлагын тогтолцоог бий болгоно гэж мөрөөдөж байсан. Гэвч тэр мөрөөдөл нь биелсэнгүй.

Онолчийн хувьд (эдийн засгийн бүх үзэл баримтлалаа К.Марксаас зээлдэн авсан хүн), үйл ажиллагааг удирдлага болгодог улс төрийн зүтгэлтний хувьд засгийн эрх мэдлийг булаан авч тэр эрх мэдлээ улс орондоо өөрчлөлт хийхэд ашигласан нь бодит үнэн юм. Түүхэнд түүний эзэлж байгаа байр суурь, үзүүлсэн нөлөөг дүгнэхдээ түүнийг залгамжлагч И.Сталиний үйл ажиллагаатай харьцуулах нь зүйтэй.

В.Ленин ЗХУ-ыг тавхан жил захирч байх хугацаандаа оросын язгууртнуудыг бүрэн устгаж эх орондоо социалист бүтээн байгуулалтыг эхлүүлсэн. Гэхдээ Ленин биш Сталин хөдөө аж ахуйг хамтралжуулах хөдөлгөөнийг удирдсан, Ленин биш Сталин ЗХУ-д хувийн үйлдвэрүүдийг устгасан. Лениний үед биш чухамдаа Сталиний үед зөвлөлтийн коммунизм дэлхий дахинд нөлөө хүчин болон хувирч Өрнөдийн ертөнцийг өдөөн хатгаж орон бүрт социализм байгуулах аюул заналыг бий болгосон.

В.Ленин таван жил коммунист засгийн газрыг толгойлохдоо хэдэн сая хүний амь насыг бүрэлгэж дэлхийн аугаа их гүрнийг цусан далайд умбуулж коммунист хөтөлбөрийг нь эсэргүүцсэн улс төрийн сөрөг хүчнээ бөөнөөр хорих шоронгууд байгуулан хорьж тамласан. Сталин үед "архипелаг ГУЛАГ" гэж нэрлэгдсэн бөөнөөр хорих шоронгууд цэцэглэж хувьсгалын эсэргүүчүүд төдийгүй хамтран зүтгэгч, жирийн иргэдээ хэлмэгдүүлсэн олон тооны цэвэрлэгээ, аллага явагдсан юм.

Ленин Сталиний өмнө байж түүнд аймшигт харгислал үйлдэх замыг засаж өгсөн хүн. Тэрчилэн Лениний онолын гэгдэх олон тооны бүтээл туурвил, явуулж байсан бодлого, үлгэр жишээ нь бусад олон орон дахь коммунист хөдөлгөөнд ихээхэн нөлөө үзүүлж байсныг мөн дурдах хэрэгтэй.

ЗХУ-д гэм зэмгүй олон арван сая хүний амь нас сүйдсэн нь Сталиний харгис бодлогын үр дагавар болохоос Лениний анх байгуулсан коммунист тогтолцоотой огт холбогдолгүй гэж үздэг судлаачид байдаг. Энэ бол туйлын их эндүүрэл. Яагаад гэвэл Сталин засгийн эрхэнд гарахаас бүр өмнө Лениний үед ЗХУ-д олон сая хүн аль хэдийнээ алагдсан байсан. Бусад коммунист оронд ч улс орноо сүйтгэж хүний амь насыг бөөнд нь егүүтгэсэн улс төрийн удирдагчид бий. Тухайлбал коммунист Пол Пот Камбож улсыг 1975-1979 онуудад захирахдаа таван сая хүн амынхаа хоёр саяыг нь цааш нь харуулсан.

Ийнхүү В.Лениний анх бий болгосон улс төрийн тогтолцоо коммунист орон бүрт маш их гамшиг тарьж гэм зэмгүй олон сая хүний амь насыг ямар ч үндэслэлгүйгээр хороох үндэс суурь болж байлаа.

В.Ленин засгийн эрх барьж байсан хэдхэн жилийн хугацаандаа сөрөг хүчний эсэргүүцлийг дарахад бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлж байснаараа дэлхийн дийлэнх хэсэгт хүний эрх, эрх чөлөөг хэдэн арван жилийн турш нухчин дарах үйл ажиллагааны эхлэлийг тавьсан гайтай хүн юм.

Марксист-ленинист хөдөлгөөн нь өнөөдөр хаа сайгүй задран унаж түүхийн хог дээр хаягдаж хүн төрөлхтөний түүхэнд ямар ч нөлөө үзүүлж чадахаа больсон нь нэгэнт нотлогдоод байна.

# 85. Суй Вен Ти

(SUI WEN TI)

541-604



Хятад улсыг хэдэн зуун жил тархай бутархай байсных нь дараа шинээр нэгтгэж чадсан хаан бол Суй Вен Ти (жинхэнэ нэр нь Ян Цзян) юм. Түүний нэгтгэсэн Хятад улс хэдэн зуун жилийн турш оршин тогтнож дэлхийн хүчирхэг улсуудын нэг болоод байна. Хятад улсыг нэгтгэсэн үйл явдлын бас нэг чухал улс төрийн үр дүн гэвэл дэлхийн хүн амын тавны нэг Европ, Дундад Дорнод болон бусад олон орнуудын оршин суугчидтай харьцуулбал дайны дажны аюулд бага өртсөн байдал юм.

Илүү дээр үеийн хаан Ши Хуан Ти манай эриний өмнөх III зуунд Хятад улсыг анх удаа нэгтгэжээ. Ши Хуан Тиний байгуулсан Цинь угсаа түүнийг нас барсны дараа бутарч оронд нь гарч ирсэн Хань угсааных тус улсыг манай эриний өмнөх 206 оноос манай эриний 220 он хүртэл захирчээ. Хань угсааг мөхсөний дараа Хятад улс олон тооны жижиг улсууд болон задарчээ.

Янг Чен 541 онд хятадын нэгэн хүчирхэг гэр бүлд төрж 14 настайдаа анхныхаа цэргийн албан тушаалд томилогджээ. Авьяаслаг залуу байсны ачаар хойд хятадын дийлэнх хэсгийг байлдан эзлэхэд Чон угсааны хаандаа ихээхэн тус хүргэж талархлыг нь хүлээж, албан тушаал түргэн ахижээ. 573 онд Янг Чений охин хааны залгамжлагч, ханхүүгийн хатнаар өргөмжлөгджээ. Таван жилийн дараа хаан өөд болж ханхүүгийн туйлбаргүй зангаас болж эрх мэдлийн төлөө хурц тэмцэл өрнөв. Энэ тэмцэлд Янг Чен ялалт байгуулж 581 онд дөчин настайдаа шинэ хаанаар залагдав.

Дан ганц хятадын хойд хэсгийн захирагч байхыг хүссэнгүй, сайтар бэлтгэл хийсний дараа 588 онд Хятадын өмнөд хэсэг рүү дайлаар мордож 589 онд нийт улсын хаан болжээ.

Суй Вен Ти хаан байх хугацаандаа нэгдсэн эзэнт гүрний том нийслэл хот байгуулж нутгийн төв хэсэгт орших Янцзы болон хойд хэсэгт орших Хуан Хэ (Шар мөрөн) хэмээх хоёр том голыг холбох Их Сувгийг барих ажлыг эхлүүлжээ. Түүний хүүгийн үед баригдаж дууссан

энэхүү суваг нь хятад улсын хойд, өмнөд хэсгийг усан замаар эгнэгт холбосон билээ.

Түүний Вен Тиний хийсэн маш чухал шинэчлэлүүдийн нэг нь засгийн газрын түшмэдүүдийг шалгалт авах замаар сонгодог журам тогтоосон явдал юм. Энэ журам нь хятадын засаг захиргааны байгууллагуудыг олон зууны турш улс орны өнцөг булан бүрээс ирсэн, нийгмийн янз бүрийн давхраанаас гаралтай авьяаслаг түшмэдээр хангаж байх эх суурь болжээ. Ийм журам урьд нь Хань угсааны хаадын үед анх бий болсон ч уг угсааг унасны дараа засгийн газрын гол албан тушаалууд өвлөгдөгдөн уламжлагддаг болсон байжээ.

Суй Вен Ти амбан захирагч нарыг төрөлх муждаа ажиллахыг хориглосон "алсаас удирдах зарчим" гэдгийг бас нэвтрүүлжээ. Төрөлх нутагтаа томилогдсон амбан захирагч нарыг илүү олон тойрон хүрээлэгч нартаа болох бололцоог нь хаах тэрчилэн эрх мэдлийн илүү их суурь дэвсгэртэй болох нөхцөл боломж олгохгүй байх зорилгоор дээрх зарчмыг нэвтрүүлсэн нь бодитой үр дүн өгч байжээ.

Олон сая хүн амтай орны хүчирхэг, авьяаслаг удирдагч байсан хэрнээ олонх байлдан дагуулагч нар шиг хатныхаа үгнээс гардаггүй, түүний нөлөөнд байжээ. Төрөлхийн ухаантай түүний хатан нь заримдаа хэт харгис зан ааш гаргадаг байсан ч хаан нөхөртөө хэрэгтэй цагт нь тусалж төрийн эрх мэдлээ баттай хадгалахад нь байнга дэмжлэг үзүүлдэг байжээ.

Суй Вен Ти 604 онд 63 настайдаа өөд болжээ. Гэхдээ орыг залгаж хаан болсон, хатныхан хайртай хүү болох хоёр дахь хүүгийнхээ далд явууллагын золиос болсон гэсэн сэжиг бий.

Шинэ хаан гадаад бодлогод нилээд өөрчлөлт хийсэн нь олны дургүйцлийг хүргэж хятад улс даяар бослого гарч 618 онд алагдсанаар Суй угсааны хаадын үе дуусчээ. Гэхдээ энэ бол хятадын нэгтгэлийн төгсгөл биш байлаа. Суй угсааны дараа Хятадын төрийн эрх мэдлийг Тан угсааных залгаж 618-907 онуудад үйл ажиллагаа явуулахдаа түрүүчийн үеийн хаадын үеийн засгийн газрын үндсэн бүтцийг хадгалж улс орноо нэгдмэл хэвээр байлгаж чадсан юм. Далимд дурдахад Тан угсааны хаадын үед Хятад улсад урлаг өрнүүн хөгжиж байсан тул тус улсын түүхийн алдарт үе гэж тооцогддог ажээ.

Хятадын хаан Суй Вен Тиний түүхэнд эзлэх байр суурийг бүрэн гүйцэд ойлгохын тулд Европ дахь нэрт хаан Их Карлын үйл ажиллагаатай голдуу зүйрлэдэг. Ромын эзэнт улсын мөхсөнөөс хойш гурван зуун жилийн дараа Их Карл Өрнөд Европийн дийлэнх хэсгийг амжилттай нэгтгэж чадсан бол Хань угсааных унаснаас бараг гурван зуун жилийн дараа Суй Вен Ти Хятадыг нэгдмэл улс болгосон. Их Карл Европ тивд хамгийн алдартай хаан байсан бол Суй Вен Ти илүү нөлөө бүхий хаан байжээ.

Яагаад гэвэл нэгдүгээрт Суй Вен Ти Хятадыг бүхэлд нь нэгтгэж чадсан байхад Өрнөд Европийн зарим хэсэг (Англи, Испани, Өмнөд Итали гэх зэрэг) Их Карл хаанд ер бууж өгөөгүй, хоёрдугаарт Суй Вен Тиний үед шинээр нэгдмэл болсон Хятад улс дахин задраагүй бол Их Карлын байгуулсан эзэнт гүрэн төдөлгүй задарч дахин хэзээ ч нэгдээгүй юм, Гуравдугаарт гэвэл нэгдсэн хятад улсын эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн үр дүнд урлаг соёл цэцэглэж байлаа. Гэтэл Өрнөд Европт эхэлсэн "Каролинскийн сэргэн мандалт" Их Карлыг нас барснаас дуусгавар болсон. Дөрөвдүгээрт Суй Вен Тиний нэвтрүүлсэн засгийн газрын түшмэдийг шалгалт авах замаар тодруулдаг журам ихээхэн үр дүнтэй байв. Чухам ийм

учраас Суй Вен Ти хүн төрөлтөний түүхэнд чухал нөлөө үзүүлсэн хүн гэж зүй ёсоор тооцогдох учиртай. Суй Вен Ти шиг Хятад болон Европийн хөгжилд нэгэн зэрэг хүчтэй түлхэц өгсөн хаад маш цөөхөн билээ.

# 86. Васко Да Гамма

(VASCO DA GAMA)

1460-1524 онуудын орчим



Африк тивийг тойрон аялал хийж Европ тивээс Энэтхэг орох далайн замыг нээсэн португалийн далайчны нэрийг Васко да Гама гэнэ.

Португал улс далайчин, ханхүү Генрих (1349-1460)-ийн үеэс Энэтхэг орох дөт замыг эрж хайж байв. 1488 онд Батолемеу Диашийн удирдсан португалийн далайчдын баг Африкийн өмнөд хэсэгт орших Сайн санааны буланг тойрсон ч яагаад ч юм нутаг буцжээ. Португалийн хаан энэ аялалын дараа Энэтхэг орох далайн зам удтал хайж байгаа нь амжилтад хүрэх ойртсоныг ойлгов.

Гэвч янз бүрийн шалтгаан гарсаар Энэтхэг рүү аялал хийх баг 1497 онд л сая аян замд гарчээ. 1460 оны орчим Португалийн Сениш хотод төрсөн, язгууртан Васка да Гама тэрхүү багийн ахмадаар томилогдсон байв.

1497 оны долоодугаар сарын 8-ны өдөр дөрвөн завьтай, араб хэлний орчуулагч бүхий нийт 170 хүнтэй аяны баг Ногоон булангийн арлууд чиглэн замд гарав. Дараа нь Диаш шиг Африкийн эрэг дагуу явсангүй, шууд өмнө зүг рүү Атлантын далайг чиглэжээ. Удтал хөвөн урагшилсаар дорно зүг эргэж Сайн санааны буланг зүглэв. Энэ бол эрэг дагуу явахаас илүү дөт гэхдээ илүү зориг, өндөр ур чадвар шаардсан зам байв. Аялалын баг эргээс алс далайн мандалд 93 хоног хөвсөн нь Х.Колумбын аялалаас хоёр дахин илүү хугацаа байв!

Да Гама Сайн санааны буланг 11 дүгээр сарын 22-ны өдөр тойрч Африк тивийн зүүн эрэг дагуу хойд зүгийг чиглэн хөвөхдөө өнөөгийн Кени улсын нутаг дэвсгэр дээр орших Момбасу, Малинди зэрэг лалын ертөнцийн хэд хэдэн хотод буудаллажээ. Малинди хотоос усан онгоцны замчин хөлсөлж Аравийн тэнгис дамжин Энэтхэг рүү хийсэн

23 хоногийн аялалдаа замчингаар ажиллуулав. Ийнхүү да Гамагийн удирдсан баг Португалиас гарснаас бараг арван сарын дараа 1498 оны тавдугаар сарын 20-ны өдөр Өмнөд

Энэтхэгийн худалдааны төв Калькутт хотод ирэв.

Калькутт хотын захирагч Заморин алсаас ирсэн зочныг анхандаа элэгсэг дотно хүлээн авснаа өгсөн бэлгийг нь бага гэж голж нүүр буруулав. Энэтхэгийн далайгаар хийдэг худалдааны замд ноёрхдог лалын худалдаачдын дайсагнасан явуулгын уршгаар да Гамад хотын захирагч Заморинтой гэрээ байгуулж чадсангүй. Гэвч наймдугаар сард Калькутт хотоос явахдаа хаандаа бэлэг болгохоор хоол амтлагч ачжээ.

Эх нутагтаа буцах аялал нь ирэхээсээ хүнд төвөгтэй болж Аравийн тэнгисийг гатлахдаа бүтэн гурван сар зарцуулж олон хүн нь чийг бам өвчнөөс үхэв. Эх нутагтаа 1499 оны долоодугаар сарын 10-ны өдөр хоёр завиар аялалд анх гарсан хүмүүсийн дөнгөж гуравны нэг нь буюу 55 хүн л эргэн иржээ. Гэвч да Гама, хаан нар хоёр жил үргэлжилсэн аялал үр дүнтэй болсныг ухаарчээ.

Португалийн хаан хагас жилийн дараа Педру Альвариш Кабралаар удирдуулсан хоёр дахь багийг илгээсэн нь зам зуур Бразил улсыг нээж Энэтхэгт хүрч мөн л хоол амтлагч ачаа тээн буцан иржээ. Гэхдээ Кабралын зарим хүмүүс Калькутт хотод алагдсанд хаан уурлаж 1502 онд Васко да Гамад хорин завь захируулж өшөө авах зорилгоор явуулжээ.

Гама зам зуур энэтхэгийн эргийн ойролцоо арабын завийг булаан авч эмэгтэйчүүд, хүүхэд оролцсон нийт зуу гаруй хүнийг завьтай нь шатаан далайд живүүлжээ. Васко да Гама Калькутта хотод ирмэгц усан зогсоолоос арабын бүх завийг холдуулахыг хотын захирагч Замориноос шаардаж түүнийг татгалзахад нь 38 энэтхэгийн загасчныг баривчилж цавчин алж дараа нь усан зогсоол руу гал нээв. Хотын захирагч Заморин уур нь шатсан ч Гамагийн шаардлагыг даруй биелүүлжээ. Буцах замдаа Дорнод Африкт хэд хэдэн нутаг дэвсгэр эзлэж Португалийн эзэмшил нутаг болгосон байна.

Васко да Гамагийн зоримог үйлдлийг Португалийн хаан өндөр үнэлж хүндтэй хэргэм зэргээр урамшуулж хэд хэдэн эдлэн газраар шагнажээ. Шинэ хаан 1524 онд амбан захирагчаар томилоход нь л Гама дахин Энэтхэгт ирсэн боловч өвчин тусаж 12 дугаар сард өөд болжээ. Хожим нь түүний шарилыг Лиссабон хотод шилжүүлэн оршуулжээ. Гама эхнэртэй, долоон хүүхэдтэй байжээ.

Васко да Гама нь Европ тивээс Энэтхэг, Алс дорнод хүрэх далайн замыг нээсэн их гавьяатай хүн билээ. Соёлт ертөнцийн хаяа хязгаарт орших ядуу Португал улс дорно зүг хүрдэг худалдааны замыг хянах болсноор удсангүй Европийн баян орнуудын нэг болон үсрэнгүй дэвшил хийсэн билээ. Португал нь Бразил, Африкийн өрнөд хэсэг дэх эзэмшил нутгаа өргөжүүлж Энэтхэгийн далайг тойрсон колонийн гүрэн байгуулж Энэтхэг, Индонези, Мадагас-карын арал, Африкийн дорнод эргийг мэдэлдээ авав. Эдгээрээс зарим эзэмшил нутаг нь хорьдугаар зууны дунд үе хүртэл Португалийн мэдэлд байсан юм.

Васко да Гама Энэтхэг хүрэх худалдааны шинэ зам нээснээр Энэтхэгийн далайгаар дайрдаг худалдааны бүх замыг хянадаг байсан лалын худалдаачдад том цохилт өгчээ. Африк тивийг тойрч Энэтхэг хүрдэг Португалийн зам нь дөт байдаг тул Энэтхэгээс Европ хүрдэг өндөр үнэтэй хуурай замын ач холбогдол буурснаар дорно зүгийн худалдааг урьд нь хянаж байсан түрэг, италийн хотуудын хөгжилт дорджээ. Тэрчилэн Алс Дорнодоос Европт авчирч



арилжаалдаг бүтээгдэхүүний үнэ өртөг хямдарлаа.

Европ тивээс алслагдмал оршдог Энэтхэг улс 1498 оноос өмнө бөглүү хязгаар нутаг байж баруун-хойд хэсгээр нь л хил залгасан улсуудтай л гадаад харилцааны бодлого явуулдаг байсан бол Васко да Гамагийн аялалын үр дүнд Европийн соёл иргэншилтэй далайн замаар шууд холбогдох болжээ. Европчуудын Энэтхэг дэх нөлөө эрх мэдэл өссөөр XIX зууны хоёрдугаар хагас гэхэд бүхэлдээ Английн эзэмшил нутаг болсон юм. Индонези улс мөн европчуудын эрхшээлд орж хорьдугаар зууны дунд үед дөнгөж тусгаар тогтнолоо олсон билээ.

Васко да Гамаг харьцуулж болох ганц хүн нь Х.Колумб юм. Түүний аялал туулсан зам, хугацаагаараа Х.Колумбаас гурав дахин их байсан юм. Х.Колумбын аялал Шинэ тивийн соёл иргэншилд их түлхэц өгсөн бол да Гамагийн аялалын үр дүнд Энэтхэг, Индонезийн соёл иргэншилд өөрчлөлт орсон билээ.

# 87. Их Кир хаан

(CYRUS THE GREAT)

Манай эриний өтнөх 590- 529 он



Их Кир бол Персийн эзэнт гүрнийг байгуулжээ. Ираны баруун-өмнөд хэсгийн удирдагчийн цэргийн даргын хувьд үйл ажиллагаагаа эхэлсэн Кир гурван удаа гайхамшигт ялалт байгуулж Миди, Лиди, Вавилоны эзэнт улсуудыг дараалан эзэлж эртний Дундад Дорнын ихэнх хэсгийг нэгдмэл улс болгон хувиргаж Энэтхэгээс Газрын дундад тэнгис хүртэлх өргөн уудам нутаг дэвсгэрийг захирах болжээ.

Гэхдээ Эдип хааны тухай грекийн домгийг санагдуулсан Кирийн тухай домог бий. Уг домог бол Мидийн эзэнт гүрний хаан ач хүүтэй болохоосоо өмнө төрсөн ач нь өөрийг нь хорлоно гэсэн зүүд харж сэтгэл ихэд шаналжээ. Тэгээд ач хүүтэй болмогц түүнийг цаазлахыг шадар түшмэлдээ

Кир манай эриний өмнөх 590 онд тэр үед Мидийн эзэнт гүрний муж байсан, өнөөгийн Иран улсын баруун-өмнөд хэсэгт орших Персис (одоогийн Фарс муж) мужид төржээ. Мидийн эзэнт гүрний хааны томилсон амбан захирагч болох цэргийн даргын угсаанаас гаралтай байжээ.

даалгатал цаадахь нь бяцхан хүүд гар хүрэхээс цэрвэж малчин залууд цааш нь харуулахыг даалгав. Малчин залуу хүүг өрөвдөж эхнэртэйгээ цуг өсгөжээ. Хүү том болоод өвөө-гөө хаан ширээнээс унагажээ.

Ер нь Кирийн хүүхэд байх үеийн тухай мэдээлэл хомс, 558 оны орчим Персийн хаан, эцэг нэгдүгээр Камбусын оронд өргөмжлөгдөж Мидийн эзэнт гүрний хааны харьяат болжээ. 553 оны үед хааныхаа эсрэг бослого гаргаж гурван жилийн дайтсаны эцэст сая дийлжээ.

Миди, Перс нь хоорондоо дотно харилцаатай, гарал хэлний хувьд адил улсууд байв. Кир хаан болоод Мидийн эзэнт гүрний дийлэнх хууль тогтоомж, засаг захиргааны бүтцийг хэвээр үлдээснээс үзэхэд энэ бол гадаадын түрэмгийлэл биш угсаа солигдсон явдал бололтой.

Их Кир хаан гадаадад түрэмгийлэл үйлдэхээр санаархаж Бага Азид орших баянаараа цуутай Крез хаан захирдаг Лидийн эзэнт гүрэн рүү довтолж манай эриний өмнөх 546 онд эзлэжээ. Дараа нь дорно зүгт дайтаж Дорнод Ираныг эрхшээлдээ оруулж манай эриний 540 он гэхэд Персийн эзэнт гүрний нутаг дэвсгэрийг Энэтхэгийн Инд мөрнөөс Төв Ази дахь Сырдарь хүртэл өргөжүүлжээ.

Үүний дараа эртний Дундад Дорнодын үржил шимтэй нутгийг эзэмшдэг, Месопотами төвтэй Вавилоны эзэнт гүрэнг дайлаар мордов. Тус улсын хаан Набонид ард түмнийхээ дургүйцлийг хүргэдэг байсан тул Кирийн цэргийг ирэхэд арми нь буун өгч манай эриний өмнөх 539 онд Вавилоны эзэнт улс нурав. Тус эзэнт гүрний бүрэлдэхүүнд багтаж байсан Сири, Палестин улсууд мөн Кирийн мэдэлд иржээ.

Кир дараагийн хэдэн жилийг эрх мэдлээ чангатгах, улс орныхоо зохион байгуулалтыг өөрчлөхөд зориулаад Каспийн тэнгисийн зүүн эрэг дагуу Төв Азид суудаг нүүдэлчин омгуудыг дайтахаар зүүн хойд зүг хөдлөв. Анхны тулалдаануудад персүүд ялж байсан ч 529 онд болсон хоёр дахь байлдаанд ялагдаж дэлхийн хамгийн том эзэнт гүрний хаан Кир алагджээ.

Түүний оронд хаанаар хүү хоёрдугаар Камбис нь өргөмжлөгдөж цэргээ удирдан байлдаж нүүдэлчдийг дийлж төрсөн эцгийхээ шарилыг олж Персийн эртний нийслэл Пасаргада хотод оршуулжээ. Дараа нь Египетийг эзлэхээр хөлгийн жолоог залж эртний Дундад Дорныг нэгтгэхээр шийджээ.

Кир хаан бол цэргийн гарамгай жанжин байсан ч зөөлөн аядуу зан ааштай, орон нутгийн шашин шүтлэг, зан заншлыг хүндэтгэдэг, харгислал үйлдэхийг таашаадаггүй, тухайн цаг үедээ хүмүүнлэг байлдан дагуулагч гэж тооцогдож байв. Тухайлбал вавилончууд 586 онд Иудей улсыг эзлэнгүүт олон мянган хүнийг алж хядаж тэднийг бослого гаргахаас эмээж хэдэн мянган иргэнийг эх нутгаас нь хөөн явуулж байв. Гэтэл Кир хаан тавин жилийн хойно Вавилоныг эзлэсний дараа бүх еврейчүүдэд төрсөн нутагтаа буцан ирэхийг зөвшөөрч байжээ. Чухамдаа Кирийн ачаар еврейн ард түмэн манай эриний өмнөх тавдугаар зуунд бүрэн сөнөх аюулаас аврагдсан байна.

Грекүүд Персийн эзэнт гүрнийг тусгаар тогтнолдоо гол заналхийлэгч гэж дургүйцэн үздэг атлаа Кир хааныг гайхамшигтай удирдагч гэж хүндэтгэдэг байжээ.

Их Кирийн үйл ажиллагаа ихээхэн үр дүнтэй байсныг нь түүнийг нас барсны дараа ч эзэнт гүрэн нь өргөжсөөр байсан явдал гэрчилнэ. Түүний эзэнт гүрний нутаг дэвсгэр дээр оршин сууж байсан ард түмнүүд тус улсыг хоёр зуун жилийн дараа Александр Македонский эзлэх хүртэл амар жимэр, хоорондоо эвтэй найртай, элбэг дэлбэг аж төрж байжээ.

Александр Македонскийг өөд болсны дараа түүний жанжнуудын нэг болох нэгдүгээр Селевк нь Сири, Месопотами, Иранд хяналтаа тогтоож Селевкидын эзэнт гүрнийг байгуулжээ. Кирийн үндэслэсэн Ахеменидийн угсааны үр сад гэж өөрийгөө өргөмжилсөн нэгдүгээр Арсакс манай эриний өмнөх III зууны дунд үед Селевкидын эсрэг бослого Иранд гаргаж Парфяны эзэнт гүрнийг байгуулжээ. Манай эриний өмнөх 224 онд Арсаксидын угсааг Сасадины угсаа залгаж бараг дөрвөн зуу шахам жил оршин тогтножээ.

Их Кир хааны үйл ажиллагаа дэлхийн түүхэнд маш чухал эргэлтийн үеүүдийн нэг болсон юм. Соёл иргэншил манай эринээс гурван мянган жилийн тэртээ анх Шумерт үүсэж шумерууд тэднийг залгамжилсан семитийн ард түмнүүд 25 зууны турш соёл иргэншлийг түгээж байжээ. Энэ бүх хугацаанд Месопотами нь Египетийн адил дэлхийн хамгийн баян, соёлын хөгжилтэй нутаг байв. Энэхүү түүхийн чухал үеийн төгсгөлийг чухамдаа Их Кир хаан хийсэн юм. Тэр үеэс хойш Месопотами ч Египет ч улс төр, соёлын ач холбогдлоороо ч соёл иргэншлийн төвүүд байхаа больсон юм.

Үржил шимтэй газар нутгийг эзэмшдэг семитийн ард түмнүүд тусгаар тогтнолоо алдаж олон зуун жил болсон юм. Персүүдийн дараа македончууд, грекүүд дараа нь парфянчууд, ромчууд, сасанидууд ирж ҮШ зуунд лалын шашинтнуудад эзлэгдэх хүртэл, Их Кирийн байлдан дагуулалтаас бараг арван хоёр зууны хожим семитийн ард түмнүүд газар нутагтаа эзэн болж чадаагүй юм.

Их Кир нь олон байлдаанд ялан дийлж том газар нутаг эзэмшиж байснаараа зөвхөн аугаа биш ээ. Түүний үндэслэсэн эзэнт гүрэн эртний ертөнцийн улс төрийн бүтцийг үндсээр нь өөрчилж байлаа. Персийн эзэнт гүрэн нь ром, англи, хятад шиг дэлхийн түүхэнд ихээхэн түлхэц өгч чадаагүй юм. Гэхдээ манай эриний өмнөх 620 онд нийт эртний ертөнц ганцхан зууны хугацаанд Ираны баруун өмнөд хэсэгт орших нүүдэлчин омгийн эрхшээлд орно гэж зүүдэлж ч бай-гаагүй юм. Иймд Их Кир хаан бол түүхийн явцыг үнэхээр өөрчилсөн хэдхэн суут хүний нэг яах аргагүй мөн.

# 88. Оросын нэгдүгээр Петр хаан

(PETER THE GREAT)

(1672-1725)



Аугаа их нэгдүгээр Петр хааны явуулсан европжуулах бодлого нь хоцрогдсон Орос улсыг дэлхийн хүчирхэг гүрэн болгон хувирахад гол хүчин зүйл болсон билээ.

Петр нь 1672 онд Алексей Михайлович хаан түүний хоёрдахь хатан Наталья Нарышкина нарын цорын ганц хүү болон Москвад мэндэлжээ. Дөрвөн нас хүрээгүй байхад нь хаан эцэг нь нас баржээ. Эцэг нь анхны хатнаасаа 13 хүүхэдтэй байсан тул хааны титмийн төлөө удтал үргэлжилсэн, ширүүн тэмцэл өрнөж залуу Петр алагдах аюул заналхийлж байв. Хатан хаанаар өргөмжлөгдсөн эгч Софьяг 1689 онд хааны ширээнээс зайлуулагдсанаас хойш Петр хаанд учирч байсан аюул түр намджээ.

1689 онд Орос улс нь Европоос бүх салбарт хэдэн зуун жилээр хоцорсон ядуу орон байв. Цөөхөн хоттой, хүний эрхийг нь хөсөрдүүлдэг хамжлагын тариачдын тоо байнга өссөөр байлаа. Европт өрнөсөн Сэргэн мандалт, Шинэчлэл оросыг дайрсангүй, хөгжлийн хувьд дундад зууныхаараа байлаа. Язгууртнууд нь бүдүүлэг, уран зохиол байсангүй, математик болон бусад шинжлэх ухааныг ойшоох нь бүү хэл бүр үзэн ядна.

1697-1698 онуудад Петр 250 орчим хүн дагуулан Петр Михайлов гэсэн нууц нэртэйгээр баруун европоор аялал хийжээ. Аялалын үед Петр хаан голландын дорнод-энэтхэгийн компани, английн хааны усан флотын засварын газарт мужаанаар ажиллаж Прусст зэр зэвсгийн хэрэг судлав. Үйлдвэр, сургууль, музей, агуулах тэр ч бүү хэл английн парламентын хуралдааныг хүртэл сонирхов.

1698 онд эх орондоо буцан ирж Орос улсыг шинэчлэх, европжуулахад чиглэсэн гүн гүнзгий өөрчлөлтийг эхлэв. Өрнөдийн технологи, техникийг нэвтрүүлэх ажлыг хурдасгахын тулд эх орондоо европийн мэргэжилтнүүдийг бөөнөөр нь урьж олон орос залуучуудыг европийн орнуудад сургалтад илгээжээ. Түүнийг хаан байх хугацаанд орос улсын аж үйлдвэр,

худалдааны хөгжил түргэсч шинэ хотууд бий болж хөрөнгөтний тоо, нөлөө нэмэгджээ.

Оросод тэнгисийн цэргийн флот байгуулж армия барууны маягаар шинэчилж дүрэмт хувцастай болгож орчин үеийн зэвсгээр хангаж байлдааны бэлтгэлийн барууны аргыг нэвтрүүлжээ. Иргэний удирдлагын албанд шинэтгэл хийж түшмэдийг гарал үүслээр нь биш ажил хэрэгч чадвараар нь дэвшүүлдэг журам тогтоов.

Нийгмийн салбарт ч европжуулах явцыг хурдасгав. Бүх эрчүүдэд эрүүний сахалтай байхыг хориглож тамхи татах, кофе ууж дасах, шүүгчдэд барууны маягаар хувцаслаж байх зарлиг буулгав. Түүний үйл ажиллагаа хурц эсэргүүцэлтэй тулгарч байсан ч төдсөнгүй үр дүн нь гарч оросын язгууртнууд өрнөдийн биеэ авч явах соёлыг эзэмшжээ.

Петр хаан оросын үнэн алдартны шашныг хоцрогдсон, харгис гэж үзэж зарим өөрчлөлт хийж хатуу хяналт тогтоожээ. Шашнаас үл хамаарах дунд сургуулиуд байгуулж шинжлэх ухааны хөгжлийг сайшааж юлианы он тооллыг хэрэглэдэг болж оросын цагаан толгойг шинэчилсэн. Оросод анх удаа сонин хэвлэгдэж эхлэв.

Хаан дотоодын эрс шинэтгэлээс гадна ирээдүйдээ нааштай үр дүн авчирсан гадаад бодлого явуулж байлаа. Түрэг улстай дайтаж 1696 онд Азовын усан буудлыг эзэлж Орос улсыг Хар тэнгис рүү гарцтай болголоо. Гэвч түрэгүүд сайтар бэлтгэлтэйгээр дайрч 1711 онд Азовын усан боомтыг буцаан авсан билээ. Мөн Шведийн эсрэг дайн өдөөж анхандаа ялагдаж байсан ч эцэст нь дийлжээ. Тухайн үедээ европийн цэргийн тэргүүлэх улс байсан Шведийн эсрэг Оросын хийсэн дайнд Дани, Саксон хожим нь Польш нэгдсэн. 1700 онд Нарв хотын ойролцоо болсон тулалдаанд оросын цэрэг томоохон ялагдал хүлээсэн. Тэр ялалтын дараа Шведийн хаан бусад дайснуудтай тулалдаж байх хооронд Петр хаан оросын армид шинэчлэл хийж амжжээ. Орос, Шведийн хоорондын дайн дахин сэргэж 1709 онд Полтавын дэргэдэх тулалдаанд оросын арми ялалт байгуулсан билээ.

Дайны дараа нутаг дэвсгэрээ Эстони, Латвийн тэрчилэн Финляндын дийлэнх хэсгээр өргөжүүлжээ. Эзлэсэн нутаг дэвсгэр нь хэмжээгээрээ томгүй ч Орос улс Балтийн тэнгис рүү гарц гаргаж Европ тив рүү цонхтой болжээ. Шведүүдээс булаан авсан нутаг дээр Нева мөрний эрэг дээр Петр хаан Санкт-Петербург хотыг байгуулж улсынхаа нийслэлийг Москвагаас тэнд нүүлгэн шилжүүлжээ. Энэ хот хожим нь Оросыг өрнөд европтой холбодог гол цэг болсон билээ.

Дотоодын шинэтгэл дайн нь асар их зардал шаардаж тиймд татварыг тогтмол нэмэгдүүлж байлаа. Үүнд дургүйцэн бослого хуйвалдаан цөөнгүй гарч байсан ч Петр хаан тухай бүр хэрцгийгээр нухчин дарж байжээ. Петр хаан цаг үедээ олон дайсантай байсан ч оросын хаадаас хамгийн аугаа нь болохыг оросын болон өрнөдийн түүхчид санал нэгтэй хүлээн зөвшөөрдөг.

Петр хаан өндөр нуруутай, бяр тэнхээтэй, сэргэлэн цовоо, дайчин давшингуй, сэтгэлээрээ байнга залуу явдаг, их хөгжилтэй эр байжээ. Улс төрийн бодлого, цэргийн хэргээс гадна мужаан, хэвлэх ажил, усан онгоц барих ажлыг сонирхдог байв.

Хоёр удаа гэрлэсэн, анхны хатан Евдокиятэйгээ 17 настайдаа гэрлэж долоо хоног л хамт

байгаад 26 нас хүрэх үедээ түүнийг хөөж сүмд суулгажээ. 1712 онд түүнээс гэрлэлтээ цуцлуулж Балтийн орчим нутгаас гаралтай Екатерина хэмээх бүсгүйг хатнаараа өргөмжилжээ. Анхны хатнаасаа Алексей хэмээх хүүтэй байсныгаа хуйвалдаан сэдэж байна гэж 1718 онд баривчилж шоронд хорьсон нь нас баржээ. Петр хаан 1725 онд 52 настайдаа Санкт-Петербург хотод нас баржээ. Бэлэвсэн хатан Екатерина нь түүний оронд хаан ширээнд заларчээ.

Хорьдугаар зууны төгсгөл дээр, дэлхийн олон орны удирдагчид өрнөдөөс суралцах хэрэгтэй, ялангуяа шинжлэх ухаан, техникийн аргыг эзэмших нь ард түмнүүдийнх нь хувьд маш чухал болохыг ойлгожээ. ХҮШ зууны үед үүнийг тэр болгон ойлгодоггүй байлаа. Гэтэл өнөөгөөс гурван зуун жилийн тэртээ оросын нэгдүгээр Петр хаан улс орноо шинэчлэх, европжуулахын чухлыг ухаарч хоцрогдсон эх орноо урагшуулж чадсан билээ. Гэвч өрнөд европ ХҮШ, ХІХ зуунуудад түргэн хөгжсөн учир орос улс түүнийг гүйцэн түрүүлж чадаагүй юм.

Петр бол зөнгөөрөө үйл ажиллагаа явуулдаг хаан биш чухамдаа цаг үеэсээ түрүүлсэн, нийгмийг бүхэлд нь шинэчлэгч хүн байжээ. Түүний алсыг харсан бодлого, үйл ажиллагаа түүхийн явцыг өөрчилж гарцаагүй урагшлан дэвжих замд нь оруулсан билээ.

# 89. Мао Зедун

(MAO TSE-TUNG)

1893-1976



Мао Зедун Хятадын коммунист намыг толгойлж дэлхийн том гүрэнд гарсан гүн гүнзгий өөрчлөлтийг 27 жилийн турш удирдсан билээ.

1893 онд Хунань мужийн Шаошан тосгонд чинээлэг тариачны гэр бүлд төржээ. Түүнийг 1911 онд 18 настай оюутан байх үед Хятад улсыг ХҮП зууны үеэс захирч байсан Цин угсааныхны эсрэг бослого дэгдэж Засгийн газар нь огцорч Хятад орон Бүгд найрамдах улс болжээ. Гэвч хувьсгалын удирдагчид тогтвортой, нэгдсэн засгийн газар байгуулж чадаагүйгээс 1949 он хүртэл эмх замбараагүй байдал, дайн тасралтгүй үргэлжилжээ.

Залуудаа зүүний үзлийг баримталдаг байсан ч 1920 онд марсист болж 1921 онд хятадын коммунист намыг анх үндэслэсэн 12 хүний нэг байжээ. Гэвч эрх мэдлийн оргилд хүрэх түүний замнал урт удаан хугацаанд үргэлжилж 1935 онд сая нэг намын удирдагч болжээ.

Тэр үед ХКН төрийн эрх мэдлийн төлөө тэмцэлд амжилттай оролцож 1927, 1934 онуудад хэд хэдэн хүчтэй цохилт амссан ч тухай бүр сэхэж байжээ. 1935 оноос хойш ХКН Мао Зедуны удирдлага дор улам бэхэжсээр 1947 он гэхэд Чан Кайшигээр удирдуулсан үндэстний үзэлтнүүдийн намын эсрэг ил дайтах нэр хүнд, хүчтэй болсон байв. Тэд 1949 онд ялалт байгуулж эх орон даяараа хяналт тогтоож чадсан байна.

Мао Зедун намын даргын хувьд удирдах болсон хятад улс нь тэр үед гучин найман жил бараг тасралтгүй үргэлжилсэн дайнд сүйдсэн, хэдэн зуун сая бичиг үсэггүй тариачдын нэн ядуу, хоцрогдсон орон байлаа. Мао ч энэ үед 56 настай, үйл ажиллагааных нь оргил үе өнгөрсөн мэт сэтгэгдэл төрж байлаа.

Үнэндээ бол Мао Зедуны асар их үйл ажиллагаа дөнгөж эхэлж байсан ба түүнийг 1976 онд нас барах үед түүний явуулсан бодлогын үр дүнд хятад орны нүүр царай танигдахгүй болтлоо



өөрчлөгдсөн байлаа. Тэрхүү бодлогын гол агуулга нь улс орны шинэчлэл байв. Хятад оронд түргэн хугацаанд аж үйлдвэржүүлэх бодлогыг ард түмний эрүүл мэндийг хамгаалах, боловсролын тогтолцоог шинэ шатанд гаргах чиглэлтэй нэгэн зэрэг хослуулан хэрэгжүүлсэн байв.

Түүний удирдсан засгийн газрын хоёр дахь том ололт нь тус орны эдийн засгийг капитализмаас социалист хэвшилд шилжүүлсэн явдал байлаа. Маог нас барснаас хэдхэн жилийн дараа түүний залгамжлагч Дэн Сяопин хятадын эдийн засагт чөлөөт зах зээлийн янз бүрийн үзүүлэлтүүдийг нэвтрүүлэх болсон юм. Энэ үйл явц цаашид хэр зэрэг өрнөх нь бүү мэд, ямартаа ч гэсэн Хятад улс хорин жилийн хугацаанд социализмаас ангижирч дахин зах зээлийн улс болж байна. Иймд, Маогийн явуулж байсан эдийн засгийн бодлого урьдынх шигээ чухал биш болоод байна.

Мао Зедун хотууд дахь ажилчид коммунист намыг дэмжих хүчтэй түшиг тулгуур гэж бат итгэж байсан нь К.Марксын сургаалтай яг таг нийцэж байлаа. Гэвч 1952 онд Хятад улсад намыг дэмжих гол хүч нь тариачид юм гэсэн дүгнэлт хийж үндэстний үзэлтнүүдийн эсрэг хийж байсан тэмцлийн явцдаа хөдөө нутгийнханд ямагт тулгуурладаг байжээ. Тухайлбал Сталин Оросод аж үйлдвэржүүлэлтийг голлодог байсан бол Мао хятадад хөдөө аж ахуйд ихээхэн анхаарал тавьдаг байжээ. Гэвч Маог улсын удирдагч байх хугацаанд хятад аж үйлдвэрийн үйлдвэрлэл мэдэгдэхүйц нэмэгдсэн байна.

Улс төрийн үзэл бодлын талаас нь авч үзвэл Мао эх орондоо дарангуйллын дэглэм тогтоож багаар тооцоход хорин сая тариачин, ихээр бодоход гучин сая хүний амь насыг хөнөөсөн хүн юм. Энэ тоон үзүүлэлтээрээ Мао дэлхийн түүхэн дэх хамгийн цуст засаглалыг тогтоосон хүн ба түүнийг гагцхүү Гитлер, Сталин, Чингис хаан гуравтай л зүйрлэж болно. Түүнийг өөд болсны дараа хятад улсад "дулаарал" эхэлсэн ч Хятад улсыг ардчиллын замд чиглүүлэх гэсэн оролдлогыг тухайлбал 1989 оны зургаадугаар сард Тяньаньмыний талбайд хийсэн оюутнуудын жагсаалыг хүчээр тараах гэх зэргээр Дэн Сяопин шийдвэрлэг нухчин дарж байлаа.

Гэхдээ коммунист засгийн газрын бодлогыг дан ганц Мао тодорхойлж байгаагүй, тэрбээр Сталин ЗХУ-д тогтоосон шиг ганц хүний дарангуйллын дэглэм тогтоох гэж ердөө ч чармайж байгаагүй ч 1949-1976 онуудад хятадын засгийн газрын хамгийн гол зүтгэлтэн байсан юм.

Тавиад оны эхээр хийсэн "Урагш том алхам хийх" тухай төслийг дангаар санаачлан зохион байгуулж хэрэгжүүлсэн юм. Хөдөөгийн жижиг коммуунуудын чиглэлд хийсэн энэ төсөл нь бүтэлгүйтсэн гэж олонхи судлаачид үздэг. Хятадын зарим удирдагчдын эсэргүүцлийг эс тоон Маогийн дэмжин хэрэгжүүлсэн бас нэг төсөл нь жараад оны сүүлч үеийн "Пролетарийн аугаа их соёлын хувьсгал" болсон билээ. Энэ хувьсгал нь үнэн хэрэгтээ нэг талаас Мао түүний талынхан, нөгөө талаас коммунист хүнд суртлын хооронд болсон иргэний дайн байсан юм.

Мао Зедун жар орчим настай байхдаа соёлын хувьсгалыг эхлүүлж далаад настай байхдаа дуусгасан бол, наян нас дөхсөн үедээ улс төрд хийсэн эмгэнэлт эргэлтийнхээ дараа АНУ-тай харилцаагаа сайжруулсан байна.

Хэдхэн жилийн өмнө хятад дахь коммунист тогтолцоо бат бэх мэт санагдаж байсан. Гэтэл одоо социализмаас ухарч Маогийн тогтоосон дарангуйллын улс төрийн тогтолцоо өнөөдөр хэвээр байгаа ч улам хэврэг болсоор байна.

Мао амьд сэрүүн байхдаа хаан Шихуанди шиг хятадын түүхэн дэх чухал зүтгэлтэн гэж тооцогдохоор байв. Хоёулаа эх орондоо хувьсгалт шинэчлэл хийсэн улс төрийн нэрт зүтгэлтнүүд юм. Гэхдээ Шихуандигийн шинэчлэлийн нөлөө бараг хорин хоёр зуун дамжсан бол Маогийн нөлөө багасч байна. Хорьдугаар зууны хувьд Маог Ленинтэй харьцуулж болно. Хоёулаа эх орондоо марксизмыг нэвтрүүлсэн, гэхдээ хятадын хүн ам ЗХУ-ынхаас гурав дахин илүү байсан. Ленин бол Маогаас түрүүнд эх орондоо коммунист дэглэм тогтоож түүнд үлгэр жишээ үзүүлж сэтгэлгээнд нь нөлөөлсөн юм.

# 90. Фрэнсис Бэкон

(FRANCIS BACON)

1561-1626



Фрэнсис Бэкон нь олон жилийн турш Английн тэргүүлэх улс төрч байсан төдийгүй гүн ухаантныхаа хувьд маш их бүтээл туурвисан хүн юм. Шинжлэх ухаан нь шинэ эриний тугч, шинжлэх ухаан, техник нь дэлхий ертөнцийг үндсээр нь өөрчилж чадна гэдгийг ойлгосон анхны аугаа их гүн ухаантан, шинжлэх ухааны судалгааг идэвхтэй хамгаалагч байсан юм.

1561 онд нэгдүгээр Элизавета хатан хааны Засгийн газарт өндөр албан тушаал хашдаг түшмэлийн гэр бүлд төрж 12 настайдаа Кембрижийн их сургуулийн Гэгээн Троицийн коллежид орж гурван жилийн дараа эрдмийн зэрэг авалгүй орхижээ. 16 настайгаасаа Париж дахь элчин сайдын яаманд ажиллаж эхэлсэн ба 18 настай байхад нь эцэг нь гэнэт нас барахдаа өчүүхэн хөрөнгө үлдээжээ. Дараа нь Бэкон хууль зүй судалж 21 настайдаа өмгөөлөгч болжээ.

Энэ үеэс улс төрийн үйл ажиллагаа эхэлж 23 настайдаа Нийтийн танхимд депутатаар сонгогджээ. Нэр төртэй хамаатан садангууд, анд найз нартай ч авьяаслаг залуу байсан болохоор нь нэгдүгээр Элизавета хатан хаан түүнийг өндөр албанд томилж зүрхлэхгүй байв. Хатан хаанаас парламентад оруулсан татварын тухай хуулийн төслийг нь Бэкон зоригтой эсэргүүцсэн нь түүнийг нүд үзүүрлэх бас нэг шалтгаан нь байв. Бие дааж дураараа байх дуртай учраас байнга банкнаас зээл авдаг, нэгэн удаа өрөө төлөөгүй учир баривчлагдаж байжээ.

Тухайн үед нэрд гарсан, улс төрийн их сонирхол бүхий гүн Эссекскийн анд, зөвлөх болж цаадахь нь ч дотнын анд, гол дэмжигч нь болжээ. Гэтэл гүн улс төрийн их сонирхолдоо хөтлөгдөн Элизавета хатан хааны эсрэг төрийн эргэлт хийхээр зориг шулуудаж андыгаа хамтран тэмцэхийг хүсэхэд Бэкон татгалзаж хатан хаанд үнэнч гэдгээ илэрхийлэв. Гүн төрийн эргэлт хийх гэсэн нь бүтэлгүйтэж цаазлуулав. Бэкон урвагчдыг илрүүлэн шүүхийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоны дараа хүмүүсийн түүнд ханддах хандлага эрс өөрчлөгджээ.

Хатан хаан 1603 онд өөд болж түүний оронд хааны ширээнд заларсан нэгдүгээр Яковын зөвлөх болов. Хаан түүний зөвлөмжийг байнга авдаггүй ч өндөр үнэлж байсны ачаар Бэкон засгийн газарт бат суурьтай болов. 1607 онд ерөнхий өмгөөлөгч, 1613 онд ерөнхий прокурор, 1618 онд Английн Лорд-канцлер буюу Дээд шүүхийн даргаар томилогджээ. Мөн онд гүн, 1621 онд вангийн зэрэг хүртэв.

Гэвч удсангүй аюулд өртөв. Шүүгч хүн болохоор мэргэжил нэгт нөхдийнхөө адилаар үйлчлүүлсэн хүмүүсээс "гарын бэлэг" авдаг байв. Парламент дахь түүний улс төрийн дайснууд түүнийг эрх мэдлээс зайлуулах бололцоо гарсныг даруй ашиглав. Бэкон хууль зөрчснөө хүлээж Лондон хотын алдарт Тауэрийн шоронд хоригдох, ихээхэн мөнгөн төлөх шийтгэл хүлээв. Түүнд хүнтэй харьцах ямар нэгэн албан тушаал хашихийг хоригложээ. Хаан төдөлгүй мөнгөн төлбөрийг нь барагдуулж шоронгоос сулласан ч Бэкон улс төрийн тавцангаас эгнэгт зайлуулагдсан байв.

Хээл хахууль авсан нь илэрч итгэл алдсан өндөр тушаалын улс төрч дэлхийн түүхэнд маш ховорхон. Хээл хахууль авсан нь илрэхэд, дийлэнх хүмүүс биеэ өмөөрч буруугүй болохоо нотлохыг оролддог. Гэтэл Бэкон тэгсэнгүй "Англид сүүлийн тавин жил би хамгийн шудрага шүүгч байсан, намайг парламентаар шүүсэн нь сүүлийн хоёр зуун жилийн хугацаанд болсон хамгийн шудрага үйл ажиллагаа болсон." гэж мэдэгджээ.

Бэконий гүн ухааны хамгийн анхны чухал бүтээл нь болох "Өгүүлэл" нь 1597 онд гарснаас хойш бусад адил нэртэй туурвилууд нь дараалан хэвлэгдсэн байна. Түүний "Өгүүлүүд" бахархам сайхан хэллэг, гярхай ажиглалт, гүнзгий агуулгаараа уншигчдын анхаарлыг гойд татаж байлаа. Түүний бичлэгийн өвөрмөц хэллэгийг дараах ишлэлүүдээс ойлгож болно:

"Залуучууд бодож сэтгэхээсээ илүү мөрөөддөг, өмөөрөн хамгаалахаасаа илүү шийтгэх сонирхолтой, тогтсон бизнесийг эрхлэхээсээ илүү шинэ төсөл бодож эрэлхийлнэ. Нас тогтсон хүмүүс дэндүү их зөрж татгалздаг, хэт удаан зөвлөлддөг, эрсдэл хийхээс эмээдэг, иймд аль аль насны хүмүүсийн давуу талуудыг нэгтгэвэл ажил үйлс мөн ч их бүтэмжтэй болно доо"

"Залуучууд, насны тухай"

"Тэр эр эхнэр, хүүхдүүдээ хувь заяаныхаа золиос болгосон нь гутамшигтай."

"Гэрлэлтийн тухай"

Шинжлэх ухааны гүн ухааны асуудлаар олон чухал бүтээл туурвижээ. Үүнд зургаан хэсэг бүхий "Их шинэчлэл" нэртэй маш том бүтээлийг нэрлэж болно. Нэгдүгээр хэсэгт нь хүний танин мэдэхүйн орчин үеийн түвшин хоёрдугаар хэсэгт нь шинжлэх ухааны судалгааны шинэ арга гуравдугаар хэсэгт ажиглалт хийсэн баримтууд дөрөвдүгээр хэсэгт шинжлэх ухааны шинэ аргыг практик хэрэглэж байгаа жишээнүүд тавдугаар хэсэгт зарим урьдчилсан дүгнэлтүүд, сүүлчийн хэсэгт шинэ аргаар хуримтлуулсан мэдлэгийн тухай бичихээр төлөвлөжээ. Энэ бол Аристотелийн үеэс хойш хийх гэсэн асар том бүтээл байлаа. 1605 онд гарсан "Боловсролын дэвшил", 1620 онд хэвлэгдсэн "Шинэ зэвсэг" номуудыг цуврал бүтээлийнх нь эхний хоёр хэсэг нь гэж үзэж болно.

"Шинэ зэвсэг" бол түүний хамгийн чухал бүтээл мөн. Энэ ном нь судалгааны туршилтын аргыг ашиглахыг хамгаалах чиглэлээр бичигджээ. Аристотелийн ерөнхийгөөс тасархайг нотлох арга үеэ өнгөрөөж тасархайгаас ерөнхийг нотлох шинэ арга шаардагдав. Бид мэдлэгээс эхлэх биш мэдлэгээс дүгнэлт хийх хэрэггүй, харин дэлхий ертөнцийг ойлгохыг тулд түүний ажиглах шаардлагатай. Эхлээд баримт цуглуулж дараа нь тасархайгаас ерөнхийг нотлох аргаар дүгнэлт хийх ёстой. Өнөө үед эрдэмтэд түүний дэвшүүлсэн аргыг чандлан мөрдөхгүй байгаа ч гол үзэл санаа нь болох ажиглалт туршилтын шийдвэрлэх ач холбогдлыг ойлгож эрдэм судалгааны ажилдаа хэрэглэсээр байна.

Номхон далайд орших зохиомол арал дээр байгаа мөрөөдлийн хамтын нөхөрлөлийн тухай өгүүлсэн Бэконий сүүлчийн ном "Шинэ Атлантида" нь Томас Морын "Утопи" номыг санагдуулах боловч эрс ялгаатай. Түүний номонд төгс хамтын нөхөрлөлийн цэцэглэлт, баялаг нь шинжлэх ухааны судалгааг төвлөрүүлсний шууд үр дүн болно гэсэн дүгнэлт гардаг. Цаад утгаараа шинжлэх ухааны судалгааг ухаалаг хэрэглэснээр европийн ард түмнүүд мөрөөдлийн арлын оршин суугчид шиг аз жаргалтай, элбэг дэлбэг хангалуун амьдрах болно гэсэн санааг хэлж байсан юм.

Ф.Бэкон бол орчин үеийн анхны жинхэнэ гүн ухаантан байлаа. Түүний сэтгэлгээ, мэдлэгийн хүрээ шашнаас ангид (тэрээр бурханд чин сэтгэлээсээ сүсэглэдэг байсан ч) байсан юм. Улс төрийн салбарт онолч гэхээсээ илүү байдлыг бодитойгоор үнэлдэг улс төрийн зүтгэлтэн байсан ба сонгодог боловсрол, уран зохиолчийн хосгүй ур чадвараа шинжлэх ухаан, техникийн ач холбогдлыг улам өндөрт өргөхөд харамгүй зориулж байлаа.

Аливаа английн иргэний адил төвийг баримтлагч хүн байсан ч үйл явдлыг илүү өргөн хэмжээнд, дэлхий дахины хүрээнд авч үзэхийг сургамжилдаг байлаа. Тухайлбал хүний сонирхол тэмүүллийг гурав ангилж үзэж байв. Нэгдүгээрт төрөлх орондоо эрх мэдлээ батжуулж байгаа хүмүүс ба тэдний үйл ажиллагаа бол бүдүүлэг, харгис шинж чанартай хоёрдугаарт эх орныхоо нөлөөг өргөжүүлэх, эрх мэдлийг бэхжүүлэх, бусад орнуудын дунд тэргүүлүүлэх зорилгыг баримталдаг хүмүүс ба тэдний үйл ажиллагаа зөв зүйтэй, гэхдээ ховдог шунахай бодлогоос ангид бол зүгээр. Гэхдээ хүн эрх мэдэлд хүрч түүнийгээ бэхжүүлэхийг эрмэлзэж тэрчилэн оюун ухаанаараа ертөнцийг байлдан дагуулахыг эрмэлзэж байгаа бол түүний сонирхол дээрх дурдсан хоёр тэмүүллээс илүү ашигтай, илүү нэр хүндтэй юм."

Бэкон шинжлэх ухааны найдан байсан ч эрдэмтэн байгаагүй юм. Логарифийг зохиосон Непер, Кеплер тэр ч байтугай дотнын анд У.Гарвей нарын нээлтүүдийг ойшоож байсангүй. Дулаан бол хөдөлгөөний нэг хэлбэр гэсэн шинжлэх ухааны чухал санааг дэвшүүлж байсан мөртөө одон орны судлалд Коперникийн саналыг хүлээн зөвшөөрөхгүй байв. Шинжлэх ухааны хуулиудын бүрэн, зөв нэгтгэсэн дүгнэлт хийхийг эрмэлзэж байсангүй, харин зайлшгүй суралцах ёстой зүйлүүдийн тоймыг хийхийг чармайж байсан. Түүний дэвшүүлсэн шинжлэх ухааны таамаглалууд нь цаашдын маргааны үндэс суурь болж байснаас биш эцсийн дүгнэлт байгаагүй.

Тасархайгаас ерөнхийг нотлох аргын ашиг тусыг нээсэн, шинжлэх ухаанаас нийгэмд өгөх ихээхэн үр өгөөжийн ач холбогдлыг ойлгосон анхны хүн нь Ф.Бэкон биш, Гэхдээ дээрх санаануудыг нийгэм даяар хүлээн зөвшөөрөх хэмжээнд хүртэл сэнхэртэл нь тайлбарлаж

чадсан гавьяа түүнд ногдоно. Шинжлэх ухааны мэдлэгийг дэмжих зорилгоор 1662 онд Лондон хотод Хааны шинжлэх ухааны нийгэмлэгийг байгуулсан хүмүүс Бэконийг зоригжуулагчаа гэж дээдэлж байлаа. Францийн Сэргэн мандлын үед Дидро, д'Аламбер нарын сэтгэгчид анх удаа Нэвтэрхий толь зохиохдоо Бэконийг мөн зоригжуулагчаа гэж үзэж байлаа. Түүний "Шинэ зэвсэг", "Шинэ Атлантида" номуудыг дэлхий даяар мэддэг болохоор өнөөдөр ч уншсаар байна.

# 91. Генри Форд

(HENRY FORD)

1863-1947



Орчин үеийн аж үйлдвэрийн салбарт бөөнөөр үйлдвэрлэлийн аргыг нэвтрүүлсэн гол гавьяа америкий цуут баян Генри Фордод ногдоно. Бөөнөөр үйлдвэрлэх аргыг сэдсэний үр дүнд америкийн ард түмний цаашлаад дэлхий даяар хөдөлмөрчин олны амьдралын түвшин эрс дээшилсэн билээ.

Мичиган муж улсын Дирборн хотоос холгүй төрсөн Форд дээд сургуульд ер суралцаагүй, хэл бичгийн сургууль төгсөөд Дейтройт хотод галт тэрэгний машинистын туслахаар ажиллаж дараа нь засварчин, инженерээр дэвшжээ. Карл Бенц, Готлиб Даймлер хоёр тус тусдаа машин бүтээн, худалдаж байх үед ид залуу байв.

"Морьгүй хөдөлдөг сүйх тэргийг" ихэд сонирхож биечлэн зохиосон төслөөрөө 1896 онд машин хийж хоёр ч удаа үйлдвэр байгуулсан ч тухай бүр дампуурч байжээ.

Гэвч сэтгэлээр унасангүй, 1903 онд дахин нэг оролдлого хийж "Форд Мотор Компани" нэртэй гурав дахь үйлдвэрээ байгуулсан нь түүнд алдар гавьяа, нэр төр авчирчээ. "Чухамдаа өдөр тутам бизнесийн, мэргэжлийн, гэр бүлээрээ, ажлаар явахад зориулагдсан, эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд цөмөөрөө энгийн, аюулгүй, тохилог байдлыг нь бишрэн шагшсан, хэдэн мянга хүн худалдаж авч чадах хямд үнэтэй машиныг зохион бүтээж худалдана." гэсэн гол зорилгыг тавьснаар Фордын компани түргэн хугацаанд амжилтад хүрчээ.

Гэхдээ түүний бүтээсэн анхны загварууд нь гайгүй сайн болсон ч тавьсан өндөр зорилгод нь нийцэхгүй байлаа. Гэхдээ 1908 онд бүтээсэн "Модель Т" загвар нь олны талархал хүлээж нийтдээ 15 сая ширхэг борлогджээ.

Үйлдвэрлэсэн машинаа хямд үнээр худалдахын тулд өөрийн өртгийг нь хямдруулах хэрэгтэй гэдгийг ойлгож үйлдвэрүүд дээр нэгдүгээрт бүтнээр сольж болох эд ангиуд хоёрдугаарт хөдөлмөр хуваарилалтын өндөр түвшин гуравдугаарт угсрах шугам гэсэн үр ашигтай технологийн шинэчлэл хийжээ. Энэ бүхнийг ажилчин бүрийн ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд чиглүүлж байлаа.

Ажилчин хүнийг шаардлагатай материал, багажаа зөөх тэр ч бүү хэл ажил эхлэхийн өмнө шалан дээрээс авахад аль болох бага хугацаа зарцуулдаг болгоход онцгой анхаарах хэрэгтэй юм байна гэсэн дүгнэлтийг хийж шаардлагатай материалыг ажилчин хүнд замаар гулсах цувуур болон таазанд бэхэлсэн рельсээр хүргэх аргыг сэдэж олов. Ажилчин хүн үйлдлээ түргэн гүйцэтгэхэд нь зориулж цувуурыг хүний бэлхүүсний түвшинд байрлуулжээ. Үйлдвэрлэлийн аргуудыг байнга нарийвчлан судалж задлан шинжилгээ хийж улам боловсронгуй болгох аргыг үргэлж эрж хайдаг боллоо. Хэцүү үйлдлийг сургалтын богино хугацаанд дадлагажсан мэргэжил тааруу ажилчин хүн гүйцэтгэж чадахаар хэд хэдэн энгийн үйлдэл болгон салгасан нь ихээхэн үр дүн өгчээ.

Энэ бүх шинэ санааг дан ганц Форд гаргаж байгаагүйг дурдах хэрэгтэй. Харилцан сольж болох эд ангийн тухай санааг анх Энри Уитни зуун жилийн өмнө сэдсэн бол нэртэй мэргэжилтэн Фредерик Уинслоу Тейлор хувийн үйлдвэр дээр угсрах шугамыг хэрэглэж байжээ. Гэхдээ Форд бол дээр дурдсан аргуудыг цогцолбороор нь үйлдвэрлэлд ашиглаж их амжилтад хүрсэн хүн юм.

Хүний санаанд багтамгүй амжилтад хүрлээ. Анхандаа 825 доллараар худалдаж байсан хөнгөн тэрэгний үнэ 1908 онд 500 доллар, 1916 онд 360 доллар болтлоо хямдарч 1926 онд хамгийн доод үнэ 290 долларт хүрчээ. Үнэ хямдарснаар хэрэгцээ улам нэмэгдлээ. АНУ "дугуйн дээр явдаг ард түмэн" болж Г.Форд дэлхийн хамгийн баян хүн болжээ.

Ажилчдын хөдөлмөрийн бүтээмж дээшилснээр тэдний цалинг нэмэх бололцоо бий болов. Форд 1914 онд цалингийн доод хэмжээг нэг цагийн 5 доллар болгон нэмж урьд нь байсан дундаж цалингийн хэмжээг бараг хоёр дахин нэмэгдүүлж дэлхий ертөнцийг донсолгов. АНУ даяар шинэ өндөр цалин бий болсноор аж үйлдвэрийн ажилчид ядуучуудын эгнээнээс чинээлэг дунд ангийн эгнээнд шилжив.

Форд бөөнөөр үйлдвэрлэлийн нууцаа хав дарж нуусангүй, харин ч хаа сайгүй өргөн сурталчилж байлаа. Бусад үйлдвэрлэгч түүний амжилтыг харж дэвшилтэт аргуудыг нь далайцтай нэвтрүүлж эхэлснээр эхлээд АНУ-д дараа нь дэлхий даяар үйлдвэрлэлийн хэмжээ эрс өссөн билээ.

Форд санхүүгийн амжилтад хүрсний дараа улс төрийн үйл ажиллагаа эхэлж дэлхийн нэгдүгээр дайны өмнө энх тайвныг хамгаалахыг уриалсан нь ямар ч үр дүнд хүрсэнгүй. Хориод оны үед еврейчүүдийн эсрэг хөдөлгөөнд оролцож нэр хүндээ барснаас хэтэрсэнгүй. Гучаад оны үед үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудтай тэмцэл өрнүүлсэн нь ажилчдын эсэргүүцэлтэй тулгарч компанид нь ашиг өгсөнгүй тул болив. Ийнхүү амьдралынхаа сүүлийн жилүүдэд түүний явуулсан үйл ажиллагаа бүтэлтэй болоогүй. Гэхдээ үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж ажилчдын амьжиргааг дээшлүүлсэн аж үйлдвэрийн салбар дахь хувьсгалд түүний оруулсан хувь нэмэр хэмжээлшгүй их билээ.



# 92. МЭН-ЦЗЫ

(MENCIUS)

Манай эриний өгнөх 371- 289 он



Хятадын гүн ухаантан Мэн-Цзы бол Күнзийн хамгийн нэртэй залгамжлагч байв. "Мэн-Цзыны сургаал" номондоо тайлбарласан түүний сургаалыг олон зуун жилийн турш өндөр үнэлж байлаа. Күнзээс хоёр зуун жилийн дараа амьдарч байсан ч хятад улсад түүнийг "хоёр дахь аугаа ухаантан" гэж нэрлэж иржээ.

Хятад орон улс төрийн хувьд хуваагдмал байж "Дайтагч улсуудын үе" гэж түүхэнд тэмдэглэгдсэн Чу угсааны хаадын хаанчлалын сүүлийн жилүүдэд манай эриний өмнөх 371 оны орчим Цу хэмээх бяцхан улсад Мэн-Цзы төржээ. Күнзийн уламжлалаар өсөж түүний онол, эрхэм тэмүүллийг үргэлж бахархан дэмждэг байсан ч бүтээл туурвилаараа эрдэмтэн, гүн ухаантан хэмээх эрхэм алдрыг хүртсэн ажээ.

Амьдралынхаа дийлэнх хэсгийг улс орноороо аялал хийж янз бүрийн удирдагчдад зөвлөмж өгч хэсэг хугацаанд Чи улсад түшмэлийн алба хааж өнгөрөөсөн ба улс төрийн албан тушаалд томилогдож байсангүй. Манай эриний өмнөх 312 онд 59 настайдаа төрөлх Цу улсдаа буцан ирж насан өөд болтлоо амьдарчээ. Түүнийг манай эриний өмнөх 289 оны хавьд үхсэн гэдэг.

Мэн-Цзы олон шавь нартаа байсан ч сургаалынхаа үндсэн зарчмуудыг тайлбарласан "Мэн-Цзыны сургаал" ном нь Хятадад ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Шавь нар нь уг номыг хянан засварласан ч түүний үзэл санааг үндсэнд нь хэвээр нь үлдээсэн байна.

Хүний мөн чанар үндсэндээ сайн талтай гэсэн бат итгэлээр бичигдсэн "Мэн-Цзыны сургаал" ном нь бадрануй өөдрөг агуулгатай. Түүний улс төрийн байр суурь олон утгаараа Күнзийн сургаалаас эрс ялгаатай. Хаан харьяат иргэдээ хүчээр биш чухамдаа ёс суртахууны үлгэр жишээгээр захирах ёстой гэсэн санааг Мэн-Цзы баримталж байв. Күнзтэй харьцуулбал олон түмэнд илүү ойр дотно хүн байжээ. "Тэнгэр эрхэс хүн шиг л хардаг, сонсдог." гэсэн хэллэгийг үргэлж номлодог байв.

Аливаа улсын гол баялаг нь ард түмэн болохоос хаан биш, ард түмний сайн сайхан аж байдлыг анхаарах нь төр улсын захирагчийн ариун үүрэг юм, ялангуяа амьжиргааны бололцоотой нөхцөлийг хангаж ёс суртахууны зарчмыг баримтлан удирдлагыг явуулна гэж үзэж байлаа. Худалдаа арилжааг чөлөөтэй байлгах, бага татвар ногдуулах, байгалийн баялагийг хамгаалах, эд баялгийг илүү шудрага хуваарилах, хөгшид болон хөрөнгө чинээ багатай хүмүүсийг халамжлах зэрэг нь засгийн газрын бодлогын амин сүнс байх ёстой гэж гүн ухаантан сургажээ. Хааны эрх мэдэл тэнгэрээс гаралтай гэж Мэн-Цзы чин үнэнээр итгэдэг байсан тул ард түмнийхээ сайн сайхныг боддоггүй захирагч тэнгэрийн ивээлийг алдаж зайлуулагдах болно, ийм учраас олон түмэн шудрага бус үйлдэл хийж байгаа захирагчийн эсрэг бослого гаргах эрхтэй гэж Ж.Локкоос бүр өмнө шүү дээ) номлож байв. Түүний энэхүү санааг Хятадад талархан дэмжиж байлаа.

Өнөөгийн өндөрлөгөөс дэлхийн түүхийг харахад Мэн-Цзыгийн сургаал эрх баригчдаас илүү захирагдагсадын дунд өргөн дэлгэрсэн байна. Түүний үзэл санааг тухайн үеийн эрх баригчид эсэргүүцэн хүлээн зөвшөөрөхгүй байв. Гэвч он цагийн уртад түүний сургаал Күнзийн талынхан, хятадын ард түмний дотор илүү өргөн түгжээ. Тэртээ тэргүй өндөр нэр хүндтэй байсан Мэн-Цзыгийн сургаал XI-XII дугаар зууны үед шинэ Күнзийн үзэл санааны цэцэглэлтийн ид үед улам түгэн тархжээ.

Өрнөдөд Мэн-Цзы ямар ч нөлөө үзүүлээгүй нь мэдээж. Гэтэл түүнтэй нэгэн үед амьдарч байсан Лао-Цзыгийн "Дао де цзин" зохиолыг түүнд тусгасан үзэл санаануудыг нь сонирхолтой гэж үзсэн учраас европийн олон хэл дээр орчуулсан байна. Гэхдээ Мэн-Цзыгийн номыг өвөрмөц, хурц гэж үздэг байсан хүмүүс өрнөдөд бас байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Засгийн газрын зүгээс хөгшид болон хөрөнгө чинээ багатай хүмүүсийг халамжлах хэрэгтэй, бага татварыг дэмжих тухай санаа нь үнэхээр содон сонсогдож байна. Гэтэл сонгуулийн хөтөлбөртөө дээрх хоёр санааг тусгахыг оролдсон америкийн улс төрч либералчууд, консерваторуудын итгэлийг алдах нь мэдээж хэрэг. Нэг талаас улс орны эд баялгийг шудрагаар хуваарилахыг дэмжиж нөгөө талаас чөлөөт худалдаа, бага татварыг сайшаах нь хоорондоо дэндүү зөрчилтэй санаа юм. Энэ утгаараа хэрэвзээ Мэн-Цзы өнөө үед амьдарч байсан бол Конгрессийн гишүүнээр яагаад ч сонгогдож чадахгүй байжээ. Хамгийн гол нь дээрх хоёр санаанаас үүдэн гарах зөрчлийг хэрхэн шийдвэрлэхийг тодорхой зааж өгөөгүй явдал юм.

Ямартаа ч болов Мэн-Цзыгийн хятад улсад үзүүлсэн нөлөө их юм. Дэлхийн хүн амын хорь гаруй хувь оршин суудаг бүс нутагт сургаалыг нь бараг хорин хоёр зууны турш судалсаар байсан гэдэг нь тэр болгон гүн ухаантанд олдохгүй их хувь заяа билээ.

# 93. Зороастр

(ZOROASTER)

Манай эриний өгнөх 628- 551 он



Ираны зөнч Зороастр бол 2500 гаруй жил оршин байсан, одоо ч шүтэн бишрэгчидтэй зороастризмын шашныг үндэслэгч билээ. Тэрчилэн зороастричуудын ариун судруудын "Авеста" эмхэтгэлийн эртний хэсэг болох "Гаты"-г зохиосон юм.

Эртний иран хэлээр Заратуштра хэмээх Зороастрын намтрын ухай мэдээлэл маш хомс, манай эриний өмнөх 628 оны ойролцоо өнөөгийн Иран улсын хойд нутагт төржээ. Идэр залуу наснаасаа зохиосон шашнаа сурталчилж эхэлсэн боловч ихээхэн эсэргүүцэлтэй тулгарч дөчин настайдаа хойд Ираны захирагч Вишгаспааг шинэ шашиндаа итгүүлж анд найз ивээн хамгаалагчаа болгож чадсанаар амжилтад хүрчээ. 77 настайдаа өөд болсон гэж тэмдэглэгдсэн болохоор манай эриний өмнөх 551 оны үед нас барсан бололтой.

Зороастризмын шашин нь нэг болон хоёр эхлэлтэй шашнуудын сонирхолтой нэгдэл юм. Зороастр нь сайн үйл, шудрага ёсыг хөхүүлэн сайшаадаг Ахурамазда (персээр Ормузд) нэртэй ганц жинхэнэ бурхан байдаг гэж үзнэ. Тэгсэн мөртөө муу үйл, заль мэхийн илэрхийлэл болох Анграмайню (персээр Ариман) муу үйлийн сүнс байдаг гэж итгэнэ. Хорвоо дэлхийд Ахурамазда болон Ариман хоёрын хооронд мөнхийн тэмцэл явагдаж байна, хүн аль талыг нь сонгохоо биечлэн шийднэ, гэвч одоохондоо тэрхүү тэмцэл далд явагдаж байна, ямар ч тохиолдолд Ахурамаздагийн хүч ялна. Зороастризмын шашныхан хойд насны амьдрал бий гэдэгт итгэнэ.

Ёс зүйн асуудлаар бол сайн үйл хийх, шудрага байх нь чухал гэж үздэг ба даянлан амьдрах, гэр бүлгүй байхыг буруушаана. Зороастричууд шашны янз бүрийн зан үйл хийдгээс ихэнх нь галын тахилгатай холбоотой. Тухайлбал зороастризм шашны сүм хийдэд ариун гал үргэлж асаатай байна. Нас барагсадын шарилыг оршуулахгүй, шатаахгүй, харин хэрмийн цамхаг дээр тавина. Тас шувууд шарилыг хоёр цагийн дотор тасчин идэж дуусгана.

Зороастризмын шашин зарим байдлаараа ираны хуучны шашин шүтлэгүүдтэй адилаар ч гэсэн Зороастрыг амьд сэрүүн байхад өргөн тархаагүй. Амьдран суудаг байсан бүс нутгийг

нь Их Кир хаан манай эриний өмнөх Ү1 зууны дунд үед Персийн эзэнт гүрний бүрэлдэхүүнд нэгтгэсэн тэр үед Зороастр ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ. Персийн захирагчид хоёр зууны турш зороастризмын шашныг шүтэн биширч байснаар түүнийг сүсэглэдэг хүмүүсийн тоо улам нэмэгджээ. Манай эриний өмнөх 1Ү зууны хоёрдугаар хагаст Александр Македонский Персийн эзэнт гүрнийг эзлэснээр зороастризмын нөлөө буурчээ. Гэвч хожим нь персүүд улс төрийн тусгаар тогтнолоо сэргээж түүний үр дүнд уламжлалт шашнаа дахин дээдлэн шүтэх болсон байна.

226-651 оны үеүүдэд Перс улсад сасанидын угсааны хаад төрийн эрх барьж байх хугацаандаа зороастризмыг төрийн шашин болгон өргөмжилсөн байна.

Ү11 зууны үед Перс улс арабчуудад эзлэгдсэний дараа хүн амын дийлэнх хувь нь лалын шашин шүтэх болжээ. Аравдугаар зууны үед зороастризм шашныг шүтэгчид дүрвэж Персийн булангийн Хормунц аралд очсон байна. Тэндээс зарим нь Энэтхэгт очиж жижиг эзэмшил газар бий болгожээ. Энэтхэгчүүд тэднийг перс гарлаар нь парсчууд гэж нэрлэдэг байв. Өнөөдөр Энэтхэгийн Бомбей хот түүний орчимд нэг зуун мянга гаруй парсчууд аж төрөн сууж байна. Зороастризм шашин Иран улсад мөхөөгүй, энэ шашныг шүтэгчдийн тоо хорин мянга орчим бий.

Одоогийн байдлаар дэлхийд энэ шашныг шүтэгчдийн тоо мормончуудаас арай илүү. Гэхдээ мормоны шашин бол шинээр бий болсон шашин. Олон зууны туршид зороастризмыг шүтэгчид илүү олон байсан юм. Зороастризмын сургаал нь иудаизм, христосын гэх зэрэг шашинд их нөлөө үзүүлсэн. Тэрчилэн Мани сайн болон муу үйлийн хоорондын тэмцлийн тухай Зороастрын санааг авч цогц сургаал болгон манихейство шашинг бий болгосон билээ. Манихейство шашин тухайн үедээ дэлхийн хэмжээний шашин болтлоо дэлгэрсэн ч хожим нь бүр мөхсөн юм.

Зороастризм нь дэлхийн эртний шашнуудын нэг мөн ч орон нутгийн хэмжээнд үйлчилж байсан юм. Тийм учраас түүнийг буддизм, христосын, лалын шашнуудтай харьцуулж болохгүй,

# 94. Нэгдүгээр Елизавета хатан хаан

(QUEEN ELIZABETH)

1533-1603



Нэгдүгээр Елизавета хатан хааныг англи улсын түүхийн хамгийн гарамгай хаан гэж зүй ёсоор үздэг юм. Түүний 45 жилийн хаанчлалын хугацаанд тус улсын эдийн засаг үсрэнгүй хөгжиж уран зохиол цэцэглэж дэлхийн тэргүүлэх далайн гүрэн болсон билээ. Английн хаад зөвхөн хаант ёсны билэг тэмдэг байгаагүй тэр цагт амьдарч ажиллаж байсан нэгдүгээр Елизавета хатан хаан нэгэн үед амьдарч байсан хүмүүсийнхээ талархлыг зүй ёсоор хүлээж байлаа. Түүний хаанчлалын үеийг Английн түүхийн алтан зуун гэж бахарлан нэрлэдэг билээ.

Улс орондоо шинэчлэл хийсэн ҮШ Генрих хааны гэр бүлд 1533 онд Гринвич хотод мэндэлжээ. Эх нь болох Анна Болейн хааны хоёр дахь хатан байсан ба 1536 онд түүний толгойг цавчин цаазалж хэдэн сарын дараа парламент гурван настай Елизавета охиныг хууль бус гэж зарлав. (Учир нь гэвээс английн католик шашинтнууд хаан Генрихийг анхны хатнаасаа салсныг хууль ёсны гэж үзэхгүй байжээ.) Парламент шахан хавчиж байсан ч Елизавета охин хааны ордонд амьдарч өндөр боловсрол эзэмшжээ.

Төрсөн эцэг, ҮШ Генрих хаан охиныгоо 13 настай байхад нь өөд болов. Дараагийн арван нэгэн жилийн хугацаанд хааны ширээнд заларсан хүмүүс улс орноо олигтой захирч чадсангүй. Елизавета охины ах ҮI Эдуард 1547-1553 онуудад хаан байхдаа үнэн алдартны шашныг илт дэмжсэн бодлого явуулж байв. Дараагийн таван жилд нь хатан хаанаар заларсан нэгдүгээр Мария ромын хамба ламыг хүчтэй дэмжиж католик шашныг сэргээх чиглэлийг барьж үнэн алдартны шүтлэгтнүүдийг хөөн тууж гурван зуу орчим хүнийг цаазалжээ. (Тийм учраас Цуст Мария гэсэн хоч авчээ.) Тэр ч байтугай Елизавета бүсгүйг баривчилж Лондонгийн Тауэрийн цамхагт хорьж хэсэг хугацааны дараа сулласан ч амь насанд нь аюул заналхийлсээр байлаа. 1558 онд Мариаг өөд болж Елизаветаг хатан хааны ширээнд залрахад английн ард түмэн их баярлажээ.

Францтай хийж байгаа дайныг эцэс болгох, Шотланд, Испани улсуудтай таагүй харилцаатай байгааг нэг тийш болгох, хамгийн хэцүү нь эх оронд нь болж байгаа шашны дайн байлдааныг зогсоох гээд даруй шийдвэрлэвэл зохих олон төвөгтэй асуудал залуу хатан хааны өмнө тулгарав.

Гэвч дотоодын асуудлыг хамгийн түрүүнд шийдвэрлэхээр зориглож хатан хааны ширээнд заларсны дараахан Англи улсын албан ёсны шашны тухай Дээд эрх мэдэл, нэгдсэн удирдлагын тухай Хуулийг парламентаар батлуулжээ. Энэ хууль дундыг баримт-лагч үнэн алдарт шашинтнуудын сэтгэлд нийцэж пуританчууд илүү эрс шинэчлэл явуулахыг шаардав. Нэг талаас пуританчууд нөгөө талаас католикчууд сөрөг хүчин болж байсан ч Елизавета хатан хаан байх хугацаандаа 1559 онд хүрсэн зөвшилцлийг насан туршаа чанд баримталж байлаа.

Шотландын Мария хатан хаан унаснаар шашны асуудал мөн хурцаар тавигдлаа. Мария Шотландаас зугтаж зориуд Англид ирж Елизавета хатан хааны олзны хүн болов. Мария бол католик шашинтан, Английн хатан хаан болох эрхтэй бүсгүй байсан тул Елизаветагийн эсрэг өдөөсөн бослого амжилттай болох юм уу алагдсан тохиолдолд байдал улам хурцдаж ээдрээ төвөгтэй болж болзошгүй байв. Тиймд Мария бүсгүйг баривчилж шоронд суулгажээ. 19 жил шоронд хоригдож байхдаа хатан хааны эсрэг хэд хэдэн хуйвалдаан зохион байгуулсан ч бүтэлгүйтсэн ажээ. Эцэст нь Мариаг 1587 онд цаазлажээ.

Елизавета хатан хаан цаазлах зарлигт гарын үсэг зурахаас татгалзсан ч засгийн газрын сайдууд, парламентийн гишүүдийн дийлэнх нь түүнийг ятган шаардсаар байж зөвшөөрүүлжээ.

Шашны маргалдаан Елизаветад маш халгаатай байлаа Тавдугаар Пий хамба лам 1570 онд түүнийг сүмээс холдуулж хаан ширээнээс буулгахыг шаардав. Английн хатан хааны амийг хороосон байхад нүгэл биш гэж XIII Григорий хамба лам 1580 онд ил мэдэгдэв. Гэвч бодит байдал Елизаветагийн талд байв. Түүний хаанчлалын үед үнэн алдартны шашинтнууд Англид католик шашныг сэргээхээс их айж байсан ба католикчуудын тэрхүү сэргэлтийн эсрэг тэмцэлд нэгдүгээр Елизавета хатан хаан гол түшиг тулгуур нь болж байсан юм. Ийм учраас үнэн алдартны шашинтангууд хатан хаанаа бүхий л талаар дэмжин талархаж байжээ.

Елизавета хатан хаан гадаад бодлогын салбарт ч зөв бодлого явуулж байлаа. 1560 онд Эдинбургийн гэрээ байгуулж Шотландтай энх тайвнаар хөрш зэргэлдээ байх баталгааг бий болголоо. Франц улстай хийж байсан дайныг зогсоосноор тус хоёр орны харилцаа сайжрав. Гэвч бодит нөхцөл байдал Испани улстай маргалдах байдалд хүргэлээ. Хатан хаан дайн гаргуулахгүйн төлөө маш хүчин чармайлт гаргасан ч амжилт олсонгүй. Католик шашин бүхэлд нь ноёрхсон ХУ1 зууны үеийн Испани улсыг санаандаа төсөөлөн бодоход дайн болсон нь гарцаагүй хэрэг байв. Оршин суугчдын дийлэнх нь үнэн алдартны шашинтангууд болох Нидерланд улсад испанийн дарлалын эсрэг бослого дэгдэхэд Испанийн засгийн газар цэрэг хөдөлгөлөө.

Нэгдүгээр Елизавета хатан хаан босогчдод бололцоотой тусламжийг үзүүлж эхэлсэн ч дайнаас зайлсхийхийг хичээж байв. Английн ард түмний дийлэнх хэсэг, засгийн газрын сайдууд, парламент зэвсэгт мөргөлдөөн хийх нь зүйтэй гэсэн шаардлага тавьж эхэллээ. 1580

онд Испанитай дайн зарлахад ард түмэн нь хатан хааны шийд-вэрээ баттай дэмжив.

Тэрбээр олон жилийн турш усан цэргийн флотоо бэхжүүлж байсан ч Испанийн хоёрдугаар Филипп хаан Англид халдан довтлох зорилгоор илүү хүчтэй, "Испанийн ялагдашгүй сүр хүч" нэртэй тэнгисийн флот байгуулсан байжээ. Байлдааны усан онгоцны тооны хувьд ойролцоо ч усан цэргүүдийн тоогоор англиас арай цөөн байв. Гэвч английн усан цэргүүд байлдааны бэлтгэлийн хувьд давуу, усан онгоцууд нь чанар сайн, илүү хүчтэй зэвсэглэлтэй байв.

Тэнгисийн шийдвэрлэх тулалдаан 1588 онд болж Испанийн тэнгисийн цэргийн флот сүйрчээ. Энэ ялалтын үр дүнд Англи улс далайн тэргүүлэх гүрэн болж энэ алдраа хорьдугаар зуун хүртэл хадгалсан билээ.

Елизавета хатан хаан санхүүгийн асуудалд ямагт анхааралтай хандаж байсан ба түүнийг хатан хаанаар залрах үед Английн санхүүгийн байдал харьцангуй сайн байв. Гэтэл Испанитай хийсэн дайны уршгаар улсын сан хөмрөг хоосров. Гэтэл ард түмний амьжиргаа дээшилсээр байсан нь сонин.

Елизавета хатан хааны 1558-1603 онуудад үргэлжилсэн 45 жилийн хаанчлалыг "Английн алтан зуун" гэж бахархан нэрлэдэг. У.Шекспир зэрэг алдарт зохиолчид энэ үед уран бүтээлээ ид туурвиж байв. Соёл, урлагийн хөгжилд онцгой анхаарч байсны нэг сонгодог жишээ нь Шекспирийн театрыг Лондон хотын засаг захиргаанаас өмгөөлөн хамгаалж санхүүгийн томоохон дэмжлэг үзүүлж байсан явдал юм. Гэхдээ уран зохиол шиг хөгжим, уран зураг хөгжөөгүй юм.

Елизавета хатан хааны хаанчлалын үед англичууд аялагч ард түмэн болохоо харуулжээ. Орос улс руу байнга аялал хийж Мартин Фробишер, Жон Дэвис нар Алс Дорнод хүрэх баруун-хойд чиглэлийн зам олох оролдлого хийж байлаа. Ноён Фрэнсис Дрейк 1577-1580 онуудад дэлхийг тойрсон аялал хийж зам зуур АНУ-ын Калифорни хотоор дайрчээ.

Елизавета хатан хааны ганц гол дутагдал нь хаан ширээ залгамжлагчийн асуудлыг огт тоохгүй байсан явдал юм. Гэрлэж байгаагүй ба залгамжлагчаа зарлахаас татгалзсаар байв. (Залгамжлагчаа зарлах нь өрсөлдөгч бий болгоно гэж айж байсан бололтой.) Хэрэвзээ Елизавета идэр залуудаа, Мариаг Шотландын хатан хаан байх үед нас барсан бол хаан суудлын төлөө дайн гарцаагүй дэгдэх байсан юм. Аз болоход Елизавета урт насалж 77 настайдаа өөд болсон билээ.

Үхлүүт хэвтэрт байхдаа Шотландын VI Яков хааныг залгамжлагчаараа зарлав. Энэ шийдвэр нь Англи, Шотландыг нэг хаантай болгосон ч тийм ч зөв шийдвэр байсангүй. ХҮ11 зууны дунд үед иргэний дайн эхэлсэн юм.

Елизавета бол хосгүй ухаантай, чадварлаг улс төрч байв. Аливаа асуудалд болгоомжтой, хуучинсаг байдлаар ханддаг, дайн дажныг үзэн яддаг байв. Эцгийнхээ адилаар улс төрийн үйл ажиллагаагаа парламенттай сөргөлдөх биш хамтран ажиллах аргаар явуулж байв. Гэрлэж байгаагүй ч эрчүүдэд таатай ханддаг, сайд нараа зөв сонгож байжээ.

Елизавета хатан хаан Англи улсыг шинэчлэлийн хоёрдугаар үед захирч католик болон үнэн

алдартны шашинтангуудын хоорондын сөргөлдөөнийг намжааж улс орныг салж бутрах аюулаас сэргийлж чадсан юм. Нийгмийг шинэчлэгч байгаагүй ч түүний хаанчлалын үед илүү их дэвшил гарчээ. Дарангуйлан захирагч байхыг хүсдэггүй байсан Елизавета ардчилсан үндсэн хуулийг гаргасан бол эх орондоо ардчиллыг хөгжүүлэхэд их түлхэц өгөх байсан юм. Цэргийн алдар цол горьддоггүй, улс орныхоо нутаг дэвсгэрийг өргөжүүлэхийг эрмэлзэж байгаагүй ч дэлхийд хамгийн хүчирхэг усан цэргийн флот байгуулж хожим нь бий болсон Британийн эзэнт гүрний үндэс суурийг тавьсан юм.



# 95. Михаил Сергеевич Горбачёв

(Michal GORVACHEV)

1931 онд төрсөн



Дэлхийн түүхэнд сүүлийн дөчин жилд болсон хамгийн том улс төрийн үйл явдал нь ЗХУ бугарч коммунист эвсэл задран унасан явдал юм. Хэдэн арван жилийн туршид бүх дэлхийг залгихаар заналхийлж байсан коммунист хөдөлгөөн маш түргэн алга болж түүхийн хогийн саванд хаягдлаа. Энэ түүхэн чухал үйл явдлын гол хүн нь ЗХУ-ыг сүүлчийн зургаан жилийн хугацаанд нь удирдаж байсан Михаил Сергеевич Горбачёв байлаа.

1931 онд Оросын өмнөд нутгийн Ставрополь хязгаарын Привольное тосгонд төрж дунд сургууль онц дүнтэй төгсөж дөрвөн жил тракторчноор ажиллажээ. 1950-1955 онуудад Москвагийн Их сургуулийн хуулийн ангид суралцаж байхдаа хамт суралцаж байсан Раиса Максимовна Титоренког эхнэрээ болгож авсан, 1952 онд коммунист намд элсчээ.

Хуульчийн мэргэжил эзэмшиж нутагтаа ирээд намын шугамаар дэвшиж 1970 онд мужийн намын хорооны дарга, 1978 онд Коммунист Намын Төв Хорооны хөдөө аж ахуй эрхэлсэн нарийн бичгийн даргаар дэвшиж 1980 онд Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн болов. 1985 оны гуравдугаар сарын 12-ны өдөр ЗХУКН-ын төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогджээ.

1966 онд Франц, 1967 онд Итали, 1983 онд Канад, 1984 онд Англид очиж өрнөдийн дэвшлийг нүдээр харсан учир түүнийг намын тэргүүнээр сонгогтоход түүнийг урьдын удирдагчдаасаа илүү орчин үеийн, либерал зүтгэлтэн болно гэж өрнөдөд талархан хүлээн авсан юм.

Засгийн эрх мэдлийг авах үед нь, ЗХУ зэвсэглэлд асар их хөрөнгө зарсаар байсан тул зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох зорилгоор АНУ-ын ерөнхийлөгч Р.Рейгантай 1985-1988 онуудад Женев, Рейкьявик, Вашингтон, Москвад дөрвөн удаа уулзаж 1988 оны 12 дугаар сард Зэвсэглэлийг хязгаарлах тухай гэрээг байгуулжээ. Энэ бол том гүрнүүдийн цөмийн зэвсгийг бодитойгоор хорогдуулсан анхны гэрээ байсан ба дунд тусгалын пуужингуудыг бараг бүгдийг

устгасан юм.

Л.И.Брежневийн удирдлагын үед Зөвлөлтийн арми 1978 онд Афганистанд халдан довтолж дэлхий олон нийтийн дургүйцлийг төрүүлж АНУ тус улсын партизануудыг зөвлөлтийн агаарын хүчний цохилтын хүчийг сааруулсан "Стингер" пуужингаар хангах болсон үеэс удал үргэлжилсэн, утга учиргүй дайнд татагдан орсон байв. М.Горбачёв зөвлөлтийн цэргийн хохирлыг багасгаж улс орны нэр хүнд барсан дайныг зогсоохоор Афганистанаас зөвлөлтийн цэргийг гаргах гэрээнд 1988 оны эхээр гарын үсэг зурлаа.

Гадаад бодлогодоо нааштай амжилт олохын зэрэгцээ дотоод бодлогын асуудлууддаа гол анхаарлаа хандуулж байв. Зөвлөлтийн үр ашиг муутай эдийн засгийг өөд татахын тулд "өөрчлөн байгуулалт" гэж нэрлэгдсэн өргөн агуулгатай хөтөлбөрийг дэвшүүлсэн. Гэхдээ М.Горбачёв нь Маркс, Лениний сургаалыг баримтлагч, социализмд бүрэн итгэдэг хүн байсан учир коммунист тогтолцоог боловсронгуй болгох зорилгыг өмнөө тавьж байв. 1986 онд ил тод байдлыг зарласан нь түүний хамгийн хувьсгалт шинэчлэл байсан юм. Засгийн газрын үйл ажиллагаа, нийгэмд сонирхол татаж байгаа үйл явдлуудыг ил тод шууд мэдээлж байх, иргэд, хэвлэлийн газруудад улс төрийн асуудлуудыг хэлэлцэх бололцоо олгосон нь ил тод байдлын гол агуулга болж байлаа. Зөвлөлтийн хэвлэлүүд засгийн газрын бодлого, коммунист намын үйл ажиллагаа, өндөр тушаалын түшмэд тэр ч байтугай Горбачёвыг шүүмжлэх эрхтэй болжээ.

1989 онд ардчилсан сонгууль явуулсан нь ЗХУ-д ардчиллын төлөө хийсэн том алхам байлаа. 1917 оноос хойш орос улсад хийсэн анхны нууц чөлөөт санал хураалтын үр дүнд хуучны удирдагчид огцорч зөвлөлтийн удирдлагад урьд нь тэрс үзэлтнүүд гэгдэж байсан хүмүүс суга дэвшин гарч ирсэн юм.

Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар зөвлөлтийн цэрэг байрласан европийн Болгар, Румын, Польш, Унгар, Чехословак, Дорнод Герман зэрэг зургаан оронд коммунист дэглэм тогтсон ч тэдгээр орны ЗХУ-д худалдагдсан удирдагчид нууц цагдаагийн алба, цэргийн хүчинд түшиглэн дөч гаруй жил оршин тогтнож байсан ч олны түмний дэмжлэг хүлээх байтугай дургүйцэл жигшлийг нь төрүүлж байлаа.

1961 онд босгосон алдарт Берлиний хана нь хоёр ертөнцийг зааглаж байсан ба Дорнод Германийг олон жилийн турш захирч байсан Э.Хонеккер ард иргэд нь өргөст торыг үл хайхран Баруун Герман руу зугтсаар байгааг болиулахын тулд 1989 оны аравдугаар сард эрс арга хэмжээ авсан нь олон нийтийн жагсаал цуглаанд хүргэв. Энэхүү хямралын үед Горбачёв Берлинд очиж өөрчлөлтийг түргэвчлэхийг Э.Хонеккерээс шаардаж жагсаал цуглааныг дарахад тус улсын нутаг дэвсгэр дээр байрлаж байгаа зөвлөлтийн 380 мянга гаруй цэрэг оролцохгүй гэдгийг мэдэгдэв.

Энэхүү мэдэгдэл нь дорнод германы арми, цагдаагийн газрын үйлдэж болзошгүй байсан цуст аллагыг зогсоож жагсаалд оролцогчдын зоригийг нэмжээ. Шинээр сонгогдсон Дорнод Германы удирдагч ком-мунист Эгон Керенц 11 дүгээр сарын 9-нд Берлиний ханыг нээж Өрнөд рүү чөлөөтэй зорчиж болно гэж мэдэгдэв.

Хэдэн сая германчууд Өрнөд Германыг нүдээр үзэж ардчилсан Герман гэгч нь дөчин жилийн туршид хэрхэн хүний эрх чөлөөг хязгаарлаж хөгжил цэцэглэлтийг чөдөрлөж байсныг

мэдэрчээ. Удсангүй Болгар улсад тус орныг Кремлийн заавраар удирдаж байсан Тодор Живковийг огцрууллаа. Унгарт засгийн газрын зөвшөөрснөөр 1989 оны аравдугаар сард болсон чөлөөт сонгуульд оролцсон сөрөг хүчин ялалт байгууллаа. Польш улсад коммунизмыг эсэргүүцэгчид 1990 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс тус оронд зах зээлийн эдийн засгийн тогтолцоог хэрэгжүүлэх шийдвэр гаргав. 1989 оны 12 дугаар сарын 15-нд Румыний Тимишоар хотод Н.Чаушескогийн дэглэмийн эсрэг хөдөлмөрчдийн жагсаал эхэлж хайрт удирдагч нь буудах тушаал өгчээ. Тийм харгис шийдвэрт дургүйцсэн олон түмэн "хайрт" удирдагчаа баривчилж 12 дугаар 25-ны өдөр түүнийг цаазлав. Ийнхүү Дорнод Европ дахь социализмын хамгийн сүүлчийн түшиг тулгуур унажээ.

Энэ бүх үйл явц нь дараах чухал үйл явдлуудын дөнгөж эхлэл байжээ. Үүнд нэгдүгээрт Чехословак, Унгараас зөвлөлтийн цэрэг гарсан хоёрдугаарт чөлөөлөгдсөн орнуудад чөлөөт сонгууль болж коммунистууд ялагдах хүлээсэн, гуравдугаарт ЗХУ-ын холбоотон байсан бусад хэд хэдэн оронд марксист засгийн газрууд нь тухайлбал Ази тивд орших Монголд унасан, дөрөвдүгээрт хоёр Герман 1990 оны аравдугаар сард нэгдсэн.

ЗХУ-ын дотоодод өргөн их өөрчлөлт гарлаа. ЗСБНХУ нь хэзээ ч сайн дураар нэгдсэн улсууд байгаагүй ба үнэндээ оросын хаан байлдан дагуулалт хийж хүчээр нэгтгэн захирч байсан Оросын эзэнт гүрний залгамжлагч байсан юм. М.Горбачёвын зарласан ил тод байдлын нөхцөлд оросод хүчээр нэгтгэгдсэн олонх ард түмэн тусгаар тогтнолоо сэргээхийг хүсэж байгаагаар ил тод хэлэх болж төдсөнгүй зохион байгуулалттай хөдөлгөөн болон өрнөлөө. Хамгийн түрүүнд бяцхан Литов улсад ЗХУ-аас тусгаарлах асуудлаар 1990 оны гуравдугаар сарын 11-нд чөлөөт сонгууль болж тус улсын парламент ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнээс бүрмөсөн гарч байгаагаар зарлалаа.

М.Горбачёв литовчуудын шийдвэрийг шууд хууль бус гэж мэдэгдэж гаргасан шийдвэрээ нэн даруй цуцлахыг шаардаж ноцтой хор уршигтай байж болохыг сануулж эдийн засгийн бүслэлт хийснээ зарлаж сүр хүчээ харуулж тус улсын нийслэлд зөвлөлтийн танкуудын жагсаал хийлгэв.

Гэвч М.Горбачёв бослого гаргасан мужуудыг хүчээр дарсангүй, литовын удирдагчийг баривчилж шоронд хийсэнгүй. Ийнхүү литовчуудын бослогыг хүч хэрэглэн цус урсган дараагүй нь бусад бүгд найрамдах улсуудад нөлөөлж тэдний зоригийг бадраав. Латвийн парламент хоёр сар хэлэлцсэний дараа ЗХУ-аас тусгаар улс байгаа тухай тунхаглал гаргав. ЗСБНХУ-ын хамгийн том бүгд найрамдах улс болох Орос улс 1990 оны долоодугаар сарын 12-нд тусгаар тогтнолоо зарлав. Оны сүүлч гэхэд бүх 15 бүгд найрамдах улсууд тусгаар тогтнолын тунхаглалаа гаргасан байлаа.

М.Горбачёвын үйл ажиллагаанаас үүдэлтэй ихээхэн өөрчлөлтөд дургүйцсэн хуучин үеийн коммунист удирдагчид, цэргийн эрхтнүүд 1991 оны наймдугаар сард төрийн эргэлт хийх оролдлого гаргаж түүнийг баривчилсан. Бослого гаргагчид түүхэн үйл явцыг ухрааж болзошгүй мэт сэтгэгдэл анхандаа төрж байсан ч Оросын холбооны улсын ерөнхийлөгч Б.Ельцин зэрэг зөвлөлтийн нэр хүнд бүхий зарим удирдагч хуйвалдагчдыг эсэргүүцэж төрийн эргэлт хийх гэсэн оролдлого бүтэлгүйтсэн юм.

Үйл явдал эрчтэй өрнөж Коммунист намыг эрх мэдлээс зайлуулж үйл ажиллагааг нь зогсоож

хөрөнгийг хураав. 1991 оны сүүл болоход бүх бүгд найрамдах улсууд бүрмөсөн тусгаарлаж ЗХУ аяндаа алга болов. М.Горбачёв 1991 оны 12 дугаар сард байхгүй болсон улсын ерөнхийлөгчийн албан тушаалаас огцров.

М.Горбачёвын удирдлага дор ЗХУ-д асар их өөрчлөлт гарсан, ер нь бол зөвлөлтийн эдийн засгийн үнэхээрийн ядуу дорой байдал дэлхийн том гүрнийг задран унах, коммунист тогтолцооог сүйрэхэд хүргэсэн гол шалтгаан байсан юм. Социализмын гол түшиг тулгуур болох ЗХУ-ын дотоодод гарч байсан нааштай өөрчлөлтүүд нь Дорнод Европийн социалист орнуудад ихээхэн нөлөөлж эдгээр орнууд өөрсдийн замаар урагшлах ёстой гэсэн зөвлөлтийн удирдагчийн удаа дараагийн мэдэгдэлд зоригжиж байлаа. 1989 оны аравдугаар сард Дорнод Германд олон нийтийн жагсаал эхэлж байдал туйлын эгзэгтэй болсон үед М.Горбачёв үйл явдалд биечлэн оролцож Дорнод Германий удирдагч Э.Хонеккерыг жагсагчдын эсрэг хүч хэрэглэхгүй байхыг ятгасан төдийгүй тус улсын нутаг дэвсгэр дээр байрлаж байсан зөвлөлтийн цэрэгт тус улсын дотоод хэрэгт оролцохгүй байхыг тушаасан юм.

Зэвсэглэлийг хорогдуулах, хүйтэн дайныг эцэс болоход М.Горбачёвын нөлөө маш их байлаа. Гэхдээ энэ үйл хэрэгт Р.Рейганы гавьяа их бий гэж үздэг хүмүүс бас бий. Зэвсэглэлээр хөөцөлдөхөд гарч байгаа зардлыг ЗХУ-аас илүү АНУ дааж гарч чадна гэдгийг бодитойгоор үзүүлж иймд хүйтэн дайныг зогсоох хэрэгтэй гэдгийг Р.Рейган зөвлөлтийн удирдагчдад ятган ойлгуулж чадсан хүн мөнөөс мөн. Гэвч Зэвсэглэлийг хорогдуулах гэрээ байгуулсны гавьяа М.Горбачёв, Р.Рейган нарт адилхан ногдоно.

Хүйтэн дайн нь АНУ, ЗХУ-д хоёуланд нь таагүй байсан гэж үзэж болохгүй. Сталиний түрэмгийлэх бодлогоос АНУ айж байснаас үүдэн хүйтэн дайн эхэлсэн юм. Зөвлөлтийн удирдагчид дэлхий даяар коммунист нийгэм байгуулахаар мөрөөдөж байсан үед Өрнөдөд зэвсэглэлээр хөөцөлдөхөөс өөр арга байгаагүй юм. ЗХУ-д коммунист хоосон мөрөөдлөөс татгалзсан удирдагч гарч ирснээр хүйтэн дайн аяндаа зогссон юм.

ЗХУ-д коммунист намын эрх мэдлийг багасгаж ил тод байдлыг зарлаж хэвлэн нийтлэх, үг хэлэх эрх чөлөөг нээж улс орныг нийтэд нь ардчилах үйл явцыг М.Горбачёв санаачлан биечлэн хийсэн гавьяатай юм. Ил тод байдал нь ЗХУ эцсийн эцэст задран бутрах гол үндэс суурь болсон юм.

Коммунист дэглэмийн ялагдлыг түргэсгэхэд хүргэсэн олон үйл явдал байдаг. Тухайлбал хуучин коммунист Артур Кестлер, Уиттакер Чемберс нар коммунист дэглэмийн жинхэнэ мөн чанарыг өрнөдийнхөнд тайлбарлан ойлгуулсан, зөвлөлтийн тэрс үзэлтэн Андрей Сахаров, Александр Солженицын нар Орос дахь "эрх чөлөөт" гэгдэгч нийгмийн үнэнийг хэлэх гэж амь насаараа дэнчин тавьж байлаа, Афганистан, Ангол, Никарагуа дахь партизанууд эдгээр улсад төрийн эрх мэдлийг коммунистуудад өгөхгүйн төлөө баатарлагаар тулалдаж байлаа, АНУ-ын улс төрийн удирдагч Гарри Трумен, Рональд Рейган нар америкийн зэвсэг, санхүүгийн арвин баялаг сан, америкийн эрх чөлөөний үлгэр жишээг коммунист дэглэмийг дэлхий даяар түгээхийн эсрэг, уг дэглэмийг бүрмөсөн ялахын төлөө ашиглаж байлаа.

Гэвч 1985 онд М.Горбачёв төрийн эрхэнд гарах үед коммунист дэглэм мөдхөн унах нь гэж хэн ч бодоогүй байсан билээ. М.Горбачёв төрийн өндөр албан тушаалд сонгогдох үедээ ЗСБНХУ-ыг бутран тараах, ЗХУКН-ын үйл ажиллагааг зогсоох зорилго тавьж байгаагүй юм.

Гэхдээ түүний явуулсан бодлого, хөдөлгөөнд оруулсан хүч нь дээрх зорилгыг биелэхэд хүргэсэн юм. Ийнхүү М.Горбачёв дэлхий ертөнцийн нүүр царайг эргэлт буцалтгүй өөрчилсөн билээ.

# 96. Мина

(MENES)

Манай эриний өтнөх 3100 он



Мина бол египетийн анхны угсааны захирагч, Египетийг анх нэгтгэж хүн төрөлхтөний соёл иргэншилд он удаан жилийн гайхамшигт үүрэг гүйцэтгэсэн улсыг үүсгэсэн хүн билээ.

Түүний төрсөн, нас барсан он тодорхойгүй боловч манай эриний өмнөх 3100 оны үед улс орноо захирч байсан ажээ. Тэр үед Египет улс нь нэгдмэл улс байгаагүй ба Нил мөрний хойд хэсэгт орших, нөгөө нь Нил мөрний өмнөд хэсэгт эрэг дагуу орших хоёр улсаас бүрдэж байжээ. Нил мөрний тэнгист цутгадаг хэсгийг

Доод Египет, өмнөд хэсэгт орших хэсгийг Дээд Египет гэж нэрлэдэг байжээ. Ер нь бол Доод Египет нь хойд хөршөөсөө илүү хөгжилтэй байжээ. Ийм учраас Дээд Египетийн хаан Мина хойд хэсгээ эзэлж эх орноо нэгтгэж чадсан билээ.

Мина өмнөд Египетийн Тинис хотоос гаралтай ба эх орныхоо хойд хэсгийг байлдан дагуулсны дараа Дээд болон Доод Египетийн хаан гэсэн цолоор өргөмжлөгдсөн нь бараг мянгаад жил үе дамжсан билээ. Эх орныхоо хоёр хэсгийнхээ хуучин хилийн ойролцоо Мемфис хэмээх шинэ хот байгуулсан нь байрлалын-хаа хувьд нэгдсэн улсын нийслэл байхад яг тохирч байжээ. Өнөөгийн Каир хотоос холгүй балгас нь оршин байгаа Мемфис хот нь Египетийн тэргүүлэх хот байсан ба түүхийн урт удаан хугацаанд тус улсын нийслэл байжээ.

Мина улс орноо 62 жил захирсан тухай мэдээ байдаг нь бяцхан хэтрүүлэг байх. Тэр үеийн тухай бидэнд байгаа мэдээлэл хомс авч Минагийн хүрсэн амжилт бахархам их ажээ. Тэр үед египетийн соёл нь өнөөгийн Ирак улсын нутаг дэвсгэр дээр байрлаж байсан шумерийн соёл иргэншлээс дорой хөгжилтэй байсан ба Египет улсыг нэгтгэсэн нь тус ард түмэнд далд нуугдмал байсан асар их хүчийг сэт татан ил гаргасан юм. Египет нь нэгдмэл улс болсноор нийгэм, соёлын салбар хөгжлийн өндөр түвшинд хүрсэн. Мина угсааны хаадын үед хөгжсөн засгийн газар, нийгмийн байгууллагууд нь хоёр мянга гаруй жилийн хугацаанд зарим өөрчлөлтийг эс тооцвол хэвээр байсан юм.

Тэрчилэн ханз үсэгтэй цагаан толгойг боловсронгуй болгож барилга, техникийн салбаруудад ихээхэн дэвшил гарчээ. Хэдхэн зууны хугацаанд египетийн соёл шумерийн соёл иргэншлийн түвшинд зэрэгцэн очиж бүр давж гарчээ. Мина хааны дараах хоёр мянга гаруй жилийн хугацаанд Египет улс баян, соёлын хувьд дэлхийн хамгийн хөгжингүй орон байсан. Ийм үзүүлэлт өөр ямар ч соёл иргэншилд байхгүй билээ.

Египетийн хаад ноёд бол нэр төдий биш чухамдаа асар их эрх мэдэлтэй хүмүүс байжээ. Мина чадварлаг удирдагч байсны үр дүнд эзлэн түрэмгийлсэн газар нутгаа хэвээр хадгалж тэр үед болсон аугаа үйл явдлуудын чухал хүчин зүйл байж эх орныхоо нүүр царайг танигдашгүй болтол нь өөрчилсөн билээ.

# 97. Их Карл

(CHARLES THE GREAT)

742-814



Дундад зууны үеийн гарамгай улс төрийн зүтгэлтэн Их Карл бол Францийн хаан, Саксониыг байлдан дагуулагч, Ромын эзэнт гүрнийг үндэслэн байгуулагч, европийн түүхийн аугаа удирдагчдын нэг байсан билээ.

742 онд хожим нь нийслэлээрээ өргөм-жилсөн Аахен хотын ойролцоо төржээ. Түүний эцэг нь алдарт Дөлгөөн Пипин, өвөө нь бол 732 онд Тур хотын дэргэд болсон байлдаанд ялалт байгуулж лалын шашинтнуудын зүгээс Францийг эзлэх гэсэн оролдлогыг тас цохисон францчуудын нэрт удирдагч Карл Мартелл байжээ. Эцэг Пипин нь 751 онд Францийн хаанаар заларч хүч дорой Меровингийн угсааг төгсгөл болгож Карлын шинэ угсааг үндэслэжээ.

Пипин хаан 768 онд өөд болж түүний улс орныг хүү Карл, түүний ах Карломан хоёр хуваан авав. Нэгдмэл Франц улс бүрэлдэн бий болоход аз болоод ч гэх үү ах Карломан нь 771 онд гэнэт нас баржээ. Ийнхүү Карл 29 настайдаа тухайн үед европ тивд хамгийн хүчтэйд тооцогдож байсан Франц улсын хаан болов.

Түүнийг хаанаар тодрох үед эзэмшил улсын нутаг дэвсгэр нь үндсэндээ өнөөгийн Франц, Бельги, Швейцар улсууд болон Голланд, Германы нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг байжээ. Цаг алдахыг хүссэнгүй, нутаг дэвсгэрээ өргөжүүлэх зорилго тавив. Карломаны бэлэвсэн хатан хүүхдүүдээ дагуулан Италийн хойд хэсэгт орших Ломбардын хаант улс руу оргов. Карл Ломбардын хаант улсаас авчирсан хатан Дезидератагаас салж армия удирдан Хойд Италид



халдаж 774 онд бүрэн эзлэв. Карломаны бэлэвсэн хатан хүүхдүүдтэйгээ олзлогдож тэр үеэс тэднийг хэн ч дахин олж хараагүй байна.

Карл хааны хувьд Германы умард хэсэгт орших Саксоны том газар нутгийг эзлэх илүү чухал, илүү хэцүү төвөгтэй байлаа. 772 оноос 804 онуудад нийтдээ 18 удаа довтолгоон хийж цус урсгасан байлдаан хийж байж сая нэг тавьсан зорилгодоо хүрчээ. Бөө мөргөлтэй саксончуудыг христос шашинд орохыг шаардаж татгалзсан хүмүүсийг цаазлах зэргээр тус улсын хүн амын бараг дөрөвний нэгийг цааш харуулсан байна.

Үүний дараа Германий өмнөд хэсэг, Францийн баруун өмнөд нутгийг байлдан дагуулж эзэмшил нутгийнхаа дорнод хил хязгаарыг аюулгүй болгох зорилгоор өнөөгийн Унгар, Югославын нутаг дэвсгэр дээр оршин тогтнож байсан азийн ард түмэн болох аварын эсрэг хэд хэдэн байлдаан хийж ялжээ. Саксон, Баварын дорнод хэсгийг эзлэж чадаагүй ч түүний эзэмшил нутаг Германий дорнод мужуудаас Хорват хүртэлх өргөн нутгийг хамарч байлаа.

Баруун хилийнхаа аюулгүй байдлыг хангахын тулд 778 онд Испанид халдан довтолж ялагдал хүлээсэн ч тус улсын хойд хэсэгт ихээхэн газар нутгийг эрхшээлдээ оруулж амжжээ.

Карл хаанчлалынхаа 45 жилийн хугацаанд 54 дайн байлдаан хийж Европийн дийлэнх хэсгийг эрхшээлдээ оруулсан байна. Нэр хүндийнхээ оргил үед эзэнт улсынхаа бүрэлдэхүүнд одоогийн Франц, Герман, Швейцари, Австри тэрчилэн Италийн хэсгийг багтааж байсан нь Ромын эзэнт гүрэн мөхөснөөс хойшхи европийн олон орнууд нэг улсын хяналтад орсон анхны тохиолдол байлаа.

Их Карл хаанчлалынхаа бүхий л үеийн туршид Ромын хамба ламтай улс төрийн нягт холбоотой байв. Энэ холбоонд тэргүүлэх үүргийг Их Карл гүйцэтгэж байлаа.

800 онд Ром хотод болсон Христосын мэндэлсний баяраар гуравдугаар Лев хамба лам Их Карлыг Ромын эзэнт гүрний хаанаар өргөмжилж хааны титэм гардуулав. Энэ бол гурван зуугаад жилийн тэртээ мөхсөн Баруун Ромын эзэнт улсыг сэргээж Их Карлыг Август

Цезарийн залгамжлагч гэж зарласан хэрэг байв.

Гэхдээ Их Карлыг Баруун Ромын эзэнт гүрний хаан гэж үзэх нь утга учиргүй юм. Тус хоёр эзэнт гүрний нутаг дэвсгэрийн хэмжээ эрс ялгаатай байв. Их Карлын эзэнт гүрний нутаг дэвсгэр хичнээн том ч гэлээ Баруун Ромын эзэнт улсын нутаг дэвсгэрийн тал хэсэгт дөнгөж хүрч байжээ, тухайлбал Англи, Испани, өмнөд Итали, Хойд Африкийг Их Карл хэзээ ч эрхшээлдээ оруулж байсангүй. Түүнээс гадна Карл гарал үүсэл, үзэл бодол, соёлоороо хэзээ ч ромын иргэн байгаагүй юм. Франц бол тевтоны омог ба Их Карл хожим нь латынаар ярьж сурсан ч түүний төрөлх хэл нь хуучин герман хэл байсан. Амьдралынхаа дийлэнх хугацааг Хойд Европт, голдуу Германд өнгөрөөжээ. Эзэнт улсынх нь нийслэл Ром биш орчин үеийн Герман улсын нутаг дээр, Голланд, Бельгийн хилийн ойролцоо орших Аахен хот байсан.

Залгамжлагчийн тухай асуудлыг шийдвэрлэх цаг ирэхэд Их Карл хаан улс төрийн ердийн заль мэх хэрэглэсэн нь их хор уршиг тарьсан. Эзэнт гүрнээ гурван хүүдээ хуваан захируулахаар болжээ. Гэтэл хоёр том хүү нь урьтаж өөд болж отгон хүү Луи нь залгамжлагч нь болжээ.

Хүү нь эцгийгээ дууриаж эзэнт гүрнээ хөвгүүддээ гурван хуваан захируулахаар болж 843 онд Вердений гэрээ байгуулжээ. Уг гэрээгээр ууган хүү нь орчин үеийн Францийн дийлэнх хэсэг, хоёр дах хүү нь одоогийн Германий дийлэнх хэсэг, отгон хүү нь Умард Итали, франц-германы хилийн дагуух өргөн зурвас хэсгийг захирах болжээ.

Их Карл хааны түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар эрдэмтэд өнөөдөр ч ихээхэн маргалдсаар байна. Ромын эзэнт улсыг сэргээсэн гэдэг нь хэтрүүлэг юм. Чухамдаа эцгээсээ өвлөн авсан газар нутгаа л өргөжүүлсэн хэрэг. Түүнийг Ромд Баруун Ромын эзэнт гүрний хаанаар өргөмжилсөн нь үнэхээр чухал үйл явдал болохоос биш иргэний засаг захиргаа болон сүм хийд хоорондын олон зуун жилийн тэмцэлд шийдвэрлэгч хүчин зүйл болоогүй юм. Гэхдээ Баруун Ромын эзэнт гүрэн нь XIX зууны эхэн үе хүртэл Европийн түүхэнд бага ч атугай тодорхой нөлөө үзүүлсээр байсан. Хэрэвзээ Их Карл Баруун Европийг бүхэлд нь нэгтгэж чадсан бол чухал ач холбогдолтой үйл хэрэг болох байсан юм, гэтэл биечлэн байгуулсан эзэнт гүрэн нь түүнийг нас барснаас гучин жилийн дараа задарч дахин ер сэргээгүй юм.

Гэсэн хэдий ч Их Карл хааны Европийн түүхэнд богино хугацаанд үзүүлсэн нөлөө асар их байсныг үгүйсгэж хэрхэвч болохгүй. Тэр Ломбардын хаант улс, Аварын улсыг довлон устгаж хамгийн гол нь Саксонийг байлдан эзлэж европийн соёл иргэншлийн үндсэн урсгалд татан оруулсан билээ. Түүний хаанчлалын үед соёлын хөгжил богино хугацаатай боловч ихээхэнд дэвшилд хүрчээ.

# 98. Гомер

(HOMER)

Манай эриний өтнөх VIII зууны орчит



Дэлхийн сонгодог уран зохиолын охь манлай болох "Илиада", "Одиссей" найраглалыг Гомер зохиосон эсэх талаар хэдэн зууны турш маргаан үргэлжилсээр байна. Чухамдаа хэн гэдэг хүн хэдийд дээрх хоёр найраглалыг туурвисан юм бэ, нэг үү нэг хэсэг уран бүтээлч бичив үү, Гомер гэдэг хүн ер нь байсан юм уу гэсэн асуултуудын талаар судлаачид янз бүрийн таамаглал дэвшүүлж өнөө хэр нэг мөр ойлголтод хүрээгүй байна. Гэхдээ дээрх хоёр найраглалыг Гомер гэдэг хүн зохиосон гэдэг талаар дараах багтай таамаглал байдаг.

Нэгдүгээрт "Илиада" найраглалыг зохиогч нь ганц хүн, уг найраглалыг судалж үзэхэд хэд хэдэн хүн хамтран зохиосон гэж үзэх ямар ч үндэслэл байхгүй. Грекийн бусад яруу найрагч өөрөөс нь өмнө хэдэн зууны туршид богино хэмжээний найраглал туурвиж байсан туршлага дээр үндэслэж хамгийн шилдгүүдийг нь сонгон нэгтгэж өөрчлөн нэмж Гомер яруу найрагчийн суут авьяасаа гаргаж шилдэг бүтээлээ туурвисан. Тэрбээр YIII зуунд амьдарч байсан бололтой.

Алдарт "Одиссей" найраглалыг түүнийг мөн зохиосон гэж үзэж болно. Энэхүү найраглалын бичлэгийн найрууллага нь "Илиада" найраглалаас ялгаатай, өөр хүн туурвисан байж магадгүй гэж таамаглаж болох боловч нарийвчлан судлахад адил зүйлүүд нь ялгаатайгаасаа харьцангуй илүү байна.

Гомерийн намтрын тухай мэдээлэл их хомс, түүнийг сохор хүн байсан гэдэг. Гэхдээ хоёр найраглалын дүрслэлийг судлахад төрөлхийн сохор хүн биш байсан бололтой. Найраглалуудын хэллэгээс үзэхэд, зохиогч нь Эгийн тэнгисийн зүүн эргийн Ионий нутгаас гаралтай хүн байжээ.

Нийтдээ 28 мянган шад мөр бүхий хоёр найраглал нь анхандаа аман хэлбэрээр зохиогдсон ч тэр даруй нь цаасан дээр буулгасан бололтой. Энэ хоёр найраглал нь манай эриний өмнөх YI зуун гэхэд л сонгодог бүтээл гэж алдаршиж байсан ч Гомерийн намтрын тухай мэдээлэл нь яагаад ч алга болжээ. Грекүүд "Одиссей", "Илиада" гэсэн хоёр найраглалыг үндэсний аугаа

бүтээл гэж бишрэн шүтдэг болсоор бараг хоёр мянга гаруй жил болж байна. Энэ хугацаанд уран зохиолын бичлэгийн арга барилд өчнөөн төчнөөн өөрчлөлт гарсан ч Гомерийн алдар хүнд хэзээ ч гандан буурч байсангүй.

Гомерийн бүтээлүүдийг өнөө үед оюутнууд л судалдаг ба коллеж, их сургууль төгссөний дараа уншдаг, зохиолоос нь ишлэл авдаг хүн бараг байхгүй болсон нь үнэн. Тийм учраас бид өнөөдөр яагаад Гомерийг өндөр үнэлээд байгаа юм бэ? гэсэн асуулт зүй ёсоор тавигдана. Нэгдүгээрт гэвэл хүн төрөлхтөн хэдэн зууны туршид Гомерийн яруу найргийн бүтээлүүдийг уншин таашаал авсаар байлаа, түүний тухай сонссон хүн хэмжээлшгүй их олон. Эртний ертөнцөд түүний найраглалууд өнөө үеэс илүү өргөн дэлгэрсэн байсан.

Өнөөдөр ч гэсэн Грек улсын хүн амын дийлэнх нь Гомерийн зохиолуудыг мэддэг, түүний бүтээл ард түмний шашин, ёс суртахууны хэм хэмжээнд удаан хугацаанд нөлөө үзүүлсээр иржээ. "Одиссей", "Илиада" найраглалуудыг уран зохиол сонирхогчид төдийгүй цэргийн, улс төрийн зүтгэлтнүүд хүртэл шимтэн уншаар байжээ. Эртний грекийн олон алдартай удирдагчид түүнээс ишлэл татдаг байсан ба Александр Македонский аян дайны үед "Илиада" найраглалыг байнга уншиж зориг нэмдэг байжээ. Өнөөдөр Гомерийн уран бүтээлийг шимтэн уншдаг хүмүүс дэлхий даяар мөн л олон байна.

Гомерийн дэлхийн уран зохиолд үзүүлсэн нөлөө асар их билээ. Грекийн бүх сонгодог яруу найрагч, жүжгийн зохиолч түүний нөлөөнд байсан ба Софокл, Еврипид, Аристотель нар түүний уламжлалаар уран бүтээлээ туурвиж уран зохиолчийн ур чадвараас нь суралцаж байжээ.

Эртний ромын уран бүтээлчид ялангуяа яруу найрагчид түүний яруу найргийг сонгодог үлгэр жишээ болгон дээдлэн суралцаж байлаа. Ромын хамгийн аугаа зохиолч болох Вергилий "Энеиду" хэмээх суут бүтээлээ бичихдээ Гомерийн "Илиада", "Одиссей" найраглалуудыг үндэс болгож байв.

Өнөө үед орон бүрийн зохиолч болгон Гомер түүний нөлөөнд автсан Софокл, Вергилий нарыг уншиж байж шилдэг уран бүтээл туурвих оюуны цэнэг авсаар байна. Дэлхийн түүхэнд Гомер шиг өргөн дээд хүндэтгэл хүлээсэн, удаан хугацааны нөлөө үзүүлсэн яруу найрагч байхгүй.

XIX, XX зуунуудад хүн төрөлхтөн Гомероос илүү Л.Толстойг л уншсан байх, гэхдээ Гомерийг бараг 2700 зуун жил уншиж судалсаар байна. Энэ бол түүхийн дэндүү урт хугацаа юм. Хүний оюун ухааны бусад салбарт энэ үзүүлэлтээр Гомертой өрсөлдөх өөр аугаа хүн байхгүй билээ.

# 99. Нэгдүгээр Юстинин хаан

(JUSTINIAN I)

483-565



Төрийн эрх барьж байх хугацаандаа Ромын эзэнт гүрний хуулиудыг эмхэтгэсэн хүн бол Юстиниан хаан билээ. Хууль зүйн салбар дахь ромын суут ухаантны бүтээл нь хожим нь Европийн олонхи оронд хууль зүй хөгжих үндэс болсон юм. Түүний эмхэтгэсэн хууль шигхүн төрөлхтөний хөгжилд их түлхэц өгсөн өөр хууль эрхийн баримт байхгүй билээ.

483 оны хавьд одоогийн Югослав улсын нутаг дэвсгэр дээр орших Торесим хотод, цэргийн албаар дамжин Дорнод Ромын эзэнт гүрний хааны суудалд заларсан бараг бичиг үсэггүй тариачин асан нэгдүгээр Юстин хааны ач хүү болон мэндэлжээ. Юстиниан тариачин гаралтай өвөөгийнхөө ачаар сайн боловсрол эзэмшиж албан тушаал түргэн ахижээ. Төрсөн хүүхэдгүй байсан нэгдүгээр Юстин хаан 527 онд Юстинианийг хамт хааны эрх мэдэл баригч болгожээ. Гэвч мөн оны сүүлчээр нас барж Юстиниан хаанаар тодорч 565 онд нас барах хүртлээ төрийн эрх мэдлийг дангаар барьжээ.

Юстинианыг нас барахаас долоо жилийн өмнө, 476 онд Баруун Ромын эзэнт улс германы бүдүүлэг омгуудын дайралтаас болж бүрмөсөн мөхсөн ч Константинополь нийслэлтэй Дорнод Ромын эзэнт гүрэн нь оршин тогтносоор байв. Иймд нэгдүгээр Юстиниан хаан умард хэсэгт алдагдсан газар нутгаа эгүүлэн авч эзэнт гүрнээ бүхлээр нь сэргээх зорилгод бүхий л үйл ажиллагаагаа зориулж багахан амжилт олж Итали, Хойд Африк, Испанийн хэсгийг л бүдүүлэг омгийнхноос булаан авчээ.

Гэхдээ Юстиниан хаан цэргийн жанжны авьяас чадвараараа биш чухамдаа ромын хуулиудын эмхэтгэл зохиосон гавьяагаараа дэлхийн суут хүмүүсийн жагсаалтад орж байгаа юм. 528 онд хаанаар өргөмжлөгдсөний дараа эзэнт улсын хуулиудын эмхэтгэл зохиох зөвлөл байгуулжээ. Тус комисс анхны эмхэтгэлээ 529 онд гаргаснаа улам баяжуулж 534 онд бүрэн хэвлэжээ. Тэрхүү хуулиудын эмхэтгэлд ороогүй бүх хууль, дүрэм журмыг 534 оноос хүчингүйд

тооцжээ.

Энэ эмхэтгэл нь "Иргэний хуулиудын цогц" гэдэг номын эхний хэсэг болсон ба "Юстинианийн эмхэтгэл" хэмээх хоёрдугаар хэсэг нь ромын алдарт зохиолчдын үзэл бодлын товч хураангуй байв. "Батлагдсан хуулиуд" нэртэй гурав дахь хэсэг нь хэвлэгдсэн даруйдаа хуульч оюутнуудын ширээний ном болжээ. Энэхүү хуулиудын эмхэтгэл хэвлэгдсэний дараа Юстинианийн баталсан хуулиудыг мөн эмхэтгэж өөд болсны нь дараа нь хэвлүүлжээ.

Дайн байлдаан удирдах, засаг захиргааны ажлаа амжуулах гээд асар их үүрэгтэй Юстиниан хаан ромын хуулиудын эмхэтгэлийг биечлэн зохиогоогүй нь мэдээж хэрэг ба энэ их чухал, нүсэр ажлыг түүний зарлигаар байгуулагдсан алдарт хуульч Трибонийг удирдсан эрдэмтдийн баг хийж гүйцэтгэсэн юм.

Юстиниан ховорхон дайчин удирдагчийн хувьд засаг захиргааны салбарт өөрчлөлт хийхэд онцгой анхаарч тухайлбал засгийн газрын түвшинд хээл хахууль явах явдлын эсрэг тууштай тэмцэл явуулж байжээ. Тэрчилэн худалдаа, аж үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжиж барилга байгууламжийн том хөтөлбөр хэрэгжүүлэхэд биечлэн оролцжээ. Түүний санаачилга, оролцоотойгоор олон цайз, сүм хийд түүний дотор Константинополь хот дахь Гэгээн София сүмийг барьж сэргээж байжээ. Бүтээн байгуулалтын их ажил, байнгын дайн байлдаанд асар их мөнгө зарцуулж байсан юм.

Тэрхүү их зардлыг татвар нэмэх замаар хуримтлуулж байсан нь олон түмний дургүйцлийг хүргэж 532 онд бослого гарч Юстиниан золтой л алагдчихаагүй ажээ. Бослогыг дарсан ч ард түмний дургүйцэл намдсангүй. Түүнийг 565 онд нас барахад олон түмэн хязгааргүй баяр хөөр болж байжээ.

Нэгдүгээр Юстиниан хааны тухай өгүүлэхдээ түүний хатан авьяаслаг бүсгүй Феодорагийн тухай дурдахгүй өнгөрч болохгүй. 500 оны үед төрсөн Феодора бүсгүй залуудаа жүжигчин, биеэ үнэлэгч бүсгүй байж нэг хүүхэд төрүүлсэн байв. Хорь гарч явахдаа Юстиниантай учирч түүний нууц амраг байснаа 525 онд хатан нь болжээ. Юстиниан хатныхаа хосгүй авьяас чадвар, гоо үзэсгэлэнг биширч хаанаар өргөмжлөгдсөнийхөө дараа шадар зөвлөхөө болгож дипломат үүрэг хариуцуулж байв.

Хаан нөхрийнхөө хууль эрх зүйн төслүүд түүний дотор эмэгтэйчүүдийн байдал, эрхийг сайжруулахад чиглэсэн хуулийн төслийг батлуулахад Феодора хатан ихээхэн нөлөө үзүүлж байжээ.

Түүнийг 548 онд нас барахад Юстиниан хаан үнэхээр их харамссан байна. Феодора хатан гоц ухаан төдийгүй гоо үзэсгэлэнгээрээ алдартай бүсгүй байсан тул олон уран бүтээлч түүний дүрийг урлагийн бүтээлээрээ мөнжүүлсэн юм.

Юстиниан хааны зарлигаар бий болгосон хуулиудын эмхэтгэл нь ромын эрх зүйн нэр хүндтэй илэрхийлэл болсон төдийгүй Византийн эзэн гүрний хувьд олон зууны туршид чухал ач холбогдолтой байсан. Өрнөдөд энэхүү хуулийн эмхэтгэлийг бараг таван зуун жил ор тас мартсаны хойно 1100 оны үеэс Италийн их сургуулиудад сэргээн судлах болжээ. Дундад зууны сүүлч үеэс ромын хуулиудын эмхэтгэл нь эх газрын европийн хууль эрх зүйн

тогтолцооны хөгжлийн үндэс суурь болсон билээ. Энэхүү эмхэтгэлийг судалж байсан орнууд англи хэлтэй орнуудад голдуу ноёрхож байсан нийтлэг тогтолцоог хаяж иргэний эрхийн толцолцоог хэрэглэх болжээ. Гэхдээ аль ч орон ромын хуулиудын эмхэтгэлийг шууд хуулбарлан хэрэглэж байгаагүй ба ихэнхдээ иргэний эрх болгон хувиргаж байлаа.

Тэрчилэн эрхийн салбарт судалгаа хийхэд үндэс болгон ашиглаж байсан. Эцсийн эцэст европийн бус олон орон иргэний эрхийг хүлээн зөвшөөрсөнд ромын хуулиудын эмхэтгэлийн гол ач холбогдол оршдог билээ.

Гэхдээ ромын хуулиудын эмхэтгэлийн ач холбогдлыг хэтрүүлэн үнэлж болохгүй. Энэ эмхэтгэлийг гарахаас өмнө иргэний эрхийн хөгжилд нөлөөлсөн хүчин зүйлүүд мөн байсан. Тухайлбал гэрээ байгуулахтай холбогдсон хуулиуд нь худалдааны практик, худалдааны усан онгоцуудын шийдвэрээс үүсэлтэй болохоос ромын хуулиудын эмхэтгэлтэй огт холбоогүй юм. Германий шашны эрх нь иргэний эрхийн хөгжилд мөн нөлөө үзүүлсэн. Өнөө үед европийн хуулиуд, эрх зүйн тогтолцоо мэдээж их өөрчлөгдсөн. Ихэнх орон дахь эрх зүйн тогтолцоо Юстинианий ромын хуулиудын эмхэтгэлээс эрс ялгаатай байна.

# 100. Махавира

(MAHAVIRA)

Манай эриний өтнөх 599- 527 онуудын орчит



Жайнизмын шашны бишрэн шүтэгчид Вардхамана Махавираг ("их баатар" гэсэн утгатай үг) уул шашныг үндэслэгч гэж дээдэлдэг

Вардхамана нь манай эриний өмнөх 599 онд хойд Энэтхэгийн, нэгэн үеийн дараа Гаутама Будда төрж байсан тэр нутагт мэндэлжээ. Энэ хоёр аугаа хүний амьдралын замнал их адилхан. Вардхамана бол омгийн удирдагчийн отгон хүү, Гаутамагийн адил тансаг нөхцөлд өсөж торнижээ. 13 настай байхдаа баян чинээлэг амьдрал ахуйгаасаа татгалзаж эхнэр, охиноо хаяж оюуны үнэн, сэтгэлийн таашаал эрж олох замд шулуудан оржээ.

Хүн амын хувьд цөөхөн ч шашны их шүтлэгтэй Парсванатха хотхонд лам болж арван хоёр жил ядуу, даянч хүний амьдралаар амьдарч бясалгал хийжээ. Голдуу мацаг барьж ямар ч эд хогшилгүй, заримдаа ус уух шанага, хоол гуйх аяга, таваггүй байдаг байв. Анхандаа ганц өмд байсан нь алга болсноор дандаа шалдан явдаг болжээ. Биеэр нь шавьж хорхой явахад хүртэл тэдний өрөвдөн авч хаях алахыг цээрлэдэг байв.

Тэнүүлчин хүмүүс ердийн үзэгдэл байдаг Энэтхэгт Махавирын даянч амьдрал хүмүүсийн гайхшийг төрүүлж байлаа.

Махавира 42 настайдаа оюуны гэгээрэлд хүрсэн гэж үзэж амьдралынхаа үлдсэн гучин жилийг биечлэн хүрсэн оюун ухааны сургаалаа сурталчлан дэлгэрүүлж өнгөрөөжээ. 527 онд өөд болоход нь шавь нар нь маш олон болсон байв.

Махавирын сургаал зарим утгаараа будда, индуизмийн шашинтай их төстэй. Түүний сургаалыг бишрэн шүтэгч жайнууд хүний бие үхэхэд түүний сүнс амьд үлдэж өөр биед, гэхдээ заавал хүний биед биш шилждэг гэж үзнэ. Сүнс шилжих номлол нь жайнизмын шашны сэтгэлгээний үндсийн үндэс ажээ. Хүний аливаа үйлдлийн ёс зүйн хор уршиг түүний ирээдүйд их нөлөөтэй гэсэн карма хэмээх номлолд жайнизмыг шүтэгчид итгэнэ.



Жайнизмын шашны гол зорилго нь хүний сэтгэлд хуримтлагдсан их гэм зэмийг арилгаж сэтгэл санааг ариусгах явдал ажээ. Тухайлбал мэдрэмжийн жаргалаас татгалзаж сэтгэлээ ариусгаж болно гэж Махавира сургажээ.

Жайнизмын шашны лам нар хүнээс ангид даянчлан амьдрахыг бүхнээс эрхэмлэнэ. Бараг амьсгаа хураах хүртлээ зориуд өлсөхийг бахдан сайшаана.

Жайнизмийн шашны маш нэг чухал номлол нь ахизм буюу хүчирхийллийн аргаас татгалзах явдал юм. Ахизм номлол нь амьтан болон хүнд хүчирхийллийн аргаар хандахаас татгалзах гэсэн утгатай ажээ. Ийм учраас жайнизмийн шашныг бишрэн шүтэгчид цөмөөрөө цагаан хоолтонгууд юм. Тэд жинхэнэ жайнизмын шашинтан хүн ялаа алахгүй, хорхой шавьж санамсаргүй залгихаас болгоомжилж харанхуйд хоол идэж болохгүй гэж үзнэ. Жайнизмын шашны бишрэн шүтэгч баян хүн санамсаргүй байдлаар хорхой, шавьж, чийгийн улаан хорхой гишгэж алахгүйг хичээж гүүрээр гарахын өмнө хүн хөлсөлж шүүрдүүлэн цэвэрлүүлнэ.

Тэд газар ухахыг цээрлэдэг тул газар тариалан эрхэлдэггүй, ер нь биеийн хөдөлмөрийн олон хэлбэрийг хориглоно. Энэ утгаараа жайнизмын шашин нь шашны номлол нь бүлэг хүмүүсийн аж төрөх ёсонд хэрхэн гүн гүнзгий нөлөө үзүүлдэгийн сонгодог жишээ болдог юм. Жайнизмын шашинтангууд үржил шимтэй нутагт аж төрөн суудаг ч олон зууны туршид худалдаа арилжаа хийж санхүүгийн үйл ажиллагаа хийж амьжиргаагаа залгуулсаар байна. Тэд аж үйлдвэржүүлэлтийг бол сайшаадаг учир Энэтхэг улсын оюун санааны болон соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож боловсролтой сайтай бүлэг хүмүүсийн тоонд зүй ёсоор багтана.

Жайнизмын шашинд анхандаа нийгмийн дээд, доод бүлгийн ойлголт байгаагүй ч индуизмын шашинтай байнга холбогдсоор илүү хатуу зааг тогтоожээ. Бурхан байдаг тухай Махавира хэзээ ч сургаал айлдаж байгаагүй ч индуизмын шашныг дууриан бурхныг дээдлэн шүтэх болжээ. Тэгээд ч Махавирын сургаалийн бичмэл эх сурвалж хадгалагдан үлдээгүй тул индуизмын шашнаас нилээд олон номлолыг зээлдэн авсан нь үнэн. Амьтдыг үл алах, мах идэхгүй байх зэрэг жайнизмын шашны сургаал мөн индуизмын шашинд нөлөөлсөн бололтой. Хүчирхийлийн аргаас татгалзах тухай жайнизмын шашны номлол нь энэтхэгийн ард түмний сэтгэлгээнд өнөө хэр нөлөө үзүүлсээр байна. Тухайлбал И.Ганди жайнист гүн ухааны нэрт төлөөлөгч Шримад Ражахандраг (1867-1900) оюун ухааны нэг эцгээ гэж дээдлэн үздэг байв.

Жайнизмын шашны бишрэн шүтэгчдийн бүлэг хэзээ ч олон тоотой байгаагүй ба өнөөдөр тэдний тоо 3,5 сая байна. 2500 жил оршин тогтносоор байгаа жайнизмын шашин нь бусад шашинтай харьцуулбал шүтэн бишрэгчдийхээ амьдралд хүчтэй нөлөө үзүүлсээр байна.

# НЭМЭЛТ АРАВ

ФОМА АКВИНСКИЙ

(ST. THOMAS AQUINAS)

1225-1274 оны орчит

Италийн гүн ухаантан Фома Аквинский бол шашны бүтээл нэн

ялангуяа католик шашны сургаалын хамгийн нэр хүнд тайлбар болох "Шашны нийлбэр" номоороо ихэд алдартай билээ.

Түүнээс өмнө гүн ухааны төгс төгөлдөр тогтолцооны тухай хэн ч тийм дэлгэрэнгүй, тийм нягт нарийн тайлбарыг бичиж байгаагүй билээ. Энэхүү суут сэтгэгчийн бүтээлүүдийн дийлэнх нь хийсвэр асуултуудаар дүүрэн болохоор уншиж ойлгоход төвөгтэй байдаг нь үнэн.

Ф.Аквинский ёс зүйн асуудлуудыг бүтээлүүддээ их анхаарч байсан ба католик шашны эртний номлолыг эмхэтгэсэн ч ёс зүйн болон улс төрийн үзэл бодолд том өөрчлөлт хийгээгүй юм. Түүнийг бүтээлийг уншаад католик шашинтан болсон хүн ховор байх, түүний бодол санаа хичнээн ухаалаг, зөв байсан ч хүмүүсийн сэтгэлгээ, түүхийн явцад хүчтэй нөлөө үзүүлж чадаагүй юм.

# Архимед

(ARCHIMEDES)

Манай эриний өтнөх 287- 212

Эртний түүхийн гайхамшигт математикч, эрдэмтэн Архимед нь хөшүүргийн зарчим, хүндийн хүчний төвийн зарчмыг нээсэн гавьяатай билээ.

Хөшүүргийн зарчим нь Архимедээс өмнө олон нийтэд тодорхой, өргөнөөр ашиглагдаж байсан, ялангуяа египетийн инженерүүд пирамид барихдаа түүнийг ихээхэн амжилттай хэрэглэж байсан. Гэхдээ Архимед бол хөшүүргийн үйл ажиллагааг тайлбарласан томъёог анх гаргасан эрдэмтэн юм.

Эд юмны нягтралын илэрхийлэл (эзлэхүүний нэгжтэй харьцуулсан жин) нь нийт жингээс ялгаатай болох нь Архимедээс өмнө мөн мэдэгдэж байв. Иймд шинэ хууль нээсэнгүй, харин тухайн салангид асуудлыг шийдвэрлэхэд хэрэглэгдэх чухал хавсарга санааг олжээ.

Математикчийн хувьд суут хүн байжээ. Интеграл тооны томъёоллыг нээхэд маш их дөхсөн ба тэр нээлтийг нь Ньютон арван найман зуун жилийн дараа хийсэн юм. Чухамдаа тэр үед математик тэмдэглэлгээний зохимжтой тогтолцоо байгаагүй учраас математикчийн хосгүй зөн билэгтэй ч эргэлтийн ач холбогдолтой нээлт хийж чадаагүй юм.

# Чарлз Баббеж

(CHARLES BABBAGE)

1792-1871

Английн зохион бүтээгч Чарлз Баббеж орчин үеийн том электрон тооцоолон бодох машин гарахаас бүтэн зуун жилийн өмнө тоон компьютерийн зарчмуудыг боловсруулсан байжээ. Зохион бүтээснийхээ дараа "аналитик хөдөлгүүр" гэж нэрлэсэн төхөөрөмжөөр нь орчин үеийн тооны машинуудын хийж байгаа бүх үйлдлийг хийж чадаж байв. Гэхдээ тэр үед цахилгаан гүйдэл байгаагүй болохоор хурд нь бага байжээ. Ихээхэн хөрөнгө зарцуулж байсан ч XIX зуунд техникийн хөгжил дорой байсан учир Баббеж аналитик хөдөлгүүрээ бүрэн дуусгаж чадаагүй юм. Түүнийг нас барсны дараа гайхамшигт санаа нь ор тас мартагджээ.

Тооны төхөөрөмж зохион бүтээх мөрөөдөлд автсан Гарвардын их сургуулийн оюутан Говард Г.Эйкеней анхаарлыг Баббежийн бүтээл 1037 онд гойд татав. Г.Г.Эйкен IBM компаний дэмжлэгтэйгээр 1944 онд анхны компьютер зохион бүтээж хоёр жилийн дараа хэсэг инженер, зохион бүтээгчид анхны цахилгаан тооцоолох машин ENIAC-ыг зохион бүтээлээ. Тэр үеэс компьютерийн техник маш их хурдацтай хөгжсөн билээ.

Тооцоолон бодох машин нь хүн төрөлхтөний хөгжилд ихээхэн түлхэц өгсөн болохоор би Ч.Баббежийн нэрийг дэлхийн түүхийн суут 100 хүний нэрсийн жагсаалтад оруулах гэж бодсоноо түүний хувь нэмэр Г.Эйкен, Ж.Мочли, Ж.П.Экерт нарынхаас илүүгүй учир больсон юм.

Тэд нараас бүр өмнө Францийн эрдэмтэн, математикч, гүн ухаантан Б.Паскаль 1642 онд нэмэх үйлдэл хийдэг механик машин зохиосон бол гүн ухаантан, германы математикч Готтфилд Вильгельм фон Лейбниц 1671 онд нэмэх, хасах, үржүүлэх, хуваах үйлдлүүд хийдэг машин бүтээсэн байна. Г.Лейбниц бинарын систем, орчин үеийн компьютерүүдэд өргөн хэрэглэж байгаа тэмдэглэлийн системийн ач холбогдлыг анх түүрүүнд олж харжээ.

Францийн зохион бүтээгч Жозеф Мария Жаккард нь XIX зууны эхээр нэхмэлийн төхөөрөмжийн ажлыг хянахад ашиглах шивэх хуудас бүхий төхөөрөмж зохиосон байлаа. Энэхүү төхөөрөмж нь үйлдвэрлэлийн талаас нь авч үзвэл маш чухал бүтээл болсон ба XIX зууны сүүлчээр шивэх хуудсыг хүн амын тооллогын хороонд тооцоо хийхэд ашиглаж эхэлсэн америкийн иргэн Герман Холлеритийн санаачилгад нөлөө үзүүлсэн байна.

Дээрх мэдээллээс дүгнэлт хийхэд орчин үеийн компьютерийг бий болоход олон хүн хувь нэмрээ оруулж байжээ.

# Хеопс

(CHEOPS)

Манай эриний өтнөх ХХҮI зууны орчит

Египетийн Хеопс хаан Аугаа Пирамид босгосноороо цуутай билээ. Түүний намтрын тухай мэдээлэл маш их хомс боловч манай эриний өмнөх ХХҮ! зууны үед Мемфис нийслэлтэй улс орноо захирч байжээ.

Аугаа Пирамид бол хүн төрөлхтөний бүтээсэн хамгийн гайхамшигт, хамгийн ач холбогдол бүхий барилга байгууламж гэдгийг хэн бүхэн хүлээн зөвшөөрнө. Дээр үед ертөнцийн долоон гайхамшигийн нэг гэж зүй ёсоор тооцогдож байсан ба өнөөгийн бидний үед хэвээр хадгалагдан ирсэн ганц гайхамшиг нь энэ билээ.

Дээр талаасаа 35 фут нь нуран унасан ч 450 фут өөрөөр хэлбэл 35 давхар байшингийн хэртэй өндөр нь, зохиомжийн төгс байдал нь өнөөдөр ч бидний бахархлыг төрүүлж байдаг. Тус бүр нь 2,5 тонн жинтэй ойролцоогоор 2300000 ширхэг чулуун хавтангаар Аугаа Пирамидийг барьжээ. Эртний египетчүүд өнөөгөөс дөчин зургаан зууны тэртээ орчин үеийн тоног төхөөрөмжгүйгээр хэрхэн Пирамидыг босгосон нь үнэхээр бахархалтай.

Энэхүү асар том барилга байгууламжийг босгохын тулд улс орныхоо нөөц бололцоог бүрэн дайчлах, маш нарийн төлөвлөлт хийх, удирдах болон зохион байгуулах өндөр ур чадвар шаардагдсан нь мэдээж хэрэг. Аугаа Пирамидыг барих ажил нийтдээ хорь гаруй жил үргэлжилсэнээр нь тооцоолж үзэх юм бол өдөрт дунджаар 300 чулуун хавтан байрлуулж байжээ. Тийм тооны чулуун хавтанг зүсэж тээвэрлэн авчраад, зохих хэлбэрт нь оруулж өнгөлж яг таг байрлуулах нь маш төвөгтэй ажил байсныг төсөөлөхөд бэрх билээ. Тэрчилэн Пирамид барих их ажлыг нугалж байгаа хүмүүсийг хувцас, хоол, байраар хангах гээд олон том асуудал гарч байсан нь мэдээж.

Аугаа Пирамид баригдаад 4500 гаруй жил болж байгаа ба хойшид байсаар байх нь ойлгомжтой. Гэхдээ Пирамид аажимдаа нурж байгаа боловч орчин үеийн эвдрэлтийн тооцоогоор бол ахиад нэг сая жил хэвээр байх ажээ.

Ийм учраас Аугаа Пирамидийг анх сэдэж, барих ажлыг зохион байгуулснаараа Хеопс хаан энэ дэлхий дээр хэн ч маргахааргүй их гавьяа байгуулжээ.

# Мария Кюри

(MARIE CURIE)

1876-1934

Жинхэнэ нэр нь Мария Склодовская болох Мария Кюри бол шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой бүтээлийг эмэгтэй хүн туурвисан

гэдгээрээ юуны түрүүнд алдартай билээ. Эмэгтэй хүн суурь шинжлэх ухаанаар судалгаа хийж гарамгай амжилтад хүрч болохыг амьдрал, үйл ажиллагаагаараа үнэмшилтэй нотлон харуулсан юм. Цацраг идэвхт чанарыг нээснийг Мария Кюригийн нэртэй холбох тохиолдол байдаг. Энэ бол буруу ойлголт.

Цацраг идэвхт чанарыг анх францийн физикч Антуан Анри Беккерель нээсэн юм. Түүний бүтээлийг уншиж танилцсанаас хойш л Мария Кюри тэр сэдвээр судалгаа туршилт хийж эхэлсэн юм.

Химийн элемент радийг нээж гаргаж авсан нь М.Кюригийн хамгийн том ололт юм. Түүнээс өмнө бас нэг цацраг идэвхт бодис нээж төрөлх эх орон Польшийнхаа нэрээр полоний гэж нэрлэсэн юм. Эдгээр нээлт нь үнэхээр гайхамшигтай ч шинжлэх ухааны хөгжилд шийдвэрлэх ач холбогдолтой байгаагүй юм.

Мария Кюри 1903 онд эхээр нөхөр Пьер Кюри, хамтран зүтгэгч А.А.Беккерелийн хамт физикийн салбар дахь Нобелийн шагнал хүртсэн бол 1911 онд химийн салбар дахь мөн шагналыг авч энэ шагналаар хоёр удаа шагнуулсан анхны эмэгтэй болсон билээ.

Мария Кюри бяцхан хүүхдүүдтэй байсан ч судалгааны ажлаа эрчимтэй хийсээр өндөр амжилтад хүрсэн хосгүй ажилсаг, зоригтой бүсгүй юм. Түүний ууган охин Ирен авьяаслаг эрдэмтэн болж мөн эрдэмтэн Жан Фредерик Жолиоотой гэрлэж хамтран ажиллаж хиймэл цацраг идэвхт чанарыг нээсэн учир 1935 онд Нобелийн шагнал хүртжээ. Хоёр дахь охин Мария Кюри Ева нь алдарт хөгжимчин, хөгжмийн зохиолч болсон билээ.

М.Кюри цацраг идэвхт бодистой байнга ажиллаж байснаас үүдсэн өвчнөөр 1934 онд ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ.

# Бенжамин Франклин

(BENJAMIN FRANKLIN)

1706-1790

АНУ-ын ерөнхийлөгч Б.Франклин бол бизнес, шинжлэх ухаан, уран зохиол, улс төр гэсэн хүний үйл ажиллагааны дөрвөн өөр салбарт хосгүй амжилтад хүрсэн суут хүн билээ.

Бизнесийн салбарт түүний оргилд хүрсэн замнал нь одоогийн залуу хүн бүрт үлгэр жишээ болохоор байдаг. Бостон хотод чинээлэг биш айлд төрж идэр залуудаа Филадельфи хотод анх очихдоо халаас хоосон байв. Гэвч хэвлэлийн бүтээгдэхүүний дэлгүүр ажиллуулах, сонин эрхлэн гаргах зэрэг үйл ажиллагаагаараа дөчин настайдаа гэхэд их баян хүн болж чөлөөт цагаараа гадаад хэл судалж шинжлэх ухаан сонирхож байв.

Б.Франклин эрдэмтний хувьд цахилгаан, гэрлийн салбарт хийж байсан суурь судалгаагаараа нэрд гарчээ. Тэрчилэн Франклиний пийшин, бифокалийн томруулдаг шил зэрэг хэд хэдэн өндөр ашигтай шинэ бүтээл гаргасан байна.

Уран бүтээлийн үйл ажиллагаагаа сэтгүүл зүйгээс эхэлж удалгүй "Хөөрхий Ричардын цоморлиг" нэртэй цуврал гаргаж түүндээ уран цэцэн үгүүд байнга хэвлүүлж уншигчдын анхаарлыг гойд татаж байв. Амьдралынхаа сүүлчийн жилүүдэд намтраа бичиж хэвлүүлснийг нь өнөөдөр дэлхий даяар амтархан уншсаар байна.

Улс төрийн салбарт захиргааны санаачилгатай ажилтан (эзэмшил нутагт ерөнхий шууданч байхдаа, шуудангийн үйлчилгээний давуу талыг үйлчлүүлэгчиддээ үнэмшилтэй харуулж чадсан.), өргөн мэдлэгтэй хуульч (Пенсильвани муж улсын хууль тогтоох байгууллагад хэд хэдэн удаа сонгогджээ.), авьяаслаг дипломатч (АНУ-ын түүхэнд Франц улсад байсан хамгийн цуутай, азтай элчин сайд байжээ.) байв. Америкийн Эрх чөлөөний тунхаглалд хамгийн түрүүнд гарын үсэг зурсан хүмүүсийн нэг, хожим нь Үндсэн хуулийн хурлын гишүүн байжээ.

Б.Франклин цогтой ухуулагч, гарамгай зохион байгуулагч хүн байсан. Тухайлбал Филадельфи хотод анхны эмнэлгийг санаачлагчдын нэг байсан ба эзэмшил нутгуудад галын аюулаас хамгаалах анхны багуудыг эмхлэн байгуулахад тусалж муж улсдаа цагдаагийн газар байгуулахад гар бие оролцож байв. Тэрчилэн эзэмшил нутгуудад нийтийн номын сангууд байгуулж шинжлэх ухааны нийгэмлэг санаачлан сэдэж байжээ.

Гэхдээ аливаа хүний адил амьдрал, үйл ажиллагаандаа алдаа дутагдал гаргаж, сүйрэл, азгүй явдалтай байнга тааралдаж байсан ч хорвоогийн амьдралаа бахархам үр дүнтэй өнгөрөөсөн хүний түүхэн дэх сонгодог жишээ болсоор байна. 84 хүрч өндөр сайхан наслахдаа эрүүл саруул бие бялдартай байж аз жаргалтай, атаархам амьдрал, тэмцлийг туулжээ.

Дээр дурдсан магтаалын үгнээс ургуулан би түүнийг дэлхийн түүхийн суут 100 хүний тоонд оруулах гэснээ түүний аль ч салбарт хүрсэн амжилт нь үнэхээр ололт гэж дүгнэхэд арай л

учир дутагдалтай байсан тул больсон юм.



# Махатма Ганди

(MOHANDAS GANDHI)

1869-1948

Махатма К.Ганди нь Энэтхэгийн тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөний гарамгай удирдагч байлаа. Тийм учраас түүний нэрийг манай номын үндсэн жагсаалтад оруулахыг олон хүн надад ятгаж байлаа. Гэхдээ Энэтхэг улс ямартаа боловч эрх чөлөө тусгаар тогтнолоо зарлах байсан. Колонийн дарлалаас чөлөөлөгдөх тэмцэл дэлхий даяар өрнөж байсан түүхийг сөхөн үзвээс Махатма байгаагүй ч гэсэн Энэтхэг улс 1947 оноос өмнө тусгаар тогтнолоо олох байжээ.

Чин үнэнийг хэлэхэд хүчирхийллийн бус замаар үл захирагдах тухай түүний дэвшүүлсэн зарчим ихээхэн амжилтад хүрч англичууд Энэтхэг орноос аргагүйд тулж орхин гарсан билээ. Энэтхэгчүүд тэмцлийн илүү хурц хэлбэрийг сонгосон бол аль хэдийнээ тусгаар тогтнолоо олох байсан тухай бичдэг судлаачид бий. Ийм учраас Гандийн үйл ажиллагааны үр дүнд энэтхэгийн тусгаар тогтнолын төлөө тэмцэл хурдассан эсэх тухай дүгнэлт хийх хэцүү. Энэтхэгийн Үндэсний их хурал нам бүр 1885 онд байгуулагдсан болохоор түүнийг энэтхэгийн эрх чөлөөний төлөө хөдөлгөөнийг үндэслэгч гэж нэрлэж болохгүй, түүгээр ч барахгүй эх орон нь тусгаар тогтнолоо зарлаж байх үед улс төрийн гол удирдагч нь байгаагүй юм.

Гэхдээ хүчирхийллийн аргаас татгалзсан нь М.Гандийн гол гавьяа юм. Энэхүү үзэл санааг Торо, Л.Толстой нарын бүтээл, Шинэ Гэрээ болон энэтхэгийн янз бүрийн эх бичмэлээс олж авсан гэж дурсан бичсэн байдаг.

1954-1955 онуудад хүчирхийллийн аргаас татгалзах тухай түүний аргыг португальчуудыг Гоа арлаас хөөх зорилгоор ашигласан нь үр дүнд хүрээгүй тул Энэтхэгийн засгийн газар хэдэн жилийн дараа байлдааны ажиллагаа хийсэн юм. Сүүлийн дөчин жилд Энэтхэг улс Пакистан, Хятадын хил залгаа нутагт гэх зэргээр нийтдээ гурван удаа дайн өдөөсөн.

Ер нь бусад орон түүний аргыг таашаан авч хэрэглэж байсан удаа маш цөөхөн. Хүчирхийллийн аргыг үл хэрэглэх тухай М.Гандийн зарчим гарснаас хойш гэхэд л дэлхийд хоёр удаа бүх нийтийг хамарсан цуст дайн гарсан.

Ийм учраас М.Ганди гүн ухаантны хувьд ялагдал хүлээсэн гэж хэлж болох талтай.

# Авраам Линкольн

(ABRAHAM LINCOLN)

1809-1865

АНУ-ын 16 дахь ерөнхийлөгч А.Линкольн бол тус улсын хамгийн алдартай, бахархам ерөнхийлөгч нарын нэг мөн билээ. 3,5 сая боолчуудад эрх чөлөө бэлэглэсэн нь аугаа гайхамшиг билээ.

Гэхдээ боолчлох ёсыг дэлхий нийтээр буруушааж байсан үед тийм шийдвэр гаргах нь зүй ёсны үйл явц байсан гэж хэлж болно. Олон орон түүнийг ерөнхийлөгч болохоос бүр өмнө боочлолыг устгаад байсан ба бусад олон улс түүнийг нас барснаас хойш жаран таван жилийн хугацаанд боолчлох ёсыг халсан байна. Боолчлох ёсыг устгах үйл явцыг хурдасгасан нь А.Линкольний гол гавьяа юм.

Гэсэн хэдий ч түүний үйл ажиллагааны зарчмын чухал ололт нь өмнөд муж улсууд салан тусгаарлах аюул заналхийлж байх түүхийн туйлын эгзэгтэй үед тус улсыг нэгдмэл болгож чадсан явдал юм.

А.Линкольн ерөнхийлөгчөөр сонгогдсон нь өмнөд мужууд салан тусгаарлахын төлөө тэмцэх шалтгаан болсныг дурдах учиртай. Умардынхныг А.Линкольн удирдаагүй бол иргэний дайнд гарцаагүй ялагдах байсан нь өнөөгийн өндөрлөгөөс харахад ч илэрхий байдаг. Умардынхан иргэний дайнд хүн амын тоогоор илүү, аж үйлдвэрийн үйлдвэрлэлээр давуу байдалтай оролцсон билээ.

Иргэний дайнд Умардынхан ялагдсан байсан ч түүхийн үйл явц шальтай өөрчлөгдөхгүй байсан билээ. Умард болон Өмнөд муж улсуудын хэл, шашин, соёл, худалдааны нэгдмэл байдал нь тэднийг хэзээ нэгэн цагт нэгдэхэд гарцаагүй хүргэх байлаа. Тиймд салан тусгаарласан үйл явц хорин жил цаандаж тавин жил үргэлжилсэн байхад ч дэлхийн түүхэнд онц чухал үйл явдал болохгүй байсан юм. АНУ өмнөд мужуудгүй байлаа ч гэсэн өнөөдөр дэлхийд хүн амын тоогоор дөрөвдүгээрт орсон, аж үйлдвэрийн хувьд тэргүүлэх орон мөн л байх байсан юм.

Гэхдээ А.Линкольний үйл ажиллагаа олон сая хүний амьдрал, бүхэл бүтэн үеийнхэнд зүйргүй их нөлөө үзүүлсэн юм.

# Фернан Магеллан

(FERDINAND MAGELLAN)

1480-1521 оны орчит

Португалийн далай судлаач Фернан Магеллан дэлхийг тойрсон анхны аялалыг удирдагч байснаараа алдартай билээ.

Бүтэн гурван жил үргэлжилсэн түүний аялал нь хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн гайхамшигт аялал байсан юм. Жижигхэн таван завьтай гарсан 265 хүнээс Европ тивд дөнгөж 18 хүн л амьд мэнд ганц завьтайгаа л эргэн ирсэн. Аялалын удирдагч Магеллан замдаа нас барсан ч түүний аялал дэлхий бөөрөнхий гэдгийг баттай нотолсон билээ.

Энэхүү аялал амжилттай болсон нь Магелланий чадварлаг удирдлага, хатан зоригтой нягт холбоотой. Багийнхны нь дийлэнх хэсэг буцахыг шаардаж бослого гаргахад Магеллан хүч хэрэглэн харгислан дарж аялалаа цааш үргэлжүүлж далай, тэнгис судлаачдын хамгийн аугаа нь болохоо баталсан юм.

Ф.Магелланий хүрсэн амжилтын нөлөө тийм ч их байгаагүй.

Тэр үед европийн боловсролтой хүмүүсийн дийлэнх нь дэлхий бөөрөнхий гэдэгт бараг итгэчихсэн байсан. Түүний аялал худалдааны цоо шинэ зам нээгээгүй юм.

# Леонардо Да Винчи

(LEONARDO DA VINCI)

1452-1519

Италийн суут уран зураач Леонардо да Винчи 1452 онд Флоренц хотод төрсөн. Өнгөрсөн таван зуун жил түүнийг дэлхийн хамгийн суут ухаантнуудын нэг мөн гэдгийг бүрэн нотолсон. Гэхдээ түүний хосгүй авьяас, зүйргүй их нэр хүнд нь түүхэнд үзүүлсэн нөлөөнөөс нь хавьгүй давуу учраас энэ жагсаалтад багтаагүй учиртай.

Леонардо тэмдэглэлийн дэвтэртээ нисэх онгоц, усан доогуур шумбагч завь зэрэг нэн шинэ түүхийн олон гайхамшигийн төслийг зурж үлдээсэн байдаг. Гэвч эдгээр зураг нь түүний гайхам оюун ухааны илэрхийлэл болсноос биш шинжлэх ухааны хөгжилд ямар ч нөлөө үзүүлээгүй юм. Шинээр сэтгэж олсон зүйлүүдийнхээ эх загварыг ганц ч удаа хийж байсангүй. Түүний бодож олсон шинэ бүтээл нь үнэхээр үр дүнгээ өгөх ач холбогдолтой байсан ч бодит амьдралд хэрэгжихээс дэндүү хол хөндий байжээ.

Нисэх онгоц юм уу усанд шумбагч завины зураг зурах нэг хэрэг, тэдгээрийн нарийн тодорхой төслийг боловсруулж ажилладаг эх загвар бүтээх илүү төвөгтэй. Тухайлбал Эдисон, Ж.Уатт, ах дүү Райт зэрэг суут зохион бүтээгчид түмэн бэрхшээлийг туулж барагдашгүй тэвчээр гаргаж ажилладаг эх загварыг яаж ийгээд бүтээж чадаж байсан. Гэтэл Леонардо тийм оролдлого ч хийж байсангүй, тэгээд ч түүний тэмдэглэлийн дэвтэртээ зурсан зураг нь хэдэн зууны турш хэвлэгдсэнгүй, хав дараастай байжээ. Зургууд нь хэвлэгдэж байх үед нөгөө шинэ санаанууд нь аль хэдийнээ биеллээ олсон байсан. Тийм учраас Леонардо зохион бүтээгч, эрдэмтний хувьд хүн төрөлхтөний түүхэнд ач холбогдол багатай байсан гэж хэлж болно.

Леонардо аугаа их зураач ч Рембрандт, Рафаэль, Ван Гог, Эль Греко нараас давуу байгаагүй ч уран зургийн цаашдын хөгжилд үзүүлсэн нөлөө нь Пикассо, Микеланжело нараас илүү ач холбогдолтой байсан нь үнэн.

Леонардо нь шинэ соргог санааг дэвшүүлэн гаргахдаа гарамгай ч аль ч шинэ санаагаа төгс төгөлдөр болгож дуусгаж чаддаггүй зуршилтай хүн байжээ. Тийм учраас түүний гараас гаргасан бүтээл нь дээр дурдсан зураачдаас хавьгүй цөөн байжээ. Толгойд нь шинэ санаа төрмөгц, хийж байсан ажлаа дутуу орхидог зуршилтайгаасаа болж байгалиас заяасан хосгүй авьяасаа бүрэн дүүрэн ашиглаж чадаагүй хүн юм.

Суут "Мона Лиза"-г бүтээсэн хүнийг ийнхүү үнэлж байгаа нь уншигчдад хачирхалтай санагдаж болох боловч түүний уран бүтээлийг нарийвчлан судладаг эрдэмтэд надтай адилхан дүгнэлт олонтаа хийсэн байдгийг дурдахад илүүдэхгүй биз ээ.

Леонардо бол хүн төрөлхтөний түүхэн дэх суут авьяастай хүмүүсийн нэг яах аргагүй мөн боловч хүрсэн амжилт нь төдийлэн их биш. Чадварлаг уран барилгач байсан ч түүний төслөөр боссон байшин ганц ч байхгүй, өнөө үед хадгалагдан ирсэн ганц ч баримал алга.

Түүний гоц авьяасаар бүтсэн хорь орчим гайхамшигт уран зураг, хэд хэдэн тэмдэглэлийн дэвгэр л бидний үед хадгалагдан ирсэн байдаг. Тийм учраас Леонардог энэхүү жагсаалтад багтаагаагүй учиртай.

# НЭМЭЛТ ТАЙЛБАР

Намайг энэ номыг бичиж байх хугацаанд цөөнгүй найз, туслахууд маань надад хандаж түүхэн олон хүнийг номондоо багтаахыг зөвлөж байлаа. Би зарим зөвлөмжийг нь хүлээн авч номондоо оруулсан, заримыг нь тодорхой шалтгаанаар хассан. Тийм учраас би энэ номонд багтаасан түүхэнд хамгийн их нөлөө үзүүлсэн 100 хүнээс гадна бас суут 100 хүний нэрийг дурдмаар санагдаж доор толилуулж байна. Үүнд:

Авраам, Эзоп, Говард Г.Эйкен, Сюзан Б.Энтони, Фома Аквинский, Архимед, Аристарх Самосский, Ричард Оркрайт, Нейл Армстронг, Чарлз Баббеж, Антуан Анри Беккерель, Жереми Бентам, Отто фон Бисмарк, Нильс Бор, Луи де Брольи, Николас Сади Карно, Хеопс (Хуфу), Уинстон Черчилль, Карл фон Клаузевиц, Рудольф Клаусиус, Мария Кюри, Готлиб Даймлер, Данте Алигьери, Давид хаан, Демокрит, Мери Бейкер Эдди, Роберт К.В.Эттингер, Жорж Фокс, Бенжамин Франклин, Их Фридрих, Бетти Фридан, Гален, Махатма К.Ганди, Карл Фридрих Гаусс, Хаммурапи, Георг Вильгельм Фридрих Гегель, ҮШ Генрих, далайчин Генрих, Теодор Герц, Гиппократ, Томас Гоббс, Жеймс Гаттон, Эхнатон, Исаия, Жанна д'Арк, Иммануил Кант, Кемаль Ататюрк, Жон Мейнард Кейнс, Гар Гобинд Хорана, бага Мартин Лютер Кинг, Альфред С.Кинси, Густав Роберт Кихгоф, Хубилай хаан, Готфрид Вильгельм фон Лейбниц, Этьен Ленуар, Леонардо да Винчи, Авраам Линкольн, Лиу Панг (Чан Кайши), ХIY Людовик, Жеймс Медисон, Фернан Магеллан, Хатагтай Мария, Мэйзи Тенно (хаан Муцухито), Дмитрий Менделеев, Монтескье, Мария Монтеessori, Сэмюель Морзе, Вольфанг Амадей Моцарт, Муавия, Жерар К. О'Нил, Блез Паскаль, Иван Павлов, Пабло Пикассо, Марко Поло, Птоломей (Клавдий Птоломей), Пифагор, Рональд Рейган, Рембрандт, Франклин Делано Рузвельт, Шанкара, Эрвин Шрёдингер, Уильям Б.Шокли, Жозеф Смит, Сократ, Софокль, Сунь Ятсен, Уильям, Генри Фокс Тальбот, Доголон Төмөр хаан, Эдвард Теллер, Генри Дэвид Торо, Чарлз Х.Таунс, Гарри С.Трумэн, Алессандро Вольт, Шелман Д.Уоксман, Жеймс Д.Уотсон ба Фрэнсис Крик, Роберт А.Уотсон-Ватт, Мария Уолстонкрафт, Фрэнк Ллойд Райт, Борис Ельцин, Владимир Зворыкин.

Энэ номонд бас "Хүндэт арав" гэсэн жагсаалт бий. Үүнд эдгээр хүмүүсийн нэрийг нэрсийг чухам яагаад суут 100 хүний жагсаалтад багтаагүй шалтгааныг би өмнө тоочсон билээ.

# Төгсгөлийн тайлбар

Энэ номонд намтар, үйл ажиллагааг нь дурдсан хүмүүс бол хүн төрөлхтөний түүхэн дэвшилд асар их нөлөө үзүүлсэн суутнууд юм. Тэдний дийлэнх нь Европ тивээс гаралтай байна. (хүснэгт А) Доор байгаа хүснэгтээс харахад бусад тив, бусад үндэстний хүмүүсээс илүү англичууд хүн төрөлхтөний соёл иргэншилд давуу хувь нэмэр оруулсан байна. Энэ номонд орсон 18 английн иргэнээс 5 нь бяцхан Шотландаас байгаа нь их сонирхол татаж байна. Дэлхийн нийт хүн амын дөнгөж 0,8 хувь оршин суудаг Шотланд орон хосгуй авьяастнуудаараа бахархмаар ажээ.

Б хүснэгтээс үзэхэд манай эриний өмнөх Y1-Ш зууны үеүдэд гоц хүмүүс олноор төрж байснаа нэг хэсэг удтал завсарлажээ. Гэвч манай эриний ХҮ зуунаас эхлээд хөгжил дэвшлийн таатай нөхцөл бүрдэж эхэлсэнтэй холбоотойгоор суутнууд дахин бөөнөөр төржээ.

Түүхэн ном зохиолд улс төрийн үйл явдлуудыг ихээхэн тусгасан байдаг. Гэтэл шинжлэх ухааны ололтууд эх дэлхийн нүүр царайг далайцтай өөрчилдөг байна. Ийм учраас В хүснэгтэд харуулснаар дэлхийн суут хүмүүсийн тоонд улс төрийн болон цэргийн зүтгэлтнүүдээс илүү эрдэмтэд, зохион бүтээгчдийн нэрс орсон байна. Энэ номонд орсон суут хүмүүсийн 19 нь гэр бүлгүй байсан ба бусад нь оюун ухаан, бие бялдрын хувьд цаг үеийнхээ хүмүүсийн бахархлыг төрүүлж байжээ. Гэр бүлтэй байсан хүмүүсийн 26 нь хүүхэдгүй байжээ. Гэхдээ хууль бус хүүхдүүд байсан эсэхийг одоо тогтоох бэрх ба боломжгүй юм.

Энэхүү номонд багтсан суут хүмүүс бүгдээрээ хосгүй гайхам ухаантай, дийлэнх нь өндөр боловсролтой байв. Тэд нараас дөнгөж долоо нь бичиг үсэггүй байсан ч цэргийн зүтгэлтний хувьд гарамгай гавьяа байгуулжээ.

Манай номод орсон суут хүмүүсийн хамгийн багаар тооцоход арван хүн нь тулай өвчинтэй байсан нь эмч нарын анхаарлыг их татаж байдаг.

# Table of Contents

[Эхлэл](#)

[1. Магомед](#)

[2. Исаак Ньютон](#)

[3. Есус Христос](#)

[4. Будда](#)

[5. Күнз](#)

[6. Найдан Павел](#)

[7. Цай Лунь](#)

[8. Иоганн Гутенберг](#)

[9. Христофор Колумб](#)

[10. Альберт Эйнштейн](#)

[11. Луи Пастер](#)

[12. Галелео Галилей](#)

[13. Аристотель](#)

[14. Евклид](#)

[15. Моисей](#)

[16. Чарлз Дарвин](#)

[17. Цинь Шихуанди](#)

[18. Август Цезарь](#)

[19. Николай Коперник](#)

[20. Антуан Лоран Лавуазье](#)

[21. Их Константин](#)

[22. Жеймс Уатт](#)

[23. Майкл Фарадей](#)

[24. Жеймс Клерк Масквелл](#)

[25. Мартин Лютер](#)

[26. Жорж Вашингтон](#)

[27. Карл Маркс](#)

[28. Нисэх онгоц зохион бүтээгч ах дүү Райт](#)

[29. Чингис хаан](#)

[30. Адам Смит](#)

[31. Уильям Шекспир](#)

[32. Жон Дальтон](#)

[33. Александр Македонский](#)

[34. Наполеон Бонапарт](#)

[35. Томас Эдисон](#)

[36. Антони Ван Левенгук](#)

[37. Уильям Томас Грин Мортон](#)

[38. Гульельмо Маркони](#)

[39. Адольф Гитлер](#)

[40. Платон](#)



- [41. Оливер Кромвель](#)
- [42. Александр Грэхем Белл](#)
- [43. Александр Флеминг](#)
- [44. Жон Локк](#)
- [45. Людвиг Ван Бетховен](#)
- [46. Вернер Гейзенберг](#)
- [47. Луи Дагер](#)
- [48. Симон Боливар](#)
- [49. Рене Декарт](#)
- [50. Микеланжело](#)
- [51. Хоёрдугаар Урбан Хамба лам](#)
- [52. Умар Ибн Аль-Хаттаб](#)
- [53. Ашока](#)
- [54. Амгалан Августин](#)
- [55. Ульям Гарвей](#)
- [56. Эрнест Резерфорд](#)
- [57. Жан Кальвин](#)
- [58. Грегор Мендель](#)
- [59. Макс Планк](#)
- [60. Жозеф Листер](#)
- [61. Николаус Август Отто](#)
- [62. Франсиско Писарро](#)
- [63. Эрнан Кортес](#)
- [64. Томас Жефферсон](#)
- [65. Нэгдүгээр Изабелла хатан хаан](#)
- [66. Иосиф Виссарионович Сталин](#)
- [67. Юлий Цезарь](#)
- [68. Байлдан дагуулагч Вильгельм](#)
- [69. Зигмунд Фрейд](#)
- [70. Эдуард Женнер](#)
- [71. Вильгельм Конрад Рентген](#)
- [72. Иоганн Себастьян Бах](#)
- [73. Лао-Зы](#)
- [74. Вольтер](#)
- [75. Иоганн Кеплер](#)
- [76. Энрико Ферми](#)
- [77. Леонард Эйлер](#)
- [78. Жан-Жак Руссо](#)
- [79. Никколо Макиавелли](#)
- [80. Томас Мальтус](#)
- [81. Жон Фицджеральд Кеннеди](#)
- [82. Грегори Пинкус](#)
- [83. Мани](#)
- [84. Владмир Ильич Ленин](#)
- [85. Суй Вен Ти](#)

[86. Васко Да Гамма](#)  
[87. Их Кир хаан](#)  
[88. Оросын нэгдүгээр Петр хаан](#)  
[89. Мао Зедун](#)  
[90. Фрэнсис Бэкон](#)  
[91. Генри Форд](#)  
[92. Мэн-Цзы](#)  
[93. Зороастр](#)  
[94. Нэгдүгээр Елизавета хатан хаан](#)  
[95. Михаил Сергеевич Горбачёв](#)  
[96. Мина](#)  
[97. Их Карл](#)  
[98. Гомер](#)  
[99. Нэгдүгээр Юстинин хаан](#)  
[100. Махавира](#)  
[Нэмэлт арав](#)  
[Архимед](#)  
[Чарлз Баббеж](#)  
[Хеопс](#)  
[Мария Кюри](#)  
[Бенжамин Франклин](#)  
[Махатма Ганди](#)  
[Авраам Линкольн](#)  
[Фернан Магеллан](#)  
[Леонардо Да Винчи](#)  
[Нэмэлт тайлбар](#)  
[Төгсгөлийн тайлбар](#)